

СҮЕЛЕММЕ

ДРЕЙФУС

ЖУЛИАН

АССАНЖЕ



ХАКЕРУУДЫН

НУУЦ

АЖИЛЛАГАА

Жулиан Ассанже, Суелемме Дрейфус

Хакеруудын нууц ажиллагаа

“Анхаарал татсан, мэдээлэл өгөхөөр ном... Дрейфус энэ улсын хамгийн далд нууцыг нээн харуулахдаа сэтгэл хөдөлгөм, гайхамшигтай бүтээлийг бий болгожээ” – Роллинг Стоун

“...Таны ном миний амьдралын хоёр өдрийн ажлыг алдагдуулсан... Би баасан гаригт ном худалдаж аваад өнөөдөр үд дундын үед дуусгалаа! (Ням гариг) Маш сайхан бүтээл болжээ! Гайхамшигтай * * ” - bam@iinet.net.au

“Хэдэн хуудас уншихад л энэ сэдвээр бичсэн бусад номын дотроос ялгаатайг мэдэрлээ. Дрейфус хатагтай номын гол баатруудаа зөвхөн ‘компьютрийн донтон’ эсвэл ‘кибер өвчтөн’ мэт бус харин эгэл жирийн хүмүүс шиг бичжээ.” – lucasb@sub.net.au

‘Жинхэнэ таашаал авлаа’ – Жеорж Смит, Крипт мэдээ

‘NASA-г сөхрүүлэх дөхсөн Австралийн хакеруудын гайхамшигтай, сэтгэл хөдөлгөмөөр бүтээл’ - The Weekend сэтгүүл

‘Тархинд зориулсан аялалын ном’ - Сара Макдоналд. Ж

‘Нууц ажиллагаа номын тухай “The Age” сэтгүүлд гарангуут олж уншихыг тэсэн ядан хүлээсэн. Удалгүй номын дэлгүүрт худалдаж эхлэхэд нь аваад хэдхэн өдрийн дотор уншиж дуусгасан юм. Энэ номыг уншиж байхад миний урам нэг ч хором хугарч байгаагүй билээ.’ – dcw@alphalink.com.au

‘Сэтгэл татмаар бүтээл’ - jimgeuin@cyberservice.com

‘Техникийн ойлголт судалгаа, шинжилгээг дэлгэрэнгүй харуулсан’ – Трудие Макинтош (Австралийн иргэн)

‘Хакерын тухай хамгийн сайхан ном’ - Жим Липпард

‘Уншихад гайхамшигтай ном’ - Neil.Garbutt@aff.gov.au’

‘Хэлэх үг олдохгүй сайхан бүтээл’ - gerardc@one.net.au

‘Өөрийн эрхгүй татагдах ном’ – Девид Николс, “The Big issue” сэтгүүл

‘Техникийн мэдээллээр цангасан хүнийг татахаар хангалттай их зүйлийг агуулсан ном юм’ jmidgley@cyberjunkie.com

‘Салж чадахгүй байсаар дуусгах ном’ –Трудие Макинтош, Австралийн иргэн

‘Номын баатруудыг сайн тодорхойлж, ойлгомжтой илэрхийлсэн’ – Эд Бюрнс, IBIS

‘Хакерын бусад номтой харьцуулахааргүй техникийн ойлголт, судалгааны ач холбогдолтой бүтээл’ – Жим Липпард

‘Нууц ажиллагаанд оролцож, элит хакеруудын сонирхолтой вант улсаар аялах мэт

санагдсан – Девид Николс, “The Big issue” сэтгүүл

‘Дрейфус ном бичихдээ судалгаа сайн хийсэн байна’–Данни Ие, “Review of books”

Судлаачийн тэмдэглэл

“Хүн байгаа төрхөөрөө ярих үед өчүүхэн мэт аашилна. Харин түүнд баг өмсгөвөл бүх зүйлийг үнэнээр хэлнэ” – Оскар Вилде

“Хамгийн чухал зүйл нүдэнд өртөлгүй өнгөрнө”-Антони Де Саинт Экзюпери

“Яг ийм зүйл болсныг чи яаж “мэдэж” байгаа юм бэ?” – Уншигч

Энэ номонд нууцлаг орчны тухай өгүүлэх учир дээрх асуултыг асуух шаардлага бий. Номын сүүл хэсэгт төгсгөлийн тэмдэглэл дээр зарим тайлбарыг олох боломж байгаа юм. Гэхдээ бид зуу гаруй ярилцлага хийж, 40,000 хуудас бичиг баримт буюу телефон утсыг нууцаар чагнасан тухай бичиг баримт, мэдээллийн сангийн мэдээлэл, лог хийсэн файлууд, гэрчийн мэдүүлэг, буруугаа хүлээсэн мэдүүлэг, шүүгчийн гаргасан шийдвэр зэргийг цуглуулсан гэвэл дээрх асуултанд өгөх хамгийн энгийн хариулт болох бизээ. Телефон утасны яриа, онлайн чатаар солилцсон үзэл бодлыг хүртэл үндсэн эх сурвалжаас авсан юм. Энэ номонд бичигдсэн томоохон хакердах үйлдлүүдийг тодорхой баримтат материал дээр үндэслэн дурьдах хэрэгтэй.

Харин энгийн бус дараах хариулт байна.

Дөрөвдүгээр бүлэгт энэ номын гол баатрын нэг болох Парыг Нууц албаныхан ажиглаж байгааг өгүүлнэ. Тэр мөрөө буруулан зугатаах бөгөөд эрэн сурвалжлагдаж байгаа оргодол юм. Тэрээр хакер Нибблериин хамт Хойд Каролинагийн Блейк Моунтэн дахь мотельд Нууц албаныхаас нуугдаж байв. Нууц албаныхан түүниймөрөөр оржээ. Номонд энэ тухай өгүүлсэн нь байнга зугатааж, нуугдах Парын амьдрал, түүний Нууц албатай хамтран ажилласан тухай тайлбарлахад чухал ач холбогдолтой байлаа. Ингээд номоо сүүлчийн удаа хянаад хэвлэн нийтлэгч рүү очихын өмнө яагаад Блейк Моунтэнд болсон явдалтай холбоотой хэсгийг хасах хэрэгтэй болсон нь харамсалтай.

Суелетте гурван өдрийн хугацаанд Параас ярилцлага авахаар Тускон Аз руу ниссэн юм. Харин би утас болон онлайнаар дамжуулан Параас ярилцлага авахад олон арван цаг зарцууллаа. Пар өөрийн амьдралд нэвтрэх боломжийг бид хоёрт харамгүй олгов. Пар болсон явдлыг маш дэлгэрэнгүй, нүдэнд харагдтал ярьж байсан юм.

Пар хуулийнхнаас зугатаж байх тэр үед олон улсын компьютерийн нууц ажиллагааны хүрээ бага боловч өөр хоорондоо нягт холбогдсон хэсэг байлаа. Америкийг олон удаа хэрэн нисэхдээ түүний холбоо тогтоож байсан арав гаруй хакераас бид ярилцлага авсан. Түүнчлэн Партай уулзаж ярилцлагаа дуусгасны дараа түүнийөмгөөлөгч Ричард Розенгоос Суелетте нилээд мэдээллийг цуглууллаа. Өмгөөлөгч Ричард Розен үйлчлүүлэгчийхээ хэрэгт хавсаргасан материалаас хангалттай мэдээллийг хувилж илгээв. Парийн компьютер дээрээ бичиж хадгалсан олон мессэжийг бид олсон. Мөн Партай харьцсан бусад хакеруудын солилцсон мэдээллийн санг олж, Парын үйл ажиллагаатай холбоотой Нууц албаны мэдээлэл, бичиг баримт олныг үзэж, шинжилсэн билээ. Би түүний үерхдэг Швейцар найз охин Теоремтойдэлгэрэнгүй ярилцсаны эцэст үл ажиглагдам Франц аялагатай ярихыг хүртэл мэдсэн юм. Тэр охин Электрон ба Пенготой холбоотой байсан билээ.

Ерөнхийдөө Парын үйл ажиллагааны тухай хангалттай их хэмжээний материалууд Парын өгсөн ярилцлагыг нотлож байсан боловч Розены бичиг баримтыг оролцуулаад үлдсэн бүх бичиг баримтанд Блейк Моунтэн, НС. Розен, Теорем болон бусад хүмүүс-түүнийг Нууц албаныхан баривчилсан гэж сонссон тухай ямар ч тайлбар агуулаагүй байв. Гэхдээ болсон явдлыг буцаан хөөж үзэхэд зөвхөн нэг эх сурвалж руу байнга хөтөлнө. Энэ эх сурвалж бол Пар байлаа.

Пар биднийг төөрөгдүүлсэн байж болох уу? Нууц Албаныхан дайрж орохоос нэг эсвэл хоёр хоногийн өмнө мотелийн гаднах утасны бүхээгнээс Швейцарь дахь найз охин Теорем руу утасдсан гэж Пар хэлсэн юм. Шуурга болж байх үед гэсэн. Гэхдээ жирийн нэг шуурга биш, “Хюго” хар шуурганы үеэр. Харин мэдээллийн архиваас “Хюго” хар салхийг хаагуур дайрж өнгөрснийг үзвэл Хойд Каролина бус Өмнөд Каролинагаар дайран өнгөрсөн байв. Өөрөөр хэлбэл Блейк Моунтэнээр хар шуурга дайраагүй аж. Пар шуурганы үеэр нэг удаа утасдсаныг Теорем санаж байлаа. Гэхдээ “Хюго” хар шуурганы үеэр биш шүү. Тэгээд бас Блейк Моунтэний мотел руу гэнэтийн дайралт хийсэн тухай тэр охин юу ч санахгүй байгаа юм.

Хэрэгт ач холбогдол бүхий олон бичиг баримтыг Пар устгажээ. Номонд энэ тухай тодорхой оруулсан байгаа. Гэхдээ бусад эх сурвалжаас бидний олж авсан олон зуун хуудас бичиг баримтанд Блейк Моунтэний тухай нэг ч удаа дурсаагүй байв. Блейк Моунтэний мотел байдаггүй юм шиг санагдана. Нибблер нүүсэн учраас хаана байгааг тогтоох боломжгүй гэж Пар хэлжээ. Сулетте Нууц алба руу хэдэн арваад удаа утасдахад бидний сонсохыг хүсээгүй зүйлийг л хэлэв. Таамаг төдий Блейк Моунтэний үйл явдалд оролцсон байж болох Нууц албаны ажилтнууд ажлаасаа гарсан, эсвэл олдохгүй байлаа. Нууц албаны мэдээллийн төв баазын жагсаалтанд Парын нэр орсон байхад Блейк Моунтэнд хэн очсоныг Нууц албаныхан огт мэдэхгүй байгаа нь хачирхалтай. Мэдээллийн төв санд байгаа Парын тухай тайлбарт дараах гурван нэмэлт мэдээллийг оруулжээ. Нэгд – Парын хувийн хэргийг өөр агентлаг түр авсан, хоёрт-Пар эрүүл мэндийн “асуудалтай” болсон, гуравт –Блейк Моунтэнд болсон үйл явдалтай холбоотой Нууц албаны бичиг баримтыг олон янзын шалтгаанаар устгасан гэжээ.

Ном хэвлэх компаниас өгсөн эцсийн хугацаа дуусахаас нэг долоо хоногийн өмнө Блейк Моунтэнд болсон явдлын тухай мэдээлэл олох хоёрдахь оролдлого яагаад ч юм бэ амжилтгүй болох мэт санагдаж байв.

Блейк Моунтэнд болсон үйл явдалд оролцсон байж болох, шилжсэн эсвэл албанаас халагдсан Нууц албаны ажилтныг олохыг хичээх зуур Парын өгүүлсэн зүйлд байгаа хоёр асуудлыг шалгаж нягтлахаар шийдлээ. Үүнд нэгдүгээрт “Хюго” хар шуурга, хоёрдугаарт нүдэнд үл үзэгдэх Блейк Моунтэн мотелийн тухай.

“Хюго” хар шуурга нь ихэнх шуурганы адил том хүрээгээр эх газрын төв рүү тэмүүлж, бага хэмжээтэй болж төгсөх замдаа таарсан бүгдийг эвдэж сүйтгэдэг байна. Энэ онцлогийг хэвлэл мэдээллээр нэвтрүүлсэн мэдээ батална. Эцэст нь Үндэсний судалгааны газраас цаг агаарын дэлгэрэнгүй мэдээллийг авлаа. Каролинад хүч нь замхрах хүртэл “Хюго” хар шуурга Хойд Каролинагийн Шарлотт хотыг дайран өнгөрчээ. “Хойд Каролинад Хюго хар шуурганы аюулыг хэрхэн багасгасан тухай” Хойд Каролинагийн Яаралтай тусламжийг удирдан зохион байгуулах газрын координатор Наталиегийн хийсэн мэдээлэл дөрөвдүгээр бүлэгт тодорхойлсон Шарлотт хотын нисэх онгоцны буудлаар дамжин Нью-Йорк руу оргосон

Парийн зугталтанд бидний анхаарлыг чиглүүлэв. Эрэн сурвалжлах хуучинсаг арга барилаар Блейк Моунтэн дэхь мотел болгон руу утасдаж Блейк Моунтэн мотелын эзэн өөрчлөгдөж, нэр нь солигдсоныг олж мэдлээ. Бүх ажилчид нь солигдсон гэнэ. Зарим талаараа Парын тухай дээрх түүх болж өнгөрсөн үнэн мэт санагдана. Харин би ийм явдал болоогүй байгаасай гэж би хүсэж байлаа. Бид хоёрдахь удаагийн бие даасан оролдлогоор үүнийг батлахаар шийдсэн юм.

Хэн үүнд холбогдсон байж болох вэ? Ямартай ч Вашингтонд байгаа нууц байгууллагаас гадна цаасан дээр буусан мэдээлэл байх л ёстой. Магадгүй Шарлотт хот дахь Нууц албаны агентлагт ямар нэгэн мэдээлэл байж болох уу? Магадгүй Шарлотт хотын шүүхэд баривчлах тогтоолын хуулбар байж болно шүү дээ. Нууц албаны дайралтыг дэмжиж Хойд Каролинагийн цагдаагийн газар орсон ч юм билүү? Хэрэв Нууц албаны хамаарах хэрэг юм бол бидэнд үзүүлэх материал байхгүй байна. Орон нутгийн цагдаа нар юу хийсэн юм бэ? Хариуцсан газар нутгийн нэг мотелд нуугдсан оргодол хакерийг баривчлах Нууц албаны ажиллагааг Блейк Моунтэний цагдаагийнхан мэдэлгүй өнгөрнө гэж баймааргүйсэн.

Магадгүй далд фронтын босогчид орон дороо нуугдахаа больсон биз. Харин Блейк Моунтэнд бол тэд утасны бүхээг хавьцаа эргэлдсэнээр тайлбарлаж болно. Би Блейк Моунтэний цагдаагийн газрын ээлжинд гарах цагдааг хүлээж байлаа. Урд ээлжний цагдаагаас арай өөр зүйл ярина гэдэгт би итгэж байв. Би АНУ-ын босогчдын хамгийн тусгай нэвтрэх хэрэгслийг ашиглахаар шийдэв. Америк аялгатай, эмэгтэй хүний ялдам занг харуулах Суелетте гайхамшигт шидийг үзүүллээ. Блейк Моунтэнд оргодлыг баривчлах дайралт яг болжээ. Орон нутгийн цагдаагийн байгууллага ч үүнийг дэмжсэн байна. Бид өөрсдийн баталгааг олж авлаа.

Энэ онигоо мэт тохиолдол их зүйлийг өгүүлэхээс гадна олон түүхийг ч төлөөлөх юм. Хакеруудын нууц ажиллагаа номын бүлэг бүр үүн лугаа адил бие даасан бодит түүхээс бүрдэнэ. Хакеруудыг шууд харах боломжгүй. Гэхдээ ном үнэн мөнийг нарийн өгүүлэхээс гадна бодит мэдрэмжийг төрүүлэх ёстой билээ.

Үзэгдэх ба үл үзэгдэх зүйлд хүн үнэн бодитоор хандана. Хэцүүхэн л зохицол.

Жулиан Ассанже

2001 оны 1-р сар

Номын талархал

Чухал факт, бичиг баримтыг олоход олон хүмүүс туслалцаа үзүүлж, ярилцлага өгсөн юм. Техникийн болон хуулийн асуудалтай холбоотой зүйлийг тайлбарлахад цаг хугацаа их зарцуулсан билээ. Би тэдгээр хүмүүст өөрийн талархлыг илэрхийлэхийг хүсэж байна. Нэрээ нууцлахыг илүүд үзсэн зарим хүмүүс шаардлагатай материалыг олоход санаачилга гарган, тэвчээртэй хандсанд талархах ёстой.

Энэ номд зориулан ярилцлага өгсөн одоо болон өнгөрсөн үеийн компьютерийн мэргэжилтнүүдэд баярласнаа хэлэх байна. Тэд өөрсдийн ажил, амьдралын талаар маш дэлгэрэнгүй танилцах боломжийг надад олгосон юм.

Түүнчлэн би уйгагүй судалгаа хийсэн Жулиан Ассанжед талархаж байна. Түүний техникийн туршлага, дээд зэргийн судалгаагүйгээр энэ ном хэвлэгдэх боломжгүй ээ. Фиона Инглис, Деб Каллагхан, Женифер Бирне нарын гурван гайхамшигтай хүүхнүүд миний ном бичих саналыг дэмжиж, итгэл хайрласан билээ. Хугацаа тулгамдсан үед Карл Харрисан Фордын шүүн найруулах авьяас их тусыг үзүүлсэн. Түүнчлэн би Жуди Брукст баярлаж байгаагаа илэрхийлье.

Жон Макмахон, Рон Тенкати, Кевин Оберман, Рей Каплан, Нью-Йоркийн номын сангийн ажилтнууд, Нью-Йоркийн шуудангийн номын сангийн ажилтнууд, Боу стрийтийн шүүхийн ажилтнууд, Соутваркийн шүүхийн ажилтнууд, АНУ-ын Нууц алба, Блейк Моунтэний Цагдаагийн газар, Майкл Розен, Мелбурнийн шүүхийн ажилтнууд, D.L Sellers&Co-ийн ажилтнууд, Викториааны шүүхийн ажилтнууд, Пол Галбалли, Марк Дорсет, Suburbia.net, Freeside Communications, Грег Хуупер, “Н&S Support Service”, Петер Андрус, Кевин Томпсон, Андру Вивер, Мухтар Хуссейн, Миднайт Ойл, Хелен Меридит, Иван Химмелхох, Майкл Холл, Донн Феррис, Викториаан мужийн номын сангийн ажилтнууд, Сидней хотын Ньюс Лимитед номын сангийн хамт олон, Аллан Янг, Эд Дехарт, Аннетте Бийбер, Артур Аркин, Доуг Барнес, Жереми Портер, Жеймс Макнабб, Каролин Форд, АТА, Домини Банфийлд, Алистаир Келман, Анн Марий Моодие, Жейэ Хатчинсон, Катерине Мюрфи, Норма Хофкинс, Н. Левилин, Христине Ассанже, Рассел Брэнд, Матью Бишоп, Матью Кокс, Мишель Зиелки, Андрию Жеймс, Брендан Макграт, Warner Chapel Music Australia, Ньюс лимитед, Pearson Williams Solicitors, Тами Фриедман, The Free Software Foundation (GNU төсөл) зэрэг байгууллага, хувь хүнд талархсанаа илэрхийлье.

Эцэст нь энэ номыг бодит бүтээл болоход цуцалтгүй дэмжлэг үзүүлж, зөвөлгөө, урам зоригоо хайрласан өөрийн гэр бүлдээ баярласнаа илэрхийлэхэд таатай байна.

Суелетте Дрейфус

2001 оны 1-р сар

Өмнөх үг

Миний аавын авга эгч усан доор зурдаг хүн байлаа. Усан доогуур хорин мянган бээр аялсан нь зохиолд гардаг шиг. 1939 онд хэрэглэгдэж байсан усанд шумбах хүнд хэрэгслийг өмссөн Люси усны гадаргуугаас аажим доошилно. Тэр гартаа тусгай будаг, будгийн хавтан, зотон барьжээ. Далайн ёроолд буунгуугаа зургийн тавиураа бэлдэж, өөрийгөө хүрээлэх ертөнцөд бүрэн нэгдэв. Хөх ногоон шүр, аварга нальхан хорхой шивээлсэн ёроолоор улаан, цагаан судалтай загаснууд шүлжилдэнэ. Нуруун дээрээ хорт хатгууртай арслан загас сүрийг үзүүлэн хажуугаар өнгөрнө. Хадан хясаан дундах оромжноос хурц тод өнгөтэй могой загас түүн рүү нүд салгалгүй ширтэх ажээ.

Мексикийн Сулу Арчипелаго, Австралийн агуу хадан эрэг, Хавайн Борнеод зэрэг олон газарт Люси шумбаж, зураг зуржээ. Тэрээр Номхон далайн эрэг дагуу амьдрах нутгийн уугуул иргэдтэй олон сар амьдарсан анхны хүн болох бизээ.

Тухайн үеийн шинэ технологи түүнийг ингэх боломжийг олгосон юм. Агаар шахдаг компрессор, эсвэл газар дээр байгаа гар носоосыг хоолойгоор холбож, хүн хүрэх боломжгүй ертөнцөд хөл тавих боллоо. Урьд өмнө нээлт бага хийгдсэн вант улсаар аялж, зотон даавуун дээр орчноо буулгах боломжийг шинэ технологи олгожээ.

Харин би компьютерийн харилцаа холбооны шинэ ертөнцийн учир битүүлэг хэсэгт тохиолдлоор орж ирэв. Хагас зууны өмнө миний авга эгчийн хүсэл мөрөөдөл нь гадны ертөнцийг нээн илрүүлэх миний зөрчилдөөнт хүсэл тэмүүллээс огт өөр бололтой. Авга эгчийн аялах боломжийг шинэ технологи олгосонтой адил миний өөрийн аялал шинэ технологи дээр тулгуурласан юм. Би авга эгчтэйгээ адилхан шинэ ертөнцийн жижигхэн буланг баримтжуулахыг хичээлээ.

Энэ номонд компьютерийн далд үйл ажиллагааг харуулахыг зорьсон. Хууль хамгаалах байгууллагын тухай энэ номонд өгүүлэхгүй, цагдаагийн ажлын талаас ч бичээгүй юм. Харин утга зохиолын үүднээс бол компьютерийн олон хакеруудийн нүдээр харж байгаа мэт бичлээ. Ингэснээр уншигч таныг бараг нэвтэрч болшгүй гэж хэлэх ертөнцийн нууцлаг цонхоор харуулна гэдэгтээ итгэлтэй байна.

Хакерууд гэж хэн бэ? Тэд яагаад хакерддаг вэ? Эдгээр асуултанд тийм ч амархан хариулахгүй. Хакер бүр өөрийн арга барилтай. Тиймээс хоорондоо холбогдсон үйл явдалд олон улс дамжсан компьютерийн далд ажиллагаанд холбогдсон хувь хүн бүрийн онцлогийг тодорхой гаргахаар оролдсон хэрэг. Эдгээр нь дэлхийн хамгийн сайн хакеруудын тухай үнэн бодит түүх юм. Дэлхийн хэмжээний гэж үнэлэгдэх зарим хакеруудын тухай би энэ бүтээлд оруулаагүй. Учир нь хакеруудын дэлгэрэнгүй мөртлөө мэдээлэл багатай жагсаалт хийхийг оролдохын оронд хэдэн сайн хакеруудын тухай өгүүлэхээр би шийдсэн юм.

Хакер бүрийн тухай тодорхой түүх өгүүлэх боловч бас нийтлэг сэдвийг хамарсан хэсэг бий. Миний бие энэ бүтээлд дурьдагдсан хувь хүмүүст цаашид юу тохиолдсоныг мэдэхийг хичээсэн. (хакердсан үйлдлүүд, цагдаагийн хяналт, шүүхэд хэргийг хэрхэн шийдвэрлэсэн гм) Шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа зарим хэргүүд хэдэн жилийн нүүр ч үзэх явдал тохиолдоно.

Хакерууд онлайн дээр никнэмийг хоёр зорилгоор (nickname-хоч, хочлох гэсэн утгатай, цахим хуудасны орчинд хэрэглэгчийн нэр гэсэн утгаар хэрэглэдэг) ашигладаг. Нэгдүгээрт хакерийн хувийн мэдээллийг нууцлах, хоёрдугаарт хамгийн чухал нь буюу компьютер сүлжээний ертөнцөд тухайн хакерийг хэрхэн хүлээн авч байгааг мэдэхийн тулд никнэмийг хэрэглэнэ. Hawk, Crawler, Toucan Jones, Comhack, Dataking, Spy, Ripmax, Fractal, Insanity, Blade гэсэн нэрнүүд бол Австралид жинхэнээр хэрэглэж байгаа никнэмүүд юм.

Компьютерийн сүлжээний орчинд хакерийн никнэм бол түүний жинхэнэ нэр мэт байдаг. Ихэнх хакерууд авьяас чадвараа өөр зүйлд сорих болсон учраас би зөвхөн тэдний никнэмийг хэрэглэв. Олон никнэмтэй хакерийн хувьд илүүд үзсэн нэг нэрийг нь хэрэглэсэн.

Номын бүлэг бүрийн эхэнд “Midnight Oil” хамтлагийн дуунаас иш татсан байгаа. Үүгээрээ бүлгийн чухал агуулгыг илэрхийлэх гэж оролдсон юм. Тэд бол Австралийн хамтлаг. Тэдний цэрэг дайны салбар дахь аж үйлдвэрлэлийн эсрэг гаргаж байгаа чанга дуу хоолой бол номын гол санааг цуурайтуулах мэт санагдана.

NASA-д “WANK worm” вирусийн хямрал нүүрэлсэн тухай нэгдүгээр бүлгийн судалгааг хийж байхад “Midnight Oil” хамтлагийн дууны үгийг ашиглах санаа төрсөн юм. RTM worm вирусийн дараах “WANK” бол компьютерийн сүлжээний түүхэнд хамгийн их алдаршсан вирус гэж үздэг. Мөн энэ worm төрлийн вирус бол улс төрийн мессеж агуулсан хамгийн анхны томоохон вируст тооцогдоно. “Worm” гэсэн компьютерийн нэр томъёо Жон Бруннерийн “The Shockwave Rider” (Цохилтын долгионоор аялагч гэсэн утгатай) шинжлэх ухааны зөгнөлт зохиолоос үүсэлтэй бөгөөд “WANK worm” бол улс төрийн шалтгаанаас үүдэлтэй вирус юм.

Түүнчлэн “WANK worm”-ыг Австрали хүний зохиосон анхны сүлжээний вирус гэж үздэг.

Энэ бүлэгт хакеруудын эсрэг талд ажиллах компьютерийн системийн администраторуудын тухай харуулахыг зорьсон. Түүнчлэн нэг эсвэл нилээд хэдэн Австраличууд дэлхийн компьютер сүлжээний ертөнцөд компьютерийн гэмт хэргийг хэрхэн үйлдсэн тухай үзүүлэх болно.

Номын дараагийн бүлгүүдэд компьютер сүлжээний хөгжлийн эхний өдрүүдээс эхлэн нууц бүлэг хэрхэн үүсэж хөгжсөн, түүнээс хойш гэм буруутан болж хүрээ нь хумигдах хүртэлх үйл явдлыг дэлгэн харууллаа. Анх эхлэхдээ компьютер сонирхогчдын бүлэг шар айрагны мухлаг зэрэг нээлттэй, нөхөрсөг газарт оршин тогтнож байв. Харин одоо хакерууд хаа нэгтээ санамсаргүй тааралдахгүй л юм бол олуулаа цуглардаг байсан хуучны нээлттэй мэдрэмжээ алдсан гэж хэлэхэд болно.

Цагдаагийн байгууллагын хяналт хөгжиж, дэлхий даяар компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль батлагдан гарах болсон тул хакердах сонирхол бүхий бүлэг хувьсан өөрчлөгдөхөөс өөр аргагүй болсон билээ. Энэ бүтээлд Австралийн түүхийн чухал хэсгийг баримтжуулах оролдлогыг хийгээд зогсохгүй хакеруудын үйл ажиллагаа улам далд шатанд шилжсэнийг ул суурьтай гарган үзүүлэхийг хичээлээ.

Суелетте Дрейфус

1997 оны 3-р сар

Нэгдүгээр бүлэг

10, 9,8,7,6,5,4,3,2,1

Хэн нэгэн тэнд байна, хэн нэгэн хүлээж байна, хэн нэгэн надад зарим нэг зүйлийг хэлэхийг хичээж байна. – Midnight Oil хамтлагийн “Хэн нэгэн надад зарим нэг зүйлийг хэлэхийг хичээж байна” дуунаас иш татав.

1989 оны 10-р сарын 16 Даваа гараг, Флорида мужийн Кеннедигийн нэрэмжит сансрын төв

NASA пуужин хөөргөх болсноо зарлаж эхлэв. Галилео Бархасвадь гариг руу нисэх болно.

Алсын удирдлагатай, нисэгчгүй экспедицийг хөөргөхөөр дэлхийн хамгийн нэр хүндтэй сансрын агентлаг түүний захиргаа, эрдэмтэд олон жилийн турш ажиллаа. Одоо 10-р сарын 17 өдөр, Мягмар гарагт Флорида мужийн Кейп Канаверал дахь Кеннедигийн нэрэмжит сансрын төвөөс таван астрономичтой Атлантис тээвэрлэгч хөлөг судалгааны Галилео төхөөрөмжийг ачаалан хөөрөх болно. Мексикийн булангийн дээр 295 километрийн өндөрт явж байхад буюу багийн тав дахь удаагийн тойрог дээр гурван тонны жинтэй сансрын судалгаа шинжилгээний экспедицийг сансарт суллан тавих юм.

Сансрын хөлгөөс Галилео төхөөрөмж амжилттай салж, холдсоноос хойш нэг цагийн дараа төхөөрөмжийн 14742 кг пуужин тээгч систем асаж, хүний оюунаар бүтсэн гайхамшиг нарны аймгийн хамгийн том гариг дээр зургаан жилийн томилолттой ажиллахыг NASA-гийн ажилтнууд харах болно. Галилео экспедици хүндийн хүчнээс гарж, Бархасвадь гариг руу хүрэх хангалттай хүчийг хураахын тулд тодорхой тооцоолсон тойрог замыг туулах бөгөөд наранд ойрхон хоёрдахь гариг болох Сугарын хажуугаар нэг, дэлхийн хажуугаар хоёр удаа дайран өнгөрөх юм.

Экспедицийг нарны системээр саадгүй аялуулах боломжийг нээхээр NASA олон жилийн туршид ажиллажээ. Нарны эрчим хүч тэдний нэг сонголт байв. Бархасвадь гариг дэлхийгээс хол оршдог гэх боловч нарнаас бүр хол, цаашаа яг 778,3 километр байлаа. Нарнаас ийм алс хол байдаг учраас Галилеог эрчим хүчээр хангая гэвэл нарны асар том зай хураагуур шаардлагатай болох ажээ. Эцэст нь NASA-гийн инженерүүд газар дэлхийгээс гаралтай энергийн эх сурвалж – цөмийн энергийг ашиглахаар шийджээ.

Сансар огторгуйн төсөлд цөмийн эрчим хүч хамгийн тохиромжтой байлаа. Хүний амьдралын орчинд үл орших радио идэвхит плутони 238 диоксид удаан хугацааны турш энерги гаргах боломжтой байв. Логикийн хувьд ч шаардлага хангахуйц санагдана. Хорин дөрвөн килограмм хүртэлх плутонийг халтал нь урвалд оруулснаар экспедицийн тоног төхөөрөмжийг эрчим хүчээр хангаж, аялалыг саадгүй туулах болно! Өөрөөр хэлбэл Галилео хөлөг Бархасвадь гаргийг судлах замдаа гарна.

Харин Америкийн цөмийн эрчим хүчний эсрэг хөдөлгөөний идэвхтнүүд асуудалд өөр өнцгөөс хандсан юм. Тэнгэр өөд илгээсэн бодис буцаж газар дэлхийд хор хөнөөл учруулна гэж тэд үзсэн хэрэг. Тэгээд ч плутоний борооны тухай ойлголт нэг их сайхан сэтгэгдэл төрүүлээгүй бизээ. Галилеогийн цөмийн эрчим хүч гаргах хэсэг аюулгүй байдлыг сайн

хангасан гэж NASA итгүүлэхийг оролдоно. Тус агентлаг 50 сая ам долларын өртөгтэй туршилтыг хийж, төхөөрөмжийн эрчим хүч үүсгэгч генераторын аюулгүй ажиллагаа найдвартай гэж нотложээ. Эрчим хүч үүсгэгч төхөөрөмж томоохон дэлбэрэлт, гэнэтийн осол, гэмтлийг тэсвэрлэх чадвартай ажээ. Агаарын давхаргад дахин орж ирэхэд гэнэтийн өөрчлөлтөөс болж плутони агаарт алдагдах аюул хоёр саяд нэг удаа тохиолдох магадлалтай байдаг гэж NASA сэтгүүлчдэд мэдэгдэв. Мөн пуужин сүйрэхэд плутоний цацраг туяа нэвчих магадлал 2700 тохиолдолд нэг удаа гарах ажээ.

Эсэргүүцэгч идэвхтнүүд NASA-гийн тайлбарыг хүлээж авсангүй. Орчин цагийн Америкийн зөрчилдөөнийг шийдэх хамгийн уламжлалт аргыг сонгож, шүүхэд өргөдөл гаргав. Плутони агаарт алдагдах аюулыг NASA дутуу үнэлж байна гэж үзсэн цөмийн эсрэг хөдөлгөөний эвсэл болон бусад бүлгүүд пуужин хөөргөхийг зогсоох шийдвэр гаргахыг Вашингтон дахь АНУ-ын Дүүргийн шүүхээс хүсчээ. Шүүхээс NASA-гийн тодорхой үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргах саналтай зэрэгцэн азаа турших, сөргөлдөх ашиг сонирхлын зөрчилдөөн ихсэв. Аравдугаар сарын 12-нд хөөргөхөөр төлөвлөсөн нислэгээс хэдэн өдрийн өмнө шүүх асуудлыг авч хэлэлцэхээр зарлажээ.

Жагсаж, цуглаан хийсээр хэвлэл мэдээллийн анхаарлыг татсан эсэргүүцэгчид хэдэн долоо хоногийн нүүр үзэв. Нөхцөл байдал улам ширүүслээ. 10-р сарын 7-ны Бямба гарагт Капе Канавералын гудамжны өнцөгт идэвхтэн гишүүд уриа лоозон барин, утааны баг өмсөн жагсчээ. 10-р сарын 9-ний Даваа гариг, өглөөний 8 цаг. Пүрэв гаригт хөөргөх төлөвлөгөөтэй байсан хөлгийн хөдөлгүүр тэсрэх цагийг урвуугаар тоолж эхлэв. Атлантис хөлгийн цаг сансарт хөөрөх хугацаагаа тоолон цохилох зуур сансрын төвийн жуулчдын цогцолборт Флоридагийн Шударга ёс, энхийн эвслийн идэвхтэн гишүүд жагсана.

Тэдгээр эсэргүүцэгч нар сансрын томоохон төслийг унагаах ажилд ахиц гарган, агентлагийн сэтгэлийг аль хэдийнээс түгшээж эхэлсэн байлаа. Хүчирхийлэл хийхгүйгээр эсэргүүцлээ илэрхийлэхийн тулд хүмүүсийг хөлөг хөөргөх тавцан дээр байрлуулна гэж Флоридагийн эвсэл хэвлэл мэдээлэлд мэдэгдсэн явдал жинхэнэ толгойны өвчин болжээ. Засгийн газрын муу нэртэй, том агентлагийн эсрэг жижигхэн эсэргүүцэгчид босож байгаа хэмээн Эвслийн удирдагч Брюс Гагنون ёжлон хэлэв. NASA болон ард түмний хоорондох тэмцлийг өөр нэгэн эсэргүүцэгч бүлэг-“Эдийн засгийн хандлага” сангийн ерөнхийлөгч Жереми Ривкин өдөөж байв. “Сансрын нисэгчид энэ аялалд сайн дураараа явж байгаа, харин цацраг туяаны бохирдолтонд хордож болох хүмүүс сайн дураар оролцож байгаа гэж хэлж болохгүй” гэж Жереми Ривкин хэлжээ.

Гэхдээ эсэргүүцэгчид хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллаж байгаа цорын ганц хэсэг биш байлаа. NASA хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн ажиллахаа сайн мэднэ. Тэд хэвлэл мэдээллийн анхаарлыг сансрын нисэгчид рүү хандуулав. Сайн дураар нисэх хүсэлтээ гаргасан эрэгтэй, эмэгтэй сансрын нисэгчид бол бүх хүн төрөлхтний төлөө хүйтэн, харанхуй огторгуй руу аялж байгаа тэргүүний баатрууд байсан юм. Атлантис хөлгийн ахлагч Дональд Вилляамс эсэргүүцэгчдийг шууд буруутган шүүмжлэхгүйгээр даруухан дүгнэлт өгсөн гэдэг. Дональд : “Юу хийж байгаагаа ойлгож, ухамсарлахгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх хүмүүс байсаар ирсэн, байх ч болно. Нөгөө талаар лоозон бариад явах амархан. Харин ямар нэгэн хэрэгтэй зүйлийг хийхээр урагш тэмүүлнэ гэдэг хэцүү” хэмээн сурвалжлагчид хэлжээ.

NASA-гийн гарт бас нэгэн хөзөр байлаа. Атлантис хөлгийн нисэгч Майкл Маккалей –эрчим хүч ялгаруулах Радиоизотоп Термоэлектрик Генераторт плутонийг хэрэглэхэд ямар ч асуудал гарахгүй. Тиймээс би өөрийн гэр бүлийн хамгийн хайртай хүнийг Атланис хөлөг хөөрөх үед Сансрын төв дээр байлгахаар төлөвлөжбайгаа гэсэн мэдээлэл хийв. Сансрын нисэгчид эрсдлийг үл тоож болно. Харин өөрийн гэр бүлийг аюулд хүргэх баатар байхгүй гэж эсэргүүцэгчид түүний хэлсэн үгийг няцаахыг оролдоно. Гэтэл АНУ-ын дэд ерөнхийлөгч Дан Кьюаиле хөлөг хөөрөх тавцангаас долоохон километрийн зайд орших Кеннедигийн нэрэмжит Сансрын төв дотор, хяналтын өрөөнөөс Атлантисийг хөөрөхийг харах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

Нөхцөл байдлыг хянахын тулд хамгаалалтын албаа өргөтгөж, томруулсан NASA аль болох тайван харагдахыг хичээнэ. Хөлөг хөөрөх талбайг хамгаалахаар 200 орчим аюулгүй байдлын ажилтыг байрлуулжээ. Энэ мөчийг NASA удаан хугацааны туршид хүлээсэн билээ. Хөлөг хөөргөхөөр төлөвлөсөн хугацаа бараг долоон жилээр хожимдож байв. 400 сая ам долларын төсөвтэй “Галилео” төслийг эхлэх зөвшөөрлийг Конгресс 1977онд өгсөн бөгөөд 1982 онд хөлөг тэнгэрт хөөрсөн байх ёстой байлаа. Харамсалтай нь төсөл эхнээсээ бүтэлгүйтжээ.

Сансрын хөлгийг бүтээх явцад бэрхшээл учирсан тул NASA 1979 онд хөлөг хөөрөх товыг 1984 он хүртэл хойшлуулав. Тээгч хөлөг болон судалгааны хөлөг болж хоёр хуваагдах сансрын хөлгөөр Галилео судалгааны экспедицийг явуулахар шийдвэрлэжээ. Зардал хэт өссөн 1981 онд NASA төсөлдөө томоохон өөрчлөлт хийлээ. Шинэ системийг туршиж үзэхээр урьд төлөвлөсөн гурван шатлалт дэмжлэгтэй Галилео системийн ажлыг зогсоож, энэ удаад 1985 он хүртэл хойшлуулав. Галилео пуужин тээгч хөтөлбөрийн төсвийг хассан 1981 онд NASA хөтөлбөрийн хугацааг 1986 оны тавдугаар сар хүртэл сунгажээ. 1986 онд Челленжер хөлөг сүйрсний дараа аюулгүй ажиллагааг хангах үүднээс Галилеогийн тээгч системийг NASA дахин өөрчлөхөөр шийдвэрлэв.

Ингээд хоёр түвшний, хатуу түлштэй IUS систем хамгийн сайн сонголт болжээ. Тэнд нэг л хүндрэл байлаа. Энэ систем Галилеог Ангараг ба Сугар гариг руу хүргэж чадна. Харин Бархасвадь гаргийн ойролцоох аль нэг хэсэгт хүрэхийн өмнө шатахуун нь дуусах юм. NASA-гийн тийрэлтэт хөдөлгүүрийн лабораторийн ажилтан Рожер Диелд нэгэн санаа төржээ. Галилео ойрхон орших хоёр гаригийг хэдэн удаа тойрсноор судалгааны станц төвөөс зугатах хүчийг багагүй хуримтлуулж, Бархасвадьгариг руу шидэгдэх маягаар хүрэх боломжтой болно. Галилеогийн Сугар гариг-Дэлхий-Дэлхий-Хүндийн хүч-Дэмжлэг буюу СДДХД-ийн траектори нь Бархасвадь гариг дээр сансрын хөлөг ирэх ажиллагааг гурван жил хойшлуулсан юм.

Дэлхийн хажуугаар өнгөрөх удаа болгонд цөмийн аюул дагуулах эрсдлийг ихэсгэнэ гэж эсэргүүцэгчид маргаж байв. Харин үүнийг чавхаар харвахтай адилхан гэж NASA үзжээ.

Газраас хөөрөхийн тулд Галилео бусад олон саадыг туулсан билээ. 10-р сарын 9-ний өдрийн Даваа гаригт сансрын хөлгийн компьютераар удирддаг хоёр дахь гол хөдөлгүүрт асуудал гарлаа гэж NASA зарлав. Үнэндээ судалгааны Галилео станц бус тээгч Атлантис хөлөгт гол асуудал байсан юм. Тэр үед зөвхөн хөдөлгүүрийн компьютерүүдийн асуудлаас гадна цөмийн эсрэг идэвхтэн гишүүдийн өргөдөл гаргасан шүүх төслийн асуудалд оролцож байв.

\/

\ Танай системийг албан ёсоор WANK-длаа /

\ _____ /

Та нар бусдад энхийн төлөө ярьчихаад дараа нь өөрсдөө дайнд бэлдэнэ.

Таашаал авсан уу? Америкийн компьютерийн олон инженерүүд урьд өмнө ийм баннер харж байгаагүй ажээ.

NASA-гийн компьютерийн систем рүү хэн халдлага хийдэг байна аа? Цөмийн алуурчдын эсрэг өтнүүдийн цаана хэн байна вэ? Тэрс үзэлт аюултай бүлэг үү? Эсвэл NASA руу халдлага хийхээр зэхэж байгаа террорист бүлэг үү? Яагаад заавал өт байх ёстой гэж? Хувьсгалт бүлэгтээ зориулж өтөөр билэг тэмдэг хийнэ гэдэг хачирхалтай санагдана. Өт тэдний хамгийн суурь илрэл байлаа. Хэн өтийг хүч чадлын билэг тэмдэг болгон сонгох вэ?

Цөмийн алуурчдын хувьд энэ явдал бүр хачирхалтай байлаа. “Та нар бусдад энхийн төлөө ярьчихаад дараа нь өөрсдөө дайнд бэлдэнэ” гэсэн баннерын уриаг үзвэл зөвхөн NASA руу хандаагүй бололтой. Тус агентлаг цөмийн зэвсэг үйлдвэрлэдэггүй, хүмүүсийг сар луу илгээдэг. Цэргийн зориулалттай цэнэгт хошуутай холбоотой ажил зарим төсөлд нь байдаг боловч Батлан хамгаалах яам мэт АНУ-ын Засгийн газрын бусад агентлагуудыг бодвол “цөмийн алуурчнаар” дуудагдах хэмжээнд очоогүй баймаар. Яагаад NASA вэ? гэсэн асуулт хариулт хүлээсээр...

“ Wank буюу гар хангалга” гэсэн үгийг ухаж ойлгосонгүй. Системд гар хангалга хийлээ гэж юу гэсэн үг вэ?

Ямартай ч NASA компьютерийн хяналтаа алдсан нь ойлгомжтой.

NASA-гийн эрдэмтэн даваа гаргийн өглөө компьютерээ асаахад дараах мессэж гарч иржээ. Deleted file <filename1>; Deleted file <filename2>; Deleted file <filename3>; Deleted file <filename4>; Deleted file <filename5>; Deleted file <filename6>. Эдгээр мессэж “би таны бүх файлуудыг устгаж байна” гэсэн мэдээллийг эрдэмтэнд өгөв. Delete/ log** гэж бичсэн мөрийг дэлгэцэн дээр байх бөгөөд “бүх файлыг устга” гэсэн командыг эрдэмтэн эмэгтэй өөрөө өгсөн юм шиг харагдах ажээ.

NASA-гийн эрдэмтэн дэлгэцэн дээр хачин үйл явдал өрнөнгүүт л процессыг зогсоохыг оролдсон байх ёстой. Мэдээж control товчлуурыг “с”-тэй хамт дарсан байж таарна. Үүний үр дүнд командыг гүйцэтгэх дараалалд саад бий болж, хийж байгаа яг тэр үйлдэл дээрээ зогсох болно. Гэхдээ тухайн үед NASA-гийн эрдэмтэн бус харин халдагч этгээд түүний компьютерийг удирдаж байлаа. Гаднаас халдагч этгээд компьютерт хандан “Энэ команд юуг ч илэрхийлэхгүй. Цааш үргэлжлүүл” гэсэн команд өгөв.

Тэгэнгүүт эрдэмтэн энэ удаа удирдах товчлуур дээр бүр хурдан дарна. Нэг дараад л дахин дараад л байлаа. Ингээд эмэгтэй компьютерийн гаргаж байгаа ер бусын аашийг ихэд гайхан,

сэтгэлээр унажээ. Ертөнцийг нээхэд зориулсан олон долоо хоногийн магадгүй олон сарын хөдөлмөр нүдний өмнө арчигдан алга боллоо. Бүх хөлс хөдөлмөрийг гэмгүй компьютер залигаж байгаа мэт санагдана. Бүх зүйл түүний хяналтаас гарч, файл нэг нэгээр арчигдсаар...

Хүмүүс компьютерээ хяналтаас алдангуут барьц алдахгүйг хичээж байлаа. Ерөнхийдөө тэд гараа бадайртал базаж, санаа зовсондоо тусламж гуйх зуур удирдлага нь чинэрсэн харцаар тэднийг ширтэнгээ ширээний тавцанг балбаж байв.

NASA-гийн компьютер сүлжээ хариуцсан менежер ажил дээрээ ирэнгүүт, бүхэл өглөөний турш утас нь хангинаж, компьютертэй холбоотой үл ойлгогдох үйл явдлыгажилтан бүр гомдолловол яана гэж та төсөөлж байна. Тэд хамгийн чухал судалгааны бичиг баримт компьютерээс алга болчихлоо гэвэл ямар байдалд орох вэ?

Энэ үед NASA-гийн салбар төвүүд төслийн төлөө хоорондоо байнга өрсөлддөг байсан муу зуршлыг улам лавшруулсан юм. Нислэгийн тодорхой нэгэн төсөл гарч ирэнгүүт тус бүр олон зуун ажилтантай хоёр эсвэл гурван төвүүд хүч мэдэн өрсөлдөнө. Бүх мэдээллийн сан, ажлын файлуудыг алга хийж, компьютерийг хяналтаас гаргах нь тендер болон түүний нилээд их хэмжээний санхүүжилтийг алдах сайн арга зам байлаа. NASA-гийн SPAN компьютер сүлжээний газрын хувьд энэ өдөр туйлын таагүйд тооцогдоно. Түүнчлэн Жон Макмахоны хувьд хар өдөр нь байв.

NASA-гийн Марилэнд дэхь Годдардын нэрэмжит Сансрын нислэгийн төвийн DECNET протокол менежерийн орлогч Жон Макмахон Годдардын төвийн 15-20 барилгуудын хооронд холбосон SPAN компьютер сүлжээний хэсгийг хариуцдаг байжээ. Макмахон 28-р байранд Годдардын Advanced Data Flow Technology Officeгэж нэрлэгдэх 630.4 код дээр ажилладаг. Годдардын судалгааны ажилтнууд тэдний компьютерт гарсан асуудлаар түүнийг дуудна. “Ажиллахгүй байна” эсвэл “эндээс сүлжээний хэсэгт орж чадахгүй байна” гэсэн хоёр өгүүлбэрийг тэр байнга сонсож байлаа.

SPAN буюу Space physics Analysis Network [үгчилбэл-сансрын физикийн анализ сүлжээ] нь дэлхий даяар 100,000 компьютерийн терминалийг холбосон сүлжээ юм. Одоо олон нийт чөлөөтэй ордог болсон интернеттэй адилгүй SPAN нь зөвхөн АНУ-ын Энергийн газар, их сургуулиуд зэрэг судалгааны институт, NASA-гийн эрдэмтэн судлаачдыг холбодог байв. Түүнчлэн SPAN-ны сүлжээнд холбогдсон компьютерийн техникийн үзүүлэлт нь интернетийн компьютерээс ялгаатай, өөр үйлдлийн систем хэрэглэдэг байв. Интернетийн ихэнх томоохон компьютерүүд Unix үйлдлийн систем хэрэглэдэг бол SPAN сүлжээ нь VMS үйлдлийн системтэй VAX компьютерүүдийг голчлон хэрэглэнэ. Сүлжээ бүхэлдээ интернет шиг ажиллах боловч компьютерүүд нь өөр хэлээр ярьдаг гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл интернет TCP/IP хэлээр “ярьдаг” бол SPAN сүлжээний компьютер DECNET-ээр ярина.

Ерөнхийдөө SPAN сүлжээг DECNET интернет гэж ч нэрлэдэг. SPAN-ий ихэнх компьютерийг Массачусетсийн Дижитал тоног төхөөрөмжийн корпорацид [Digital Equipment Corporation]-д үйлдвэрлэдэг тул DECNET гэж нэрлэжээ. SPAN сүлжээний DEC компьютер бүр 40 хүртэлх терминалтай байна. Зарим SPAN компьютер үүнээс ч олон терминалтай байж болно. Нэг DEC компьютер 400 хүнд үйлчлэх явдал жирийн үзэгдэл байв. 250,000 гаруй эрдэмтэн судлаачид, инженер, бусад зохион бүтээгчид сүлжээтэй холбогдсон компьютерийг хэрэглэж

байлаа.

Цахилгааны инженер мэргэжилтэй Макмахон NASA-гийн Сансар огторгуйн далд нууцын нээлт төслийн хэдэн зуун судлаачдын хэрэглэж байгаа компьютерийг хариуцна. Түүний COBE төсөл дээр ажиллаж байсан Годдардын 7-р байранд сонирхол татах зарим төслийг хэрэгжүүлж байв. Төслийн багийнхан сансар огторгуйн зурагчлал хийхийг оролдож байлаа. Тэд хүний нүдэнд харагдахгүй долгионы уртад хэмжилт хийхийг хичээжээ. 1989 оны 11-р сард COBE хиймэл дагуулийг NASA хөөргөх болно. Астрономын орчноор хязгаарлагдаж, эртний ертөнцөөс диффузлэгдсэн хэт улаан ба хэт богино туяаны радиацийг хэмжих нь тэдний гол зорилт байв. Халт сонссон хүнд “Орчлонгийн хэт улаан туяаны газрын зураг” гэж нэрлэж болох энэ төсөл орчин үеийн урлагийн шинэ төрөл мэт санагдах бизээ.

10-сарын 16-ны өдөр Макмахон ажилдаа ирэхэд SPAN төслийн байрнаас утасны дуудлага хүлээн авав. NASA-гийн SPAN сүлжээний хагасыг хариуцдаг Үндэсний сансар огторгуйн шинжлэх ухааны мэдээллийн төвийн Тодд Батлер, Рон Тенкати хоёр компьютер сүлжээгээр зөвшөөрөлгүй нь илэрхий, ямар нэгэн хачин үйлдэл хийгдээд байгааг илрүүлжээ. Энэ нь компьютерийн өт шиг санагдаж байв.

Компьютерийн өт [worm] бол компьютерийн вирустэй бага зэрэг төсөөтэй. Өт компьютер руу нэвтрэн орж, үйл ажиллагааг нь доголдуулдаг. Хэсүүчлэх боломжтой ямар ч компьютерийн сүлжээгээр аялах өт сүлжээнд холбогдсон систем рүү довтлох оролдлого хийнэ. Хэрэв компьютерийн системд аюулгүй байдлын шаардлага хангахгүй цоорхой байвал түүгээр мөлхөж, системд нэвтрэнэ гэж ойлгож болно. Ингэж байхдаа системийг бүхэлд нь дарангуйлахыг оролдож, компьютер хэрэглэгчид мессэж илгээх зэрэг олон тооны үйлдлийг урьдчилан зааварчилсны дагуу хийдэг. Өт нь вирусны адил нэг компьютерээс нөгөө рүү өөрөө бие даан шилждэгээрээ бусад компьютерийн програм хангамжаас ялгарна. Тэр шинэ систем рүү нэвтрэнгүүтээ дахин өөр систем рүү өөрийгөө шилжүүлж хөдөлнө. Гэхдээ өт нь вирустай адилхан файл ба програм хангамжтай наалдаж, түгждэггүй онцлогтой. Компьютерийн “өт” гэсэн хэллэг Жон Бруннерийн 1975 оны сонгодог зөгнөлт зохиолоос улбаатай. Уг зохиолд ард түмнээ дарангуйлахыг хүссэн хэмжээлшгүй эрхт засгийн газрын компьютерийн хүчирхэг сүлжээнд, “туузан өт” нэртэй програмыг засгийн газрын эсрэг тэмцэгч нэгэн програмч залуу зохиож, нэвтрүүлсэн тухай гардаг. Түүний зохиосон програмын өтийг устгахын тулд засгийн газар компьютерийн сүлжээгээ унтраан өөрийн хяналтаа алдсан тухай өгүүлдэг юм.

Жинхэнэ хор хөнөөл учруулах өттэй таарч байгаагүй VMS компьютер сүлжээний менежерт тохиолдсон адал явдал Бруннерын номонд өгүүлэх зүйлтэй туйлын ойрхон санагдана. 1980 оны сүүлч хүртэл өт бодит биелэлээ олоогүй, компьютер лабораторын хүрээнд л яригдаж байсан юм. Жишээлбэл компьютерийн тоног төхөөрөмжийг илүү үр нөлөөтэй ашиглахын тулд Хегох-ийн судлаачид хэдэн өглөгч буянтай өтнүүдийг бий болгож байв. Тэд “хотоор зар тараагч өт”-ийг боловсруулж чухал зарлалуудыг сүлжээгээр дамжуулан илгээж байлаа. Мөн “онош тавих” өт сүлжээгээр байнга хэсүүчлэн, машинд гарсан эвдрэл гэмтлийг шалгах үүрэг гүйцэтгэнэ.

Зарим програм зохиогчдын хувьд компьютерийн өт бодит амьдрал дээрх өттэй ижилхэн ажээ. Бие даан сүлжээгээр хэсүүчилж, өөрийгөө дахин бий болгох дээд зэргийн чадалтай өт

бол ухаалаг шинжийг агуулна. NASA-гийн компьютерийн системийг дарангуйлсан хор хөнөөлтэй өт үхэшгүй, бүтээлч төрлийнх мэт санагдах агаад компьютерүүдэд өөрийнхөө хэсгийг саадгүй тараан цацна.

NASA-гийн компьютерийн дэлгэцнүүд дээр WANK баннер гарч ирэхээс өмнө тэд зөвхөн хоёр төрлийн өгийг мэддэг байлаа. Тэдний нэг нь арван хоёр сараас бага хугацааны өмнө интернет Unix дээр үндэслэсэн интернетийг халдварлуулсан RTM өт байв. Нөгөөх нь Эцэг Христмас нэртэй анхны VMS компьютерийн өт юм.

Эцэг Христмас бол жижиг, энгийн өт бөгөөд аялж байгаа компьютер сүлжээнд ямар нэгэн байнгын гэмтэл учруулдаггүй байв. 1988 оны Зул сарын баярын өмнөхөн зохион бүтээгдсэн өт маань агуу өдрийг хүлээн олон зуун VMS компьютерт нэвтрэхийг оролдоно. Зул сарын баярын өдрийн өглөө энэ төрлийн өтнүүд нойрноос сэрж, ажилдаа зоригтой орлоо. Тагтан дээрээс чихэр шидэхтэй адилхан өтөөр халдварласан компьютерийн бүх хэрэглэгчдэд Зул сарын баярын мэндчилгээг урсгаж гарав. Түүний хүрч болох бүх газарт Зул сарын мэндчилгээ аваагүй хүн үлдсэнгүй. Ажлаа хийж дууссан өт замхран алга боллоо. Эцэг Христмас өттэй тэмцэх үндсэнбагийн нэг гишүүн нь Жон Макмахон байжээ. 1988 оны Зул сарын баяраас хэдхэн хоногийн өмнө оройны 4 цагийн орчимд Макмахоны дохиоллын мониторинг хийдэг програм доголдож эхлэв. Анхааруулах хонхны дууг өдөөж байгаа орж ирсэн арав гаруй холболтыг даган шалгахыг Макмахон оролджээ. Шугамын нөгөө үзүүрт хүн байхгүйг тэрээр шуурхай тогтоолоо. Цааш үргэлжлүүлэн шалгасны дараа өөрийн системд HI.COM код гэж нэрлэдэг гадны програм байгааг илрүүлэв. Түүнийг уншиж байх зуур шугамд холбоотой байгаа принтрээс HI.COM кодийн хуудсууд урсаж гарлаа. Тэр ихэд сандарчээ. Энэ бол өт байна! гэж тэр бодов. Гэхдээ Макмахон урьд өмнө хэзээ ч ийм өт харж байгаагүй юм.

Тэр компьютерийнхээ процессор руу гүйн очиж, системээ сүлжээнээс аль болох хурдан салгав. Магадгүй тэр зохих ёсоор ажиллаагүй байж болох авч үүнийг буруу гэж бодсон хүмүүс түүн рүү хашгичахаар байлаа. Сүлжээний өөрийн хэсгийг хаасны дараа Макмахон дотуур сүлжээний газар руу мэдэгдлээ. Хэвлэгдсэн цаасыг авч, сүлжээний газар руу бааз дундуур хөндлөн гулд давхисаар очиж, шөнө болохоос өмнө бусад менежерүүдтэй хамтран өгийг зогсоох арга замыг хайжээ. Тэрээр Эцэг Христмасыг даган мөшгисөөр өгийг тавьсан систем байрлах газрыг Швейцарь гэж тогтоожээ. Гэхдээ тэд өгийг бий болгосон хүнийг хэзээ ч олж чадаагүй юм.

Эцэг Христмас бол жирийн өт бөгөөд системийн орчинд үүрд үлдэхгүй учраас аюултайд тооцогдохгүй. Энэ өт тодорхой өдөр идэвхждэг програм байлаа.

SPAN төслийнхэн WANK довтлогчийг юу хийх чадвартайг одоохондоо мэдрээгүй ажээ. Тэд програмыг хэн зохиосон эсвэл хэн гаргасан болохыг мэдэхгүй юм. Гэхдээ тэд програмын хуулбарыг хийж авчээ. Макмахон програмыг задалж чадах болов уу?

Фуззфейс никнэмтэй, найрсаг зантай компьютерийн програмч Жон Макмахон өөрийгөө сорих дуртай нэгэн байв. Сониуч зан нь хөдөлж, асуудлын учрыг тунгаахыг зорьсон Макмахон тухайн үедээ өтний халдлагаас сэргийлэх хямралын төв болж хувирсан SPAN төслийн ажилтнуудаас довтлогч програмын хуулбарыг өгөхийг хүсэв. Өт ямар үйлдэл хийснийг төсөөлөхийн тулд долоон хуудас цаасан дээр хэвлэгдсэн source кодонд анализ хийж

ЭХЭЛЛЭЭ.

Урдны хоёр өт зөвхөн тодорхой компьютерийн систем, сүлжээнд л ажиллах чадвартай байжээ. Дээрх тохиолдолд WANK worm зөвхөн VMS компьютерийн систем рүү довтолсон байгаа юм. Харин Макмахон урд өмнө хэзээ ч харж байгаагүй source кодийг үзэв. “Овоолсон шпагетти гоймонг ухаж, нэгжих мэт санагдсан. Гоймонгийн нэг үзүүрээс татаж байна гэж төсөөлдөө. Энэ өт ийм зүйлийг л хийдэг юм. Та дараа нь тавганд үлдсэн хэсгийн орооцолдоог тайлах хэрэгтэй болно доо” гэж тэр хэлсэн гэдэг.

DCL буюу дижитал командын хэлээр бичигдсэн програм хангамж сайн зохион байгуулалттай хэв загварыг агуулах жирийн програмтай адилгүй байв. Жон компьютерийн кодны арав эсвэл арван таван мөрийг доош цувуулан ажиглаж, дараагийн хэсэг ямар үйлдэл хийхээр оролдохыг мэдэхийн тулд програмын эхний хэсгийг дахин нягталж байлаа. Энэ өт NASA-гийн компьютерын системд ямар нөлөө үзүүлэх чадвартайг олж тогтоохын тулд тэрээр тэмдэглэл хөтөлж, зохих төсөөлөлтэй болохоор хүлээцтэй ажиллана.

Кеннедигийн нэрэмжит Сансрын төв дээр байгаа цөмийн эсрэг хөдөлгөөний бүлгийн хувьд хэцүүхэн өдөр тохиожээ. АНУ-ын Дүүргийн шүүхээс нааштай шийдвэр аваагүй тэмцэгчид бууж өгөхийг татгалзан, АНУ-ын давж заалдах шатны шүүхэд өргөдөл гаргав.

Давж заалдах шатны шүүх NASA-гийн талыг дэмжсэн шийдвэр гаргасан тухай мэдээг 10-р сарын 16-ны өдөр авчээ. Шүүхийн шийдвэрт дургүйцсэн Кеннедигийн нэрэмжит Сансрын төвийн үүдэнд дахин цугларсан тэмцэгчдээс найман хүнийг баривчилжээ. “Энэ бол сансарт цөмийн эрчим хүч болон цөмийн зэвсгийг хэрэглэх засгийн газрын төлөвлөгөөны эхлэл” гэж Шударга ёс, энхийн төлөө эвслийн Жейн Броун зарлан мэдэгдэв.

Кеннедигийн нэрэмжит сансрын төвийн дотор нөхцөл байдал мөн адил таатай байсангүй. Даваа гаргийн үдээс хойш NASA-гийн техникийн мэргэжилтэн бас нэгэнгэмтлийг илрүүлжээ. Сансрын хөлгийн удирдлагын системийн хурд болон бусад чухал мэдээллийн санг бичиж хураадаг хар хайрцагт эвдрэл гарав. Хөлгийн бүхээгний төхөөрөмжийг сольж байх зуур-Мягмар гаригт хөлөг хөөргөх товыг өөрчлөх бодолгүй байгааг агентлагийн хэвлэлийн төлөөлөгч эмэгтэй батлах ажээ. Нислэг үйлдэх өдрийг тэсэж ядан хүлээх NASA бүх асуудлыг хяналтандаа авсан байна.

Гэхдээ тэд цаг агаараас бусдыг зохицуулах чадвартай байсан юм.

Чейленжер хөлөг сүйрснээс хойш сансрын хөлгийг хөөргөх шийдэр гаргахад NASA-д хэцүү байлаа. Цаг агаарын хүндрэл шаардлагагүй эрсдэл бий болгох магадлалтай тул NASA цаг агаарын байдалд сэтгэл зовнино. Мягмар гаригт хөлөг хөөрөх үед цаг агаарын байдал сайхан байх магадлал 80 хувьтай гэж цаг уурчид урьдчилан мэдээлжээ. Цаг агаарын долоо хоногийн тойм таагүй мэдээ агуулсан учраас сансрын хөлөг товлосон цагтаа хөөрсөн нь дээр байлаа.

Мягмар гаргийн өглөө Галилеог бүтээсэн хүмүүс амьсгаа даран хүлээнэ. Хөлөг хөөрөх цаг үдийн 12:57-г зааж байлаа. Цөмийн эсрэг жагсагчид таг чимээгүй болов. Нөхцөл байдал таатай боломжийг амлах шиг санагдана... Галилео замдаа гарах цаг болжээ.

Гэтэл хөлөг хөөрөхөөс арван минутын өмнө аюулгүй байдлын дохиолол гэнэт ажиллав. Хэн нэгэн хүн хамгаалалтын бүсэд нэвгэрчээ. Аюулгүй байдлын албаны ажилтнууд гадны халдагч этгээдийг илрүүлэв. Гэхдээ тэд зэрлэг гахай орсныг тогтоосон юм.

Гахайг гаргасны дараа хөөрөх цаг ойртохыг хүлээлээ. Сансрын хөлгийн гүйх замаас зургаан километрийн зайд борооны үүл хуралджээ. NASA-гийн пуужин хөөргөх удирдлагын газрын захирал Роберт Сиек төлөвлөгөөт хугацааг уртасгахад, Атлантис хөлөгт 26 минутийн хугацаа үлдлээ. Удалгүй хөлгийг хөөргөх цагийг цуцалж, Лхагва гараг хүртэл хойшлуулах магадлал өндөр болов.

Цаг агаар ч нэг их өөрчлөгдөх шинж ажиглагдсангүй.

Үдээс хойш 1:18-д Атлантис хөлөг хөөрөхөд тавхан минут үлдсэн байхад Сиек хөлөг хөөрөх хугацааг Лхагва гараг хүртэл хойшлуулав.

SPAN-ий төв дээр нөхцөл байдал хүндэрчээ. Компьютер сүлжээний өт цаг өнгөрөх тутам илүү олон системд нэвгэрч, утсаар өгөх яаралтай дуудлага ихэссээр... NASA-гийн компьютерүүд бүгд цохилтонд өртжээ. SPAN төслийн ажилтнуудад яаралтай туслалцаа туйлын хэрэгтэй байв. Гадны програмд дүн шинжилгээ хийхэд хамаг анхаарлаа төвлөрүүлж, утсаар улангасах ажилтнуудыг нэгэн зэрэг тайвшруулах амаргүй ажил гарчээ. Хэн нэгэн этгээд тоглоод байна уу? эсвэл цагийн бөмбөг түр зуур сандаргав уу? Хэн үүний ард байж болох вэ?

WANK-ийн тухай мэдээллийг олохоор NASA-гийн ажилтнууд хөдөлжээ. Сансрын хөлгийн төв дээр болж байгаа эсэргүүцлийн үйл ажиллагааг зарим ажилчид мэдэж байгаа боловч үүнд ямар нэгэн бэлтгэлгүй байлаа. Галилеог хөөргөхийг эсэргүүцэгчид болон NASA-гийн компьютерт халдлага хийсэн үйлдэл хооронд ямар нэгэн холбогдол байгаа гэж NASA-гийн албаныхан итгэж байв. Хоорондын холбоотой байх магадлал өндөр боловч хариулт шаардлагатай өөр асуулт маш их байлаа.

SPAN-ны албан байр руу утсаар ярьж байгаа хүмүүсийн сэтгэл ихэд зовнижээ. Утасны нөгөө үзүүрт байгаа хүмүүс бүгд айж түгшсэн байдалтай сандарна. Тэр үед Маршалын нэрэмжит Сансрын нислэгийн төв дэхь NASA-гийн тусгай байрлалын SPAN-ий хэсгийг хариуцсан сүлжээний менежерүүдээс маш их дуудлага ирэв. Зарим нь сандарч, үлдсэн хэсэг нь 25 өөр администраторын тэвдэж гайхсан дуудлагыг аваад юу хийхээ мэдэхгүй хөшинө. Ийм асуудлын үед менежер ажлаа хүлээлгэн өгөх нь гарцаагүй бизээ.

SPAN-ий албан байр руу утасдаж байгаа хүмүүсийн ихэнх нь тохиолдсон асуудалтай холбоотой мэдээллээр цангаж байв. Хор хөнөөлтэй өт компьютер руу хэрхэн оров? Хир их хөнөөл учруулах бол? Халдвар авсан компьютерт байгаа шинжлэх ухааны судалгааны мэдээллийн бааз бүгд устах болов уу? Өгийг устгах ажлыг хийж чадах уу?

SPAN-ий компьютерүүдэд NASA-гийн асар их үнэтэй мэдээллийг хадгалдаг юм. Энэ мэдээллүүдийг нууцлах шаардлага байхгүй хэдий ч ач холбогдлын хувьд туйлын үнэтэй байлаа. Энэхүү мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийхэд олон сая хүн/цагийн ажил орсон билээ. Тиймээс NASA-гийн SPAN төслийн хямралаас гарах багийнхан их хэмжээний

мэдээллийн бааз устаж эхэлснийг сонсоод сандарчээ. Утасдсан хүн бүр ажлын файлуудыг өт устгаж байгааг хэлж байлаа.

Компьютерийн менежерийн хувьд ийм асуудал хамгийн аймшигт хар дарсан зүүд мэт санагдах агаад хямралын багийн түгшүүрт байдал хөдөлгөөнгүй батлагдах цаг ойртжээ.

Өтнүүд маш шургуу ажиллаж байлаа. Зарим компьютер дээр нэргүй мессэж илгээнэ, зарим нь хөгжилтэй, зарим ер бусын, нөгөө нь ёс журамгүй, бүдүүлэг араншин харуулна. Хэрэглэгч компьютертээ log in хийнгүүт л дэлгэцэн дээр нь: “Чи хархны уралдаанд оролцож түрүүлсэн ч харх хэвээрээ үлдэнэ гэдгийг санаж яв” гэсэн мессеж гарч ирнэ.

Эсвэл муухан шоглох аядан: “гэрлийн хурдаас хурдан зүйл гэж үгүй... Үүнийг батлахын тулд гэрэл асахаас өмнө хөргөгчний хаалгыг онгойлгохыг хичээ” гэсэн мессэжийг гаргана. Бусад хэрэглэгчдэд-сэтгэцийн эмгэгийг ажиглаж байгаа эрх баригчдын эсрэг хандаж байгаа мэт: “Холбооны мөрдөх товчоо чамайг ажиглаж байна” эсвэл “Анархистуудын төлөө саналаа өг” гэсэн мессэж дэлгэц дээр зурайн гарч байв.

Гэхдээ тэдгээр системүүдийн файлуудыг өт арилгаж байгаа юм шиг санагдахгүй байлаа. Магадгүй нүдэнд өртсөн файлуудыг устгаж байгаа илбэ мэт санагдах үйлдлийг тодорхой цаг хугацаанд, ялангуяа шөнийн цагаар тохиолдож болох бяцхан зугаа гэлтэй. Тэдгээр системд ажиллах компьютер хэрэглэгчийн санаандгүй дарсан товчлууур өтөөр ямар нэгэн өөрчлөлт, үйлдэл хийлгэж болох юм. Магадгүй систем дээр байгаа бүхнийг сэргээж болохгүйгээр устгах цуваа командыг нэг товчлуурын даралт эхлүүлж болох талтай.

NASA-гийн SPAN компьютерийн баг өттэй тэмцэлдэж эхэллээ. Өт тэдэнд ямар хохирол учруулсныг олж тогтоохын тулд зарцуулах минут тутамд өт NASA-гийн компьютерийн системийн гүнд гүнзгий нэвтэрч байв. Өгийг эмчлэх арга замыг хайсан цаг тутамд өтнүүд хайлт хийх, шалгаж хянах, кодыг эвдлэх, нэвтрэн орох үйлдлийг хийнэ. Системийн эмчилгээг бий болгоход нэг хоног алдвал эмзэг компьютеруудад хэдэн арван төрлийн шинэ өтнүүд дайралт хийх болно. SPAN-ны баг үүнийг задлан шинжлээд, хурдан ажиллах шаардлагатай байлаа.

Компьютерийн зарим менежерүүд маш их сандарсан харагдана. Калифорнийн Технологийн Институттай (Caltech) ойрын харилцаатай, 6500 ажилтантай NASA-гийн чухал төв болох Тийрэлтэт хөдөлгүүрийн лабораториос SPAN-ны албан байр утсаар мэдээ хүлээн авав. Тийрэлтэт хөдөлгүүрийн лаборатори сүлжээгээ тасалснаа мэдэгдлээ.

Энэ өт маш их эрсдлийг дагуулжээ. Компьютерыг сүлжээнээс тусгаарлах ажиллагаа хамгийн аюулгүй сонголт байлаа. NASA-гийн бусад салбарууд хямралыг хяналтандаа авах хүртэл SPAN DEC дээр үндэслэсэн харилцаа холбоог таслах юм. Энэ сонголт SPAN-ны багийн ажлыг улам хүндрүүлнэ. SPAN-тай холбоогоо тасалсан бусад олон газруудын адил Тийрэлтэт хөдөлгүүрийн лаборатори руу өгийг устгах програм хангамжийг илгээнэ гэдэг маш хэцүү асуудал болно. Бүх зүйлийг утсаар хийх шаардлагатай болжээ.

Тийрэлтэт хөдөлгүүрийн лаборатори NASA-гийн SPAN компьютер сүлжээний таван гол төвийн нэг байсан явдал бүр ч муу мэдээ байв. Үүнийг олон арван салаа бүр нь SPAN-ны өөр

нэгэн сайт руу хөтлөх томоохон дугуйны төв хэсэгтэй зүйрлэж болох юм. Тэдгээр бүх газруудыг сүүлний сайт гэх бөгөөд SPAN-тай холбогдсон лабораторийн сайтаас хамааралтай гэж ойлгоно. Тийрэлтэт хөдөлгүүрийн лаборатори сүлжээнээс тасрангуут сүүл сайтууд мөн адил тасарна.

Виржиниа дахь SPAN-ны албан байранд ажиллах хүмүүст дээрх асуудал хүндхэн бэрхшээлийг үүсгэнэ. Сүлжээний шугамыг роутын төвөөс салгана гэдэг NASA-гийн SPAN-ны аюулгүй байдлын тэргүүн Рон Тенкатид том асуудал байлаа. Харин тэр яах учраа олохгүй байв. Өргөн хэмжээний газар нутгийг хамарсан сүлжээний төв удирдлага болох SPAN бие даасан бусад төвүүд-өтгэй хэрхэн тэмцэх талаар зааварчилгаа өгөх тэнхээгүй байлаа. Төв бүр амиа бодох шаардлагатай болов. SPAN-ны баг өтийг хордуулах арга замын талаар зөвхөн зөвөлгөө өгч, хурдан хийхийг үүрэгдэхээс өөр туслалцаа үзүүлж чадсангүй.

SPAN-ны албан байрнаас Жон Макмахон руу утасдаж яаралтай хүсэлт тавив. Энэ удаад түүнийг хурдан ирж, хямралыг зогсоох арга хэмжээ нэн даруй авах шаардлага гаргажээ. Макмахоны ажлын байрнаас SPAN-ны оффис хүртэл 800 метр байдаг. DEC Net-ийн протокол менежер бөгөөд дарга Жероме Беннетт хүсэлтийг зөвшөөрөн толгой дохив. Хямралаас бүрэн гарах хүртэл Макмахон бүх ачааг үүрэх ёстой ажээ.

NASA-гийн SPAN төслийн байр буюу 26-р байшинд ирэхэд NASA-г хямралаас гаргах ажлын хэсгийн Тод Батлер, Рон Тенкати, Пат Сиссон нар хүлээж байв. Дейв Петерс, Дейв Стерн зэрэг NASA-гийн чухал хүмүүс хэрэгтэй цагт мөн хамтран ажиллажээ. Годдардын нэрэмжит Сансрын Үндэсний шинжлэх ухааны мэдээллийн сангийн төвийн дарга Жим Грийн (SPAN-ны дарга) нөхцөл байдлын тухай мэдээг цаг тутам шаардана. Эхэндээ NASA-гийн хүмүүсийг багтаасан ажлын хэсэг Годдарт дээр төвлөрч байв. Удалгүй өдөр хоног өнгөрөх тутам АНУ-ын засгийн газрын зарим ажилтнууд ажлын хэсэгт нэгджээ.

Өт NASA-гаас гадагш тархав. АНУ-ын Энергийн газрын “Өндөр-хүчдэлийн энергийн судалгааны хүрээлэн”-гийн компьютерийн сүлжээ рүү өт дайрав. SPAN сүлжээний бас нэгэн хэсгийг NEPNET гэж нэрлэдэг. Euro NEPNET ба Euro-SPAN мөн түүнтэй адил нэг хэсэг нь байлаа. NASA болон Энергийн газрын компьютер сүлжээний DEC компьютерүүд олон газраараа холбогдсон байв. Жишээлбэл судалгаа шинжилгээний лаборатори нь NEPNET болон NASA-гийн SPAN-ны сүлжээнээс компьютерүүд рүү нэвтрэх шаардлагатай. Ажлын таатай орчин бий болгохын тулд лаборатори хоёр сүлжээг шууд холбож ч болно. Үүний үр дүнд NASA-гийн SPAN ба Энергийн газрын NEPNET сүлжээнүүд нэгэн аварга том сүлжээг үүсгэн, өтийг чөлөөтэй сэлгүүцэх боломжийг олгожээ.

Энергийн газар компьютерүүд дээрээ нууцын зэрэглэлтэй мэдээллийг хадгална. Маш нууц ангиллын материалууд шүү. Энергийн газрыг дотор нь хоёр хэсэгт хуваадаг. Эхнийх нь иргэний энергийн төслүүд дээр судалгаа шинжилгээ хийнэ. Нөгөө нь атомын бөмбөг хийдэг хэсэг байв. Тиймээс “үндэсний аюулгүй байдалд заналхийлэх” эрсдэл байдаг учраас Энергийн газар аюулгүй байдлыг хангах тал дээр маш их анхаарал тавина. Хэдийгээр NEPNET сүлжээ өөрийн холболтуудаар нууцын ангилалтай мэдээллийг дамжуулдаггүй байсан боловч компьютерийн мэргэжилтэн гадны довтолгоог илрүүлэнгүүт Энергийн газар асуудлыг шийдэх арга хэмжээг маш хурдан авчээ. Тэд VMS системийн компьютерийн аюулгүй байдлыг сайн мэдэх Кевин Оберманыг хамт ажиллуулав. Оберман Макмахонтой

адил компьютер сүлжээний аюулгүй байдал хариуцсан үндсэн ажилтан байгаагүй юм. Тэр Энергийн газрын санхүүжилттэй Сан Франциско хотын ойролцоох Лауренсе Ливерморийн Үндэсний Лаборатори буюу LLNL –ийн сүлжээний менежер ажилтай.

Лауренсе Ливерморийн Үндэсний Лаборатори голчлон цэргийн салбартай холбоотой судалгаа шинжилгээ хийнэ. Оддын дайны хөтөлбөрт зориулан лазерын зэвсэгзохион бүтээх, цөмийн зэвсгийн талаархи судалгаа хийх ажилд Лауренсе Ливерморегийн Үндэсний Лабораторийн эрдэмтэд хамаг цагаа зарцуулна. Энергийн газарт CIAC буюу Компьютерийн ажиллагааны сааталд зөвөлгөө өгөх бүлэг нэртэй аюулгүй байдлын мэргэжилтнүүдтэй ажилладаг байлаа. Гэхдээ тэд VMS дээр үндэслэсэн компьютерийн систем ба сүлжээний аюулгүй байдлаас илүүтэй Unix-ийн аюулгүй байдлыг хангах тал дээр мэргэжсэн ажээ. “Яагаад гэвэл сүүлийн хэдэн жилийн турш VMS-ийн аюулгүй байдалтай холбоотой хүндрэл маш бага гарч байсан бөгөөд VMS –ийг сайн мэддэг хүнийг урин авчирч байгаагүйгээс гадна тэд үүнд нэг их анхаарал тавьдаггүй байлаа” гэж Оберман дүгнэсэн юм.

VMS компьютерийн амгалан тайван өт байдлыг эвджээ. WANK өт NASA-гийн сүлжээгээр хөлхөж байхдаа Чикаго хотын ойролцоох Энергийн газрын Фермигийн нэрэмжит Үндэсний лабораторийн компьютер рүү хүчтэй довтолгоо хийж байв. Өт компьютерийн олон систем руу нэвтэрч Фермилабийн ажилтнуудыг зовоосон байна. Тэд Компьютерийн ажиллагааны сааталд зөвөлгөө өгөх бүлэг (CIAC) руу утасдаж Обермантай холбогдох үед 10-р сарын 16-ны өглөө болж байв. Тэд WANK өтөндзадлан шинжилгээ хийлгэн, хир зэрэг аюул учруулж болохыг мэдэхийг хүсчээ. Мэдээж өгийг хэрхэн устгах талаар асуух нь гарцаагүй байлаа.

Энергийн газрын мэргэжилтнүүд 10-р сарын 14-нд өт орж ирснийг илрүүлжээ. Цаашдын задлан шинжилгээгээр өт 13-ны өдрийн Баасан гарагт нэг өдрийн өмнө идэвхтэй ажилсныг олж тогтоов. Өгийг зохион бүтээсэн хүн эсвэл хүмүүс муу ёрын тоог санаатайгаар сонгосон гэж Оберман үзэж байлаа.

Өт тивийн нөгөө тал, 3200 км-ийн зайтай газраас гаралтай болохыг Оберман задлан шинжилгээгээр тогтоожээ. Түүний шинэ танил Жон Макмахон болон хамтран зүтгэгчид нь бас адилхан дүгнэлт гаргав.

NASA-гийн систем болон сүлжээний менежерүүдийн цухалдсан асуултанд хариулж байхдаа Макмахон халдвар авсан компьютерийн өтний хуулбарыг авахыг хичээжээ. Түүнчлэн тэдний компьютерийн системийн log-ийг лавлан асууна. Ямар компьютер өтнөөс халдвар авсан байна? Халдвар авсан сайтнаас ямар компьютерүүд рүү халдсан байна вэ? Онолын хувьд logs нь өтний мөрөөр тойм зураг гаргах боломжийг NASA-гийн багт олгох юм. Хэрэв өтний замд компьютерийн систем байвал урьдчилан мэдэгдэж, аюулыг зайлуулах арга хэмжээ авна. Түүнчлэн саяхан өтний халдвар авсан компьютерийн хэрэглэгчид мэдэгдэн, шинэ өт үүсгэж, дайралт хийх шинэ бааз, талбар болон хувирахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Гэхдээ дээрх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байв. Хэрэв компьютерт өт нэвтрээд, дотор нь ажиллаж байх үед мэргэжилтэн өтний цааш явах замыг бус харин хаанаас ирсэн замыг л мөрдөх боломжтой. Ихэнх менежерүүд өөрсдийн компьютер дээр их хэмжээний log-уудыг хадгалаагүй нь байдлыг хүндрүүлэв.

Хэн компьютерт холбогдсон тухай мэдээллийг цуглуулах ажил маш чухал гэж Махмахон үзжээ. Тэр бусад компьютерүүдэд холбогдсон холболтын талаархи аюулгүй байдлын мэдээллийг аль болох их хэмжээгээр цуглуулах боломжтойгоор компьютерээ өөрчилж сайжруулсан аж.

VMS компьютерүүд дохио өгөх стандарт функцтэй үйлдвэрлэгдсэн боловч Махмахон сайн ажиллана гэж бодохгүй байв. “Сайн уу, эндээс сүлжээний холболт хүлээж авлаа” гэх мессэжийг VMS-ийн дохио өгөх функц компьютерийн менежерт илгээнэ. Харин сайжруулсан дохионы систем нь: “Сайн уу, эндээс сүлжээний холболт хүлээж авлаа. Сүлжээний нөгөө үзүүрт байгаа хүн файл дамжуулалт хийж байна” гэхээс гадна Махмахоны компьютерээс нөгөө компьютер руу хэдэн хэсэг, хэдэн битийн мэдээллийг шахаж чадахыг харуулсан мэдээллийг өгдөг байна. Харамсалтай нь NASA-гийн компьютер сүлжээний менежерүүдын олонхи нь аудит logs-ийг хэрэглэх тал дээр маруухан байжээ. Ихэнх хүмүүс компьютерт хэзээ, хэн нэвтэрсэн дэлгэрэнгүй мэдээллийг хадгалдаггүй учраас өгийг мөшгин хөөх ажилд хүндрэл гарлаа.

Харин SPAN-ны ажилтнууд өтөнд найр тавин бууж өгсөн NASA-гийн компьютерүүдийн logs-ийг маш сайн хадгалахыг хичээж байв. Өтний үйл ажиллагаа идэвхжиж байгаа тухай мэдээллийг хүлээн авах бүрд багийн гишүүд дэлгэрэнгүй мэдээллийг үзэг цаас хэрэглэн бичиж авна. Халдвар авсан компьютерүүдийн хаягнуудыг жагсаан бичиж, халдварын зэргийг тэмдэглэн, компьютер дээр хадгалж байлаа. Гэхдээ гараар бичиж авсан тэмдэглэл хамгийн найдвартай аргад тооцогдоно. Цаасан дээр бичсэн мэдээллийг өт арилгаж чадахгүй билээ.

Энергийн газар өтний дайралтанд өртсөнийг сонсонгуутаа Махмахон хяналтыг гурван цаг тутам хийж эхлэв. Хол газар орших хоёр бүлэг халдвар авсан компьютерийн мэдээллийг утсаар солилцож байлаа. Цаасан дээр гараар бичсэн мэдээлэлтэй адилхан утсаар ярих дуу хоолой өтнөөс ангид холбоо барих суваг болжээ. “Энэ бол хуучны системийн төрөл юм. Нөгөө талаар оршиж байгаа сүлжээнд бид найдах шаардлагагүй. Бидэнд довтолгоонд өртсөн сүлжээтэй адилгүй харилцаа холбоо шаардлагатай байлаа” гэж Махмахон хэлсэн гэдэг.

Компаний хэрэглэгчийн нийгэмлэг DECUS –ээр дамжуулан DEC-ийн янз бүрийн хэсгүүдтэй NASA-гийн SPAN багийн гишүүд холбоо тогтоов. Эдгээр тогтоосон харилцаа их тустай ажээ. 1989 онд 12 тэрбумын орлого давуулан хийснээ зарласан, 125,000 ажиллагсадтай компаний хүнд суртлыг амархан давна гэдэг хэцүүбайлаа. Олон нийтийн анхааралд байдаг NASA шиг байгууллагын WANK өтний хямралтай нүүр тулахыг том хэмжээний, нэр хүндтэй компани огт хүсэхгүй юм. DEC-ийн програм хангамжийг өтний амжилттай довтолгоотой холбон авч үзэх нь гарцаагүй асуудал билээ. Мэдээж ийм хямралийг хэн ч хүсэхгүй. DEC компьютер маргааны бай болсон ч хямралыг даван гарахад туслахгүй. Гаднаас нь өнгөц харвал компьютер үйлдвэрлэдэг компаний буруу мэт харагдана.

Хэрэв хэн нэгэн нь компаний доторхи техникийн мэргэжилтэнтэй холбоотой бол бодит байдалд өөр өнцгөөс хандана байх. Энэ явдал зургаан сарын өмнө агентлагтсая долларын өртөгтэй компьютер зарсан DEC-ийн залуу руу NASA-гийн менежер хүйтэн хөндий утасдаж байгаатай адилгүй юм. Өнгөрсөн сард хурал дээр зэрэгцэн суусан DEC-ийн залуу руу NASA-гийн ажилтан утасджээ. Тэр залуу бол NASA-гийн менежерийн хамтран зүтгэгч, найз байлаа.

Жон Макмахоны задлан шинжилгээгээр WANK өтний гурван хувилбар байгааг тогтоожээ. Сүлжээнээс цуглуулсан өтний дээжнүүдээс тусгаарласан тэдгээр хувилбарнилээд төстэй гэхдээ хувилбар бүр нилээд өвөрмөц ялгааг агуулах ажээ. Бусад компьютер руу нэвтрэхийн тулд өт өөрийгөө шинээр бий болгосон арга замаар тэдгээр ялгааг тайлбарлаж болно гэж Макмахон үзэж байв. Гэхдээ өтийг зохион бүтээсэн этгээд яагаад өөр олон хувилбарыг гаргасан бэ? Зөвхөн ганц хувилбарыг гаргаад тараачихаж болоогүй гэж үү? Өт зүгээр л нэг тавьсан сум шиг байсангүй, галзуурсан довтолгоог хийж байлаа. Тэд NASA-гийн бүх түвшний компьютер рүү олон талаас дайрч байв.

Өтний янз бүрийн хувилбарыг цаг хугацааны хувьд бага зэрэг зөрөөтэйгээр зохиосон байж магадгүй гэж Макмахон таамаглана. Магадгүй зохиогч эхлээд өтийг гаргаад дараа нь цохыг (bug) нээсэн байж болно. Тэр өтний програмыг дахин оролдож, бага зэрэг засварлаад дахиад сүлжээ рүү тавьсан байх. Магадгүй хамгийн эхлээд цохны програм таалагдаагүй байж байгаад түүнийг дахин өөрчилж, гуравдахь удаагаа сүлжээ рүү илгээсэн байж болно.

Харин хойд Калифорниад байсан Кевин Оберманы дүгнэлт өөр байлаа. NEPNET ба SPAN сүлжээгээр зөвхөн ганц төрлийн өт аялж байгаа гэдэгт тэр итгэж байв. Өт нэг компьютерээс нөгөөд шилжихдээ өөрчлөгдөн, зохицох чадвартай бөгөөд хуваагдаж төрөл бүрийн жижиг хувилбар болж байгаа мэт санагдана.

Макмахон ба Оберман хоёроос гадна өтний төрөл бүрийн хувирлыг илрүүлэхээр олон хүн ажиллаж байлаа. DEC-ийнхэн өтийг шалгах хангалттай шалтгаантай байв. WANK өт тэдний корпорацийн сүлжээнд дайралт хийжээ. Дэлхий даяар тарж байрласан салбар компаниуд, худалдааны оффисууд, DEC-ийн бүтээгдэхүүний үйлдвэртэй холбогдсон DEC-ийн хувийн компьютерийн сүлжээ Easynet-ээр өт мөлхөж эхэлсэн ажээ. DEC корпораци асуудлыг олон нийтийн дунд хэлэлцэхээс зайлсхийж байв. Гэхдээ Easynet сүлжээнд тархсан WANK өтний хувилбар бусдаасаа илт ялгаатай байлаа. Энэ өт кодчиллын хачин эгнээг хэрэглэсэн агаад тэрхүү эгнээ бусад хувилбаруудад байхгүй байв. Өт зөвхөн нэг газрыг орхиод аль болох олон компьютерийг дайран эзлэх зааварчилгаатай байлаа. Тэр DEC-ийн доторхи 48-р бүсийн компьютер руу ямарч тохиолдолд халдах ёсгүй ажээ. NASA-гийн баг энэ мэдээллийг ихэд эргэцүүлсний эцэст 48-р бүсийг харлаа. Энэ бол Шинэ Зеланд байв.

Шинэ Зеланд?

NASA ямар учиртайг тааж ядан эргэлзэнэ. Энэ довтолгоо үнэхээр хачирхалтай санагдаж байлаа. Хариулыг олохоор зөв чигт явсан SPAN-ны баг булан тойроод итгэлээ алдав. Шинэ Зеланд улсыг цөмийн аюулаас хол бүс гэж дэлхий даяар зарлахыг хэн нэгэн хүсчээ. Цөмийн зэвсэг тээвэрлэж байгаа болон цөмийн эрчим хүчээр явдаг АНУ-ын усан онгоцыг өөрийн боомтуудад орж ирэхийг эсэргүүцэх шийдвэрээ Шинэ Зеланд улс 1986 онд зарласан юм. Номхон далайн өмнөд хэсгийн үндэстний энэ мэдэгдлийн хариуд АНУ тус улын аюулгүй байдлыг хангах үүргээсээ албан ёсоор татгалзав. Хэрэв Шинэ Зеланд улс руу өөр нэгэн дайсагнагч улс халдан довтолбол АНУ зүгээр л хараад сууж байх болно. Түүнчлэн АНУ тагнуулын мэдээлэл солилцох, цэргийн хамтарсан хээрийн сургууль хийх ажиллагааг хүчингүй болгов.

АНУ асуудалд хэт болчимгүй хандсан гэж Австрали, Шинэ Зеландчууд дүгнэж байлаа. Шинэ

Зеланд эх орноосоо Америкчуудыг хөөж гаргаагүй, зөвхөн хүн амаа цөмийн зэвсэг эсвэл цөмийн дэлбэрэлтэнд өртүүлэхгүй байхыг л хүссэн билээ. Үнэндээ АНУ идэвхитэй хамтын ажиллагаагаа зогсоосноос хойш Шинэ Зеланд улс Вайхопай дахь тагнуулын баазаа ашиглахыг Америкчуудад хүлээн зөвшөөрсөн хэвээр байлаа. Тус улс АНУ эсрэг биш цөмийн эсрэг зогсож байсан юм.

Тиймээс Шинэ Зеланд улс цөмийн эсрэг үйл ажиллагаа явуулах маш сайн шалтгаан байж болох талтай. Энэ улс олон жилийн турш Францтай хамтран Номхон далайд цөмийн зэвсэг туршиж байсан. 1985 оны 7-р сард Грийнпийс олон улсын байгууллагын цөмийн эсрэг ажиллагааны хөлөг онгоц Аукландын боомтод зогсож байхад нь Францчууд дэлбэлжээ. Цөмийн туршилт хийсэн газар болох Муруроа Атолл руу хөвөх ёстой “Солонгын дайчин” хөлөг онгоцыг Францын тусгай албаны ажилтнууд дэлбэлж, Грийнпийс байгууллагын идэвхтэн Фернандо Переираг алжээ. Франц улс олон долоо хоногийн турш аллага үйлдсэнээ эсэргүүцэв. Дэлбэлэх төлөвлөгөөг Ерөнхийлөгч Миттеран сайн мэдэж байсан явдал Францчуудын нүүрийг улайгаж, үнэнийг цухуйлгалаа. Францын Батлан хамгаалахын сайд Чарльз Хенруг хүчээр огцруулж, Францын тагнуул, нууц ажиллагааны товчооны дарга, адмирал Пиерре Лакостег албан тушаалаас нь зайлуулав. Аукландийн шоронд тус бүр арван жилийн ял сонссон хорлон сүйтгэгч хоёр этгээдийг Шинэ Зеланд эргүүлэн өгсний нөхөн төлбөрт Франц улс 13 сая шинэ зеландын доллар төлж, уучлал гуйсан байна. Харилцан тохиролцсон ёсоор Хао Атолл дахь Францын цэргийн баазад хорлон сүйтгэгчдийг гурван жилийн турш хорих амлалтыг Франц улс авчээ. Хоёр жилээс бага хугацаа өнгөрсний дараа 1988 оны 5-р сард хоёр нууц ажилтан чөлөөтэй хэсэн тэнүүчилж байв. Хоёр ажилтны нэг ахмад Доминикуе Приеур Францад буцаж ирсний дараа түүнийг албан тушаал ахиулж командант цол олгожээ.

Эцэст нь байж болох нэгэн таамаглалыг Макмахон бодож олов. Шинэ Зеландыг өтний халдлагаас гадуур авч үзсэн явдал бол улс төрийн зорилготой мессэж гэж үзжээ.

WANK өт компьютерийн системд нэвтрэн оронгуут өөрийгөө хувилж, бусад компьютер руу илгээх зааварчилгатай байв. Өт сүлжээнд холбоотой компьютерт орсны дараа сүлжээгээр чөлөөтэй гулсан, эмзэг цэгийг хайж явдаг. Тэрээр өндөр түвшний компьютерийн эккаунт руу орохыг ихэд хүсэх боловч ихэнх тохиолдолд хэрэглээний ба үндсэн түвшний эккаунтыг эзэмдэнэ.

VMS системүүд нь олон төрлийн түвшний эккаунттай байдаг. Өндөр түвшний эккаунттай хэрэглэгч нь өөр компьютерийн хэрэглэгчийн цахим шууданг унших эсвэл тэр хэрэглэгчийн фолдероос файлыг устгах боломжтой байдаг. Түүнчлэн ийм түвшний эккаунттай хүн систем дээр компьютерийн шинэ эккаунт нээх, хаасан эккаунтыг дахин идэвхижүүлэхийг зөвшөөрнө. Мөн дээд түвшний эккаунттай хүн хэн нэгэн өөр хэрэглэгчийн пассвордыг өөрчлөх боломжтой юм. Компьютерийн систем эсвэл сүлжээг ажиллуулдаг хүнд системийг хэвийн ажиллагааг хангах боломжтой байхын тулд дээд түвшний эккаунттай байх шаардлагатай. Өт ийм төрлийн эккаунттай хэрэглэгчийн компьютерийг хайдаг нь хорлонт програмыг зохиосон хүн хүч чадал хаана байгааг сайн мэдэж байгаатай холбоотой билээ.

Өт ухаалаг бөгөөд аялах тусам ихийг сурж байх шиг санагдана. Сүлжээг туулах замдаа өтнүүд нийтлэг хэрэглэгдэх эккаунтын нэрсийн жагсаалтыг бий болгоно. Эхлээд нэвгэрч амжаагүй

байгаа системээс компьютер хэрэглэгчийн жагсаалтыг хуулж авахыг оролдоно. Үүнийг хийх амаргүй боловч системийн аюулгүй байдалхангалтгүйн улмаас өтний оролдлого амжилттай болдог. Дараа нь хуулж авсан жагсаалтаа одоогийн host дээр байгаа хэрэглэгчийн жагсаалттай харьцуулна. (host – файлууд, принтерүүд мэтийн хамтран эзэмших эх сурвалжид үйлчлүүлэгч компьютерийг нэвтрэх бололцоог сүлжээгээр дамжуулан хангадаг компьютерийг хэлнэ-орч)Хоёр жагсаалтанд давхардаж байгаа эккаунтын нэрийг олж тогтоогоод, өт өөрийн дотроо хадгалж яваа мастер жагсаалтанд нэмж, ирээдүйд шинэ системийг эвдэн орохдоо тэрхүү эккаунтыг дахин ашиглах тэмдэглэл хийдэг.

Энэ бол довтолгоо хийх ухаалаг арга бөгөөд ялгаатай компьютерүүд дотор дээд түвшний тодорхой экаунтууд стандарт нэрстэй байх хандлага байгааг өт зохиогч мэдэж байгаа хэрэг. Компьютерийг үйлдвэрээс зөөвөрлөхөөс өмнө “SYSTEM”, “DECNET”, “FIELD” нэртэй экаунтуудыг “SYSTEM” ба “DECNET” гэсэн стандарт пассвордтой хийчихдэг. Хэрэв урьдчилан програмчилсан экаунтыг компьютер хүлээн авсан менежер өөрчлөөгүй бол түүний компьютер аюулгүй байдлын томоохон эрсдэл гарахыг л хүлээх нигууртай.

Компьютер үйлдвэрлэгчийн экаунтын нэрсийг өт зохиогч тааж болох авч бүгдийг онож таагаад байх боломжгүй. Өтөнд зохицон, мэдрэх чадварыг өгснөөр зохиогч түүнийг маш хүчирхэг болгоно. Өт цааш дамжин тархах тутам улам ухаалаг, хүчирхэг болно. Өт өөрийгөө дахин хувилж шинэ үр удмаа бий болгоход тэр нь шинэ системд цөмрөн орохдоо илүү амжилт олсон, дэвшилтэт, хүчирхэг өт болон өөрчлөгдөнө.

Макмахон нэг өтний үр удамд задлан шинжилгээ хийгээд олж мэдсэн зүйлдээ ихэд гайхав. Өтийг задалж, бүтцийг нь шалгаж үзэхэд SPAN сүлжээний дээд түвшний экаунтын тухай мэдээллийн цуглуулгатай байлаа. Үнэндээ, өт зөвхөн стандарт VMS компьютерийн дээд түвшний экаунтуудыг түүгээд зогсохгүй бусад VMS компютерт шаардлагагүй боловч NASA-д нийтлэг хэрэглэгдэх экаунтуудыг судалсан байжээ. Жишээлбэл: POSTMASTER эсвэл MAILER экаунтын аль алинд шаардлагатай TCP/IP мэйлер төрлийн NASA-гийн сайтуудыг судалсан гэсэн үг. Тэдгээр нэрс өтний залгамжлагч удам дотор илэрхий харагдаж байхыг Жон олжээ.

Дээд түвшний экаунтыг эвдэн орж чадаж байгаа бол өт экаунтыг инкубатор шиг ашиглана. Өт өөрийн яг ижил хуулбарыг үүсгэж сүлжээнд байгаа компьютерүүд руу довтолно. Бүрэн удирдлагатай дээд түвшний экаунт руу өт нэвгэрвэл ямар хор хохирол учруулах боломжтойг олж тогтоохын тулд Макмахон болон SPAN-ны баг өтний кодны үлдсэн хэсгийг задлан шинжилж байв. Тэд өтний цаана хошин шогийн аястай мэдрэмж төрүүлэх мессэж байгааг оллоо. Өтний програмын нэг хэсгийг (subroutine) “find fucked” гэсэн нэртэй ажээ. (find fucked-үгчилбэл: бэлгийн харьцаанд орсныг олж илрүүл гэсэн утгатай-орч)

NASA-гийн менежерүүдийн асуултанд SPAN-ны баг өтний талаар аль болох дэлгэрэнгүй хариулт өгөхийг оролдоно. Улс орны алс зайдуу хэсэгт орших компьютерын менежерүүдэд хямралыг хяналтандаа оруулахад туслахыг хичээх нь хамгийн шаардлагатай ажил байлаа.

SPAN-ны багийн бусад гишүүдийн адил Макмахон утсаар ярьсан хүнийг тайвшруулахыг оролдож, тэдний системд хяналтаа тогтоосон өтний тархацыг олж тогтооход чиглэсэн асуултуудыг тавина. Эхлээд тэдний системд ямар шинж тэмдэг ажиглагдаж байгааг асуув.

Хямралт нөхцөл байдал үүссэн үед та алх барьж байвал бүх зүйл хадаас мэт харагдана. Системд учирсан асуудал өөр бусад шалтгаанаас бус зөвхөн өтнөөс улбаатай гэдгийг тогтоохыг Макмахон хүсэж байлаа.

Хэрэв дэлгэцэн дээр гэнэт гарч ирэх нууцлаг үгнүүд л тэдний асуудал болж байгаа бол хөрш системд нь өт амжилттай нэвтэрч, компьютертийг эзэмшилдээ авахаар өдөөн хатгаж байна хэмээн Макмахон дүгнэжээ. Эдгээр мессэж нь хүлээн авагчийн эккаунт өтөнд олзлогдоогүй байна гэдгийг илэрхийлнэ. Гэхдээ одоохондоо шүү дээ...

VAX/VMS-ийн компьютерүүд нь онлайн холбоо барихад хэрэглэх Phone гэж нэрлэдэг функцтэй. Жишээлбэл NASA-гийн ажилтан нь өөр компьютер дээр байгаа хамтрагч руу хонх цохиж нөхөрсөг чатыг онлайн дээр хийж болно. Чат хийх нөхцөл бодит цаг хугацаанд боловч дуугаар бус харин компьютерийн дэлгэц дээр шивэх маягаар хийгдэнэ. VMS Phone нь хэрэглэгчид мессэж илгээх боломжийг өтөнд олгоно. Өт phone протоколыг ашиглан жирийн дуудлагыг хийдэг. Гэхдээ чатыг эхлүүлэхийн оронд тэр компьютер руу хожмоо Fortune Cookie File гэж сүрхий нэрлэгдсэн богино үгнүүдийг илгээнэ. Fortune Cookie File-ийг үгчилбэл дотроо бичигтэй жигнэмэгнээс азаа үзэн сугалах файл гэсэн утгатай бөгөөд урьдчилан програмчилсан сануулгууд эсвэл 60 орчим мэдэгдлийн цуглуулга байдаг.

Зарим тохиолдолд “өт” ажилтныг сандаргаж эхэлбэл компьютерийн Phone функцийг унтраах хэрэгтэй гэж Макмахон зөвлөж байв. Гомдол гаргасан хэдэн менежерт “Phone-ийг эсвэл амар амгаланг сонго” гэсэн ойлгомжтой зөвөлгөөг Макмахон өгнө. Мэдээж ихэнх нь амар амгаланг сонгоно.

Анхны задлан шинжилгээг дуусгасны дараа Макмахон сайн ба муу мэдээтэй болов. Сайн мэдээ нь: NASA-гийн компьютер хэрэглэгчдэд ойлгуулж байгаа члан файлуудыг устгаагүй харин тэдний мэдээллийн санг delete хийж байгаа мэт дүр үзүүлж байгаа аж. Өгийг зохиогчид бол практикийн томоохон доог тохуу хийгчид... NASA-гийн мэргэжилтнүүдэд бол толгойны өвчин, зүрхэнд цус хуруулсан ажиллагаа. Эцэстээ зүрхний шигдээс болох халдлага...

Муу мэдээ нь: өт дээд түвшний эккаунтыг хяналтандаа авангуут хэн нэгэнд (өгийг зохиосон хүнд гэж хэлж болно) NASA-гийн сүлжээнд нэвтэрч, илүү ноцтой дайралт хийхэд туслана. Хэрэв үйлдвэрлэгчийн үүсгэсэн FIELD эккаунтыг хаасан бол өт түүнийг эрж олоод дахин идэвхижүүлэхийг оролдож, FIELD пассвордыг суулгадаг. Түүнчлэн хамгийн багадаа 12 үсэгнээс бүрдэх DECNET-ийн стандарт эккаунтын пассвордыг өөрчлөхөөр програмчлагдсан байдаг. Товчхондоо өт системийн арын хаалгыг онгойлгохыг хичээнэ гэсэн үг.

Ингээд арын хаалгыг нь эвдэж, амжилттай нэвтэрсэн эккаунтын тухай мэдээллийг цахим мэйл хайрцагны төрлийн GEMPAK нэртэй эккаунт руу SPAN 6.59 зангилаагаар илгээнэ. Мэдээж өгийг зохиосон хакер шуудангийн хайрцагнаас мэдээлэл авах бөгөөд хожмын өдөр NASA-гийн эккаунт руу нэвтрэхдээ уг мэдээллийг ашиглана. Шуудангийн хайрцаг буюу mailbox-ийг хакер нууцаар “зээлсэн” гэдэгт эргэлзээ алга. Харин үүнд хууль ёсны эзэмшигч ихэд гайхах нь гарцаагүй.

Компьютерийн хакер иж бүрэн шинэ асуудлын суурийг тавьжээ. Ганцхан хакерыг бодвол өт

асар их хурдтайгаар шинэ эккаунт рүү нэвтрэх чадвартай. SPAN ба Энергийн газрын ажлын хэсгүүд өгийг тусгаарлаж авангуут түүнийг юу хийж чадахыг мэдэх болно. Хэдий тийм боловч хакерын үйлдлийг урьдчилан тааварлаж боломгүй юм.

Өгийг устгаснаар асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй гэдгийг Макмахон ойлгожээ. NASA ба Энергийн газрын сүлжээний бүх системийн менежерүүд өтний довтолгоонд өртсөн эккаунтуудын пассворд бүрийг өөрчлөх ёстой. Түүнчлэн өт дайрсан систем бүрийг нэг бүрчлэн шалгаж, хакерт зориулсан арын хаалга бий болгосон эсэхийг тогтооно. Системийн админ бүх арын хаалгыг хааж, цоожлох ёстой.

Хэрэглэгчийн username нь password-тойгоо адилхан гэсэн довтолгооны жирийн стратегийг ашиглан NASA-гийн системийг бусниулсан нь SPAN-ны багийг илүү ихээр зовоож байлаа. Компьютерийн хэрэглэгчийн эккаунтны нэр пассвордтой яг адилхан байгааг ашиглан NASA-гийн компьютерүүдэд бүрэн хяналт тогтоосон билээ.

Болсон явдалд SPAN-ны баг итгэхийг хүсэхгүй ч нотлох баримт хангалтай их байлаа. NASA-гийн нэг газраас ирсэн утасны дуудлаганд Тодд Батлер хариулна. Энэ бол муу мэдээ дагуулсан яриа байв. Тэр утсаа тавиад: “зангилаа саяхан довтолгоонд өртжээ” гэж багийн гишүүдэд хэлэв.

“Юуг вэ?” хэмээн Макмахон асуухад “Дээд түвшний эккаунт” гэв.

“Баларчээ.” Макмахон компьютер рүү түргэн очиж SET HOST хийн, NASA-гийн зайдуу орших компьютерт холбогдлоо. “Танай системд албан ёсоор WANK хийлээ” гэсэн бичиг гарч ирэв.

Макмахон Батлер руу эргэн хараад: “Ямар эккаунт руу?” гэж асуухад нь “Тэд SYSTEM гэж бодож байх шиг байна” гэж Батлер хариуллаа.

Хурцадмал байдал түгшүүрт байдлаар солигдов. Багийнхан туслаж чадсангүй.

NASA дээд түвшний SYSTEM эккаунтанд SYSTEM пассвордыг хэрэглэдэг байв. Энэ бол уучилж болшгүй алдаа. NASA бол ертөнц дээрх агуу том техникийн оюун санааны цуглуулга мөртлөө компьютерийн аюулгүй байдал нь өсвөр насны хөвгүүн хакердчих хэмжээнд байх гэж...

Компьютерийн аюулгүй байдлын талаар системийн менежерийн хамгийн эхэнд сурах ёстой зүйл бол username, password –ыг ижил үгээр хийхгүй байх явдал юм. Гэнэхэн хэрэглэгч ийм алдааг гаргах үе байна. Харин дээд түвшний эккаунттай компьютерын системийн менежерийн хувьд юу хэлэх билээ.

Өтний ард байгаа хакер сэтгэл муутай хүн үү? Магадгүй үгүй бололтой. Хэрэв өтний зохиогч хүсэх юм бол NASA-гийн бүх файлуудыг устгахаар WANK өгийг програмчилж болох байлаа. Бараг л харсан болгоноо хядах боломжтой програмчилж болно гэсэн үг.

Үнэндээ өтнүүд зохиогчийн хүсэж байгаагаас бага хэмжээгээр тархаж байгаа мэт санагдаж

байв. WANK өт хэд хэдэн даалгавар хийхээр бүтээгдсэн боловч заримыг нь гүйцэтгээгүй байлаа. Өтний чухал хэсэг ажиллаагүй байна. Энэ доголдол бол тохиолдлын асуудал биз гэж Макмахон итгэжээ. Жишээлбэл: Хэрэв эккаунт эзэмшигч пассвордны хэсгийг хоосон үлдээвэл пассвордгүйгээр эккаунт руу нэвтрэхээр өт програмчлагдсан байгааг түүний задлан шинжилгээ харуулсан юм. Өтний програмын бүтцийг задлангуут програмын тэр хэсэг зохих ёсоор ажиллахгүй байгааг тэр олжээ.

Гэсэн хэдий ч хуваагдсан зарим хэсэг нь сайн ажиллахгүй байгаа WANK өт АНУ-ын засгийн газрын агентлагуудын дотор томоохон хямралыг тарьж чадсан билээ. VMS-ийн олон жилийн туршлага хуримтлуулсан DCL програмч хүн энэ өгийг ашиглан юу хийж чадах бол гэдэгт Жон ихэд сэтгэл түгшиж байв. Ийм туршлагатай хэн нэгэн хүн их хэмжээний хор хохирол учруулж чадна. Хэрэв WANK өт ямар нэгэн ноцтой довтолгооны эхлэл байвал яах бол? Үүнийг эргэцүүлэн бодоход тийм ч аятай санагдахгүй ажээ.

WANK өт хор хөнөөлтэй үйл ажиллагаа явуулах санаа зорилго байхгүй мэт харагдах боловч SPAN-ны ажлын хэсэгт хүнд дарамт учруулсан юм. Макмахоны задлан шинжилгээгээр өтний илүү сэтгэл түгшээсэн талыг ил болгов. Хэрэв өт дээд түвшний эккаунт буюу SYSTEM-ийн эккаунтыг эвдэж чадвал системийн администратор руу хүргэх бүх цахим шууданг хаана. SPAN-ны удирдлага цахим анхааруулгыг хүргэх эсвэл өт нэвтэрсэн компьютерийг хэрхэх талаархи зөвөлгөөг тараах боломжгүйболно. Энэ асуудлаас гадна SPAN-тай холбоотой компьютерүүд шаардлагатай бусад мэдээлэл тарааж чадахгүй. Энэхүү хээрийн түймэртэй тэмцэхэд туслах цорын ганц арга бол ажилтнууд рүү утасдах явдал байв. Гэвч SPAN-ны төв оффис хэн рүү утасдахаа мэдэхгүй байлаа. Компьютер нь халдлагад өртөх үед администраторууд SPAN-ны төв байрны утасны дугаарыг ширээнийхээ ойролцоо бичиж тавьсан байх гэдэгт SPAN-ны ажлын хэсгийнхэн найдах л хэрэгтэй болжээ.

Өт бие даан хир хэмжээний хор хохирол учруулж болохыг Макмахоны эхний задлан шинжилгээ тоймлон харуулав. Харин менежерүүд өөрийн системд өтнөөс шалтгаалсан алдааг хир зэрэг учруулах вэ гэдгийг хэмжих боломжгүй байлаа.

WANK өт мэдээллийн баазыг устгасан мэт дүр үзүүлж байгаа гэсэн Жоны дүгнэлтийг SPAN-ны оффис руу утасдсан нэгэн компьютерийн менежер эсэргүүцжээ. Өт түүний систем рүү довлоод зогсохгүй бүхэлд нь устгачихлаа гэж тэр гомдоллож байв. “Өт бол тоглоом хийж даажигнасан шинжтэй байгааг түүнд хэлэхэд итгэхгүй байсан. Тэр системийг дахин эхнээс нь уншуулсан” гэж Макмахон хэлэв. Reinitialised нь системийг дахин эхнээс уншуулах буюу системийг цоо шинээр суулгана гэсэн үг. Ингээд халдвар авсан компьютер дээрх бүх зүйлийг устгаснаар NASA-гийн ажилтнуудын мэдээллийн бааз алга болно. Үнэндээ бол өтний арилгаж байгаа дүр үзүүлсэн үйлдлийг тэр өөрөө бодитоор хийчихжээ.

Харамсалтай нь тэр менежерийн системд байгаа мэдээллийн баазын хуулбарыг SPAN-ны ажлын хэсэгт хэзээ хадгалж байгаагүй юм. Түүний компьютер өтөөр халдварлагдсан гэдгийг хүртэл хэзээ ч нотлож чадахааргүй болжээ.

Макмахон бүхэл өдрийн туршид байнга хангинах SPAN-ны утсанд хариу өгч, өтний тухай NASA-гийн тайланг бичиж байв. Тэрээр сүлжээний орчинд довтолгоо хийж байгаа талаар криптик цахим мессэж байрлуулсныг Кевин Оберман уншжээ. Сүлжээнд WANK өтний эзэн

хяналтаа тогтоогоод аятай мөчийг хүлээж байгаа эсэхийг хэн ч мэдэхгүй учир мессэжийг хянамгай тавих учиртай. Хэсэг хугацааны дараа Макмахон, Оберман хоёр шугмын утсаар холбогдож, задлан шинжилгээний болон өөрсдийн санал бодлын талаар мэдээлэл солилцов.

Нөхцөл байдал үнэхээр няцмаар байлаа. Макмахон, Оберман хоёр өтийг устгах програмыг амжилттай бичиж дуусгасан боловч NASA-гийн SPAN ажлын хэсэгт бас нэгэн асуудал тулгарав. NASA-гийн бүх хэсэг рүү өтний алуурчинг илгээх ажил санасныг бодвол илүү хэцүү байв. Учир нь SPAN сүлжээний шинэчлэгдсэн, тодорхойтойм зураг тэдэнд байхгүй ажээ. SPAN системийн төвлөрсөн тойм зураг гаргах санааг NASA дэмжээгүй юм. WANK өт дайралт хийхээс хэсэг хугацааны өмнө системийг зурагчлахыг нэгэн менежер оролдож байсныг Макмахон санаж байв. Түүний чармайлт системийн олон дохиоллыг санамсаргүй идэвхижүүлсэн учраас зорилгоо чимээгүйхэн орхиж, дахиад хийхгүй гэж хэлжээ.

Ажлын хэсгийнхэн менежерүүдийн утасны дугаарыг олж авангуут тэрхүү мэдээлэл аль хэдийнээ хуучирсан байдаг байв.

“Үгүй ээ, тэр энд ажиллаж байсан, гэхдээ жилийн өмнө ажлаасаа гарсан.”

“Үгүй ээ, Бидний компьютерт ямар нэгэн асуудал гарвал утасдах шаардлагатай хүмүүсийн дугаар байхгүй. Энд янз бүрийн газарт компьютертэй ажилладаг хүмүүс их байдаг.”

Дээрх яриаг Жон утасны нөгөө үзүүрт байгаа хүнээс байнга сонсоно.

Сүлжээ төвийн зохицуулалтгүй, замбараагүй болжээ. Годдард дахь төв байранд хэлэхгүйгээр АНУ-ыг хөндлөн гулд хэрсэн NASA-гийн төвүүд SPAN руу анхаарлаа хандуулав. Хүмүүс нэр байхгүй сүлжээн дэхь компьютерийн зангилаанаас хямралын төв рүү утасдаж байлаа.

“Харанхуйгаар аюулгүй байдлыг хангах” гэж компьютерийн аюулгүй байдлын хүрээнд нэрлэдэг философийг тэдгээр хүмүүс хэрэгжүүлжээ. Компьютерийн систем оршиж байгааг хэн ч мэдэхгүй, нэр өгөөгүй, SPAN сүлжээний зурагчлал болон жагсаалтанд ороогүй бол хакерууд болон компьютеруудын дайснуудаас хамгаалагдана гэж тэд төсөөлжээ.

“Энд, манай системд хачин зүйл тохиолдоод байна” гэж хэлэх системийн менежерүүдийн яриаг Макмахон олон удаа сонсов. “Энд гэж хаана вэ?” гэсэн асуулт Жоно хэлэх дуртай үгс болжээ. Мэдээж SPAN-ны оффис тэдгээр компьютерийн систем оршиж байгааг мэдэхгүй бол тэдний менежерүүдэд өтний тухай анхааруулга илгээх боломжгүй болно. Эсвэл өөрсдийгөө хэрхэн хамгаалах, шинээр зохиосон өтний эсрэг програмыг өгөх, өтийг бүтээсэн этгээдэд мэдээлэл дамжуулах, эккаунтын нууц хаалгыг битүүлэхэд туслах зэрэг үйл ажиллагааг хийж чадахгүй.

Учир нь олдохгүй нөхцөл байдал бий боллоо. Өтийг хэн зохиосон байж болох талаар Макмахон их бодож байв. Уг програмыг бүрэн дуусгахаас өмнө тавиад явуулчихсан юм шиг санагдана. Түүний зохиогч эсвэл зохиогчид асуудлыг хэрхэн шийдэх талаар нилээд зэгсэн, сонирхолтой санааны цуглуулгатай боловч түүнийгээхээ ч зохих ёсоор дуусгаагүй мэт санагдсан ажээ. Довголгоо хийх стратегиа байнга сайжруулах зааварчилгаатай өт тэрхүү зорилтоо хэзээ ч бүрэн дүүрэн биелүүлж байсангүй. Програмыг урт хугацааны турш амьд байлгах явдлыг баталгаажуулан, алдааг зохицуулж янзлах хангалттай кодыг өт агуулаагүй

байв. Эккаунтын нэр, паролдыг олзлохын хажуугаар mailbox-ийг амжилттай эвдэж нэвтэрсэн эккаунтын хаягуудыг өт илгээхгүй байлаа. Энэ бол үнэхээр ер бус байв. Ямар компьютерийн системд хэрэглэхийг огт мэдэхгүйгээр паролд ба эккаунтын нэрийн хэрэгцээ байна гэж үү?

Нөгөө талаар өтний эзэн үүнийг санаатайгаар хийсэн бололтой. Магадгүй WANK өт хэдэн компьютерт амжилттай нэвтэрч чадах вэ гэдгийг дэлхийд харуулахыг тэр хакер хүссэн байх. Гэхдээ халдвар авсан хэсэг бүрийн хаягийг багтаавал админий ажлыг хялбарчлах болно. Тэд өтнөөс салгах шаардлагатай газруудын жагсаалтыг гарган GEMPAK-ын цуглуулгыг захиалгат аллагын жагсаалт мэт хэрэглэх байсан юм. Боломжит онол хязгааргүй ажээ.

Макмахомын хэзээ ч сэтгэж байгаагүй зарим зүйлийг өт агуулсан байв. VMS компьютерт хэрхэн нэвтрэх талаар нилээд өргөн мэдлэгтэй Макмахом дайсагнасан програмын хүч чадлыг биширчээ. WANK өтөнд нилээд бүтээлч тал ажиглагдах боловч тууштай, тогтвортой шинж байхгүй аж. Өтний довтолгооны дараа WANK өтний програмыг бичсэн хүний тоо нэгээр зогсохгүй нэмэгдэнэ гэж компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд таамаглаж байв. Харин Макмахон үүнийг нэг хүний ажил гэж үзсээр байлаа.

Өтний эзэн анхны санаагаа хэрэгжүүлж эхэлсэн боловч хожмоо сатаарч, чиглэлээсээ хазайсан болов уу хэмээн санагдана. Гэнэт код бичихээ зогсоон, өөр замыг сонгосон учраас төгсгөлдөө хүрээгүй гэлтэй. Энэ өт сэтгэцийн эмгэгтэй гэмээр бүтэцтэй, хаа сайгүй үсчиж байв.

Өт юу хийх чадвартайг олж тогтооход саад хийхийн тулд хакер санаатайгаар ингэсэн байх гэж Макмахон таамаглана. Магадгүй код анхандаа шугаман, сайн цэгцтэй байсан биз. Дараа нь зохиогч бүтээлээ хэдэн хэсэгт таслан, дунд хэсгийг дээд хэсэг рүү, дээд хэсгийг доод хэсэг рүү зөөж, нягт зохицолдоогүй багц код болгон “GO TO” команд өгсөн байх. Магадгүй өтийг хамгаалахын тулд үймж бужигнасан шинжтэй болгосон хакер маань DCL-ийн нилээд чадварлаг програмч болов уу. Харанхуйгаар аюулгүй байдлыг ханганаа гэж.

Харин Оберман өөр үзэл бодолтой байв. Програмчилсан хэв загварт зарим хэсэгтээ ялгаа их байгаа нь хэсэг хүмүүсийн бүтээл байж болохыг илтгэнэ гэж тэр үзжээ. Компьютерийн програмчид код бичиж байхдаа онцын шаардлага байхгүй бол өөрийн хэв загварт жижигхэн олон өөрчлөлтийг оруулахгүй гэдгийг тэр мэднэ.

Кевин Оберман, Жон Макмахон хоёрын санаа зөрчилдөв. Тэд өөр өөрийн анализийг хийжээ. Оберман NEPNET-ийн томоохон сайтуудын нэг болох Fermilab дахь дотоод сүлжээг хариуцан ажиллаж байсан Марк Калеткаг авчирч, хянах ажиллагаанд давхар оролцуулав. Өт олон тооны ноцтой сул талын агуулах боловч бүслэгдсэн компьютеруудад нөлөөлөхгүйгээр хурдан арчихад төвөгтэй байлаа.

VMS-ийн компьютер үйлдлээ хийж эхлэх бүрт цорын ганц процессын нэрийг компьютер өгнө. Өт компьютерийн хэсэгт нэвтэрч оронгуугаа тэр компьютерт өөрийнх нь хувилбар ажиллаж байгаа эсэхийг шалгах үйлдлийг хамгийн эхэнд хийдэг юм. Үүнийг хийхдээ өөрийн процессын нэрсийг шалгана. Өтний процессыг NETW_ гээд дараа нь нийтлэг дөрвөн цифртэй тоогоор нэрлэнэ. Хэрэв шинээр орж ирж байгаа өт энэхүү процессын нэрийг олбол

өөрийнх нь хуулбар уг компьютерт ажиллаж байгааг мэдээд өөрийгөө устгадаг.

Урхины өгөөш үүний хариулт болох байх. Өт мэт харагдах програм бичиж, NASA-гийн бүх эмзэг компьютерүүдэд суулгана. Анхны анти WANK програм яг үүнийг хийж байлаа. Энэ програм SPAN-ны компьютерүүдэд чимээгүйхэн байрлаж, NETW_ процесс хийж байгаа мэт дүр үзүүлнэ. Ингэснээр WANK өтний жинхэнэ хувилбар орж ирэнгүүт түүний хувилбар мэт харагдаж хуурна. Хууртсан өт өөрийгөө устгах зааварчилгааны дагуу үүргээ гүйцэтгэнэ.

WANK өтний эсрэг анхны програмыг Оберман дуусгаж, Макмахон ажиллагаанд оруулжээ. Програм сайн ажилласан, гэхдээ Макмахом нэг том алдааг олж харав. Оберманы програм NETW_ процессын нэрийг шалгана. Гэхдээ SYSTEM group-ийн дор өт ажиллаж байгаа мэт дүр үзүүлнэ. Ихэнх тохиолдолд ийм байсан нь үнэн. Мөн байнга хэвээр байхгүй нь ч үнэн. Хэрэв өт өөр group-т ажиллаж байвал Оберманы програм хэрэггүй болно. Алдааг Макмахон тайлбарласны дараа Оберман: “Ээ бурхан минь, би яаж ийм зүйлийг орхиж чадав аа” гэсэн гэдэг.

Оберманы програм дээр үндэслэн Макмахон өөрийн WANK өтний эсрэг програмын хувилбарыг гаргаж, NASA-д тараахаар бэлдэв.

Үүнтэй зэрэгцэн Энергийн газарт зориулсан WANK өтний эсрэг програмыг Оберман сайжруулжээ. Даваа гаргийн шөнө Оберман өтний тухай цахим анхааруулгатай, халдвар аваагүй компьютерыг хамгаалахаар зохион бүтээгдсэн вакциныг илгээхэд бэлэн болов. Компьютерийн ажиллагааны сааталд зөвөлгөө өгөх бүлэг CIAC-аар тараагдсан түүний анхны цахим анхааруулганд:

“Компьютерийн ажиллагааны сааталд зөвөлгөө өгөх бүлэг CIAC

Зөвөлгөө өгөх тэмдэглэл

W.COM өт VAX VMS системд нөлөөлж байна.

1989 оны 10-р сарын 16, 18:37 PST Number A-2

Энэ бол жирийн хорхой бөгөөд их хэмжээний хохирол учруулж чадна.

Энэ өт амжилттай нэвтэрснээ хэн нэгэнд мэдэгдэх (мэйлээр) агаад саадгүй нэвтрэх цоорхой (FIELD account) үлдээдэг тул зүгээр устгаад орхих нь хангалтгүй. Та компьютерээ шалгаж, бүх эккаунтууд пассвордтой, пассворднууд нь эккаунтын нэртэй адилхан бус байлгахад анхаарах ёстой.

P. Кевин Оберман

Зөвөлгөө өгөх тэмдэглэл

NASA-гийн SPAN сүлжээ рүү DECnet-д холбогдсон VAX/VMS системээр дамжин WANK өт дайралт хийж байна. Өтний тархалтыг шалгасан эсэх нь тодорхой бус байна. Хэдэн өдрийн дотор энэ өт Энергийн газрын HEARNET зэрэг бусад систем рүү тархаж магадгүй. VMS

системийн менежерүүд одоо бэлтгэлтэй байх хэрэгтэй. Өт VMS компьютерүүдийг онилж байгаа бөгөөд зөвхөн DECnet-ийн сүлжээгээр дамжин тархана.

Өөрийгөө тархаахын тулд DECnet/VMS-ийн хоёр онцлогийг өт ашигладаг. Эхнийх нь компьютерт login хийх ID байхгүй хэрэглэгчдэд зориулсан DECnet-ийн default account. Өт өөрийгөө хувилан компьютер рүү нэвтрэхийн тулд DECnet-ийн default-ийг ашиглах ба дараа нь зайтай байгаа хуулбараа дуудахдаа DECnet-ийн “TASK 0”-ийг хэрэглэнэ. Түүнчлэн бүдүүлэг довтолгоо хийх зэрэг бусад олон онцлогтой.

Өт таны систем рүү амжилттай нэвтэрсний дараа .COM файлуудад халдвар тарааж, аюулгүй байдалд нөлөөлөх сул талыг ихэсгэнэ. Дараа нь тэдгээр эмзэг талыг сүлжээгээр дамжуулан цацна. Энэ нь санамсаргүй эсвэл бусад байдлаар файлуудыг гэмтээж болох юм.

Өтний задлан шинжилгээг Лауренсе Ливерморийн Үндэсний Лабораторийн Р.Кевин Оберман хийлээ. Задлан шинжилгээний хамт өтний одоогийн хувилбарыг хаах DCL програм багтаав. Хамгийн багадаа энэ өтний хоёр хувилбар оршиж байгаа бөгөөд дахиад шинээр хийгдсэн байж болно. Энэ програм хангамж аюулгүй байдалд нөлөөлөх илэрхий цоорхойг бөглөх цагийг танд олгоно. DCL програмаар хийгдэж болох олон зүйлийг бичсээр байгаа билээ. Хэрэв таны сайт ямар нэгэн нөлөөнд орсон бол CIAC рүү хандаж илүү дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

W.COM өтний тухай илтгэл

Р. Кевин Оберман

Инженерийн газар

Лауренсе Ливерморийн Үндэсний Лаборатори

1989 оны 10-р сарын 16 ” гэжээ.

Дараахь хэсэгт W.COM өтний үйлдлийг тодорхойлно. (одоогоор эхний хоёр хувилбар дээр хийсэн хяналт шалгалтыг орууллаа.) Өөрийгөө хувилах арга техник нь довтолгооны эх сурвалж, олж хураасан мэдээллээр кодыг бага зэрэг сайжруулах нөлөөтэйг харуулж байна.

Бүх задлан шинжилгээг аль болох хурдан хийсэн, гэхдээ үндсэн фактуудыг зөв гаргасан гэдэгт найдна. Эхлээд програмын тодорхойлолт байна.

1. Өтний эзэн нь програмдаа бүрэн нэвтэрдэг болохыг програм харуулж байна (унших, бичих, гүйцэтгэх, устгах)
2. Өтний өөр нэгэн хуулбар ажиллаж байгааг WANK өтний програм эхлээд шалгана. “NETW_” –ны эхний таван үсгэнд процесс хийж байх шиг санагдаж байна. Хэрэв дээрхтэй адил зүйл олдвол өөрийгөө устгаж (файлаа) процессоо зогсооно.

Тэмдэглэл

нэвтрэх оролдлогоо үргэлжлүүлдэг. Дараа нь зайтай орших систем дээр идэвхитэй байгаа хэрэглэгчийн жагсаалтыг авахдаа PHONE-ийг ашиглана. Өт тэдэн рүү PHONE-ний хонхыг дуугаргаж ажиллагаагаа үргэлжлүүлдэг.

11. Дараа нь програм хэрэглэгчийн (өтний эзэмшилд орсон компьютерийг оролцуулаад) “стандарт” харилцагчийн жагсаалтанд орсон, алс хол байгаа систем болон RIGHTSLIST файл руу нэвтрэх оролдлого хийнэ. Өт тэр эккаунттай адилхан нэртэй пассвордуудыг хайна. Тэр ийм эккаунтыг бүх мэдээллийг бичиж авдаг.

12. SYSUAF.DAT руу оролттой эккаунтыг өт хайна.

13. Хэрэв дээд түвшний эккаунт олдвол програм тэрхүү эккаунт руу өөрийгөө хуулбарлаж, ажиллагаагаа эхэлнэ. Хэрэв дээд түвшний эккаунт олдохгүй бол сонгож авсан системдээ олдсон бусад эккаунт руу өөрийгөө хуулбарлана.

14. Тухайн системтэй хийх ажлаа дуусангуут өөр системийг сонгон авч үйлдлийг давтана. (тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн үг)

Хариу арга хэмжээ

Дараах програм өтний довтолгоог хаана. Доорхи кодыг гаргаад, ажиллагаанд оруул. Энэ нь хамгийн бага нөөц дэмжлэгийг хэрэглэдэг. Програм NETW_BLOCK нэртэй процессыг бий болгож өт орж ирэхээс урьдчилан сэргийлдэг.

Зохиогчийн тэмдэглэл: Програм зөвхөн өтний энэ хувилбарт нөлөөлнө.

Мутацид орж өөрчлөгдсөн өтнүүдийг устгахын тулд энэ кодыг сайжруулах шаардлага гарна. Гэхдээ энэ програм өтийг устгаж чадахгүй ч гэсэн таны системийн аюулгүй байдлыг хангаж, өтний довтолгооноос хангалттай хугацаагаар хамгаалах болно.

Даваа гаргийн орой WANK өтний эсрэг програмын Макмахоны зохиосон хувилбар бэлэн болжээ. Гэвч програмыг NASA руу гаргахад нилээд хугацаа алдсан байна. Эхлээд ажлаа хийж гүйцэтгээд дараа нь хүнд суртлын шат дарааллаар алхахдаа албаны дарга нарын хөл дээр гишгэхгүйг хичээх шаардлагатай. Ер нь NASA-д ажиллана гэдэг бол тэнцвэржилтийг барих жүжиг мэт ажээ. WANK өтний эсрэг програмыг албан ёсоор гаргахад нилээд хэдэн өдрийг алджээ.

Энергийн газар хүртэл WANK өтний эсрэг програмыг ашиглах, NEPNET-ээр зөвлөмж тараахад өнөөх хүндрэлийг хуваалцав. 10-р сарын 17-ны үдээс хойш 17:54-д Оберман өтний тухай илтгэлийн сүүлчийн мөрийг бичих үед албан байрны шал чичирхийлжээ. Байшин хүчтэй чичирхийлж байлаа. Кевин Оберман 1989 оны Сан Францискогийн газар хөдлөлтийн дунд байв. Рихтерийн шаталбараар 7,1 баллын хүчтэй газар хөдлөлт Сан Франциског бүхэлд нь хамарсан аж. Чичирхийлэл зогссоны дараа Оберман ажлаа үргэлжлүүлэхээр компьютер дээрээ суув. Албан байрнаас бүх хүмүүсийг яаралтай гарахыг зарлах үед Оберман илтгэлийн сүүлчийн мөрийг шивж дуусгажээ. Тэр хэсэг тээнэгэлзсэнээ-газар хөдлөлт Лауренсе Ливерморын лабораторид мэдэгдэх үед ихэд сандарсан учир илтгэлийн сүүл хэсгийг

тааруухан бичсэн байж болно гэсэн тэмдэглэл хийгээд WANK өтний илтгэлийг илгээх гэсэн товчлуур дээр даран явуулж, барилгыг орхилоо.

Америкийн зүүн эрэгт байрлах SPAN-ны оффис өтний довтолгоонд өртсөн NASA-гийн салбаруудаас ирэх утасны дуудлагад хариулсаар байв. Өтгэй холбоотой асуудлыг мэдээлсэн салбаруудын тоо нэг долоо хоногийн дотор огцом өсчээ. Албаны хүмүүсийн мэдээлснээр WANK өтний довтолгоо хийж байгаа цар хүрээ тодорхойгүй гэсэн боловч Network World ба Computer world зэрэг худалдааны сэтгүүлд – өт цөөхөн компьютерт амжилттай нэвтэрсэн, магадгүй VMS дээр үндэслэсэн 60 орчим компьютер байх гэсэн мэдээлэл гарсан байна. SPAN-ны аюулгүй байдлын менежер Рон Тенкати: “NASA-гийн SPAN сүлжээний хэсэгт өт зөвхөн 20 компьютерт нэвтэрсэн” гэж мэдэгдсэн бол дотоодын өөр эх сурвалжаас авсан мэдээлэлд энэ тоог 250-300 орчим гэж дурьджээ. Тэдгээр компьютер тус бүр зуу эсвэл түүнээс илүү хэрэглэгчтэй. Дээрх тоо эргэлзээтэй байж болох ч сүлжээн дэхь бүх хүнийг оролцуулбал нийт 27,000 компьютерийн экаунт өтний муу нөлөөг их бага хэмжээгээр амсжээ. Яагаад гэвэл сүлжээний зарим хэсгийг off-line болгосон, эсвэл халдвар авсан компьютерээс login хийхээр дахин дахин оролдохдоо WANK өт тэдний компьютерийн үйл ажиллагааг саатуулдаг байв.

Хямралын төгсгөл хэсэгт NASA ба Энергийн газрын сүлжээний менежерүүд WANK өтөнд зориулсан вакцин, хорны ерөндөг, цусны шинжилгээнээс сонголт хийн ашиглах боломжтой болсон байлаа. Макмахонын зохиосон ANTIWANK.COM нэртэй програм нь өтийг устгаж, цаашдын довтолгооноос хамгаалах вакцинжуулалтын үүрэг гүйцэтгэдэг байна. Мөн WORM-INFO.TEXT сайтанд өтөөр халдварлагдсан шинж тэмдгийн жагсаалтыг харуулжээ. Оберманы програмыг CHECK_SYSTEM.COM нэрлэх бөгөөд өт компьютерийн систем рүү нэвтрэхдээ хэрэглэдэг бүх алдаануудыг шалгадаг аж. Түүнчлэн DECNET-ийн экаунт дахь аюулгүй байдлын цоорхойг DEC-ийнхэн бөглөсөн байна.

Халдвар авсан компьютерийн тоо хэдхэн байсан ч өт дэлхийг тойроод амжжээ. Тэр Мэриланд дахь Годдардын компьютерүүдээр дамжин Швейцарийн Цөмийн судалгааны Европын төв нэрээр олны танил болсон CERN-ны Европ дахь сайтууд, Чикагогийн Фермилаб дараа нь Япон дахь Riken Accelerator Facility руу Номхон далайг гатлан хүрчээ.

10-р сарын 16-ны өдөр, Даваа гаргийн үүрийн 4.30-д өт сүлжээнд нэвтэрсэн гэж NASA-гийн ажилтан хэвлэлд мэдэгдэв. Тэд өтийг Европ магадгүй Францаас гаралтай гэдэгт итгэж байлаа.

1989 оны 10-р сарын 18-ны өдөр, Флорида дахь Кеннедигийн нэрэмжит Сансрын төв

Лхагва гаргийн өглөө Атлантис хөлгийн таван гишүүн таагүй мэдээ сонсчээ. Цаг уурын албанаас ирсэн мэдээгээр бороо, үүлийг эс тооцвол хөлөг хөөрөхөд таатай цаг агаарын байдал 40 хувийн магадлалтай ажээ. Хажуугаар нь Калифорниад газар хөдөлсөн.

Кеннедигийн нэрэмжит Сансрын төв нь дээд газрын шийдвэрээр хөлөг хөөргөдөг цорын ганц төв байгаагүй юм. Хөлгийг хөөргөх асуудал Флоридагаас алс хол орших олон газраас хамаатай байв. Үүний нэг нь даваа гаригт тээвэрлэгч хөлөг газардах ёстой Калифорнийн Эдвардын нэрэмжит Агаарын хүчний бааз байлаа. Түүнчлэн тээвэрлэгч хөлгийн замыг

хянах, аялалын зарим дэмжлэгийг хийхэд чухал үүргийг гүйцэтгэх цэргийн бусад баазыг хамарна. Тэдгээр баазын нэг бол Калифорнийн Саннивэйл дахь Онизукагийн Агаарын хүчний баазын хөлгийн замыг хянах станц юм. Булангийн орчмын газар нутагт газар хөдөлж, хөлгийн замыг хянах станцад гэмтэл учруулжээ. Иймээс Саннивэйлийн нөхцөл байдлын талаар хэлэлцэхээр NASA-гийн шийдвэр гаргагчид лхагва гаргийн өглөө цугларав. Сансрын агентлаг дүнсгэр, тайван байдлаа хадгалах ажээ. Сүүлийн үед гарсан техникийн асуудал, шүүхийн маргаан, эсэргүүцэгчид, тогтворгүй цаг агаарын байдал, байгалийн гамшиг, WANK өт зэргийг эс тооцвол NASA нөхцөл байдлыг хяналтаа байлгаж байгаа мэт харагдана.

“Хохирол учирсан, гэхдээ хир зэрэг гэдгийг мэдэхгүй байна. Ерөнхийдөө надад нилээд нааштай мэдрэмж төрж байгаа. Гэхдээ зарим нэг асуудал бий” хэмээн NASA-гийн хэвлэлийн төлөөлөгч UPI-д ярьжээ. Энэ үед Вашингтон хот дахь Пентагоны хэвлэлийн төлөөлөгч Рик Оборн: “Тэд тээвэрлэгч хөлгийн замыг хянах, нислэгийг дэмжих боломжтой болсон... Тэд үүргээ гүйцэтгэх чадвартай байгаа” гэж олон нийтэд батлан хэлэв.

Хөлөг хөөрөх тавцан 39Б дээр Атлантис хөлөг нисэх цагаа хүлээн зогсоно. Цаг агаарын байдлаас болж нислэг хойшилж магадгүй байсан ч техникийн ажилтнууд тээвэрлэгч хөлгийг пуужингийн шатахуунаар дүүргэж байв. Тэнгэр солигдмол үүлтэй хэдий ч Кеннедигийн Сансрын төвд цаг агаар шаардлага хангахуйц гэж үзжээ.

Астрономчид хөлөгтөө суув. Хөлөг хөөрөхөд бэлэн болжээ.

Флоридад цаг агаар тааламжтай байсан боловч ослын буулт хийх газар Африкт зарим нэг асуудал үүсэв. Нэг нь зүгээр болонгуут нөгөө нь саатал үүсгэнэ. NASA нислэгийг дөрвөн минутаар хойшлуулах тушаал өглөө.

Ингээд 12:54-д хөлөг хөөрөх тавцангаас Атлантис хурдаа авав. Кеннедигийн төвөөс хөөрөх хөлгийн тийрэлтэт хөдөлгүүрээс хос оч мөр татуулан гялалзаж, атмосферийн дээд хэсгээс тээвэрлэгч хөлөг сансар руу одлоо.

Хөөрснөөс хойш 6 цаг 21 минутын дараа 19:15-ын үед Галилео ганцаарчилсан аялалаа цааш үргэлжлүүлэв. 20:15-д Галилео судалгааны хөлгийн хөдөлгүүр аслаа.

Тээвэрлэгч хөлгийн удирдлагыг хянах төвөөс NASA-гийн хэвлэлийн төлөөлөгч: “Сансрын хөлөг Галилео дэлхийн татах хүчнээс гарах зайд явна” гэж зарлана.

1989 оны 10-р сарын 30, Даваа гараг, Мэриланд, Грийнбелт, NASA-гийн Годдардын нэрэмжит Сансрын нислэгийн төв.

10-р сарын 16-наас эхэлсэн долоо хоног SPAN-ны багийн хувьд урт долоо хоног байв. Тэд өдөрт 12 цаг ажиллаж, уцаарлаж, түгшсэн хүмүүстэй бүхэл өдрийн турш харьцана. Тэд WANK өтний эсрэг програмын хуулбарыг гадагш түгээсээр байлаа.

10-р сарын 20-ны Баасан гараг. Өтний довтолгооны талаар шинэ мэдээлэл ирээгүй байв. Хямралын үе өнгөрсөн мэт санагдана. Асуудлыг SPAN-ны ажлын хэсгийн бусад гишүүдэд үлдээж, Макмахон өөрийн ажилдаа оров.

Долоо хоног өнгөрлөө. Гэвч Макмахон сонор соргог байдлаа хадгалсаар.. WANK өгийг зохиоход багагүй хүч хөдөлмөр зарсан эзэн нь бүтээлээ ийм хурдан устгуулчихна гэдэгт Макмахон эргэлзэж байв. Өт нь процессын нэрийг адилхнаар хадгалж байгаа цагт “Урхины өгөөш” стратеги үр дүнгээ өгнө. Өөрөөр хэлбэл аль хэдийнээ халдвар авсан системүүд дээр өөрийгөө идэвхижүүлэхгүй байхаар програмчлагдсан байдаг.

Процессын нэрийг өөрчлөх эсвэл өтөнд амиа хорлохгүй байхыг сургавал SPAN-ны ажлын хэсэгт маш том хүндрэл дахин үүсэх юм. Харин Макмахон өгийг буцаж ирнэ хэмээн зөгнөнө. Тэр нөхцөл байдлыг үнэн зөв зөгнөжээ.

Дараагийн даваа гарагт SPAN-ны төслийн оффисоос бас нэгэн утасны дуудлагыг Макмахон авлаа. Тэр даргынхаа өрөөнд оронгуут Жероме Беннетт: “нөгөө зүйл буцаад иржээ” гэж Макмахонд хэлэв. Нөгөө зүйл гэж юуг хэлээд байгааг лавлан асуух хэрэггүй байв. “Би SPAN-ны оффис руу явлаа” гэж тэр шуудхан хэллээ.

Рон Тенкати, Тодд Батлер хоёр Макмахонд зориулан WANK өтний шинэ хувилбарыг хуулбарлан авжээ. Энэ хувилбар илүү хор хөнөөлтэй байв. Өт өөрийгөө илүү үр нөлөөтэй хувилж, сүлжээгээр маш хурдан хэсүүчилнэ. Шинэ хувилбар анхны WANK өгийг бодвол дөрөв дахин хурдан нэвтрэх ажээ. Ингээд утасны хонх дахин дуугарч эхэллээ. “Би чиний WANK өтний эсрэг програмыг хэрэглэж, захианд дурьдсан зааварчилгааг дагалаа. Тэгээд юу болсныг хардаа!” гэж нэгэн менежер уцаарлангуй маягаар Жонд хэлэв.

Өт процессын нэрээ өөрчилжээ. Энэ програм “урхины өгөөшийг” мөшгиж, устгахаар зохиогдсон байлаа. Үнэндээ, SPAN-ны сүлжээ цуст тулааны талбар болох гэж байв. Энэ өт өгөөшийг устгаад зогсохгүй, WANK өтний бусад хуулбарыг шууд алга хийх чадвартай аж. Макмахон өөрийн програмны хэрэглэж байгаа процесс нэрийг өөрчилсөн ч “урхины өгөөш” стратеги үр дүн өгөхөө больжээ.

WANK өтний шинэ хувилбар нь бусад олон түгшүүр дагуулсан сайжруулалтыг агуулсан байна. Хамгийн эхэнд авсан мэдээллээр-нэвтэрч орсон ямар ч эккаунтын пассвордыг шууд өөрчилдөг аж. Бас нэгэн хүндрэл. Гэхдээ зөвхөн систем дэхь дээд түвшний эккаунтын пассвордыг өөрчилж байгаа нь санааг түр ч болов амраав. Шинэ өт системийн менежерийг цоожлох чадвартай байлаа.

Өөрийн эккаунт руу нэвтрэхэд тулгарсан байдлаас гарахын тулд компьютерийн менежер дундаж хэрэглэгчийн эккаунтыг зээлдэж болно. Эккаунтыг Эдвин гэж нэрлэе. Харамсалтай нь Эдвины эккаунт доод түвшнийх байх нь гарцаагүй. Эдвиний эккаунтанд олгосон хүч чадлыг ур чадвартай компьютерийн менежерийн гарт өглөө ч гэсэн өгийг устгах ажил хязгаарлагдмал байна. Жирийн хэрэглэгчийн эккаунтын сулхан байрлалаас өтгэй тулалдах ажиллагаанд менежер бүхэл өглөөг зарцуулж болно. Хамгийн сүүлчийн арга болгож менежер компьютерийн системийг бүхэлд нь унтраах болно.

Дараа нь менежер компьютерийг дахин асаах ажлыг хүчээр хийхээс өөр арга байхгүй. Унтраагаад, дараа нь хамгийн бага конфигураци хийж үлдээнэ. Ингээд өтний өөрчилсөн пассвордыг сольж, logout хийнэ. Зарим өөрчлөлтийг reset хийнэ. Дахиад компьютерыг reboot хийнэ. Өтний ард үлдсэн аюулгүй байдлын цоорхойг битүүлж, нөхнө. Хэрэглэгчийн нэрстэй

адилхан ямар ч пассвордыг өөрчилнө. Томоохон VMS компьютерийг асаахад цаг их ордог. Гэтэл NASA-гийн астрономич, физикч, инженерүүд өөрсдийнхөө компьютер дээр ажиллах боломж олдохгүй байв.

Энэ удаад SPAN-ны ажлын хэсгийнхэн өтний эсрэг багагүй бэлтгэлтэй байлаа. Өтний дайралтанд сэтгэл зүйн хувьд бэлэн байсан гишүүд сүлжээний мэдээлэл, холбоо барих жагсаалтыг шинэчилжээ. Түүнчлэн DECNET-ийн интернет хүрээнийхэн өтний талаар бүрэн мэдлэгтэй, шаардлагатай үед туслалцаа үзүүлэхэд бэлэн байв.

Өтний зохиогчийг ихэд сонирхож байсан Францын систем менежерээс туслалцаа ирлээ. Орсэй хотын Цөмийн Физикийн Институтын менежер Бернард Перрот өтний хуулбарыг авч шинжлээд түүний алдаа шалгах чадвар султайг тогтоожээ. Энэ бол өтний хамгийн эмзэг тал байлаа.

Өт компьютерийн экаунтуудыг эзэмшдэг бүх хүмүүсийн жагсаалт болох RIGHTS LIST database-ийг хайж олох үүрэгтэй байв. Хэрэв database-ийг дахин шинээр нэрлээд оронд нь хуурамч database-ийг орхивол юу болох бол? Онолын хувьд өтийг хуурамч database-ийн араас хөөх ёстой. Харин database дотор нууц бөмбөг суурилуулна. Хэрэв энэ амжилттай болвол SPAN-ны ажлын хэсгийнхэн өтний анхны довтолгоог мэдэрч алах шаардлагагүй, зөвхөн өөрсдөө сайн дураараа устахыг хүлээх хэрэгтэй болно.

Рон Тенкати ихээхэн анхаарал тавьсны хүчинд өтийг устгадаг Франц менежерийн програмыг авч, бага хэмжээний лабораторийн туршилт хийж байсан Макмахонд өгчээ. Тэр өтийг хэдэн хэсэгт хувааж холбоотой багц битүүд болгон зайлуулж үзжээ. Энэ туршилт өтийг алдахгүйгээр мөн хор хохирол учруулах эрсдэлгүйгээр өт устгах Франц програмыг турших боломжийг олгов. Франц гаралтай програм үнэхээр гайхамшигтай ажиллаж байлаа. Түүнийг сөрөг ажиллагаанд оруулав. Өтний хоёрдахь хувилбар илүү хор хөнөөлтэй байсан учраас SPAN-ны сүлжээнээс зайлуулахад эхнийхийг бодвол арай илүү цаг зарцуулжээ. Эцэст нь WANK өтний хоёрдахь хувилбарыг хоёр долоо хоногийн дараа SPAN-ны системээс бүрэн устгалаа.

Макмахоны тооцоолсноор WANK өт хагас сая долларын хохирол учруулжээ. Өдөр тутмын ажлаа хаяж, өтний хойноос хөөцөлдсөн хүмүүсийн ажлын цаг хохирлын ихэнхийг эзэлж байв. Түүний бодлоор WANK өт хулгайлах гэмт хэрэг үйлдсэн ажээ. “Хүмүүс цаг хугацаа, хөдөлмөрийн бүтээмжээ их алдлаа. Энэ хулгайн гэмт хэрэг тохиолдлын зүйл бишээ. Хэн нэгэн хүний санаатай зохион байгуулсан үйлдэл. Компьютер руу нэвтрэхийг зугаа цэнгэл гэж үздэг хүмүүсийг мөрдөн шалгах хэрэгтэй гэсэн санааг би дэмждэг. Тэдний тэнэг үйлдлийн улмаас ямар сөрөг нөлөө бий болдгийг тийм хүмүүс ойлгодоггүй юм шиг санагдана. Компьютер руу нэвтрээд юуг ч оролдолгүй орхихыг ямар ч хор хөнөөлгүй гэж боддог байх. Энэ бол буруу. Тэдний үйлдэл хүмүүсийн ажлын цагийг үрж орхидог. Ажлын бус цагаар ажиллах шаардлагыг хүмүүст бий болгож, төлөвлөгдөөгүй ажлыг хийлгэн, илтгэх хуудас хүртэл бичүүлдэг юм шүү дээ. Түүнчлэн хүмүүс сэтгэл санааны дарамтанд орж, орилж уурлах энүүхэнд. Тэднийг хууль хяналтын байгууллага хяналтандаа авах ёстой. Хэн нэгний системд нэвтрээд ямар нэгэн хор хохирол учруулаагүй байсан ч хариуцлага хүлээх шаардлагатай.” гэж тэр хэлсэн юм.

WANK өгийг хэн зохиосныг Макмахон хэзээ ч олж чадаагүй. Үүнийг бусдын сүлжээнд оруулснаар ямар ашигтай вэ гэдгийг ч тэр илрүүлж чадаагүй билээ. Зохиогчийн зорилго, санаа тодорхой бус байв. Улс төрийн зорилготой үйлдэл гэдгийг хэн ч нотолж чадаагүй юм.

Хариулт шаардлагатай олон асуултыг WANK өг ардаа үлдээв. Өгийг зохиосон хакер плутоний эрчим хүчээр аялах сансрын судалгааны хөлөг Галилеог NASA хөөргөхийн эсрэг зогсож байсан уу? Америкчуудаас гаралтай бус “WANK” гэсэн үгийг хакер ашигласан нь түүнийг Америк хүн биш гэдгийг илэрхийлэх үү? Өгийг яагаад хоёрдахь удаагаа зохиож сүлжээнд оруулав? Яагаад WANK өтний хариуцлагыг хэн нэгэн хүн, бүлэг, улс төрийн хүчин хүлээхгүй байна вэ?

Хоёр дахь довтолгоонд хэрэглэсэн өтний хувилбар хамгийн их нууцыг агуулж байв. Өг зохиогчийн NETW_ гэсэн процесс нэрээр оригиналь нэрийг өөрчилж, WANK програмын эсрэг цохилт өгөхийг оролдсон. Хамгийн эхний процесс нэр “netwank” нь хакерийн зорьсон санааг шууд илэрхийлнэ гэж Макмахон үзэж байв. Харин шинэ процесс нэр ямар нэгэн утга илэрхийлэхгүй байлаа. Үсэгнүүд хэн нэгний нэрийн эхний үсгүүд баймааргүй... Мөн ямар нэгэн байгууллагын товчилсон нэр гэж үзэх үндэс алга. Мэдээж англи хэлний зүй зохистой үг лав биш. NASA болон Энергийн газрын олон зуун компьютерүүд рүү дайрсан өтний эзэн хакер маань ийм сонин үг сонгосон нь бүхэлдээ нууцлаг ажээ.

Тэр “OILZ” гэсэн үгийг хэрэглэсэн байв.

Хоёрдугаар бүлэг

Шар айрагны мухлаг

“Та нар бусдад энхийн төлөө ярьчихаад дараа нь дайнд бэлдэнэ”...

“Midnight Oil” хамтлагийн дуулсан “Цусны дэлбээ” дууны шүлгийн мөр

SPAN-ны аюулгүй байдал хариуцсан ажилтнууд “Oilz” гэсэн үгийн утгыг олж мэдээгүйд гайхах зүйл алга. Тэд WANK өтний “Oilz” хувилбарыг “ойл зий” гэж дуудахаас хэтрэхгүй бизээ. Түүнчлэн сайжруулсан өтний сүүлийн хувилбар гулсамтгай, тосолсон юм шиг баригдахгүй нэвтэрнэ гээд “Oilz” гэсэн нэрийг зохиогч нь бодож олоо биз гэж тэд таамаглаа байх.

Харин зөвхөн нэг Австрали хүн л Midnight Oil-ийн дууны шүлэгтэй өт холбоотой гэдгийг хэлж чадна.

Энэ бол улс төрийн мессэж илгээсэн дэлхийн анхны өт, мөн дэлхийг хэрсэн компьютер сүлжээний түүхэнд алдаршсан хоёрдахь өт билээ. Үүнээс гадна Аюулгүй байдлыг хангах багууд ба хэрэг учралд хариу цохилт өгөх форум буюу англиар FIRST гэж нэрлэгдэх олон улсын байгууллага байгуулах шалтгаан болж өгсөн. FIRST бол компьютер сүлжээний аюулгүй байдлаар мэдээлэл солилцох боломжийг засгийн газрууд, их сургуулиуд, худалдааны байгууллагад олгодог олон улсын аюулгүй байдлын чиглэлийн эвсэл юм. NASA болон АНУ-ын Энергийн газар WANK өтний эзнийг олох найдвараа алджээ. Франц руу хөтөлж байгаа цахим мөрийг дагасан мөрдөгчид Австралид байгаа гэмт хэрэгтэн компьютер, модемний ард нуугдаж байгааг яахин мэдэх билээ.

Газар зүйн байрлалын хувьд Австрали тив дэлхийн хаанаас ч хол оршино. Америкчуудын хувьд энэ тив компьютерийн хакерыг бус тачирхан үстэй уугтан амьтдыг сануулна. NASA болон АНУ-ын Энергийн газрын компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүдэд бас нэгэн саад бэрхшээл учирж байв. Тэд бизнес карт, албан тушаал, жинхэнэ нэр, албан ёсны уулзалт хийгдэх цемент, бетоноор хүрээллэгдсэн ертөнцөд үйл ажиллагаагаа явуулна. Харин компьютерийн нууц ертөнц ньбүрэнхийгээс гарч орох үсэг тоогоор бүрхэгдсэн далд ертөнц юм. Энд хүмүүс жинхэнэ нэрээ хэзээ ч хэрэглэхгүй. Энэ бол хувь хүмүүс өөрийн жинхэнэ мэдээллийг өгдөг ертөнц биш. Гэхдээ сансар огторгуй шиг их хэмжээний талбайг эзлэхгүй, гарт мэдрэгдэж, баригдахгүй боловч төөрдөг байшин мэт иж бүрэн систем байдаг.

NASA-гийн компьютерийн сүлжээнд гадны этгээд халдлага хийсэн учраас NASA-гийн SPAN-ны аюулгүй байдал хариуцсан менежер Рон Тенкати АНУ-ын Холбооны Мөрдөх Товчоонд мэдэгдэв. Хариуд нь АНУ-ын ХМТ-ны Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс багц асуултаар булжээ. Хэдэн компьютер халдлагад өртсөн?Тэд хаа хаана байсан? Довтолгооны ард хэн байгаа вэ? гм асуулт шил шилээ даган цуврана. “Биднийг нөхцөл байдлын талаархи мэдээллээр тасралтгүй хангаж байхыг хүсье” гэж ХМТ Тенкатигаас хүслээ. Энергийн газрын “Компьютерийн ажиллагааны сааталд зөвөлгөө өгөх бүлгийн” адил (CIAC) ХМТ-ныхон VMS-ийн талаар гаргууд мэдлэгтэй биш ажээ. VMS бол SPAN-д хэрэглэдэг компьютерийн үйлдлийн систем юм.

Гэвч Холбооны Мөрдөх Товчоо өтний довтолгоог нилээд ноцтой гэдгийг сайн ойлгожээ. Гадаадын компьютерийн систем рүү бүдэгхэн чиглүүлэх цахим мөрийг олж тогтоох үед АНУ-ын Нууц албаныхан хэргийг мөрдөх ажиллагаанд оролцож эхлэв. Дараа нь дуулиант хэргийн араас Францын нууц алба DST (Direction de la Surveillance du Territoire) оржээ.

Францын Нууц Алба ба ХМТ хэрэг дээр цуг ажиллав. Гарсан хэрэг явдлыг сайн мэдэх хөндлөнгийн ажиглагч нь хоёр улсын засгийн газрын агентлагууд өөр өөр ашиг сонирхлын хойноос явж байгааг харж болох ажээ. Холбооны Мөрдөх Товчоо гэмт этгээдийг баривчлах, харин дэлхийн хамгийн нэр хүндтэй сансрын агентлаг руу довтолсон WANK өт Франц улсаас гаралтай биш гэдгийг Францын Нууц Алба (ФНА) батлахыг хүсэж байлаа.

Засгийн газрын агентлагуудын хамгийн нууц далд уламжлалыг дагах ХМТ ба ФНА –ны хүмүүс албан ба албан бус харилцаа холбооны сувгийг байгуулжээ. Албан ёсны сувагт элчин сайдын яамдууд, атташе нар, албан ёсны мэдэгдэл зэрэг орно. Харин албан бус сувагт зарим хурдан хариултыг агуулсан утасны дуудлага орж байв.

Рон Тенкати Европ дахь SPAN-ны томоохон хэрэглэгч байсан Францын SPAN сүлжээнд Крис нэртэй хамтран зүтгэгчтэй байлаа. Крис компьютер сүлжээнээс илүү их зүйлд холбогдсон нэгэн байв. Тэрээр Францын засгийн газарт тодорхой хүмүүстэй холбоотой бөгөөд бараг л тэдний компьютер сүлжээтэй холбоотой мэт санагдана. Элчин сайдын яамны хүнд сурталт ажилтны шүүж хассан мэдээллийг тодруулах, мөрдөн байцаалттай холбоотой мэдээлэл шаардлагатай үед ХМТ-ны ажилтан Рон Тенкати руу утасдаж: “Рон та найзаасаа үүнийг асуугаач” гэж хэлдэг байв. Рон ч хэлснээр нь хийнэ.

“Крис минь ХМТ үүнийг мэдэхийг хүсэж байна” гэж Францын SPAN дахь найзаасаа Тенкати асууна. Крис шаардлагатай мэдээллийг авч Тенкати руу утасдан: “Рон хариулт нь энэ байна” гээд ФНА үүнийг мэдэхийг хүсэж байна гэж дамжуулдаг. Ингээд Рон ФНА-аас хүссэн асуултын хариуг хайж гүйнэ.

Арын хаалганы гэмээр сувгыг ашиглан, бие биедээ туслах маягаар мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжилж байлаа. Гэтэл NASA руу довтолсон өт Францын компьютерээс гаралтай гэсэн дүгнэлтэнд Америкийн мөрдөн байцаагчид хүрэв. Өт өөр системээс Францын компьютерээр дайран аялсан байж болох авч, Францад байгаа компьютер NASA руу халдвар түгээсэн үндсэн цэг мэт санагдаж байв.

Мөрдөн байцаалтын үр дүнд Францууд сэтгэл дундуур байлаа. Өт Францаас ирэх учир байх ёсгүй ажээ.

Удалгүй АНУ-аас WANK өт ирсэн гэдэгт Францчууд итгэлтэй байгаагаа илэрхийлэв. Нэвтэрч орсон бүх компьютерийн эккаунтийн мэдээллийг АНУ дахь компьютер руу илгээхээр програмчлагдсан байж болохгүй гэж үү? Тэр GEMPAK нэртэй компьютер руу? Яагаад гэвэл өтний зохиогч нь Америк хүн болох нь тодорхой шүү дээ! Энэ бол бидэнтэй холбоотой асуудал бишээ. Энэ бол танай л асуудал гэж Францчууд Америкчуудад хэлнэ.

Хакер ба хакердуулсан газрын хооронд хамгийн ээдрээтэй мөр, холбоог үүсгэх явдал хакеруудын дунд нийтлэг тохиолддог гэж ихэнх компьютерийн аюулгүй байдлын

мэргэжилтнүүд үздэг. Тиймээс өгийг илгээсэн байрлалаас хакерын үндэстний тухай дүгнэлт хийхэд хэцүү бөгөөд өгийг гаргасны дараа нэн удалгүй албаныхан мөрдсөн ч хэн болохыг тогтоох магадлал багатай.

10-р сарын 16-ны Даваа гаргийн өглөө NASA руу WANK өт довтолж байхад зарим компьютер Францтай холбогдож байсныг Тенкати тогтоожээ. Компьютерийн logs-ийг харахад харьцангуй тодорхой байсан тул чухал нотолгоонд тооцогдож байлаа. Өдрийн туршид өөрийгөө хувилсан өт, сүлжээн дэхь компьютерүүд бие бие рүүгээ довтолхыг албадах оролдлогыг их хэмжээгээр хийжээ. Өглөөний 11 цаг болмогц хаанаас халдлага эхэлж, хаана дууссаныг бараг хэлэх боломжгүй болсон юм.

Эхний довтолгооноос хойш хэсэг хугацаа өнгөрсний дараа нийслэл Вашингтон руу өөр нэгэн асуудлаар нэр бүхий ажилтан очихыг ФНА мэдэгдэв. Тэд ХМТ-той уулзахыг хүсчээ. Уг уулзалтанд NASA-гийн SPAN-ны аюулгүй байдлын албаны хэн нэг нь NASA-гийн төв удирдлагын албан төлөөлөгч болж оролцох юм.

NASA руу довтолсон WANK өт Францаас гаралтайг нотолж чадна гэж Тенкати бодож байлаа. Гэхдээ ХМТ-ны хурал дээр Францын Нууц Албаны ажилтнуудын тавьсан сөрөх асуулт бүрт няцаашгүй хариулт болох бүх зүйлийг баримтжуулах шаардлагатайг тэр мөн мэдэж байв. Довтолгоонуудын цагийн судалгааг гаргаж байхдаа WANK өтний халдлага гарах тэр цагт Францын компьютероос өөр системээр дамжин X25 сүлжээний холболт хийгдсэнийг GEMPAK компьютер харуулж байгааг олж мэдлээ. Мөрний үнэр авсан Тенкати тэр системийн менежертэй холбогдов. Сүлжээний менежер Тенкатид дуртайяа тусалжээ.

Тенкати X25 сүлжээг урьд өмнө хэзээ ч хэрэглэж байгаагүй ажээ. Янз бүрийн эккаунт руу нэвтрэхээр оролдох өт login хийж чадаагүй танил ул мөрийг компьютер дээрээс олов. Харин WANK өтний ул мөрний үлдэгдэл 10-р сарын 16-ны өдөртэй давхцахгүй байлаа. Бүр тэр өдрийн хавьд гэж хэлэх үндэслэл ч алга байжээ. NASA руу довтолохоос хоёр долоо хоногийн өмнө өтгэй холбоотой үйлдэл хийгдсэнийг logs харуулж байв. Энэ компьютер бол өт анхны дайралтаа хийхэд ашигласан компьютер төдийгүй програмыг хөгжүүлсэн машин болж таарлаа.

Гарцаагүй нотолгоо.

ФНА ба ХМТ-ны бэлдсэн хуралд Тенкати явж оров. Францчууд зэмлэж эхлэнэ гэдгийг тэр битүүхэндээ мэдэж байв. Буруутанг нотлосон мөрдлөгөө тэдэнд танилцуулсны дараа Францын нууц албаныхан илт няцааж чадсангүй. Гэхдээ тэд өөрсдийнхөө бөмбөгийг хаяв. Францын системийг халдлагын буруутан болгож болно. Харин WANK өт савраа тэнийлгэж байх тэр үед X25 холболт өөр газраас ирсэн болохыг бид шалгалтын явцад тогтоолоо гэж тэд хэлжээ.

Холболтууд Австралиас иржээ.

WANK өгийг Францын хакер зохиогоогүйг нотлосон Францчуудын сэтгэл тэнэгэр байв. Одоо асуудал тэдэнд огт хамаагүй болжээ.

Эндээс хойш ул мөр маш бүдэг болж эхэлсэн юм. АНУ болон Австралийн хууль хяналтын болон компьютерын аюулгүй байдлын мэргэжилтнүүд WANK өтийг хэн зохиосон байж болохыг зөвхөн таамаглах төдий байв. Хэн нэгнийг олж, буруутгах боловч торонд орж ирэх загас байсангүй. Өтний эзэн Австралийн хакеруудын адил компьютерийн нууц ертөнцийн сүүдрээс цухуйгаад, хэсэг зогсож байснаа дахин алга болж байлаа. Мөрдөн байцаагчдын ажлын өдрийн төгсгөлд нэг хүн олоод, маргааш гэхэд хэрэг үүсгэх хангалттай нотлох баримтгүй болно.

1980 оны Австралийн компьютерийн нууц ертөнц бол WANK өтний зохиогч хүмүүжиж, өсөж торнисон орчин байлаа. Apple II ба Commodore 64 мэтийн компьютерүүд хотын захын гэр бүлийн жирийн хэрэгцээнд орж, гэрийн компьютер нийтлэг хэрэглээ болов. Тэдгээр компьютерүүд өргөн дэлгэр тархаагүй тэр үед чин сэтгэлээсээ сонирхсон хүн компьютерийн үнийг төлчих боломжтой болсон цаг байлаа.

WANK өт NASA руу довтлохоос нэг жилийн өмнө 1988 онд Австралид компьютер сүлжээний хэрэглээ ихсэв. Улс орон нь 200 жилийнхээ ойг тэмдэглэж, эдийн засаг цэцэглэн хөгжиж байлаа. Худалдааны хориг болон хуучны зохицуулалтыг халж байв. Лос Анжелос, Нью-Йорк хотуудад Австраличууд зугаацаж, “Матар хочтой Данди” дэлхийн кино урлагийн тайзнаа хөл тавьж байсан цаг. Олны хандлаг, зан араншин өөдрөг байлаа. Энх амгалан Австрали улс арван долоо гаруй сая хүн амтай бөгөөд Баруун Европын ардчиллын нөлөө орсон тив-Азитай хаяа дэрлэн байрлана. АНУ-ын соёлын нөлөө Австраличуудын амьдралд гүнзгий нэвчсэн ажээ. Нээлт, туршилт хийхэд итгэл чухал үүрэг гүйцэтгэж байсан 1988 онд Австрали тэрхүү найдлагыг олж хүртсэн гэлтэй.

1988 онд Австралийн компьютерийн ертөнц Азийн гудамжны зах шиг дуу шуугиант орчин болж өргөжив. Үйлчлүүлэгчид байнга зочлох лангуугаар эргэлдэж, худалдаачидтай үнэ хаялцах агаад найз нөхдүүд уулзалдах газар болон хувирчээ. Зах дэлгүүртэй адилхан нийгэмших газар болсон гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй. Хүмүүс жижигхэн кафе, бааруудад дотно яриа үүсгэн суух болов. Хамгийн сүүлийн үеийн импортлосон эд зүйлийг ширээн дээр хятад торго мэт дэлгэн тавьж, халуухан яриаг эхлэнэ. Наймаачны хамгийн таалагддаг үйлчлүүлэгч, эсвэл найз нөхөд нь хүрж ирээд гудамжны зах бүрийн хамгийн чанартай эд зүйлсийг шууд худалдан авна. Нууц ертөнцийн мөнгөн тэмдэгт нь мөнгө биш мэдээлэл байлаа. Хүмүүс мөнгийг баялаг болгон цуглуулахаар мэдээлэл солилцдоггүй байв. Тэд нэр хүнд олох, эсвэл бусдыг айлгахын тулд үүнийг хийнэ.

Австралийн компьютерийн нууц ертөнцийн гишүүд BBS хэмээн нэрлэдэг bulletin board system дээр уулзана. Өнөөгийн стандартаар бол жирийн л болсон зүйл. Нилээд хүчтэй Apple II компьютер, нэг модем, нэг утастай телефон утасны шугам ашиглан BBS-ийг хэрэглэнэ. Нийгмийн олон давхаргын хүмүүсийг BBS татаж байв. Ажилчин ангийн гаралтай өсвөр насны хөвгүүдээс эхлээд хувийн сургууль, Их сургуулийн оюутнууд, анх ажилд орсон хорь орчим насны хүмүүс, гэртээ хуучны компьютер угсарч, компьютерийн гарын авлага судлаж амралтын өдрүүдээ өнгөрөөх гуч, дөч орчим насныхан зэрэг хүмүүс сонирхоно. BBS-ийн байнгын ихэнх хэрэглэгч нь эрчүүд байв. Зарим үед хэрэглэгчийн эгч нь өөртөө найз залуу хайхаар BBS-ийн ертөнцөд заларна. Эмэгтэй зорилгоо биелэнгүүт хайгуулын талбараас хэдэн долоо хоног, магадгүй хэдэн сар алга болох агаад дараагийн зочлох шаардлага гартал

завсарлана.

BBS-ийн хэрэглэгчид нийтлэг хэдэн шинжийг агуулна. Ерөнхийдөө тэд оюун ухааны дундаж түвшний ангилалд хамаардаг, техникийг хүчтэй сонирхогч бөгөөд сонгосон хоббидоо хэт автсан байдаг. Тийм ч байх ёстой. Зөвхөн компьютерийн системд холбогдохын тулд ачаалал ихтэй, завгүй BBS-ийн ганц утастай шугам руу залгалт хийхэд 45 минут болно. Магадгүй нэг цаг хагасын хугацаа ч өнгөрнө. BBS-ын идэвхитэй сонирхогч үүнийг өдөрт хэд хэдэн удаа давтдаг гээд боддоо. BBS-ын эзэмшигч дэлгэц дээрх самбарыг янз бүрийн хэмжээгээр хувааж хэлэлцүүлэг хийж болно. Нэг BBS-д 30 эсвэл түүнээс илүү цахим хэлэлцүүлгийн групптэй байдаг.

Хэрэв та хэрэглэгч байсан бол дэлгэц дээр үүсгэсэн самбарын улс төрийн хэсэгт зочилж, сайтад зочлох хэн ч уншиж болох улс төртэй холбоотой сэтгэгдэл, үзэл бодлоо бичиж болно. Түүнчлэн яруу найргийн булангаар зочилж, өөрийн зохиосон шүлгийг ч байрлуулах боломжтой. Ихэнх булан өсвөр насны тогтворгүй сэтгэлгээний бүтээлүүдээр дүүрсэн хар бараан өнгөтэй ажээ. Магадгүй та хөгжмийн талаар санал бодлоо солилцохыг илүүд үзэж болох юм. Та олон BBS дээр хөгжмийн төрөл бүрийн урсгалыг сонсож болно. Хамгийн нэрд гарсан хамтлагийн тоонд Pink Floyd, Tangerine Dream, Midnight oil орсон байдаг. Midnight oil-ийн зарим томоохон байгууллагын үйл ажиллагааг эсэргүүцэж бичсэн мессежүүд шинээр бий болсон BBS-ийн хүрээнийхний анхаарлыг зүй ёсоор татна.

1989 он бол Австралийг хөндлөн гулд хэрсэн BBS сүлжээний алтан үе байлаа. Үзэл бодлоо чөлөөтэй солилцох нээлттэй уур амьсгал зонхилсон зах, нийгмийн гэмбуруугүй, гэнэхэн давхаргын үе энэ байлаа. Ихэнх тохиолдолд хүмүүс өөрсөдтэйгээ ижилхэн нийгмийн төлөөлөл болон BBS-ын операторуудад итгэх бөгөөд тэднийг агуу хүч чадалтай бурхан мэт хүндэлж байв. Энэ бол сэтгэл хангалуун байх орчин ажээ. Ерөнхийдөө шинэ үзэл бодол, санааг зочиддоо өгдөг учраас үүнийг аюулгүй орчин гэж үзнэ. Чухам энэ орчинд л WANK өтийг зохиогч өөрийнхөө компьютерийн ур чадварыг төгөлдөржүүлж, сэтгэлгээний баримлаа урлаж байв.

Австралийн шинэ цахим иргэншлийн нийслэл нь Мелбурн болжээ. Өмнөдийн энэ хот яагаад BBS ертөнцийн соёлын төв болсон гэдгийг хэлэх амаргүй юм. Түүнчлэн Австралийн компьютерийн нууц ертөнцийн төв болсныг ч тайлбарлаж чадахгүй. Магадгүй бусдын хаясан компьютерийн эд ангийг сониуч зангаас илүү сэтгэл тавьж, өөрийн компьютерийг угсарсан олон залуучуудын хуран цугларах газар бий болоход Австралийн оюун ухааны төв их үүрэг гүйцэтгэсэн байх. Хотын захад суурин амьдрах хэвшлийг илүүд үзэх Мелбурний оршин суугчид BBS-ийн соёлд амархан нэвтэрсэн ажээ. Магадгүй Мелбурнийн далайн эргийн эзэнгүй амралтууд, байнга зэврүүхэн байх цаг агаарын байдал компьютер сүлжээний соёл хурдацтай хөгжихөд нөлөөлсөн бизээ. “Өөрийн компьютер, модемийн хамт бүхэл өвлийн турш ичэхгүй бол энд юу хийх билээ дээ?” гэж нэгэн Мелбурнийн хакер хэлсэн юм.

1988 онд Мелбурнд BBS-ийн 60-100 оператор байв. Хөдөлгөөнтэй байгаа зүйлийн цуглуулгыг тоолоход хүндрэлтэй учир тоог яг нарийн хэлэх аргагүй. Сонирхогчийн бий болгосон систем нь замбараагүй багцалсан утаснууд, электроникийн хуучин эд ангиас бүрдэх бөгөөд хэн нэгний гараашинд байрлана. Иймэрхүү нөхцөл байдалд байгаа ямар нэгэн компьютерийн систем өсвөр насны хүүхдийн сонирхол адил богино настай байлаа. BBS

шинээр гарч ирээд хоёр долоо хоногийн дараа дахин алга болно.

Тэдний зарим нь оройн 10 цагаас өглөөний 8 цаг хүртэл л ажилладаг. Эзэмшигч орондоо оронгуут өөрийн гэрийн утасны шугамыг BBS рүү хийгээд, өглөө болтол орхино. Зарим нь өдөрт 24 цагаар ажиллана. Хамгийн завгүй үе нь шөнийн цаг байдаг аж.

Мэдээж зарим хэрэглэгчид зөвхөн оюун санааны хэрэгцээгээ хангах гэж үүнд нэгдэхгүй. Зочид бусдын санаа сэтгэгдлийн хажуугаар хүмүүсийн тухай мэдээллийг эрх хайх болжээ. Электроникийн бюллетень самбар дээр та өөрийн хувийн шинж чанарыг тусгаж, хэлбэр дизайныг өөрчлөн, өөрийн болгоно. Таны нас, гадаад төрх ямар ч хамаа байхгүй. Харин техникийн ур чадвар их хамаатай юм. Ямар ч болхи бүдүүлэг, сэвхтэй өсвөр насны хүүхэд өөрийгөө сүр жавхлантай, дур татам BBS-ын дүр болгон хувиргана. Өөрчлөлтийг нэр сонгохоос эхэлдэг. Бодит амьдрал дээр олон жилийн өмнөх авга ахаа дурсан санаж ээжийн тань өгсөн нэр чинь Эллиот Дингл байж. Харин BBS дээр бол та Блейд Раннер, Нед Келли, Мэйд Макс гэсэн хувь хүнд хувирна. Ингээд сонголтоо хийсэн хүүхдүүд BBS-ын ертөнцөд чөлөөт цагаа өнгөрөөнө.

Ерөнхийдөө онлайн нэрээ сонгонгуут хэрэглэгчид BBS-ээс холдож чадахаа байчихдаг юм. Түүний бүх цахим шуудангууд урьдаас сонгосон нэртэй экаунт руу орж ирнэ. Бюллетень самбар дээр үлдээсэн мэдээлэл нь тэрхүү нэрний хамт бусдад хүрнэ. Сонгосон нэр нь хувь хүний шинжийг ямар нэгэн хэмжээгээр илэрхийлэх тул The Wizard (Шидтэн), Conan (Хүч чадалтай эрийн тухай киноны баатар), Iceman (Мөсөн хүн) нэртэй хакерууд BBS дээр цагаа өнгөрөөх бол Crystal Palace (Болор ордон), Megaworks (Мега ажлууд), The Real Connection (Жинхэнэ холболт), Electric Dreams (Цахилгаан мөрөөдлүүд) нэрийг хэрэглэнэ.

BBS-ыг үнэлдэг иймэрхүү зочдыг олон ангилалд хувааж болно. Зарим нь BBS-ын нийгмийн амьдралд оролцохыг хүсдэг. Тэд өөртэйгээ адилхан цоглог, өвөрмөц хүмүүстэй танилцаж, компьютерийн мэдлэгээ хуваалцах сонирхолтой байдаг. Бодит амьдрал дээр ихэнх нь нийгмээс салангид амьдралтай, сургууль, найз нөхдийн жирийн хүрээллээс гадуур байдаг онцлогтой. Зарим нэг нь анхныхаа ажлыг хийж эхэлсэн ч өсвөр насны амьдралаас хойш дагалдах хэв загваргүй мөртлөө болхи зуршлаа халж чадаагүй байв. Өнгөн талдаа хөлбөмбөгийн тэмцээний дараа тэднийг хүйтэн шар айраг ууя хэмээн урихаар хүмүүс биш байлаа.

Гэхдээ энэ бол жирийн үзэгдэл. Ерөнхийдөө тэд хөлбөмбөгт нэг их шохоорхоод байхгүй.

BBS бүр өөрийн хэв маягтай байв. Зарим нь бүхэлдээ хууль ёсыг дагуу ажиллагаа явуулж, хориглоогүй эд зүйлийг нээлттэй зарна. Харин The Real Connection мэтийн бусад BBS-үүд нэгэн цагт Австралийн эхэн үеийн хакерууд уулздаг орчин байлаа. 1989 оны 6-р сард Засгийн газраас анхны хакерын хуулийг батлахаас өмнө BBS-ын хакер хийхтэй холбоотой хэсэг хаагдсан юм. Тухайн үед Мелбурнийн арав эсвэл арван хоёр BBS-үүд компьютерийн нууц ертөнцийн харанхуй талыг дагаж, нууц хадгалсан шинжтэй байв. Greyhawk ба The Realm мэтийн ихэнх BBS-үүд зөвхөн урилгаар хүмүүсийг өөрийн board руу нэвтрүүлнэ. Өөрөөр хэлбэл та board руу зүгээр л холбогдож, шинэ экаунт үүсгэн login хийх боломжгүй. Board-ын эзэмшигчийн урилгаар л нэвгэрнэ гэсэн үг. Модем хэрэглэгч нийтлэг хүрээний гишүүд эд нартай харьцах шаардлагагүй байв. 1987-1989 оны хоорондох Австралийн компьютерийн

ертөнцөд үйл ажиллагааны хамгийн гол хоёр BBS-ийг Pacific Island ба Zen гэж нэрлэдэг байлаа. Энэ хоёр системийг хорин гурван настай Грейг Боуен өөрийн унтлагын өрөөнөөс ажиллуулж байв.

Thunderbird нууц нэрээр алдаршсан Боуен хакеруудын сайт шаардлагатай болсон учраас 1987 онд Pacific Island-ийг эхлүүлжээ. Мелбурнийн хамгийн анхны хакеруудын board ANUBBS хаагдсаны дараа дөнгөж өдөлж эхэлсэн хакерын хүрээнийхэн тарж бутарсан юм. Мелбурнийн хакерууд цугларч, мэдээлэл солилцох орон зайг үүсгэхийн тулд BBS-ын үймж бужигнасан хар захын дунд кафе бар байгуулахаар Боуен шийджээ. Түүний унтлагын өрөө эгэл жирийн бөгөөд ганц ор, хувцасны шүүгээ байна. Уралдааны машин хурдлах дүрсийг хананы цаасан дээр дүрсэлжээ. Цонх нь хотын захын навч дүүрсэн гудам руу харсан аж. Түүний өрөөнд Nyble and Byte компьютерийн сэтгүүлийн цуглуулга, компьютер програмчлалын тухай хэдэн зузаан ном, VAX/VMS-ийн гарын авлагуудыг өрсөн харагдана. Хэдийгээр ном тийм ч олон байхгүй боловч Артур С.Кларкегийн зөгнөлт зохиол голдуу байв. Мөн Дээд сургуулийн хятад хэлний ангид суралцаж байхдаа хэрэглэж байсан Хятад хэлний толь бичиг байлаа. Тэр анх ажил хийж эхлэхдээ хятад хэлийг бие даан судалж байв.

Apple IIe компьютер, модем, телефон утасны шугам түүний орны хажуугийн ширээн дээр байрлуулжээ. Боуен компьютерийнхээ хажууд телевизороо тавьж, Pacific Island-ийг хэрэглэхийн хажуугаар нэг дор телевизороо үзнэ. Хожим Zen-ийг эхлүүлсний дараа Pacific Island-ийн хажууд байрлуулав. Тэр үнэхээр төгс ажлын орчинтой болжээ.

Өнөөгийн UNIX-ийн интернет компьютерийн стандартыг бодвол Pacific Island харьцуулшгүй энгийн байсан боловч 1987 ондоо сэтгэл татмаар компьютерт тооцогдож байлаа. PI буюу орон нутгийн хэрэглэгчдийн нэрлэж заншсанаар “пай” хэмээх машин 20 мегабайтын хард драйвтай байв. Тухайн үеийн персонал компьютерт бол агуу багтаамжтай гэсэн үг. Боуен PI-г босгоход 5000 доллар зарцуулжээ. Түүнд энэ хоёр систем ихэд таалагдсан тул тэднийг сайжруулахад долоо хоног бүрийн олон цагийг зарцуулж байв.

Ихэнх BBS-ийн адил PI ба ZEN компьютерүүдийн экаунтуудаас ямар нэгэн төлбөр авахгүй. Австралийн компьютер ба телефоны ухаалаг олон хакерууд уулзалдах байрны эзэн болсон даруухан зантай Боуен өөрийн компьютерүүдийн төлбөрийг олох хоёр эх үүсвэртэй байлаа. Нэгдүгээрт тэр аав ээжтэйгээ амьдардаг, хоёрдугаарт Австралийн дотоод телефон үйлчилгээний цорын ганц оператор Telecom компанид бүтэн цагаар ажиллаж байв.

PI нь ойролцоогоор 800 компьютерийн хэрэглэгчтэй, үүнээс 200 орчим хэрэглэгч нь системд байнга орох эрхтэй “үндсэн” гишүүд байв. Телефоны шугамыг байнга завгүй байлгаж эцэг эхийнхээ тав тухыг алдагдуулахгүйн тулд PI-д зориулан тусдаа телефон утасны шугамыг Боуен гаргажээ. Дараа нь ойролцоогоор 2000 хэрэглэгчтэй ZEN-д зориулан нэмэлт дөрвөн утасны шугамыг тэр холбов. Telecom компанид ажиллаж байхдаа эзэмшсэн туршлагад тулгуурлан, өөрийн гэртээ зохих зөвшөөрлийн дагуу мөртлөө стандарт бус олон зүйлийг Боуен суурилуулжээ. Мастер свитч, утасны зангилааны хайрцаг зэргийг тэр байрлуулсны дараа Боуены гэр нь теле харилцаа холбооны халуун цэг болон хувирав.

Хэрэв Боуен ажилдаа үлдэхийг хүсвэл хууль бус ямар нэгэн үйлдэл хийх хэрэггүй гэдгийг мэдэж байлаа. Австралийн үндэсний хэмжээний теле харилцаа холбооны оператор

техникийн мэдээллийн арвин эх сурвалж байв. Жишээлбэл: тэрээр Telecom компаний компьютер сүлжээний эккуанттай байсан учраас Telecom-ын төвийн телефон утасны станцын тухай их зүйлийг сурах боломжтой байжээ. Гэхдээ тэр хакердах ажиллагаандаа тэр эккаунтыг хэзээ ч хэрэглэж байгаагүй юм. Хүндлэл хүлээсэн хакерууд үүний адил философийг дагана. Зарим нь сурах үйл ажиллагаандаа зориулан албан ёсны их сургуулийн компьютерийн эккаунт хэрэглэх агаад тэдгээр эккаунтыг цэвэрхэн байлгадаг байв. “Өөрийн үүрийг бүү сүйтгэ” гэж нэгэн хакерийн хэлсэн үг компьютерийн нууц ертөнцийн үндсэн дүрэм байлаа.

PI нь хувийн ба олон нийтийн хэсгээс бүтнэ. Олон нийтийн хэсэг нь хуучин цагийн шар айрагны мухлаг шиг байдаг. Хэн ч хэсүүчлэн орж ирээд нутгийн хүмүүстэй яриа өдөн, тухлаж болно. Системтэй модемоор холбогдож, жинхэнэ нэр, сонгосон нэр, утасны дугаар, бусад үндсэн мэдээлэл зэргийг шивнэ.

BBS-ийн олон хэрэглэгчид өөрсдийн бодит мэдээллийг далдлах үүднээс хуурамч мэдээлэл өгнө. Ихэнх операторууд үүнийг үл тооно. Харин Боуен үүний эсрэг бодлого баримтална. Холбооны компьютерийн гэмт хэргийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хүртэл хакерийн board ажиллуулах нь зарим эрсдлийг дагуулж байлаа. Зөвшөөрөлгүй хуулбарласан програм хангамж хууль бус байв. Гадаадын компьютерээс хакердах арга замаар хуулбарласан мэдээллийн санг хадгалах үйлдэл мөн адил хууль бусд тооцогдоно. Хэвлэл мэдээллийн туршуулууд болон цагдаа нарын хараанд өртөхгүйн тулд Боуен PI дээрх хэрэглэгч бүрийн ажил, гэр рүү нь утасдаж, хувийн мэдээллийг шалгахыг хичээнэ. Заримдаа тэрээр хана мөргөх үе ч гарч байв.

PI-ийн “Ганцаардсан зүрх” нэртэй хэлэлцүүлгийн хажууд “олон нийтийн” гэсэн хэсэг дээр IBM, Commodore, Amiga, Apple, Atari зэрэг томоохон брендийн персональкомпьютерийн тухай хэлэлцүүлэг явагддаг байв. “Ганцаардсан зүрх” хэсгийн хэлэлцүүлэгт ихэнх нь гормоны өөрчлөлтийн улмаас бэлэг эрхтэн дутуу хөгжсөнд сэтгэл санаагаар унаж явдаг хорь орчим хүн байнга эргэлдэнэ. Хөвгүүн огт танихгүй охинд хаягдаж, түүний анхаарлыг татахыг хүснэ. Өсвөр насныхан амиа хорлохоо эргэцүүлнэ. Мессэжүүд бүхэлдээ нэргүй учраас уншиж байгаа хүмүүс зохиогчийн нэрийг мэдэхгүй ч зүрхэнд хүрсэн мессэжийн жинхэнэ хариултыг сэтгэх ажээ.

Zen бол PI-гийн сайжруулсан дүү нь байв. PI өөрийнхөө тоглолтыг хоёр жилийн турш хийх хооронд Боуен нэгээс илүү телефон утасны шугамтай Австралийн анхны BBS-ын нэг Zen-ийг нээлээ. Бүх цаг хугацаанд түүнийг залхаах компьютерийн хэрэглэгчдээс холдохын тулд Боуен Zen-ийг босгожээ. PI руу хэн нэгэн хүн log хийнгүүтээ юуны өмнө системийн оператортой онлайн чат хийх хүсэлт тавих явдал байв. Өнөөгийн стандартаар PI-ийн Apple II нь бараг үндсэн компьютер байв. Боуен ийм компьютер дээр олон үйлдлийг хийж чадахгүй байлаа. Зочин PI руу log хийсны дараа тэр өөрийн мэйлийг шалгах боломжгүй болж байв.

Австралийн BBS хүрээнийхний дунд Zen түүхийн чухал өөрчлөлтийг хийсэн юм. Zen олон үйлдэл хийж чадна. Компьютер руу нэгэн зэрэг дөрөв хүртэлх хүн login хийж болно, мөн түүний хэрэглэгч онлайн дээр байхад Боуен өөрийн зүйлийг хийж чадна. Үүнээс гадна түүний хэрэглэгчид бүх цаг хугацаанд Боуенийг хоргоож байхын оронд өөр хоорондоо ярьж болох давуу талтай байв. Олон тооны утасны шугамтай, олон үйлдэл хийдэг компьютер дээр

хэрэглэгчидтэй харьцана гэдэг цэцэрлэгийн багш болсон мэт санагдана.

Өнгөн талдаа олны бодлыг дэмжигч, хууль ёсыг хүндлэн дээдлэгч харагдах Боуен компьютерийн нууц ертөнцийн олон баатруудын адил тодорхой байгууллагын үйл ажиллагааны эсрэг үзэл бодлыг агуулдаг байв. Zen гэсэн нэрийг сонгож авсан нь үүнийг батална. Ёс суртахуунгүй тоталитар засгийн газрыг түлхэн унагаахыг оролдох босогчдын тухай өгүүлэх Британий олон ангит “Black 7” зөгнөлт киноноос Zen үүсэлтэй юм. Zen бол босогчдын хөлөг онгоц дээр байсан компьютер байлаа. Өөр гариг дээр аваачиж шийтгэхээр цөллөгт явуулж байгаа хоригдлууд шоронгийн хөлөг онгоц дээр уулзалдсаны дараа нийлж бослого хийснийг энэ кинонд харуулдаг. Энэ бол Австралийн компьютерийн нууц ертөнцтэй холбоотой байж болох түүх байв. Киноны гол баатруудын нэг нь хакердах үйлдэл хийсний төлөө шоронд хоригдох ялаар шийтгүүлсэн хүн байжээ. Тэр бусад хүмүүст найдаж том алдаа хийснээ хамтран зүтгэгчдээ хэлдэг. Тэр тэдэнд итгэсэн. Гэхдээ тэр ганцаар ажиллах ёстой байсан тухай кинонд өгүүлнэ.

Хэдэн сарын дотор уг кинонд гарсан зүйл хир зэрэг үнэн болохыг Крейг Боуен мэдрэнэ гэдгээ зүүдлээ ч үгүй байв.

Боуены байр компьютерийн ертөнцийн одоо ба ирээдүйн гэрэлт үеийн чухал төв байлаа. Wizard, Force, Powerspike, Electron, Phoenix, Nom, Prime Suspect, Mendax, Train Trax компьютерийн ертөнцийн гол аялагчид. Прайм Саспект мэтийн зарим нэгэн хакер үйл ажиллагааг нь халт сонирхож, найз нөхөдтэйгээ мэндчилэхээрхааяа нэг орж ирнэ. Ноум мэтийн зарим нэг нь PI гэр бүлийн хамгийн ойрын хэсэг байв. PI-г босгож, ашиглахад Ноум Боуенд туслажээ. Компьютерийн хүрээнийхний эхэн үеийн гишүүдийн адил тэд Мелбурн дахь Apple хэрэглэгчийн нийгэмлэг AUSCOM-оор зуучлуулан танилцжээ. PI болон тэдний өөрсдийн компьютерийн хооронд файл шилжүүлэхэд хэрэглэдэг програм ASCII Express-ийг Боуен ашиглахыг хүсчээ. Харин уг програмын зөвшөөрөлгүй, хууль бус хуулбар байгааг Боуен болон түүний таних хүн бүр мэдэж байв. Програм хангамжийн тодорхой хэсгийг хэрхэн хэрэглэх тухай ямар ч гарын авлага байхгүй байлаа. Тиймээс долоо хоногийн амралтын өдөр-Ноум, Боуен хоёр програмыг бие даан ажиллуулж, хэрхэн ашиглах талаар судалжээ. Хоёр хакер өөр өөрсдийн гэртээ, өөрсдийн компьютер дээр, програмын хуулбартай ажиллана. Тэд утсаар дамжуулан програм хэрхэн ажиллаж байгаа талаар хэдэн цагаар ярилцана. Иймэрхүү бичиг баримтын дутагдлаар шаналж байсан компьютер ертөнцийн хүмүүст зориулан өөрсдийн гарын авлагаа тэд бичив. Дараа нь тэд улам боловсронгуй болгож, PI дээр хэрэглэж эхэллээ.

BBS-ийн олон группуудтай холбоо тогтоосон PI ба Zen board-ууд хакердсан мэдээллийн хажуугаар бусад ашиг тусыг өгнө. Хэрэв та нэр нь үл мэдэгдэх багаа тайлахыг хүсвэл маш ойр дотно хүрээ үүсгэсэн найз нөхөдтэй нэгдэж болно. Жишээлбэл, зорилго нэгтэй PI-ийн хэсэг хүмүүс “Blue Brothers” киноны шүтэн бишрэгчид байлаа. Баасан гараг бүрийн шөнө энэ групп “Blue Brothers” киноны баатруудын адил хар костюм, нарийн зангиа, цагаан цамц, Рейбан буюу Rayban (туяа эсэргүүцэгч гэсэн утгатай) нарны шилээр гангарна. Хүүхдээ авчирсан нэг гэр бүлийнхэн мини “Blue Brothers”-ийн өмсгөлөөр хүүгээ хувцасласан байв. Баасан гаргийн шөнийн групп 11:30-ийн үеэ Норткотегийн Валхалла театр (одоо Вестгарт болсон) руу явна. Шөнийн наргиа, наадам болон хөгжсөн соёлын арга хэмжээ сүртэй

мөртлөө бусдын анхаарлыг нэг их татахгүй уур амьсгалыг бүрдүүлдэг. Тайзан дээр гарч ирэх PI-ийн группууд киноны гол үйл явдлыг жүжиглэн үзүүлнэ. Үүнийг хямдхан боловч зугаатай үдэш гэж тодорхойлж болно. Зохих ёсоор хувцасласан хүмүүсийг Валхалла театрын ажилтнууд чөлөөтэй нэвтрүүлдэг. Группууд зөвхөн завсарлагааны үеэр л уух зүйлд мөнгө төлнө.

Боуен заримдаа PI ба Zen-ны залуу хэрэглэгчдэд зориулан цугларалт зохион байгуулдаг байв. Группууд ихэвчлэн Мелбурнийн төвд, зарим тохиолдолд Хотын төв талбайд уулзалдана. Группийн ихэнх нь хөвгүүд байх хэдий ч үе үе хэдэн охидууд үзэгдэнэ. Син нэрийг хэрэглэдэг Боуены дүү охин энэ арга хэмжээнд мөн оролцдог. Тэрээр BBS-ийн хэдэн хакеруудтай ирдэг цөөхөн хүмүүсийн нэг байлаа. Ихэнхдээ аймшгийн кино үзсэний дараа Хотын төв талбайд групп цагийг нөхцөөнө. Хааяа арай өөр хувилбарыг сонгож, боулинг тоглохоор явна. Эртлэн зугаацсаны дараа Макдоналдсын хямдхан бургер идэж, хоолны газрын хана руу дарсан өргөст хэмх шидлэн, инээлдэх нь энүүхэнд.

Техникийн чиглэлээр холбогдохоос илүү нийгмийн идэвхтэй арга хэмжээ PI ба Zen-ны хэрэглэгч дунд амжилттай өрнөж байв. Гэхдээ бусад хэсгүүдийг бодвол хакерын хувийн хэсэг илүү амжилттай байсныг хэлэх хэрэгтэй. Хакерийн хэсэг нууц далд орших агаад Мелбурний компьютерын ертөнцийн гишүүд тэнд ямар нэг зүйл явагдаж байгааг гадарлана. Гэвч хэн ч юу хийж байгааг олж мэдэхгүй. Хувийн хэсэгт элсэх урилга авахад хакерын ур чадвар, мэдээлэл шаардлагатай бөгөөд ихэнхдээ аль хэдийнээ гишүүн болсон хэн нэгнээс Боуенд санал тавьсан үед элсэх боломжтой. Дотоод Сүм гэж нэрлэдэг хакерын хувийн хэсэгт хакердах арга техник, компьютерын шинэ бүтээгдэхүүнүүд, хакердаж болох шинэ сайтуудыг байгуулсан компаниудын дэлгэрэнгүй мэдээлэл, хууль хяналтын байгууллага юу хийх гэж байгаа тухай сүүлийн үеийн цуу яриа зэрэг мэдээллийг тухтай нь аргагүй солилцоно.

Гэхдээ Дотоод Сүм нь цорын ганц хакерын хувийн хэсэг байгаагүй юм. Элит болон Н.А.С.К гэсэн хакерийн хоёр бүлэг тэрхүү хэсгийн арын өрөөнд чимээгүйхэн байрлах ажээ. Та Дотоод Сүм-д нэвтэрч чадлаа ч гэсэн Элит болон Н.А.С.К бүлгүүд оршиж байгааг мэдэхгүй. Илүү их сонголттой хэсэг байгааг та мэдрэх авч, хамгийн тусгай хэсэг ба таны хооронд сонгины хэдэн үе байгааг таах аргагүй юм. Энэ номонд зориулж ярилцлага өгсөн бараг бүх хакерууд дотоод хүрээллийн гадна байгаа мэт бүдэгхэн мэдрэмжтэй байснаа хэлж байв. Тэд тэнд ямар нэг юм байгааг мэдэж байвч яг юу байгаа талаар төсөөлөлгүй байжээ.

Боуен Дотоод сүмд нэвтрэх хаалгыг онгойлгохыг тэмүүлж, хакер болохыг хүсэгчдээс хааяа нэг утасны дуудлагын хүлээж авдаг байв. “Би танай зохиогчийн эрх зөрчсөн систем рүү орохыг хүсэж байна” гэж хэн нэгэн царайчлана.

“Ямар зохиогчийн эрх зөрчсөн системийн тухай ярьж байна вэ? Миний систем зохиогчийн эрх зөрчсөн гэж хэн чамд хэлэв?”

Утсаар ярьсан хүн хир их зүйлийг мэдэж байгаа, хэн түүнд хэлснийг мэдэхийг хүсчээ. Дараа нь тэр бүгдийг үгүйсгэлээ.

Эдгээр хүсэлтээс зайлсхийхийн тулд Боуен BBS-ыг хэрэглэдэг ихэнх хүмүүсийн утасны дугаар, жинхэнэ нэр, хаягийг нууцлахыг хичээжээ. Харин түүний оролдлого амжилттай

болсонгүй. Нэгэн өдөр түүний гэрийн үүдэнд Masked Avenger (багтай өшөө авагч гэсэн утгатай-орч) гэнэт гарч ирэв. Багтай өшөө авагч түүний гэрийн хаягийг хэрхэн олж авсан нь нууц байлаа. Тэр хоёр онлайн дээр нөхөрсөг чат хийсэн боловч Боуен түүнд өөрийн дэлгэрэнгүй мэдээллийг өгөөгүй байна. Боуены гэрийн гадаа, дугуйныхаа хажууд зогсох хамгаалалтын том малгай өмссөн хүүхэдтэй гэнэт тааралдлаа. “Сайн уу!. Миний нэрийг Masked Avenger гэдэг” хэмээн тэр хоолойгоо шахан хэлэв.

Арван таван настай болов уу гэмээр тэр хүүхэд (Masked Avenger) Боуены мэдээллийг олж авсан нь эх сурвалж сайтайг илтгэнэ. Боуен түүнийг гэртээ оруулж өөрийн системийг үзүүлэв. Тэд удалгүй тэд найз нөхөд болжээ. Гэхдээ тэр цагаас хойш Боуен өөрийн тухай мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахаар шийдсэн гэдэг. “Мэдээллээ бүрэн нууцлахын төлөө” гэсэн үгнээс тэр эхэллээ. Тэрээр Крейг Боуен нэрийг зохиож компьютерийн ертөнцийн хүн бүр түүнийг энэ нэрээр нь мэдэх болов. Түүнчлэн PI руу үе үе хэн илгээх хэрэглэгчдийн сайн дурын хандивыг авах хуурамч банкны дансыг Боуений нэр дээр нээлгэжээ. Оюутнууд мөнгө багатай тул хандивын мөнгө 5 юм уу 10 доллараас хэтэрдэггүй байв. Хандивыг буцаан PI-г сайжруулахад хэрэглэнэ.

Дотоод Сүм–д нэвтрэхийг хүсэх олон шалтгаан хүмүүст байв. Зарим нь АНУ-аас зохиогчийн эрх зөрчин авсан тоглоом зэрэг хамгийн сүүлийн үеийн програмынхуулбарыг үнэгүй авахыг хүснэ. Бусад хүмүүс орон нутгийн их сургуулиудын компьютер руу нууцаар нэвтрэх санаа оноо, мэдээлэл хувцаалцахыг хүсэх аж. Цөөхөн хүн телефон утасны системийг хэрхэн хянах талаар сурахыг оролдоно.

Хакерийн хувийн хэсэг нь сэхээтэн, бие даасан мэргэжилтэн, үнэнч шударга эсвэл өрсөлдөөнийг харуулах хүмүүсээр дүүрсэн танхим мэт байв. Нийгмийн иж бүрэн эмх цэгц, хүндэтгэл бол тоглоомын нэр байлаа. Хэрэв та нууц хэсэгт нэгдэхийг хүсвэл элит байх хэмжээний хакерийн мэдээллийг хангалттай эзэмшиж, чалчаа биш гэдгээ харуулах учиртай. Хамгийн сайн сорилт бол Мелбурнийн Их сургуулийн dial-out хийдэг пассвордыг мэдэх явдал байв.

Их сургуулийн dial-out бол хамгийн үнэт зүйлийн нэг юм. Хакер Их сургуулийн компьютер руу холбогдож, “модем”-той адил login хийхэд компьютер түүнийг модемтой холбож, дахин dial out хийх боломжийг олгоно. Дараа нь хакер дэлхийн аль ч өнцөг рүү dial хийх бөгөөд их сургууль утасны төлбөрийг төлнө. 1980 оны сүүлээр, интернет холболт хямд болохоос өмнөхөн Их сургуулийн dial out-ыг олбол Панам дахь АНУ-ын цэргийн бааз, Германы BBS компьютерийн ертөнцөд нэвтэх боломжийг хакерт олгоно гэсэн үг байлаа. Тэр пассворд бол хакерийн гарын үзүүрт ертөнцийг авчирахтай адилхан байв.

PI-ийн Дотоод Сүмд орохыг хүссэн хакер олон нийтийн хэлэлцүүлгийн хэсэгт dial out-ын пассвордыг ил тавихгүй. Ихэнх тохиолдолд ийм үнэт мэдээлэл түүнд олдохгүй. Одоогийн пассвордыг ямар нэгэн аргаар оллоо ч гэсэн олон нийтийн нүдэнд ил гаргах нь эрсдэл дагуулна. Хэрэв тэгэх аваас Их сургуулийн модемны экаунтаар хүссэн хүн бүр оролдож тоглох болно. Системийн администратор үүнийг мэдээд пассвордыг өөрчилж, хакер их сургуулийн экаунтаа алдана. Харин нэвтрэх боломжийг Н.А.С.К, Дотоод сүм, Элитийн хакеруудад алдвал бүр муу зүйл тохионо. Тэд энэ шар тосыг жинхэнэ ашиглана. Тэдний хувийн эзэмшлийнх гэж үзсэн экаунтын пассвордыг урьдчилан сануулахгүйгээр өөрчилбөл

хакерууд маш их уурлана. Парольдыг өөрчлөхгүй ч гэсэн хакер нууц хадгалж чадахгүй гэж үзвэл түүнийг үзэн ядаж эхэлдэг.

Харин хуучин парольдыг тавина гэдэг бол огт өөр асуудал юм. Хэрэгцээгүй гэж үзэх мэдээлэл байвал хакер их зүйлийг өгөхгүй гэсэн үг. Гэхдээ хакер тийм төрлийн мэдээлэлд орох боломжтойг харуулбал тэр ямар нэг зүйл мэдэж байгааг илэрхийлнэ. Экаунтын пароль хүчинтэй байх үед нууцыг мэддэг байж хэмээн бусад хакерууд бодно. Хамгийн чухал нь хүчингүй болсон парольдыг мэдэж байгаа бол одоогийн парольдыг мэдэж байж болзошгүйг далдуур илэрхийлнэ. Ингээд гэнэтийн хүндэтгэл эдэлнэ. Дотоод Сүм-д нэвтрэх урилга олж авах нь стратегийн тоглоомыг санагдуулна. Шохоорхол төрүүлэх авч шууд ногоон гэрлээр яваад орчихгүй. Хэсэг хугацааны дараа Дотоод Сүмийн дотроос хэн нэгэн нь таныг ажиглаад Боуентэй ярилцана. Тэгээд та урилга хүлээн авна.

Хэрэв та дотоод давхаргын эхний хэсгийг давж гарахыг хүсэж байгаа бол жинхнээсээ ажиллаж эхлэх ёстой. Олон нийтийн хэсгийг эрх мэдэлтнүүд хянах магадлалтай тул та нуугдаад байж чадахгүй. Утасны систем, компьютер рүү нууцаар нэвтрэх талаар хир их мэдээллийг та хангаж байгааг хамгийн элит түвшний хакерууд үнэлдэг. Тэд мэдээлийн үнэн бодит байдлыг мөн хянана. Монашын Их сургуулийн компьютерийн систем дэхь оюутны хуучин экаунтын login нэр, парольдыг олж авахад амархан. Шинэ Зеландын ойн аж ахуйн газрын VMS системийн хүчинтэй байгаа экаунтыг тавьбал хүмүүсийн анхаарлыг илүү татна гэсэн үг.

Компьютерийн нууц ертөнцийн балчир хүүхдээс насанд хүрэгсэд хүртэлх хүмүүсийн сорилт явуулах талбар нь Минерва байлаа. Австралийн засгийн газрын эзэмшлийн Overseas Telecommunication Commission буюу ОТС байгууллага Минерваг ажиллуулдаг байв. Минерва бол Сиднейн гурван толгой компьютерийн системийг багтаасан юм. Мендакс нэртэй хакерын хувьд Минерва руу нэвтрэх үйлдэл сорилт адил байжээ.

1988 оны эхээр Мендакс хакерын ертөнцөд дөнгөж хөл тавьжээ. Тэрээр PI-ын олон нийтийн хэсгээс хувийн хэсэгт шилжиж дөнгөсөн толгой боловч амжилтандаа сэтгэл ханахгүй байв. The Force, The Wizard зэрэг хакеруудаар өөрийн ур чадварыг үнэлүүлэхийн тулд хакерууд Минерва систем дотор их цагийг өнгөрөөх шаардлагатай болно. Мендакс Минерва системд нэвтрэх оролдлого хийхээр шийджээ.

Минерва олон шалтгаанаар онцгойд тооцогдоно. Хэдийгээр энэ Сиднейд байсан ч үүнийг X.25 rad гэж нэрлэх агаад компьютер руу орох утасны дугаар нь үнэгүй дуудлага байв. Тухайн үед Мендакс Мелбурнийн захад байрлах Эмеральд сууринд амьдарч байлаа. Мелбурн руу хийсэн ихэнх утасны дуудлагаас хот хоорондын утасны төлбөр авдаг учраас олон улсын компьютерын системүүд рүү нэвтрэхийн тулд Мелбурнийн Их сургуулийн dial out дугаарыг олж авах нь зөв сонголт байв.

Эмеральд сууринг хот гэж хэлэхэд хэцүү юм. Арван зургаан настай ухаалаг хүүгийн хувьд уг суурин уйтгарлаж үхмээр газар байв. Мендакс өөрийн эхийн хамт амьдарна. Түүний орон гэр нь шил шилээ даран нүүх олон гэр бүлийн хорогдох газар мэт байжээ. Гэхдээ хэсэг хугацаанд ч аюулгүй тайван байдлыг хангах сууцанд Мендакс болон түүний туйлдсан гэр бүлийнхэн хоргодох шинэ газар олохын өмнө түр амсхийхээр буужээ. Мендакс хааяа л сургуульдаа явна.

Явахаас явахгүй нь их гэж хэлэхэд бараг болно. Түүний сонирхлыг сургууль нэг их татахгүй байв. Минерва л түүний оюун санааг сургуулиас илүү тэжээнэ. Орон нутгийн сургуулиас илүү Сидней хотын компьютерийн систем сонирхлыг нь татна.

Минерва бол Prime компьютер бөгөөд Prime төрлийн компьютерүүд хэрэгцээнд орж эхэлж байв. Австралийн компьютерийн нууц ертөнцөд 1987-1988 онд хамгийн их хүндлэл хүлээсэн хакер Force “Prime” төрлийн компьютерт хэрэглэгддэг тусгай үйлдлийн систем Primos-т мэргэжсэн байв. Компьютерийн одоогийн username ба password-ийг хангах програм хангамжийг Force зохиосон учир түүнийг компьютерийн ертөнцийн загварыг тодорхойлсон гэхэд болно.

Prime компьютерүүд овор ихтэй бөгөөд үнэтэй байсан учраас ямар ч хакер худалдан авч чадахгүй байлаа. Тиймээс хакер өөрийн програмыг хэрэглэхийн тулд Минерва шиг компьютерийн хурд, тооцоолох чадварт нэвтрэх боломж маш их үнэ цэнийг агуулна. Жишээлбэл ирээдүйд хакердах компьютерийг олохын тулд X.25 сүлжээн дээрх компьютерийн хаягуудыг цуглуулдаг network scanner програмыг хэрэглэнэ. Харин энэ програм тооцоолох нөөцийг шавхдаг тул компьютер хэвийн ажиллахгүй. Гэтэл Минерва шиг компьютер иймэрхүү төрлийн програмыг хялбархан ажиллуулна. Түүнчлэн Минерва дэлхийн хэрсэн X.25 сүлжээн дээрх бусад компьютертэй холбогдох боломжийг хэрэглэгчид олгоно. Үүнээс гадна Минерва өөр дээрээ BASIC хөрвүүлэгчтэй. Энэ нь тухайн үед хамгийн нийтлэг компьютерийн хэл болох BASIC програмчлалын хэл дээр програм бичих боломжийг хүмүүст олгоно. Тийм програмууд Минерва дээр ажилладаг юм. Гэвч та Форс шиг ОТС-ийн компьютер дээр ажилладаг програмыг бичиж ашиглах болон түүн шиг Primos үйлдлийн системийн бишрэгч байх шаардлагагүй. Минерва Мендаксд маш ихээр таалагдаж байв.

ОТС-ийн компьютерийн систем бусад олон талын ашигтай байлаа. Австралийн олонхи том корпорациуд энэ систем дээр эक्каунттай байлаа. Эक्каунт руу нууцаар нэвтрэхэд username, password шаардлагатай. Username-ийг олчихвол асуудлын хагасыг шийдсэн гэсэн үг. Үнэндээ Минервагийн эक्каунт нэрийг олж авахад нэг их төвөггүй байлаа. Эक्каунт нэр бүр нь гурван үсэг, гурван тооноос бүрдэх системийг хакердах нь үсэг, тоо таахаас хэцүү байж болно. Эхний гурван үсэг нь ямар нэгэн компаний товчилсон нэр байх нь тодорхой. Жишээлбэл ANZ Банк ANZ001, ANZ002 гэсэн эक्каунттай. Ихэнх компаниудын арын гурван тоо нь дээрхтэй адил загвартай байна. BHP001, CRA001, NAB001, OTC007 гэх мэт. Минерва дээр байгаа эक्каунт нэрсийг IQ өндөр биш хэн ч төвөггүй таах байсан юм. Пассвордыг олж мэдэхэд бага зэрэг хүндрэл гарах боловч Мендаксд зарим нэг санаа байв. Тэр social engineering аргыг хэрэглэхээр шийджээ. Social engineering гэдэг нь таны төлөө ямар нэгэн зүйлийг хийлгэхийн тулд эрх мэдэлд байгаа хэн нэгэнтэй хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр ярилцахыг хэлж байгаа юм. (Social engineering-нийгмийн буюу олон нийтэд хандсан шинжтэй үйл ажиллагаа явуулдаг инженерчлэл гэсэн утгатай-орч) Үүнийг хийхэд зарим нэг хуурч мэхлэх үйлдлийг ашиглана.

Минервагийн нэг хэрэглэгчийн пассвордыг авах social engineer ажиллагааг Мендакс хийв. Хэрэглэж чадах хүмүүст зориулан өөр нэгэн хакерын PI дээр тавьсан Минервагийн хэрэглэгчдийн нэрсийн жагсаалтын нэг хэсгийг тэр download хийж авжээ. Энэ жагсаалт хоёр жилийн настай бөгөөд бүрэн бус аж. Гэхдээ Минервагийн эक्каунтын хэрэглэгчийн нэр,

компаний нэр, хаяг, холбоо барих хүн, телефон утасны ба факсын дугаар зэргийг багтаасан 30 гаруй хуудас мэдээллийг бага хэмжээтэйд тооцохгүй. Тэдний зарим нь хүчинтэй байсаар л байгаа.

Түүний насанд Мендакс шингэн дуу хоолойтой байв. Боломжийн дуу хоолой байхгүйгээр social engineer талаар төсөөлөх ч хэрэг байхгүй юм. Social engineer болж жүжиглэх хүнд өсвөр насны хүүгийн дуу хоолойг өөрчлөх шаардлага тулгарна. Түүний дуу хоолой болломжийн байсан ч гэсэн албан байр, эсвэл Сиднейн утасны дугаар байхгүй. Мендаксийн хараанд өртсөн хохирогч түүн рүү буцаж утасдахыг хүсвэл яах вэ. Эцэст нь байнгын завгүй байдаг Сиднейн 02 area кодтой дугаарыг олж тогтоон Сиднейн утасны дугаартай холбоотой асуудлыг шийджээ. Нэг хүндрэл шийдэгдэж, нөгөө нь шийд хүлээсээр...

Дараагийн хүндрэл бол албан байрны жирийн дуу чимээг бодитоор бий болгох явдал байв. ОТС-ийн ажилтан болж аль нэгэн компани руу утсаар ярих үед цаана нь хөдөөний цэвэр агаарт шувуу жиргэх чимээ сонсогдвол үнэмшилтэй байх уу.

Үгүй ээ, түүнд Сиднейн төвийн хүн олноор цугларч, бум бужигнасан газрын дуу чимээ хэрэгтэй байлаа. Мендакс дуу хураагуураар офисийн дуу чимээг урьдчилан буулгаж аваад Минервагийн жагсаалтан дээрх компаниуд руу утасдахдаа дахин уншуулж болно. Харин зохих офисийн дуу чимээ олох нь нэг хүндрэл байв. Орон нутгийн шуудангийн салбар болломжийн дуу чимээг гаргах чадваргүй ажээ. Шаардлага хангахуйц офисийн дуу чимээ олж чадахгүйгээс хойш Мендакс тэрхүү дуу чимээг өөрөө гаргаж үзэхээр шийдэв. Энэ тийм ч хялбар зүйл биш ээ. Бичигч төхөөрөмж нь нэг замтай учир нэг дуу чимээн дээр өөр дуу чимээг нэмж найруулах болломжгүй юм. Тэр бүх дуу чимээг нэг дор гаргах шаардлагатай болов.

Эхлээд тэр телевизийн мэдээг маш бага дээр тавьж, утсаар ярих үед ард нь дүнгэнэж байхаар болголоо. Дараа нь Commodore MPS 801 принтерээр их хэмжээний бичиг баримт хэвлэхээр тааруулж бэлдэв. Цэгэн матриктэй хэвлэх машины тагийг авч шаардлагатай арын дуу чимээг гаргахаар таарууллаа. Түүнд бас өөр ямар нэгэн дуу чимээ шаардагдана. Операторуудын дуу чимээг хүн ихээр цугларсан газар гаргах хэрэгтэйг тэр санав. Тэр амандаа аажуухан үглэж болох боловч өрөөний голд зогсоод арван таван минут тасралтгүй ярих ур чадвар өөрт нь байхгүйг төд удалгүй ойлгожээ. Мендакс Шекспирийн ботийг авчирч, чангаар уншиж эхлэв. Уншлагыг хүн сонсох төдийд, гэхдээ Макбетийг хохирогч ойлгохооргүй нам дуугаар уншиж үзлээ. (Макбет-Шекспирийн зохиолд гардаг 1057 онд нас барсан Шотландийн хаан-орч) ОТС-ийн операторууд компьютерийн гар дээр ажилладаг. Тиймээс өөрийн компьютерийн гар дээр хааяа нэг товшиж эхлэв. Дуу чимээг бичиж байх зуур бичигч рүү дөхөн очиж ямар нэгэн асуулт асуугаад өөр хүний гэмээр дуугаар хариултыг тэрээр даруй хэлж байлаа. Дараа нь бичигчээс холдохдоо шал хүчтэй товшин алхаж, өрөөг хөндлөн гулд туулан, буцаж аажуухан гэтэн компьютерийн гар руу дөхөж хэд товшоод Макбетийн үглэх чимээг гаргана.

Үүнд бас хөөрхөн хөдөлмөр шаардах ажээ. Бичлэг хамгийн багадаа арван таван минут тасралтгүй хийгдэх ёстой гэж тэр үзэв. Офисын дуу чимээ гэнэт таг болж хэдэн секунд үргэлжилбэл бодитой санагдахгүй. Бичлэгийг олон дахин хийж үзэв. Шекспирийн мөрийг уншиж, компьютерийн гар дээр хэд цохиод, принтерийн цаас шажигнах байх зуур дарга

аятай асуулт асууна. Чөтгөр гэж! Тэр дахиад л бүгдийг шинээр эхэлнэ. Дуу чимээний шизофрениэр өвчилсний дараа хэдэн цаг оролдсоны эцэст офисын дажгүй дуу чимээг гаргаж авлаа.

Ингээд Минервагийн хэрэглэгчдийн жагсаалтын хэсгийг харж, ажиллагаагаа эхлэв.

“Таны залгасан дугаар холбогдсонгүй. Утасны дугаараа шалгаад дахин залгана уу”.

Дараагийн дугаар.

“Уучлаарай тэр одоо хуралтай байна. Тань руу дахин залгуулах уу?” Аа, зүгээр, баярлалаа.

Бас нэгэн оролдлого.

Дажгүй амжилт.

Перт хот дахь нэгэн компаний холбоо барих нэрсийг тэр олжээ. Хүчинтэй дугаар, компани, холбоо барих нэр. Тэр дуугаа бүдүүрүүлэхийн тулд хоолойгоо засаад, яриагаа эхлэв.

“Миний нэрийг Жон Келлар гэдэг. Сиднейн ОТС Минервагийн оператор байна. Манай D090 хард драйвуудын нэг эвдэрчихлээ. Хамгаалалтын back up хальс дээрх мэдээллийн санг бид дахин татаж авсан. Тэгээд таны мэдээлэл үнэн зөв гэдэгт бид найдаж байна. Гэхдээ зарим төрлийн мэдээлэл эвдрэлийн үеэр өөрчлөгдсөн байж болно. Тиймээс таны мэдээллийг бид дахин нягтлахыг хүссэн юм. Мөн бидэнд байгаа back up хальс хоёр хоног болсон учраас таньд үзүүлэх үйлчилгээ саадгүй байх үүднээс таны мэдээллийг шалгахыг хүслээ. Таны мэдээллийг дахин тулгаж асуухыг надад зөвшөөрнө үү...” Мендакс ширээн дээр байсан хэсэг цаасыг шажигнуулав.

“Өө баларсан юм аа. Тэгье тэгье.” гэж санаа зовсон менежер хариуллаа.

Мендакс Pacific Island-аас авсан Минервагийн жагсаалт дээрх мэдээллийг эхнээс нь уншив. Тэр зөвхөн факсийн дугаарыг бага зэрэг өөрчиллөө. Оролдлого амжилттай болов. Менежер яг тэр мөчид: “өө үгүй, наадах чинь буруу байна. Бидний факсын дугаар буруу байна” гээд зөв дугаарыг өглөө.

Мендакс сэтгэл түгшсэн дүр үзүүлэв. “Хм” гэж тэр менежерт хэлээд: “Бид төсөөлж байснаас илүү асуудалтай учирсан бололтой. Хм” хэмээн түгдэрлээ. Тэр томоохон асуулт асуухаар зүрхээ чангалан пауз авчээ.

Хэн илүү хөлөрч байгааг хэлэхэд хэцүү ажээ. Минервагийн эккаунт буруу байсан гэж компаний ажилтнууд эгдүүцэх байх гэж сэтгэсэн Пертийн менежер үү эсвэл анх удаагаа social engineering-ийн үйлчилгээг хийхийг хичээж байгаа хүүхэд үү?

Эрх мэдлийг гартаа байлгах хүний адил дуу хоолой гаргахыг хичээх Мендакс: “За тэгэхлээр бид танай эккаунтын дугаарыг авлаа, гэхдээ пассвордыг шалгах хэрэгтэй... ямар пассвордтой вэ?” гэж асуув. Сум нумнаас тавигдлаа...

Сум байгаа оножээ. “За, L-U-R-C-H”. Lurch гэнээ? Аанха, Аддамсийн гэр бүлийн бишрэн шүтэгч.

“Бүх зүйл хэвийн ажиллаж байгааг шалгаж өгнө үү? Бид өөрсдийн үйлчилгээ доголдохыг хүсэхгүй байна” гэж Пертийн менежер сандран хэлэв.

Мендакс компьютерийн гар дээр ганц нэг товшлоод, пауз авснаа: “Тэгэхлээр одоо бүх зүйл хэвийн ажиллаж байна. Зүгээр санаа зоволтгүй” гэж хурдхан хэллээ.

“За за сэтгэл амарлаа!” гэж Пертийн менежер уулга алдаад “Баярлалаа, маш их баярлалаа, Бидэн рүү утасдсанд маш их талархлаа!” гэв.

Мендакс өөрийгөө тайвшруулах хэрэгтэй байв. Тэр сандарч эхэлжээ. “За одоо ингээд тасалъяа. Олон үйлчлүүлэгч рүү утасдана”. Түүний хүлээж байсанчлан Пертийн менежер түүнтэй холбоо барих утасны дугаарыг асуув. Урьдчилан бэлдсэн, байнгын завгүй байдаг өнөөх утасны дугаарыг Мендакс өглөө.

“Эелдэг үйлчилгээ үзүүлсэнд баярлалаа!”. (Ёоох...) Танд байнга туслахдаа бэлэн байна гээд Мендакс утсаа тавин, Минервагийн үнэгүй дугаар руу залгаж үзэв. Пассворд ажиллаж байв. Мендакс хялбархан амжуулсан ажилдаа итгэж ядна.

Ихэнх хакерууд шинэ компьютерт нууцаар нэвтрээд орчноо хурдхан судалдаг хэв маягийг тэр дагажээ. Зээлсэн эккаунтын цахим шууданг шалгах нь хамгийн эхэнд хийх ёстой үйлдэл. Цахим шуудан бол үнэтэй мэдээллийг хадгалдаг. Нэг компаний менежер өөр эккаунтын нэр, пассворд, бүр модем руу залгах утасны дугаарыг хүртэл илгээж болно. Дараа нь мэдээллийн сайн эх сурвалж, үндсэн систем дээрх зүйлийг хэн ч уншиж болох directory буюу файлын жагсаалтыг шалгана. Эцсийн зогсоол: Минервагийн мэдээллийн bulletin board. Үүнд бусад үйлчилгээний асуудал эсвэл төлөвлөгөөт завсарлагааны талаар системийн оператороос тавьсан зарыг олж мэдэх боломжтой. Тэр удаан сэлгүүцсэнгүй. Хамгийн анхны айлчлал бол ихэнхдээ тагнах чиглэлтэй байдаг.

Минерва олон талын ашигтай. Тэдний нэг нь олон төрлийн X.25 сүлжээнүүд рүү хакерууд нэвтрэх боломжийг Минерва өгдөгт оршино. Компьютер харилцааны сүлжээний төрөл X.25 бол Unix дээр үндэслэсэн интернет эсвэл VMS дээр үндэслэсэн DECNET-тэй маш адилхан. Энэ нь өөр командууд, протоколуудтай боловч дэлхий даяар тархсан дата холбооны сүлжээний зарчимтай ижилхэн юм. Гэхдээ бас нэг чухал ялгаа бий. X.25 дээрх хакеруудад зориулагдсан хохирогчид бусдын сонирхлыг илүү татна. Жишээлбэл ихэнх банкууд X.25 дээр байдаг. Үнэндээ X.25 бол дэлхийн санхүүгийн зах зээлийн олон талын ачааг үүрдэг юм. Нилээд олон улсын цэргийн нууц компьютерийн сайтууд зөвхөн X.25 дээр явагдана. Үүнийг DECNET систем болон интернетээс хамаагүй аюулгүй гэж олон хүн үздэг билээ.

Тухайн үеийн Австралийн ихэнх Их сургуулиудын сүлжээ санал болгохгүй боломжийг Минерва олгож, ирж байгаа утасны дуудлагыг X.25 сүлжээгээр дамжуулдаг байсан юм. Минерва нь хот хоорондын утасны ярианы төлбөр төлөхгүй утсаар ярих боломжийг Австраличуудад олгож байв.

Минерваг ашигласан эхний өдрүүдэд ОТС-ийн операторууд хакеруудад нэг их анхаарал тавьдаггүй байв. Магадгүй тэднээс ангижирахад амар бус байсан биз. ОТС-ийн операторууд Х.25-ийн дата сүлжээний телефон утасны станцтай адилхан гэж хэлэхээр ОТС Х.25 станцыг ажиллуулж байсан билээ.

Майкл Роузенбергийг тулааны талбар дээр гарч иртэл Австралийн эхэн үеийн хакерууд тааваар зугаацаж байв. Онлайн дээр MichealR гэсэн нэрээр алдаршсан Роузенберг Минерваг цэвэрлэхээр шийджээ. Куинсландийн Их сургуулийг төгссөн инженер Майкл Сидней рүү нүүж, ОТС-д ажилд орохдоо 21 настай байлаа. Тэрээр системээс цэвэрлэгдэж байсан хакуруудтай ойролцоо настай байв. Роузенберг ОТС-ийн оператороор бус харин Минервагийн програм хангамжийн хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй ажиллана. Тэр Форс шиг хүмүүсийн амьдралыг там болгон хувиргаж чадсан юм. Хакеруудын хэрэглэдэг эккаунтуудыг чимээгүйхэн ажиглан, аюулгүйн нүхийг битүүлж, тэдгээр эккаунтуудыг устгаснаар ОТС-ийн Минервад байгаа хакерийн ихэнх үйл ажиллагааг Роузенберг хялбархан цэвэрлэж чаджээ.

Иймээс “Миний хакерууд” хэмээн байнгын зочдоо нэрлэдэг Роузенбергийг хакерууд огт хүндлэхгүй байх нь аргагүй юм. ОТС-ийн бусад ажилтнуудын адил тэрээр техникийн өндөр боловсролтой бөгөөд техникийн мэдлэг ур чадварыг мөнгөөр үнэлдэг ертөнцөд Роузенберг баян залуу байлаа.

Тэрээр хакеруудыг барьж авахыг хүссэн ч шорон руу илгээхийг хүсээгүй аж. Тэд түүний цухалдлыг төрүүлнэ. Харин Роузенберг тэднийг системээсээ холдуулахыг л хүсэж байв. Хакерын мөрөөр оронгуут тухайн үед ОТС-ээс тусдаа байгууллага байсан Telecom-оор нэвтрэх хэрэг гарна. Байгууллагын нууцын тухай хатуу хуулийн дагуу тийм зүйлийг хийж болохгүй гэж Telecom-ийнхон Роузенбергт хэлжээ. Тиймээс ихэнх хакеруудтай өөрийн нүцгэн гараар бие даан тулалдах сонголт үлдлээ. ОТС өөрийн үйлчлүүлэгчид пассворд тараах эрхгүй учир Роузенберг системээ бүрэн хамгаалж чадахгүй байлаа. Тэдний үйлчлүүлэгчид зальт хакеруудаас урьдчилан сэргийлэхэд анхаарал тавихын оронд ажилтнууд нь пассвордыг амархан цээжилчих чадвартай эсэхэд сэтгэл зовох ажээ. Ийм шалтгаанаар Минервагийн олон эккаунтын пассвордыг амархан таачих боломжтой байв.

1988-1990 оны хооронд ОТС ба хакеруудын хоорондхи дайн олон хэлбэрээр үргэлжилсэн юм. Заримдаа ОТС-ийн операторууд хакерын онлайн session-д орж ирэн, хэн эккаунтыг эзэмшиж байгааг мэдэхийг оролдоно. Хааяа операторууд доромжилсон мессэжийг хакерууд руу илгээнэ, харин тэд буцаан хариу барина. Хакерын session-д орсон оператор: “Өө, чи тэнэг амьтан дахиад л энд байж байна уу” гэж мессэж үлдээнэ. Операторууд хакеруудыг бүрэн зайлуулж чадахгүй ч өөр аргазамаар хариугаа авах ажээ.

Австралийн компьютер ертөнцийн өсөж байгаа од, Мелбурнийн хакер Электрон ОТС-ийн Х.25 холболтыг ашиглан Герман дахь систем рүү log хийв. Минервагийн охин систем гэж хэлж болох VMS компьютерийг ашиглан Altos системийн Хаант улс нэртэй тоглоомыг тэр тогложээ. Энэ бол хакеруудын цагаа өнгөрөөх дуртай тоглоом байв. Дэлхийн эргэн тойрны олон тоглогчдын анхаарлыг татсан дайны стратегийн тухай иж бүрэн тоглоом Empire дээр хийж байгаа түүний анхны оролдлого энэ байлаа. Хакерууд стратегийн түвшний үйлдвэрлэлийн нэгжүүдийг мэдэлдээ оруулж байх зуураа бүс нутгийг булаан эзлэхэд өдөрт

нэг цагаас бага хугацаа зарцуулдаг байв. Мелбурнийн хакер өөрийн байр суурийг хадгалж үлдэхийн тулд хэдэн долоо хоногийг өнгөрөөжээ. Тэр хоёрдугаар байранд оров.

Минерва ба Германы системээр дамжин тоглоом руу log хийсэн нэгэн өдөр дэлгэц дээр харсан зүйлдээ тэрээр огт итгэхгүй байлаа. Түүний эзэлсэн бүс нутаг, тоглоомд эзэлсэн байр суурь болон хэдэн долоо хоногийн хичээл зүтгэл талаар болж, арчигдсан байв. OTC-ын оператор X.25 packet sniffer програмыг ашиглан хакерын login-ийг хянаж, Empire тоглоом руу орох пассвордыг олзолжээ. Ёс суртахуунгүй доромжлол хэрэглэх тактикийн оронд хакерыг тоглоомоос logoff хийхийг оператор хүлээж байгаад, тоглоом руу өөрөө орж хакерын нөр их хөдөлмөрийг үгүй хийв.

Электрон галзуурах дөхтлөө уурлажээ. Хамгийн анхны тоглоомд эзэлсэн байр сууриараа тэр маш их бахархаж байв. Гэхдээ Минерва системийг бусниулж, хариугаа авах асуудал шаардлагагүй юм. Түүний олон долоо хоногийн ажлыг үгүй хийсэн ч Минервад гэмтэл учруулах хүсэл Электронд төрсөнгүй. Энэ системийг удаан хугацаанд хэрэглэсэн нь аз гэж тэр боджээ.

PI ба Zen-ий BBS-үүд дээр өөгшүүлж байсан зарим байгууллагын бодлогын эсрэг хандлага шинээр гарч ирсэн хакеруудын сэтгэлээр хооллож байв. Тэнд зөвхөн хуучин өлгийгөө авч хаяад шинэ рүү шумбан орох хүсэл тэмүүлэл байлаа. Томоохон нээлтүүдийг байнга эрэлхийлэх, баяр баясгалантай өсвөр насны мэдрэмж дунд найз нөхдүүдийн хоорондох итгэлцэл бий болжээ. Хүмүүс өөрсдийн модемуудыг ашиглан тэдний компьютер руу дуудлага хийн, туршиж байв. Тэд өдөр шөнөгүй сэтгэлийн дуудлагаа дагана. Тэдгээр хакерууд хар тамхитай холбогдож байсангүй. Наснаасаа болоод ч тэр юм уу согтууруулах ундаа их удаггүй байлаа. Ихийг мэдэхийг хүссэн сэтгэлд нь хөндлөнгөөс нөлөөлөх зүйлүүд тэдний хурц ухааныг мохооно. Нууц ертөнцийн гишүүдийн ямар нэгэн байгууллагын эсрэг үзэл бодол нь ихэвчлэн Telecom мэтийн байгууллага руу чиглэж байв. Ийм байгууллага тэдний шинэ хүсэл тэмүүллийг хааж байна гэж тэд үздэг юм.

‘Telecom’ гэсэн үг хүчтэй сонсогдож байлаа. Энэ үгийг тэр үеийн компьютерийн нууц ертөнцийн гишүүдэд хэлбэл хамгийн этгээд хариу үйлдлийг та ажиглах болно. Тэдний царайд үзэн ядсан дүр шууд илэрнэ. Уруулаа мушийлган “Telescum” гэж доромжлон хэлээд хорсолтойгоор инээх биз. (telescum – теле хог, шаар гэсэн утгатай болно-орч) Нууц ертөнцийнхөн Австралийн үндэсний телефон компанийг аливааг нээх хүсэл сонирхолтой адил хэмжээгээр үзэн ядаж байв. Telecom хөгжлийг хойш татаж, ажилтнууд нь теле харилцаа холбооны технологийг хэрхэн хэрэглэхээ мэддэггүй гэж тэд үзнэ. Түүнчлэн BBS-ийн үйл ажиллагааг Telecom идэвхитэй эсэргүүцэгч мэт санагдана.

Нэг модем нөгөөтэйгээ харьцаж байхад шугамын дуу чимээ маш их саад хийх агаад шугамын дуу чимээнд Telecom буруутай гэж нууц ертөнцийн гишүүд үздэг. Нилээд амттай ярилцлагын дундуур учир үл ойлгогдох үсэг, тоонууд буюу “‘2’28 v’1’;D>nj4” гэж бичсэн мөр гарч ирэхийг хакер PI дээрх мессэжнээс уншна. “Шугамын дуу чимээ. Чөтгөр аваг Telecom! Тэд дээд зэргээр үймүүлэн, саад хийж байна” гэсэн тайлбар үүнийг дагалдана. Заримдаа хакерыг logoff хийтэл нь шугамын дуу чимээдуугарах бөгөөд BBS рүү залгасаар дахиад 45 минутыг алдах байдалд оруулдаг байв. Модемууд алдаа засах функцгүй ба модемны хурд нь өндөр байх тусам шугамын дуу чимээ ихэснэ. Үүний улмаас Telecom-ын шугамын дуу чимээ ихсэхээс

өмнө хакерууд цахим шуудангаа хурдан шалгаад, хэдэн мессэж үлдээн logoff хийх байдалд хүргэдэг байв.

Удалгүй Telecom орон нутгийн утасны дуудлагын үнээр үйлчилгээ үзүүлдэг болно гэсэн цуурхал нууц ертөнцийн хүрээнд яригдах болов. Уурлаж зэвүүцсэн уур амьсгал ноёлж эхэллээ. Орон нутгийн утасны дуудлагын үнээр BBS-д log хийж ордог болно гэдэгт BBS-ын хүрээнийхэн итгэжээ. Түүнчлэн Telecom компани нь нэг BBS-д ирэх дуудлагыг нэг цаг хагасын хугацаатайгаар хязгаарлана гэсэн цуурхал гарсан нь бүр жигшмээр байлаа. Тэр цагаас хойш компьютерийн нууц ертөнцийнхөн Telecom-ийг Teleprofit гэж хочлох болов. (Teleprofit-Теле ашиг гэсэн утгатай-орч)

Telecom-ын Хамгаалалтын албаны нэгжийг BBS-ын хэрэглэгчид дайснаа гэж үзнэ. Тэд электроникийн цагдаа нар байлаа. Компьютерийн далд дайчид хамгаалалтын албыг компьютерийг нь хэзээ ч хураан авах, утасны шугамыг нь чагнах, гэр оронд нь гэнэтийн нэгжлэг хийх хуулийн байгууллагатай адил үздэг байв. Энэ бол Telecom-ыг үзэн ядах хамгийн том шалтгаан байсан юм.

Компьютерийн хакерууд Telecom-ыг үйл ажиллагаанд хорлон сүйтгэх ажиллагаа хийх талаар хэлэлцэх болтлоо ихээр үзэн ядсан байв. Зарим нь телефон утасны шугамаар 240 вольтийн цахилгаан гүйлгэх талаар яринэ. Хэрэв тэгвэл телефон утасны төв станцыг дэлбэлж, тухайн үед кабель дээр ажиллаж байсан техникийн ажилтнуудыг будаа болгох байсан биз. Telecom компаний шугам дээр цахилгаан гүйдлийг зогсоох гал хамгаалагчтай боловч BBS-ын хакерууд тэдгээрийг даван гарч өндөр давгамжтай вольтийг дамжуулах гүйдлийн төлөвлөгөө боловсруулжээ. Харин нууц ертөнцийн зарим гишүүд Telecom компаний төв станцын гаднах бүх кабелиудыг шатаах талаар төлөвлөж байв.

Энэ бол далд ертөнцийн гишүүд фреакинг хийж байна гэх ярианы эсрэг хийсэн ажиллагаа байлаа. Фреакинг гэдгийг телефон утасны системийг хакердах үйлдэл гэж ойлгож болно. Зарим хүмүүс фреакинг бол хот хоорондын утасны дуудлагыг үнэгүй хийхийн тулд хүмүүсийн кредит картны дугаарыг хулгайлах үйлдлийг хамруулдаг гэдэгт итгэдэг. Харин Пуристууд энэхүү тодорхойлолтыг няцаасан юм. Тэдний хувьд хулгайлагдсан кредит картыг хэрэглэх бол фреакинг биш, картинг гэдэг ажээ. Фреакингийг хийхэд тодорхой хэмжээний техникийн ур чадвар, телефон утасны төв станцын мэдлэг, тодорхой арга тактик шаардлагатай гэж тэд маргана. Утасны шугамын вольтыг өөрчлөх, тусгай дууг бий болгохын тулд цахилгаан гүйдэл эсвэл компьютер хэрэглэн энэ ажиллагааг хийдэг. Тодорхой телефон утасны шугамыг телефон утасны төв станц хэрхэн удирдаж байгааг фреакингийн арга өөрчилнө. Үүний үр дүнд үнэгүй бөгөөд мөрөөр нь буцаан хөөж болохгүй утасны дуудлагыг хийнэ. Фреакинг бол дэлхийн хаа нэгтээ байгаа найзуудтайгаа үнэгүй ярихаас илүүтэй телефон утасны шугамаар нь мөшгих ажиллагаанаас зайлсхийх арга зам гэж пурист хакерууд үздэг.

1988 онд ойролцоогоор зургаан сарын хугацаанд фреакинг, дараа нь картинг руу шилжих эхний үе хийгдсэн юм. PI ба Zen-ий эхэн үеийн хакерууд олон улсын компьютерийн сайтуудаар хэсэхийн тулд Мелбурнийн Их сургуулийн эсвэл Telecom-ын Клейтон дахь офистой адилхан dial out-д найдаж байв. Түүнчлэн тэд АНУ, Швед, Герман зэрэг улсуудаар аялахад X.25 dial out-ийг хэрэглэж байлаа.

Эцэстээ dial out-ийг ашигладаг хүмүүс сул талыг нь олж мэдэв. Удалгүй dial out хэрэгцээнээс шахагдаж эхэллээ. Пассвордууд өөрчлөгдөв. Харин хакерууд хилийн чанад дахь системүүд рүү орохоос татгалзахыг хүсэхгүй байлаа. Тэд олон улсын дуудлага хийх анхны амтыг мэдрээд, цааш илүү ихийг хүснэ. Тэнд нээлт хийхийг хүлээсэн маш том, электроникийн гялалзсан ертөнц байлаа. Хакерууд явахыг хүссэн газар руугаа хүрэх янз бүрийн аргуудыг оролдож эхлэв. Үүний хажуугаар Мелбурнийн компьютерийн ертөнцийн гишүүд фреакинг хийх замдаа оржээ.

Фреакерчууд PABX руу балан дээр шавах зөгийнүүд мэт дайрлаа. PABX (private automatic branch exchange-теле холбооны автомат зохицуулалттай жижиг станц-орч) нь жижигхэн Telecom-ийн телефон утасны төв станц мэт ажиллана. Томоохон компаний ажилтан нь PABX-ийг ашиглан нэг байранд ажиллаж байгаа нөгөө ажилтан руу утасдвал орон нутгийн утасны дуудлагын үнийг төлөхгүй юм. Жишээлбэл: Хэрэв ажилтан хотоос гадагш байрлах зочид буудалд байрлаж байхдаа зочид буудлын холын дуудлагаас авдаг өндөр мөлжлөгнөөс (төлбөрөөс) зайлсхийн өөрийн компаний PABX-аар дамжуулан бүх утасны дуудлага хийхийг хүсэж болно. Компаний ажилтан албан томилолтоор Брисбанд байгаа бол Сиднейд орших компаний PABX рүү Брисбаний утасны дугаараар залгана. Тэндээс Ром, Лондон руу залгаж ярих агаад төлбөр шууд компаний төлбөр дээр гарна. Компаний ажилтан ашиглаж байгаа зүйлийг фреакер мөн адил ашиглана.

PABX руу залгаж байгаа фреакерт дахин залгалт хийхийн тулд пассвордыг мэдэх эсвэл таах шаардлага гарна. Ихэнх тохиолдолд фреакераас ажилтны дотуур утасны дугаарыг автомат мессэжээр дамжуулан асуудаг. Энэ дугаартай нь нэвтрэх пассворд адилхан байна. Тэгэхлээр асуудал нэг их хүндрэлгүй шийдэгдэнэ гэсэн үг. Фреакер таамгаар хэдэн тоо хийсээр залгагдаж болох дотуур утасны дугаарыг олчихно.

Зарим үед PABX систем пассвордгүй байх тохиолдол бий. PABX-ын менежер утасны дугаарыг нууц байлгах нь аюулгүй байдлын баталгаа гэж үзсэнээс тэр байх л даа. Хааяа фреакерууд PABX-ын тодорхой бренд эсвэл моделийн аюулгүй байдлын алдааг ашиглан PABX-аас үнэгүй дуудлага хийдэг. Олон хувилбарт тусгайтовчлуурыг дарснаар компаний нэр, ажилтны нэр, пассвордыг хүртэл мэдэхгүй фреакер санасандаа хүрч болно.

BBS дээрх харилцаа, үйл ажиллагаа үеэ өнгөрөөж, хакердах үйлдлийг фреакинг давамгайлах боллоо. Ингээд PI дээр фреакинг хийх хувийн хэсгийг нээв. Тухайн үед өөрийгөө хакер гэж нэрлэвэл хөгширсөнд тооцогдох болж, фреакинг урагшлах замыг гэрэлтүүлж эхэллээ.

Энэ шилжилтийн үед Таван Фреакер үүсгэн байгуулагдсан юм. Фреакер болж хувирсан таван хакерийн бүлэг PI-ийн тусгай хэсэг дээр цугларчээ. Шөнө дундаас хойш хийх тэдний аялал BBS-ийн бусад хэсэгт нэвчиж, фреакер болохыг хүсэгчдын атаархлыг төрүүлэх боллоо.

Эхлээд фреакерүүд ихэнх гудамжинд хаа сайгүй зоосон, дугуй саарал бүрхүүлтэй телефон утасны бүхээгийг сонгоно. Шөнийн цагт хүний хөдөлгөөнөөс хол зарим газар, цэцэрлэгт хүрээлэнгийн ойролцоо байгаа утасны бүхээг хамгийн тохиромжтой. Хотын захын хувийн байшингуудын үүд хавьцаа байрлуулсан утасны зангилаа байршсан бүхээг бага зэрэг эрсдэлтэй. Магадгүй сэжигтэй харагдсан бүхнийг цагдаа руу утасдаж хэлэх дуртай хөгшин авгай тэнд амьдардаг ч юм билүү. Хэрэв тэр хөгшин авгай хөшигний цаанаас харлаа гэхэд

хачирхалтай ажиллагааны гэрч болох байсан бизээ.

Ачааны битүү тэрэгнээс таван хакерын нэг нь үсрэн бууж, Telecom-ын техникийн ажилтнаас хулгайлсан, зээлсэн, гуйж авсан түлхүүрээр бүхээгийг онгойлгоно. Түлхүүрийг олж авахад амархан. Зургаан багц шар айргаар солих эсвэл хууль ёсны аргаар Telecom-ын засварчнаас 500 метр кабель, эсвэл утасны бүхээгний түлхүүр зэрэг Telecom-ын үнэт хэрэгслүүдийг олж авсан тухай хөгжилтэй түүхээр BBS-ын мессэж самбар дүүрэн байлаа.

Ингээд фреакер хэн нэгний утасны шугам, утасны зангилааг бүхээгнээс олж сонгоно. Дараа нь кабелийн бүрээсийг хуулж, хоёр хавчаар зүүнэ. Хэрэв фреакерутсаар ярихыг хүсвэл Telecom-оос хулгайлсан эсвэл худалдаж авсан гар харилцуурыг ашиглана. Хэрэв утсаар ярихын оронд өөр нэгэн компьютер руу залгахыг хүсвэл утасны шугамыг фреакерын компьютер руу сунгах хэрэгтэй. Энэ үед Telecom-ын 500 метр кабелийн хэрэг гарна. Урт кабель ашигласнаар машин дотор байгаа таван залуу утасны бүхээгний хажууд хэдэн цагаар суух шаардлагагүй болно. Шөнө орой нохойгаа салхилуулж яваа оршин суугч үүнийг харвал ихэд сэжигтэй санагдах бизээ.

Фреакерүүд гудамж дагуу кабелийг татна. Болж өгвөл булан тойруулна. Сунгасан кабелийн үзүүрийг машин дотор байгаа модем руу залгана. Таван хакерын нэг нь автомашины аккумулятор руу модем, компьютерийг холбох чадварыг эзэмшсэн байдаг. Одоо таван фреакер мөнгө төлөхгүй, мөрдөх аюулгүйгээр ямар ч компьютер руу холбогдоно. Утасны дуудлагын төлбөр нөгөө үзүүрт байгаа орон нутгийн иргэний утасны билл дээр гарна. Тухайн үед Telecom компани оршин суугчдын утасны билл дээр ярьсан дуудлага бүрийг нэг бүрчлэн жагсааж үзүүлдэггүй байжээ. Компьютер, матар хошуутай утасны хавчаар, тэжээлийн адаптороор зэвсэглэсэн залуус хотын захын гудамжинд шөнийн цагаар сэлгүүцэх дүр зураг нийтлэг үзэгдэлд тооцогдох боллоо. Ийм ажиллагаа жинхэнэ хакердах үйлдлээс ялгаагүй хууль бус байсан юм. Харин фреакер залуус үүнийг ухаалаг бөгөөд хөгжилтэй ажиллагаа гэж үзнэ.

Таван Фреакерийн үйл ажиллагаанд Крейг Боуен нэг их анхаарал тавьсангүй. Гэхдээ фреакинг хийх үйлдэл ихсэж байгаад тэр бага зэрэг сэтгэл түгшиж байсан юм. Энэ ажиллагаанд техникийн ур чадвар, тодорхой хэмжээний хакерын мэдлэг шаардлагагүй гэдэгт Боуен итгэж байв. Түүний бодлоор хакердах бол компьютерийн шинэ ертөнцийг зоригтойгоор нээх үйлдэл байлаа. Харин Фреакерууд бол сайн хакерын доор байх ёстой гэж тэр үзнэ.

Хакердах үйл ажиллагаа шаардлагатай хэвээр байна гэдэгт тэр итгэсээр байв. Хакеруудын ихэнх нь фреакинг хийх үндсэн ур чадвараа ахиулж байсан хэдий ч үүнийг компьютер “А”-аас “Б” рүү холбогдохоос өөр ноцтой ажиллагаа биш гэж Боуен зүтгэсээр байлаа. Тэгэвч РИ-ийн хувийн хэсэгт фреакингийн тухай хэлэлцүүлгийг тэр байрлуулсан юм.

Гэхдээ кредит картны залилангийн хэргийг тойрсон хэлэлцүүлэг хийлгэхээс татгалзаж байв. Компьютерийн зарим сонирхогчид фреакингээс картинг руу шилжиж эхэлснийг ажигласан Боуен картингийг маш ихээр эсэргүүцэж байлаа.

Фреакинг руу шилжиж байсан шиг картинг руу хошуурах нь зайлшгүй тохиолдох үзэгдэл

байсан юм. Энэ үзэгдэл 1988 онд ойролцоогоор зургаан сар хиртэй үргэлжилсэн бөгөөд шивнэлдэж байгаа охидын бөөгнөрөл адил нүднээ ил байлаа.

Картинг бол фреакингийн нэг төрөл гэж олон фреакерууд үзэж байв. Үнэндээ бол ямар нэгэн компаний PABX-ийг оролдохоос хавьгүй амархан үйлдэл юм. Оператор руу утас цохиж, хэн нэгэн танихгүй хүний кредит картны дугаарыг өгөөд утасны дуудлага хийсэн төлбөрийг хийнэ. Ингээд тэд гол ажилдаа орно. Мэдээж кредит картыг PABX-ийг бодвол хамаагүй өргөн хүрээгээр хэрэглэнэ. Та АНУ эсвэл Англи дахь өөрийн найзууд руугаа утасдаж, нэгэн зэрэг дуут конференс хийж болдог нь картингийн давуу тал. Харин PABX дээр ингэх нь илүү хэцүү байдаг аж. Мөн өөр зарим ашиг тус бий. Та кредит картаар эд зүйл худалдан авах төлбөрийг хийнэ. Жишээлбэл шуудангаар эд зүйл худалдан авах захиалга өгнө.

Иван Троцкий нэртэй хакерын бүлгийн нэг гишүүн АНУ-аас захисан скейтээс эхлээд 50,000 долларын эд зүйлийг хулгайлагдсан картаар захиалжээ. Гэвч тэр захиалсан зүйлээ гар дээрээ авч чадаагүй юм. Гаалийн байцаагчид хулгайн кредит картаар гаалийн татвар төлөх явдлыг таатай хүлээж аваагүй бололтой. Өөр нэгэн тохиолдолд Троцкий илүү амжилттай байсан юм. Карл Маркс, Лениний зургийг өөрийн компьютерийн терминалын хажууд байрлуулсан хичээнгүй хакер Троцкий далд ертөнц даяар коммунист номлолыг байнга цацна. Харьцангуй бие даасан мөртлөө зөрчилдөөнт үзэл бодолтой тэрээр Австралийн Коммунист Намын уулзалтанд оролцож, нугас буудан чөлөөт цагаа өнгөрөөдөг байлаа. Нэгэн хакерын хэлснээр: хулгайлагдсан кредит карт ашиглан АНУ-аас өндөр үнэтэй модемуудыг зөөх зохицуулалт хийсэн нь капиталист дэглэмийг түлхэн унагаахад оруулж байгаа Троцкийн хувь нэмэр ажээ. Компьютерийн хүрээнийхэнд модем бүрийг 200 доллараар зарж, чамгүй орлого олсон тухай цуу яриа ч байдаг юм. Коммунист хувьсгалын хэсэг болсноор түүнд олон төрлийн ашиг тусыг өгсөн нь тодорхой. Намын гишүүнчлэл нь бас нэгэн давуу тал байв.

Боуений хувьд картинг бол хулгай хийхээс илүү үйлдэл байлаа. Хакердах нь ёс суртахуунтай шууд холбоотой асуудалаас гадна 1988 оны эхээр Австралид хууль ёсныүйлдэл биш байв. Картинг бол үүнийг эсрэгээр ёс суртахууны болон хуулийн ноцтой асуудал юм. Маргаан хоёрдмол утгыг агуулж байсан ч зарим хүмүүс хакердах үйлдлийг хулгай хийх гэмт хэргийн нэг төрөл, хэн нэгний компьютерийн эх сурвалжаас хулгайлах гэмт хэрэг гэж үзэж байсныг Боуен мэдэж байв. Хэрэв тэдгээр эх сурвалж тэр шөнийн 2 цагт хэнд ч хэрэггүй байвал юу болох вэ? Үүнийг “зээлэх” гэж үзвэл илүү дээр санагдана. Учир нь хакерууд ямар ч хөрөнгийг байнгын шинжтэй эзэмшдэггүй шүү дээ. Картингийн хувьд тийм бишээ.

Хөдлөх механизмтай тоглоомын хэмжээтэй техник сэтгэлгээ шаардлагатай учраас картинг нэр хүндгүй болсон юм. Картинг нь ихэнх сайн хакеруудын дор ороод зогсохгүй хакердах урлагт буруу гарын хүмүүсийг уруу татах муу талтай байв. Нууцаар нэвтэрсэн компьютерийн системд гэмтэл бүү учруул; тэнд байгаа мэдээллийг бүү өөрчил (өөрийн ул мөрийг далдлахын тулд log-уудыг өөрчлөхөөс бусад тохиолдолд); мэдээллээ харилцан солилцож байх гэсэн Австралийн эхэн үеийн хакеруудын алтан дүрмийг хүндэлдэггүй хүмүүс картинг руу хошуурсан билээ. Эхэн үеийн Австралийн хакеруудын хувьд хэн нэгний систем рүү зочлоно гэдэг бол үндэсний паркт аялж байгаатай адилхан байлаа. Ямар байдалтай байсан тэр хэвээр нь үлдээ.

Сөрөг нөлөө хакерын хүрээний дээд хэсэгт хүрэх үед зарим нэг хог шаар картингийн

бүлгийн дээр хөвж эхлэв. 1986 оноос хойш Мелбурнийн захын хорооллын хакеруудын хүрээнд эргэлдэх болсон Blue Thunder-т олон хакерууд үнэлгээ өгсөн байдаг. (Blue Thunder – хөх аянга гэсэн утгатай.) Blue Blunder гэж түүнийг дуудах ахмад хакерууд мань эрийг маш их доог тохуу болгоно. (Blue Blunder-хөх алдаа гэсэн утгатай. Ёжлох маягаар үгийг өөрчилсөн-орч) Бүжгийн танхимд сүр жавхлантайгаар орж ирэнгүүтээ толгойгоороо шал мөргөсөн гэж түүнийг доогтойгоор шоолно. Тэрээр Мелбурнийн хакер хүрээний тэргүүн хатагтайтай өрсөлдөх сонголтыг хийсэн аж.

Real Article нь компьютерийн хакеруудын дунд онцгой байр эзэлнэ. (Real Article-жинхэнэ нийтлэл гэсэн утгатай үг-орч) Тэрээр Мелбурнийн хакеруудын дундах цорын ганц эмэгтэй байж магадгүй. Real Article бусдын компьютерийг хакердах үйлдэл хийдэггүй боловч тэр тухай маш өргөн мэдлэгтэй байв. Тэрээр PI-ийн идэвхтэн хакерууд байнга зочилдог The Real Connection (жинхэнэ холболт гэсэн утгатай) нэртэй BBS-ыг ажиллуулна. Найз хөвгүүн хайх сонирхолгүй тэр эмэгтэй нас ахисан нэгэн. Гэрлэж, хүүхэдтэй болсон Real Article хакерын хүрээнд нэр хүндтэй байлаа. Н.А.С.К-ийн гишүүд түүнийг өөрсдийн клубын хүндэт гишүүн болгосон нь хакеруудын дунд ямар байр суурь эзэлдгийг шууд харуулах биз. Магадгүй тэр эмэгтэй олны хүртээл болсон board-ыг ажиллуулдаг байсан учраас энэ хүндэтгэлийг авсан байх. Тухайн үед ихэнх хакерууд залуу хүмүүсийн асуудалтай хүмүүс байсантай ч холбоотой байж магадгүй. Нас ахимаг, ухаалаг Real Article тэдгээр залуусын асуудлыг анхааралтай сонсохоо мэддэг байжээ. Хакердах ажиллагаа хийдэггүй тэр хүүхэн үе тэнгийхэндээ нууцаа дэлгээд байдаггүй эрчүүдийн бүрхэг занг зөөллөж чаддаг байжээ. Тэрээр өсөн дэвшиж байгаа хакерын хүрээнийхэнд ээжийн адил үүрэг гүйцэтгэх болов. Гэхдээ тэр хатагтай хүүхдүүдийн асуудалд өвдөг сөхрөх эцэг, эхчүүдийн сэтгэлгээний зөрчлөөс зайлсхийж чадахуйц сэргэлэн бөгөөд залуухан байлаа.

1986 оны эхээр Blue Thunder ба Real Article хоёр BBS дээр хамтарч ажиллаж байв. Дээд сургуулийн оюутан Blue Thunder board ажиллуулах хүсэлтэй байсан учраас Real Article системийг хамтран ажиллуулахыг түүнд зөвшөөрчээ. Түншлэл дажгүй эхлэв. Blue Thunder дээд сургуульд бичсэн эссе-ний алдааг хянуулахаар түүнд авчирч өгнө. Гэтэл тун удалгүй түншлэлд сэв сууж эхэллээ. Бусад хакеруудаас мэдээлэл цуглуулж аваад дараа нь тэр хүнийг хаях зорилгоор BBS-г ажиллуулж байгаа Blue Thunder-ийн хандлагад Real Article дургүйцжээ. Хакерууд BBS дээр log on хийгээд үнэтэй мэдээллээ хадгалсны дараа тэр мэдээллийг хулгайлж аваад дараа нь тэднийг өөрийн экакаунтанд нэвтэрч чадахгүй болгон цоожилох стратегийг Blue Thunder ашиглаж байв. Тэднийг цоожилсноор Blue Thunder хакерын бүх чадвар зүтгэл шингэсэн мэдээллийг хулгайлж, тэрхүү хакерын нууцыг өөрийн болгон авах зорилготой ажээ. Real Article үүнийг ёс суртахуунгүй үйлдэл гэж үзсэн учраас өөрийнхөө BBS-ээс Blue Thunder-ийг гаргав.

Уг явдлаас хойш нэг их удалгүй үүрийн дөрвөн цагт Real Article-ийн утасны хонх дуугардаг боллоо. Үнэхээр уйгагүй утасны дуудлага үргэлжилсээр. Үүрийн дөрвөн цагт, шөнө бүр утас дуугарна. Шугамын нөгөө үзүүрт байгаа дуу хоолойг компьютерээр хийсэн байлаа. Үүний дараа Commodore ASCII принтерээр хэвлэсэн автомат бууны зургийг түүний шуудангийн хайрцаг руу илгээнэ. Шуудан дотор “Хэрэв та хүүхдүүдээ амьд үлдээхийг хүсэж байвал, гэрээс нь гарга” гэсэн заналхийлсэн мессэжийг хавсаргасан байлаа.

Дараа нь тэдний гэрийн цонхоор тоосго нисэж ирээд телевизор дээр буув. Real Article-ийг өглөө босоход телефон утасны шугам тасарсан байлаа. Гудамжны эсрэг талд байрлах Telecom-ийн зангилааг хэн нэгэн этгээд нээж, нэг метр орчим кабелийг тасалжээ. Үүний улмаас гудамжны бүх телефон утасны шугамууд ажиллахгүй болсон байна.

Хонзогносон хүүгийн өшөөрхөл гэхэд арай дэндсэн үйлдэл байсан учраас Real Article Telecom-ийн Хамгаалалтын Албанд мэдэгджээ. Тэд үүрээр хийсэн утасны дуудлагыг мөрдөхын тулд эмэгтэйн утасны шугам дээр ирсэн сүүлийн хэдэн дуудлагыг тодруулах ажилдаа орлоо. Эмэгтэй Blue Thunder-ийг сэжиглэж байсан авч хангалттай нотолгоо хэрэгтэй байв. Эцэстээ нэг юм утас дуугарахаа болив. Real Article өөрийнхөө сэжиглэлийг хакеруудын ертөнцийн бусад хүмүүст тараажээ. Хэсэг хугацаанд Blue Chunder гэж дуудагдах болсон Blue Thunder-ийн нэр хүнд навс уналаа. (chunder-бөөлжис, гулгидас гэсэн утгатай-орч)

BBS-ийн хэрэглэгч болон журмын нөхдийн итгэлийг алдсан Blue Thunder түнэр харанхуйд нуугдсан мэт болжээ. Тэрээр язгууртан хакеруудын өлмийг үнсэж үлдсэннасаа өнгөрөөхөөс өөр аргагүй болсон билээ. Гэтэл картингийн арга мэндэлж, түүнд таатай боломж олгосноор Blue Thunder картингтай хувь заяагаа холбожээ. Гэвч түүний сонгосон хувь тавилан шулуун замаар үргэлжлээгүй юм.

Тэрээр хийсэн нүглийнхээ горийг амсах хувьтай гэж бусад хакерууд үзэх болсон нь түүний сулхан ёс суртахуун болон онгиороо зантай нь холбоотой байв. “Тэр баригдана гэсэн санааг баяртай хүлээж авах шиг санагдсан. Тэр маш олон кредит картны дугаарыг хулгайлсан гэж хүмүүст ярихаас гадна ашиг орлого олох үүднээс систем дээр байгаа эккаунтуудын мэдээллийг худалдсан” гэж нэгэн чадварлаг хакер ярьсан юм. Түүнчлэн цагдаагийн залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс рүү цэцгийн баглаа санаатайгаар илгээж, хулгайлагдсан кредит картны дугаарыг ашиглан төлбөрийг нь хийж байв.

1988 оны 8-р сарын 31-нд Blue Thunder 22 удаагийн гэмт үйлдэлдээ Мелбурнийн шүүхээс ял авсан байна. Түүний ихэнх ялыг хүчингүйд тооцож, ижил үйлдлийг нэг хэрэгт багтаажээ. Түүнд залилан, хулгайлах гэмт хэргийг оролцуулаад таван гэмт хэрэгт ял тулгасан юм. Real Article шүүх танхимын хойно суугаад бүх зүйлийг харж байв. Тэр үдийн хоолны цагаар Real Article дээр ирээд өмгөөлөх гэрч болохыг хүссэн гэж эмэгтэй хэлсэн учраас шүүгч түүнд ямар ял оноох вэ гэдгээс Blue Thunder-ийг айж байлаа. Эмэгтэй түүний нүд рүү эгцлэн хараад: “Та үүнийг хүсэхгүй байсан нь дээр юм биш үү” гэж хэлсэн гэдэг. Түүнд 200 цагийн албадан хөдөлмөр хийлгэх ял оноож, 706 долларын торгууль төлүүлжээ.

Блуе Тандерын явсан замаар хакеруудын хүрээний зарим хэсэг замнах болсонд Крейг Боуен дургүйцэж байв. Түүний үзэж байгаагаар Чандер ба Троцкий нар эв эрүүл модонд ургасан хорхойтой алим бөгөөд хакерууд мэдээлэл худалдах чиглэлд орж байгаа дохиог бусад хүмүүст өгсөн ажээ. Мэдээж энэ бол хийхийг хориглосон агуу муу үйлдэл. Энэ бол муу ул мөртэй, ёс суртахуунгүй үйлдэл. Бусад хүмүүст шинийг нээгчид бус гэмт хэрэгтнүүдийн вант улс мэт харагдах болно. Австралийн компьютерийн далд ертөнцийнхөн гэм буруугүйд тооцох зарим үнэт зүйлээ алдаж эхэллээ.

Энэ бүх зүйл тохиолдож байх хооронд Мелбурнийн хакеруудын дунд нэгэн шинэ тоглогч орж ирэв. Түүнийг нэрийг Стюарт Гилл гэнэ. Тэр Hackwatch гэдэг компаниас иржээ.

Боуен Кевин Фицжеральдаар дамжуулан Стюарттай танилцав. Кевин Фицжеральд бол хожмоо Австралийн Компьютерийн Зүй бус хэрэглээг Судлах Товчоо болж хөгжсөн Чисхолмын нэрэмжит Технологийн хүрээлэнгийн Компьютерийн Зүй бус хэрэглээг Судлах Товчоог үүсгэн байгуулагч бөгөөд нэр хүндтэй хакер судлаач хүн байв. Фицжеральдийн яриаг иш татсан сонингийн нийтлэлийг Крейг уншаад хакер-баригч нэрээр нууц ертөнцийн дунд алдаршсан хүн рүү утасдахаар шийдэв. Яагаад болохгүй гэж? Хакердахын эсрэг Холбооны хууль Австралид байхгүй учраас Боуен сэтгэл нэг их зовнисонгүй. Хажуугаар нь тэр өөрийнхөө дайсантай уулзахыг хүсчээ. Австралийн хакеруудаас өөр хэн нэгэн хүн үүнийг хийж байсангүй. Тэр Фицжеральдтай шууд тулж уулзан, хакеруудын юуны хойноос явдаг болохыг мэдрүүлж рекорд тогтоохыг хүсэв. Тэд тогтмол утсаар ярилцах болов.

Түүнээс хойш Фицжеральдтай хамтран ажиллаж байсан Стюарт Гиллтэй Боуен танилцлаа. Тун удалгүй Гилл РI дээр зочлох болжээ. Хэсэг хугацааны дараа Моунт Мартад авга эгч, ахтайгаа хамт амьдрах Гиллийн гэрт Боуен зочлов. Стюарт өөрийнхөө гэрт олон төрлийн компьютерийн төхөөрөмж байрлуулж, гаражаар дүүрэн судалгааны цаастай хайрцаг овоолсон байлаа.

“Аан сайн байна уу? Паул” гэж Гиллийн авга ах нь хэлэв. Хөгшин эр хөлөө зөөж ядан холдоход, Гилл Боуенийг өөртөө татан: “Санаа зовоод хэрэггүй ээ. Хөгшин Эрик түүнийг дайнд алдсан юм. Өнөөдөр тэр намайг Паул гэж бодлоо. Маргааш хэн нэгэн өөр хүнтэй андуурна” гэж хэлэв.

Боуен ойлгосноо илэрхийлж толгой дохино.

Стюарт Гиллийн тухай олон хачирхалтай зүйл байх агаад бүгдэд нь ямар нэгэн тайлбар хэрэгтэй санагдана. Одоогоор асуултанд бүрэн хариулах эрт байлаа.

Тэрээр гуч гарч яваа гэхэд Крейг Боуеныг бодвол илүү буурьтай, нас ахимаг харагдана. Гилл хэзээ ч нар харж байгаагүй юм шиг маш цонхигор царайтай байв.

Гилл өөрийн амьдралыг Боуенд дэлгэрэнгүй танилцуулжээ. Тэрээр зөвхөн Hawkwatch-ийг ажиллуулаад зогсохгүй тагнуулын ажилд холбоотой гэдгээ залуу хакерт ярив. Австралийн Холбооны цагдаагийн газар, Гэмт хэрэгтэй тэмцэх Үндэсний байгууллага, Эрүүгийн тагнуулын товчооны Викториа дахь салбар, Австралийн Аюулгүй байдлын тагнуулын байгууллага зэрэгт Гилл холбоотой аж. Тэр Боуенд зарим нэг компьютерийн нууц файлууд, бичиг баримтуудыг үзүүлэхийн өмнө бусдад задлахгүй байх баталгаа болгож, бэлэн бланк дээр гарын үсэг зуруулсан байна.

Боуен түүнийг биширчээ. Тэр яагаад ийм болж болохгүй гэж? Гиллийн нууц ертөнц бүхэлдээ адал явдлаар дүүрэн мэт санагдана. Хакердах ажлаас хол давсан өргөн цар хүрээтэй байв. Тэр нэг л онцгой, санагдах нь өөртөө татах арга байсан ч байж болно.

1988 оны Зул сарын баяраар тэд Викториа мужийн Сейл хот руу хамт аялжээ. Түүний хойноос муу хүмүүс ирэх учраас хэд хоног хотоос гарах хэрэгтэй болоод байна гэж Гилл Боуенд хэлэв. Тэр жолоодож чадахгүй учраас Крейгээс тусламж гуйсан аж. Мэдээж тэр татгалзахгүй. Тэд хямдхан мотелийн өрөөнд хамт орж, Гилл төлбөрийг нь хийв. Зул сарын

баяр ойртож байсан учраас Стюарт Крейгт хоёр бэлэг авчирсан гэж хэлжээ. Крейг эхний бэлгийг онгойлгоход Жон Траволтагийн бялдаржуулах урлагийн ном байв. Харин хоёр дахь бэлгийг нээж үзээд Крейг нилээд гайхжээ. Хоёр дахь хайрцагт эмэгтэй хүний дотуур хувцас байв. Тухайн үед Крейг найз охингүй байсан, магадгүй Стюарт түүнд нэг дотуур өмд авахад туслаж байгаа юм шиг санагдаж байлаа.

Хэсэг хугацаанд түдгэлзсэнээ Крейг : “аан... баярлалаа” гэв.

“Чамд таалагдсанд баяртай байна. Өмсөөд үз л дээ” гэж Стюарт хэллээ.

“Өмсөх өө?” одоо Крейг улам ихээр цочирдов.

“Тиймээ, таарч байгаа эсэхийг хармаар байна. Тэгээд л болно”

“Өө тийм үү” гэх Крейг тээнэгэлзээд, бүдүүлэг зан гаргахыг хүссэнгүй. Энэ маш сонин хүсэлт байлаа. Түүнд урд өмнө эмэгтэй хүний дотуур өмд өмсөх шаардлага гарч байсангүй. Хэн нэг нь чамд хувцас өгвөл таарч байгааг нь үзэх гэж өмсөнө...

Крейг хурдхан өмсөж үзэв.

“Таарч байх шиг байна” гэж Стюарт хэлээд гэнэт эргэн харав.

Крейг бага зэрэг тайвширч, өөрийн хувцсыг өмслөө.

Тэр шөнө Крейг нууцлаг шинэ найзынхаа тухай бодолд дарагдан хэвтэв. Стюарт бага зэрэг гажууд мэт санагдах бөгөөд эмэгтэй хүн сонирхдог юм шиг байдаг. Крейгийг ийм маягаар сонирхоно гэж байхгүй дээ хэмээн Крейг бодож байв. Сонины эмэгтэй сурвалжлагчтай маш ойр дотно гэж Стюарт бардам ярьсан төдийгүй видео киноны дэлгүүрт нэг охинтой уулздаг гэж ярьдаг.

Стюартын хачин зан аашны талаар Крейг их юм бодохгүй байхыг Крейг хичээж байв. Тэгээд ч залуу өөрийн найзын этгээд аашийг уучлахыг хүснэ. Удалгүй СтюартPI-д хязгааргүй нэвтрэх эрхийг өгөхийг Крейгээс гуйв.

Түүний санаа Крейгийг маш тавгүй байдалд оруулаа. Гэвч тэр хэт шургуу зүтгэж байв. Викториа мужийн хамгийн чухал хакерын board руу нэвтрэхгүйгээр тэр тагнуулын чухал ажлаа хэрхэн үргэлжлүүлэх вэ?

Крейг Воуен шиг гэм буруугүй царайлсан хакеруудын хойноос Стюарт Гилл яваагүй юм. Үнэндээ хакер бүрийг цагдаа нар шалгах үед тэр Боуеныг хамгаалах болно. Картчингууд болон залилан мэхлэгчдийг л Стюарт хүсэж байлаа. Харин Крейг тийм хүмүүсийг хамгаалахыг хүсээгүй, тийм биш гэж үү?

Тэр Иван Троцкийтэй найз нөхөд бололцсон хэвээр байсан тул картчингуудын араас явж байгаа Стюартыг гайхсаар байлаа. Мэдээж түүний тагнуулын ажлаас шалтгаалан тайлбарлаж болохгүй нууц байсанд эргэлзээ алга.

Крейг зөвшөөрчээ.

Хэрэв Крейг ирээдүйн хэдэн жилийг урьдчилан харж чаддаг бол, хэрэв тэр цагдаагийн мөрдөн байцаалт, Омбудсманы хэрэг, сонин хэвлэл дээр гарсан нийтлэл, шүүх ажиллагааны талаар олж мэдсэн бол яг тэр мөчид хамгаас хайрт PI ба Zen-ийг үүрд хаах шийдвэр гаргах байсан бизээ.

Гуравдугаар бүлэг

Америк Холбоо

“Танай улсад учрах бэрхшээлийг АНУ-ын хүчнүүд зөвшөөрчихсөн байгаа”... Midnight Oil-ийн “АНУ-ын хүчнүүд” дууны шүлгээс

Форс нууцтай байдаг. Пармастер ч үүнийг хүсэж байв.

Ихэнх хакеруудын адил зүгээр л нууц байлгахыг Пармастер хүсээгүй юм. Түүнд нууц шаардлагатай байлаа. Тодорхой нэгэн мэдээллийг олж авахын тулд юуг ч хийхээс буцахгүй болсон жинхэнэ хакеруудтай тэр адилхан байв. Тэр улайрчээ.

Мэдээж Пармастер чухал мэдээллийг олж авахыг ихэд хүснэ. Форс, Пармастер хоёр ханаж цадахгүй гэдгээ мэдэж байв. Жинхэнэ хакерууд энд тэндхийн үлдэгдэл, сэгээр хооллоод байдаггүй юм. Тэнд ямар нэгэн нууц гарц байгааг мэдэнгүүтээ тодорхой системийн мэдээллийг олж авахын тулд уйгагүй тэмүүлдэг. Пармастер яг тийм байдалд орсон байв. Юу хүссэнээ олж автал Форсыг зогсоо зайгүй мөрдөнө.

Компьютерийн хакерын хоёр аваргын хооронд 1988 оны эхний хагаст болсон ярилцлагын үед энэ асуудал гэнэт эхэлсэн юм. Мелбурн дэхь BBS-ын Realm хэлэлцүүлгийн хэсгийг ажиллуулдаг, алдартай Австралийн хакер Форс Партай чатлаж суув. Пар бол Герман дахь X.25 сүлжээний Америк мастер байлаа. Тэр хоёр Германд биечлэн уулзаж байгаагүй юм. Харин Алтос тэнд байв.

Гамбургт байх Алтос Компьютерийн Систем өөрийн компьютерүүдийн нэг дээр Алтос Чат нэртэй сайтыг ажиллуулдаг байв. X.25 дата холбооны сүлжээн дээр дэлхийн хаанаас ч дуудлага хийж болох агаад тус компаний компьютер таныг холбогдоход туслана. Компьютерын гар дээр хэдэн богинохон цохилт хийж, нэгэнтээ холбогдсоны дараа Германы компьютер таныг бодит цагт бүртгэж, онлайн дээр байгаа хэнтэй ч ярих боломжтой session хийнэ. Компаний бусад компьютерийн систем өдөр тутмын хүнд ажилтай зууралдаж байх хооронд компьютерийн энэ хэсэг онлайн дээр бодит цаг хугацаанд чатлах боломжийг олгоно. Үнэгүй шүү дээ. Энэ бол Интернет релей чатны эртний хэлбэртэй адилхан байв. Мэдээж тус компани дэлхийн хамгийн алдартай хакерын цаг нөхцөөх газар болохыг хүсэхгүй биз. Тэгээд ч энэ байдал удаан үргэлжлээгүй юм.

Алтос бодит цаг хугацаанд чатлах олон улсын анхны суваг байсан бөгөөд ихэнх хакерууд үүнийг гайхамшигтай зүйлд тооцож байв. Сайн хакерууд дэлхийн эргэн тойрны маш олон компьютерийн сүлжээгээр аялсан байж таарна. Заримдаа тэд онлайн дээр хэн нэгэнтэйгээ тааралдаад сүүлийн үеийн хов жив солилцоно. Хааяа нэг хилийн чанад дахь BBS рүү log хийж, мессэж бичиж үлдээнэ. Харин Алтос огт өөр байв. Нууц ертөнцийн BBS-үүд нэг өдөр л үгүй болох хувь тавилантай байтал Алтос байнга орших заяатай байжээ. Энэ бол жинхэнэ амьд байлаа. Итали, Канад, Франц, Англи, Израиль, АНУ зэрэг орнуудын олон арван хакеруудтай нэгэн зэрэг холбоо барина. Тэдгээр хүмүүс компьютер сүлжээний сонирхлоо хуваалцахын сацуу дургүйцлийг нь төрүүлсэн хэн нэгний эсрэг зэвүүцлээ илэрхийлж байв. Эгшин зуурын, бодит цаг хугацаанд санал бодлоо солилцох үзэг нэгтнүүд.

Гэсэн хэдий ч дундаж хакеруудын BBS-ийн хажууд Алтос илүү онцгой байв. X.25 сүлжээнүүдийг хэрэглэвэл төлбөр төлдөг учраас хүссэн хакер болгон ороод байх боломжгүй ажээ. Сүлжээн дэх зарим системүүд 1-800 дугаартай адилхан эсрэг төлбөрийн холболтууд хийдэг. Харин Алтосыг оролцуулаад бусад системүүд тийм холболт хийдэггүй байв. Алтос руу ороход танд компаний Network User Identifier буюу NUI хэрэгтэй. (Network User Identifier-Сүлжээний хэрэглэгчийг тодорхойлогч, танигч-орч) Энэ нь онлайн дээр өнгөрөөсөн таны хугацааг билл болгоход хэрэглэдэг X.25-д сүлжээнд зориулсан дуудлага хийх картын дугаар гэсэн үг. Эсвэл хийсэн бүх холболтуудад автоматаар төлбөр тооцох Минерва шиг системд та нэвтрэх эрхтэй байх ёстой.

Хожим хөгжсөн интернетээс X.25 сүлжээнүүд олон зүйлээр ялгаатай. X.25 сүлжээнүүд мэдээлэл холбооны өөр өөр протоколуудыг хэрэглэх ба хэрэглэгчийн түвшинд интернеттэй адилгүй үсэгнүүд бус тоо агуулсан хаягнуудыг хэрэглэдэг юм. Дата сүлжээгээр дамжуулж байгаа мэдээллийн багц бүрийг тодорхой төрлийн дугтуйнд хавсаргах шаардлагатай. Товчоор тайлбарлавал X.25-аар сүлжээгээр илгээгдсэн “үсэг”-т X.25-аар “тамгалагдсан” дугтуй хэрэгтэй болохоос Интернетээр “тамгалагдсан” дугтуй хэрэггүй гэсэн үг.

Telenet ба Tymnet мэтийн харьцангуй томоохон тоглогчийн хяналтанд X.25 сүлжээнүүд байдаг. Харин орчин үеийн Интернет нь үүний эсрэг буюу олон жижиг ба дунд хэмжээний сайтуудын цуглуулга юм.

Олон улсын хакеруудын ертөнцийг Алтос урд байгаагүйгээр нэгтгэжээ. Өөрийн улс орнуудын компьютер ба сүлжээний тухай мэдээллийг солилцсон хакерууд бие биедээ цааш аялах хүчийг өгсөөр байлаа. Алтос Австраличуудын хүндэтгэлийг нилээд хүлээж эхлэв. Тэд өөрсдийн бүтээлийг сайн мэдэж байлаа. Хамгийн чухал нь тэд DEFCON нэртэй програмыг эзэмшдэг. Энэ програм нь систем дээр холбоотой байгаа компьютерүүдийн эккаунтыг шүүн скан хийж, бүртгэгдээгүй сүлжээнүүдийн бүдүүвчийг гаргадаг юм. Форс өөрийн найз бөгөөд дотны зөвлөх Крейг Боуены (Thunderbird) өгсөн жирийн автомат скан хийдэг програм дээр үндэслэн DEFCON програмыг бичжээ. X.25 сүлжээнүүд нь телефон утасны системтэй адилхан сүлжээ хэрэглэгчийн хаяг буюу network user addresses (NUA) хэмээн нэрлэгдэх олон тооны “утасны дугаарууд”-тай. Тэдний ихэнх нь хүчинтэй бус юм. Тэднийг зүгээр л хэн нэгэнд олгож амжаагүй гэж ойлгоход болно. Сүлжээнд байгаа компьютерүүд руу нууцаар нэвгэрч орохын өмнө та тэдгээр дугаарыг олох шаардлагатай. Мэдээллийг сонирхол нэгт хакеруудаас сонсох эсвэл скан хийх замаар олж авна. Байх боломжтой нэг хаягийг ээлж дараалан шивж скан хийх нь өвсөн бухал дотроос зүү хайхтай адил билээ. 02624-589004-0004. Дараа нь сүүлийн цифрийг нэг нэгээр ихэсгэх замаар хийнэ. 0005,0006,0007 гэх мэтээр нөгөө үзүүрт байгаа компьютерийг олж чадтал хийдэг.

1987 он болон 1988 оны эхээр Крейг Боуентай ярилцахын тулд Pacific Island руу Форс log хийв. Цаг шаардсан гар скан хийх аргыг Форс дуу алдан халаглана.

“Тэгэхлээр чи яагаад үүнийг гараар хийгээд байгаа юм бэ?” гэж Боуен хэлээд: “Чи миний програмыг хэрэглээд үз” гэв. Дараа нь Боуен жирийн автомат скан хийдэг програмын source кодыг, зааварчилгааны хамт Форсод өгөв.

Форс програмыг нарийвчлан судлаад, томоохон програмын суурь болгон хэрэглэхээр

шийджээ. Гэхдээ уг програмд томоохон хязгаарлалт байсаар байв. Энэ програм нэг удаад нэг холболт дээр ажиллах чадвартай байлаа. Өөрөөр хэлбэл нэг удаад сүлжээний нэг хэсгийг л скан хийх чадвартай гэсэн үг.

Гурван сараас бага хугацааны дараа Боуэны өгсөн програм дээр үндэслэн Австралийн хакеруудын нэр хүндийн титэм дээрх үнэт чулуун шигтгээ болсон хүчирхэг DEFCON програмыг Форс бичив. Хакерууд DEFCON-ийг ашиглан сүлжээний 15-20 сүлжээний хаягийг автоматаар, нэг зэрэг скан хийж чадах боллоо. Тэрээр Бельги, Англи, Грекийн X.25 холбооны сүлжээнүүдийн хэсгүүдийг зурагчлах командыг компьютерт өгч, модны мөчрийн үзүүрт ургах соёонууд шиг сүлжээнд холбогдсон компьютерүүдийг хайж байв.

Онолын хувьд тайлбарлавал-асах хугацаанд ганц програмыг унших чадвартай компьютерийг нэг дор олон програмуудыг ажиллуулж, олон цонхыг нээж чадах илүү боловсронгуй үйлдлийн системтэй компьютертэй харьцуулж байгаатай адил юм. Түүнчлэн та нэг цонхон дээр ажиллаж, захиа бичиж байгаа үед компьютер ард талд нь өөр програмаар тооцоолох үйлдэл хийж болно гэсэн үг. Түүнчлэн компьютерийн далд хэсэг буюу ар талд нь нэгэн зэрэг ажиллаж байгаа ялгаатай үйлдлүүдийн хооронд солих сонголт хийж болно.

DEFCON програм скан хийгээд завгүй байх хоорондуур Алтос дээр ярих зэрэг өөр бусад зүйлийг хийх боломжийг Форсод олгоно. Тэр DEFCON програмын дөрвөн өөр хувилбарыг бичиж, улам сайжруулсаар байлаа. Тун удалгүй DEFCON програм нэгэн зэрэг хорин өөр холболтуудыг скан хийгээд зогсохгүй тэдгээр холболтууд дээр олдсон компьютерүүд рүү нууцаар нэвтрэхийг оролдох үйлдлийг автоматаар хийх чадвартай болжээ. Уг програм зөвхөн үндсэн default пассвордыг олохыг хичээдэг боловч нэгэн зэрэг сүлжээний олон хаягнууд руу довтлох чадвартай болсныг нилээд амжилт олсонд тооцдог. Цаашлаад шинэ сайтууд ба мини сүлжээнүүдийг маш хурдан нэмж байсан учир аюулгүй байдлын асуудал хүндэрч байв. Хаягнуудыг олон нийтэд ил тавьдаггүй учраас бүрхэг далд байдал хангалттай хамгаалж чадна гэж компаниуд үзэж байлаа.

DEFCON програм довтолгоо хийж болох хэдэн мянгаад компьютер сайтуудын жагсаалтыг гаргаж байв. Форс хакердсан Prime компьютерийг скан хийхээр орхих агаад нэгээс хоёр өдрийн дараа ондоо сүлжээнүүд дээрх 6000 орчим хаягнуудыг файл болгон авна. Тэр жагсаалтыг анхааралтай уншиж байгаад сонирхол татсан сайтуудыг сонгодог. Хэрэв түүний програм маш сонирхолтой хаяг олвол компьютерийн тэр хаяг руу нууцаар нэвтрэхийг оролдож, X.25 сүлжээгээр аялдаг байна. Үүнээс гадна DEFCON програм нь default пассворд хэрэглэж байгаа ямар нэгэн компьютерт амжилттай нэвтэрч ороод Форсыг хүлээх хаяг, экаунт нэр, пассвордыг log файлд хийдэг. Өөрөөр хэлбэл Форс зүгээр л алхаж ороход бэлэн болсон байна гэсэн үг.

Алтосд ордог хүн бүр DEFCON програмыг хүсэж байсан ч Force програмыг хамаагүй тараахаас татгалзаж байв. Онгон гэж болох сүлжээнүүдийг бусад хакерууд эвдэж сүйтгэхийг тэр хүсээгүй юм. Америкийн хамгийн алдартай хакерын бүлэг Legion of Doom (LOD)-ын удирдагчдын нэг Эрик Блудакс хүртэл DEFCON-ыг авах хүсэлт тавиад амаа бузарлажээ. (Legion of Doom-Хувь заяаны легион гэсэн утгатай-орч)

Эрик Английн Ёорк мужийн газар нутгийг захирч байсан Viking king-ийн нэрийг өөрийн

сүлжээн дээрх нэр болгосон гэдэг. Хэдийгээр Эрик Австралийн хакеруудтай найрсаг харилцаатай байсан ч Форс түүнд нүүр өгөхгүй байв. Тэр өөрийн үнэт эрднээ алдахыг хүссэнгүй. Гэтэл 1988 оны гайтай тэр өдөр DEFCON програмыг Пар хүсээгүй байсан юм. Тэрээр саяхан нээсэн Форсын нууцыг олж авахыг хүсжээ. Австрали эр түүнд өгөхийг хүсээгүй байна.

Форс маш нямбай хакер байлаа. Хакерын өрөө гэхэд түүний унтлагын өрөө гайхамшигтай цэвэрхэн ажээ. Бүх юм гялалзах мэт санагдана. Унтлагын өрөөнд хар өнгөтэй нэг хүний метал ор, орчин үеийн дизайнтай хар өнгийн орны хажуугийн ширээ, шилэн раамтай аянганы зураг ханан дээр өлгөөстэй харагдана. Түүний өрөөнд байгаа хамгийн том тавилга бол хөх саарал өнгөтэй ажлын ширээ байв. Ширээн дээр түүний компьютер, принтер, эмх цэгцтэй хэвлэсэн цаас байлаа. Өрөөний бусад тавилгатай хослох номын өндөр тавиур дээр зөгнөлт номны цуглуулга байх агаад Девид Эддингсийн бичсэн бараг бүх номыг өржжээ. Номын тавиурын доод хэсэгт хими, програмчлалын номнууд байна. Dungeons ба Dragons хэвлэлийн газар хэвлэсэн номнуудыг агуулах тавиур дээр Химийн шагналууд бардам цухуйх ажээ.

Тэрээр пластик хавтаснуудад хакердах аргын тухай бичсэн тэмдэглэлийг эмх цэгцтэй хийж, номын тавиурын хамгийн доор нь тавьсан байв. Тэмдэглэл хийсэн дэвгэрбүрийн дээр нямбай хэвлэж, цэвэрхэн бичсэн хаяг нааж, засвар хийсэн харагдана.

DEFCON програмыг арван хүнд өгвөл нэг сүлжээг арван удаа дахин скан хийх явдал гарна гэж Форс бодож байв. Энэ нь цаг үрж, эх сурвалжийг баллана. Цаашлаад Минерва шиг Австралийн голлох X.25 сайтууд руу ороход хэцүү болно. Скан хийх үйл ажиллагаа бол системийн админы анхаарлыг татах үйлдэл бөгөөд үр дүнд нь эккаунтаа устгуулна. Олон хүн скан хийх тусам олон эккаунт устгагдана, тэгээд Австралийн хакерууд сүлжээнд орох боломж багасна. Тиймээс Форс DEFCON програмыг The Realm бүлгээс гадуур гаргахыг эсэргүүцсэн юм. Үүний хүчинд өөрийн бүлгийг хүчирхэг байлгаж чадсан ч байж болно.

DEFCON-оор скан хийнэ гэдэг нь Netlink програмыг хэрэглэнэ гэсэн үг билээ. Хууль ёсны хэрэглэгчид энэ програмыг байнга хэрэглээд байдаггүй. Админ хакеруудыг агнахын тулд Netlink програмыг хэрэглэж байгаа хүмүүсийг хайж болох юм. Эсвэл хэрэглэгч ямар системтэй холбогдсон байгааг шалгаж үзээд хакерыг илрүүлж болно. Жишээлбэл: Хэрэв хакер Минервагаас Алтос руу шууд холбогдсон бол Минервагийн админууд эккаунтыг устгана гэж тооцоолж болно.

DEFCON програм тухайн үедээ хувьсгал хийсэн бүтээл болсон юм. Түүнтэй адил програмыг ч бичихэд төвөгтэй. Тэгээд ч энэхүү програм Prime компьютерт зориулагдан бичигдсэн ба ихэнх хакерууд Prime програмыг хэрхэн бичих мэдлэг хомс байв. Үнэндээ худалдааны чиглэлээр хэрэглэдэг, том компьютерийн програмыг бичиж сурахад хүндрэлтэй байлаа. Системийн инженерчлэлийн гарын авлагыг олж авахад хэцүү бөгөөд томоохон компаниуд тэдгээр гарын авлагуудыг худалдааны нууц мэт хамгаалж байв. Хэрэв танай компани 100,000 долларын систем худалдаж авбал ажиллуулах багц гарын авлагыг өгнө. Тэдгээр гарын авлагыг өсвөр насны хакер олж авахад бэрхшээлтэй байдаг. Ерөнхийдөө компьютер үйлдвэрлэгч, системийг худалдан авсан томоохон компаниуд, системийн администраторууд, их сургуулиуд хүртэл мэдээллийг чадлан хамгаалдаг.

Онлайнаар сурах явдал удаан бөгөөд бараг боломжгүй. Ихэнх хакерууд 300 эсвэл 1200 баудын модем хэрэглэдэг. (baud-компьютерийн дата дамжуулах хэмжээ/bits/second/-орч) Тэдгээр том оврын, үнэтэй төхөөрөмж рүү нэвтрэх бүх access хууль бус байлаа. Онлайн дээр өнгөрөөж байгаа хором болгон эрсдэл дагуулж байв. Дээд сургуулиуд ийм төрлийн үнэтэй төхөөрөмжийг хэзээ ч хэрэглэж үзээгүй байлаа. Гэхдээ олон их сургуулиуд ийм системтэй, администраторууд нь оюутнуудыг хязгаарлагдмал цагаар онлайныг ашиглуулна. Ихэнх тохиолдолд компьютерийн шинжлэх ухааны сургалтанд хамрагдах хоёрдугаар курсээс эхлэн том төхөөрөмжинд нэвтрэх экаунтыг оюутнууд авдаг байлаа. Тэр үед их сургуулийн хуучин, болхи төхөөрөмж дээрх оюутнуудын экаунтууд олон янз байсан юм. Хэрэв чи компьютерийн шинжлэх ухааны ангийн оюутан биш бол мартсан нь дээр. VMS системийг сонирхох таны оюуны хүсэл тань мөрөөдөл болж үлдэнэ.

Гэвч та тэдгээр саад бартааг даван туулж, VMS системийн програмчлалын талаар ямар нэгэн туршлага хуримтлуулсан бол өгөгдсөн сүлжээн дээр багахан төхөөрөмж дээр л ажиллах боломж олдоно. X.25 сүлжээнүүд нь маш олон төрлийн үйлдлийн системтэй олон тооны төхөөрөмжүүд рүү холбогддог. Тэдгээр олон төхөөрөмжийн нэг нь Prime-ын компьютерүүд бөгөөд хэрэв та VMS-ийг мэддэг, Prime-ийг оролдож үзсэн бол том зүйлд тооцох учиртай.

Мэдээж хэрэг та The Realm шиг хакеруудын омогт харьяалагддаг бол BBS-д орж, мессэж тавих боломжтой болно. “Хөөе, би энэ хаяг дээр маш дажгүй Primos төхөөрөмжийг оллоо. Netlink командыг параметрийг олохыг хичээж байна. Хэн нэгэнд санаа байна уу?” гэж бичихэд л танай багийн хэн нэгэн гишүүн чамд туслахаар орж ирнэ.

The Realm дээр янз бүрийн туршлагатай, Австралийн хамгийн сайн хакеруудын бүлгийг цуглуулахыг Форс хичээж байв. Мөн тэрээр Prime компьютерүүдийн талаар туршлага ихээр хуримтлуулсан мэргэжилтан болсон байлаа.

The Realm-ийн гишүүн бус хэнд ч DEFCON програмыг өгөхгүй хэдий ч Форс зарим талаараа зөөлөн бодлого барьж байв. Хэрэв та системд нэвтрээгүй боловч сонирхол татсан сүлжээг олж, скан хийхийг хүсвэл Форс танд скан хийхэд туслана. Сүлжээний хэрэглэгчийн хаягнуудад скан хийхийг “NUA sprints” гэж Форс нэрлэдэг байв. (NUA sprints-NUA хурдан гүйлт гэсэн утгатай-орч) Тэр танд NUA sprints-ийг өгнө. Үүнийг хэрэглэж байхад тэрээр хуулбарыг The Realm-д зориулан хадгалдаг. Энэ бол үр нөлөөтэй арга байв.

Форсын төсөл The Realm-д зориулсан сүлжээ болон төхөөрөмжийн мэдээллийн санг үүсгэж, шинээр олсон мэдээллийг сандаа нэмсээр байлаа.

Шинэ сүлжээнүүдэд зурагчлал хийх явдал Форсын агуу хүсэл мөрөөдөл байв. Гэвч бүхий л цаг хугацааны туршид төв X.25 сүлжээнүүд дээр шинэ мини сүлжээнүүд нэмэгдсээр байлаа. ВНР мэтийн том корпорациуд Англи болон Баруун Австралийн Куинсланд, Викториад өөрийн албан байруудыг бага хэмжээний сүлжээгээр холбоно. Тэрхүү мини сүлжээ Austrac мэтийн тодорхой X.25 сүлжээтэй холбогдож болно. Ингээд Austrac сүлжээ рүү нэвтэрснээр тус компаний ямар ч сайт руу орж чадна.

Судлагдаагүй газар нутгийг нээх ажиллагаа Форсын ихэнх цагийг үрдэг байв. Шинэ сүлжээг олж нээх, өргөжиж байгаа сүлжээний онцлогийг болгоомжтойгоор судлах нь үнэхээр адал

явдалтай ажээ. Тэрээр сүлжээний шинэ хэсэг бусадтайгаа хэрхэн холбогдсоныг харуулсан нарийвчилсан зурагнууд, диаграмуудыг цуглуулна. Үүнийг ямар шалтгаанаар хийж байгаа нь тодорхой бус хэдий ч “The Realm”-ийн бүлэгт бас нэгэн үнэт өмчийг бий болгож байв.

Сүлжээнүүдийн зурагчлал хийж байхдаа Австралийн анхны хакерын сэтгүүл “Globetrotter”-ийг Форс хэвлүүлжээ. Олон улсын хакеруудын хүрээнд өргөнөөр унших болсон “Globetrotter” сэтгүүл нь олон улсын тавцанд Австралийн хакеруудын эзлэх байр суурийг харуулж байлаа.

Гэхдээ тэр нэгэн өдөр Пар түүнээс Globetrotter сэтгүүлийн дугаарыг авах эсвэл түүнд зориулан сүлжээнд скан хийхийг Форсоос хүсээгүй байв. Тэр нууцын тухай бодож байлаа. Форсын шинэ нууц. Тэр нууцыг Пармастер маш ихээр хүсэж байв.

Алтос дээр Партай чатлаж байхдаа Форс тав зургаан сүлжээнүүдийг DEFCON програмыг хэрэглэн скан хийж байлаа. Тэрээр маш сонирхолтой холболтыг сканаас олонгуугаа шалгахаар шийджээ. Үл мэдэх компьютерт түүнийг холбогдонгуут Форсын компьютерийн дэлгэцэн дээр олон эгнээ тоонууд урсаж гарав. Дэлгэцэн дээр урсах дүрсүүдийг Форс ажиглан сууна.

Маш сонин явдал боллоо. Тэр юу ч хийж чадалгүй сууна. Нууцлаг компьютер руу Форс ямар ч команд илгээсэнгүй. Тэр компьютер руу нэвтрэх өчүүхэн ч оролдлого хийлгүй харна. Дэлгэцэн дээр олон тоонууд урссаар... Ямар төрлийн компьютер ийм байдаг байна аа? Компьютерийг тогтоох боломжийг олгох зарим нэг header гарч ирэнгүүтээ маш хурдан алга болно. Форс үүнийг харж чадахгүй алдаж байлаа.

Алтос дээр Партай чат хийж байсан хэсэг рүү Форс оров. Нөхөрсөг Америк найз нь тогтворгүй байж магадгүй гэж боддог учраас тэрээр Парт бүрэн итгэдэггүй байлаа. Харин Пар Х.25 сүлжээнүүдийн мэргэжилтэн төдийгүй тэдгээр дугаарын тухай зарим зүйлийг мэдэх ажээ. Хэрэв тэдгээр тоонуудыг ямар нэгэн нууц гэж мэдсэн бол Форс тэднийг хаанаас олсон тухайгаа Парт хэлэхгүй байв.

“Би маш ер бусын хаяг оллоо. Энэ бол маш хачин компьютер. Түүн рүү холбогдонгуут л олон тоонуудыг над руу буудаад байна. Үүнийг үзээч” гэж бичив.

Тэдгээр тоонууд ямар учиртай байсныг Форс огт мэдэхгүй байлаа. Харин Пар мэднэ. “Кредит картны дугаарууд юм шиг байна” хэмээн Пар хариу бичлээ.

“Өө” гээд Форс хэсэг чимээгүй болов.

Австралийн хакер нилээд гайхсан байх гэж Пар боджээ. Хэсэг хугацаа өнгөрсний дараа сонирхолдоо хөтлөгдсөн Пар яриа өдөв. “Хэрэв тэр дугаарууд хүчинтэй картнууд бол надад шалгах арга байна. Жаахан хугацаа шаардагдах байх, гэхдээ хийх боломжтой, би эргээд холбогдоё” гэсэн саналыг тэр гаргалаа.

“Тэг. Ок”. Форс бага зэрэг тээнэгэлзсэн санагдаж байв.

Pacific дээр Парын нөгөө үзүүрт байгаа Форс гэнэтийн тохиолдлын талаар эргэцүүлнэ.

Хэрэв тэдгээр тоо нь хүчинтэй кредит карт байгаа бол сайхнаа. Мэдээж тэр Иван Троцкийтэй адилхан кредит картны залилан хийхгүй. Форс зөвхөн хилийн чанад руу холын дуудлага хийхийн тулд ашиглаж болох юм. Олон тооны картны дугаар байгаа нь гайхалтай. Мянга, мянгаар магадгүй 10,000 ширхэг байна. Чөтгөр гэж! Үлдсэн бүх насаа үнэгүй холболтон дунд өнгөрөөнө.

Картнуудыг хилийн чанад руу дуудлага хийхэд ашиглана гэдэг бол бага зэрэг ёс суртахуунгүй боловч хүлээж авж болохуйц үйлдэл гэж Форс үзжээ. Картны эзэмшигч биллийг хэзээ ч төлж дуусахгүй. Тэдний дургүй Telecom бүх зардлыг үүрэх байх гэж хакерууд төсөөлсөн учраас нэг их эмзэглэхээр үйлдэл биш санагдана. Хакердах ажилд картыг ашиглана гэдэг бол эд бараа захиалахтай адилгүй билээ. Тэр бол жинхэнэ картны залилан хийх гэмт хэрэг. Тэгээд ч Форс өөрийн гарыг ийм төрлийн үйлдлээр бохирдуулахыг хүсэхгүй.

Түүний компьютерт орсон тоонуудын бүртгэлийг Форс буцаан гаргаж үзэв. Нилээд анхааралтай үзсэний эцэст жагсаалтанд Headers үе үе гарч ирэхийг тэр ажиглажээ. Нэгэн headers нь “CitiSaudi” гэсэн байлаа.

Тэрээр нууцлаг компьютерийн сүлжээний хаягний эхний хэсгийг дахин шалгав. Эхний сканаас дэлхийн томоохон банкны нэг Citibank-ны сүлжээнд харьяалагддаг болохыг тэр мэджээ.

Дата буюу мэдээлийн санг дамжуулах процесс бараг гурван цаг үргэлжилэв. Үүний дараа Citibank-ны компьютер үхсэн мэт болжээ. Дэлгэцэн дээр юу ч гарахгүй байхыг харсан Форс холболтыг хэвээр үлдээлээ. Энэ холболт тасрахыг тэр хүсэхгүй байв. Citibank-ны сүлжээг DEFCON-оор скандах үед гарсан хаяг дээр байгаагүй учраас банкны компьютертэй тохиолдлоор холбогдсон, ховор тохиолдол гэж тэр үзжээ.

Өөр юу тохиолдож болох байв? Мэдээж Citibank хэн нэгэн этгээд “сайн уу?” гээд дуудлага хийх тоолонд кредит картны дугаарыг өмнөөс нь асгадаг компьютертэй баймааргүй юм. Ийм төхөөрөмжинд аюулгүй байдлын маш олон хамгаалалт байх учиртай. Тэр компьютерт пассворд хүртэл байхгүй байна шүү дээ. Нууц гар барилт гэдэгтэй адилхан тусгай команд хүртэл хэрэггүй гэж үү.

Х.25 сүлжээнүүд дээр гаж холболтууд тохиолддог. Телефон утасны холболттой адилхан гэж ойлгож болно. Та найзынхаа утас руу зөв дугаар хийж залгахад төв станц болон утасны зангилаанд төөрч өөр дугаар руу таны дуудлага очно гэсэн үг. Мэдээж үүнтэй адилхан тохиолдол Х.25-ын хакерт учирна. Юу тохиолдсоныг мэдэхийн тулд хакер системийн жинхэнэ хаягийг хайж, компьютерээсээ мэдээллийн хэрчим бүрийг шигшин үздэг. Энэ бол тохиолдлын чанартай учраас тэр компьютерийг дахин хэзээ ч олохгүй гэж хакер үздэг ажээ.

Иймээс тэр компьютерийн хаалгыг хэрхэн тогшоноо олж тогтоохын тулд Форс холболтыг хоёр өдрийн турш амьд байлгаж, сургуульдаа явалгүй гэртээ өнжив. Энэ хугацаанд Citibank-ны компьютер хэдэн удаа сэрж, илүү их мэдээллийг дамжуулаад унтах горимд орно. Холболтыг амьд байлгана гэдэг нь админд мэдэгдэхэрсдлийг дагуулах боловч олох ашиг тус нь учрах эрсдлээс хамаагүй их юм.

Хакердах ажлаа хийхийн тулд сургуулиа таслах нь Форсын хувьд нийтлэг үзэгдэл байв. “Чи үүнийгээ зогсоосон нь дээр дээ. Эсвэл чи үлдсэн насаа нүдний шилтэй найзалсаар өнгөрөөнө байх” гэж эцэг эх нь хэлдэг байлаа. Гэвч тэдний хүүхэд нэг их хүч гаргахгүйгээр сурлагын амжилт гаргадаг тул хичээлээ таслахыг эцэг эх нь юман чинээ тоохгүй байв. Дунд сургуульд байхдаа есдүгээр ангиа алгасах ёстой гэж багш нартаа итгүүлэхийг Форс оролдож байжээ. Зарим багш нар түүний саналыг эсэргүүцнэ. Гэхдээ тэрээр наймдугаар ангид байхдаа есдүгээр ангийн хичээлийг чимээгүйхэн үзэж дуусгасан гэдэг.

Форс Citi Saudi-ийн компьютерээс холболтоо салгасны дараа сайн унтаж аваад дахин холболт хийж болох эсэхийг шалгахаар шийджээ. Эхлээд ямар ч хариу өгөхгүй байснаа дахин нэг удаа оролдонгуут бүх зүйл хэвийн холбогдов. Энэ удаад өнөөх компьютер урдны адил чалчаа зангаа давгаж байлаа. Компьютер өдрийн тодорхой цагуудад ажиллаж байгаа мэт санагдавч Citibank-ны сүлжээний хаяг зөв байв. Тэр дахин тэдний сүлжээнд нэвтрэв.

Citibank-наас хакердаж олсон мэдээллийг Форс харж байхдаа сүүл хэсэгт дамжуулсан мэдээлэл эхнийхтэй адилхан кредит картны дугаар агуулаагүйг анзаарчээ. Мэдээллийн энэ хэсэгт хүмүүсийн нэр, Ойрхи Дорнодын хүний нэрс, мөнгө шилжүүлсэн жагсаалт байв. Ресторанд идсэн оройн хоол. Янхны газарт айлчилсан тухай. Бүх төрлийн л мөнгөн шилжүүлэг байв. Түүнчлэн кредитын хязгаар мэт харагдах тоо байна. Зарим тохиолдолд хүн бүрт маш их хэмжээний мөнгө байгаа нь харагдана. Шейх болон түүний эхнэр нэг сая долларын кредитын лимиттэй юм шиг харагдана. Бас нэгэн хүний нэр дээр таван сая долларын лимит байна.

Мэдээллийн санг үзвэл зарим нэг хачин зүйл байх шиг Форсод санагдав. Энэ мэдээллийн бүтцийг үзвэл Citibank-ны компьютерээс өөр компьютерт дамжуулдаг жирийн мэдээлэл биш бололтой. Энэ мэдээлэл нь компьютерээс шугамын принтерт дамжуулж байгаа текст файл шиг харагдана.

Форс сандлын түшлэгээ налан шинэ нээлтийнхээ тухай бодно. Тэр The Realm дээрх хамгийн ойрын найз нартайгаа сайхан мэдээгээ хуваалцахаар шийджээ. Форс өөр хэнд ч бус харин Phoenix-д л хэлнэ.

Мэдээллийн санг дахин харангуут бага зэрэг тавгүй мэдрэмж Форсод төрж эхлэв. Citibank бол үйлчлүүлэгдийн мэдээллийг дээд зэргээр нууцалдаг, санхүүгийн хүчирхэг институцийн нэг билээ. Хэрэв Форсын нээлт сонингуудад гарвал тус корпораци нэр нүүрээ алдана. Тэд түүний араас заавал ирэх болно. Дараа нь түүний өрөөний ханан дээр өлгөөтэй байгаа аянганы зураг оюун санааг нь эзэмдлээ.

Би галаар наадаж байна.

Алтос дээр Форсыг байхад “Чи тэдгээр дугаарыг хаанаас олвоо?” гэж Пар асуув. Форс хариулахаас зайлсхийхэд Пар асуултаар булсаар...

“Би тэдгээр дугаарыг чамд зориулж шалгасан юм. Тэд бол хүчинтэй картны дугаар” гэж тэр Форсод хэллээ. Тэр сүлжээний хаягийг авахыг хүснэ. Америк хакер шуналд авгжээ. Дараагийн зогсоол бол нууц компьютер гэж тэр бодно. “Тэгэхлээр хаягийг хэлэх үү?” ...

Энэ бол сонсохыг хүссэн асуулт биш байлаа. Пар тэр хоёр сайн хөршийн харилцаатай, мэдээллээ хааяа солилцдог. Гэхдээ тэр харилцаа хол явсангүй. Пар зөвхөн мэдээлэл хүсэхээс илүү зүйлийг бодож байгаа гэж Форс төсөөлнө. Парыг картинг хийдгийг Форс мэдэхгүй боловч тиймэрхүү муу үйл ажиллагаа явуулдаг найз нөхөдтэй гэж сэжиглэж байжээ. Тиймээс нууц компьютерийг олоход Парт туслаагүй аж.

Пар тийм ч амархан бууж өгсөнгүй. Картны тоог бэлэн мөнгө болгохоос буцахгүй Пар нууц компьютерийг шалгаж үзэхийн хойноос юугаа ч өгөхөөс буцахгүй болжээ. Пар хүссэнээ автал Форсыг тайван байлгахгүй. Австралийн хакерыг зөөлөртөл нь Пар зууралдав. Ингээд эцэст нь DEFCON-оор скан хийж, CitiSaudi-ийн компьютер дээр бүдэрснээ Форс Пард хэллээ. Форс гудамжны хаягийг өгсөнгүй, зөвхөн хотын захад байрлах газрын нэрийг хэлсэн гэхэд болно. DEFCON програм нь X.25 холбоо харилцааны протоколыг хэрэглэж байгаа Америкийн дата сүлжээний томоохон компани болох Telenet-ээр дамжин Citibank-ны сүлжээнд нэвгэрчээ. Сүлжээний Citibank-д зориулсан хэсгийн хаяг нь 223 ба 224 байлаа.

Хаягны үлдсэн хэдэн тоог шалгаан хоргоосон боловч Форс бууж өгөлгүй гүрийсээр байв. Форс маш хашир, болгоомжтой хакер байсан төдийгүй Парын гэтэж буй ажиллагаанд хутгалдахыг огт зөвшөөрөхгүй ажээ.

За за, үүнийг би чамгүйгээр хийчихэж дөнгөнө гэж арван долоон настай Пар өөртөө хэлэв. Тэр сүлжээн дээр 20,000 боломжит хаяг байгаа, тэдний аль нь ч нууцлаг компьютерын өлгий нутаг байж болно хэмээн тооцоолжээ. Бага тоо байнга эхэнд хэрэглэгддэг, дээгүүр тоог ихэвчлэн сүлжээний тусгай үйл ажиллагаанд зориулан хадгалдаг учир сүлжээний бага тоогоор эхэлсэн төгсгөлд нөгөө компьютер байж болохыг тэр төсөөлөв. Түүний төсөөллийн үр дүнд хайх хүрээг 2000 боломжит хаяг болгон багасгажээ.

Ингээд Пар Citibank Global Telecommunications Network (GTN) дээр өнөөх нууцлаг компьютерийг хайж гар скан хийж эхлэв. X.25 сүлжээний мэдлэгээ ашиглан эхлэх дугаараа тэр сонголоо. Тэрээр 22301, 22302, 22303 гэж шивжээ. Нэг нэгээр нэмсээр 22310 руу дөхөж ирэв. Цаг аажмаар өнгөрч, бүх сонголтыг цуцалтгүй шалгасаар сүлжээг скандав. 223-аар эхэлсэн хаягийг шалгаж дуусаад 224 рүү орлоо.

Компьютерийн ард урт шөнийг өнгөрөөж, нүд нь чилсэн Пар оролдлогоо зогсоохыг хүснэ. Калифорнийн Салинас дахь орон сууцны цонхоор нарны туяа тусаад хэдэн цаг өнгөрчээ. Түүний зочны өрөө замбараагүй, хоосолсон шар айрагны лааз Apple Пе-г тойрон хөглөрнө. Пар хэсэг зуур завсарлаж, нүдээ анилаа. Боломжит хаягуудаар бүхэл шөнийн турш орж, олон хаалгыг тогшсон ч үр дүн байдаггүй. Тэр сүлжээг скандах ажиллагааг дараагийн хэдэн өдөр тасралтгүй үргэлжлүүлэв. Энэ удаад тэрээр нилээд аргачилсан байдлаар, бүгдийг эхнээс нь хийхээр зориг шулууджээ.

Хоёрдахь сканаа хийж байхад Парын компьютер ямар нэгэн төхөөрөмжтэй холбогдов. Тэр өндийн суугаад дэлгэцийг ширтэнэ. Юу болоод байна аа? Тэр хаягийг дахин шалгав. Урьд нь энэ хаягийг оролдож үзэхэд ямар нэгэн хариулт ирж байгаагүй гэдэгт тэр итгэлтэй байлаа. Бүх зүйл маш хачин санагдав. Тэр өөрийхөө компьютер руу гөлрөнө.

Дэлгэц хоосон, дээд хэсэгт нь курсор анивчина. Одоо яах бол? Форс ийм зүйлтэй учирсан

болов уу?

Пар удирдлагын товчлуур дээр, мөн өөр хэдэн үсэг дээр дарж үзэв. Юу ч байдаггүй. Магадгүй энэ зөв хаяг биш байх. Өнөөх компьютерээс холболтоо салгаж, хаягийг цаасан дээр тэмдэглэж аваад дахин нэг оролдохоор шийдэв.

Гуравдахь удаагийн оролдлогоор дахин холбогдоход уур хүргэм өнөөх хоосон дэлгэц ахиад л гарч ирэв. Энэ удаад компьютерын гарны удирдлагын товчлуурын үсэг бүрийг нэг нэгээр нь дарлаа.

Control L.

Энэ бол шидэт товчлуур байлаа. CitiSaudi нууц агуулахаа энэ товчлуурт нээж өгчээ. Мянга мянган картны үнэр авсан Парын цусанд адреналин хүчтэй шахагдаж байв. Агшин зуурын бэлэн мөнгө түүний дэлгэцээр дүүрнэ. Урсан өнгөрч байгаа мэдээллийг цуглуулахын тулд screen capture-г асааж, дараа нь анализ хийхэд ашиглах юм. Түүний 1200 баудын модемоор урсан орж ирэх мэдээллийн санг хадгалахад олон диск шаардлагатай болж байв.

Гайхамшигтай цаг мөч ирлээ. Форсод болсон явдлыг ярихдаа таашаал хэрхэн авахаа Пар бодно. Хөөе Австралийн хакераа чи ганцаараа юм болгоныг чаддаггүй шүү дээ гэж хэлмээр байна. Citibank-д уулзъяа.

Нэг цаг гаруйн дараа CitiSaudi мэдээллийн сангаа дамжуулж дуусав. Хуулж авсан мэдээллийг үзсэн Пар гайхсандаа дуу ч гарахаа больжээ. Тэд зүгээр ч нэг хуучин картнууд байсангүй, баян Арабууд эзэмшдэг дебит картнууд байлаа. Банкныхаа дансанд хэдэн саяыг хийсэн Арабууд өнөөх дансаа жижигхэн, тэгш өнцөгт хуванцар карттай холбожээ. Бүх төлбөр банкны балансас хасагдана. Мэдээллийн сангийн жагсаалтанд орсон нэгэн залуу өөрийнхөө картаар 330,000 доллараар Мерседес Бенз машиныг Истанбулаас авчээ. Тэрхүү картыг гудамжны булан тойруулахад л “Төлбөр хий!” гэсэн санааг хүнд өгнө.

Хэн нэгэн хүн сугалаанд ялахад өөрийн найз нөхөдтэй хуваалцах мэдрэмж төрдөг. Пард ч гэсэн яг тийм мэдрэмж төрнө. Хамгийн эхэнд өөрийн өрөөний хамдаа үзүүлэв. Тэр өдрөөс хойш Пар маш алдартай залуу болжээ. Түүнийг бараг л нууц ертөнцийн Гобин Гууд мэт өргөмжилнө. Удалгүй хүн бүр түүнтэй ярилцахыг хүсэх болов. Нью-Йоркийн хакерууд, Виржиниагийн фреакерууд, Сан Францискогийн Нууц албаныхан гэх мэт.

Пар Теоремд дурлахыг өгт хүсээгүй ажээ. Энэ бол зүгээр л гэнэтийн тохиолдол байсан бөгөөд хэцүүхэн охинтой үерхэхийг тэр тэвчихгүй биз. Тэр охин Швейцарт амьдардаг, 23 настай, харин Пар дөнгөж 17 настай. Тэр охин 1980-аад оны сүүл үеийн Австралийн хамгийн сайн хакеруудын нэг Электронтой холбоотой байв. Гэхдээ Пар биеэ барьж тэвчсэнгүй. Тэд хэзээ ч уулзалдаж байгаагүй боловч Теорем бол татгалзаж болмооргүй онцгой хүүхэн байлаа. Тэр ухаалаг, хөгжилтэй Европ бүсгүй ажээ.

Тэд 1988 онд Алтос дээр анх тааралджээ.

Теорем компьютерийн хакер биш байлаа. Тэр их сургуулийн хуучин компьютерийн

экзаунтаар Алтос руу холбогддог учраас түүнд хакердах шаардлага байгаагүй юм. Теорем 1986 оны 12-р сарын 23-нд анх удаа Алтосыг олж нээсэн байна. Энэ өдрийг тэр хоёр шалтгаанаар санаж байв. Эхлээд тэр нэг дор олон орны хэдэн арван хүмүүстэй онлайн дээр бодит цаг хугацаанд ярилцаж болох Алтосын хүч чадлыг биширчээ. Түүний хувьд Алтос цоо шинэ ертөнц байв. Хоёрдугаарт тэр Электронтой учирсан юм.

Электрон байнга л Теоремыг инээлгэнэ. Түүний ёжтой, эрээ цээргүй хошигнол Теоремын сэтгэлийн утсыг хөглөж байв. Швейцарчуудын бүгчим, хаалттай уламжлалт орчинд Электроны хошигнол цэвэр агаар амьсгалах мэт болгоно. Тэр цанаар гулгах дургүй байв. Зургаан тохой өндөр Теорем компьютерт юунаас ч илүү дуртай ажээ.

Анх тэднийг онлайн дээр уулзаж байхад Теорем хорин нэгэн настай, залуу насны ид хаваар дүүрэн байв. Тэрээр Их сургуулийн математикийн ангид сураад нэг жил хагасыг өнгөрөөсөн аж. Харамсалтай нь тэр сурлагадаа сайнгүй байлаа. Үнэнийг хэлэхэд их сургуулийн хоёр дахь жил нь түүний эхний жилийн сургалттай адил байсан юм. Их сургуулийн компьютер дээр түүний ангийн хүүхэд нь анх удаа Алтосыг танилцуулсан гэдэг. Электронтой танилцсанаас хойш нэг их удаагүй байхад Теорем сургуулиасаа гарч, нарийн бичгийн даргын курст суралцжээ. Курсээ төгсөөд эдийн засгийн институцэд нарийн бичгийн даргын ажилд оров.

Алтос дээр Теорем, Электрон хоёр олон цаг ярилцдаг байлаа. Тэд амьдрал, гэр бүл, кино, намууд зэрэг бүх сэдвээр ярилцах боловч ихэнх хүмүүсийн гол сэдэв “хакерын” тухай бараг огт ярьдаггүй байв. Эцэстээ Электрон зориг гарган Теоремын утасны дугаарыг асуужээ. Эмэгтэй утасны дугаараа шууд өгч, Электрон Лаузанне дахь түүний гэр рүү утасддаг болов. Удалгүй тэд бүх цагаа утсаар ярьж өнгөрөөдөг боллоо.

Арван долоон настай Электрон хэзээ ч үерхэж байгаагүй аж. Дээд сургуулийн ямар ч охин түүнд нүүр өгдөггүй байсан гэхэд болно. Гэтэл одоо уяран хайлах мэт сонстох Франц аялагаар ярьдаг дотносог хүүхэнтэй учрав. Тэр эмэгтэй үнэн сэтгэлээсээ түүнд татагджээ. Электроны амнаас унасан хэдхэн үг түүнийг унаж тустал нь инээлгэнэ.

Телефон утасны билл ирэхэд 1000 доллар гарсан байлаа. Электрон биллийг нууцаар цуглуулж, шатаагаад унтлагын өрөөнийхөө шургуулганд хийв.

Дараа энэ тухайгаа Теоремд хэлэхэд, хүүхэн төлбөр хийхэд нь туслах санал тавилаа. Тун удалгүй 700 долларын чек ирэв. Энэ чек нь Telecom-оос ирсэн сануулах бичгийг аавдаа тайлбарлах даалгаврыг маш хөнгөлсөн гэдэг.

Романтик харьцаатай үерхэл 1987 оноос 1988 оны эхний хагас жил хүртэл үргэлжиллээ. Электрон, Теорем хоёр дурлалын захидлаа 16,000 км компьютерийн сүлжээгээр илгээх тэр үед тэдний харилцаанд үл ойлголцол хүртэл гарч байлаа. Хүүхэн хэдэн сарын турш Пенготой учир ургуулах болов. Германы хакеруудын Chaos Computer Club бүлэгтэй холбоотой Германы алдарт хакер Пенго Электроны найз, дотны зөвлөгч байв. Теоремоос галт тэргээр хэдхэн буудал яваад очих зайныгазар Пенго амьдарч байлаа. Хүүхэн Пенготой найз нөхөд болж, удалгүй тэднийд зочилдог болжээ. Эндээс л асуудал урган гарсан юм.

Теорем өөрийн болзооны тухай Электронд үнэнээр ярьдаг боловч түүнд хэлж,

илэрхийлээгүй, далд зүйл оршсоор байв. Дурлалын паян төгссөн ч түүнээс хойш хэдэн эрчүүдтэй дэр нийлүүлснээс үл шалтгаалан анхны дурлалдаа үнэнч үлдсэн Теорем Пенго үгүйлсээр байсан юм.

Электрон сэтгэлээр унаж, уурласан хэдий ч Теоремийн сээтэгнүүр занг уучилжээ. Эцэстээ Пенго тайзнаас алга боллоо.

АНУ-ын цэргийн нууцыг компьютерээс авч КГБ-д худалдсан хүмүүстэй Пенго холбогджээ. Хэдийгээр олон улсын компьютерын тагнуулын ажиллагаанд шууд холбоогүй байсан ч тэрээр гарах эрсдлээс ихэд сэтгэл түгших болов. Түүний жинхэнэ сонирхол бол тагнуул хийх бус хакердах байлаа. Оросуудтай холбоотой болсноор түүнд илүү том, сайн компьютерт холбогдох боломж олджээ. Харин компьютерт холбогдохоос бусад үед тэр Оросуудад үнэнч бус хандаж байв.

1988 оны эхний хагаст тэр өөрийгөө Германы эрх мэдэлтнүүдэд өгчээ. Тухайн үеийн Баруун Германы хуулиар тагнуул хийх гэмт хэргийг илрүүлэхээс өмнө иргэн сайн дураар өөрийгөө илчилж, улс орондоо учруулах хор хохирлыг зайлуулвал шийтгэлээс чөлөөлөгдөж байв. Хулгайлагдсан сүлжээ хэрэглэгчийн хаягийг (NUI) 1986 оны 12-р сард хэрэглэсэн гэмт үйлдлээ цагаатгахын тулд хуулийн энэ боломжийг ашиглан өөрийгөө илчлэх нь зүйтэй гэж Пенго үзжээ.

Тэр жилийн сүүлээр Пенгогийн хувьд нөхцөл байдал ээдрээтэй болж 1989 оны 3-р сард Берлины 21 настай залууг гэрт нь баривчлав. Энэ удаад бусад дөрвөн хүн тагнуулийн бүлэгт холбогджээ. Болсон явдлыг хэвлэл дээр нийтэлж, Пенгогийн жинхэнэ нэр ил боллоо. Тэрээр гэмт хэрэгт буруутгагдах эсэхээ мэдэхгүй байв. Пенгогийн ухаан санаанд зургаан тохой өндөр хүүхнээс өөр хэдэн бодол эргэлдэж байсан гэдэг.

Пенгод дээрх явдал тохиолдосны дараа Теорем ба Австралийн хакерын харилцаа сайжрав. Гэтэл дахиад нэг хүн тэдний хоорондуур орж ирлээ. Энэ бол Пар байв.

Пар, Теорем хоёр гэм буруугүй найзууд болж үйл явдал эхэлжээ. Олон улсын хакерын ба фреакингийн тавцан дээрх хэдэн охидын нэгд тооцогдох Теоремыг Алтос дээр бусдаас ялгаатай ханддаг байв. Тэр хүүхэн Германы чатын систем дээр олон эрэгтэй найзуудтай бөгөөд бие биедээ хэлэхгүй нандин зүйлээ түүнд хэлнэ. Тэд түүнээс зөвөлгөө авахыг хичээнэ. Алтос дээр хөвгүүдтэй харьцаж байхдаа эх, найз охин, сэтгэл зүйч мэт олон хүний малгай өмсөж байгаа мэт сэтгэгдэл Теоремдтөрдөг байв.

Онлайны найз охин Норатай асуудалтай болсон учраас Пар Теоремоос бага зэрэг дэмжлэг хүслээ. Тэр найз охинтойгоо уулзахаар Калифорниагаас Нью-Йоркт иржээ. Нью-Йоркийн халуун зунаар урьдчилан мэдэгдэхгүйгээр ирсэн Парыг охины хуучинсаг үзэлтэй Хятад эцэг эх нь таатай хүлээж аваагүй ажээ. Нора, Пар хоёрын хооронд мөн өөр зөрчилдөөн байв. Алтос дээр болон телефон утсаар тэдний харицлаа дажгүй байсан боловч яг биеэрээ уулзангуут байдал өөр тийшээ эргэжээ.

Цахим орчинд гагнагдсан холбоо бодит байдал дээр үгүйсгэгдэнэ гэдгийг тэр аль хэдийнээ мэдэж байв. Заримдаа бүр сэтгэлээр унамаар ч байж болно.

The Realm-ийн Австрали гишүүн Феоникс болон өмнөд Калифорниагийн хөгжилтэй охинтой Пар утсаар их ярьдаг байв. Хааяа фреакер хийдэг Тамми хөгжилтэй, хошин мэдрэмжтэй, маш өвөрмөц зан чанартай хүн байлаа. Цаг хугацаагүй мэт удаан чалчих зуур тэр охин, Феоникс хоёр дэлбэрэх шахам шанална. Фреакингийн нууц ертөнцөд тэднийг хүндэлдэг байв. Тэр охин Феониксийг өөрийн гэртээ ирэхийг хүртэл урьсан аж. Удалгүй нэгэн өдөр Монтерей дэхь Парын гэрт гэнэт зочлохоор Тамми шийджээ. Түүний гадаад төрх байдал жигшмээр байв.

Тамми өөрийгөө Калифорнийн хөх нүдтэй, шаргал үстэй охин гэж Феониксд хэлсэн байжээ. Наран шарлагын хувцас өмссөн байдлаар Феоникс түүнийг төсөөлж байгаа гэдгийг Пар мэдэж байлаа. Өмнөд Калифорнийн соёлын талаархи гадны хүмүүсийн төсөөллөөр түүний ойлголт хязгаарлагдана. Сүү, зөгийн балны орон. “Charlie’s Angels” телевизийн цуврал болон “Beach Boys”-ийн өлгий нутаг.

Таммиг харах эгшинд Феоникс тэр хоёр хэзээ ч тохирохгүй гэдгийг Пар мэджээ. Хэдийгээр Тамми шаргал үс, хөх нүдтэй боловч 300 паунд жинтэй гэдгээ хэлэхээ мартсан санагдана. Онлайн дээр Тамми түүнд маш ихээр таалагдаж байсан ч одоо харж байхад төрсөн бодлоосоо салж чадахгүй байлаа. Хэцүүхэн бодлоо хаяхыг хичээсэн ч оюун санааг амархан арчиж болох биш дээ. Тэр Таммигийн тухай бүх үнэнийг Феониксд хэлэх сэтгэл Парт төржээ.

Тиймээс онлайн нөхөрлөлийн суурийг бодит байдал үгүй хийнэ гэдгийг Пар урьдчилаад мэдэж байсан юм.

Нью-Йорк ба Нораг орхисны дараа Нью Жерсей рүү өөрийн найз Байтмантай уулзахаар Пар явжээ. Байтман бол “Bell Communications Research” (Bellcore)-ийн компьютерийн системд нууцаар нэвтрэхэд мэргэжсэн хакерын бүлгийн нэг гишүүн байв. АНУ-ын телефон утасны монополь компани Bell Systems задарсны дараа 1984 оны эхээр Bellcore байгуулагдсан юм. Bell Systems задрахаас өмнө түүний эцэг компани American Telephone & Telegraph (AT&T) нь Bell Labs нэртэй судалгааны хамгийн сайн институцийг тэтгэж байв. Түүхийн явцад Нобелийн шагналт долоон эрдэмтэн, олон шинжлэх ухааны нээлтээр Bell Labs бахархаж ирсэн юм. Энэ бүхэн хакеруудын ур чадвараа шалгах овоо хараанд “Bellcore”-ийг өгчээ.

Алтос дээр Байтман Теоремтой чатладаг байсан бөгөөд удалгүй түүн рүү утсаар ярих болжээ. Нэгэн өдөр Байтман Теоремтэй ярьж байгаад гэнэт “Хөө миний найзтай ярихыг хүсэж байна уу?” гэж асуухад Теорем “Тэгье” гэв. Байтман харилцуурыг Парт өгч, тэд хорь орчим минут ярьсан байна.

Түүнээс хойш тэд Алтос болон телефон утсаар байнга ярьжээ. Хэдэн долоо хоногийн дараа Пар Калифорниад буцаж ирлээ. Норатай бүтэлгүйтсэн сэтгэлийн дарамтнаас гаргахын тулд Теорем түүнийг хөгжөөхийг оролдоно. 1988 оны дунд үед тэд бие биендээ дурлажээ.

Форсын The Realm бүлгийн гишүүн Электрон энэ мэдээг таатай хүлээж аваагүй юм. Алтос дээрх хүн бүр Электронд дуртай байгаагүй аж. Тэр жаахан барьцгүй, за гэвэл ёогүй боловч олон улсын тавцан дээр алдартай хакер байв. Хүн бүр түүнийг сонсоно. Бүтээлч, уйгагүй Электронд Пар атаархдаг байжээ. Онлайн дээр хувийн ярилцлага хийх үедээ Теорем муу мэдээг Электронд сонсгов. Электрон бараг хүн бүрийн нүдэн дээр, Алтосын чатын төв

хэсэгт Америк хакер руу довтолж, олон нийтийн хэсэг дээр ялаа үлдээжээ.

Пар ямар нэгэн эсэргүүцэл, тэмцэл хийсэнгүй. Тэр юу ч хийж чадах билээ? Түүнийг маш ихээр зовооно гэдгийг тэр мэднэ. Теоремийг алдвал түүнд ямар хэцүү байхыг Пар төсөөлж байв. Электрон маш ихээр шанална гэдэг нь ч илт байсан юм. Электрон, Теорем хоёрыг хүн бүр нэг мэт санадаг бөгөөд тэд жилээс илүү хугацаанд үерхсэн. Тиймээс Пар Электроны уур хилэнг чимээгүйхэн ажиглаж өнгөрөөв.

Тэр өдрөөс хойш Пар Электроноос ямар нэгэн заналхийлэл сонсоогүй ажээ. Алтос дээр Электрон зочлох авч Парыг байх үед гарчихна. Нэгэн өдөр Пар олон хакеруудын хамт түүнтэй холбогдохыг оролдов.

Феоникс: “Хөөе Электрон Пар чамтай ярьяа гэж байна” гэхэд Электрон хэсэг түдгэлзсэнээ “Өө тийм үү” гэж хүйтнээр хариулаад чимээгүй болов.

Электроныг зайгаа барихыг Пар ажиглаж байв. Тэгээд ч Пар хүссэн зүйл буюу хүүхнээ авч чадсан.

Теорем руу Пар өдөр бүр утасдана. Удалгүй биечлэн уулзахын тулд Калифорни руу нисэж ирэх төлөвлөгөөг тэд гаргав. Энэхүү уулзалтаас их зүйл горьдохгүй байхыг Пар хичээнэ. Нүүр нүүрээ тулан уулзахад юу болох талаар тэр бодохгүй байж чадахгүй байлаа. Одоо тэр хүлээх л хэрэгтэй болжээ.

Хакер ямар ч нэрийг сонгож, орон нутгийн бусад BBS эсвэл Pacific Island дээр орж болох нь Алтосын гайхамшиг байлаа. Хакер олон улсын хэмжээнд ч үүнийг хийж болно. Алтос руу зочлоно гэдэг бол гял цал болсон үдэшлэгт оролцож байгаатай адил юм. Хэн өөрийгөө дахин өөрчилж болно. Болхидуу хакер өөрийгөө романтик, адал явдалд дуртай хүн болгон харагдуулах боломжтой. Мөн хууль хяналтын байгууллагын ажилтан хакер болон зочилж болно.

1988 оны 10-р сарын 27-ны өдөр “Telenet”-ийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Стив Матьюс яг тийм үйлдэл хийсэн юм. Тухайн үед Пар онлайн дээр өөрийн найз нөхөд, хамтрагч хакеруудтай чатлаж байв. Алтос дээр байнгын болон золбин гэж хэлж болох хүмүүс байнга хөлхинө. Матьюс өөрийгөө Telenet-ийн ажилтан гэж зарлалгүй, бусад хакерын адил орлоо. Тэрээр хакертай ярилцлага хийх боловч нөгөө хүнээ илүү яриулж, их сонсох тактикаар ажиллана.

Тэр нэгэн гайтай өдөр Пар их сайхан, өглөгч ааштай байв. Пар хэзээ ч их мөнгөтэй байгаагүй боловч юу байгаагаа өгчихөөр өглөгч байдаг аж. Тэрээр Алтос дээр үл таних хакертай ярилцаж байгаад CitiSaudi-гийн компьютерээс авсан дебит картны нэгийг түүнд өгөв. Яагаад үгүй гэж? Алтос дээр өөрийн нэрийн хуудсаа тарааж байгаа мэт аашилж болно биз дээ. “Пармастер-параметрс Пар дээд зэргийнх”

Пар урьд өмнө Пармастер гэсэн нэртэй байв. Тэр үед Пар Apple II компьютерийн програмыг хуулбарлахаас хамгаалах бүтцийг эвдлэх өсвөр насны бүлэгт харьяалагдаж байжээ. Ялангуяа тоглоомын програм хангамж дээр их ажиллана. Хуулбар хийхээс

хамгаалсан параметрийг эвдэх тусгай аргыг Пар эзэмшсэн байв. Бүлгийн ахлагч түүнийг “параметрийн мастер” хэмээн дуудах болсноор “Пармастер” дараа нь Пар гэсэн богино нэртэй болжээ. Ингээд Х.25 сүлжээнүүдэд өөрийн чадварыг хөгжүүлсэн Пар шинэ орчинд сайн тохирсон нэрээ авч үлдсэн хэрэг. Х.25 сүлжээ рүү орох модемны gateway, Х.25 пад дээр “Пар” түгээмэл команд байлаа.

“Надад маш их байгаа. Citibank-ны системийн 4000 карт байгаа” гэж үл таних хүнд Пар хэлэв.

Тэр явдлаас хойш нэг их удалгүй Алтосыг хянаж байхад Пар хүмүүст дахин карт тараасныг Стив Матьюс ажиглав.

“Би дотроос нь мэдээлэл авдаг. Citibank-ны компьютерээс авсан хүчинтэй дугааруудаар нилээд томоохон бантанг хутгана даа. Гэхдээ зөвхөн том дансаар шүү. 25,000 доллараас дээш баланстай дансаар”...

Пар том яриа үүсгэж Алтос дээр жүжиглэж байв уу? Эсвэл тэр ийм том залилангийн хэрэг үйлдэхээр шийдэв үү? Citibank, Telenet, АНУ-ын Нууц алба хэзээ ч мэдэж чадахгүй гэж тэр бодно. Яагаад гэвэл түүний санаа хэрэгжихээс өмнө Парын эргэн тойрны сүлжээг аюулгүй байдлын залуус хааж эхлээд байлаа.

Матьюс Калифорнийн Сан Метео дах Citibank-ны залилангийн хэрэг мөрдөгч Ларри Валластай холбоо барилаа. Валлас картуудыг шалгахад хүчинтэй байв. Картууд Саудын Арабын Сауди-Американ банкинд харьяалагдах бөгөөд Өмнөд Дакота дахь Сьюкс Фаллсийн “Citibank”-ны мэдээллийн сангаас алдагдсан дугаарууд байж. Ойрхи Дорнодын банкинд ийм явдал тохиолдсон учраас Citibank экаунтуудыг хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй гэж Валлас үзжээ. Өөрөөр хэлбэл тэрээр томоохон мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах юм. 11-р сарын 7-нд АНУ-ын Нууц албыг мөрдөн байцаалтандаа татан оролцууллаа. Дөрвөн өдрийн дараа Валлас, тусгай ажилтан Томас Холман нар хамгийн анхны томоохон учгаас барьж авав. Тэд Сан Франциско дахь “Pacific Bell”-ийн аюулгүй байдлын офисийн ажилтан Герри Леонсоос байцаалт авчээ.

Леонс хэрэгтэй байж болох мэдээллийг мөрдөн байцаагчдад өгөв. Тэр эмэгтэй хакерууд болон фреакеруудын тухай бүгдийг мэдэж байлаа. Тухайн үед төлбөрт утасны бүхээгийг фреакинг хийх гэж байсан хоёр залууг Сан Хосегийн Цагдаагийн газар баривчилсан байв. Фреазерууд “Citibank”-ны системийн тухай зарим зүйлийг мэдэж байгаа мэт санагдсан байна.

Сан Хосегийн Цагдаагийн газрын түрүүч Дейв Флоритой уулзсан мөрдөгчид бас нэгэн таатай бэлгийг хүлээн авлаа. Телефон утасны хоёр фреакерыг баривчлах үед хураан авсан хакеруудын нэр утасны жагсаалтаар дүүрэн тэмдэглэлийн дэвгрийг түрүүч үзүүлэв. Түүнчлэн фреакерууд шоронгийн утаснаас Пар руу ярьсан ярианы бичлэг түрүүчийн мэдэлд байж таарав.

Хэнэггүй фреакерууд шоронгийн төлбөртэй утаснаас Виржиниагийн Их сургуулийн ойролцоо байрлах телефон утасны зангилаанд холбогдох гэж оролдсон байна. Австралийн

хакерууд, Америкийн зарим фреакерууд болон Пар тэр зангилаанд байнга зочилдог байв. Ихэнх цаг хугацаанд нууц ертөнцийн наймаас арван хүн уг холболт дээр байдаг байлаа. Фреакерууд Парыг тэндээс олж, анхааруулж амжсан аж. Фреакеруудыг баривчлах үед хураасан дэвтэр дээр Парын нэр, утасны дугаар байсан юм.

Пар нэг их сэтгэл зовнисон шинжгүй байлаа. “Зүгээр санаа зоволтгүй. Би өнөөдөр өөрийн утасны дугаараа салгачихсан” гэж батлан хэлжээ.

Энэ үнэн байв. Түүний өрөөний хам Скотт дүрсгүйтсэн дуудлагууд хүлээн аваад байсан учир өөрийн нэр дээр байсан утсыг салгажээ. Тэгээд Скотт тэр өдрөө хуучин хаягаараа өөрийн нэр дээр шинэ утасны экакаунт нээсэн нь нууцлаг хакер Парыг хөөж олох хууль хамгаалах байгууллагуудын ажлыг маш хялбар болгосон юм.

Мөрдөн байцаалтын явцад Ларри Валлас аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг танилууд руу утасдаж, бас нэгэн учгийг барьж авав. Атланта хотын “МСІ” мөрдөн байцаалтын Зүүн өмнөд бүсийн дарга Ванда Гамблед өөрийгөө Пар гэж нэрлэсэн хакерын тухай мэдээлэл маш ихээр хадгалагдаж байв. Тэр хатагтай хакерын үйлдсэн гэмт үйлдлийн талаар мөрдөн байцаалт явуулж байхдаа найдвартай олон мэдээлэгчтэй болсон байлаа. Парын хоёр шуудангийн хайрцагны дугаарыг “Citibank”-ны мөрдөгчид Ванда Гамбле өгчээ. Түүнчлэн хатагтай Ванда түүний гэрийн утас байж болох дугаарыг мөрдөгчид өгөв.

Талархлын баярын дараа 11-р сарын 25-ны өдөр дугаарыг шалгаад Нууц Албаныхан Парын гэрт иржээ. Тэдний довтолгоо маш сүртэй болов. Хамгийн багадаа хууль хамгаалах байгууллагын дөрвөн ажилтан хаалгаар орж, гар буугаа шагайсан харагдана. Тэдний нэг нь хоёр амтай урт буу барьжээ. Pacific Bell ба Citibank-ны хувийн мөрдөгчид тэдний хамт дайралтанд оролцов.

Мөрдөгчид нотлох баримт хайж нэгжлэг хийв. Гал тогооны тавиур дээрх хүнсийг буулгаж, эрдэнэ шишийн тэжээлийг угаалтуур руу султган нуусан компьютерийн диск хайжээ. Тэд дээврийн хөндийд байдаг гэж хэн ч мэдэхээргүй жижигхэн өрөөнд хүртэл нэгжлэг хийв.

Парын AppleIIe, принтер, модемыг хураан авчээ. Мөн телефон утасны лавлах ном, телефон утас, Скотын дөнгөж худалдаж авсан Nintendo тоглоомыг хүртэл хураав. Мөрдөгчид кофены ширээний доор тавьсан их хэмжээний цааснуудыг, аялалын агент ажилтай Скоттын онгоцны тийз захиалах бүртгэлийн дэвтэртэй хамт мөн адил хаман авчээ. Тэд гэрийн хогийг нь хүртэл үлдээсэнгүй.

Төд удалгүй мөрдөгчид Парын компьютерийн хажууд байх загасны аквариумын доороос гутлын улаан хайрцагт хийсэн дискүүдийг олов. Маш их хэмжээний нотлох баримт олжээ. Гэхдээ тэд Парыг барьж чадсангүй.

Харин түүний оронд дайралтаас ихэд цочирдсон Парын найз Скотт, Эд хоёрыг барьсан гэдэг. Парын жинхэнэ нэрийг мэдэхгүй Нууц Албаныхан Скоттыг буруутгаж байв. Утас түүний нэр дээр байснаас гадна дайралт хийхээс долоо хоногийн өмнө тусгай ажилтан Холман нууц ажиглалт хийжээ. Түүний гэрийн өмнө 1965 онд үйлдвэрлэгдсэн хар өнгийн Форд Мустангны бүртгэлийн дугаар Скоттын нэр дээр байсан учир зөв хүнээ барьсан гэж Нууц

Албаныхан үзэж байв. Гэтэл Скотт би биш хэмээн зүтгэсээр их цаг хугацааг баржээ.

Бид хакер эсвэл фреакер биш гэж Скотт, Эд хоёр чин сэтгэлээсээ тангараглана. Тэд Парыг сайн мэдэх тул түүний жинхэнэ нэрийг хэлж өгөв. Нууц Албаныхны шахалтаар Скотт, Эд хоёр цагдаагийн хэсэгт очиж, мэдүүлэг өгөхийг зөвшөөрчээ.

Энэ үед Хойд Калифорниагаас 2700 километрийн зайд орших Чикагод Пар ээжийнхээ хамт цагаан өнгийн өмсгөлтэй авга эгчийгээ харан зогсож байв. Тивийн баруун дунд хэсгийн эргээс мэнд асуухаар Пар нэг удаа утасдсан аж. Тэр дайралтын дараа тэрээр утас цохижээ.

“Гэр орноор сонин юу байна?” гэж өрөөнийхөө хамаас Парыг асуухад “Сонин юу байхав дээ. Энд юу ч болоогүй байна” гэж Скотт хэлэв.

Барьж явсан улаан цүнхээ хараад Пар гэнэт айдаст автлаа. Сан Хосегийн автобусны буудал дээр тагтаануудын дунд тогос шиг зогсож байгаагаа тэр гэнэт ойлгожээ.

Гурав хоногийн өмнө болсон дайралтын талаар огт мэдээгүй Пар Сан Хосегийн онгоцны буудал руу ээжийн хамт нисэж ирэв. Тэд буудлаас “Greyhound”-ын автобусанд сууж Монтерей руу явлаа. Автобус хүлээж байхдаа Пар Тамми руу утасдаж Калифорниад буцаж ирснээ мэдэгджээ.

Магадгүй утсаар ярихаар дугаарлан зогсох хүмүүс бор үстэй хүүгийн царай гэнэт барайхыг ажигласан бизээ. Инээмсэглэх царайд гэнэтийн уйтгар тодрон, хувхай цагаан болжээ. Нууц Албаныхан Парын жинхэнэ нэрийг мэднэ, түүнийг эрэн сурвалжилж байгаа гэдгийг Тамми хэлэв. Хакердсан тэмдэглэл, Citibank-ны кредит картны дугаарыг хэвлэсэн цааснуудыг хийж явдаг Парын улаан цүнхний тухай Нууц Албаныханд Скотт ярьжээ.

Тийм учраас Пар өөрийн цүнх рүү түгшсэн байдалтай харсан байна. Нууц Албаныхан улаан өнгөтэй цүнх эрэн сурвалжилж байгааг тэр ойлгожээ. Хэрэв тэд түүний гадаад төрхийг мэдэхгүй бол зүгээр л цүнх хайх болно.

Цүнхийг шууд нуухад хүндрэлтэй байв. Хэвлэж авсан Citibank-ны дугаарууд телефон утасны лавлах шиг хэмжээтэй. Түүнээс гадна картны дугаар, хакердах тухай нууц мэдээллийг хадгалсан дискүүд байв.

Пар хэдэн үнэгүй дуудлага хийхэд л картнуудыг ашигласан бөгөөд эд зүйл худалдан авч амжаагүй байлаа. Тэр яахаа шийдэж ядна. Ёс суртахуунгүй зарим хакерууд карт олбол хамаагүй үрнэ гэж Пар дотроо төсөөлнө. Түүний зөв байлаа. Жишээлбэл: Нэгэн хакер хулгайлагдсан картыг ашиглан Эл Пасод амьдардаг хүүхэн рүү 367 долларын цэцгийн баглаа илгээхийг оролдсон аж. Картчин хакер Саудын банкны захирлын дебит картыг болгоомжгүй сонгожээ. Цэцэгний захиалга хийж байх тэр үед банкны захирал ажил дээрээ байж таарав. Citibank-ны мөрдөгч Ларри Валлас тэр хэргийн тухай тэмдэглэлийг өөрийн хавтсанд нэмсэн гэдэг.

Карт хэрэглэхээр завдсан үйлдэл бүрийг түүний нэр дээр тохохыг хичээнэ гэж Пар бодлоо. Яагаад үгүй гэж? Арван долоон настай хакер тийм гүтгэлгийг няцааж чадна гэж үү?

Чадахгүй ээ. Пар шийдвэрээ гэнэт гаргав. Тэр харанхуй буланд орших хогийн сав руу бусдын анхаарлыг татахгүй дөхөж очлоо. Ойр орчноо хянамгай ажиглах Пар Citibank-ны картны дугаарыг хэвлэсэн цааснуудаа хогийн сав руу чихэж гарав. Цаасны дээр хэдэн хог овоолж далдаллаа.

Тэрээр хакердах үнэт мэдээллийг агуулж байгаа дискэнд санаа зовж байв. Дискэнд хэдэн мянган цагийн хөдөлмөр шингэсэн учраас шууд хаячихаж чадахгүй байлаа. Ялалт бахархлыг илэрхийлэх 10 мегабайтын мэдээлэл, 4000 карт, 130,000 төрөл бүрийн шилжүүлэг. Эцэст нь эрсдлийг үл тоон дискийг өөртөө үлдээхээр шийджээ. Тэгээд ч хэвлэсэн цааснаас салсан учир бусдын анхаарлыг татахгүйгаар авч явж болно. Хогийн савнаас аажмаар холдох зуураа Пар үнэт материалаа оршуулсан газраа дахин нэг харав. Зүгээр л овоолсон хог шиг харагдана. Хэдэн сая долларын үнэтэй хог...

Салинас руу явах автобусанд ээжийнхээ хамт сууж байх зуур, хогийн сав ухаж байгаа орон гэргүй хүний дүр зураг Парын ухаан санаанаас гарахгүй байлаа. Тэрбодлоо өөрийн толгойноос авч хаяхыг Пар оролдоно.

Автобусаар явж байхдаа цаашид хэрхэхээ Пар бодов. Тэр ээждээ юу ч хэлээгүй. Ээж нь компьютер сүлжээний ертөнцийн тухай ойлгох ч үгүй байсан юм. Түүнчлэн 17 дахь төрсөн өдрийнхөө дараа орон гэрээ орхисноос болж түүний ээж, Пар хоёрын хооронд хүйтэн хөндий байдал үүссэн байв. Хичээлээ тасалж сургуулиасаа хөөгдсөн ч орон нутгийн коллежид компьютерийн оюутнуудад хичээл заах болов. Чикаго руу явах аялалын өмнөхөн, Пар зургаан сарын хугацаанд ээжтэйгээ ганц удаа л уулзжээ. Үгүй ээ, тэр ээжээсээ туслалцаа гуйж чадахгүй.

Автобус Салинасын буудал руу дөхөж ирэв. Аялалын зам дагуу нь Парын амьдардаг гудамж байна. Тэр walkman хөгжим зүүсэн, хар арьст туранхай хүн гүйж байхыг харлаа. Хагас үйлдвэржсэн дүүрэгт хэн ч гүйдэггүй учир “Энд юугаа хийж гүйдэг байна аа” хэмээн Пар бодож амжив. Парын гэр жижиг аж үйлдвэрүүдийн яг дунд хэсэгт оршино. Гүйж байгаа хүн түүний гэр харагдах зайны газар өнгөрөнгүүт замаасаа гарч, газар хэвтэв. Өвсөн дээр элэг дөрвөөрөө хэвтэж байх зуураа түүний гэрийг чиглэн ажиглалт хийнэ. Тэр хүн walkman рүүгээ ярьж байх шиг санагдлаа.

Автобусаас үүнийг ажигласан Пар огцом өөр тийш харав. Тэд түүнийг барих гэж байгаад эргэлзэх зүйл алга. Буудал дээр автобус ирсний дараа, ээж нь ачаагаа янзлах зуур Пар улаан цүнхээ сугандаа хавчуулаад алга болов. Пар төлбөртэй утсаар Скотт руу ярьж нөхцөл байдлыг лавлажээ. Скотт харилцуурыг тэр байранд хамт амьдардаг Крист өгөв. Талархлын баярын үеэр дайралт хийх үед Крис эцэг эхийнхээ гэрт байжээ.

“Тэвчээртэй бай, бусдын анхаарлыг бүү тат. Би чамайг авахаар очлоо. Тэгээд зөвөлгөө эсвэл хамгаалалт авч болох хуульч руу хүргэж өгнө” гэж Крис Парт хэлэв.

Эрүүгийн эрх зүйгээр мэргэшсэн Ричард Роузен Нью-Йоркт төрсөн боловч бага насаа Калифорниад өнгөрөөжээ. Тэрээр Нью-Йоркчуудын хөдөлшгүй зөрүүд занг, баруун эргийн найрсаг харьцаагаар чимсэн онцлогтой хүн байв. Роузен анти авторитариан буюу хэмжээгүй эрхт дарангуйлагчийн эсрэг үзэл бодлыг хүчтэй дэмжигч ажээ. Тэрээр Монтерей бүсийн

нийгмийн дундаж давхаргын төлөөлөл байсан юм. Түүнчлэн Роузен гэртээ хүүхэд төрүүлэх явдлыг дэмждэг эх баригчдынхөдөлгөөнийг төлөөлж, олны анхаарлыг татсан нэгэн. Үүний үр дүнд Калифорниагийн эмч нар түүнд дургүй болжээ.

Парыг буцаж ирэхээс өмнө Роузен хуультай өрөө хамууд нь уулзжээ. Парын эсрэг мэдүүлэг өгүүлэхээр дарамталж, цаг хагасын хугацаатай байцаасан Нууц Албаны гэнэтийн дайралтын тухай хуульчид ярьсан байна.

Түүнчлэн Парын эсрэг мэдүүлэг өгүүлэхээр хүч хэрэглэсэн гэж Скотт мэдэгджээ. Кристэй утсаар ярьж байхад төлбөртэй утасны дараалалд зогсох эрэгтэй walkman зүүсэн байхыг Пар ажиглав. Тэр Парын нүд рүү эгцэлж харалгүй, түүний зогсож байгаа чигт нууцаар ширтэж байлаа. Энэ залуу хэн бэ? Түүний ухаан санаанд олон эргэлзээ эргэлдэж эхлэв. Тэр хэнд итгэж болох вэ?

Скотт дайралтын тухай түүнд огт яриагүй ажээ. Түүний өрөө хамууд Нууц Албатай хуйвалдсан уу? Эсвэл тэд түүнийг барьж өгөхийн тулд цаг хожих гээд байна уу? Пар хэнд итгэж болохгүй байлаа. Ээж нь түүнийг ойлгохгүй. Хажуугаар нь тэр өөрийн асуудалтай. Парт аав байхгүй. Түүний хувьд аав нь үхсэнд тооцогдоно. Харинхэзээ ч уулзаж үзээгүй аавыгаа Флоридагийн шоронгийн харгалзагч хийдэг гэж сонсчээ. Ийм нөхцөлд тэр туслаж чадах хүн биш байлаа. Өөрийнхөө эмээ өвөөтэй Пар ойр дотно байв. Түүнд компьютер бэлэг болгон авч өгсөн хөгшчүүд ойролцоох жижигхэн хотод амьдрах бөгөөд бас л түүнийг ойлгохгүй.

Пар яахаа огт мэдэхгүй байв. Түүнд өөр сонголт байхгүй учраас буудал дээр Крисийг хүлээхээр шийджээ. Тэр булан тойрч, бусдын нүднээс далд байхыг хичээнэ.

Хэдэн минутын дараа Крис буудал дээр ирэв. Пар Toyota Landcruiser-т үсрэн орж, Крис Роузены офис руу хурдаллаа. Тэдний араас цагаан өнгийн машин ухасхийхийг Крис ажиглав.

Роузен руу явах замд Крисийн ярьсан зүйлийг Пар эргэцүүллээ. Гэрийн утасны шугамыг нууцаар чагнаж байсан учраас хэн ч түүнийг отоож байгааг хэлээгүй аж. Чикагод байхад нь Парт хэлсэн бол Нууц Алба дахин айлчилна. Тэдний хийж чадах цорын ганц зүйл бол Роузенаас тусламж гуйх явдал байлаа.

Пар машины арын цонхыг ажиглаж явав. Цагаан машин тэднийг дагасаар. Дараагийн уулзвараар Крис огцом эргэлт хийж, Калифорниагийн хурдны замаар хааз нэмэн гишгэв. Крис хичнээн хичээсэн ч цагаан машинаас мултарч чадахгүй байлаа. Пар жолоочийн хажууд суух агаад чимээгүйхэн түгшиж явна.

Хорин дөрөвхөн цагийн өмнө тэр Чикагод аюулгүй байж билээ. Ингээд хэн нь мэдэгдэхгүй жолоочтой цагаан машинд хөөгдөөд Калифорниад явж байх гэж...

Крис мөрдөгчөөс мултрахаар дээд зэргээр хичээв. Цагаан машин чадварлаг дагаж байлаа. Гэхдээ Крис, Пар хоёрын машин дөрвөн дугуйгаар мааждаг учраас нэг ч гэсэн зүйлээр давуу байлаа. Хурдны замаас гарах шийдвэрийг хагас секундын дотор л Крис гаргалаа. Тэдний унасан Landcruiser байцааны талбай руу оржээ. Бартаат замд тохирсон жийп машин цэвэрхэн

Энгээгээр тарьсан байцаан дундуур үсчих зуур Пар хаалганаас тас зуурсан байлаа. Дугуйны доороос байцааны навч цацагдсаар машин эгшин зуур шавраар будагджээ. Гулсаж, шарвасаар машин талбайн нөгөө хэсэгт гарав. Крис дахин хурдны зам руу орж хурдлав.

Пар машины ар тал руу харахад цагаан машин сураггүй болсон байв. Ричард Роузены байрны гадаа Landcruiser ирж зогсоход Пар сандарсан хэвээр байлаа.

Тэр улаан цүнхээ сугандаа хавчуулсан хэвээр хуульчийн өрөөнд оров. Өөрийнхөө нэрийг хүлээн авагч хүүхэнд хэлэхэд сандарсан байдалтай харагдана. Хэн нэгэн хүн тэр эмэгтэйд бүгдийг ярьсан байж болох юм.

Роузен тэднийг өрөөндөө хурдхан оруулав. Танилцуулгыг товч хийгээд машиныг нь дагасан тухай сандран ярьжээ. Роузен тэднийг анхааралтай сонсож байгаад тодруулах асуулт тавина.

Хамгийн эхэнд Нууц Албаны мөрдөлтийг зогсоох шаардлагатай байсан учраас Роузен Сан Францискогийн Нууц Алба руу утасдаж, тусгай ажилтан Томас Ж. Холмантай ярив. Тэднийг мөрдөлтөө зогсоовол Пар хүндрэл учруулахгүйгээр уулзах болно гэсэн тохиролцоог хийхийг Роузен оролдлоо.

Харин Нууц Алба Партай ярилцах хэрэгтэй байна гэж Холман шаардав. “Үгүй ээ тохиролцоонд хүртэл Парыг ямар ч хуулийн ажилтан байцаахгүй” гэж Роузен хариулжээ. Түүний үйлчлүүлэгчтэй холбогдох гэж оролдох хэрэггүй хэмээн Холманд Роузен санууллаа. Хэрэв Пард ямар нэг зүйл хэлэх шаардлагатай бол надаар дамжуулна гэж тэр нэмж хэлэв. Холман түүний хүсэлтийг таатай хүлээж авсангүй. Нууц Албаныхан хэн нэгэнтэй ярилцахыг хүсвэл өөрсдийнхөө аргаа амжуулахыг хүснэ. Тэр Роузенаас шаардсан хэвээр байсан хэдий ч үгүй гэсэн хариултыг авсаар байлаа. Холман алдаа гаргажээ. АНУ-тай Нууц Албатай хүн бүр хамтарч ажиллахыг хүсдэг гэж тэр боджээ.

Роузен хэлсэн үгнээсээ буцахгүй гэдгийг мэдсэн Холман түүний хэлснээр хийв. Роузен холбооны прокурор АНУ-ын хуульч Жое Буртонтой тохиролцоонд хүрчээ. Парыг мөрдөж мөшгихөө зогсоохыг Холманы даргатай Жое Буртон тохиролцлоо.

Дараа нь Пар өөрийн улаан цүнхийг Роузенд хадгалуулжээ.

Яг тэр үед Citibank-ны мөрдөгч Валлас, Салинасын Цагдаагийн эрүүгийн ажилтан Портер нар автобуснаас бууж гэртээ ирсэн Парын ээжээс мэдүүлэг авч байв. Түүний хүүхэд зургаан сарын өмнө гэрээсээ явахдаа 2000 долларын телефон утасны төлбөр үлдээгээд явсан гэж хэлжээ. Тэр биллийг төлж чадаагүй байв. Гэр оронд нь нэгжлэг хийж болох уу гэж тэд асуув. Хэрэв эсэргүүцвэл түүнд юу тохиолдох бол гэж ээж нь санаа зовж байв. Түүний ажлын газарт мэдэгдэж ажлаас нь халуулах болов уу? Хуулийн байгууллагын ажилтнуудтай харьцах туршлага байхгүй жирийн эмэгтэй нэгжлэг хийхийг зөвшөөрчээ. Мөрдөгчид Парийн диск болон цааснуудыг авч явлаа.

12-р сарын 12-ны үдээс хойш Салинасын Цагдаагийн газарт Пар өөрөө очив. Түүнээс гарын хээ авч, фото зургийг авахдаа 502 (с) (1) РС гэсэн жижигхэн шар цаас бариулжээ. Пард тулгаж байгаа ял доод тал нь гурван жилийн хорих ялтай байв. Нэгдүгээрт Citicorp-ийн

Кредит үйлчилгээг хакердсан гэмт үйлдэл хийсэн. Ялаас гадна 10,000 долларын торгуультай. Хоёрдугаарт “телефон утасны үйлчилгээг залилж хохирол учруулсан”-д ял онооно, торгууль байхгүй гэжээ.

Пар маш залуухан байсанд Холбооны мөрдөгчид их гайхжээ. Холбооны шүүхийн системд өсвөр насны хүний хэргийг авч хэлэлцэхээс төвөгшөөдөг учир хэрэгтмөрдөн байцаалт явуулах талаар мужийн эрх мэдэлтнүүдээс мөрдөгчид тодруулав. 1989 оны 7-р сарын 10-нд Монтерей бүсийн Насанд хүрээгүй хүний шүүх хурал дээр Парын хэргийг таслахаар болжээ.

Дараагийн хэдэн сард Пар Роузентай ойр ажиллав. Роузен маш их туршлагатай хуульч хэдий ч нөхцөл байдал маш ээдрээтэй байлаа. Citibank төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангахад 30,000 доллар зарцуулсан гэж мэдэгдсэнээс гадна тус корпорац гурван сая долларын хохирлыг нэхэмжилнэ гэж Пар бодож байв. Картнаас Пар өөрөө мөнгө авсан гэдгийг нотлож чадахгүйгээс хойш түүний өглөгч байдал санхүүгийн хохирол ихээр учруулсан гэж мөрдөгчид маргах болно.

“TRW”-ийн компьютер руу Пар нууцаар зочилсон явдал хамгийн сэтгэл зовоосон асуудал болов. “TRW” компаний материалтай нэг дискийг Нууц Алба хурааж авчээ.

Өргөн цар хүрээг хамарсан үйл ажиллагаа явуулдаг TRW компани нь 2,1 тэрбум долларын хөрөнгөтэй, худалдааны орлого нь 1989 онд 7 тэрбум байлаа. Үүний бараг тэн хагас нь АНУ-ын засгийн газраас ирдэг байв. Энэ компаний 73,000 гаруй ажилтнуудын ихэнх нь компаний санхүүгийн бизнест хүч үздэг. TRW компаний мэдээллийн санд олон сая хүний хаяг, утасны дугаар, санхүүгийн бичиг баримт хадгалагдана.

Энэ бол компаний олон бизнесүүдийн зөвхөн нэг нь байлаа. TRW нь Батлан хамгаалах чиглэлийн тэр дундаа маш нууц ангилалын ажлыг гардан хийнэ. Калифорни дахь Редондо Бийчийн Сансар ба Батлан хамгаалахын хэлтэс нь Рейганий Засгийн газрын Оддын дайны төсвийн ихэнх хэсгийг зарцуулдаг байсан юм. Компаний нийт ажилтнуудын арваас илүү хувь нь энэ хэлтэст ажиллаж, сансрын хөлөг, холбоо мэдээллийн төхөөрөмж, хиймэл дагуул бусад тодорхой бус тоноглолыг үйлдвэрлэдэг байв.

Хурааж авсан дискэнд компаний TRWMAIL төхөөрөмжөөс авсан шуудангуудыг хадгалсан байж. Ерөнхийдөө нууцын ангилалд хамаарахгүй боловч компаний зүгээс ажилтнууддаа суртал ухуулга болгон явуулсан мэдээлэл голдуу байлаа. Мэдээж Нууц Албаныхан тэнд утаа байгаа бол гал байх ёстой гэсэн зарчмаар ажиллах нь гарцаагүй. Системд нь хууль бусаар, нууцаар нэвтэрсэн гэж сонсвол засгийн газар нилээд тавгүйцэх томоохон ажлуудыг TRW хийдэг юм. Гэтэл Пар TRW-ийн тодорхой тооны компьютерүүдэд зочилсон төдийгүй тус компани пуужингийн судалгаа шинжилгээний болон сансрын зэвсгийн хэсэгтэйг мэдээд амжсан байдаг. Citibank, Нууц Алба, Орон нутгийн цагдаагийн байгууллага, бүр өөрийнх нь төрсөн эх хүртэл эсрэг талд ажиллаж байхад хакердах явцдаа олж мэдсэн мэдээллийг ил болгох нь зөвхөн цаг хугацааны л асуудал болжээ. Шүүх хурал хүртэл хүлээгээд байж байх нь сайхан санаа гэж үү хэмээн Пар бодох болов.

1989 оны эхээр Швейцараас Сан Франциско хүртэл ниссэн онгоцноос Теорем буув. Тэр хэлсэн амандаа хүрсэндээ маш их баярлаж байлаа. Энэ бол тийм амархан гүйцэлдүүлчих

амлалт биш байсан юм. Дэлхийн хоёр захад байрлах тэдний дуу хоолойны хооронд ойр дотно, янаг халуун, төгс төгөлдөр холбоо байсан цаг саяхан санагдана.

Пар хүндхэн байдалд хөрвөх зуур Теорем гутаасан, доромжлох маягаар өөрийгөө тодорхойлсон гэдэг. Алтос дээр уулздаг бусад хакераас түүнийг онцгүй хүүхэн гэж Пар сонсжээ. Харин тодорхойлолтыг Теорем өөрөө өгсөн тул юу ч хэлэх билээ.

Эцэстээ зорчигчдын урсгал хүлээлгийн танхимд орж ирэнгүүт, одоо өнгөрсөөн, яах ч аргагүй гэж Пар өөртөө хэлэв. Тэрээр Теоремийг махан биеэрээ байгаагаар нь бус компьютерийн ертөнцөд байгаагаар нь л дурласан. Дурласнаа ч түүнд илэрхийлсэн. Тэр ч бас адил хариуг илгээсэн билээ.

Гэнэт Теорем түүний өмнө гарч ирэв. Тэр эмэгтэй нэг инчээр өндөр тул түүний нүд рүү Пар аажуухан эгцлэн харах хэрэгтэй болжээ. Бор нүдтэй, мөрөө шүргэсэн урт, шулуун үстэй, Теорем үнэхээр үзэсгэлэнтэй ажээ. Түүний бодож байснаас хамаагүй илүү царайлаг хүүхэн байлаа.

Теорем инээмсэглэн зогсоно.

Пар бараг гуйвах шахав. Энэ бол үнэхээр сэтгэл татам, том, дулаахан, чин сэтгэлийн инээмсэглэл байлаа. Түүний царай гэрэлтэх мэт харагдана. Харин инээмсэглэл нь улам чимжээ.

Эмэгтэй хэлсэн үгэндээ хүрсэн. Партай уулзахаас өмнө түүний тухай ямар ч төсөөлөл байгаагүй юм. Жилийн өмнө Алтос дээр харилцагч хакеруудын уулзалт Мюнхен хотод болсон. Түүнээс хойш онлайн дээрх хувь хүний шинжээр нь хүмүүсийг төсөөлөхгүй байхыг Теорем хичээх болжээ. Тиймээс эмэгтэй хэзээ ч сэтгэлээр унах байдалд орохгүй гэдэгтээ итгэлтэй байв.

Пар Теоремын цүнхийг аваад Брайны машинд суулаа. Теоремыг маш сайхан хүүхэн гэж бодсон Брайн нисэх онгоцны буудлын таксины жолоочийн дүрд тоглохоор шийджээ. Тэгээд ч Пар машингүй байв. Францаар ярьдаг зургаан тохой өндөр Швейцарь бүсгүй. Маш сайхан байлаа. Тэд Парын гэрийг зорьжээ. Төд удалгүй Брайн ярианд орж эхлэв.

Брайн түүнээс олон янзын асуулт асуужээ. Тэр Европ хүнтэй тааралдаж байгаагүй учир үнэхээр сониуч зан гаргаж байв. Өөрийнхөө найзыг хурдхан явуулахыг Пар хүссэн боловч Брайн Швейцарийн тухай улам ихийг мэдэхийг хичээнэ. Цаг агаар ямар байдаг вэ? Хүмүүс дандаа цанаар гулгадаг уу?

Пар Брайны нүд рүү харж байгаад хаалга руу заав.

Ихэнх Швейцарьчууд Англиар ярьдаг уу? Тэр өөр ямар хэл мэдэх вэ? Калифорниад олон хүн цанаар гулгадаг. Дэлхийн нөгөө хагасаас ирсэн хүнтэй ярилцах сайхан байлаа.

Пар эрүүгээрээ хаалга руу дохих мөчид л Брайн ойлгов. Пар өөрийнхөө найзыг гэрээсээ үтэр түргэн явууллаа. Брайн тэнд зөвхөн арван минут зогссон боловч бараг жил болсон мэт

санагдана. Пар, Теорем хоёр бага зэрэг ярилцаж суугаад гадагш салхилахаар шийджээ.

Гудамж дагуу алхаж явахдаа Пар түүний гарыг атгалаа. Түүнд таалагдаж байх шиг байна. Түүний гар дулаахан байв. Хэсэг алхаж байснаа зогсож, утсаар ярьж байснаа давтах мөчид Теорем түүнийг үнслээ. Пар гэнэтийн үйлдэлд цочирджээ. Тэр үүнд бэлэн байгаагүй юм. Дараа нь Теорем түүний хэлснийг давтан хэлэв.

Тэд хоёр долоо хоног хагасын хугацааг хамтдаа өнгөрөөж, онлайн дээр байхаас илүү таашаалыг эдэлжээ. Тэд өдөр шөнийг үл огоорон бүхнийг хамж ярилцана.

Удалгүй Теорем төрөлх Швейцарьтаа буцаж ажилдаа орох цаг нь болов. Түүнийг онгоцны буудал хүргэж, онгоцонд суухыг харах Парт хэцүү байлаа. Теорем сэтгэлээр унасан харагдана. Онгоц нисэх хүртэл Пар нулимсаа барьж ядсан ажээ. Шүүх хурлын тухай хоёр долоо хоногийн туршид ор тас мартсан Парыг хүнд дарамт бүчин авав.

Хүнээс гуйн хэрэглэж байгаа компьютер дээр бүхэл шөнийн турш Пар сууж байлаа. Компьютерийн дэлгэцний бүдэгхэн гэрэл харанхуй өрөөг гэрэлтүүлэх агаад аквариумын загаснууд түүнийг ширтэж байх шиг санагдана. Онлайн дээр чимээгүй болонгуут Парын анхаарал могой болон арслан загас руу шилжинэ. Магадгүй тэд компьютерийн өнгөлөг дэлгэц рүү татагддаг байх. Пар тамхиа хэд дахин сайн сороод, загасаа харна. Дараа нь лаазтай ундаагаа уугаад дахин компьютерээ шагайна.

Тэр шөнө Пар харах ёсгүй зүйлээ харсан юм. Энэ бол хакерт байнга тохиолддог зүйл биш аж. Их сургууль дотор ч ийм зүйлийг сонсохгүй. Ойрхи Дорнодын шейхын санхүүгийн мэдээллийг агуулах олон улсын банкинд ч ийм зүйлийг харахгүй юм.

Түүний харсан мэдээлэл нь ямар нэгэн тагнуулын алуурчин сансрын хиймэл дагуултай холбоотой байв. Тэрхүү хиймэл дагуул нь тагнаж байгаа хиймэл дагуулыг буудан устгах хүчин чадалтай бөгөөд TRW-ийн Сансар ба Батлан хамгаалах хэлтсийн сүлжээнд холбогдсон компьютерээс олж харжээ. Форс скан хийж байхдаа CitiSaudi-гийн компьютер руу санамсаргүй орсон шиг тэр тохиолдлоор TRW-ийн компьютерт нэвтэрсэн байна. Олж мэдсэн мэдээлэл түүнийг их айлгасан учир Пар хэнд ч хэлээгүй юм.

Гэнэт тэрээр маш их зүйлийг мэддэг юм шиг санагдав. Тэр олон цэрэг дайны систем, нилээд нууц материалд орж гарч үзсэн учраас бүх л зүйлд хайхрамжгүй ханддаг болжээ. Материалыг уншихад үнэхээр сонирхолтой байв. Олж мэдсэн зүйлээ юунд ч ашиглахыг хүсэж байгаагүй гэдгийг бурхан мэдэх байх. Нууцыг мэднэ гэдэг бол хакерын ур чадварыг батлан харуулсан олз, түүнд хүртээсэн бэлэг юм. Харин энэ нээлт түүнийг бага зэрэг сандаргаж, нүүр рүү нь алгадаад авсан мэт санагдаж байв.

Хэрэв Нууц Алба энэ тухай мэдвэл яах бол? Түүнд “502C” гэсэн бичигтэй бас нэгэн замын хуудас өгөх болов уу? Үгүй л байхаа даа. Түүний мэдэж байгаа болгоныг шүүх хурал дээр шүүгч нарт хүргэх боломж олгох уу? Тэгээд сонинд тэрхүү мэдээлэл нийтлэгдэхийг зөвшөөрөх үү? Тамд л тийм боломж олдох байх.

Энэ бол батлан хамгаалахад асар их мөнгө төсөвлөж, ЗХУ мэтийн хорон санаат эзэнт гүрэн

асар том тулааны талбар дээр ганцаар байгаа мэт үздэг сэтгэцийн эмгэгтэй цэргийн командлагчуудтай, Сансрын хамгаалалтыг санаачилсан Рональд Рейган, Жорж Буш нарын эрин үе байсан юм.

АНУ-ын засгийн газар түүнийг шоронд хийж түгжээд түлхүүрийг нь ус руу шидчих болов уу? Эсвэл бусад хоригдлууд дунд оруулж, мэдээллийг яаж доллар болгохыг мэддэг гэмт хэрэгнүүдэд мэдэх бүхнээ ярих эрсдлийг хүсэх үү? Мэдээж үгүй байх.

Тэнд ганц л сонголт үлдэв. Устгах.

Таатай бодол л лав биш. Харин арван долоон настай хакерын хувьд энэ бол том асуудал байв. Цорын ганц шийдэлтэй харагдах нөхцөл байдалд тэр юу хийж чадах вэ гэж Пар гүнээ эргэцүүлнэ.

Зугатах...

Дөрөвдүгээр бүлэг

Оргодол

Тэнд ганц буу байна. Магадгүй олон буугаар эсвэл өөр хүмүүс манай арын хаалга руу шагайж байгаа байх.

Салинасын Монтерей бүсийн Өсвөр насны иргэдийн шүүх хуралд 1989 оны 7-р сарын 10-нд очих ёстой байсан Пар зугатаажээ. Түүнийг албан ёсоор оргодолд тооцов. Бараг хэдэн долоо хоногийн өмнө түүний оргох ажиллагаа эхэлсэн байлаа. Түүний хуульч болоод өөр хэн ч энэ тухай мэдээгүй юм.

Шүүх хурал болохоос арав хоногийн өмнө Пар уулзалтанд хүрч ирээгүйг Ричард Роузен гайхсан боловч түүний үйлчлүүлэгч буруу үйлдэл хийхгүй гэдэгт итгэлтэй байв. Нууц Албатай бүрэн хамтран ажиллахгүй бол арван таван өдөр насанд хүрээгүйчүүдийн шоронд хоригдоно, нэмээд нөхөн төлбөр төлнө гэсэн тохиролцоог Роузен хуульч Парын өмнөөс хийжээ.

Гэмт хэрэгт холбогдсоноос хойш хэдэн долоо хоногийн турш Пар шаналав. Бусдын компьютер руу нууцаар хэрхэн нэвтэрсэн талаар мөрдөгчдөд ярьж өгөхөөс татгалзаагүй боловч энэ бол тэдний хүсэн хүлээж байсан зүйл биш байв. Түүнийг өөрийн хүрээнийхнээс урвахыг тэд хүсжээ. Бүр хүн бүрийн тухай ярьж өгөхийг хүснэ. Групп дотроо Парыг нөлөө бүхий хүнд тооцогддог гэдгийг тэд мэдэх учир далд ертөнцийн гишүүдийг сайн мэднэ гэж үзсэн байна. Яг хэрэгтэй хүнээ олжээ. Пар өөрийгөө хар тамхитай тэмцэх албаныханд шилжүүлэхийг хүсэхгүй байв. Тэр бүх үнэнийг тоочсон ч эрх мэдэлтнүүд түүнийг шоронд байхад юу хийх вэ гэсэн асуулт хонх цохино. Түүнийг устгана гэсэн бодол ухаан санаанаас нь салахгүй байлаа.

Ингээд нэг өдөр Пар зүгээр л усанд шидсэн чулуу шиг алга болсон юм. Тэр болгоомжтой төлөвлөж, өөрийн өрөө хам мэтийн хүмүүст мэдэгдэхгүйгээр найдвартай хүнтэй холбогдон, авч явах зүйлээ бэлджээ. Түүний өрөө хамууд байхгүй хооронд найз нь Парыг авахаар ирэв. Одоо арван найман нас хүрсэн Пар маш урт хугацаагаар алга болно гэж өрөөний нөхөд нь огт төсөөлөөгүй байна.

Эхлээд тэр Сан Диего руу явав. Дараа нь Лос-Анжелос. Тэгээд Нью Жерсей рүү... түүнээс хойш түүний бараа сураг тасарсан юм.

Байнга зугатаж амьдарна гэдэг хэцүү байлаа. Эхний хэдэн саруудад Пар хамгийн үнэтэй хоёр зүйлээ биедээ авч явжээ. Нэг нь хямдхан лаптоп компьютер, нөгөө нь Теоремийг ирэх үед авсан гэрэл зургууд. Эдгээр зүйлс түүний амьдралын шугам байсан бөгөөд нэг хотоос нөгөө рүү хэсүүчлэхдээ биедээ байнга авч явна. Тэр далд ертөнцийн найзуудтайгаа холбоотой хэвээр байв. Хакеруудын сулхан сүлжсэн сүлжээ Өмнөдөөс хойд зүгийн мужууд руу оргон зугатах боолуудын хэрэглэдэг арван наймдугаар зууны Америкийн “газар доорх төмөр зам”-тай бараг адилхан байсан гэж хэлж болно. Түүнээс өөр аюулгүй хоргодох газар Парт үгүй ажээ.

Пар тивийг хөндлөн туулж, байнгын нүүдэл хийсээр. Нэг газарт нэг долоо хоног. Нөгөөд нь хэдэн шөнө... Заримдаа электроникийн нууц төмөр замаар аялж бяцхан завсарлага авна. Энэ аялалыг нэг шугам төгсөж нөгөө нь эхэлдэг орон зайд хийдэг учир нилээд хүндрэлтэй байлаа. Өөрөөр хэлбэл зарим үед хүйтэнд, ил хээр газар хоноглож, хоол хүнсгүй, хэнтэй ч ярихгүйгээр өнгөрөөнө гэсэн үг.

Тэр бусдад харагдахгүй учраас хакердах ажиллагаагаа үргэлжлүүлсээр байлаа. Хууль хамгаалах байгууллагынхан юу хийж чадах юм бэ? Хүрч ирээд түүнийг баривчлах уу? Тэр аль хэдийнээс хойш оргодол болсон. Одоогоор хэдхэн сарын хугацаанд оргон зугатаж байгаа Пар үүрд ийм байдалд байх юм шиг бодож байлаа.

Тэрээр хакеруудтай холбогдож байхдаа болгоомжтой байхыг хичээнэ. Гэхдээ гадаад ертөнцөөс тасарч, мотелийн өрөөнд ганцаар байхдаа айх аюулгүйгээр хакердсаар байв. Нууц Албаныхан түүнийг хайж байгааг тэр мэднэ. Түүнийг хайж байгаа хүмүүст зориулж дуут шуудан үлдээнэ. Уг шууданд: “Тиймээ энэ бол Пар байна. Байнга утас цохиж, харилцуураа өлгөхөөс залхсан Нууц Албаны бүх гахайнуудад амжилт хүсье. Яагаад гэвэл та нар тэнэг. Хөгжилтэй ч биш. Хэрэв та нар миний баасыг Apple-ийн компьютер руу илгээж анализ хийх гэж байгаа бол тэнэг, өрөвдөлтэй хэрэг. Надад фреакинг хийхэд зориулсан төхөөрөмж байгаа гэж та нар бодоо юу. Фреакингийн төхөөрөмж гэж төсөөлөхийг чинь бодоод миний инээд хүрч байна. Та нар тийм доожоогүй. Аан тийм. Надад мессэж үлдээхийг хүсвэл үлдээгээрэй. Хүн бүр тайван байж, надад хогоо үлдээнэ биз. За ингээд баяртай.”

Сэтгэцийн тавгүй байдлын илрэл болох дэмийрэл Парыг бүрэн эзэмджээ. Хэрэв тэр замын нөгөө талд цагдаа харвал зүрх нь хурдан цохилж, гэнэт эргээд эсрэг зүгт алхана. Хэрэв цагдаа түүнийг чиглэн алхвал Пар гудамж хөндлөн гараад ойролцоох гудамж руу эргэн алхана. Ямарч цагдааг харсан Парын сэтгэл тавгүй болж байв.

1989 оны намар Хойд Каролинагийн жижиг хотод Пар иржээ. Тэрээр гэр бүлээрээ motel ажиллуулж амьдрах, онлайн дээр Nibbler нэрээр ордог найзындаа түр амсхийв. (Nibbler-хазагч гэсэн утгатай-орч) Хоёр долоо хоногийн турш нэг газар, нэг орон дээр унтах нь диваажинд байгаа мэт санагдаж байв. Түүнээс гадна өрөөний хөлс төлөхгүй учраас Теоремоос мөнгө зээлэх шаардлага байсангүй. Пар тухайн өдөр ямар өрөө таарна түүнд унтах боловч ихэнх цагаа Нибблерийн “компьютерийн өрөө” болгон хэрэглэдэг мотелийн нэг өрөөнд өнгөрөөдөг байв. Тэд Нибблерийн компьютерээс хакердаж өдрийг өнгөрөөнө. Хойд Каролинад ирэхээс өмнө хямдхан лаптопоо зарах шаардлага оргодолд гарчээ.

Motelд хэдэн долоо хоног өнгөрөөсөн ч түүнийг хайж байгаа гэсэн мэдрэмжээ хаяж чадахгүй байв. Тэнд маш олон хүн ирж, явна. Машин дотор суух motelын зочид түүнийг нууцаар ажиглаж байх шиг санагдах тул сүүдэр бараадан алхдаг байлаа. Магадгүй Нууц Албаныхан түүнийг олно гэдэгт тэр эргэлздэггүй байсан биз.

Хакердах ажиллагааг улам боловсронгуй болгох талаар Пар бодож байв.

Атлантагийн гурван хакерын нэг Профет хакерын тухай мэдээлэл солилцохоор Нибблер руу утасдана. Ялангуяа Unix системийн аюулгүй байдлын цохны талаар тэр их сонирхож байлаа. Нэгэн удаа утасны компанид харьяалагддаг сүлжээн дээр туршилт хийж байгаад аюулгүй

байдлын шинэ алдааг олсноо Парт Профет хэлэв. The Legion of Doom бүлгийн Жеоржиа мужид орших жигүүрийн гурван хакерууд буюу Атлантагийн гурав АНУ-ын зүүн өмнөд хэсгийг хамран үйл ажиллагаа явуулдаг утасны BellSouth компаний сүлжээгээр хангалттай хэсүүлчилсэн ажээ. Tumnet-ийн тухай Пар сайн мэддэг байсан шиг тэр гурав телефон утасны свитч станцуудыг сайн мэддэг байв. Нууц Албаныхан 1989 оны 7-р сард хакеруудыг илрүүлсэн боловч 9-р сар гэхэд өөрийн дуртай объектоо Профет үргэлжлүүлэн хакердсаар байлаа.

“BellSouth”-ийн сүлжээний цоорхой нилээд дажгүй санагдсан учир Пар тус компаний сүлжээгээр ёстой нэг тоглох шиг болж байв. Компаний компьютерийн сүлжээ рүү холбогдон, галзуу мэт хайлт хийж байгаад гарна. Хакерын хийдэг л үйлдэл.

Пар мотелын телефон утасны бичлэгийг шалгах боломж гарсан учраас ямар нэгэн сэжигтэй үйлдэл байгаа эсэхийг нягтлав. Тэр мотелын утасны дугаарыг шивэнгүүт компаний системээс мотелын хаяг, нэр, утасны дугаарт залгасан кабель зэрэг зарим техникийн холбоотой мэдээллийг харуулна. Дараа нь тэр компьютерийн хэсгийн утасны шугамыг нягтлан харав. Шугам нэг л өвөрмөц харагджээ.

Нибблер тэр хоёрын хакердах ихэнх ажиллагаагаа явуулдаг шугам дээр тусгай статус буюу “шугам дээр засварын нэгж ажиллаж байна” гэсэн бичгийг харуулав

Ямар засварын нэгж? Мотелийн утасны шугамд ямар нэгэн эвдрэл гарлаа гэж Нибблер ярьж байгаагүй боловч Пар түүнээс дахин лавлав. Утаснуудад ямар ч эвдрэл гэмтэл алга.

Пар сэтгэл түгшиж эхлэв. Утасны компаний сүлжээгээр тоглож байхдаа тэрээр Оросын компьютерийн сүлжээг хакердсан. Зөвлөлтийн сүлжээ цоо шинэ гялалзсан тоглоом шиг байлаа. Дэлхийн бусад глобал пакет свитчтэй сүлжээ рүү холбогдоод сар гаруйн хугацаа өнгөрснөөс үзвэл маш онгон зэрлэг газар нутаг гэлтэй.

Нибблер өөрийн найзыг дуудаж, мотелийн утаснуудыг шалгуулав. Бие даан ажиллах болсон Нибблерын найз телефон утасны компанид техникч хийж байжээ. Тэр залуу мотелд ирж төхөөрөмжийг үзээд ямар нэгэн хачиралтай зүйл утасны системд тохиолдож байгааг Ниббллер, Пар хоёрт хэлэв. Шугамын вольтгүй болжээ.

Пар юу болж байгааг шууд ойлгов. Системийг хянаж байжээ. Орж, гарч байгаа бүх шугамыг чагнаж байх магадлалтай. Утасны компани, орон нутгийн цагдаа, ХМТ, Нууц Албаны аль нэг нь түүнийг мөрдөж байна гэсэн ганц дүгнэлт хийхэд хүргэв.

Нибблер, Пар хоёр бүх компьютер, дагалдах хэрэгслийг хурдхан баглаж аваад хотын нөгөө хэсэгт ойрхон орших мотел руу хөдөлжээ. Тэд хакердах ажиллагаа хийсэн бүх мөрөө далдалж, нуух хэрэгтэй болов. Пар сүлжээнд оронгуутаа хүмүүсийн пассворд ба login хийсэн нэрсийг олзолдог програмыг ажиллуулж орхиод, олсон бүх мэдээллээ хакердсан компьютер дээр файл болгон хадгалж байв. Тэр файлийг Пар өдөр бүр шалгана. Хэрэв тэр програмыг унтраалгүй орхисон бол лог файлын хэмжээ маш их болж, системийн администраторын анхаарлыг татна. Өөрийн системийг хакердуулснаа мэдэх юм бол аюулгүй байдлын цоорхойг даруй хаах арга хэмжээ авчихна. Харин тэр системд дахин нэвтрэн ороход Парт хүндрэлтэй

байх юм.

Хакердсан компьютерээ цэвэрлэж дуусаад Парын бичсэн бүх тэмдэглэл ба Нибблерын компьютерийн төхөөрөмжийг дахин цуглуулж, түрээсэлсэн агуулахад хадгалав. Дараа нь тэд мотелдоо буцаж ирлээ.

Пар тэндээс шууд явчихаж чадахгүй байв. Магадгүй зөвхөн телефон утасны компани л мотелийн утасны системийг сонирхсон байж болно. Пар мотелийн телефон утаснаас Харилцаа холбооны компаниудын компьютерийн системүүд рүү маш их хайлт хийж, хэсүүчилсэн. Гэхдээ тэр үүнийг ямар нэгэн нэрийн дор хийгээгүй. Магадгүй “BellSouth” компани бага зэрэг сонирхож, илүү мэдээлэл олохоор снифф хийсэн байж болно. (sniff-үнэрлэх гэсэн утгатай үг, хувьд нууцаар мэдээлэл олж авах төрлийн компьютерийн програмыг ингэж нэрлэдэг-орч) Хэрэв тийм бол мотелд Пар гэдэг оргодол нуугдаж байгааг хууль хамгаалах байгууллагууд мэдээгүй байж таарна.

Мотелд өдөр өнгөрөөх нь дарамттай санагдаж эхлэв. Ирж, явах хүмүүсийг Пар нилээд ажиглах боллоо. Тэрээр үүд рүү харсан цонхоор байнга шагайж, хонгилоор явж байгаа хүмүүсийн хөлийн чимээг амьсгаа даран сонсох ажээ. Мотелд ирсэн зочдын яг хэд нь жинхэнэ жуулчид вэ? Пар зочдын нэрсийг үзэж байгаад Нью Жерсейгээс ирсэн эрэгтэйг олжээ. Тэр хүн Bell Systems компани хуваагдсаны дараа бий болсон AT&T корпорацийн нэг салбараас ирсэн аж. AT&T-ийн ажилтан Хойд Каролинагийн жижигхэн хотод юу хийж явдаг байна аа? Магадгүй Нууц Албаны хэдэн ажилтнууд мотел руу чимээгүйхэн нэвтэрч, байрыг ажиглаж байгаа байх.

Пар дэмийрсэн хийсвэр бодлоо хянах хэрэгтэй байв. Түүнд цэвэр агаар шаардлагатай болсон учир салхинд алхахаар гарлаа. Цаг агаар муухай, салхи хүчтэй салхилж намрын навчсыг хөөрөгдөнө. Удалгүй бороо орж, Пар гудамжны эсрэг талд байрлах төлбөртэй утасны бүхээгт нөмөр хайн зогсов.

Хэдэн сарын турш зугатааж явааг эс тооцвол Пар Теорем руу өдөр бүр утасдана. Ихэвчлэн харилцаа холбооны компаниудын шугамаар фреактинг хийн утасдах аргыг хэрэглэнэ. Энэ удаад мотелын PABX зангилааны хүчдэл байхгүй болсон, утсыг чагнаж байж магадгүй тухай түүнд хэлжээ. Түүний хэрхэн амьдарч байгааг Теорем асуусны дараа уулзах мөчид хэрхэхээ хоёр залуус ярилцана.

Утасны бүхээгний гадна цаг агаарын байдал ширүүслээ. Бүхээгний нэг талаас бороо хүчтэй шавшиж, үе үе хүчтэй салхи үлээнэ. Харанхуй гудамж эзгүйрэн үлдэв. Хүчтэй салхины улмаас модны мөчир хугарах нь энд тэнд сонстоно. Борооны усны урсгал, салхины эсрэг талын хананы шил даган урсаж, хогоор дүүрсэн сав салхинд хамагдан унаж, зам дагуу хог хийсэнэ.

Ойр орчинд нь болж байгаа байгалийн гамшигт үзэгдлийг эс тоох Пар Калифорниад өнгөрөөсөн өдрүүдээ дурсан ярьж, сэтгэлээ онгойлгож байв.

Модны мөчир салхинд хүчтэй найган ганхаж байснаа тас няс хийн хугарав. Утасны бүхээгний ойролцоо өнөөх мөчир унахад юун дуу гарч байгааг Теорем түүнээс асуулаа.

“Хүчтэй шуурга ирж байна. Хар шуурга Хьюго. Өнөө шөнө энд ирэх ёстой байсан юм. Одоо эхэлж байх шиг байна” хэмээн Пар түүнд хэлэв.

Үүнийг сонссон Теорем Парыг буудал руугаа хурдан очиж, хоргодохыг шаарджээ. Утасны бүхээгний хаалгыг нээхэд борооны ус түүнийг шалба норголоо. Пар зам хөндлөн гарч, хар шуурганы салхитай хүчээ үзсээр буудалд орж, халуун орондоо шургав. Шуурганы дуу чимээг сонсох зуураа нам унтсан залуу Теоремийг зүүдэлж эхэллээ.

Хар салхи Хьюго гурван өдөр үргэлжлэв. Энэ гурван өдөр долоо хоногийн хамгийн аюулгүй гурван өдөр байлаа. Хар шуурганы үеэр Нууц Алба дайралт хийхгүйгэдэгт мөрийцөхөд ч болох байв. Өмнөд Каролина хар шуурганд өртөж, Хойд Каролинад их хэмжээний эвдрэл гэмтэл учирчээ. Ойрын хэдэн арван жил тохиолдоогүй хар шуурга энэ байлаа. Салхи оргил үедээ цагт 240 км цагийн хурд хүрж, Баруун эргээс Каролина хүрэх замд 7 тэрбум долларын хохирол учруулж, 60 хүний амь насыг авч оджээ.

Шуурганаас хойш хэдэн өдрийн дараа мотелоос гадагш гарахад агаар цэвэрхэн, сайхан байв. Тэрээр мотелоос холдоод ойр орчноо ажиглаж байтал машины зогсоол дээр бужигнаан болжээ. Тэнд машинуудаас гадна хөндлөнгийн сонирхогчид зогсоно.

Мөн тэнд Нууц Албаныхан байлаа.

Хөх өнгийн цамцан дээр Нууц Алба гэсэн бичигтэй найман ажилтан тэнд байна. Пар зог тусан хөшиж орхив. Бүх зүйлс удаан хөдөлгөөнөөр хөдөлж эхлэв. Партай адилхан харагдах мотелын засварчин Жоныг хэдэн тусгай ажилтнууд тойрон зогсчээ. Тэд Жоныг шороон дээр чирээд, биед нь үзлэг хийж байх шиг санагдав. Дараа нь тэд микро автобус руу хамгаалан аваачихыг бодвол гарын хээг нь тулгаж үзэх гэж байгаа бололтой.

Пар дахиад л гүн бодолд дарагдав. Тэр тайвширч байгаад сайн бодох хэрэгтэй байлаа. Эндээс мултрах ямар арга байна вэ? Тэр өөрийн өрөө рүү орох ёстой. Дараа нь юу хийхээ бодож байх зуур гадаад байдлаа өөрчлөх хэрэгтэй. Түүний санаанд Теоремийн зураг гялсхийн орж ирэв. Нууц Албанд түүний зургийг хэрхэвч үлдээж болохгүй. Зургаа аваад хурдхан шиг арилах хэрэгтэй.

Компьютерийн өрөөг Нууц Албаныхан нэгжиж байгааг тэр харж байлаа. Аз болоход Нибблер тэр хоёр бүх тоног төхөөрөмжөө зөөсөн учраас гэмт хэрэгт холбогдуулах ямар ч нотлох баримт үлдээгүй билээ. Пар амьсгаагаа авч жаахан тайвшраад өөрийнхөө өрөө рүү ухрав. Гэнэтийн хөдөлгөөн бусдын анхаарлыг татах учраас өрөө рүүгээ яарахыг урьтал болгосонгүй.

Парыг хөдөлж эхлэнгүүт Нууц Албаны нэг ажилтан эргэж харав. Тэрээр хоёр давхар мотелийн зүг ширтэж байснаа харцаа Пар дээр тусгалаа. Пар түүний нүд рүү нь хөдлөлгүй ширтэнэ.

“Одоо өнгөрлөө. Би баригдчихлаа. Эндээс гарах зам байхгүй. Хэдэн сар зугатаачихаад Хойд Каролинагийн жижигхэн хотод баригдлаа гэж үү. Тэдгээр залуус намайг хол аваачих болно. Би дахиад гэрэл хэзээ ч харахгүй. Түүнийг устгах ганцхан л сонголт байгаа”

хэмээн Пар боджээ. Эдгээр бодол түүний оюун санаанд эргэлдэж байх зуур түүний хөл цементэн шаланд наалдсан мэт хөшиж, тусгай албаны ажилтны хянуур харцтай тулгарав. Хорвоо ертөнц дээр тэр хоёр л оршиж байгаа мэт сэтгэгдэл төрөх ажээ.

Гэтэл тусгай ажилтан аар тийшээ харцаа шилжүүлэв. Тэрээр нөгөө ажилтантай яриагаа төгсгөхөөр бүтэн биеэрээ эргэлээ. Оргодлыг хэзээ ч харж байгаагүй мэт байлаа.

Пар хөдлөхгүй зогссоор... Ийм байж таарахгүй... Пар мотелын өрөө рүү алхаж эхлэв. Мотелын босго давангуут хаалгаа аажуухан хаалаа.

Теоремийн зургийн тухай бодолд эргэн автахын хажуугаар өрөөнд нуугдах газар хайв. Аятайхан газар харагдсангүй. Нүдний төвшнөөс дээш ямар нэгэн газарт нуугдах нь хамгийн зөв сонголт байлаа. Тэр сандал татаж өрөөний голд тавиад тааз руу түлхэж үзэв. Тэгш өнцөгт хавтан амархан өргөгдөж, Пар хөндий зайнд фото зургуудаа шургуулаад хавтанг байранд нь тавилаа. Хэрэв тусгай албаны ажилтнууд өрөөнд нэгжлэг хийвэл зургийг олох боломжтой. Гэхдээ тухайн үед хамгийн сайн газар нуусан гэж тэр боджээ.

Дараа нь тэр оргох асуудалд анхаарлаа хандуулав. Орон нутгийнхан болж байгаа үйл явдлыг маш ихээр сонирхож байлаа. Нууц Албаныханд өөрийнх нь тухай буудлын ажилтнууд хэлэхгүй байх гэж Пар найдна. Ингэж эргэлзсээр хэсэг хугацаа алдсан Пар бусдын нүдэнд ажиглагдахгүйгээр өрөөнөөс гарах боломжгүй болжээ. Хэрэв тэр байрнаас гарвал түүнийг заавал зогсоож, шалгаана.

Буудлаас гарч явж амжсан ч гэсэн тэр мултрах боломж бага байлаа. Хотод нуугдах газар олдохгүй бөгөөд түүнийг нуучих итгэлтэй хүн байхгүй. Хүн бүр л машинаар явдаг орчинд, нэг залуу буудлаас гараад явган алхана гэдэг маш сэжигтэй санагдах юм. Замын машинд дайгдана гэдэг бүтэхгүй асуудал. Магадгүй түүнийг барихаар ирсэн нэг тусгай албаны ажилтны машинд гар өргөөд зогсож байх биз. Үгүй ээ түүнд илүү үр нөлөөтэй төлөвлөгөө хэрэгтэй байв. Пар тэр мужаас л гарч явах арга хайх хэрэгтэй байлаа.

Ашевилле дэхь сургалтандаа Жон эрт явдгийг Пар мэднэ. Хэрэв хууль хяналтынхан мотелыг хэсэг хугацаанд ажиглаж байгаа бол өглөө эрт 5 цагт явахыг нь жирийн үзэгдэл гэж үзнэ. Тэгээд ч яг тэр цагт харанхуй байдаг учраас нилээд боломжийн санагдана.

Хэрэв Пар Ашевиллегээс аль болох холдож чадвал Шарлотте руу очиж, тэндээс онгоцоор хаа нэг тийшээ нисэж болно.

Пар төлөвлөгөөгөө дахин дахин эргэцүүлж үзэв. Буудалд нуугдана гэдэг хамгийн хэцүү асуудал ажээ. Тэр буудлын өрөөг байнга сольдог учир өөр нэгэн аялагчид зүгээр л жуулчин мэт санагдах байх. Аз болоход Нууц Албаныхан компьютерийн өрөөг нэгжихэд хамаг анхаарлаа чиглүүлж, нотлох баримт олохоор улайрч байсан юм. Эдгээр бодлыг эргэцүүлж байтал гэнэт утас дуугарав. Пар харилцуурыг авах эсэхээ шийдэж ядан гөлрөнө.

Тэр харилцуурыг авав.

“Нибблер байна” гэсэн шивэгнэх дууг сонсоод “За юу болж байна” гэж хариу шивнэлээ. “Пар

Нууц Албаныхан ирчихээд мотелийн нэгжиж байна”

“Би мэдсэн, тэднийг харсан”

“Тэд чиний хажуу талын өрөөг нэгжиж байна” гэж Нибблерыг хэлэхэд Пар золтой л ухаан алдчихсангүй. Нууц ажилтнууд түүнээс бараг 2 метрийн зайтай зогсож байхад тэр огт мэдээгүй сууж байдаг?! Тэр бол Жоны байрлаж байсан өрөө. Энэ өрөө Парын өрөөтэй дотуураа хаалгаар холбоотой. Гэхдээ тэр хаалга хоёр талаасаа цоожлогдсон.

“Жоны өрөөнд ороод орон доогуур орж хэвт. Би явлаа” гээд Нибблер утсаа огцом тавилаа.

Пар чихээ хананд наагаад сонсож байв. Чимээ байдаггүй. Тэр дотуур хаалганы цоожийг эргүүлээд, бөндгөр бариулыг зөөлхөн түлхлээ. Болж байна! Хэн нэгэн хүн нэгжлэг хийж байхдаа нөгөө талын цоожийг тайлсан байна. Пар хаалганы завсраар шагайхад-өрөө чив чимээгүй, хүнгүй байв. Бүх зүйлээ хамж аваад Жоны өрөөнд нүүж орлоо.

Тэр чимээгүйхэн хүлээнэ. Гадна талд болж байгаа үйл явдлын талаар төсөөлөлтэй болж авахын тулд чимээ анир сонсож суулаа. Хаалга цохиод, онгойх бүрт тэр сандарч байв. Хууль хяналтынхан шөнө орой явсны дараа Нибблер гэрийнхээ утсаар түүн рүү ярьж, юу болсныг хэлжээ.

Нэгжлэг хийх зөвшөөрлийн бичгийг Нууц Албаныхан үзүүлэх үед Нибблер компьютерийн өрөөнд сууж байв. Тусгай ажилтнууд нэрс, дугаар, ер нь авч чадах бүхнээ авсан ч нэг ч нотлох баримт олж чадаагүй аж. Эцэст нь компьютерийн ганц диск гартаа барьсан тусгай ажилтан гавьяа байгуулсан мэт өрөөнөөс гарч ирэв. Хамт яваа ажилтнууд дуу алдан баярлаж байхад Нибблер хачин царайлан харж байжээ. Түүний бага дүү нь Logo нэртэй програмаар компьютер графикайн үндсийг судалж байв. Удалгүй АНУ-ын Нууц Алба дунд сургуулийн хүүхдийн нууц зураглал олсноо мэджээ!

Пар доогтой инээв. Түүний түгшүүрийг арилгахад энэхүү инээд бага ч болов тусаллаа. Тэр өөрийн оргох төлөвлөгөөг Нибблерт хэлэхэд тэр зөвшөөрчээ. Түүний эцэг эх нь бүх түүхийг мэдэхгүй боловч Парт туслахыг хүсэв. Дараа нь Нибблер найздаа сайн сайхныг ерөөлөө.

Орголтын өмнө Пар амрахыг хүсэхгүй байлаа. Уралдааны морь зурхайгаас гарах гэж байгаа мэт түүний сэтгэл нь их хөдөлжээ. Мотелийн эргэн тойрныг Нууц Албаныхан ажиглаж байвал яах вэ? Мотелын байранд машины залгаа гараж байхгүй учраас машинд байрны дотроос сууж чадахгүй. Нэг минутын хугацаанд амжиж машинд суулаа ч гэсэн тэр илрэх болно. Түүнд шөнө л боломжийн халхавчаар хангана. Гэхдээ оргох төлөвлөгөө төгс төгөлдөр биш байлаа. Тусгай албаныхан холоос ажиглалт хийж байгаа бол түүнийг өрөөнөөс гарч байгааг харж чадахгүй. Нөгөө талаар бүх байгууламжийг хяналтаа байлгахын тулд өрөө хөлсөлж авсан нууц ажилтанг ашиглаж болно.

Пар шөнөжингөө бодолд дарагдав. Яг 5 цаг болохын өмнө Жоны машин мотелын гадаа ирж зогслоо. Пар өрөөнийхөө гэрлийг анивчуулаад, мотелын гаднахыг ажиглав. Дуу чимээгүй анир орчин, хүйтэн агаар. Буудлын бүх цонх харанхуй байлаа.

Пар өрөөнийхөө хаалгыг онгойлгож, хонгилоор алхав. Түүнийг доод давхарт буухад үүрийн жавар чичрүүдэс хүргэнэ. Хоёр тийш хяламхийн хараад хүлээж байгаа машин руу ухасхийв. Машины хаалгыг зөөлхөн хаагаад арын сандал дээр цагираглан хэвтэнгүүт машины мотор аслаа. Пар суудал дээр хаясан хөнжлөөр өөрийгөө хучиж хэвтэв. Хэсэг хугацаа өнгөрсний дараа хотоос гарлаа гэж Жон түүнд хэлжээ. Гадаа үүрийн гэгээ цайж, өглөөний тэнгэр дүнсийнэ. Ашевиллед ирэнгүүт Парыг тохирсон газраа буулгав. Пар талархлаа илэрхийлээд түүнийг хүлээж байсан машинд үсрэн орлоо. Нууц сүлжээ дэхь олон найзуудын нэг нь түүнийг Шарлотте руу хүргэхээр явж байгаа энэ байлаа.

Энэ удаад Пар машины урд талын сандал дээр сууж явав. Хьюго хар салхины учруулсан хохирлыг тэрээр анх удаа харжээ. Түүний нуугдаж байсан газрын зэргэлдээх хот суурин бороо, салхинд цохиулж, хүн харахын аргагүй болсон байв. Хар салхины учруулсан хохирлоос нүдээ салгахын аргагүй байлаа.

Хар салхи бэхэлгээгүй сулхан орших бүгдийг хаман авч, үхлийн ажиллагааныхаа зэвсэг болгожээ. Хүчтэй салхины дараа үлдсэн бүх зүйлс урьд өмнө харж байсан хүн танихааргүй болтол өөрчилсөн байна.

Тивийн нэг булангаас нөгөө рүү доншуулчилж байгаа Парт Теорем санаа их зовж байлаа. Үнэндээ тэр түүнийг бууж өгвөл яасан юм бэ гэж ятгаж хүртэл үзжээ. Байнгын айдас хүйдэс дунд зугатана гэдэг нэг их сайхан бодол биш, тиймээс хуульчид нь төлбөр өгөхийг Теорем санал болгож байв. Пар үүнийг зөвшөөрсөнгүй. Түүнийг устгах бололцоотой гэж итгэсэн хүн яаж ч бууж өгөх билээ дээ. Пар амин зуулга хийх хөрөнгө байхгүйгээс хойш Теорем түүнд мөнгө илгээж байлаа. Парт юу ч тохиолдож болно гэсэн хар дарсан бодол түүнийг байнга түгшээнэ. Утсаар ярих хооронд түүнд юу ч тохиолдож болох ажээ. Тэр амьд байна уу? Шоронд орсон уу? Түүнийг баривчлах үеэр буудуулчих болов уу? гэх мэт асуултууд ээлжлэн зовооно.

Нууц Алба болон хувийн аюулгүй байдлын ажилтнууд түүнийг олохыг маш ихээр хүсэж байлаа. Тэр зүгээр л зугатах бус тэднийг айлгаж түгшээсээр байсан юм. Пар тэдний компьютерийн сүлжээ рүү нэвтрэн нууц мэдээллийг нь хакеруудын хүрээнд цацсаар байлаа. Түүнийг гэртээ байхгүй үед хүртэл дайран орж байсан гээд бодохоор баривчлахыг ихэд хүсэж байсан бололтой. Дараа нь Хойд Каролинад хийсэн хоёр дахь баривчлах ажиллагааны үеэр тэдний гарын салаагаар мултарч дөнгөв. Өөрийнхөө дуут шуудангийн мессэжээр зэвүүцлээ илэрхийлж, бараг ил шахуу хакердах довтолгоо хийн анхаарлыг нь татна. Пар өөрийн хаа байгаа талаар хуурамч мэдээлэл их тараадаг учир тусгай албаныхан байнга мөрдөж мөшгих ажлаасаа залхсан байх гэж тэр бодож байв. TRW компаний системд нэвтэрснийг тэд мэдэж байгаа гэсэн бодол түүнээс салахгүй байлаа. Тэдний хувьд Пар үнэхээр нэгдүгээр зэргийн аюул болж хувирчээ.

Нэг хотоос нөгөө рүү аялах тусам Парын сэтгэл түгшилт улам нэмэгдэж, үе үе хойш харж алхах үйлдэл жирийн мэт болжээ. Тэрээр байнга ядарна. Хаалга хэзээ цохих бол хэмээн түгшсэнээс хэвийн унтаж чадахаа болив. Хэдэн цаг унтаад босохдоо зарим өглөө хаана ирснээ санахгүй сэрдэг байлаа. Аль хот, хэн гэдэг найз, ямар буудал билээ гэж эргэлзсээр босно.

Энэ хооронд компьютер олох тоолонд Пар хакердах ажиллагаагаа үргэлжлүүлсээр байв. Австралийн хакерууд болон “Legions of Doom”-ийн гишүүд байнга зочилдог, Ментор ба Эрик Блудаксын ажиллуулах BBS хэлэлцүүлэг буюу Феоникс төсөл дээр тэр байнга мессэж үлдээнэ. Хакерын ертөнцөд Феоникс төслийн нэр хүндийг өргөсөн бас нэгэн ажиллагаа бол Техасаас гаралтай board руу компьютерийн алдартай зарим мэргэжилтнүүдийг урьдаг байсан явдал юм. Аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа хүмүүс хакеруудыг сонирхдог шиг хакерууд тэднийг бас сонирхоно. Хоёр талыг учруулж, үзэл бодлоо солилцох таатай орчинг бүрдүүлэх, төвийг сахисан газар байсан учраас Феоникс төсөл маш онцгой хэсэг байлаа.

Мелбур дахь Realm-ийн Феоникс, Техасийн Эрик Блудакс гэх мэтийн найз нөхөдтэйгээ харьцах явцад Пар хакердах ур чадвараа сайжруулсаар байв. Электрон хүртэл Феоникс төсөл дээр байнга зочилно. Түүнийг зугатаж байгааг хакерууд мэдэж байсан учир хааяа хошигнож тоглоом хийх ажээ. Нөхцөл байдлыг даван гарахад хошигнол тусалж байв. Феоникс төслийн хакерууд түүнийг баригдах талаас нь асуудалд хандана. Харин байнгын зугатах орчинд тарчилж байсан Пар тэдний хүлээлтийг тас цохиж урагшилна.

Парын илгээсэн мессэжүүд итгэл найдвараа алдсан, гутарсан шинжтэй болж ирэнгүүт хакерууд чадах бүхнээрээ туслахыг оролдож эхлэв. АНУ-ын болон гадаадын элит хакерууд Феоникс төслийн хувийн хэсэгт үлдээсэн мессэжийг үзээд түүнийг өрөвдөж байлаа. Пар өөрийн хачирхалтай ертөнцөд улам гүн гүнзгий шигдсээр...

Сэдэв: ЧӨТГӨР АВАГ!!!

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Бямба гараг, 1990 оны 1-р сарын 13 08:40:17

Хог гэж, өнгөрсөн шөнө би согтоод, Филлиппиний систем рүү орж үзлээ...

Тэнэг админ орж ирээд... намайг хэн бэ гэж асуулаа..

Дараа нь яасан тухай миний санаж байгаа зүйл бол – намайг компьютерээ унтраасны дараа систем дээр байсан эккаунтнууд алга болсон байлаа.

Үүгээр ч дуусахгүй ээ. Филлиппиний бүхэл бүтэн нет дахиад дуудлага авахаа болив. (намайг компьютерээ унтраасны дараа бүхэлдээ алга болсон байв.)

Хэн нэгэн этгээд надаас залхсан нь илт байлаа. Тиймээс хүүхдүүдээ согтуу байхдаа хэзээ ч бүү хакерд!

- Пар гэжээ.

Сэдэв: Gawd

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Бямба гариг. 1990 оны 1-р сарын 13 09:07:06

Нууц алба болон NSA-ийн хөвгүүд намайг коммунист гэж бодоод байх шг байна... хэхэхэ гэхдээ би баяртай байна. Би одоо хүртэл эрх чөлөөтэй явна.

Бахахахаха

- Пар

Сэдэв: хамгийн доод талын мөр

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Ням гараг. 1990 оны 1-р сарын 21 10:05:38

Хамгийн доод талын мөр эвдэрчээ. Phrack хөвгүүд дөнгөж сурж байгаа юм байна. Би үүнд итгэлтэй байна.

Зөвхөн коднууд эсвэл картнууд гэх мэт юу хийж байгаагаас хамааралгүй та өөрийн үйлдэлд анхаарах цаг шүү.

Засгийн газар үүнээс цааш тэвчихгүй байх. Харамсалтай нь энэ бүгдийн тухай мэдээгээр гарснаар тэд хакеруудтай тэмцэх их хэмжээний мөнгийг засгийн газраас авах боломжтой болно.

Энэ бол бидэнд зориулсан маш муу мэдээ. Ийм зүйл рүү хөтлөх багш нарын хойноос тэд хөөцөлдөх болов уу гэж би бодож байна.

Алс зайтай гарсан тохиолдлуудыг хоорондоо холбоотой гэж тэд үзэх болов уу. Тэд биднийг зөвхөн хакерууд л гэж харна. Тэд үүнд л хамаг эрч хүчээ тавина. Бүх ХАКЕР-уудыг зогсоо, заналхийлэл болохоос нь өмнө зогсоо. Эрдэм мэдлэгийг түгээгч нарыг үлдэн хөөснөөр бүх зүйл дуусна. Энэ бол зөвхөн онол шүү.

- Пар

Сэдэв: Холболт

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Ням гараг. 1990 оны 1-р сарын 21 10:16:11

Тэгэхлээр, Гандалфийн [Британий хакер] хэлж байгаагаар цорын ганц холболт тасарчээ.

Би өөрийн булшны чулуун дээр ингэж л бичнэ. ЦОРЫН ГАНЦ ХОЛБОО САЛГАГДЛАА...

Магадгүй тэд миний араас ирэх юм бол би хэдийг нь хамт авч явахаа бодноо.

-Пар

Сэдэв: За тэгэхлээр

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Мягмар гараг. 1990 оны 1-р сарын 23 19:30:05

“Одоо төгсгөл ойртжээ. Би бараг бүх зам, харгуйгаар аяллаа...” Хааны үгнээс... За тэгэхлээр. Хэнд ч хамаатай билээ? Үхэхээсээ өмнө тэр тарган баас байсан юм дөө.

Бодит байдлыг далдлахад тусалсан миний сайн найзууд болон хүн бүрт талархлаа. Тэгээд бусад хүмүүст тайван байж, удаан тэсэхийг хүсье.

Үүнийг бичих үед би түр зуур галзуурсан байх. Хөгжилтэй газар дахин уулзая ухаалаг залуусаа.

- Пар

Сэдэв: Пар

Хэнээс: Эрик Блудакс

Он сар өдөр цаг: Мягмар гараг. 1990 оны 1-р сарын 23 23:21:39

Боль доо залуу минь, архи бүү уу, ийм зүйл бодоод хэрэггүй ээ. Энэ бол эрүүл, ухаалаг шийдвэр биш.

Техаст Аустин руу ир. Бид чиний асуудал шийдэгдтэл хаа нэгтээ байлгана. Дэглэм доогуур шоронд ганц жил өнгөрөөнө гэдэг бол бүх насаараа зовсноос хавгүй дээр шүү дээ. Чи дөнгөж 19 настай! Сайн сайхны төлөө чиний байнгын шийдвэрийг зөрчин хэлж байна. Үхсэн хүн бэлгийн харьцаанд орж чадахгүй, харин холбооны шоронд эхнэртэйгээ унтах боломж олдоно шүү!!!

Теоремын тухай бод. Үүнийг хэдэн удаа уншсан тоогоор утасдаарай.. Би маш ихээр түгшиж байгааг мэдэрч байна. Тиймээс зүгээр л утасдаадаг за?

- Эрик

Сэдэв: Хах

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Пүрэв гараг. 1990 оны 1-р сарын 25 18:58:00

Чиний хийж байгаа бүхнийг тэд харж байгаа гэдгийг бүү мартаарай. Надад итгэ. Би мэдэж байна.

- Пар

Сэдэв: Балай юм

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Даваа гараг. 1990 оны 1-р сарын 29 15:45:05

Удахгүй бүх зүйл болж өнгөрнө өө залуусаа

Надад цаг их байгаасай гэж хүсэж байна. Тохиролцоонд ч хүрэх юм билүү. Гэхдээ бүтэхгүй биз. Тэд маш ойрхон байна.

Тэд ямар машин жолоодож байгааг би хэлж чадна. Энэ бол хэнд ч тохиолдож байгаагүй явдал.

Гэлээ ч гэсэн би сонирхолтой дуудлага хүлээн авлаа. Энэ бол Белл системийн компьютерийн Эдд байв.

Энэ бараг л зөнгөл гэхэд болно... “Баяртай” гэдгээ илэрхийлэх түүний арга зам байх. Эдди сайн найз байсан. Тэр өнөөдөр надтай холбогдож баяртай гэж хэллээ.

Би одоо алингаа алдана гэж мэдэж байна. Баярлалаа Эдди

- Пар

Сэдэв: Пар

Хэнээс: Эрик Блудэкс

Он сар өдөр цаг: Бямба гараг. 1990 оны 1-р сарын 29 19:36:38

Найз минь, чи арай хэтрүүлээд байх шиг байна... наад бодлоо орхи. Хар шилтэй, хар хувцастай болгон мөрдөгчид биш шүү. Нийтлэг бүх машинууд чамайг тагнана гэж байхгүй ээ.

Балай юм, Эдди ямар юм аа яриад байгааг ойлгохгүй байна. Гэхдээ чи маш хачирхалтай мессэж үлдээсэн байна лээ.

Ер нь маргааш Аустин руу нис. Асуудлыг тань шийдэгдтэл хоргодох газар энд хангалттай газар байна.

- Эрик

Сэдэв: Яах вээ

Хэнээс: Феоникс [Австралиас]

Он сар өдөр цаг: Мягмар гараг. 1990 оны 1-р сарын 30 07:25:59

Хмммммммм...

<Үнэхээр ихээр гайхаж байна>

<Бодоод бодоод юу ч олж чадахгүй нь...>

Залуу Пар одоо яах гээд байгаа юм бол?

Сэдэв: Пар ба Эрик

Хэнээс: Даниеел Оливав

Он сар өдөр цаг: Даваа гараг. 1990 оны 1-р сарын 29 21:10:00

Хүмүүсийг нуугаад байх хүн л лав чи биш тийм үү?

Сэдэв: Чи хэзээ баригдахаа мэдэж байгаа

Хэнээс: Пармастер

Он сар өдөр цаг: Лхагва гараг. 1990 оны 1-р сарын 31 14:26:04

Чи хэзээ баригдахаа мэдэж байгаа: Таны хөршийг байнга ажиглах үед цаг агаар фаренгейтийн 11 хэм, тэгээд үүлтэй, маш бүрхэг байхад шил зүүвэл яах вэ.

Гэрийн чинь гадаа өдөр шөнөгүй нэг машин зогсоод байвал яах вэ? (би тэдэнд цагирган боов, кофе хүргэж өгөх тухай бодож байгаа)

- Пар

Сэдэв: яах вэ? Пар аа

Хэнээс: Ментор

Он сар өдөр цаг: Лхагва гараг. 1990 оны 1-р сарын 31 19:36:38

Уммммм. Би цаг агаар 11 хэм, үүлтэй бүрхэг байхад нарны шил зүүдэг...тэгэхлээр чи тэр хүнийг устгах хэрэгтэй

Сэдэв: Хмм, Пар

Хэнээс: Феоникс

Он сар өдөр цаг: Пүрэв гараг. 1990 оны 2-р сарын 01 10:22:46

Чи буудуулахгүй ээ.

Сэдэв: Пар, чи яагаад

Хэнээс: Сүйтгэл

Он сар өдөр цаг: Пүрэв гараг. 1990 оны 2-р сарын 01 10:56:04

Гадаа гараад тэр жентельменд “сайн уу” хэмээн хэлж болохгүй гэж үү? Хэрэв манай гадуур нэг л хүн байнга эргэлдээд байвал би маш сайн шалгах байлаа.

Сэдэв: Пар аа, тэднийг будаа болгоод өг...

Хэнээс: Астон Мартин

Он сар өдөр цаг: Мягмар гараг. 1990 оны 2-р сарын 29 18:04:55

Гадаанаа байгаа микро автобус руу гүйж очоод тэднийг сэжиглэж байгаагаа хэл. (чи мэднэ дээ, хоёр хүн бүхэл өдрийн турш суугаад байдаг) Тэдний чилээг гаргах хэрэгтэй юу гэдгийг асуу.

- Астон

Эдгээр хачин мессэжийн хооронд Пар техникийн холбоотой тайлбар байнга тавина. Бусад хакерууд Х.25 сүлжээнүүдийн тухай ээлж дараалан асууна. Бусад хакеруудтай адилгүйгээр Пар тэдэнд туслалцаа үзүүлсээр байлаа. Харьцангуй даруухан бөгөөд бусдад туслахад бэлэн, өөрийгөө илчлэхээр зүтгэл гаргах Пар олон хакеруудын хүндэтгэлийг хүлээжээ. Энэ бол хоргодох газар олон олдож байсан гол шалтгаан байсан юм.

Зугатааж байхад нэрмээс болж байсан өвлийг давж, хавартай золгов. Дараа нь зун ирнэ. Оргодлыг үндэсний хэмжээнд эрэн сурвалжилж байсан Нууц Албыг залилж, Пар зугатаасаар байв. Намар болоход хуулийн ажилтнуудаас зугатаасан хугацаа нэг жил гаруй болжээ. Парын ирээдүйг бас нэгэн хүйтэн өвөл хүлээх боловч Пар анзаарсан шинжгүй байв. Түүнд амьдрах зорилго байгаа учраас ямар ч хувь тавилантай эвлэрэх зориг тэвчээр байлаа.

Теорем дахиад зочлох хугацаа ойртжээ.

1991 оны эхээр Теорем Нью-Йоркт ирэхэд цаг агаар харьцангуй хүйтэн байв. Тэд Коннектикут руу аялж, найзуудтайгаа өрөө хамтран хөлсөлж байгаа Парынд ирлээ.

Пар олон зүйлд сэтгэл зовниж байсан бөгөөд Теоремын түүнд хандах хандлага хэвээр байгаа эсэхэд хамгийн ихээр шанална. Түүнийг ирснээс хойш хэдхэн цагийн дотор өнөөх нь айдас нь агаарт замхран одов. Арван хоёр сар гаруйн өмнө Калфорниад байхдаа ямар байсан яг тэр хэвээр энхрий байсан явдал түүнийгтайвшруулжээ. Теорем түүний амьдралын үймээний их далай дахь авралын завь адил байв.

Гэхдээ нөхцөл байдал бодит амьдрал дээр өөр байлаа. Байнгын оргож зугатаасан амьдрал Теоремд тийм таатай санагдахгүй нь лавтай. Байнга л бусдын тус дэм, өглөгт найдан явна.

Нэгэн удаа өрөөний хам нь согтож, Парын найзуудтай зодолдох дээрээ тулав. Маргаан томоохон үймээний хэмжээнд очиж, найзууд нь хөөрчээ. Ухаан алдталаа согтуурсан залуу эрх

мэдэлтнүүдэд Парыг хэлнэ гэж заналхийлсэн аж. Үгээ зөөж ядах агсам залуу ХМТ, Тагнуулын төв газар, Нууц Алба руу утасдаж, Пар хаана амьдарч байгааг хэлнэ гэж бардам зарлажээ.

Түүний хэлсэн үг үнэний хувьтай байж болох учир Теорем, Пар хоёр удаан хүлээсэнгүй. Хувцсаа шүүрэн авч, харанхуйд гүйн гарч одов. Очих газаргүй, мөнгө муутай хоёр хүйтэн жавартай өдөр олон цагийг гадаа өнгөрөөжээ. Эцэстээ согтуу залуу унтсан байж магадгүй гэж бодоод шөнө оройн болсон хойно түрээслэсэн байрандаа буцаж очихоор шийдэв.

Байрны үүдэнд ирээд сэтгэл түгшин зогсоно... Гэвч согтуу залуу хууль хамгаалах байгууллага руу утасдсан байж болох тул болгоомжлох хэрэгтэй байлаа. Магадгүй тусгай ажилтнуудын цуглуулга гэрт нь отоож байхыг үгүйсгэхгүй. Гудамжинд анир чимээгүй байв. машины зогсоолд тавьсан бүх машин хоосон эзэнгүй харагдана. Харанхуй цонх руу шагайхад Пар юуг ч эс харж чадах ажээ. Тэр Теоремыг дагаад ор гэж толгойгоороо дохилоо.

Парын царайг харж чадахгүй ч гэсэн түүний айж байгааг Теорем мэдэрч байв. Хамтдаа ойрхон байхад сэтгэлийн агуу таашаал авах Теоремд яг энэ мөч маш аймшигтай хараал мэт санагдана. Өрөө бүрийг шалган, тэмтчих зуур Парыг шаналгах сэтгэлийн түгшүүр Теоремыг давхар айлгаж байлаа. Эцэст нь Парын өрөөнд дөхөж ирэхэд Нууц Албаны хоёр эсвэл гурван ажилтан харанхуйд тэвчээртэй хүлээж байгаагаар тэр төсөөлж байв.

Өрөө хоосон хэн ч байхгүй байлаа.

Теорем орондоо орж унтахыг хичээсэн ч боловч байранд орж ирэхдээ туулсан аймшигт дарамтын талаар бодож, хөрвөөсөөр шөнийг өнгөрөөжээ. Хэдийгээр Партай өдөр болгон утсаар ярьж байсан ч тэр ямар нэгэн зүйл үгүйлсээр байсан юм. Урт хугацаагаар зугатаж явсаар Пар ихэд өөрчлөгджээ.

Удалгүй Теорем Швейцарь руу буцаж, Алтос руу зочлох явдал цөөрсөөр, чимээгүй болов. Тэр их сургуулийнхаа хуучин эккаунтыг ашиглан log хийж байсан учраас сургуулиа хаясан оюутны эккаунтыг хаасан байна. Х.25 сүлжээгээр гадаад ертөнцтэй холбогдож чадахаа больсон учир Алтос руу орж чадахгүй болжээ. Тэрээр хакердах ажиллагаа хийж байгаагүй ч Алтосоор өвчилсөн байлаа. Швейцарийн Х.25 сүлжээнд нэвтрэх боломжоо тэр дундаа Алтос руу орж чадахгүй болсон Теоремсэтгэлээр унажээ. Энэ тухайгаа уйтгартай дуугаар Парт хэлсэн байна.

Пар түүнд багахан бэлэг барихаар шийдэв. Х.25 сүлжээнд холбогдсон компьютеруудад ихэнх хакерууд нэвтэрсэн үед Х.25 сүлжээнүүдийг ажиллуулдаг компаниудын компьютерт Пар нэвтрэн оржээ. Telenet эсвэл Tumnnet компаний эзэмшдэг компьютеруудыг хяналтандаа авна гэдэг жинхэнэ эрх мэдэл байлаа. Ингээд Х.25 сүлжээний эзэн болсон Пар хайрт Теоремдоо зориулж Tumnnet дээр тусгай эккаунт үүсгэв.

Пар эккаунт үүсгэж дуусгаад бахархалтайгаар сандлаа налан суужээ.

Эккаунтын нэр: Теорем

Пассворд: Парнададхайртай!

Тэгэхлээр одоо Теорем маань Tumnnet сүлжээн рүү орох болгондоо энэ хэдэн үгийг шивэх болно. Алтос дэлхийн шилдэг хакеруудаар дүүрэн байх агаад Теоремд сээтэн хаях биз. Гэхдээ тэр log хийнгүүтээ л миний тухай бодно гэж Пар төсөөлж байв.

Пар түүнийг телефон утас руу утасдаж, маш онцгой бэлгээ барилаа. Шинэ эккаунтын пассвордыг түүнд хэлэнгүүт Теорем баяртайгаар инээмсэглэнэ. Түүнд маш сайхан санагджээ.

Бусад хакерууд буюу MOD-ийн хакерууд ялгаагүй баярласан юм. (MOD-Masters of Deception – хууран мэхлэгч мастерууд гэсэн утгатай-орч)

Хэнд ярьснаас шалтгаалан хууран мэхлэгч эсвэл эвдэн бусниулагч мастер алин болохыг тодорхойлох хакерууд бол Нью-Йоркийн хакеруудын бүлэг байв. Алтосыг хакердах нь сайхан санаа гэж тэд үзжээ. Алтосын хамгаалалтыг нэвтрэж access хийнэ гэдэг тийм ч амаргүй байв. Харин Теорем түүнийг давж чадсан мэт харагдана. Тэгээд ч ихэнх хүмүүс тухайн сүлжээнд холбогдсон компьютерийн эккаунтыг ашиглах бодолтой байдаг. Гэхдээ тухайн сүлжээнд холбогдсон компьютерийн эккаунтаас илүү хамгаалалттай эккаунтаас Алтосыг хакердах нь хамгийн амархан байв. Тиймээс Теоремийн эккаунтыг довтолгоо эхлэх цэг болгон ашиглах болно.

MOD-ын хакерууд Теоремийн Алтос дээрх пассвордыг хэрхэн олох вэ? Хамгийн боломжит хувилбар бол тэд Tumnnet-ээр дамжин Алтосд орохын тулд Теоремийн ашиглаж байгаа X.25-ын сүлжээний gateways-үүдийн нэгийг отоож байж мэдэх юм. Магадгүй MOD-ын хөвгүүд замд нь түүний пассвордыг sniff хийх биз. Эсвэл тэд gateway-г ажиглаж байгаа Tumnnet-ийн аюулгүй байдал хариуцсан хүмүүсийг хянаж байж болно. Алтос дээрх Теоремийн пассвордыг MOD-ын хакерууд яаж олж авсан нь гол асуудал биш билээ. Хамгийн гол асуудал нь түүний пассвордыг сольсонд оршиж байгаа юм. Теорем Алтос руу орж чадахгүй болонгуут маш сандарлаа. Мэдээж тэр Партай холбогдож чадахгүй болов. Тэр байнга зугатаж байсан учраас Теорем руу утасдах хүртэл хүлээх болжээ. Түүнчлэн Алтос дээрх Парын найзуудаас туслалцаа гуйх боломж хаалттай байв. Тэднийг яаж хайж олох вэ? Тэд бүгдээрээ л хакерууд... Тэд сүлжээний нэрийг сонгосон учир хэн ч бие биенийхээ жинхэнэ нэрийг мэдэхгүй.

Алтос руу орох access-ээ алдсан төдийгүй MOD-ын хөвгүүд Алтос системийг хакердахдаа түүний эккаунтыг ашиглаж байгааг Теорем огт мэдэхгүй байлаа. Бусад хүмүүс Теоремийг хакердаж байна гэж бодох болно.

Ашгүй Британий хакер Гандалф руу Теорем мессэж илгээж амжив. Тэр түүнийг хоёр шалтгаанаар хайжээ. Нэгдүгээр тэр сайн найз, түүнд туслана гэдэгт итгэлтэй байсан. Хоёрдугаарт Алтосын фолдерууд руу нэвтрэх эрхтэй эккаунтыг Гандалф эзэмшинэ. Өөрөөр хэлбэл тэр түүнд шинэ пассворд эсвэл эккаунтыг өгөх чадвартай байв.

Гандалф бол “The Eight Legged Groove Machine” гэсэн Британий хамтлагийн нэр нэрлэгдсэн хакерын бүлгээрээ нууц ертөнцийн дунд алдаршсан хүн байлаа. (8lgm буюу The Eight Legged

Groove Machine-Найман хөлтэй ховил гаргах машин гэсэн утгатай-орч) Тэр болон түүний найз Британий хакер Пад нар бүлэг дотроо хамгийн сайн дөрвөн хөлтөйд тооцогдоно. Британий хакердах тавцан дээр гарч ирсэн хамгийн авьяастай, дэлхийн сонгодог хакерт тэднийг тооцдог юм. Гэхдээ Гандалф (арай бага гэх байх) ба Пад хоёр хэт бардам зангаараа алдаршсан хоёр ажээ. Тэд Америкийн хакеруудын заримыг буруу замаар няц дарсан гэдэг. Тэр хоёрын аль нь ч үүнд эмзэглээгүй аж. Тэд өөрсдийн үйлдлийг: “Бид сайн. Бид мэднэ. Замаас зайлуул” гэсэн үзлээр хөөрөгдөнө.

Гандалф Алтос дээрх Теоремийн эккаунтыг ажиллахгүй болголоо. Тэр пассвордыг өөрчлөх замаар хяналтандаа оруулж, Теоремийн түүнд мессэж дамжуулахад хэрэглэдэг холбоосоор шинэ пассвордыг илгээв. Түүний эккаунтанд хэн нэгэн этгээд санаатайгаар довтолсон нь илт байв. Мэдээж хакеруудын ертөнц даяар Теоремийн эккаунтын шинэ пассвордыг цацах үйлдлийг Гандалф хэзээ ч хийхгүй. Гэхдээ Гандалф юу хийснийг Пар, Теорем хоёрын аль нь ч мэдэхгүй байв.

Энэ хооронд Пар хайрт руугаа утасджээ. Уурлаж бухимдсан Пар эккаунтыг оролдсон хүнийг олно гэж амласан байна.

MOD-ын хөвгүүд энэ хэргийг хийснээ Пард хэлэнгүүт тэр гайхаад л өнгөрөв. Учир нь Пар тэдэнтэй сайн харьцаатай байсан аж. Теорем маш их сэтгэлээр унаж, хараан зүхсэн талаар Пар тэдэнд хэлэв. Дараа нь туйлын ер бусын зүйл боллоо. Нью-Йоркоос гаралтай хар арьст залуу, MoD-ын хамгийн хүнд гар Corrupt Параас уучлалт хүсчээ. (Corrupt-эвдэрсэн, завхарсан, хахуульдсан гэсэн утгатай-орч)

MoD-ын залуус буруугаа мэдэж байвч хэзээ ч уучлалт гуйж байгаагүй юм. Нью-Йорк хотын гудамжинд уучлалт гуйсан хүн нэг их хол явахгүй. Энэ бол цэвэр хандлагын асуудал байв. “Уучлаарай Пар” гэж Коррапт чин сэтгэлээс хэлжээ.

Шинэ пассворд нь: MODm0dMOD гэсэн байв. Корраптыг орж ирэх тэр мөчид шинэ пассвордыг шалгаж үзэхийн тулд Пар sign off хийж байлаа. “Тиймээ Пар, чи мэдэх ёстой зарим зүйл байна” гэхэд “За” гэж яарч байсан Пар хэлэв. “Би таны найз охины мейлийг шалгасан. Тэнд зарим зүйл бичсэн байсан” гэв.

Теоремийн захидал? Зарим зүйл? Юу байсан гэж? Тэр асуув.

“Гандалфаас ирсэн захидал”

“Тэгээд?”

“Найрсаг захидал, маш найрсаг” гэж Коррапт бичжээ.

Тэр мэдэхийг хүсч байсан боловч асуулгүй орхив. Хэрэв тэр мэдэхийг хүссэн бол Алтос дээр рууг access хийх аргыг ашиглаж болох л байлаа. Гэхдээ тэр тэгээгүй юм. Теоремийн мейл рүү орох учир тэр энэ санааг орхисон билээ. Гэхдээ хүсэх юм бол мэдэж болно. Алтос дээр Теорем маш их алдаршсан учир түүнийг сэжиглэж хандвал алдас болно гэж Пар боджээ. Тэгээд ч хамтдаа маш сайхан цагийг өнгөрөөсөн Теоремыг хардаж маргах утгагүй байв.

“Маш найрсаг захиа” гээд Коррапт зогсжээ. Парт бүгдийг хэлэх хэцүү байлаа. Найзынхаа үерхдэг хүүхний пассвордыг хулгайлаад эккаунт руу нь орж үзнэ гэдэг нэг хэрэг. Хакеруудын хувьд энэ бол буруудаад байх зүйл биш гэхсэн. Гэхдээ тийм мэдээллийг өгнө гэдэг амар биш ажээ. Ялангуяа Гандалфтай 8lgm-д хамт ажиллаж байгаа Корраптын хувьд хэцүү байв.

“Баярлалаа” гэж Пар бичээд сүлжээнээс гарлаа.

Гандалф эккаунтыг ажиллахгүй болгосон учраас MOD-ын пассвордыг Пар оруулж үзэхэд нэвгэрч чадаагүй нь мэдээж. Гэхдээ Пар учрыг нь мэдэхгүй байв. Теоремийн эккаунт ажиллахгүй болсон явдал Парт нэг их төвөг учруулаагүй боловч хайртай хүнтэйгээ холбогдож чадахгүй байгаад тавгүйтнэ. Гандалф, Теорем хоёрын хооронд юу болсныг Пар тэсэлгүй асуухад юу ч болоогүй гэж үгүйсгэсээр байв.

Пар өөр юу ч хийж чадах билээ? Түүнд итгэнэ эсвэл эргэлзэнэ. Харин түүнд итгэнэ гэдэг хэцүү, эргэлзэнэ гэдэг зовлонтой. Тиймээс тэр итгэх замыг сонгожээ.

Энэ явдлаас хойш Теорем Алтос дээр биеэ барих болов. Теорем муу зүйл хийж байгаагаа мэдэж байлаа. Германы чатын системд орж чадахгүй өнгөрөөсөн цаг хугацаа түүнийг хар тамхинд орсон мэт болсныг ойлгуулж өгсөн юм. Тэр ингэж донтохыг буруу гэж үзэж байв. Өөрийн амьдралыг эргэж харсан Теорем найз нөхөд, Швейцарь дахь амьдралаа үл ойшоож байгаагаа ойлгожээ. Шөнө бүр компьютерийн дэлгэц ширтэн өнгөрөөх юунд ашигтай юм бэ?

Ингээд Теорем хатуу шийдвэр гаргав.

Тэр Алтосыг хэрэглэхээ үүр болихоор шийдлээ.

Талархлын баярын үеэр Пармастерт муу зүйл тохиолдох юм шиг санагдана.

1991 оны 11-р сарын сүүлээр Пар Виржиниа Бийчээс Нью-Йоркт нисэж ирэв. Морти Роузенцфилд нэртэй түүний танил гэртээ ирэхийг урьжээ. Тэр залуу MOD-ын хакеруудтай нийлдэг байв. Хот руу аялах нь таатай санаа гэж Пар бодох зуураа өөрийнхөө сайн найзынд очихоос татгалзсангүй. Зээлийн компаний пассвордыг худалдсан хэргээр кредит картны залилангийн хэрэгт холбогдсон Морти хэдэн сарын өмнө Холбооны шүүхээс ял авчээ. Пар пассворд худалдах ажил хийж байгаагүй юм. Морти ч өөрийн хэмжээнд дажгүй тохижсон нэгэн. Тэр Манхаттены ойролцоох Коней арал дээр эзэмшилтэй.

Мортигийн хэсэг нөхдийн хамт Пар хөгжилдөх зуураа түүний компьютер дээр цагаа өнгөрөөнө.

Нэгэн өглөө Пар маш хүчтэй шартсан байдалтай босож ирэв. Түүний дотор эвгүйрхэхийн хажуугаар хөргөгч хоосон байлаа. Тэр Хятад хоолны дуудлагын үйлчилгээ рүү утасдаж, гахайн махтай будаа захиалжээ. Хоол ирэхийг хүлээх зуур Пар тамхи уугиулж, буйдан дээр сууна. Пар 19 нас хүртлээ тамхи татаагүй бөгөөд сүүлийн хоёр жилийн дотор муу зуршлаа хөгжүүлсэн байна. Тамхи л түүнийг тайвшруулахад туслана.

Үүдний хаалга тогших сонсогджээ. Парын гэдэс ч хариу хэлэх мэт хоржигноно. Гахайн

махтай будаа ирлээ гэж бодсон Пар хаалгаа онгойлгоход түүнийг Нууц Албаны ажилтнууд хүлээж зогслоо.

Үүдэнд хичээл насны жентльмен зүүн талд, залуу ажилтан баруун талд зогсоно. Залуу ажилтан Парыг харангуугаа ихэд цочив. Гэнэт залуу Парыг хойш түлхсээр дотор орж унагав. Түүний нүүрийг хананд тулган дараад бөөр рүү нь буу тулгажээ. Дараа нь гар буугаа далд хийн гарыг нь гавлав.

Булангаас нүдэндээ нулимстай ширтэх Мортиг харах зуураа Пар “Чи намайг олилоо доо” хэмээн бодно.

Парыг гавлаж аюулгүй болгосны дараа Нууц албаны ажилтнууд түүнд энгэрийн тэмдгээ үзүүлэв. Тэд түүнийг Манхеттан руу авч явав. Машин Дэлхийн худалдааны төвийн эсрэг талд ирж зогсонгуут залуу ажилтан нь Парын гарыг урд нь гавалжээ. Гавлуулсан оргодлыг том цахилгаан шатанд оруулахад бүх хүмүүс тэдэн рүү гайхан харж байв. Гадна талаас нь бууны хэлбэр мэдрэгдэхээр хөх өнгийн нейлон куртка өмссөн залуу ажилтан гавнаас илүү бусдын анхаарлыг татах ажээ.

Энэ хоёр яагаад намайг заавал үүдний хаалгаар оруулав? Пар бодсоор байлаа. Ардаа машины зогсоолтой, тэндээс орох хаалга байх л ёстой. Бусад хүмүүст харагдахааргүй далд газар...

Түүнийг цонхгүй өрөөнд оруулж, сандалтай гавлан суулгажээ. Мөрдөгчид нааш цааш хөлхөлдөн, бичиг цаасаа янзалж харагдана. Удалгүй түүнийг гавнаас суллаж, цаасан дээр гарын хээг даруулж авлаа. Дараа нь зүүн баруун гараар нь бичүүлж бичгийн хэвийг нь сандаа авав.

Түүнийг сандалтай гавлахын Пар нэг их дургүйцсэнгүй. Харин гарын хээ авдаг өрөөний дунд байх том төмөр тор түүнийг маш ихээр зовоож байх шиг санагдана. Амьтны хүрээлэнд л ийм тор байдаг байх.

Түүнийг баривчилсан хоёр мөрдөгч өрөөнөөс гарангуут өөр нэгэн мөрдөгч орж ирэв. Тэр бусдыгаа бодвол тийм ч найрсаг биш бололтой. Муу цагдаа болж жүжиглэх мань эр Пар руу орилж, давшлан сэтгэлийг нь тавгүйцүүлэхийг оролдоно. Гэвч түүний энэ дайралт Парыг огтхон ч өөрчилсөнгүй.

Citibank-ны талаар мөрдөгч ганц ч асуулт асуулгүй, TRW-ийн талаар мэдэх бүхнээ ярихыг шаардана.

Алуурчин хиймэл дагуулын тухай аймшигт зүйлс, маш ихийг мэдэж байгаа хүнийг яах бол гэсэн урдны бодол Парын оюун санаанд дахин холхилдож эхлэв. Пар хариулахыг эсэргүүцэн чимээгүй суусаар байлаа.

Эцэст нь өрөөнд настайвгар мөрдөгч орж ирээд Парыг асууж байсан мөрдөгчийг авч гаран, өрөөний гадна шивнэв. Үүний дараа нөгөө мөрдөгч TRW-ын тухай нэг ч үг асуухгүйгээр зөөлөн хандах болжээ.

Нууц Албаны ахлах ажилтан том гэрээлэгчийн тухай яриаг яагаад зогсоосныг Пар эргэцүүлсээр байв. Гэнэт чимээгүй болох шалтгаан юунд байв? Пар дахиад л өнөөх сэтгэл зовнилдоо автлаа.

Калифорния руу албадан хүргэх ажиллагааг хүлээх зуур Парыг хорионд байлгана гэж мөрдөгч хэлжээ. Бичиг цаасны бүх ажлаа дууссаны дараа тэд Парыг гавнаас суллаж, биеийн чилээг гаргах боломж олгов. Парыг тамхи асуухад мөрдөгчдийн нэг нь тамхи өглөө. Дараа нь хоёр гурван мөрдөгч, тэгээд залуу ажилтнууд түүнийг тамхиар дайлж байлаа.

Залуу ажилтнууд түүнд маш найрсаг хандана. Тэдний нэг нь Партай гар барьж, өөрийгөө хүртэл танилцуулжээ. Тэд хакеруудын тухай бүгдийг мэдэх ажээ. Парын өөртөө зориулж бий болгосон дуут шуудангийн мессэжийг тэд мэдэж байлаа. Калифорниагийн цагдаагийн хавтаст хэрэг болон нууцаар авсан зурагнаас түүнийг ямар харагдахыг хүртэл тэд мэднэ.

Телефон утасны зангилаанаас утасдаж ярьсан бичлэг болон Нууц Албаны файлын тухай тэд бүгдийг мэдэж байв. Түүний аялсан газраа үлдээсэн бүх ул мөрийг тэд даган, шиншилсэн бололтой. Маш олон талаар судалж байсан ч тэдэнд ганц зүйл тодорхой байсан юм. Мөрдөгчид түүнийг зөвхөн гэмт хэрэгтэн хакер биш бас хүн гэдэг талаас нь харьцаж байв.

Энэ бол маш хачин мэдрэмж байлаа. Урьд өмнө хэзээ ч уулзаж байгаагүй мөрдөгч Парын хөрш эсвэл зэргэлдээх хотоос ирсэн найз нөхөд мэт Майкл Жексоны сүүлийн үеийн видео бичлэгийн талаар ярилцана. Дараа нь тэд цагдаагийн хэсэг дээр аваачиж дахин бичиг цаасны ажил хийв.

Энэ газар бол Дэлхийн худалдааны төвийн тансаг офис биш байлаа. Пар хуучирч муудсан өрөөний ховхорч байгаа саарал будгийг ширтэнэ. Тэр илтгэх хуудсаа хоёр хуруугаар тонших цагдааг харан аргаа барсан янзтай толгойгоо сэгсрэх ажээ. Тэнд ямар нэгэн компьютер харна гэж найдахын ч хэрэггүй. Парыг энэ удаад ямар нэгэн зүйлтэй холбож гавлаагүй бөгөөд тэр хаа нэгтээ явах талаар бодох шаардлагагүй боллоо.

Парыг байцааж байсан цагдаа ширээнээс босож арван минут гарах үед Пар маш их уйдаж байв. Тэр цагдаагийн ажилтны ширээн дээр байгаа мэдээлэлтэй хавтас, материалыг үзэж эхэллээ. Ширээн дээр ХМТ-той холбоотой лавлагааг хавсаргасан мафи, мөнгө угаах, залилангийн хэргийн материалууд байв. Эдгээр хүмүүс хүнд ажил эрхэлдэг бололтой гэж Пар бодов.

Тэр өдрөө Парыг шүүх хурлаар оруулж, Калифорниагаас хариуцсан ажилтнууд ирж автал нь Манхаттаны түр саатуулах байранд хорих шийдвэр гарсныг мэдэгджээ.

Пар тэнд бараг долоо хоног. Гурав дахь өдрөөс эхлэн Парын дотор нь бачуурч амьдаараа булшлагдсан мэт санагдах боллоо.

Шинэ мэдээллээр байнга хангагдаж байдаг хүнд хамгийн аймшигтай шийтгэл бол долоо хоногийн туршид ямар ч хүнтэй харьцахгүй байх явдал байлаа. Тэр хорих өрөөнөөс ч гарч үзсэнгүй. Саатуулах төвийн харгалзагч өрөө рүү хоол тавьсан хавтан шургуулж, идсэний дараа буцаан авна.

Зургаа дахь өдрөө Пар байж ядсан учир гэнэт хүчтэй уурлаж хорих өрөөний хаалгыг балбаж, орилов. Тэр харгалзагчид: “Эндээс гарахыг л хүсэж байна” хэмээн тавгүйхэн хэллээ. Нью-Йоркийн муу нэрээр алдартай шорон Рикерс Айланд руу шилжүүлэх болвол Пар гадагш гарна гэж харгалзагч хэлжээ. Ганцаар хорих өрөөнөөс гарч л байвал сар луу явсан ч хамаагүй мэт Парт санагдана.

Цуврал алуурчдыг хорих хэсгийг бодвол Рикерс Айландын эмчилгээний хэсэг нь Манхаттаны саатуулах газраас хавьгүй илүү санагдаж байлаа. Парыг шөнийн цагт л хорих өрөөнд нь түгжинэ. Өдрийн цагаар бусад хоригдлуудын хамт эмчилгээний байгууламжаар сэлгүүцнэ. Тэнд гэмт хэрэг хийх солиролтой хүнээс гадна, хэцүүхэн гэмт хэрэгтнүүдтэй хутгахыг хүсээгүй хүмүүс саатуулагдаж байв.

Энд төрөл бүрийн хүний цуглуулга байгаа гэж хэлж болно. Үнэт чулууны хулгайч болсон гал сөнөөгч, Колумбийн хар тамхины босс, 300 хулгайлагдсан машины цуглуулгатай машин хулгайлж задлан зардаг бүлгийн толгойлогч гэх мэт хүмүүс байна. Мөн өөрийнх нь араас гүйдэг хүнийг алсан гомо эр хоригдоно. Тэрээр хожим арван хоёр хүнийг хүчиндэж алсан хэрэгт буруутгагдсан гэдэг.

Алуурчинтай хамт хоригдохыг юман чинээ тоохгүй байсан хэдий ч залуу хүн шоронд хоригдоход юу тохиолдох вэ гэдгээс л эмээж байв. Гомо алуурчинтай найз нөхдийн холбоогоо бэхжүүлбэл зөв ч байж магад. Тэр ч гайгүй залуу боллоотой. Гэхдээ түүнийг буруу өнцгөө харж болохгүй л дээ.

Эхний өдөр Пар Кентакитай танилцав. Тэр эр үрчийсэн сонингийн хуудас хакерын гарт бариулаад “Энэ бол би” хэмээн өөрийгөө танилцуулсан аж. “Тэднийг ал гэж надад дуу хоолой хэлдэг” гэсэн гарчигтай нийтлэлд арав гаруй магадгүй түүнээс ч олон хүнийг алсан байж болох цуврал алуурчныг цагдаа нар хэрхэн барьсан тухай өгүүлжээ. Түүний сүүлд үйлдсэн аллагын үеэр хохирогч эмэгтэйн гэрийн ханан дээр танихгүй хүмүүсийн нэрийг цусаар бичихийг тэр дуу хоолой тушаасан гэж Кентаки Пард ярив.

Кентакигаас хол байхыг үнэт чулууны хулгайч анхааруулсныг үл тоох Пар түүнтэй нийлсээр байлаа. Гэвч бүх зүйл оройтжээ. Кентаки залуу хакер луу орилон дайрч, зодолдохыг оролдов. Пар хөдөлгөөнгүй зогсож хөшсөн мэт байлаа. Зэрлэг цуврал алуурчинтай хэрхэн зодолдох вэ? Цуврал алуурчин дайран давшлах энэ шоронд тэр юу хийгээд байгаа билээ? Их зүйлийг бодох хэрэгтэй байлаа.

Үнэт чулууны хулгайч Кентакиг хориглон барьж, тайвшруулахыг хичээнэ. Кентаки Пар руу ширүүнээр харах бөгөөд орилж, чарлахаа зогсов.

Рикерсэд хэдэн хоног байх хугацаанд Парыг Харанхуй хонгил ба Луу нэртэй тоглоом тоглохыг Гомо Алуурчин урив. Бүхэл өдрийн турш телевизийн шоу үзэхээс залхсан Пар урилгыг хүлээн авчээ. Гомо Алуурчин зугаалгын төмөр ширээн дээр самбар тавиад Парыг хажуудаа суулгав. Ингээд Калифорниагаас ирсэн хорин настай компьютерийн хакер, Х.25 сүлжээгээр сэлгүүцэгч маань Рикерс Айландын шоронд цуврал алуурчин, гомо алуурчин, үнэт чулууны хулгайчийн хамт Харанхуй хонгил ба Луу нэртэй тоглоом тоглох боллоо.

“Би өөрийнөө сүхтэй жадыг авна, тэгээд энэ одой чөтгөрийг нэвт сүлбэнэ” гэж Кентаки инээмсэглэн хэлэв. Дараагийн тоглогч нүүдлээ хийж эхлэнгүүт Кентаки саатуулаад “Би болоогүй байна аа” гэж хэлэхэд чөтгөрийн гэмээр инээмсэглэл нүүрэнд нь тодорлоо. “Тэгээд би хэрчинэ. Огтлоно. Цус хаа сайгүй үсрэнэ” гэж Кентаки тааламжтай үглэнэ.

Бусад гурван тоглогчид гайхан ширтэх агаад Гомо алуурчин руу Пар сэтгэл түгшсэн харцаар харна.

“Тэгээд би түүний зүрх рүү хутгаа дүрнэ, цус цус хаа сайгүй цус. Тэгээд би цавчина, цавчина, цавчсаар байна” гэсээр Кентаки дуугаа өндөрсгөнө. Тэр улам огшижхутга дээрээс доош дүрж байгаа мэт гараа өргөн хөдөлгөснөө ширээнээс босож орилж гарлаа.

Кентаки гэнэт зогсов. Ширээн дээр сууж байсан хүн бүр хөшжээ. Түүнийг улам галзуурахаас айсан хүмүүс хөдөлж чадахгүй байв. Парын дотор гэнэт муухай оргилоо. Өрөөний нөгөө булан хүртэл зугаалгын төмөр ширээнээс хэдэн секунд зарцуулахыг тэр тооцоолохыг хичээнэ.

Хүмүүсийг алмайрч байх зуур Кентаки ширээнээс холдон, духаараа хана налан амандаа үглэж эхлэв. Үнэт чулууны хулгайч түүн рүү аажуухан дөхөж очин, чихэнд нь хэдэн үг шивнээд ширээн дээр буцаж ирлээ.

Чимээ шуугиан гарангуут харгалзагчдын нэг нь ширээн дээр ирэв.

“Тэр залуу зүгээр үү?” гэж үнэт чулууны хулгайчаас асуугаад Кентаки руу дохилоо.

“Түүнийг тайван орхио. Тэр харь гаригийнхантай ярьж байгаа юм” гэж харгалзагчид үнэт чулууны хулгайч хэлэв. Харгалзагч: “За за” гэж хэлээд эргэлээ.

Кентакид зориулсан тусгай эмийг шоронгийн сувилагч өдөр бүр өгнө. Тэр хачин үнэртэй шингэнийг нэг аяга уугаад хамаг цагаа унтаж, ухаангүй өнгөрөөдөг байлаа. Заримдаа сувилагчийн өгсөн эмийг нууж байгаад өдөржин унтахыг хүссэн хоригдолтой Кентаки наймаалцдаг байв.

Кентаки эмээ наймаалцсан өдрүүд үнэхээр хэцүүхэн өнгөрнө. Чухам тэр өдрүүдэд тэр Парыг алахыг оролдсон аж.

Пар төмөр сандал дээр суугаад бусад хоригдолтой ярьж байхад гэнэт түүний араас гараараа хүзүүг нь боожээ. Тэр эргэхийг оролдсон боловч чадсангүй.

“Нэгэн залууг хэрхэн алсныг би чамд үзүүлэх болно” гэж Кентаки Парт шивнэж хэлэв.

“Үгүй үгүй ээ” гэж Парыг хэлж эхлэнгүүт Кентакигийн хоёр толгойт булчин Парын төвөнхийг шахаж эхэллээ. Түүний хүзүүг яг бахь шиг хавчиж байв.

Кентаки биеэрээ хойш суун, булчингаа чангалахдаа “Тиймээ яг ингэж, би яг ингэж түүнийг алсан” гэж хэлнэ.

“Үгүй ээ, болиочээ, чи ингээд хэрэггүй” гэж Пар амьсгаа давхцан тийчилж байлаа. Тэр гараа хий дэмий л сарвалзуулна.

“Би ингээд үхжээ. Миний амьдрал дуусчээ. Рикер Айландын Цуврал алуурчин хакерыг алжээ гэх биз” гэж Пар бодож амжив.

Шаардлагатай тохиолдолд гэнэт гарч ирдэг зангаараа өнөөх чулууны хулгайч гүйж ирээд Кентакигийн чихэнд Парыг тавь гэж зөөлөн дуугаар хэлжээ. Дараа нь Парын ухаан балартаж эхлэх яг тэр мөчид чулууны хулгайч Кентакиг огцом хойш татлаа.

Үүнээс хойш Пар үргэлж хана налж суудаг зантай болсон юм.

Торны цаана сар гаруй хугацаатай суусны дараа Калифорниагийн Монтерейн шерифийн газраас хүн ирж Парыг авч явахыг мэдэгдэв. Пар Нью-Йоркийн шоронд үзсэн таагүй зүйлүүдын дараа Калифорниа руу буцаж явахыг ихэд хүсчээ. Мөн Нью-Йорк дахь Холбооны прокурортой ярилцсан явдал түүнийг санаагаа өөрчлөхөд нөлөөлсөн аж.

Нью-Йорк дахь АНУ-ын Хуулийн газар хэрэг дээр дахин ажиллах болсон хуульч Ричард Роузены толгойны өвчин болжээ.

Тэдний хоорондох тохиролцоо Америкийн нэгэн телевизийн шоууг санагдуулж байв. Тэр шоунд гудамжинд гэмгүй явж байсан хэн нэгнийг сүртэй чимэглэсэн сандалд суулган, асуулт асуугаад дараа нь шагнал өгдөг юм. Нью-Йоркийн Хуулийн газрын ажилтнууд Парыг тиймэрхүү сандал дээр суулгаж маш олон асуулт асууж байлаа. Гавлаж хүлээгүй байцаалтын төгсгөлд тэд шагнал өгнө. Тэр шагнал бол шоронгийн хугацаа. Торгууль. Шийтгэл. Тэд юу гэж үзнэ түүнийгээ өгнө. Яг тийм шийтгэл авна гэж хэлэх аргагүй. Тоглоомын төгсгөлд ямар хүнд нь хөнгөн шийтгэл өгөхийг тэд шийднэ.

Тэд MOD-ын хөвгүүдийн эсрэг нотлох баримт хайж байгаа гэдгийг Пар мэдэж байлаа. Энэ тухай Пар мэдээлэл муутай байв. Нөхцөл байдал таагүй болж ирсэн тул Калифорниа руу шилжүүлэх шийдвэрийг эсэргүүцэхгүй байхаар Пар шийджээ. Шоронгийн солиотой хоригдлууд болон их зантай холбооны прокурортой Нью-Йоркийг бодвол Калифорниа хамаагүй илүү билээ. 1991 оны 12-р сарын 17-нд Монтерейн шерифийн ажилтан Парыг авахаар ирэв.

Дараагийн хэдэн долоо хоногийг өнгөрөөсөн Калифорниа дахь шоронгийн орчин Нью-Йоркийн шоронгоос огт өөр байлаа. Тэр Мексикийн хар тамхины наймаачин болон бусад мафийн гишүүдтэй хамт хоригдож байсан ч энэ удаад биеэ хэрхэн авч явах арга барилтай болжээ. Тэд Рикерсийн зарим нэг хоригдлуудтай адилхан галзуу балмад биш ажээ. Пар хэнд ч хэлэлгүй алга болсонг үл харгалзан хуульч Ричард Роузен хэрэг дээр дахин ажиллах болов. Пар түүнийг сайн хуульч гэж хүндэлсээр байсан юм. Гэвч шүүх хурал хуралдах өдөр түүнд ямар сайн зүйл авчирах вэ гэдгийг мэдэхгүй байв.

Роузен руу Пар шоронгоос утасдаж хэргийн талаар ярихад Роузен түүнд зарим нэг томхон мэдээг танилцуулсан аж.

“Буруугаа хүлээ. Чи бүх зүйлд буруутайгаа хүлээх хэрэгтэй” гэж тэр хэллээ.

“Роузен солирсон байх” гэж Пар бодох зуур “хэрэв чи буруугаа хүлээх юм бол бид ялалт байгуулж болно” гэж Роузен батлан хэлэв.

Утасны нөгөө үзүүрт Пар дуугүй дүмбийн сууна. “Чи надад итгэх ёстой” гэх хуульч маш ээдрээтэй гэмээр зэвсэг олжээ. 1991 оны 12-р сарын 23-ны өдөр Монтерейн насанд хүрээгүйчүүдийн шүүх Пард хоёр гэмт хэрэгт ял тулгажээ. Тэр бүгдийг хүлээн зөвшөөрөв. Тиймээс би бол Пармастер, Би компьютер руу нэвтэрсэн. Тиймээ би мянга мянган кредит картны мэдээллийг Citibank-ны компьютерээс авсан. Тиймээ, тийм...

Зарим талаараа түүнд хэргээ хүлээх нь хэцүү байсан авч Роузен маш сайн хөзрийг гартаа атгаж байгааг Пар мэдэж байлаа.

Парт хөнгөн ял оноож болох Насанд хүрээгүйчүүдийн шүүхээр хэргийг авч хэлэлцүүлэхээр Роузен ажиллажээ. Бодлоггүй хуумгай байсан учраас Роузен яарсан гэж ойлгож болохгүй аж. Парыг 1971 оны 1-р сарын 15-ны өдөр төрснийг албан ёсны бичиг баримт нь батлаж байгааг Роузен олж мэдэв. Үнэндээ бол үүнээс Пар арай эрт төрснийг хуулийнхан мэдээгүй байжээ.

Калифорния мужийн хуулиар хорин нэгээс доош насны иргэний хэргийг Насанд хүрээгүйчүүдийн шүүх хянан хэлэлцэх эрхтэй байдаг. Арван наймаас доош насны хүн гэмт хэрэг үйлдээд хорин нэгээс доош настай байхдаа шүүхээс ял авах болвол Насанд хүрээгүйчүүдийн шүүхэд хэргийг хянан хэлэлцэж болдог ажээ.

Нэгдүгээр сарын 13-нд Парын хэргийг шүүх хянан хэлэлцэх байсан бөгөөд нэгдүгээр сарын 8-ны өдөр хэргийг хэрэгсэхгүй болгох хүсэлтийг Роузен тавив. Орлогч прокурор Девид Шотт яагаад гэж асуухад Роузен өөрийн бэлдсэн бөмбөгийг хаялаа.

Пар аль хэдийнээ 21 нас хүрсэн тул Насанд хүрээгүйчүүдийн шүүх түүнд ял оноох эрхгүй болно. Цаашлаад Калифорния мужид Насанд хүрээгүйчүүдийн шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болговол яллагдагчийг насанд хүрэгсдийн шүүхэд шилжүүлж болохгүй ажээ. Яагаад гэвэл Парын нас аль хэдийнээ хязгаарыг давсан учир түүний хэргийг Насанд хүрэгсдийн шүүх хурлаар авч хэлэлцэж болохгүй болжээ. Хууль хяналтын байгууллагын нүдэн дээр хэрэг шийдэгдэв. Орлогч прокурор хэлэх үггүй боллоо. Тэр түгдэрч, шүлсээ үсчүүлэн үглэж байв. Прокурорын газар түүнд тулгасан гэмт хэргийн ялыг хэрэгсэхгүй болгожээ. Яаж байгаад ийм зүйл болов? Пар оргодол байсан. Тэр Нууц Албыг хоёр гаруй жил хана мөргүүлж, зугатаасан шүү дээ. Шүүхийн танхимаас эрх чөлөөтэй зүгээр л алхаад гарчих ёсгүй билээ.

Түүнийг төрсөн өдрөө нотлохыг Параас шүүх хүсэв. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн газраас жолоо барих зөвшөөрлийг шүүж үзэхэд Пар болон түүний хуульч үнэн хэлсэн нь нотлогдлоо. Ингээд Пар шүүхийн танхимыг эрх чөлөөтэйгээр орхин гарав.

Шүүх хурлын танхимаас гарсны дараа Пар нар луу ширтэн зогсоно. Тивийн хоёр талд гурван янзын шоронд хоёр сар өнгөрөөсний дараа нар сүр жавхлантай гийж байв. Сэтгэл дүүрэн алхах гайхамшигтай санагдана. Гудамжаар эрх чөлөөтэй алхахад үнэхээр сайхан байлаа.

Энэ явдлаас хойш Пар суурин амьдрах хувьгүй байжээ.

Калифорния мужийн Салинас дахь шоронгоос суллагдсанаас хойш Пар улс орноор хэрэн тэнүүчилж, түр зуурын ажил энд тэнд хийсээр өдөр хоногийг өнгөрөөнө. Нэг газар хадагдсан мэт амьдрах нь түүнд хэцүү байв. Хамгийн хэцүү нь түүнд хачирхалтай зүйлс тохиолдох болов. Ер нь түүнд ийм зүйл байнга тохиолдож байсан хэдий ч сар өнгөрөх тусам улам хачирхалтай болж ирлээ. Түүний бодит байдлын төсөөлөл өөрчлөгдөж эхлэв.

Мотелын өрөөнд байхад нэгэн асуудал гаржээ. Улс орноо хэрсэн нэг аялалын үеэр Лас Вегасын Трейвэллоджд Пар амарч байв. Гэтэл түүний өрөөний доод давхарт хэн нэгэн хүн хөдлөөд байх шиг санагдав. Пар түүнийг сонсохыг хичээнэ. Тэр хүн Партай яриад байх шиг санагджээ. Өнөөх хүн түүнд юу хэлэхийг хичээж байна вэ? Пар түүний хэлснийг сайн ойлгохгүй байсан агаад тэр түүнд нэг юмыг ойлгуулах гээд байна гэдэгт итгэлтэй байлаа. Парын сэтгэл үнэхээр их хямарчээ. Тэр яаж ч хичээн, хана, шаланд чихээ наан чагнаад юу ч ойлгохгүй байв.

Хийсвэр төсөөлөл мэт байдал үргэлжилсээр... Мексик рүү хийсэн аялалын үеэр түүнд маш хачин мэдрэмж төрсөн тул туслалцаа авахаар АНУ-ын консулын газарт очжээ. Харин консулын газрын хүн бүр түүнээс зайгаа барина.

Парын бичиг баримтыг шаардахад тэдэнд түрийвчээ гаргаж өгөв. Тэд Калифорния мужийн иргэний үнэмлэх, Нийгмийн халамжийн картыг нь аваад хүлээж байхыг хүслээ. Өөрсдийн компьютерээс түүний тухай мэдээлийг гаргаж үзэх гэж байна гэдэгт Пар итгэж байв. Хүлээж байх зуур түүний хөл чичирч, нурууг нь даган хүйтэн жихүүдэс дээш доош гүйж эхэлжээ. Энэ бол маш жигд бус, тасалдсан чичрүүдэс байлаа. Газар хөдлөлтийн голомт дээр сууж байгаа мэт мэдрэмж төрсөн учир тэр маш их айх ажээ. Консулын ажилтан түүнийг гөлөрсөн харцаар ажиглана.

Удалгүй Пар чичрэхээ болив. Консулын газрын ажилтан буцаж ирээд түүнийг явахыг хүсжээ. “Энд хэн ч таньд туслаж чадахгүй” гэж тэр Парт хэлэв.

Консулын газрын албан тушаалтан яагаад ингэж хэлэв? Түүнийг яв гэсэн үг юу илэрхийлж байгаа билээ? Тэр яах гэж ингэж хэлэв? Пар түүнийг ойлгосонгүй. Тэнд гав барьсан нэгэн ажилтан Пар руу дөхөж ирэв. Яагаад хүн бүр ийм сонин аашилж байгаа юм бэ? Энэ компьютертэй холбоотой юу... Компьютер дээр түүний нэртэй хамт тусгай мессэж гарч ирсэн юм болов уу..

Пар нөхцөл байдлыг тайлбарлах гэж оролдсон боловч консулын ажилтан түүнийг ойлгоогүй бололтой. Нууц Албаны ажилтуудаас хоёр жил хагас гаруйн хугацааны турш зугатааснаа Пар тэдэнд хэлэхэд зөвхөн сонжсон харцаар л харж байв. Ямар ч өөрчлөлтгүй гөлийсөн царай. Ойлгохыг хүсээгүй харц. Тэр тайлбар их хийх тутам тэдний царай улам хөшинө.

Консулын газар энэ өдөр ажиллахгүй байгаа гэж консулын албан тушаалтан хэлэв. Тэр консулын байрыг орхин гарах шаардлагатай болжээ. Энэ бүхэн Парт сэжигтэй санагдаж байв. Хэдэн минутын дараа Мексикийн цагдаагийнхан ирлээ. Цагдаатай ярьж байх зуураа консулын ажилтан түүнд цаасанд боосон хуйлаастай песогийн (мөнгө) дэвсгэртийг өгч

байна гэж Пар ойлгожээ.

Консулын газар дээр нэмж хоёр цагдаа ирэв. Тэдний нэг нь Пар руу эргэж: “Яв!” гэхэд Пар хариу хэлсэнгүй. Мексикийн цагдаа нар түүний хөл гараас нь барьж өргөөд консулын газраас хүчлэн гаргав. Айж түгшсэн Пар консулын байрны босго өнгөрөнгүүт орилжээ.

Тэд цагдаагийн машинд Парыг хийгээд шоронд аваачиж маргааш хүртэл хорив.

Дараа өдөр нь Парыг суллан явуулсан бөгөөд АНУ-ын консулын газарт очихоос өмнө тэрээр ямар ч зорилгогүй хот дундуур сэлгүүцсэн ажээ. Өчигдөр уулзсан ажилтан гарч ирээд түүнээс сэтгэл санаа ямар байгааг асуусан байна. Пар “Зүгээр” хэмээн хариулаад хил даван гарахад туслаж чадах эсэхийг нь лавлав. Консулын ажилтан түүнд туслахаа амлаж, цагаан өнгийн микро автобусаар Парыг хилийн шугам дээр аваачжээ. Пар хил дээр ирэнгүүт галт тэрэгний тийз авах хоёр доллар жолоочоос гуйлаа. Жолооч ч түүнд өгөв.

Хаашаа явж байгааг нь мэдэхгүй галт тэргэнд Пар суужээ.

1992 онд Теорем Калифорниад хоёр удаа айлчилж, тэдний харилцаа дахин хуучиндаа орлоо. Шүүх хуралд орох болон зугатаж байхдаа түүнээс зээлсэн 20,000 долларын зээлээ эргэн төлөхийн тулд Пар ажил олохыг хичээнэ. Түүнд ажил олгох хүн олдохгүй байлаа.

“Чамд компьютер дээр ажиллах ур чадвар байхгүй юм байна” гэж тэд хэлнэ. Харин тэр “тиймээ” гэж даруухан хариулна. Мэдээж түүнд ур чадвар хангалттай байсан юм.

“Чи ямар их сургуулиас зэрэг авсан бэ?” гэхэд нь ямар ч их сургуульд сурж байгаагүй гэж тэр хэлнэ .

“Ямар компанид ажиллаж байсан бэ?”

Аль нэгэн компанид ажиллаж байхдаа ур чадвараа эзэмшээгүй гэнэ.

За тэгэхлээр 1989-1992 оны хооронд юу хийсэн бэ? гэж залхсан дуугаар ажилд зуучлагч агентлагын ажилтан зайлшгүй асууна.

“Би... би улс орноо тойрон аялсан” гэж хариулах ажээ. Пар өөр юу хэлж чадах билээ?

Хэрэв тэр азтай байсан бол цагийн 8 долларын мэдээлэл оруулдаг ажил агентлагаас олгох л байлаа. Хэрэв түүний аз бага бол үүнээс бага хөлстэй үйлчилгээний ажил дээр буух байв.

1993 онд Теорем тэр хоёрын харилцаа хөндийрчээ. Ингээд дөрвөн жил хагас үерхсэн хосууд салж хагацав. Тэр хоёрын хоорондох зай бүх талаараа хол байсан юм. Теорем байнгын хөдөлгөөнд байх Парын амьдралаас тогтвортой байдлыг хүсэж байсан билээ.

Тэдний хагацал үнэхээр гуниг гутрал дагуулсан гэхэд болно. Шийдвэр гарсны дараа хэдэн долоо хоног хоорондоо яриагүй бөгөөд Теорем алдаа хийсэн байх гэж бодсоор байлаа. Парыг буцаж ирэхийг ихэд хүссэн боловч бодож санаснаа гүйцэлдүүлээгүй юм.

Пар архинд оржээ. Нууц Албаны хураасан зүйлсийг буцаан олгуулахыг Роузен хөөцөлдөж, Пар үеэ өнгөрөөсөн компьютер, дагалдах хэрэгсэл, хэдэн диск, хэвлэсэн цаас, тэмдэглэлийн дэвтрээ хүлээн авав.

Үйлдсэн хэргийн нотлох баримтуудаа цуглуулсан Пар нэг шил виски асган түүдэг асаалаа. Галд хийсэн дискүүд хайлж байх зуур Пар тэмдэглэлийн дэвтрээ уншиж, түүх өгүүлэх хуудас бүрийг аажуухан эргүүлнэ. Дараа нь тэр бүгдийг базаж галд шидэв.

Нууц Албаны илтгэх хуудсыг базаж цаасан бөмбөг хийж байхад түүнийг гайхуулах нэгэн зүйл нүдэнд нь өртжээ. 1988 оны Талархлын баярын үеэр Парын гэрт хийсэн анхны дайралтын дараа дэлхийн эргэн тойрны олон хакеруудыг баривчилсан байв. Эрик Блудакс, MOD-ын хөвгүүд, LOD-ын хөвгүүд, Атлантын гурав, Пад, Гандалф, Австралийн хакеруудыг 1989, 1990, 1991 онд баривчилжээ.

Эдгээр баривчилгаа хоорондоо ямар холбоотой байв? Хакерууд руу довтлох ажиллагааг дэлхий даяар хийхдээ гурван өөр тивийн хуулийн байгууллагууд сайн зохион байгуулалттай ажиллаж чадсан гэж үү?

Нууц Албаны илтгэх хуудас түүнд нэг учгийг өгчээ. 1988 оны 12-р сард хоёр мэдээлэгч Нууц Албаны хоёр өөр хэлтэс рүү утасдаж, Парын тухай мэдээллийг өгсөн гэж илтгэх хуудсанд дурьдсан. Мэдээлэгч болсон хоёр хакер агентлагын хайж байгаа Citibank-ны хакер бол Пар биш гэж хэлсэн аж. “Citibank-ийг дээрэмдсэн жинхэнэ хакер” бол Феоникс... Австралийн Феоникс гэж тэд хэлжээ.

Тавдугаар бүлэг

Алтан цөгцний эрэлд

“Бид эзлэн түрэмгийлээд Британий колони орнууд болон хаадын эд баялагийг оллоо”.

“Гол улаанаар эргэлдэнэ”-ээс иш татав. Midnight Oil хамтлаг

1982 оны нэгдүгээр сард Австралийн иргэн Хэлэн Мередитын бичсэн хоёр нийтлэлд бүх зүйл цагаан дээр хараар бичсэн юм шиг илхэн байлаа. Австралийн хакерын ертөнц тэр аяараа бужигнав. Нэгдүгээр сарын 14-ны өдөр гарсан анхны нийтлэлд: -“Citibank-ны хакеруудын учруулсан хохирол 500,000 америк доллар боллоо” гэж дурьджээ.

Австралийн түүхэнд тохиолдсон хакердах гэмт хэргүүд дотроос хамгийн их алдаршсан гэмт хэргийг Австралийн хакерын элит бүлэг үйлджээ. Тэд Америкийн Citibank-наас 500,000 америк долларыг (580,000 Австрали доллар) хулгайлсан юм.

Мелбурн, Сиднейн хакеруудыг илрүүлэхээр Австралийн хуулийн байгууллага Америктай хамтран ажиллаж байгаа тухай урд нь мэдээлсэн аж. Тэд бол цагаан захтны гэмт хэргийн элит “хакерууд” байлаа...

Мелбурн хотын 119 Вилляамын гудамжинд орших Telecom компаний төв байрны зааланд байгаа утсыг ашиглан 2600 герцийн сигнал илгээж, телефон утасны гол шугаманд Австралийн хакерууд нэвтэрчээ. Тэрхүү гол шугамнаас Citibank-ны менежерийн нэвтрэх кодуу орсон байна. Эх сурвалжийн мэдээлж байгаагаар өнгөрсөн шөнө Америкийн банкнаас 563,000 долларыг авч, хэд хэдэн дансанд хуваан байршуулжээ. Дансанд орсон мөнгийг хэн нэгэн авсан байна.

“Одоо нэгжлэг хийх зөвшөөрлөөр зэвсэглэсэн Гэмт хэргийг мөрдөн байцаах товчооны ажилтнууд хакеруудын эзэмшилд байдаг байр саванд нэгжлэг хийв. Тэд хэдэн мянган долларыг биетээр олно гэдэгт найдаж байна” хэмээн эх сурвалж мэдээлжээ.

Арван өдрийн дараа хоёр дахь нийтлэл гарлаа.

Австралийн холбоо гэх хакерын бүлэг, олон улсын хакердах ба фреакинг хийх бүлэглэлийн тухай сүүлийн үеийн мэдээлэлд эрх баригчид эргэлзсээр байв. Гэвч Мелбурнийн бюллетень боардууд дээр нотлох баримт үргэлжлэн гарсаар байгаа нь сэжиг төрүүлж байлаа... Бюллетень боардын үйл ажиллагааны сүүлчийн хэсэгт орон нутгийн хакерууд болон Австралийн кредит картны хэрэгт Австралийн холбоо бүлэг холбоотой тухай сүүлийн үеийн мэдээллийг АНУ-ын Captain Cash нэртэй хакер тавьжээ. (Captain Cash-Ахмад бэлэн мөнгө гэсэн утгатай нэр) АНУ-ын хакерууд 362,018 америк долларын хохирол учруулсан байна.

Pacific Island нэрээр алдаршсан Компьютерийн бюллетень боард систем дээр тавигдсан мэдээллийг Австралийн холбоо идэвхитэй ашиглажээ.

Уг мессэжэнд: “ОК Бидний өнөөдөр хааж байгаа 5353 серүүд дээр Мастер карт \$109400.50.

4564 серүүд дээр Виза байгаа. Түүнийг би долоо хоногийн туршид нээлттэй байлгана \$209417.90. Хэн нэгний 43,200 долларыг авахгүйгээр гэрээсээ бүү гар. Нийт 362018.40 долларыг хийгээрэй!

‘Австралийн найзууддаа энэ тухай сонсоё!. Тэд мөн сайн ажиллаж байгааг би сонссон. Хорин гуравдугаар дээр тэд олон дугаарыг илгээж байна! Гайхамшигтай! Тэд 10%-ийн бонус авна. 36,200.00 долларын бонус шүү дээ!’ ” гэжээ.

Түүнчлэн бюллетень боард дээр Telecom компаний 199 Виллям гудамжин дахь төв байрны телефон утсуудыг ашиглах тухай зөвөлгөөг фреакеруудад зориулан тавьжээ. Мөн Мелбурнийн Спенсер гудамжны буудал дээрх ногоон утаснуудыг олон улсын дуудлага үнэгүй хийхэд ашиглах тухай зөвөлгөө бас байлаа.

Орон нутгийн бюллетень боардын хэрэглэгч Феоникс “ЕХТС” бэлдмэлийн үнийн жагсаалтыг тавьжээ.

Баасан гарагийн орой The Realm нэртэй Австралийн хакерын бүлэг АНУ-ын Citibank-ны сүлжээ рүү нэвтрэхийг санал болгосон уриалгыг орон нутгийн өөр нэгэн бюллетень боардны хэрэглэгч хүлээн авав.

АНУ-ын хакерын бүлэг Милвауки ба Хьюстонд байрлаж байгаа гэж үздэг байлаа. АНУ-д Citibank-ны сүлжээнд нэвтэрсэн Америкийн хакеруудыг Холбооны хуулийн байгууллагууд аль хэдийнээ баривчилж амжсан байна. Эрүүгийн тагнуулын товчоо Австралийн холбоо бүлгийг нууц хяналтандаа авч, өнгөрсөн долоо хоногт Pacific Island боард болон Zen, Megaworks нэртэй ижил үйл ажиллагаа явуулдаг бусад боардуудаас зургаан сарын турш хураасан нотлох баримтуудыг танилцуулжээ.

Австралийн хакерын бүлэг нь Мелбурн хотын гаралтайгаас гадна залилан, хар тамхи хэрэглэх, машины хулгай зэрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн эсвэл сэжиглэгдсэн зарим өсвөр насны хүмүүсээс бүрджээ. Тэдний ихэнх нь томоохон гэмт хэрэгтэй холбоотой байж болно гэсэн ангилалд багтсан байлаа.

Америкийн Citibank-ны сүлжээнд нэвтэрсэн, фреакинг хийх зөвөлгөө өгсөн үйлдлийг Австралийн хакерууд хүлээн зөвшөөрсөн мэдээлэл гарч эхлэв. Дараах мэдээллийг бюллетень боардаас авчээ... Энэ мэдээлэл нь Киллер Томато руу Иван Троцки нэртэй хакераас илгээсэн боард дээрх цахим шуудангийн хайрцганд хадгалагдсан байжээ.

“Тэгэхлээр ийм юм болж байна... Холбооны мөрдөгчид Сисоп руу утасдаж Форс, Феоникс, Ноум, Бретт Макмиллан болон миний нэрийг The Realm-ийн хакердсан ажиллагаатай холбогдуулан лавласан байсан. Түүнчлэн зарим картингын гэмт хэрэгтэй холбон шалгаж байх шиг байна. Дараа нь Америкийн Citibank-ыг хакердсан үйлдэлд холбогдуулан баривчилсан хүмүүсийг Форс, Электронтой холбоотой байсан гэсэн мэдээллийг сүүлийн хэдэн хоногийн турш авлаа... Pacific Island –ын материал бол зөвхөн мөсөн уулын орой нь гэж DPG-ийн мониторингийн албаны хэвлэлийн төлөөлөгч Стюарт Гилл хэлжээ. Тэд цагдаагаас илүү сайн зохион байгуулалттай байсан” гэж тэр бичжээ.

“Хүн бүр хийсэн үйлдэлдээ асуудалд холбогдчихгүй л юм бол дараа жилийн өдийд бид үүнтэй адилхан зүйлийг хэлэлцээд сууж байх болов уу.”

Өмнөд Австралийн цагдаагийн газар бюллетень боардуудыг нууцаар хянах ажиллагаагаа эхэлсэн. Харин засгийн эрхэнд аль ч нам гарсан компьютерийн хакерын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг үргэлжлүүлэх болно гэж Баруун Австралийн улс төрийн намууд харилцан зөвшөөрчээ. Түүнчлэн өнгөрсөн долоо хоногт залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэнд компьютер сүлжээ ашиглан залилан хийсэн гэмт хэргийг мөрдөх компьютерын гэмт хэрэгтэй тэмцэх тасаг шинээр байгууллаа гэж Викториагийн цагдаагийн газар зарлав. Хакерын нууц ертөнцийн гишүүн бүр дээрх нийтлэлийг уншаад зүрх нь шимширчээ.

Каптэйн Кеш гэж хэн бэ? Киллер Томато гэж хэн байв? Тэр хоёр бол Стюарт Гилл байсан эсвэл Гилл хуурамч мессэжийг тэднээр бичүүлсэн, магадгүй Боуены боардын хэн нэгэн бичсэн байх. Хакерууд кредит картны залилангийн гэмт хэргийг хамгийн их хийдэг болов уу? Үгүй ээ. Тийм хүмүүс хакерын хүрээний дунд цөөхөн бий. Citibank-наас Мелбурнийн хакерууд хагас сая долларыг хулгайлсан уу? Мэдээж үгүй. Цагдаагийн мөрдөн байцаалтын үр дүнд энэ таамаглал бүхэлдээ буруу байсныг тогтоосон юм.

PI болон Zen-ий зургаан сарын турш харилцахдаа илгээсэн мессэжүүд Викториа мужийн цагдаагийн эрүүгийн тагнуулын товчооны гарт яаж орсон бэ? Хакерын хүрээний гишүүдэд дээрх зүйлүүд их сэжигтэй санагдаж байв.

Стюарт Гилл хакерын нийгмийн дунд мэдээлэл худалдагчийн үүрэг гүйцэтгэж байна гэж зарим нэг нь үзэж байлаа. Тэр цагдаагийн агентлагт мэдээлэл дамжуулж, хариуд нь зарим нэг материалын тухай тайлбарыг хүлээн авдаг. Дараа нь тэр хуучин ба шинэ материалыг нийлүүлж, шинэ бичиг баримтаа өөр нэгэн цагдаагийн агентлагт хүргэнэ. Харин тэд нар түүнийг дахин нэмэлт материалаар дэмжинэ. Гилл хакерын нийгэмд адилхан л тоглоом тоглож байгаа мэт санагдаж байлаа.

PI болон Zen-ий байнгын зочин Ментат, Бретт Макмиллан нар залилагчдыг сэжиглэн, өөрсдийн үзэл бодлоо хамгаалахын тулд BBS дээрх дайныг эхлүүлжээ. 1989 оны эхээр Стюарт Гиллийн эзэмшдэг бизнес худалдааны нэр гэх Hackwatch нь Викториа мужийн компаниудын хэрэг эрхлэх газарт бүртгэгдээгүй байна гэсэн мессэжийг Макмиллан тавьжээ. Цаашлаад DPG мониторингийн алба бизнесийн нэрээр албан ёсоор бүртгэгдээгүй, бүртгэлд байхгүй гэж тэр дурьдсан байна. Тэгээд ч Hackwatch-ийг өөрийн нэр дээр бүртгүүлсэн хэмээн Макмиллан зарлаж хакеруудыг гайхшруулав. Мэдээж Стюарт Гиллийг Hackwatch-ийн хэвлэлийн төлөөлөгч шиг харагдах явдлыг зогсоохын тулд ингэсэн бизээ. Хакеруудын ихэнх нь Гиллд хууртагдсан гэж үзэх боловч тэд цорын ганц хохирогчид биш байв. Удалгүй сэтгүүлчид болон цагдаа нар эгнээнд нэгджээ. Стюарт Гилл түүний жинхэнэ нэр биш ажээ.

Хакеруудын эсрэг хууль гаргахад олон нийтийн анхаарлыг татах зорилготойгоор Гилл ажиллаж байна гэж хакерын нийгэмд харъяалагдах зарим гишүүд итгэх болов. 1989 оны дунд үед Засгийн газраас яг тийм арга хэмжээ авч, Холбооны анхны компьютер гэмт хэргийн тухай хуулийг баталжээ.

Энэ бол сэтгүүлчдийн алдаа биш байлаа. Жишээлбэл Хелен Мередит Гиллээс нотолгоо

байгаа эсэхийг асуухад өөрийг нь хамгаалан дэмжих Викториа мужийн цагдаагийн дарга Тонни Варрены нэрийг Хеленд дурьджээ. Сурвалжлагч үүнээс өөр нотолгоо олж чадахгүй байв.

Тэгээд Гиллийг хамгаалах олон шалтгаан байжээ. Дотоод аюулгүй байдлын нэгжид бүртгэлтэй мэдээлэгч Гилл мөн зөвлөгч, зөвлөх, Викториагийн Цагдаагийн олон ажилтны найз, итгэлт анд нь байсан юм. Тэрээр Варрен болон байцаагч Хрис Косгрифф нартай ойр дотно нөхөрлөдөг байлаа. 1985-1987 онд Варрен Эрүүгийн тагнуулын товчоонд ажиллаж байв. Түүний дараа 1988 онд орсон Косгриффтэй хамт ажиллахаар Дотоод мөрдөн байцаалтын газарт иржээ. 1992 онд Тони Варрен бараг зургаан сарын турш Стюарт Гиллээс 200 орчим утасны дуудлагыг хүлээн авав. Тэдний 45 дуудлага нь Гиллийн гэрийн утаснаас хийгджээ. 1991-1992 оны хооронд найман сарын хугацаанд Гиллийн гэрт Хрис Косгрифф 76 удаа зочилж, 316 удаа утсаар ярьсан байна.

Дотоод аюулгүй байдлын нэгж цагдаагийн байгууллагын ажилтнаас үйлдсэн авилгын хэргийг мөрдөн байцаана. Хэрэв та Дотоод аюулгүй байдлын нэгжтэй холбоотой бол цагдаагийн ажилтнуудын авлигын тухай Викториа мужийн цагдаагийн газраас албан ёсоор мэдэж байгаа бүхийг мэдэх боломжтой юм. Цагдаагийн нэг ажилтан нөгөөгийнхөө гэмт үйлдлийг мэдээлдэг тул тус нэгжийн мэдээлэл маш чухал нууцад хамаарна. Гэвч 1993 оны Викториа мужийн Омбудсманы илтгэх хуудсанд дурьдсанаар Косгрифф Дотоод аюулгүй байдлын нэгжийн их хэмжээний нууц мэдээллийг Гиллд задалсан, Гилл Варрен хоёрын найрсаг харьцаа зохих ёсны бус гэжээ. (Омбудсман-засгийн газраас томилсон, бие даасан мөрдөн байцаалт, хяналт шалгалт явуулдаг эрх бүхий байгууллага, албан тушаалтан юм-орч)

1989 онд Гиллт хууртагдсан гэдгээ Крейг Боуен мэдэнгүүтээ сэтгэлээр их унажээ. PI-ийн хүрээний хакерууд түүнд итгэж байсан юм. Гилл түүний найз нөхрийн нандин итгэлийг гутаажээ.

Сэтгэлээр унаж, итгэл нь бөхсөн Крейг Боуен PI болон Zen-ийг үүрд хаасан билээ.

1989 оны хоёрдугаар хагаст компьютерийнхээ өмнө сууж байсан Форс дэлгэцээ ширтэх боловч ухаан санаа нь хэдэн сая милийн цаана байв. Нөхцөл байдал муу, бүр маш муу байлаа. Бодолдоо дарагдаж, компьютерийн хулганаар зорилгогүй тоглох Форс асуудлыг хэрхэн шийдэх талаар эргэцүүлнэ.

Мелбурнд байгаа хэн нэгнийг баривчлах гэж байгаад асуудал оршиж байв.

Хакерын ертөнцөөр үе үехэн түгэх ээлжит баривчилгааны тухай цуу яриа гэж үзээд нууцаар анхааруулахаа болихыг хүссэн ч тэгж чадахгүй байлаа. Гавинаас ирсэн анхааруулга бодит ажээ.

Форсын найз Гавин “Telecom” компанид гэрээгээр ажиллаж, шөнийн цагт хакер хийдэг байв. The Realm-ийн бусад гишүүд Гавиныг мэдэхгүй бөгөөд Форсын бяцхан нууц байлаа. Гавин BBS-ийн тавцан дээрх хакерын хэсгийн нэг байсан нь тодорхой билээ. Тэр Форсоос нас ахимаг, онлайн нууц нэргүй, ганцаар хакерддаг онцлогтой байв. Учир нь хакердах ажиллагааг бүлгээр хийх нь эрсдэлтэй гэж тэр үздэг байжээ.

Telecom компанид гэрээгээр ажилладаг Гавин ихэнх хакерууд зөвхөн зүүдэндээ нэвтэрч болох компьютер, сүлжээнд чөлөөтэй орно. Түүнчлэн телефон утасны бичлэг ба шугамын талаархи асуултанд саадгүй хариулах компаний ажилтнуудтай сайн хөршийн харилцаатай байлаа. Магадгүй тэд Telecom компаниас туслалцаа шаардаж байгаа цагдаагийн мөрдөн байцаалтын тухай мэдэж байж болно.

Гавин хуучин тоног төхөөрөмж худалдан авч байхдаа Форстой танилцсан байна. Тэд удалгүй найз нөхөд болж, хамтран хакердаж эхлэв. Хүн бүр гэртээ харьсны дараа харанхуйгаар нөмөр хийн Гавины офист очиж, бүхэл шөнийн турш хакердана. Үүрээр бүх зүйлээ цэгцлэн эмхлүүлж, байрыг чимээгүйхэн орхино. Харин Гавин гэр лүүгээ явж, шүршүүрт ороод юу ч болоогүй юм шиг ажилдаа ирнэ.

Гавин trashing буюу хог ухах ойлголтыг Форсод танилцуулсан юм. Гавин компьютер дээр бүхэл шөнийг өнгөрөөж байхдаа Telecom компаний хогийн савыг ухаж офисын цаасны үрчгэр өөдөс дээрээс мэдээллийн сувд шүүрдэг байв. Эккаунтын нэр, пассворд, dial up модемууд, Сүлжээ хэрэглэгчийн хаягууд (NUA) зэрэг олон мэдээллийг хүмүүс хэрэггүй цаасан дээр бичээд дараа нь хаа сайгүй хаядаг.

Форсийн хэлснээр Гавин ажлын байраа олон дахин өөрчилж, хакердсан ул мөрөө балладаг байжээ. Өдөр бүр хэдэн зуугаад утасны дуудлага хийдэг арваад ажилтантай офисоос тэр ажиллана. Гавин болон Форсийн хууль бус үйлдлүүд өдөр болгон үргэлжлэх хууль ёсны мэдээлэл дамжуулалтын давалгаанд булагддаг байв.

Хоёр хакер бие биендээ итгэнэ. Гавин бол CitiSaudi-ийн компьютерийн тодорхой хаягийг Форсоос авсан цорын ганц хүн байсан юм. Форсийн дуртай хакер, The Realm-ийн өсөж яваа од Феоникс хүртэл Форсийн сүлжээний нээлтийн явцад олж мэдсэн Citibank-ны бүх нууцаас холуур өнгөрсөн билээ.

Форс нээлтийнхээ зарим хэсгийг л Феоникстэй хуваалцсан болохоос бус бүгдийг хэлчихээгүй аж. Дайны олз болсон хэдхэн Citibank-ны карт болон Citibank-ны сүлжээний тухай ерөнхий мэдээллийг түүнд танилцуулжээ. Олон тооны картны дугаар цуглуулж, хэрэглэх нь залуу Феониксийн хүсэл мөрөөдөл учир Citibank-ны машины байрлалыг нууц хэвээр хадгалахаар Форс хичээжээ. Гэвч Citibank-ны системийг Феоникс өөрөө олж чадна, тэр цагт юу ч түүнийг зогсоохгүй гэдгийг тэр мэдэж байлаа. Феониксийг ямар нэгэн хүндрэлтэй асуудалд ороход Форс туслахгүй байхаар шийдсэн байна.

Citibank-ны сүлжээ бол янз бүрийн эх сурвалжаар баян учраас Форс өөртөө үлдээхийг хүссэн нь эргэлзээгүй. Тэр хир зэрэг ихийг нээнэ, сүлжээн дээр мөн адил ихийг олно. CitiSaudi-ийн системийн анхны нээлтийг хийсний дараа Сауд-Америкийн банкны компьютертэй адилхан картны мэдээллийг илгээхийг хүссэн гэмээр бас нэгэн CitiGreese-ийн машиныг олжээ. Систем дээр олсон арван таван кредит картны хоёр нь л хүчинтэй байв. Бусад картууд нь туршилтынх байж магадгүй, тиймээс шинээр нээгдсэн байх гэж тэр тооцоолжээ. CitiGreese-ийн компьютерийг нээсний дараа үүнтэй ижил бойжилтын шатандаа яваа өөр хоёр газрыг өөр орнуудад олов.

Форс компьютер сүлжээний тухай ихийг олж мэдэхийг хүссэн, шинэ хакерын зориг зүтгэлд

сэтгэл хөдөлсөн Феониксийг дэмждэг байлаа.

Хэдэн жилийн өмнө Форсийг танилцуулсан Крейг Боуен шиг тэр Феониксийг Минерватай танилцуулжээ. Феоникс их юм сурч, дахин ихийг мэдэхээр буцаж ирэв. Хашир Форсийн үзэж байгаагаар тэр юм сурахад өлөн мэт санагдана. Залуу хакераас Форс олон зүйлийг олж мэдрэв. Тэд хоёулаа нийгмийн дунд давхаргаас гаралтай. Мөн сонирхол адилхан, уламжлалт хэсгээс бага зэрэг зайгаа барьдаг. Форсийн гэр бүл Австралид нүүн ирж суурьшсан. Харин Феониксийн гэр бүлийн зарим гишүүд Израильд амьдардаг бөгөөд шашин шүтлэг ихтэй байлаа.

Орчин цагийн ортодокс Зионист институц гэж тодорхойлох Викториа мужийн Ортодокс Еврейчүүдийн сургуулиудын нэгд Феоникс суржээ. Есдүгээр ангид зааж байгаа хичээлийн бараг хагас нь Еврей судлалын тухай байх агаад бүх хөвгүүдээс тоорцог өмсөж, сургуулиа төгсөх үед Еврей хэлээр чөлөөтэй ярьдаг болохыг шаардана.

Сургуульд орсон анхны жилээс Феоникс “Өндөг” гэсэн хоч авчээ. Дараагийн жилүүдэд крикет тоглохдоо мастер болж, шашин судлалаар идэвхитэй оролдсон тул эцэг эх, багш нарын магтаалыг ихэд сонсов.

Гэхдээ сургуульд гаргаж байсан амжилтын хажуугаар Феоникс асуудалтай тулгарсан юм. Түүний эцэг эхийн салалт Феониксийг хүнд цохилтонд оруулжээ.

Эцэг эх нь салсны дараа түүнийг зургаан сарын хугацаатай Израиль руу сургуульд илгээв. Тэр Мелбурнд буцаж ирээд ээжийнхээ эмээгийн дэвсгэрт эх, охин дүүгийн хамт амьдарчээ. Түүний эрэгтэй дүү нь аавтайгаа хамт амьдардаг аж.

Феониксийн гэрт ирсэн сургуулийн найзуудад нь хэцүү сэтгэл төрдөг байв. Феониксийн ээж гэнэт хүчтэй орилох сэтгэл мэдрэлийн эмгэгтэй болсныг түүний хамгийн сайн найз нарын нэг нь олж мэджээ. Хүчтэй шуурганаас гэрийнхээ утасны шугамыг хэрэглэж байгаад тогонд цохиулж үхэхээс айх Феониксийн эмээ нь угийн сэтгэлзөвөх өвчтэй нэгэн юм. Феоникс аавтайгаа дотно харьцаагүй байв. Telesom компаний менежер ажилтай аав нь түүнийг үл огоорч, хүчтэй уурлан хүйтэн ханддаг байжээ.

Гэхдээ Феоникс биш харин түүний дүү нь асуудал их тарьж аавыгаа уурлуулна. Тэр арван долоон настай байхдаа гэрээсээ оргож, тогтвортой амьдралтайгаа золгохоос өмнө хар тамхинд орсон байна. Түүний амьдрал, асуудал нь бусдын нүдэнд ил харагдах ажээ.

Харин Феоникс өөрийн дургүйцлийг илэрхийлэхдээ бусдын анхаарлыг үл татах аргуудыг хэрэглэнэ. Тэдний дотор хүч чадлын хэрэгсэл болох зодооны урлаг, сэлэм ба нийгмийн инженерчлэл багтаж байв. Дунд сургуулийн төгсөх ангид сурж байх үедээ тэрээр хакерын замыг сонгожээ. Тэр Мелбурнийн төрөл бүрийн BBS-ийн хэлэлцүүлгээр хэсүүчилж, Форстой онлайнаар танилцан, нөхөрлөлөө бататгасан байна.

Феониксийн хакерын ур чадвар дээшилж байгааг Форс анзаарч, танилцсанаас хойш хоёр гаруй сар өнгөрсний дараа The Realm-д нэгдэхийг урьжээ. Realm-ын ямар ч гишүүний хувьд энэ бол богино хугацаанд хийгдсэн сонголт байлаа. Тэд шинэ хакерыг элсүүлэхдээ нэргүй

санал хураадаг байв. Феоникс сайн гишүүн болохоо батлаж, The Realm-ийн мэдээллийн санд зориулан шинэ системүүд, сүлжээнүүдийн тухай мэдээллийг идэвхитэй цуглуулжээ. Хакердах ажиллагааныхаа оргил үед Форс, Феоникс хоёр өдөр бүр утсаар ярьж байв.

Феониксийг шинээр элсүүлсэн явдал The Realm-д 1988 онд хэдэн сарын турш тогтмол зочилж байсан Электронтой байр суурьтай зөрчилдөж эхлэв. Форсын дэмжлэгт сэтгэл өег байсан Феониксийг арван найман настай Электрон үзэн ядаж байлаа. Эцэстээ Форс Мелбурнийн хакеруудын клубээс Электрон болон түүний найз Power spike –ийг гаргажээ. (Power spike-хүчтэй хадаас эсвэл гадас гэсэн утгатай) Электрон хоёр томоохон нүгэл үйлдсэн гэж The Realm-ийн бусад гишүүдэд тэр мэдэгджээ. Нэгдүгээрт заналхийллийг өсгөж, бусдын анхаарлыг татан, мөшгүүлэх үйлдэл хийхэд хүргэх үйлдлийг Электрон хийсэн. Өөрөөр хэлбэл Алтос руу холбогдох ОТС-ын Минерва систем дээрх экаунтуудыг хэрэглэж эх сурвалжуудыг сүйтгэсэн аж. The Realm-ын өст дайсан, Минервагийн админ Майкл Роузенберг Алтосын сүлжээний хэрэглэгчийн хаягийг олж мэдсэн. Хакеруудын эсрэг ОТС-ийн хамгийн сайн хамгаалалт бол Розенберг байв. Тэрээр хакеруудын зан зуршлыг бараг цээжээр мэдэх агаад Минервагаас тэднийг зайлуулахад маш их цагийг үрсэн нэгэн юм. Хакерууд эхлээд найзуудтайгаа чат хийхийн тулд Алтосыг судалж байгаад дараа нь хакердах ажиллагаагаа эхэлдэг байна.

Минерва дээрх ихэнх экаунтуудыг томоохон корпорациуд эзэмшдэг байв. Алтос руу ANZ банкны хууль ёсны хэдэн хэрэглэгч зочлодог вэ? Нэг ч хүн байхгүй. Тиймээс Алтос руу холбогдсон экаунтыг Роузенберг харангуутаа хакер юу хийж байгааг чимээгүйхэн ажиглана. Хэрэв Германы чат боард дээр хакер онгирч сагсуурвал пассвордыг өөрчилж, клиент рүү мэдэгдэн хакерыг холдуулах оролдлого хийдэг байна.

Форсийн үзэж байгаагаар Электроны хоёр дахь нүгэл бол бүлгийн бусад гишүүдээс хакердах мэдээллээ харамлан дарсан аж. Хэдий тийм боловч Форсийн тайлбарыг түүнд шууд тулгах боломж байхгүй байлаа.

Энэ бол олны зүгээс тэднийг хөөсөн үйлдэл байв. Поуерспайк, Электрон хоёр үүнд нэг их эмзэглэсэнгүй. BBS-ийн The Realm-д орж гарч байсан боловч хоёр хакер The Realm-ийн жинхэнэ гишүүд байгаагүй хэмээн тэд үзэж байв. “The Realm шиг авьяас чадваргүй бүлгийн гишүүд байхыг хэн хүсэх юм?” гэж Электрон наргиа болгон Поуерспайкд хэлж байжээ. Мэдээж тэд эмзэглэж л таараа. 1988-1990 оны хакерууд бие биетэйгээ хуваалцах мэдээллээс ихээхэн хамааралтай байсан юм. Тэд мэдээллийн цуглуулгад найдлага тавих байдал ихсэж, нууцаар олж мэдсэн мэдээллээ хуваалцах бүлэгт харъяалагдаж байвал тэдний ур чадвар ахидаг байлаа. Хэдэн сарын дараа Электроныг The Realm-д дахин нэгдэх хүсэлт гаргахад Форс дурамжхан зөвшөөрчээ. Электрон дахин log in хийж BBS-д оронгуутаа “Электронноос хулгайлсан сканнер” гэсэн файлыг олов. Электроныг цөллөгт байх хооронд хилийн чанад дахь компьютер дээр байгаа Электроны VMS сканнерын хуулбарыг Форс илрүүлжээ. Харин Форс үүнийг The Realm дээр тавихыг хүсээгүй байна.

Гэвч энэ бол жирийн сканнер биш юм. Энэ бол VMS трожан бөгөөд томоохон ялгаа их байв. Энэ програм сүлжээн дээрх компьютерүүдийн хаягуудыг скан хийдэггүй. Энэ програм нь X.25 сүлжээн дээрх бусад компьютертэй хүмүүс өөрийнхөө VMS компьютерийг холбонгуут пассвордыг нь барьж авна. Электрон: “Тэгэхлээр Форс Prime компьютерийн тухай мэддэг

байж болно. Гэхдээ тэр VMS-ийн тухай юу ч мэдэхгүй” гэж Поуерспайкт хэлж байсан гэдэг.

Электрон байр сууриа алдсаны дараа Феоникс түүнтэй холбоотой хэвээр байлаа. Нийтлэг санаа зорилго нь холбоотой байхад нөлөөлжээ. Электрон Феоникстэй адилхан сурах эрмэлзлэл ихтэй бөгөөд Мелбурнийн бусад хакеруудаас мэдлэг чадвараар хэнийг ч урдаа оруулахааргүй байсан юм. Феоникс Электронтой тогтмол холбогдож эхлэнгүүт Форс түүнийг холдуулахыг хий дэмий л оролджээ. Австралийн хакерын ертөнцөд эцэг эх шиг байр сууринаас хандах Форсод тэдний харилцааг эс хүлээн зөвшөөрөх хандлага төрөв. Тэр хакердах хүрээний загалмайлсан эцэг гэж өөрийгөө үздэг байв. Түүнчлэн компьютерийн аюулгүй байдлын томоохон мэргэжилтнүүд болон системийн админуудаар тоглоом хийж, тохуурхах Феониксийн үйлдэлд Форс санаа их зовж байжээ. Нэгэн удаа түүний сүлжээний холболтыг даган мөшгиж, барихаар систем дээр хүлээж байсан аюулгүй байдлын ажилтнууд, системийн админуудыг тэр мэдэж байв. Тэр компьютерийн сүлжээгээр нууцаар, мэдэгдэлгүй нэвтэрч, админуудыг чимээгүйхэн log off хийжээ. Тухайн үед Форс үүгээр бахархаж байсан авч түүний сэтгэлийн буланд түгшүүр хурж эхэлсэн ажээ.

Компьютерийн аюулгүй байдлын салбарын эсрэг бяцхан өдөөн хатгалга хийх Феониксийн сэтгэл өндөр байлаа. Тэр өөрийгөө сайн гэдгээ батлан харуулахыг улам ихээр хүснэ. Түүнчлэн систем дээр нь алдаатай цоорхой байгааг тэдгээр мэргэжилтнүүдэд хэлэх юм бол тэдний дэмжлэгийг хүртэнэ гэж Форсийн гарын хүн бодсон нь хачирхалтай. Магадгүй тэд дотоод мэдээллээ түүнд өгч, нэвтрэх арга техникээ хуваалцана гэж тэр итгэжээ. Асуудлын логик холбоог олж харалгүйгээр ой ухаандаа зөрчилдөөнт хоёр бодлыг тээсэн Феониксийг Форс ихэд гайхаж байлаа.

1989 оны сүүлээр Гавин яаралтай анхааруулгыг Форсод өгсөн явдал тайзан дээр болж байсан үйл ажиллагааг няцаасан юм. Мелбурнээс эхтэй хакеруудын ажиллагааны тухай гомдлууд Австралийн Холбооны цагдаагийн газарт ирэх болсныг Гавин мэджээ. Мелбурнийн хакерууд олны анхаарлыг татах болж, дэлхийн мэдээллийн сангийн сүлжээгээр хэсүүчилэхдээ ул мөрөө хаа сайгүй үлдээж байв.

Мөн Нью-Йорк, Техас, Английн хойд хэсэгт хакеруудын ажиллагаа идэвхижсэн аж. Гэхдээ Мелбурнийн хакерууд зөвхөн дуу чимээтэй байгаагүй юм. Тэд Америкийн компьютеруудын дотор маш их шуугиан тарьж байв. Америкийн систем рүү зөвхөн Америкийн хакерууд бус мөн гадаадын хакерууд довтолж байлаа. Австралийн хакеруудыг сэжиглэх шаардлага тухайн үед гарчээ. АНУ-ын санхүүгийн томоохон институт Citibank-ны дотор Феоникс нэртэй Австрали хакер нэвтэрсэн гэдгийг АНУ-ын Нууц Алба мэдэж байв.

Форсед өгөх мэдээлэл Гавинд хомс байлаа. АНУ-ын хуулийн байгууллагууд түүний дотор Нууц Албанаас тэдгээр хакеруудыг илрүүлэн баривчлуулахаар Австралийн засгийн газарт нилээд дарамт үзүүлж байгааг л Гавин мэдэж байв. Харин Номхон далайн нөгөө эргээс ирж байгаа дарамт зөвхөн Нууц Албанаас ирээгүй гэдгийг Гавин мэдээгүй байсан юм. Америкийн системд нэвтэрсэн Австралийн хакеруудын талаар Австралийн Холбооны цагдаагийн газарт ХМТ мэдэгдэж, Австраличууд түүний мөрөөр ажиллаж эхэлжээ.

1989 оны сүүлээр Мелбурнийн хакеруудын хэргийг мөрдөн байцаах Австралийн Холбооны цагдаагийн багийг эрүүгийн албаны дарга, хурандаа Кен Хант толгойлов. Австрали улсад

хакеруудын эсрэг анхны хууль батлагдсанаас хойш компьютерийн гэмт хэрэгт хийж байгаа анхны томоохон мөрдөн байцаалт гэж үүнийг үздэг юм. Дэлхийн бусад орны хууль хамгаалах байгууллагын адил Австралийн Холбооны цагдаагийн газар компьютерийн гэмт хэргийг мөрдөх салбарт туршлага дутаж байлаа. Компьютерийн дадлага туршлагатай хэдхэн ажилтнуудыг мөрдөн байцаалтанд татан оролцуулсан нь чухал алхам болов.

Гавин мэдэж байсан зүйлээ хэлэнгүүт Форс даруй ажилдаа оржээ. Тэр Феоникс руу утасдаж аль болох хурдан биечлэн уулзахыг шаардав. Тэдний нөхөрлөл улам бэхжих тусам онлайнаас утсанд, утаснаас биечлэн уулзах байдалд шилжжээ. Форс нилээд хатуу сануулгыг Феоникст өгөв. Тэр хаанаас мэдээлэл авснаа хэлээгүй боловч найдвартай эх сурвалжаас ирүүлсэн болохыг тодорхой тайлбарлажээ.

Хэн нэгэн хакерыг баривчлах ёстой гэж цагдаа нар үзэж байгаа гэсэн утгатай мессэж тарж байлаа. Хэрэв та нар ямар нэгэн алхам ойрын үед хийхгүй бол бид ямар нэгэн ажил хийхээс гэж Америкийн хуулийн байгууллага Австралийн мэргэжил нэгт нөхөддөө хэлсэн мэт санагдаж байв.

Феониксийн царай гэнэт хувхай цайлаа. Тэр бараг байнга л системүүд рүү нэвтэрч олны анхаарлыг маш ихээр татсан нэгэн. Тэдгээр халдлагын бай болсон системийн ихэнх нь АНУ-д байдаг байв.

1989 оны 6-р сард Германы ойгоос шатахуун нэвт шингэж, нүүрс болтлоо шатсан хүүрийн үлдэгдэл олдсон нь Баруун Германы хакер Хагбардын цогцос болж тааржээ. Түүн шиг төгсгөл болохыг Феоникс хүсээгүй нь лавтай.

Пенгогийн хамтрагч Хагбард 1986-1986 оны хооронд Зүүн Герман дахь КГБ-ын туршуулд Америкийн компьютерүүдээс олсон мэдээллийг худалдсан Германы хакерын бүлэгтэй холбоотой байсан юм.

1989 оны 3-р сард Германы цагдаагийнхан Германы хакеруудын бүлгийн гишүүдийн гэр орон, албан байр руу дайралт хийж, баривчилж эхэлжээ. Хагбард Пенгогийн адил үйлдсэн гэмт хэргээсээ мултрахын тулд хакерын бүлгийн үйл ажиллагааг хэдэн сарын өмнө Германы эрх баригчдад задалсан билээ.

Америкийн хууль хамгаалах байгууллагууд болон прокурорууд хакеруудад хүнд ял өгөх бодлого баримтлана. ТТГ болон ХМТ зэргийг багтаасан АНУ-ын агентлагууд Германы тагнуулын бүлгийг хайж байсан бөгөөд хүнд ял оноолгохыг хүсэж байсан юм. Тэд Германы хакерыг Америкийн шоронд хийх сонирхол асар их байв.

Хагбардын цогцсыг олох үед Германы шүүх ажиллагаа ид дундаа болж байжээ. Тэр амиа хорлосон уу? бусдад хорлогдов уу? Хэн ч үүнийг мэдэхгүй. Гэхдээ түүний цогцос олдсон тухай мэдээлэл хакерын ертөнцөд хүчтэй доргилт өглөө. Хакерууд болсон явдлыг янз бүрээр тайлбарлана. Нэг талаар Хагбард мансууруулах бодис болон сэтгэцийн тогтворгүй байдалд орж байсан учраас сэтгэл мэдрэлийн эмнэлэг, хордлого тайлах төвүүдэд нилээдгүй хугацааг 1987 оноос хойш өнгөрөөсөн ажээ. Нөгөө талаар та өөрийнхаа амийг хорлох бол шатахууны галд үхэх замыг сонгох уу гэсэн асуулт гарч ирж байгаа юм. Эсвэл хурдан сум, унтуулдаг

хэдэн ширхэг эм сонгох уу?

Ямартай ч аллага эсвэл амиа хорлохын аль нь ч бай Хагбардын үхэл Феониксэд ихийг бодогдуулжээ. Австралид ажиллаж байгаа Америкийн хуулийн байгууллагын ажилтан хэн бэ? Тэд түүнийг хайж байгаа болов уу?

Үгүй ээ. Тэд Электроны араас ирсэн гэж Форс батлан хэлэв. Харин Феоникс Электронтой утсаар ярьсаар байгаа нь асуудал үүсгэж болох ажээ. Хэрэв Феоникс Электронтой нийлээд байх юм бол Австралийн Холбооны цагдаагийн газрын торонд орно гэсэн үг.

Феониксэд өгсөн мессэж маш ойлгомжтой байлаа.

Электроноос хол байгаарай. “Сонсож бай чи муу алингаа алдсан гахай минь”

“Юу?” гэж Феоникс үл тоосон байдалтай хариулав.

“Хогийн компьютер. Би бүх засалт, боловсруулалтыг хийсэн, гэтэл энэ муу компьютер өөрчлөлтийг хадгалаагүй байна” хэмээн Электрон унтлагын өрөөний ширээн дээр сууж байхдаа архиран хэлэв. Тэр 512К санах ойтой, Commodore Amiga компьютер руугаа муухай харан сууна.

1990 оны нэгдүгээр сард их сургуулийн хичээл эхлэхээс өмнө Феоникс, Электрон хоёр гэртээ байв.

“Тиймээ, энэ зүйлийг ажиллуулахыг би маш их хүсэж байна. Новш гэж. Чи ажилла л даа” гэж Феоникс ориллоо. Түүнтэй ярих зуураа утасны нөгөө үзүүрт компьютерийн гар дээр юм шивж байгааг Электрон сонсож байв. Тэрээр Unix-ын Apple-д зориулсан хувилбар AUX-ыг Machintosh SE30 компьютер дээр ажиллуулах гэж олон өдөр оролдож байгаа юм.

Феоникстэй саадгүй ярилцлага хийхэд хэцүү байлаа. Компьютер нь зүгээр байгаа эсэхийг түүний өрөөний хаалганы гадна талаас эмээ нь асууна.

“Чи жагсаалтыг эхнээс нь уншуулахыг хүсэж байна уу? Чиний файл чинь хэр зэрэг том юм бэ?” гэж ярианд овоо анхаарч эхэлсэн Феоникс асуув.

“Юу? Ямар файл?”

“Толь бичгийн файл. Пассворд эвдэгч програм руу оруулах үгнүүд” гэж Феоникс хариуллаа.

Электрон толь бичгийн жагсаалтыг татан гаргаж, харав. Энэ жагсаалтыг жаахан хасах хэрэгтэй гэж тэр боджээ. Толь бичиг пассворд эвдэгч програмын хэсэг байлаа. Толь бичиг хир зэрэг том байна пассвордуудын жагсаалтыг эвдэх компьютер цаг их шаардаж байв. Хэрэв тэрээр пассворд болгон сонгож авахааргүй үгнүүдийг хасаж хаявал түүний эвдэгч програм хурдан ажиллах боломжтой ажээ.

Пассвордыг сайн эвддэг програм үнэхээр үнэт хэрэгсэлд тооцогдоно. Электрон хохирогчийн компьютерийг сонгож өөрийн компьютерээ пассворд эвдэгч файлаар тэжээгээд орондоо

орно. Жишээлээд Мелбурнийн их сургууль ч юм уу. Ингээд арван хоёр цагийн дараа тэр өөрийн компьютерийн хийсэн ажлыг шалгана.

Хэрэв тэр азтай байвал файл дотроо хэрэглэгчийн нэр, пассвордыг агуулсан зургаа эвсэл түүнээс олон эккаунтыг олох болно. Ажиллагаа бүхэлдээ автоматчлагджээ. Дараа нь Мелбурнийн Их сургуулийн сүлжээ рүү log хийж, эвдсэн эккаунтыг хэрэглэнэ. Тийм эккаунтыг орон нутгийн телефон утасны дуудлагын үнээр өөр систем рүү хакердах цэг болгон ашигладаг.

Unix-ийн пассвордыг эвдэх нь тийм ч хүндрэлтэй биш. Гэхдээ энэ процесс цаг их шаардагдана. Зарчим нь маш энгийн. Пассвордын файлд холбогдох хэрэглэгчийн нэртэйгээ хадгалагдаж байгаа пассвордууд нь энкриптлэгдсэн байдаг. Хутгасан өндгийг буцаан хэвэнд оруулж болохгүйтэй адилхан энкриптэлсэн процессыг буцаах боломжгүй. Харин танд энкриптлэх процессыг дахин бий болгож, үр дүнг харьцуулах хэрэгтэй болно.

Тэнд гурван үндсэн алхам байна. Нэгдүгээрт, компьютерээ олж сонгоод, пассвордын файлын хуулбарыг авах. Хоёрдугаарт, хамгийн нийтлэг хэрэглэдэг пассвордуудын жагсаалтыг авна. Ингэхдээ пассвордын файлаас хэрэглэгчийн нэрсийг авах эсвэл толь бичгээс үгнүүд авна. Тэгээд тэдгээрийг хоёрдахь жагсаалтанд энкриптлэнэ. Гуравдугаарт, жагсаалтуудыг зэрэгцүүлэн тавиад харьцуулна. Хэрэв та ижил үг олвол пассвордыг оллоо гэсэн үг.

Хэдий тийм боловч тэнд нэг чухал хүндрэл байна. Энэ бол давс. Пассвордыг энкриптэлсэн аргыг давс өөрчилдөг. Өөрөөр хэлбэл DES энкриптлэлтийн алгоритм ажиллах аргыг сайжруулдаг гэсэн үг. Жишээлбэл “Underground” гэсэн үгийг хоёр өөр давсаар хоёр өөр аргаар энкриптэлж болно. “kyvbExMcdAOVM” эсвэл “IhFaTmw4Ddrjw” Хамгийн эхний хоёр үсэг давсыг төлөөлнө. Бусад нь пассвордыг төлөөлдөг. Хэрэглэгчийн пассвордыг энкриптлэхдээ компьютер давсыг сонгож хэрэглэнэ. Олон давснаас зөвхөн нэгийг нь хэрэглэх бөгөөд тэнд 4096 төрлийн ялгаатай давснууд байдаг. Unix-ийн бүх компьютерүүд пассворд энкриптлэх процесстоо давснуудыг ашиглана.

Пассвордыг хакердах үйлдлийг хэцүү болгохын тулд давс гарсан гэхэд болно. Тиймээс хакер толь бичгийг зүгээр нэг энкриптлээд, дараа нь энкриптэлсэн пассвордын жагсаалт бүртэй харьцуулаад хүссэндээ хүрчихгүй юм. 4096 давснууд гэдэг нь 4096 өөр толь бичгийг хакер хэрэглэнэ гэсэн үг.

Электроны нэвтэрсэн нэг систем дээр зөвхөн 25 хэрэглэгч байж болно. Гэхдээ тэнд зөвхөн 25 пассворд байх боловч 25 өөр давсыг хэрэглэсэн гэсэн үг. Энкриптэлсэн пассвордны өмнө давсны үсэг хадгалагдан үлддэг учир хакер тодорхой пассвордыг энкриптлэхэд ямар давс хэрэглэсэн болохыг амархан харж болно. Тэгсэн хэдий ч хакер толь бичгийг 25 удаа энкриптлэж үзэх шаардлагатай юм.

Түүнчлэн янз бүрийн давснуудыг ашиглаж томоохон толь бичгийг 25 удаа энкриптлэнэ гэдэг нь жирийн гэрийн компьютерийн хард драйвын багтаамжийг маш их багасгадаг. Тэгээд энэ бол зөвхөн толь бичиг гэж байгаа. Хамгийн боловсронгуй програмууд нь пассвордны “ухаалаг таалт”-ыг бий болгодог. Жишээлбэл програмхэрэглэгчийн нэрийг аваад том ба жижиг үсгээр тааж үзнэ. Түүнчлэн төгсгөлд нь “1”-ийг хүртэл нэмж болно. Товчхондоо

үсгийн байрлалыг холих, солих, урд хойно оруулах зэргээр хэрэглэгчийн нэрийг шинэ үгэнд хувиргах үйлдлийг хийх агаад шинээр таалт хийдэг юм.

“Энд 24000 үг байна. Балай юм ямар том юм бэ?” гэж Электрон хэлэв. Толь бичгийг танана гэдэг арилжиж тоглохтой адилхан. Толь бичигт цөөн үг байх тусам энкриптэлсэн пассвордыг эвдэхэд компьютер бага хугацаа зарцуулна. Жижигхэн толь бичиг нь өгөгдсөн эхкаунтын пассвордыг эвдэх боломжийг нилээд багасгах агаад таах үг цөөрнө гэсэн үг юм.

“За яах вэ? Минийх 24328 байна. Ерөөсөө хамтраад жаахан таная”

“за тэгье, Чи үсэг сонго”

“С. С-ээс эхэлье”

“Яагаад С гэж?”

“С. Миний эмээгийн муур, Сосоа”

“За за.Ок. Ингээд эхэлье. Cab, Cabal, Cabala, Cabbala”. Электрон хэсэг түдгэлзсэнээ: “Cabbala гэж юу байдаг юм бэ?”

“Мэдэхгүй ээ. За за тэгэхлээр Cabbala бишээ, за юу, Cabaret, cabbage.. Новш гэж . Би байцааг үзэн яддаг. Ийм пассвордыг хүн хэрэглэх үү?”

“Rom хэрэглэнэ” гэж Электрон хариулав. (Rom-англи хүнийг доош хийн ингэж хэлдэг)

“Тиймээ” гэж Феоникс инээд алдлаа.

Заримдаа Феоникс Форсийн сануулгыг мартаж боловч хааяа нэг таагүй санагдангуут түр зуур эргэцүүлнэ. Тэр сэтгэл зовниж байгаагүй гэж хэлэхэд хэцүү ажээ. Форс асуудалд нилээд нухацтай хандсан. Электронтой хамтарч байгаагаа зогсоохоос гадна маш далд чимээгүй байдалд орсон мэт болжээ.

Форс хөгжмийн хоббитой болов. Тэр дуу зохиож, дуулдаг боллоо. 1990 оны эхээр хөгжимдөө их анхаарал тавьж, The Realm-ыг мөсөн дээр орхижээ. The Realm-ын гишүүд бүлгийн өөр гишүүн Ноумын хэсэг дээр цуглардаг болоод сарын нүүр үзэв.

Гэвч түүх ингээд дуусахгүй гэдгийг Феоникс мэдэж байв. Хакер хүн зүгээр л нэг яваад өгчихдөггүй юм. Ялангуяа Форс шиг хүн шүү дээ. Форс бол хакераар өвчилсөн хүн байсан учраас ямар нэгэн зүйл хийх л учиртай. Форсийн өгсөн зөвөлгөөг дагсан Феоникс Электроноос зайгаа авчээ. Ямартай ч түр зуур ч болов зайгаа авсангэхэд болно.

Тэр юу болохыг хүлээгээд л байлаа. Юу ч тохиолдсонгүй. Электрон хакердах ажиллагааг маш идэвхитэй хийсээр байсан боловч түүнийг хэн ч саатуулсангүй. Юу ч өөрлөгдсөнгүй. Магадгүй Форсийн мэдээлэл худлаа байх. Хэрэв мөрдөгчид ямар нэг зүйл хийх гэж байгаа л юм бол Электроныг одоо л оролдох ёстой. Гэвч удалгүй Феоникс Электронтой харьцаагаа сэргээв. Электрон түүний харьцаанд цааргалах байтугай дуртай байлаа.

1990 оны 1-р сард Электрон байнга хакердаж байв. Тэр зөвхөн унтаж байхдаа л хакердах ажлаа завсарлана. Гэвч тэр унтаж байхдаа хүртэл хакердаж зүүдэлдэг байсан гэдэг. Электрон, Феоникс хоёр Мелбурнийн хакеруудыг хойноо хаяжээ. Феоникс Форсоос илүү ур чадвар эзэмшсэнтэй адилхан Электрон Пауерспайкийн туршлагаас хол давуу болж ирэв. Тэд Х.25 сүлжээнээс халж, дөнгөж хөгжиж эхэлсэн интернет рүү анхаарлаа хандуулжээ.

Түүнчлэн шинэ интернет сайтуудын үндсийг бий болгосон Unix үйлдлийн системийн талаар туршлага ихтэй Ноум хүртэл Электроны стандартад хүрэхгүй болов. Түүндхакердах урлагт суралцах ижил түвшний хичээл зүтгэл, агуу хакер болоход шаардлагатай тэвчээр байгаагүй юм. Ерөнхийдөө Электрон ба Пауерспайкын хоорондох харилцааг Ноум, Феоникс хоёр хуулбарласан гэхэд болно.

Электрон Феониксийг ойрын найз гэж үзэхгүй боловч сонирхол нэгтэй, хакер гэж хүндэтгэнэ. Үнэндээ бол чалчаа, Форстой дотно холбоотой Феоникст тэр итгэх үндэс байхгүй юм. Гэхдээ Феоникс ухаантай, сурч мэдэх эрмэлзлэлтэй. Электроны үндэслэсэн мэдээллийн санд Феоникс маш их мэдээлэл цуглана. Бараг түүнээс Феоникс руу илгээсэн мэдээллээс илүү ихийг Электронд өгдөг байв.

Ингээд зуны амралтын үеэр нэг сарын дотор Феоникс, Электрон хоёр байнгын харилцаатай болж, телефон утсаар хүртэл ярилцах болжээ. Заримдаа бүр өдөрт гурав, дөрвөн удаа ярина. Хакердаад ярина. Тэгээд тэмдэглэлээ харьцуулна. Дахин нягтлаад хэдэн асуулт асууна. Тэгээд буцаад хакердах ажилдаа орно.

Бодит хакердах ажиллагаа бол ганцаарчилсан үйлдэл байдаг байлаа. Феоникс шиг нийгмийн амьтан болсон хүний хувьд ганцаардсан аялал мэт санагдана. Ихэнх хакерууд баяр баясгалан, шинэ нээлтээ ганцаар тэмдэглэдэг. Харин Феониксийн хувьд хэн нэгэнтэй хуваалцах хүсэл их байдаг аж. Гэхдээ зүгээр л нэг хүн биш, түүнийг ойлгодог, ижил зорилго мэдлэгтэй хүнтэй хуваалцах шаардлагатай.

“Caboodle. Caboose” хэмээн Электрон үргэлжлүүлнэ. “Cabriolet. Ер нь Cabriolet гэж юу гэсэн үг вэ? Чи мэдэх үү?”

“Тиймээ” гэж Феоникс хариулаад цааш үргэлжлүүлэн: “Ок. Cacao, Cache.Cachet...”

Юу гэсэн үг вэ? надад хэлэл дээ гэж Электрон Феониксийн яриаг таслав.

‘Cachinnation. Cachou...’

“Чи тэгээд мэдэж байгаа юм уу үгүй юм уу?” гэж Электрон бага зэрэг уурсангүй асуулаа. Феоникс мэдэхгүй зүйлээ мэддэг гэж хэлдэг зан байдаг ажээ.

“Хмм? Өө тийм” гэж Феоникс сулхан хариулаад “Cackle. Cacophony...” гэж хэлэв.

Заримдаа Феоникс үгүй гэсэн утгыг “yeah” гэж хэлдгийг Электрон мэдэж байлаа. Тэгээд ч Феониксийн хэлсэн ихэнх зүйлд Электрон итгэдэггүй зантай байв. Түүнд ямар нэгэн хөдөлшгүй нотолгоо л байхгүй бол Электрон түүний ярьсныг салхи мэт үздэг аж. Тэр

Феоникстэй ярилцахад хүндрэлтэй үе их тохиолддог тул анд найз бөгөөд хакер Пауерспайктай цагийг өнгөрөөх сонирхолтой байлаа.

Пауерспайк хөгжилтэй, бүтээлч залуу учир Электронд таатай байдаг аж. Тэд хөгжмийн таагүй урсгалын талаар байнга хошигнож, тоглоом хийнэ.

Пауерспайк хүнд метал урсгалд дуртай харин Электрон энэтхэг хөгжим сонсдог байлаа. Тэд эрх баригчдыг үл хүндэтгэсэн үзэл бодлоороо нийлнэ. Тэд хакердах ажиллагаагаа чиглүүлэх NASA эсвэл АНУ-ын Тэнгисийн цэргийн судалгааны лабораториудын эрх баригчдын эсрэг төдийгүй The Realm-ийн эзнийг үл хүндэлдэг байв. Улс төртэй холбоотой асуудал дээр тэр хоёр зүүнтнийг баримтлана. Гэсэн хэдий ч улс төрийн намд нэгдэхээс илүүтэй цэргийн аж үйлдвэрлэл, анархизмийн эсрэг тэмцэх сонирхол давамгайлах ажээ.

The Realm-ээс хөөгдсөний дараа Электрон хэсэг хугацаанд тусгаарлагдсан байна. Түүний хувийн амьдралд тохиолдсон эмгэнэлт явдал ганцаардал дээр улам дарамт учруулжээ. Найман настай байхад нь түүний ээж уушгиний хорт хавдраар өнгөрчээ. Ээж нь Германы хорт хавдрын эмнэлэгт нилээд хугацаа өнгөрөөсөн учир сүүлийн хоёр жил ээжийгээ хэрхэн шаналсныг хараагүй байлаа. Ээжийгээ сүүлчийн өдрүүдээ өнгөрөөхөөр буцаж ирэхэд Электрон түүнийг харж суухаас өөр аргагүй байсан юм.

Нэгэн шөнө эмнэлгээс утасны дуудлага хүлээж аваад, чухам юу тохиолдсоныг Электрон шууд ойлгов. Түүний аав утасны харилцуурыг авах агшинд тэр уйлж байлаа. Хөвгүүнд хүнд байсан тэр үед учир ойлгохгүй зургаан настай охин дүү нь нэг их эмзэглээгүй юм.

Электрон охин дүүтэйгээ ойр дотно байсангүй. Тэрээр охин дүүгээ мэдрэмжгүй, хөндий хүн шиг төсөөлөх бөгөөд ээжийнх нь үхлийн дараа аав нь дүүд нь илүү анхаарал тавих болжээ. Магадгүй эхнэртэй нь хамгийн адилхан учраас илүү хайрласан биз. Үүнээс хойш ах дүү хоёр их хөндий байх болов.

Орон нутгийн дээд сургуульд урлагийн хичээл заадаг, зураач мэргэжилтэй Электроны аав нь эхнэрээ нас барснаас хойш сэтгэлээр унажээ. Нийгмийн гарал үүсэл, мөнгө санхүүгийн ялгаа байсан хэдий ч тэдний гэрлэлт агуу аз жаргалыг авчирсан байлаа. Электроны гэрийн ханаар аавынх нь зурсан зураг дүүрэн байдаг байв. Харин түүний ээжийн үхлээс хойш аав нь бийр барихаа больжээ. Энэ тухай ч эргэн яриагүй гэдэг. Нэгэн удаа, та яагаад зурахгүй байгаа юм бэ гэж асуухад аав нь: “Өөр тийшээ харангуутаа би зураг зурах хүсэл тэмүүлээ алдсан” гэж хэлжээ.

Электроны эмээ нь хоёр хүүхдийг асран хүмүүжүүлэхэд туслахаар ирсэн боловч өөрөө Алцхаймерийн өвчнөөр шаналж байв. Тэр хүүхэд харах биш харин хүүхдүүд түүнийг сувилах болжээ. Тэр үед нэрийг чинь санахгүй хэн нэгнийг асарч сувилна гэдэг залхмаар ажил хэмээн Электрон боддог байлаа. Удалгүй эмээг нь асрамжийн газар руу шилжүүлжээ.

1989 оны 8-р сард аав нь эмчид үзүүлээд гэртээ ирэв. Зарим үед аав нь бага зэрэг өвдөх боловч эмчид үзүүлэхээс татгалздаг байв. Сүүлийн таван жилд нэг өдөр л чөлөө авсан аав нь өөрөөрөө бахархаж байжээ. Ингээд амралтын өдрүүдэд эмчид үзүүлж баахан шинжилгээ өгсний дараа хариу гарчээ. Электроны аав ходоодны хорт хавдар тусаж, халдвар бүх биеэр нь

тархжээ. Эмчилгээгүй өвчин туссан аавд нь хоёр жил амьдрах нас үлдсэн байна.

Тэр үед Электрон арван есөн нас хүрч компьютер модемд ихэд татагдах болов. Хэдэн жилийн өмнө аав нь түүний сонирхлыг дэмжиж, сургуулийн AppleIIe компьютерийг амралтын өдрүүдэд гэртээ авчирах болжээ. Түр зуур хэрэглэхээр авчируулсан компьютер дээр Электрон олон цагийг өнгөрөөнө. Тэр компьютер дээр тоглоогүй үедээ аавынхаа дуртай ном “Бөгжний Эзэд”-ийг уншдаг байв.

Компьютер анх удаагаа хэрэглэж эхэлснээс хойш Электрон компьютерийн програм бичих сонирхолд хөтлөгджээ. Тэрээр арван нэгэн настай байхдаа ном ашиглан, цаасан дээр жирийн програм хангамж бичиж байв. Ихэвчлэн тоглоомын програм бичдэг байсан Электрон компьютерийн гар дээр юм шивж үзээгүй байжээ.

Түүний сургууль нь хэдхэн компьютертэй байсан бөгөөд администратор нь юу хийхээ ч мэддэггүй байв. Электрон есдүгээр ангид байхдаа сургуулийн зөвлөхтэй уулзаж, компьютертэй ажилладаг мэргэжлийн тухай ярилцжээ.

“Би компьютерийн програм бичдэг сургалтанд суухыг хүсэж байна..” хэмээн эргэлзсэн маягтай сулхан хэлэв.

“Чи яагаад тэгэхийг хүсэж байгаа юм бэ? Чи түүнээс өөр гайгүй мэргэжил бодож болохгүй байна уу?” гэж эмэгтэйд асуухад “Хмм..” гэж түгдрэв. Электрон юу хэлэхээ мэдэхгүй байв. Тэр юу хийхээ огт мэдэхгүй байлаа. Тиймээс л тэр зөвлөх дээр ирсэн шүү дээ. Тэр компьютер дээр ажиллах боломж олгох өөр ямар нэгэн мэргэжлийн тухай санааг олохоор эргэн тойрноо харна. “Тэгэхлээр, нягтлан бодох ч юм уу?”

“Тиймээ тэр чинь дажгүй сонсогдож байна шүү” гэж тэр хэлэв. “Чи их сургуульд орж, нягтлан бодох мэргэжлээр суралцаж болно. Чамайг баяртай байх болно гэдэг би итгэлтэй байна ” гэж эмэгтэйд хэлээд хавтсаа хаажээ.

Электроникийн үзэл бодлоор сургуулийн компьютерийг ашиглаж болдог нь авахууштай ганц сайн тал байлаа. Тэр сургуульдаа их хүчин чармайлт гаргадаггүй учраас сурлага доогуур байв. Багш нар нь ангийн бусад хүүхдэд нөлөөлдөг, биеэ дайчилдаггүй гэж аавд нь ховлоно. Энэ шүүмжлэл нь зүгээр л нэг ялаа дүнгэнэх төдийд л нөлөө үзүүлсэн гэхэд болно. Заримдаа Электрон бусад хүүхдээс хамаагүй давуу амжилт үзүүлэх тул түүнийг авьяас чадвартай гэж хэсэг багш үздэг байв. Электрон арван зургаан настай байхдаа анхныхаа компьютерийг авчээ. Тэрээр Партай адилхан програм хангамжийн хамгаалалтыг эвддэг байв. Удалгүй Apple компьютер нь 20 мега байт багтаамжтай, IBM-тай энэ зэрэгцэх илүү хүчирхэг Amiga компьютерт байраа тавьсан юм. Түүний унтлагын өрөөний хоёр ширээний нэг дээр компьютерүүд өрөөстэй харагдана. Хичээлийн даалгавараа хийхэд зориулагдсан хоёр дахь ширээн дээр нь хүний гар хүрээгүй дэвтрүүд овоолоостой байдаг байлаа.

Электроны өрөөний шалан дээр дот матриктэй принтерээр хэвлэсэн цааснууд хөглөрөн хэвтэнэ. Жирийн тавилгатай өрөөний хаана ч зогсож байсан компьютерийн програм код эсвэл пассворд, хэрэглэгчийн нэрийг агуулах цаасыг багцаар нь авчих боломжтой харагдана. Овоолон тавьсан цаасны хоорондуур жинсэн өмд, подволка, шаахай, номнууд хөглөрчээ.

Ямар нэгэн зүйл дээр гишгэчихгүйгээр Электроны өрөөнд алхана гэдэг боломжгүй байв.

1986 онд 300 баудын хэрэглэсэн хуучин модемыг Электрон худалдан авсан явдал түүний сонирхлыг орвонгоор нь өөрчилсөн юм. Худалдаж авсан модем нь Электроны компьютерийг гайхамшигт ертөнц болгон хувиргана. Түүнийг модемтой болохоос өмнө эхний семестерийн хичээлийн дүн зургаан “А”, нэг “В” байсан бол дараагийн семестерт зургаан “В”, нэг “А” болж хувирчээ.

Сургуулиа төгсөхөөс илүү том ирээдүйтэй зүйлд Электрон амташсан байлаа. Тэр маш хурдан нууц BBS-ийн байнгын хэрэглэгч болж, хакердаж эхлэв. Компьютерийг хакердан огторгуйд байгаа хиймэл дагуулыг байрнаас нь хөдөлгөсөн хакеруудын тухай нийтлэлийг Электрон уншаад сэтгэл нь ихэд хөдөлжээ. Тэр цагаас хойш нийтлэл үнэн худал болохыг олж тогтоохын тулд хакердах сонирхолтой болжээ.

1987 онд сургуулиа төгсөхөөс өмнө Электрон NASA-гийн компьютерийг хакердаад “Би NASA руу орчихлоо, Би NASA руу орчихлоо!” хэмээн галт тогооныхоо ширээг тойрон гүйж байсан гэдэг. Тэр ямар нэгэн хиймэл дагуулыг хөдөлгөж чадаагүй боловч, сансрын агентлагийн сүлжээ рүү нэвтэрсэн ажиллагаа сар руу нисэж байгаа мэт байлаа. 1989 онд гэрийн ганцхан утасны шугам модемтой байнгын холбоотой байгаагаас нийгмийн амьдралаас хөндийрлөө гэж охин дүү нь гомдоллож, олон жил хакердсан Электрон цухалдах болжээ.

Феониксийн хувьд Электрон бол түнш хакер, хамгийн багаар бодоход багш байв. Тухайн үед Электрон The Realm-аас илүү зүйлийг Феоникст санал болгож байлаа.

“cactus, cad, cadaver, caddis, cadet, caesura.. Caesura гэж юу гэсэн үг вэ?” хэмээн “С” үсгээр эхэлсэн үгсийг шүүрдэж байх зуураа Феоникс асуув.

“Мэдэхгүй, хасчихгүй юу” гэж Электрон цухалдангуй хэллээ.

“Ceasura. За за. Би ийм л үгийг пассворд болгох байлаа” гэж Феоникс инээгээд “Ер нь Cadecues гэж ямар утгатай үг байна аа? Аан?” гэлээ.

“Хэн нэгэн үхсэн хүн биз дээ. Тийм үгнүүдийг хасчихаа. Ийм толь бичгийг хэн хийдэг юм бэ?” гэж Электрон хэллээ.

“Харин тиймээ”

“Caisson, Calabash бүгдийг хас. Хас. Хас” хэмээн Электрон хөгжилтэйгээр хэлнэ.

“Байж байгаарай, Миний жагсаалтанд яагаад Calabash гэсэн үг байдаггүй билээ?” гэж Феоникс зэвүүцсэн дүр үзүүлэн шогшироход Электрон инээв.

“Хөөе, бид ‘Qwerty, ABCDEF, ASDFGH’ гэж компьютерийн гар дээрх товчлуурын байрлалаар үзэх ёстой юм биш үү гэж” Феоникс санал гаргалаа.

“Тэрийг чинь аль хэдийнээ хийчихсэн” гэж хэлэхэд Феоникс дахиад л эхнээс нь “та тэгвэл

Со-оос эхлэе. Commend, Comment, Commerce, Commercial, Commercialism, Commercially” гэж уншаад сүүлийн гурвыг хас гэж тушаав.

“Яагаад Commercial-ийг хасах гэж?”

Феоникс: “Ер нь наймаас илүү үсэгтэй үгнүүдийг шууд хасъяа”.

Электрон: “Үгүй ээ. Наадах чинь нэг их сайн санаа биш байна.”

Феоникс: “Юу гэсэн үг вэ? Компьютер зөвхөн эхний найман үсгийг уншиж, энкриптэлдэг шүү дээ. Тиймээс үлдсэнийг нь хасах хэрэгтэй болно.”

Заримдаа Феоникс өөрийнхөөрөө зүтгэнэ. Харин Электрон үүнийх нь эсрэг нэг их довтлоод байхгүй ажээ. Тэрээр Феониксийн хэлсэн санааг хугалахгүйгээр чимээгүй өнгөрөөнө. Феоникс ахмад хакеруудын зөвшөөрлийг авахыг эрмэлздэгийг Электрон мэдэрсэн хэдий ч санаа нь утга төгөлдөр бус байдаг байв.

“Чи боддоо. Хэн нэгэн хүн Commerce эсвэл Commercial гэсэн бүхэл үгийг хэрэглэж болно. Тэдгээр үгнүүдийн эхний найман үсэг нь ижилхэн биш байгаа биз дээ. Commerce гэсэн үгний сүүлийн үсэг ‘e’ харин Commercial гэсэн үгнийх ‘L’ байгаа биз дээ” гэв.

Тэр хэсэг чимээгүй суулаа.

Электрон: “Тэгэхлээр Commercial гэсэн үгний араас гарч ирэх Commercially, Commercialism гэсэн үгнүүдийг бүгдийг хасчихна шүү дээ. Ойлгов уу?”

Феоникс: “Аан за за. Ойлголоо”.

Электрон: “Тиймээс наймаас илүү үсэгтэй үг бүрийг шууд хасчихаж болохгүй ээ” хэмээн нэмж хэлэв.

Феоникс: “За за” гэж дурамжхан хэлээд гэнэт “миний компьютер зогсоод бүхэл бүтэн арван минут болсон байна” гэж хэллээ.

Электрон: “Тийм үү” гэж сонирхсон янзтай асуухад

Феоникс: “Тиймээ, бидэнд Deszip маш их хэрэгтэй байна. Түүнийг л олъёо доо” гэж дуртай сэдэв рүүгээ яриаг эргүүллээ. Deszip бол пассвордыг илрүүлэхэд хэрэглэдэг компьютерийн програм байсан юм.

Электрон: “Тэгээд бас Zardoz. Бидэнд Zardoz хэрэгтэй” гэж нэмлээ. Zardoz бол компьютерийн аюулгүй байдлын цоорхойг нарийвчлан харуулдаг хориотой програм хангамж байв.

“Тиймээ. Спафын компьютер руу нэвтрэхийг хичээе. Спафд найдвартай байгаа даа” гэв.

Евгене Спаффорд бол АНУ-ын Пурдугийн Их сургуулийн Компьютерийн шинжлэх ухааны

дэд профессор бөгөөд 1990 онд интернетийн чиглэлээр компьютерийн аюулгүй байдлын хамгийн алдартай мэргэжилтэн болсон хүн юм.

“Тийм шүү”.

Ингээд тэд алтан цөгцний эрэлд гарлаа.

Олон улсын хэмжээнд Unix үйлдлийн системтэй компьютерийг хакерддаг хүмүүсийн хамгийн их хүсэн мөрөөдөх програм хангамж бол Deszip болон Zardoz байв.

Пассвордыг хакердана гэдэг цаг их шаардсан ажил байжээ. Их сургуулийн хүчирхэг компьютерүүд хүртэл иймэрхүү тооцоолох үйлдлийг хийх команд өгвөл хүрхэрч, шуухитнаад хэцүүхэн болдог байв. Харин Deszip програм ачааллыг зохицуулж, ажиллах чадвартай агаад харьцуулбал хөнгөн шингэн ажиллах ажээ. Энэ програм хангамж маш хурдан ажиллах бөгөөд энкриптэлсэн пассвордыг 25 дахин хурдан эвдэнэ.

Zardoz бол дэлхийн хэмжээний аюулгүй байдлын мейлинг жагсаалт юм. Түүнийг өөр шалтгаанаар ашиглахаас гадна нилээд чухалд тооцдог байв. Жагсаалтыг “Security Digest” гэж албан ёсоор нэрлэх боловч хакерын ертөнцийнхөн үүнийг анх илгээсэн компьютерийн нэрээр нь Zardoz хэмээн нэрлэжээ. Түүнчлэн алдарт жүжигчин Шон Коннерийн тоглосон киноны нэр Zardoz байсан юм. Нейл Горсучын ажиллуулдаг Zardoz мейлинг жагсаалт нь компьютерийн аюулгүй байдлын салбарын янз бүрийн түвшний мэргэжилтнүүдийн нийтлэлүүд, зөвлөмж, мэдээллийг агуулна. Мэдээлэл, зөвлөмж дээр шинээр илрүүлсэн цохнууд, компьютерийн руут “access”-ыг олж, нэвтрэхэд тулгарсан асуудлыг хэлэлцдэг байв. Үүнд тодорхойлсон програмууд болон үйлдлийн системийг ашиглаж, компьютерийн ямар ч систем дээр ажиллах цохнуудын тухай Zardoz дээр дурьдана. Zardoz дээр бичигдсэн програм хангамжийг ашигладаг ямар ч их сургууль, цэргийн байгууллага, судалгааны хүрээлэнгийн компьютерийн системийг мууд тооцно. Zardoz бол цоож бүрт таарах түлхүүрийн цуглуулга байлаа.

Zardoz дээр гарсан тодорхой мэдээлэл, зөвлөмжийг уншсан системийн администраторууд тэрхүү аюулгүй байдлын цоорхойг хаах арга хэмжээг авдаг нь үнэн юм. Гэхдээ тэрхүү цоорхой болон Zardoz дээрх мэдээлэл гарах хооронд маш урт хугацаа шаарддаг гэдгийг аль ч хакер мэдэх ажээ. Олон компьютер дээр ажиллаж байгаа цохны тухай аливаа мэдээлэл Zardoz дээр зарлагдахаас өмнө хэдэн сар, заримдаа хэдэн жил болно.

Яагаад? Цохны тухай анх удаа зарлагдахад олон админууд урьд өмнө сонсож байгаагүй санагдана. Zardoz бол тусгай клуб бөгөөд ихэнх админууд гишүүн болж амжаагүй байдаг. Та зүгээр л хандаад, Zardoz дээр sign up хийчихгүй ээ. Таныг компьютерийн аюулгүй байдлын салбарын олон мэргэжилтэн хянаж шалгах болно. Та их сургууль болон судалгаа шинжилгээний байгууллагын хууль ёсны компьютерийн системийн администер байх ёстой. Өөрөөр хэлбэл мэргэжилтнүүд Zardoz-ын гишүүдийн мейлинг жагсаалтыг маш няхуур шалгаад Zardoz-ын клубт элсүүлэх үнэ цэнэтэй эсэхийг шалгадаг гэсэн үг юм. Дэлхийн компьютерийн системийн аюулгүй байдалтай холбоотой агуу нууцыг хуваалцахын тулд тухайн админд итгэж болох эсэхийг зөвхөн тэр мэргэжилтнүүд шийддэг байв. 1989 онд компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтэн буюу цагаан малгайтнууд буруу хүмүүсийн

гарт Zardoz-ыг оруулчих вий гэхээс ихэд эмээж байв. Zardoz нь цоо шинэ урлагийн агуу жишээг маш ихээр дэлгэн харуулах талбар болсон байлаа. Компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд “хоолны ном”-ны адил шинэ цохны тухай маш дэлгэрэнгүй тайлбарыг хийдэг байв. Энэ байдлаас болж компьютерийн аюулгүй байдлын салбар дотор томоохон маргаан дэгдэж эхэллээ. Zardoz дээр хүмүүс бие биетэйгээ шулуухан л хандах юм бол их тустай гэж хүмүүс үзэх болов. Тэд аюулгүй байдлын тодорхой цоорхойг хэрхэн ашиглах талаар нэг бүрчилсэн, дэлгэрэнгүй тайлбарыг Zardoz дээр тавихыг хүмүүс хүснэ. Хакерууд ямар нэг аргаар цохны тухай мэдээлийг олж хүртэх учраас тэднийг холхон байлгах арга зам бол аюулгүй байдлыг зохих ёсоор хангах явдал юм. Тэд мэдээлэл олох сувгыг бүрэн хаалттай байлгахыг хүсэж байв.

Нөгөө талаар компьютерийн аюулгүй байдлыг хянах, удирдах төрлийн ажилтай хүмүүс Zardoz дээр мэдээлэл цацах явдал маш их эрсдлийг дагуулна гэж маргана. Zardoz буруу хүмүүсийн гарт орвол яах вэ? Яагаад арван зургаан настай хакер мянга мянган хүний компьютер руу нэвтрэх зааварчилгааг алхам алхмаар аваад сууж байх ёстой гэж ! Хэрэв чи аюулгүй байдалтай холбоотой чухал алдааг олж харвал хамгийн хязгаарлагдмал хүрээнд үнэлгээ авах учиртай.

Zardoz дээрх зөвөлгөөг дэлхийн түвшний Электрон шиг хакерууд уншаад хэдэн өдөр, магадгүй хэдэн цагийн дотор цоорхойг ашиглавал юу тохиолдох вэ? гэдгийг зарим нэг хүмүүс ойлгохгүй байгаа юм. Тэд аюулгүй байдлын цохоор хоол хийх хувилбарыг хялбархан бичнэ шүү дээ.

Ихэнх хакерууд нэр хүндтэй институтийн компьютер дээрхи системийн администраторийн цахим шуудантай ноцолдож байх зуураа Zardoz-ын нэг хоёр асуудалтай заавал тулгардаг. Мөн Алтосын элит хакеруудын нэг нь ч бүх асуудлыг хамарсан бүхэл бүтэн архивтай байхгүй. Тийм хакер байлаа гэж үзэхэд хамгийн багадаа 1988 оноос хойшхи компьютер сүлжээний аюулгүй байдлын алдарт мэргэжилтний нээсэн томоохон цоорхойн тухай л мэдээлэлтэй байх болно.

Zardoz-той адилхан Deszip-ийг мөн адил сайн хамгаалдаг байв. Энэ програм хангамжийг Нью Хампшайре дах Айви Лийг коллеж, Дармоутад багшлах ажил хийхээсээ өмнө NASA-гийн компьютерийн институтэд ажиллаж байсан компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтэн, доктор Матьюв Бишоп бичсэн юм. Deszip програмын хамгийн хурдан энкриптлэх алгоритмыг АНУ-ын засгийн газраас маш чухал нууцад тооцож, цэргийн зэвсэглэлийн хэмжээнд үнэлж байв. Энэ програмыг АНУ-аас экспотрлохыг хууль бус хэмээн тооцсон билээ.

Мэдээж 1990 онд хэдэн хакерууд Zardoz, Deszip програмыг зэвсэг болгон ашиглах замыг нээсэн юм. Бодит байдал дээр хэдхэн хүн энэ тухай мэдэж байв. Эдгээр хүмүүсийн дотор Британий Пад, Гандалф, мөн Электрон, Феоникс нар багтаж байлаа. Герман дахь Алтос дээр цугларч бусадтай нууц бүлэг болон ажиллах хакерууд тэдний алтан цөгцийг хадгалж байгаа гэж үзсэн сайт руу болгоомжтой довтолно. Тэдний довтолгоо маш аргачилсан, өндөр стратегитай, мэдээллийг задлан шинжлэх асар няхуур ур чадварыг агуулна. Компьютер руу бусад хакерууд бүдүүлэг дайралт хийж байх зуур Алтосын нууц бүлэг компьютерийн аюулгүй байдлын хүрээний өгзгөн дээр нь халуухан жин тавих ажиллагааг хийхэд ихэнх цагаа

зарцуулж байлаа.

Тэд компьютерийн аюулгүй байдлын лидер болсон өндөр түвшний хүмүүсийн компьютерийг довлох албан бус жагсаалтыг гаргажээ. Zardoz дээр урд өмнө гарсан нэг, хоёр зөвөлгөөг унших зуураа аюулгүй байдлын цохноос гадна нийтлэл, зөвөлгөө бичсэн хүмүүсийн хаяг, нэрсийг олж тогтооход Электрон анхаарлаа төвлөрүүлнэ. Zardoz дээр байнга бичих зохиогчдын нэрсийг довлох жагсаалтанд шууд оруулдаг гэхэд болох ажээ. Тэдгээр хүмүүс өөрсдийн компьютер дээрээ Zardoz-ын архив, Deszip-ийн хуулбарыг хадгалж байх магадлал өндөр байдаг юм.

Хожмоо Deszip програмд хэрэглэх болсон оригиналь энкрипт DES (Data Encryption Standard – дата энкриптлэх стандарт) буюу Deszip-ийн тухай мэдээллийг хайж Электрон дэлхийн сүлжээгээр хэсүүчилнэ. Тэр Финландын Тампере Их сургууль, Мелбурнийн Их сургууль, Нью Жерсей дэхь Рутгерсийн Их сургууль, Хелсинкийн Технологийн Их сургууль, Вашингтон дахь АНУ-ын тэнгисийн цэргийн судалгааны лаборатори, Нью Йоркийн Их сургууль зэрэг институцуудын компьютер дотор ан хийж байв. Гэвч үр дүн муу байлаа. Тэрээр Deszip-ийн програмыг бус харин DES алгоритмд хэрэглэдэг public domain-д энкрипт хийдэг CDES програмын хуулбарыг олжээ. CDES-ыг файл энкриптлэхэд хэрэглэхээс бус пассвордыг эвдэхэд хэрэглэдэггүй байлаа.

Гэвч Австралийн хоёр хакер Deszip-ийн амтыг аваад ихэд хангалуун байв. Тэд 1989 онд Баавгай нэртэй Дартмоундын коллежийн компьютер руу нэвтэрчээ. Баавгай компьютерийн буланд болгоомжтой хургах Deszip програм өөр институтийн аюулгүй компьютер руу програмын хуулбарыг шидэж байгааг тэр хоёр нээв.

Энэ бол хоосон ялалт мэт харагдаж байлаа. Deszip-ийн энэ хуулбар нь дэлхийн хоёрдугаар дайны үед хэрэглэж байсан Герман Энигма компьютерийн програм дээр үндэслэсэн Crypt-ээр энкриптлэгдсэн байв. Энкриптийн цоожийг тайлах түлхүүргүйгээр Deszip-ийг тайлах аргагүй юм. Тэд гар хүрч болохгүй үнэт эдлэл “Deszip” гэсэн нэртэй файлыг алмайран харж суухаас өөр зүйлийг хийж чадсангүй.

Гэвч хакерууд үүнд бууж өгөлгүй энкриптэлсэн файлыг хадгалахаар шийджээ. Магадгүй тэд хаа нэгтээ жишээлбэл өдөр бүр хакерддаг хэдэн арван шинэ компьютерийн цахим шууданд энкриптийн цоожийг тайлах түлхүүрийг олж болох юм. Тэд энкриптэлсэн Deszip файлд хүний анхаарал татахгүй нэр өгч өөрчлөөд компьютерийнхээ харанхуй буланд хадгалж орхилоо. Даатгалын бодлого давхар явуулах нь ач холбогдолтой байж болно гэж үзсэн учраас энкриптэлсэн Deszip файлын хоёр дахь хуулбарыг Гандалфад өгөв. Австралид байгаа хуулбар алга болсон тохиолдолд ашиглах зорилгоор Английн Гандалфийн компьютерт хадгалсан ажээ.

1990 оны нэгдүгээр сард Электрон Zardoz-д анхаарлаа хандуулав. Zardoz-ын хуучин хуулбарыг анхааралтай ажиглаж байгаад жагсаалтанд Мелбурн дахь системийн админ байгааг Электрон олж мэджээ. Тэр хүний компьютерт Zardoz-ын архив байх магадлал өндөр байлаа. Гэтэл тэр компьютер Электроны гэрээс нэг цаг хагас машинаар давхих ойрхон газарт байж байдаг. Электронд CSIRO руу нууцаар нэвтрэх л үйлдэл хийх ёстой байв.

Английн колони орнуудын шинжлэх ухаан, аж үйлдвэрийн судалгааны байгууллага CSIRO бол засгийн газрын мэдэлд байдаг бөгөөд Австрали тивийн олон газарт өөрийн офистой байлаа. Электрон зөвхөн тэдний нэг рүү л нэвтрэхэд хангалттай. Тэр Мелбурнийн Их сургуулийн буланд байрлах 55 Барри стрийт, Карлтоны Мэдээллийн Технологийн хэлтсийн сүлжээ рүү нэвтэрчээ.

Электрон Мелбурнийн их сургуулийн компьютерээр хэсүүчилж, системийн админы эзэмшилд байсан Zardoz-ын архивын нэг хуулбарыг олжээ. Файлыг цуглуулж нэгтгээд өөрийн компьютер руу download хийж байтал Zardoz-ын хуулбар түүний компьютерээс аажуухан устаж, Их сургуультай холбогдсон холболт нь гэнэт тасрав. Админ хакерыг илрүүлээд холбоог шууд тасалжээ. Тэр CSIRO-ийн нэг компьютер дээр байгаа Zardoz-ын хуулбарыг Электрон олох хүртэл бүхнийг эхнээс нь хийв.

1990 оны 2-р сарын 1-ний өдөр үүрийн 3 цагийн орчим Электрон ид дундаа ажиллаж байв. Тэр DITMELA хэмээн нэрлэдэг CSIRO-ийн компьютерийн Ворслей нэртэй эккаунт руу амжилттай нэвтрэхдээ илгээсэн цахим шуудангийн цохыг хэрэглэжээ. DITMELA бол Мелбурнийн Мэдээллийн технологийн “А” зэрэглэлийн компьютер байх гэж Электрон боджээ.

Андрей Ворслейгийн эккаунтэнд байгаа фолдеруудыг Электрон шүүж эхэллээ. Тэр Zardoz-ыг урьд өмнө харсан учраас компьютерийн хаа нэгтээ байх ёстой гэдгийг мэдэж байв. Аюулгүй байдлын өөр цоорхойгоор нэвтэрч болно гэж итгэсэн Электрон болгоомжтой нэвтэрч чаджээ. Энэ үед үд өнгөрч байсан учраас гадны этгээдийг олж тогтоох магадлал өндөр, хакердах таатай цаг хугацаа гэж үздэг. Тиймээс Электрон үүнийг зөвхөн тагнан турших даалгавар гэж өөртөө хэллээ. Компьютер дээр Zardoz байгааг олж тогтоовол хурдан гарч, сүүлд эргэн ирэхээр төлөвлөжээ. Мэдээж тэр шөнө дундын үед Zardoz-ыг авахаар эргэн ирнэ.

Ворслейн фолдер дотор Zardoz-ын иж бүрэн цуглуулгыг олонгуут Электрон шүүрч аваад зугатаахыг хүсэж байв. Гэвч түүний удаан модем хурдан зугатах боломжийг олгосонгүй. Zardoz-ыг download хийж авахад хэдэн цаг зарцуулагдана. Zardoz-ыг авах омгоо дарх Электрон компьютерээс чимээгүйхэн гарч явлаа.

Маргааш өглөө эрт DITMELA руу Электрон нэвтэрч шууд Ворслейн фолдер руу чиглэв. Zardoz түүнийг хүлээж байлаа. Zardoz-ын урдны дугаарт гарч байсан компьютер руу нэвтрэх аюулгүй байдлын цохыг Электрон ашиглаж байгаа нь хамгийн инээдтэй санагдаж байв. Энэ цох бүх архивыг хуулбарлаж авахад түүнд туслах юм.

CSIRO-ийн машинаас Zardoz-ыг гаргаж авна гэдэг тийм ч амар бус ажил байх болно. Архив том хэмжээтэй учраас секундэд 30 үсэг дамжуулах, 300 баудын модемоор татаж авахад таван цаг зарцуулах ёстой. Zardoz-ын бүх дугаарыг хуулбарыг 500 к файл болгон шахахад Электрон CAT командыг ашиглав. Тэр шинэ файлыг .t гэж нэрлээд DITMELA-ийн түр зуурын фолдерт хадгаллаа.

Дараа нь юу хийхээ тэр бодов. Тэр олзоо аюулгүй хадгалахын тулд CSIRO-ийн компьютерээс гаднах өөр нэгэн эккаунт руу Zardoz-ын шахмал захиаг илгээхээр шийджээ. Гэвч түүний дараа Электрон сонголт хийх ёстой болно. Олзоо өөрөө татаж авах эсвэл Феоникс руу

утасдаж, түүгээр татаж авахуулна.

2400 баудын модемтой Феоникс Zardoz-ын файлыг Электроны компьютерээс найм дахин хурдан татах боломжтой юм. Нөгөөтэйгүүр CSIRO-ийн компьютер руу нэвтрэх нууцыг Феониксд өгөхийг Электрон хүсэхгүй байлаа. Тэд CSIRO-ийн компьютерийг хараандаа авсан байсан хэдий ч амжилтаа Феониксд хэлээгүй байжээ. Феониксийг аюулгүй байдлын файлыг уншуулж, үзэл бодлоо уралдуулахыг Электрон хүсэх авч найдваргүй зангаас нь болж бодлоо өөрчилсөн аж.

Компьютерийн гар дээр юм шивж байхдаа Электрон өөрийн шийдвэрээ гаргаж байлаа. Тэр Мелбурнийн Их сургуулиас хакердсан оюутны хоёр экаунт руу Zardoz-ын шахсан файлын хуулбарыг цахим шуудангаар илгээхын тулд хурдан шивж байв. Хоёр экаунтын пассвордоор тэр хүссэн газраа хүрэх агаад үнэтэй ачаагаараа дэнчин тавихыг Электрон хүсээгүй юм. Хоёр экаунт нэгээс илүү найдвартай ажээ. Нэг нь гол экаунт нөгөө нь эхний экаунтын пассвордыг сольсон тохиолдолд хэрэглэх хамгаалалтын экаунт болно.

DITMELA-ийн компьютер Zardoz-ын файлыг цахим шуудангаар илгээх процессыг хийж байтал Электроны холболт гэнэт тасарлаа.

CSIRO-ийн компьютер холбоогоо тасалсан явдал нэг зүйлийг илэрхийлэх нь гарцаагүй байв. Админ түүнийг log off хийжээ. Электрон маш их уурлав. Шөнийн цагаар администратор юу хийж байдаг билээ? Админ унтаж байх ёстой биш билүү! Тийм учраас л Электрон түүний компьютер руу log on хийсэн шүү дээ. Эрсдэл маш өндөр байсан учраас урд өдөр нь CSIRO-ийн компьютер дээр Zardoz-ыг хараад хэлээ хазаад өнгөрсөн. Гэтэл гэнэт ийм юм болох гэж...

Одоо тэр Мелбурнийн Их сургуулийн экаунт руу log in хийж цахим шуудан аюулгүй ирсэн эсэхийг шалгуулахын тулд Феоникс руу утасдах л үлдэв. Хэрэв тэгж чадвал Мелбурнийн Их сургуулийн админ руу CSIRO-ийн админ утасдаж, пассвордыг солихоос өмнө түүнийг хурдан модемоор download хийж амжина.

Электрон Феоникс руу утасдлаа. Хоёр залуу өдрийн хэдэн цагт утасдаж байгааг тоохоо болиод удаж байв. Оройны 10, шөнийн 2, шөнийн 4:15, үүрийн 6:45 гэх мэт хүссэн үедээ тэр залгана.

“За юу байна даа” гэж Электрон Феоникстэй мэндчилэв.

Феоникс: “Сайн” гэхэд Электрон юу болсон талаар ярьж, Zardoz-ын файлыг илгээсэн Мелбурнийн Их сургуулийн хоёр экаунтыг түүнд өгөв.

Феоникс утсаа тавиад хэдэн минутын дараа утасдав. Хоёр экаунт ажиллахгүй байлаа. CSIRO-ийн компьютерээс Электрон гарснаас хойш 30 минутын дотор Мелбурнийн Их сургуулийн хэн нэгэн пассвордуудыг өөрчилжээ. Хоёр хакер маш их харамсаж байв. Энэ бол тэднийг хэд хэдэн хүн ажиглаж байна гэсэн үг юм. Гэхдээ тэдний айдсыг Zardoz-ыг авах хүсэл давжээ.

CSIRO-ийн компьютер дээр Электрон бас нэгэн эккаунттай байв. Тэр энэ эккаунтыг Феоникст өгөхийг хүсээгүй боловч өөр сонголтгүй болжээ. Бүх зүйл тодорхой бус санагдаж эхлэв. Zardoz-ын файл тэнд байгаа гэдгийг хэн мэдэх вэ? Магадгүй Электроныг хөөж гаргасан админ Zardoz-ыг хүрч болохгүй хаа нэг мухар руу шилжүүлсэн байгаа. Гэвч тэнд бас найдвар байв.

Zardoz-ын файлыг хуулбарлаж ав гэж Феоникст user name, пассвордыг хэлж байхдаа шууд өөрийн компьютертээ татаж авахын оронд өөр компьютер руу сору хийхийг Электрон сануулжээ. Энэ бол илүү хурдан арга бөгөөд CSIRO-ийн админ өөр хэн нэгний компьютер руу нэвтэрч хуулбарласан файлыг устгаж зүрхлэхгүй юм. Хилийн чанадад байгаа сайтуудыг сонговол CSIRO-ийн админ тэдгээр компьютерийн админтай холбогдож, анхааруулахад хүндрэл үүсгэх байв. Тэгээд Zardoz-ыг хэдэн сайтан дээр хамгаалж аюулгүй авсны дараа Феоникс интернетээр дамжуулан download хийж болно.

CSIRO-ийн компьютерээс хойд чигт, хоёр хорооллын зайтай газар буюу Торнбюри дэхь Келвин Грув гудамжинд орших гэртээ Иан Матиесон түүний компьютер руу хакер орж ирэхийг ажиглаж суув. Түүний компьютерт хакер нэвтэрлээ гэсэн утасны дуудлага үүрийн 2:30-д авангуут Матиесон гэрийнхээ компьютер ба модемооражлынхаа DITMELA систем рүү хурдхан log хийжээ. Мелбурнийн Их сургуулийн компьютерийн шинжлэх ухааны салбарын Девид Хорнсбайгаас ирсэн утасны дуудлага худал түгшүүр байгаагүй юм.

Мелбурнийн Их сургуулийн компьютерийн терминал серверээр дамжин орж ирсэн үл мэдэгдэх хакер хорин минут болж байгааг Матиесон харангуут өөрийнхөө системээс гаргаж хаяв. Үүний дараа хакерын өгсөн командыг DITMELA-ийн компьютер биелүүлэхийг оролдсоор байгааг тэр ажиглажээ. Нилээд сайн шалгасны эцэст Мелбурнийн Их сургуулийн эккаунтууд руу DITMELA-ийн компьютер цахим шуудан илгээх гэж байгааг илрүүлэв.

Гэсэн хэдий ч цахим шуудан бүрэн хүргэгдэж амжаагүй байлаа. Түүний системээс хакер юуг хулгайлах гэж оролдсоныг сонирхсон Матиесон файлыг шилжүүлэн үзэв. Бүхэл бүтэн Zardoz-ын архивыг олж харангуут ямар зорилготой болохыг нь шууд мэдэв. Тэд бол жирийн хакер биш байлаа. Цахим шуудан илгээгдэхээс өмнө зогсоож, аюулгүй болгосон учир Матиесон бага ч болов тайвширчээ.

Харамсалтай нь Zardoz-ын хуулбаруудыг шахсан Электроны оригиналь файлыг Матиесон олж хараагүй аж. Электрон цахим шууданд файлыг хавсаргаад, оригиналь хувийг нь тэр чигээр нь үлдээжээ. Тэд DITMELA дээр хүний нүдэнд анзаарагдахгүй .t нэртэй файл болон сууж байв. Файлыг илгээвэл тэр чигээрээ алга болчихдоггүй түүний оригиналь хувийг л зөвхөн илгээнэ. Анагаахын доктор цолтой, компьютерийн шинжлэх ухааны магистер цолтой Матиесон ухаантай хүн байсан боловч Unix үйлдлийн систем дээр хакер файлаа хадгалж болох хэдэн газруудын нэг, түр зуурын фолдерыг шалгахаа мартсан байна.

Яг өглөөний 3:30 болж байхад Феоникс Техасийн Их сургуулиас DITMELA руу log хийв. Тэр түр зуурын фолдерыг хурдхан үзээд Электроны хэлсэн .t нэртэй файлыг олжээ. Феоникс файлыг нэн даруй Техасын Их сургууль руу дамжуулж эхлэв.

Австралийн хакерууд Zardoz-ын цуглуулгатай болох гэж байгаа учир түүний сэтгэл маш өндөр

байлаа. Дамжуулалт гэнэт тасрахаас өмнө бүх зүйл сайхан явагдаж байв. Zardoz-ын их хэмжээтэй файлыг download хийхээс өмнө Техасын Их сургуулийн компьютерийн дискний багтаамж хангалттай байгаа эсэхийг Феоникс шалгахаа мартжээ. Одоо түүний хөдөлгөөн бүрийг админ ажиглаж байж болох компьютер руу log in хийсэн Феоникс Zardoz-ын файл багтах хангалттай өрөө олж чадаагүйг хожим ухаарав.

DITMELA-ийн сүлжээнд өнгөрөөж байгаа секунд бүр эрсдэл дагуулж байгаа учраас Феоникс CSIRO-ийн компьютерээс яаралтай log off хийлээ. Энэ удаад ямар ч алдаа гаргахгүйгээр ажиллахыг тэр хичээнэ. Тэр файл дамжуулалтыг эхлүүлээд, хүлээж байв. Арван минутаас бага хугацааны дараа тэр CSIRO-ийн компьютерээс log off хийж, Техасын Их сургуулийн системийг цухалдангуй шалгажээ. Zardoz байрандаа хүлээж байлаа. Тиймээс түүнийг агуу үйлийн эхлэл Zardoz хүлээж байв. Одоо энэ түүнийх болжээ.

Гэхдээ баярлах арай эрт байв. Тэр Zardoz-ыг энкриптэлж, хурдхан шахлаа. Техасын компьютер дээр бага хэмжээтэй файл бусдын анхаарлыг татахгүйгээс гадна, файлыг давхар хамгаалах компьютер руу илгээхэд илүү хурдан байх болно. Мөн файлыг олсон хэн нэгэн нээж үзэхэд ойлгохгүй байхаар энкриптэлж хамгаалсан нь энэ ажээ. Тэр системийн админий талаар санаа зовоод зогсохгүй тус Их сургуулийн оюутан, Legion of Doom-ын хакер Эрик Блудакс байнгын ан хийдэг газар учир болгоомжтой байх шаардлагатай байв. Техасын систем хакеруудын зочлох дуртай газрын нэг болоод удаж байсантай холбоотой юм. Zardoz аюулгүй болсны дараа үүрийн 4 цагт Феоникс Электрон руу утасджээ. 8:15 болоход Техасын компьютерээс Zardoz-ыг өөрийн компьютер дээрээ download хийж авав. Өдрийн 1:15 үед Феониксийн компьютер дээрээс Электрон өөртөө татаж авлаа.

Zardoz-ыг олж авахад амаргүй байсантай адил Deszip-ийг олзлоход хэцүү байв. Zardoz-ын архивыг аюулгүй байдлын олон мэргэжилтнүүд эзэмшиж байсан бол Deszip хамаагүй цөөн хүрээнд эргэлдэж байлаа. Гэхдээ тэдний ихэнх нь АНУ-ын дотор оршиж байв.

Криптографийн алгоритмыг экспортлохыг АНУ-ын засгийн газраас хоригложээ. Deszip-ийн хуулбар болон DES эсвэл бусад энкриптийн програмыг АНУ-аас гадагш гаргах нь гэмт хэрэгт тооцогдож байсан юм. АНУ-ын Төрийн департаментын Батлан хамгаалах худалдааны хяналтын газар нь энкриптын ямар ч програмыг зэвсэг гэж үздэг байв. 1977 оны АНУ-ын зэвсэглэл экспортлоход хяналт тавих хуулиас урган гарсан Олон улсын Зэвсэг зөөвөрлөх журам IPAR-д зааснаар “батлан хамгаалахад зориулсан эд зүйлийг” гаргахыг хоригложээ. Та халаасандаа диск хийгээд Европ руу нисэх эсвэл ямар нэг материал интернетээр илгээх хоёрын хооронд ямар ч ялгаа алга байв. Хэрэв та IPAR-ыг зөрчвөл таныг шорон хүлээж байх болжээ.

Зарим үед АНУ-аас гадагш энкриптийн програмын хуулбарыг мэргэжил нэгт нөхдүүдээ Америкийн компьютерийн програмчид болгоомжтой тараах шаардлага гарна. Харин нэгэнт АНУ-аас гадагш гарсан програмын талаар АНУ-ын эрх баригчид юуг ч эс хийж чадна. Жишээлбэл Австрали дахь хамтрагчдаа хэн нэгэн хүн Норвегис Deszip-ийг илгээх явдал энгийн үзэгдэл байсан юм. Гэвч АНУ-ын гадна байсан компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд, криптографийн хүрээнийхэн Deszip мэтийн програмуудыг өөрсдийн мэдлээс гаргахгүй хадгалсаар байжээ.

Өөрөөр хэлбэл АНУ-ын хараалсан бай руугаа Электрон, Феоникс хоёр заавал довтлоно гэсэн үг юм. Zardoz-ын мейлийн жагсаалтын дагуу Электрон довтолгоо хийх субъектуудаа сонгож Феоникст өгчээ. Хоёр хакер сонгосон хохирогчдын компьютерийг хайж эхлэв.

Энэ бол гайхамшигтай жагсаалт байлаа. Deszip-ийн зохиогч Маттью Бишоп, АНУ-ын Энергийн газрын санхүүжилттэй судалгааны лаборатори болох Лауренс Ливерморийн Үндэсний лабораторын Рассел Брэнд, пассвордыг эвдэх програмыг багтаасан COPS багц програм хангамжийн зохиогч Дан Фармер зэрэг олон хүний нэрс оржээ. Жагсаалтын хамгийн эхэнд хакеруудын нэрлэж заншсанаар Спаф буюу Евгене Спаффорд байв.

1990 оны байдлаар хакерууд Спафыг аюулгүй байдлын лидер мэргэжилтэн гэж үздэг байлаа. Анти хакер хөдөлгөөнийг тэргүүлэгч гэж ч бас нэрлэнэ. Спаф компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн үүр гэж үздэг Пурдугийн Их сургуульд ажиллаж байв. Бишоп Пурдугийн Их сургуульд докторын зэргээ хамгаалж байхад Дан Фармер тэнд байсан юм. Интернет нь юс группын үйлчилгээний usenet-ийн үндэслэгч нь Спаф байлаа. Их сургуульд компьютерийн мэргэжилтнээр ажиллаж байхдаа RTM өтний техникийн анализыг Спаф хийжээ. 1988 онд Корнеллийн Их сургуулийн оюутан Роберт Т.Моррисийн зохиосон өт Спафын хүссэн алдар хүндийг өгч чадсан гэдэг.

RTM өтний анализ бичихээс өмнө Спаф програм хангамжийн инженерээр ажилладаг байв. Өтний дараа тэрээр компьютер хэрэглээний ёс зүйг судлаач болсон бөгөөд компьютерийн аюулгүй байдлын салбарт маш их консерватив үзэлтэй төлөөлөл болсон юм. Спаф АНУ-ыг хөндлөн гулд туулж, хакердах ёс зүй, өт болон вирусны тухай олон нийт, хэвлэл мэдээлэлд зориулан лекц уншжээ. Моррисийн хэрэг гарсны дараа АНУ-д хакерын тухай сэдэв олны анхаарлын төвд орсон тэр үед Спаф галыг түлшээр тэтгэж байлаа. Шүүгч Ховард Ж. Мунсон Моррисыг шоронд хийхийг эсэргүүцэж, 400 цагийн албадан хөдөлмөр хийлгэх шийдвэр гаргажээ. Үүний хажуугаар 10,000 долларын торгууль оноож, гурван жилийн тэнсэн харгалзах ял өгснийг Спаф эсэргүүцэж олон нийтийг өдөөж байлаа. Роберт Т. Моррисийг ажилд авахаар сонгосон ямар ч компанийг компьютерийн аж үйлдвэрлэлийн салбарынхан эсэргүүцэх уриалгыг тэр гаргасан гэж хэвлэл дээр мэдээлжээ.

Австралийн хакерууд Спафыг сонгосон явдал дээрхээс өөр зорилгыг агуулж байв. Тэр бол Deszip мэтийн үнэт эрдэнэ агуулж байх ёстой авдар гэдгийг хакерууд эргэлзэхгүй байлаа. Спаф бол дээд зэргийн архив байж болно.

Нэгэн шөнө Deszip-ийн хуулбарыг хулгайлахаар Пурдуге дэхь Спафын компьютерт нэвтрэхээр Электрон, Феоникс хоёр шийджээ. Феоникс хурд сайтай модемтой учир хакердах үндсэн ажиллагааг хийнэ. Үүний хажуугаар нь тэр Электронтой утсаар давхар ярих шаардлагатай. Электрон түүний бүх замыг газарчилна. Тэр хоёр Медуза нэртэй Пурдугийн компьютерт амжилттай нэвтрэжээ. Харин Спаф Медузатай холбоотой Утхер гэсэн компьютерийг тусад нь хэрэглэж байв. Феоникс Утхер руу нэвтрэх сиймхий хайхын тулд сайтар бэлдсэн довтолгоог хийлээ. Электроны зөвлөснөөр тэр CHFN цохыг хэрэглэхийг оролдов. CHFN команд нь хэн нэгэн этгээд хэрэглэгчийн экаунтыг мэдэнгүүт хэрэглэгчийн нэр, ажлын хаяг, албан байрны утас зэргийг өөрчлөх боломжийг олгодог. Zardoz-ын файлийн нэгэнд нь гарч ирсэн цохыг Феоникс, Электрон хоёр бусад олон компьютер руу нэвтрэхэд ашиглажээ. Хэрэв довтолгоо амжилттай болвол Спафын компьютерт руут экаунт буюу хард дискэн дээр хадгалагдаж

байгаа файлууд руу нэвтрэх хамгийн найдвартай замыг нээх боломж олдох учраас CHFN цохыг ашиглуулахыг Электрон хүсэж байв. Энэ бол компьютерийн аюулгүй байдлын топ мэргэжилтний нүүрийг хүчтэй алгадах алхам байлаа.

Гэхдээ бүх зүйл Феониксийн хүссэнээр болсонгүй. Австралийн хакер цохыг сайн ажиллах ёстой гэж үглэсээр байсан боловч амжилт гарсангүй. Спафын компьютер “Sequent” байсан учраас болоогүй байх гэсэн таамаглалыг Электрон гаргав. Unix-ийн пассвордны файлын тодорхой бүтцээс CHFN цохны ажиллагаа хамаардаг. Гэтэл Sequent компьютер өөр бүтцийг ашигладаг. Sequent-ийн тухай ихийг мэдэхгүй Феоникс амжилт олохгүй нь ойлгомжтой. Харин Гандалф үүнд сайн мэргэшсэн байлаа.

CHFN цохыг ажилуулах гэж хэдэн цагийн турш оролдсоны эцэст Феоникс нэг юм бууж өгөөд, аюулгүй байдлын өөр нэгэн алдааг хайхын тулд Электроны санаачилсан FTP цохыг хэрэглэв. Феоникс энэ цохны тухай эргэцүүлж эхлэв. Энгийн үед FTP цохыг хүмүүс нэг компьютерээс нөгөөд сүлжээ ашиглан файлууд дамжуулах, файлын протокол дамжуулахад хэрэглэнэ. FTP-г ашиглах гэдэг нь өөр компьютер руу холбогдоход телнетийг (интернет ашиглан холбогдохыг хэлж байгаа юм-орч) ашиглан log хийхийг ойлгоно. Гэхдээ хэрэглэгч log in хийхэд пассворд шаардлагагүй, өөр компьютер дээр гүйцэтгэх командын тоо хязгаарлагдмал ажээ.

Хэрэв энэ цох сайн ажиллаж чадвал FTP log in хийх процессын үед Феоникст өөр тусгай команд хажуугаар нь чихэх боломж олгох юм. Тэрхүү команд нь хүссэн хэн нэгний оронд log in хийх бололцоог Феоникст олгох бөгөөд тэр давуу эрхтэй log in хийдэг хэн нэгний оронд орохыг хүсэж байв. Хэрэв хакерын үйлдлийг хэн нэгэн ажиглаж байгаа бол руут эккаунт бага зэрэг азаартай байж болно. Яагаад гэвэл зайнаас access хийх явдал ховор байдаг юм. Тиймээс Феоникс нийтлэг руут эрхтэй эккаунт болох “daemon”-ыг сонгов.

Энэ бол нүдээ боогоод харвахтай адилхан байлаа. Мэдээж Спаф ийм илэрхий дайралтаас өөрийн компьютерийг хамгаалах арга хэмжээг авсан гэдэгт Феоникс итгэлтэй байсан боловч Электрон оролдоод үзэхэд гэмгүй гэж тулгасаар байв. FTP цох нь Zardoz-ын нилээд эртний дугаар дээр гарч, компьютерийн аюулгүй байдлын хүрээнхийхний дунд аль хэдийнээ танигдсан ажээ. Феоникс эргэлзэж байснаа дараах зүйлийг шивлээ.

```
FTP-I uther.purdue.edu
```

```
Quote user anonymous
```

```
Quote cd-daemon
```

```
Quote pass anything
```

Мелбурнийн захад орших түүний гэрээс командууд аялах хугацаа хэдэн секунд болох авч бүхэл амьдрал үргэлжилсэн мэт санагдана. Тэр Спафын компьютерийг мэдэлдээ оруулж, Deszip-ийг олзлохыг хүсэх тул довтолгоо амжилттай болоосой хэмээн залбирна. Хэрэв тэр Deszip-ийг авч чадвал Австраличуудыг юу ч зогсоохгүй гэсэн ойлголтыг өгөх байлаа.

Зочид буудлын хаалгач үүдээ нээж өгөх мэт Спафын компьютер хаалгаа онгойлгож өглөө.

Феоникс тааламжтай нь аргагүй дэлгэц рүү ширтэнэ. Тэр дотор оржээ.

Тэр Алладины эрдэнэсийн агуйд орсон мэт байлаа. Тэнд байгаа бүх зүйлс шинэ эзнээ хүлээн гэрэлтэнэ. Спаф өөрийн файлуудын жагсаалт дээр аюулгүй байдалтай холбоотой олон мегабайтын файлуудыг хадгалжээ. RTM интернет өтний source код, WANK өтний source код гэх мэтчилэн бүх л зүйл байна. Тэр өөрийн эрдэнэсийн авдарт гараа дүрээд дээш цацмаар санагдана. Гэвч түүнд юуны өмнө хийж дуусгах стратегийн томоохон, чухал даалгавар бий.

Тэр хард дискэн дээр хадгалж байгаа файлуудын жагсаалтыг шигшин Deszip-ийг хайна. Орон байрны хулгайч гэрийн алт мөнгөн эдлэлийг хайхтай адилхан нэг файлаас нөгөө рүү шургуу шилжиж байлаа. Спафад Deszip байх л учиртай. Матью Бишопоос өөр хүнд тэр програмын хуулбар байхад түүнд байж л таарна. Эцэст нь нэг юм оллоо. Deszip Феониксийг хүлээж байлаа.

Дараа нь Феоникс бас нэгэн содон файл ажиглав. Сонирхлоо барьж ядах Феоникс файлыг түргэн нээлээ. Тэр файлд passphrase буюу Deszip-ийн оригиналь хуулбарын энкриптыг тайлах түлхүүр байв. Гурван сарын өмнө Австраличууд Дартмоундын баавгай нэртэй компьютерээс хулгайлсан Deszip-ийг тайлах декрипт.Феоникс нүдэндээ итгэхгүй байлаа. Энэ бол маш хялбар, маш илэрхий ажээ. Гэхдээ түүнд алга байв. Асгасан сүүний хойноос харамсах цаг байсангүй. Хакер орж ирснийг хэн нэгэн мэдэхээс өмнө Deszip-ийг аваад компьютерээс яаралтай гарах хэрэгтэй.

Феоникс команд өгөхөөр дэлгэц дээр шивж эхэлмэгц, түүний дэлгэц гацав. Шалгаж үзэхэд түүний компьютерээс шалтгаалаагүй аж. Нөгөө үзүүрт байгаа компьютер дээр ямар нэгэн үйлдэл хийгдэж байна. Тэр Спафын компьютерт log хийсэн хэвээр байлаа. Холболт тасраагүй байдаг... Феоникс Индиана мужийн Баруун Лафайеттед байгаа компьютер руу команд бичсэн боловч хариу өгсөнгүй. Спафын компьютер дүлий мэт байсаар...

Феоникс юу болж байгааг мэдэхийг хичээнэ. Спафын компьютер яагаад хариулахгүй байна? Тэнд хоёр хариулт байх шиг байна. Нэгдүгээрт Спафын болон анх нэвтрэхэд хэрэглэсэн Пурдугийн компьютер хоёрын хоорондох сүлжээ санамсаргүй тасарсан. Эсвэл хэн нэгэн хүн санаатайгаар холболтыг салгасан.

Яагаад холболтыг салгана гэж? Хэрэв тэд намайг мэдэж байгаа юм бол яагаад компьютерээсээ шууд хөөгөөд гаргачихгүй байна вэ? Пурдугийн компьютерээс хүртэл хөөчихөж болно шүү дээ. Магадгүй ямар компьютерээс холбогдож байгааг мөрдөх хугацаа хожихын тулд түүнийг он лайн дээр байлгаад байж болох юм.Феоникс сандарч эхлэв. Хэрэв холболт санаандгүй тасарсан бол сүлжээ буцаж сэргэтэл хүлээх хэрэгтэй. Спафийн компьютерийн FTP-ийн цоорхой бол үнэхээр ер бусын азтай учрал байлаа. Хэн нэгэн түүнийг нууцаар нэвтэрснийг нотлох ул мөрийг олвол түүнийг бөглөчихнө боломжтой. Нөгөө талаар Пурдугийн хүмүүс түүний холболтыг мөшгихийг тэр хүсээгүй юм.

Тэр хэдэн минут азаа сорин хүлээв. Спафын компьютерээс ямар ч хариу ирүүлэхгүй хэсэг чимээгүй байх хугацаанд сэтгэл нь тавгүйцсэн учраас Феоникс таслахаар шийдэв. Феоникс холболтыг салгангуут Алладины эрдэнэсийн агуйд байсан үнэт зүйлс зэрэглээ адил замхран одлоо.

Харамсалтай үйл явдлын гэрч болсон Феоникс Электронтой дурамжхан ярих ажээ. Deszip-ийг олно гэдэг тийм амархан ажил биш гэж Электрон сануулна. Тэрнээс гадна Дартмоундаас авсан Deszip-ийн энкриптийг тайлах түлхүүр хэрэгтэй.

Тэд удалгүй бас нэгэн асуудалтай тулгарав. Хэдэн сарын өмнө хадгалсан програмын хуулбарыг Дартмоугаас хайгаад олсонгүй. Ор сураггүй болжээ. Дартмоутын системийн админ уг файлыг арилгасан бололтой.

Ёстой галзууртлаа уурламаар байв. Deszip-ийг харсан ч хазахын заяа байхгүй байлаа. Тэдний аазгайг Deszip маш ихээр хөдөлгөж, олз болгох хүсэлдээ хоёр хакер дарлуулах ажээ.

Тэдний эцсийн найдвар бол Дармоутгийн Deszip энкриптэлсэн файлын хоёрдахь хуулбарыг хадгалуулсан Гандалф юм. Гэвч найдвар бас л их зүйлийг амлаж чадсангүй. Хэрэв Австраличуудын файлын хуулбар устсан бол Британий хакерт хадгалуулсан хуулбар бас адилхан хувь тавилантай байв. Гандалф хуулбарыг өөрийн компьютертээ хадгалаагүй ажээ. Тэр Британи дахь компьютерийн хаа нэг харанхуй буланд хийж орхисон гэнэ.

Тэр хоёр Гандалф, Пад нарыг Алтос дээр орж ирэхийг хүлээнэ.

Феоникс онлайн дээр байгаа хакеруудын жагсаалтыг мэдэхийн тулд .s гэсэн командыг шивлээ. Пад log on хийснийг тэр олж харав.

Guest 0

1. Феоникс

2. Пад гэсэн үгс харагдана.

Guest 0 бол Электрон байв. Тэр ихэнхдээ зочин гэж log on хийнэ. Учир нь операторууд түүний холболтыг мэддэг учраас Электрон орж ирлээ гэж амархан мэднэ хэмээн болгоомжилсон хэрэг. Тэд Алтос дээрх түүний өөрийн эккаунтыг олж мэдээд маш их баярлах мэт санагдана. Түүнийг log off хийн гарсны дараа түүний пассвордоор нэвтэрч пассвордыг өөрчилдөг. Тиймээс Электрон гэсэн нэрээр дахин орж чадахгүй болно. Үүнээс өөр цухалуудах юу байх билээ. Феоникс: “Хөөе Пад, сайн уу?” гэж бичив.

Пад: “Фииний! Сайн уу”

Феоникс: “Хэдэн сарын өмнө Гандалф та хоёрт өгсөн Deszip-ийн энкриптэлсэн хуулбар байгаа биз дээ?”

Пад: “Энкриптэлсэн хуулбар... Хмм Бодож байна” гэснээ хэсэг алга болов. Пад, Гандалф хоёр өдөр бүр хэдэн арван компьютерийн системийг хакерддаг учир яг хаана хадгалснаа санахад хэцүү байв.

“Аан тийм би чамайг юуг хэлээд байгааг ойлголоо. Би сайн мэдэхгүй байна. Тэр чинь ЖАНЕТ дээрх компьютер дээр байл уу?” гэж Пад хэллээ. Австралийн AARNET-тэй адилхан Британий Академийн Хамтарсан Сүлжээ нь их сургуулиуд болон судалгааны

хүрээлэнгүүдийн дэмжлэг дээр тулгуурласан эхэн үеийн интернет байсан юм.

“Яг ямар систем дээр байсныг би сайн санахгүй байна” гэж Пад үргэлжүүлэн бодох ажээ.

Хэрэв аль институтийн компьютер дээр хадгалснаа санахгүй бол бүх итгэл найдварыг унтраах байлаа. ЖАНЕТ бол хэдэн зуун, магадгүй хэдэн мянган компьютерүүдийг агуулна. Гандалфийн нуусан нь эргэлзээ байхгүй файлыг ийм том хүрээнээс хайна гэдэг бүтэхгүй ажил байв.

“Гэхдээ файл энкриптэлсэн, та нарт пассворд байхгүй шүү дээ. Та нарт хэрэг болох юм уу даа?” гэж Пад бичлээ.

Феоникс: “Бид пассвордыг олсон”. Энэ бол Алтос дээр тогтсон дүрэм байв. Хэрэв та ямар нэг үйлдэл хийхийг санал болговол та <> гэж оруулна.

“Гайхалтай (Gr8)” гэж Пад хариулав.

Энэ бол Пад, Гандалф хоёрын онлайн стиль байлаа. Тэдний бүлгийг 8lgm гэж дууддаг байсан учраас наймын тоо Британий хакеруудын таних тэмдэг байв. Тэд үсэгний оронд ингэж хэрэглэдэг байж. “Great, mate, later” гэсэн үгнүүдийг ‘gr8, m8, L8r’ гэж товчлон бичнэ.

Хүмүүс Алтос руу лог хийнгүүтээ бусад хүмүүс харж болох газрын нэрийг оруулж болно. Мэдээж та хакерын эсрэг хууль баталсан орноос уг сайт руу орж байгаа бол өөрийн орны жинхэнэ нэрийг гаргахаас зайлсхийнэ. Тиймээс нийтлэг гэж үзэх улс орныг сонгоно. Зарим хүмүүс Аргентин эсвэл Израиль мэтийн орнуудаас лог хийдэг. Пад, Гандалф нар 8lgm-ээс лог хийнэ.

“хуулбарыг хаана хийснийг Гандалф мэдэж байгаа эсэхийг би асуунаа” гэж Пад Феониксд бичжээ.

“Ойлголоо, баярлалаа”.

Падыг буцаж онлайн дээр орж иртэл Феоникс, Пад хоёр хүлээж байв. Удалгүй Пар онлайн дээр орж ирээд ярианд нэгдлээ. Пар Guest 0 гэж хэн болохыг мэдэхгүй харин Guest Парыг хэн болохыг сайн мэдэж байлаа. (Guest-зочин гэсэн үг) Электроны хуучин шархыг цаг хугацаа эдгээж амжаагүй гэдгийг Пар мэдээгүй байв. Теорем одоо хүртэл бүтэлгүйтэж байгааг Электрон хүлээн зөвшөөрч чадахгүй ажээ. Тэр Партай шөргөөлцөх хэрэг байхгүй, Пар бол зөвхөн фреакер, жинхэнэ хакер биш, Пар бол чадваргүй тэнэг амьтан гэж Электрон өөртөө хэлнэ.

“Хөөе Пар юу байна даа” гэж Феоникс шивлээ.

Пар: “Юу болж байна даа?”

“Өө их зүйл болж байна аа.”

Пар нууцлаг Guest 0 рүү анхаарлаа хандуулав. Чат хийж байгаа сувагт аюулгүй байдлын

ажилтан байж болох учир нууцхан яриаг дэлгээд байхыг тэр хүсэхгүй байлаа.

Зочин минь танд нэр байгаа юу? гэж Парыг асуухад “Тиймээ. Энэ бол Guest--# 0” байна гэв.

“Чамд өөр нэр байхгүй юм уу?”

Хэсэг хугацаанд чимээгүй байж байснаа Электрон “Тэгж бодохгүй байна” гэж хариулав.

Пар: “Боовон толгойноос өөр нэр байхгүй гэж үү?” гэхэд Электрон тусгай мессэж Феоникс руу илгээж Парт түүний нэрийг хэлж болохгүй гэж мэдэгдлээ.

“Ок ойлголоо” гэж Феоникс хариу өгөв. Электроны санааг дэмжиж байгаагаа илэрхийлж Феоникс хэмээх смайли нэмдэг тавьжээ.

Харин Электрон, Феоникс хоёр шивнэж байгааг Пар огт мэдэхгүй байв. Тэр Guest-ийн нэрийг олж мэдэхийг оролдсоор л байлаа. “Тэгэхлээр хэл л дээ Guest гуай. Өөрийг чинь хэн болохыг таахаар оролдох уу?”

Тухайн үед Пар хуулийн байгууллагаас зугатааж байсныг Электрон мэджээ. 1990 оны эхэн үе гэхэд Пар зургаан сарын турш АНУ-ын Нууц Албанаас зугатааж байсан юм. Түүнчлэн Пар сэтгэцийн өөрчлөлттэй мэт аашилдаг гэдгийг тэр мөн мэдэж байв.

Электрон байг онилж байгаад буудлаа.

“Хөөе Пар Чи их идэх хэрэгтэй шүү. Чи олон өдрийн турш Холбооны мөрдөгчдийн доор хэвтэнэ шүү” гэлээ.

Пар хэсэг хугацаанд чимээгүй суув. Партай бараг дэлхийн нөгөө өнцгөөс харьцаж байгаа Электрон түүнийг чимээгүйхэн шоолж суух ажээ. Тэр Парыг бага зэрэг уурлуулах хэрэгтэй гэж үзжээ. Түүнийг хуулийн байгууллагын тухай яриа төвөггүйхэн сатааруулах байлаа.

Чи түүнийг харж байна уу? Холбооны мөрдөгчдийн дор гэж юуг хэлээд байна аа? гэж Пар Феоникс руу шивнэлээ. (тусдаа мессэж илгээх функцийг ашиглахыг шивнэх гэж байгаа юм)

“Би мэдэхгүй ээ” гэж Феоникс хариу шивнээд Парын мессэжийг Электрон руу явуулав. Тэр үүнийг уншаад инээнэ гэж Феоникс мэдэж байлаа.

Пар илт зовсон байдалтай “Чөтгөр гэж чи хэн юм бэ?” гэж Электрон буюу Guest 0 рүү шивнээд хариу авч чадсангүй.

Уур нь багтаж ядсан Пар Феоникс руу шивнэж: “Энэ хэн гэдэг залуу юм бэ? Чи түүнийг мэдэх үү?” гэхэд Феоникс хариу өгөөгүй аж.

“Чи мэдэрсэн үү? Холбооны мөрдөгчид өөрийгөө нууцалдаг. Түүний хэлсэн зүйл юу гэсэн үг вэ? аан? Тэр мөрдөгч юм болов уу? Тэр Холбооны мөрдөгч нараас ямар нэгэн мессэжийг надад хүргэхийг хичээж байгаа юм болов уу?”

Электрон оос алс хол Мелбурнийн нэг хэсэгт, өөрийн терминал дээр сууж байгаа Феоникс мөн инээж байлаа. Түүнд Пар таалагдах боловч амархан “бай” болсон Америк залуу өрөвдөлтэй ажээ. Америкийг хөндлөн гулд туулсан Пар сэтгэлийн дарамтанд орсныг Электрон мэдэх тул зөв газар нь хатгажээ.

“Би мэдэхгүй ээ. Би түүнийг Холбооны мөрдөгч биш гэдэгт бүрэн итгэлтэй байна” гэж Феоникс Пар руу шивнэв.

“Тэгэхлээр би түүний бичсэн зүйлийг үзээд их гайхаж байна л даа. Холбооны мөрдөгчдын дор Хмм. Магадгүй тэр ямар нэг юм мэдэж байгаа байх. Зарим төрлийн сэрэмжлүүлэг байж болох юм. Хог гэж Нууц Албаныхан намайг хаана байгааг мэдэж байж магад” хэмээн Пар хариу шивнэлээ.

“Чи үүнийг сануулга гэж бодож байгаа юм уу?” гэж Феоникс Пар руу бичив.

“Чи сүлжээ хэрэглэгчийн хаягийг шалгаад өгч чадах уу?” гэж нууцлаг зочныг хаанаас орж байгаа хаягийг мэдэхийг хүссэн Пар бичжээ. Түүнд танихгүй зочны нэрийг олчих учиг олдох магадлал байхыг үгүйсгээгүй байна.

Феоникс өөрийгөө тэсч ядан барьж байлаа. Тэр хувийн мессэжийг нь Электрон руу илгээсээр байв. Пар ч тун уурлаж эхэлсэн нь мэдрэгдэнэ.

“Түүнийг хэн гэдгийг надад хэлээд өгөхийг л би хүсэж байна” гэж Пар шивнэлээ.

Дараа нь Пар log off хийжээ.

“Пар явах ёстой гэж би бодож байна” гэж Электрон бичив. Тэрээр Гандалфаас Deszip-ийн хуулбарын тухай мэдээг хүлээх зуураа дотроо шоолон инээж байлаа.

Хэрэв Deszip-ийн хуулбарыг Пад, Гандалф хоёр хадгалснаа олж чадвал Австралийн хакерууд Deszip байтугай зүйлийг агуулсан системийг агнах болно. Ингээд Пад, Гандалф хоёр Алтос дээр орж ирэнгүүт Феоникс, Электрон түгшүүртэй хүлээж байв.

“За тэгээд Deszip одоо хүртэл байгаа биз дээ”

“Би аль систем дээр түүнийг үлдээснээ мартчихсан гэж бодож байлаа...”

Электрон: “тэгээд юу гэж?”

“Дараа нь би хаана хадгалснаа саналаа” гэхэд “Сайн мэдээ дуулгах уу тэгээд?” гэж Феоникс уулга алдав.

Гандалф: “Яг ч тийм биш ээ. Эккаунт үхсэн буюу хаагдсан байна” гэв.

Түүн рүү хувин хүйтэн ус цацсан мэт цочсон Электрон: “Үхсэн? Яаж тэр вэ?” гэж асуулаа.

Хэн нэгэн этгээд пассвордыг нь өөрчилсөн учир хаагдсан байх л даа. Яагаад гэдгийг хэлж

чадахгүй нь. Файлыг буцаан авахын тулд систем рүү дахин хакердах хэрэгтэй байна.

“Чөтгөр гэж. Энэ муу Deszip ёстой нэг шаналгаж байна даа” гэж Электрон бичив.

“Ёстой хөгжилтэй юм” гэж Феоникс нэмж хэллээ.

Гандалф: “Хуулбар тэнд байгаа гэдэгт би баталгаа өгч чадахгүй ээ. Би уул нь нуусан л юм. Гэхдээ хэн мэдэх вэ дээ. Хэдэн сар өнгөрсөн байна. Админууд түүнийг delete хийсэн байж магад” гэв.

Феоникс: “Гандалф чи системийг дахин хакердахад туслалцаа хүсэж байна уу?” гэхэд

“Үгүй ээ. Амархан байх. Энэ бол Sequent компьютер. Зөвхөн эзэн нь гэртээ харихыг л хүлээх хэрэгтэй” гэв.

Хэрэв компьютерийн эзэн log on хийж Гандалфыг илрүүлбэл тэр хакерын сонирхож байгаа файлыг шалган Гандалфыг хөөх болно. Тэгвэл өнөөх Deszip-ийг дахин алдана.

“Түүнийг авч чадна гэдэгт найдаж байна. Gr8 байх болно” гэж Падыг бичихэд Гандалф: “Gr8 шүү дээ. Феоникс чи энкриптийн түлхүүрийг нь олсон юм уу?” гэж асуулаа.

“Тиймээ”

“Хэдэн эгнээ тэмдэгтэй байна вэ?” . Энэ бол түлхүүрийг нь асуудаг Гандалфын зальт арга байв.

Феоникс юу гэж хэлэхээ мэдэхгүй байлаа. Британий хакерт түлхүүрийг өгөхийг хүсэх боловч хэрхэхээ мэдэхгүй алмайрчээ. Deszip-ийн хуулбарыг авахад Пад, Гандалф хоёрын туслалцаа хэрэгтэй байдаг. Гэтэл Электрон тэдний яриаг харж байгаа. Мэдээллээ гадагш өгөхөд Электрон дургүй.

“Би түүнд түлхүүрийг өгөх үү?” гэж Феоникс Электрон руу шивнэв.

Гандалф хүлээсээр... Түүнийг сатааруулж холдуулахын тулд Феоникс “9 эгнээ тэмдэгтэй” гэж хэлэв. Алтос дээр аль болох товч бичдэг тул тэмдэглэгээг char гэж бичжээ.

“Эхний тэмдэг ямар юм байна?”

“Хэлээ, түүнд хэлчихээ” гэж Электрон шивнэв.

“Тэгэхлээр түлхүүр бол ...”

“Чи сонсонгуутаа гайхах болно доо” гэж Электрон дундуур нь орж ирлээ.

“За за би хүлээж байна” гэж Гандалф хэлэв.

“Чи итгэхгүй ээ. Түлхүүр нь ... Дармоут”

“Юу уууууу?????? Үгүй байлгүй дээ. Чи тоглоод байгаа юм уу?” гэж Гандалф уулга алджээ.

Британий хакер толгойгоо балбана. Зүгээр л нэг Их сургуулийн нэр шүү! Ямар тэнэг пассворд вэ! Феоникс онлайн дээр инээж байгаагаа илэрхийлэв. “Бид аль хэдийнээ Deszip-ийг олж авах боломжтой байлаа...”

“Иус минь, ЖАНЕТ систем дээр байгаа гэж найдьяа даа” гэж Гандалф өгүүлнэ. Одоо пассвордыг мэдэх болсон тэрээр файлыг олох хүсэл улам бадарчээ.

“Мөргөө, мөргөө, мөргөө. Тиймээ Deszip дээрхи лицензийг үзвэл NASA хийсэн юм билээ” гэж Феоникс хэлэв.

“Чи харсан юм уу? Deszip-ийн source кодыг чи харжээ?”

Феоникс: “Үгүй ээ. БААВГАЙ компьютерыг шалгаж, Deszip програм тэнд байгаа эсэхийг үзэхэд аль хэдийнэ алга болсон байсан. Гэхдээ лицензийн зөвшөөрөл, бусад мэдээлэл тэнд байлаа. Лицензийг уншаад үзэнгүүт маш их гайхсан юм. Үүнд бид нар шиг хүмүүст энэ програмыг эзэмшлүүлэхгүй байх тухай хүмүүсийн бичсэн янз бүрийн зүйлээр дүүрэн байлаа. Хэхэ” гэжээ.

Электрон харин нилээд тайван байлаа. “За за Ганд чи хэзээ ЖАНЕТ системийг үзэх гэж байна?”

“Одоо, амлаж байна. М8! Дахиад уулзьяа I8г ...” гэж бичээд гарч одов.

Электрон хүлээж чадахгүй байв. Тэр хэдэн сарын өмнө Deszip-ийг эзэмшиж болох байсан гэхээс байж ядна. Энэ програм үнэхээр том шагнал юм.

Гандалф дахин орж ирэнгүүт Пад, Феоникс, Электрон нар хурдхан түүн дээр шавлаа.

“Нөхдүүдээ тэрнийг чинь олчихлоо!!!!” гэж Гандалф ориллоо.

Пад: “Сайн ажиллаа”

Электрон: “тиймээ” гээд “Чи энкриптийг тайлах гэж оролдов уу?” хэмээн асуув.

Гандалф: “Арай л амжаагүй байна. Крипт тэр компьютер дээр байхгүй байна. Тэр компьютер руу Криптыг хуулбарлах эсвэл файлыг Крипт суулгасан компьютер руу шилжүүлнэ” гэв.

“Тэгвэл шилжүүлье. Хурдан.. хурдан... энэ муу програм алга болох гээд байдаг зуршилтай” гэж Электрон хэлэв.

“Тиймээ энэ бол хамгийн сүүлийн хуулбар. Надад байгаа цорын ганц нь”

“Ок, Бодоорой бид хаана үүнийг хуулбарлаж болох вэ?” гэж Электрон хэллээ.

“Техаст!” LOD-ийн хакер Эрик Блудаксийн төрөлх гэр орон Техасын Аустиний Их сургуулийн компьютерт хуулбарлаж хадгалахыг Гандалф санаачлав.

“Тиймээ, Эрикийг л бүх юманд буруутга! Гэхдээ үнэндээ бол энэ газар Эрикийн хойноос хөөцөлдөж байгаа аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн отолт хийдэг газарболсон шүү. Тэд хэнийг ч орж ирсэн агнах болно” гэж Феоникс тоглож хэллээ.

Эрикээс хамгаалсан ажиллагаа их сургуулийн сүлжээнд идэвхжсэн гэдгийг Феоникс сонссон байв. Австралийн хакерууд AT&T-ийн хулгайлагдсан картуудыг ашиглан Эрик рүү байнга холбоо барина. Одоогоор Нууц Албныхан Эрикийг баривчлаагүй байгаа боловч ойрын өдрүүдэд гэнэтийн гийчин айлчилж болохыг мэдэгдэж байлаа.

“Яаж ч үзсэн энкриптийг тайлж чадахгүй бололтой” гэж Электроныг хэлэхэд Гандалф “фак офф, Алив надад сайт одоо хэрэгтэй байна!” эгдүүцэн бичив.

Феоникс: “Бодож байна аа... Аль нэг хэсэгт нь байж л таараа.. аль хир том юм?”

“900 орчим К, шахсан байгаа, магадгүй шахаагүй байхад 3 мега байсан байхаа. Алив хурдал! Их сургууль яаж байна?”

“Принцтон, Яале-д алийг нь ч хийж болно. Саяхан эккаунтыг нь хакардсан МПТ байвал яаж байна? Гандалф?” гэж Электроныг санал болгов.

“Үгүй”

Дөрвөн хакер аюулгүй хоргодох газрыг олох ажилд толгойгоо өвтгөж суулаа. Германы сайт дээр шууд ярилцаж байгаа Британи, Австралийн хакерууд үнэт эрдэнэсээ Аустин, Техас, Принцтон, Нью Жерсей, Бостон, Массачусеттес, Нью Хавен, Коннектикутийн алинд нь хадгалахаа эргэцүүлнэ. Дэлхий яг л тэдний атганд байгаа мэт сонголтыг харьцуулна.

“Бид download хийтлээ хаа нэгтээ түр зуур хадгалах л хэрэгтэй шүү дээ. Бидэнд руут нь байгаа компьютер байх л учиртай. Тэр компьютерт нэр нь мэдэгдэхгүй FTP байж л таараа” гэж Гандалф хэлэв. (FTP-File Transfer Protocol буюу Файл дамжуулах протокол гэсэн хураангуйлал. Сүлжээн дээр ямар ч систем болон өөрсдийн дотоод системийн хооронд файл хуулбарлахад ашигладаг протокол юм.)

Сонгосон компьютер дээр байгаа нэргүй FTP нь JANET системээс интернетээр дамжуулан сонгосон компьютер рүү файл шидэх боломжийг Гандалфад олгох юм. Гандалф бай болгон сонгосон компьютерийн эккаунтгүйгээр файл шидэх боломжтой нь хамгийн чухал асуудал байв. Жирийн эккаунт руу logging хийхээс илүү хязгаарлагдмал шинжтэй нэвтрэх аргаар тэр “anonymous” нэрээр login хийж болно. Хэдийгээр ингэж нэвтэрч байгаа боловч түүнд upload хийх боломж байсаар байна.

“Ок,ок надад нэг санаа байна. Би нэг үзээдэхье” гэж Феоникс хэллээ.

Феоникс Алтосоос гарч Техасийн Их сургуулийн сүлжээ рүү холбогдлоо. Сайтны бодит

байрлал ямар ч хамаагүй ажээ. Түүний толгой эргэж байсан ч сонгож болох газар энэ л мэт санагдана. Гэвч тэр Эрикийн түүнд байнга л ярьж байдаг “Нарру” нэртэй компьютер руу холбогдохыг хичээсэнгүй. Тэр Их сургуулийн компьютерүүдийн нэг Валт нэртэй компьютер рүү чиглэв.

Сүлжээ ачаалал ихтэй байв. Феоникс нөгөө төгсгөлийг холбогдтол түр хүлээлээ. Тэр Алтос руу буцаж орж ирээд Пад, Электрон хоёртой холбогдов. Энэ үед Гандалф хаана байгаа нь мэдэгдэхгүй байв.

“Балай юм. За тэгвэл надад нэг санаа байна” гэж Электрон бичжээ.

Феоникс: “Үгүй ээ! Байж байгаарай. Би нэг сайтны тухай бодлоо. Надад бас нэг руут байгаа юм. Гэхдээ энэ бол NASA-ийнх л даа.. Гэхдээ зүгээр байхаа. Тэднийг анзаарахгүй байхад би анхаарал тавьяа. Би байдлыг хурдан тандаадахья” гэв.

Феоникс Алтосоос гарч NASA руу зүглэжээ. Тэр Виржиниа мужийн Хамптон дахь Ланглейн судалгааны төвийн CSAB нэртэй NASA-ийн компьютерт login хийв. Эхлээд эккаунт идэвхитэй ажиллаж байгааг шалгаж, дараа нь системийн администратор login хийгээгүй байгааг магадлах хэрэгтэй.

АНУ-ын засгийн газрын мэдлийн компьютерт зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно гэсэн албан ёсны анхааруулгын хажуугаар Феоникс чөлөөтэй нэвтэрч username, password гэсэн хэсэг дээр хэдэн үсэг шивлээ.

Эккаунт ажиллаж байв. Тэр сүлжээнд нэвтэрчээ. Түүнд одоо руут эрхтэй компьютер бий болов. Тэр системээр хурдхан самналт хийхэд администратор нь онлайн дээр байв. Чөтгөр аваг!

Феоникс NASA-ийн компьютерээс зугатан гарч, Алтос руу орж ирлээ. Тэнд Гандалф нөгөө хоёрын хамт түүнийг хүлээж байв.

Электрон: “Юу болов?”

Феоникс: “Ок. Бүх юм болж байна. NASA-ийн компьютер ажиллана. Тэр компьютерт нэргүй FTP байна. Тэгээд ч надад бас руут нь байгаа. Бид хэрэглэж болно”.

Гандалф: “Байж байгаарай-наадах чинь Сгурт-тэй юу?”

Феоникс: “Аан! Шалгахаа мартсан байна. Би тийм гэж бодож байна. Шалгасан нь дээр байхаа даа. M8-аа!”

“За за Ок”.

Ажиллах сайтуудыг хайхыг хичээж, хамаг хүчээрээ ажилласан Феоникс ядарч байгаа мэт санагдана. Тэр Алтосоос log out хийж NASA-ийн компьютер рүү дахин аяллаа. Админ нь онлайн дээр байсаар хэвээр байв. Гэтэл Феониксэд цаг бага байдаг. Компьютер дээр Сгурт байгаа эсэхийг тэр олж мэдэх ёстой. Аз болж тэр компьютерт Сгурт байна.

Феоникс Алтос руу яаран орж ирэв. “Би ирлээ. Ажил гарсан шүү залуусаа” гэж бичлээ.

“Ашгүй дээ” гэж Электрон хэлээд анхааруулга хурдхан бичив.

Электрон: “NASA-гийн компьютер эсвэл яг тэр экаунтыг бүү бичээрэй. Зөвхөн Гандалф руу шивнэ. Нууц мессэжээр илгээ. Миний холболтыг мөрдөгч нар хянаж байж магад!” гэв.

Феоникс: “Тэгэхлээр нэг асуудал байна аа. Админ log on хийсэн байгаа.”

Электрон: “Үгүй ээ.”

Пад: “Зүгээр л хийчихгүй юу даа, санаа зовох хугацаа байхгүй шүү дээ”.

NASA-ийн компьютерийн интернет IP хаягийг Гандалф руу Феоникс шивнэлээ.

Феоникс: “ОК, м8, Би NASA руу нэргүй FTP явууллаа. Би буцаж орж ирээд, шинэ файлын нэрийг хэлнэ. Дараа нь чи орж, декрипт хийн, файлыг задлаарай. Намайг эндээ хүлээж байгаарай” гэв.

Арван минутын дараа Гандалф буцан орж ирээд: “Ажиллагаа амжилттай дууслаа. Файл тэнд байгаа шүү” гэсэн мессэжийг үлдээжээ.

Электрон: “Феоний минь одоо гялалзуул!” гэхэд

Феоникс: “Файлын нэрийг надад Гандалф шивнэлээ. Файлын нэрийг “d” гэсэн, pub directory-д байгаа” гэжээ.

Феоникс NASA-ийн компьютерт яаралтай холбогдож, “d” нэртэй файлыг хайж байв. Тэр олж чадсангүй. Тэр pub directory-д хайгаад ч олсонгүй. Тэр системийн үлдсэн файлуудын дотор эрлээ үргэлжлүүлэв. Хараал идсэн файл чинь хайчив аа?

Системийн администратор Шарон Бескенис сүлжээн дээр байсаар байгааг Феоникс ажиглав. Тэр эмэгтэй NASA-ийн өөр нэгэн компьютер Феобегээс холбогджээ. CSAB-ын компьютерийн сүлжээнд түүнээс гадна зөвхөн Каррие нэртэй хэрэглэгч байв. Өөр хэрэглэгч байгаа нь түүнд нэг их муу санагдсангүй. Ямар ч байсан тоон дотор үсэг цохиж яваа мэт содон байх магадлалыг бууруулах юм. Хэрэв админ онлайн дээр хэн байгааг шалгавал эхлээд Каррие, админ өөрийгөө, тэгээд “friend” гэсэн нэртэй хэрэглэгчийг харна. NASA-д ийм нэртэй хэдэн хэрэглэгч байгаа бол?

Гэтэл Феоникс өөрийн login хийсэн мөрийг арилгахаа мартсан байлаа. Муу хэрэг. Хэрэглэгч “friend” Техасийн Их сургуулиас NASA-ийн компьютер холбогдсон байв. Үгүй дээ, болих хэрэгтэй гэж тэр бодонгуугаа NASA-ийн компьютерээс салгагдав. Дараа нь тэр их сургуулийн сүлжээ рүү шилжиж, дахин NASA руу log in хийлээ. Гэнэтийн бэлэг! Одоо NASA-ийн компьютер дээр хоёр хүн “friend” гэж log хийсэн гэж харуулна. Компьютер урьдны log in хийсэн хэрэглэгчийн нэрийг зохих ёсоор устгаагүй байв.

Эхний log in хийсэн нэрийг арилгахын тулд процессын дугаарыг алга хийхийг Феоникс

улайран оролдоно. Харин NASA-ийн компьютер процессын ийм дугаар байгаагүй хэмээн хариу өглөө. Сэтгэл нь тавгүйтэж ирсэн Феоникс буруу дугаар оруулсан байх гэж боджээ. Галзууртлаа сандарсан тэрээр процессын дугааруудын нэгийг шүүрэн оруулж, устгаж чадлаа.

Бурхан минь! Админий процессын дугаар байсан байна. Шароныг өөрийнх нь компьютерээс Феоникс тасалжээ. Байдал хүндэрч эхлэв.

Одоо тэр хүндхэн байдалд, дарамтанд орлоо. Шарон түүний “friend” эхкаунтыг олж, аюулгүй байдлын цоорхойг бөглөх нь эргэлзээгүй тул тэр log out хийхийг яарсангүй. Эмэгтэй өөрийнхөө компьютер дээр Deszip програм байгааг олохгүй ч гэсэн Феоникс түүнийг буцаан авах боломжгүй болно.

Яарч сандарсан хэдэн минутыг өнгөрөөсны эцэст Феоникс Гандалфын үлдээсэн файлыг оллоо. Одоо л жинхэнэ үнэнийг мэдэх цаг хугацаа...

Тэр энкриптийг задлах гэж оролдов. Ашгүй ажиллаж байна! Deszip-ийн компресс хийсэн файлыг буцаан задлаад тэндээс гарахад л Феониксийн даалгавар биелэх байлаа. “Uncompress deszip.tar.z” гэж Феоникс шивээд хэсэг хугацаанд эргэлзэв. NASA-ийн компьютер түүний командыг хүлээж авсангүй.

Corrupt input

Зарим нэг зүйл буруу, бүр маш буруу болжээ. Файлын зарим хэсэг нь гэмтсэн бололтой. Сэргээх боломжтой эсэх нь туйлын эргэлзээтэй байв. Deszip програмын өчүүхэн хэсэг л гэмтсэн бол програмыг бүхэлд нь хэрэглэх боломжгүй болдог ажээ.

Файлыг компрессоос буцаан задалж байхад гэмтсэн байх гэж алганыхаа хөлсийг үрэх зуураа Феоникс бодов. Тэр оригиналь эхийг хадгалж байсан учраас энкриптийг дахин задалж, компресс хийсэн файлыг сэргээлээ. NASA-ийн компьютер дахиад л ижилхэн хариулт өгөв. Тэр файлыг дахин өөр аргаар задлаад оролдлого хийсэн боловч амжилт олсонгүй. Феониксийн мэдэх бүхэн дуусчээ. Арай л барахгүй бололтой. Гандалфийн ЖАНЕТ компьютерээс файлыг дамжуулж байхад л гэмтсэн байх гэсэн таамаглал түүнийг эзэмдэв. Тэр NASA-ийн сүлжээнээс гарч, Алтос дээр орж ирлээ. Бусад гурав нь түүнийг тэвчээртэй хүлээж байв.

Нууцлаг зочин гэж log in хийсэн Электрон түүнийг орж ирэхийг харангуутаа: “Болсон уу?” гэж асуув.

Феоникс: “Үгүй ээ. Энкриптийг тайлж болж байна. Харин компресс хийсэн файлыг задлах үед файл эвдэрсэн бололтой.”

Гандалф: “Ааарр балай юм аа!” гэв.

“Fuckfuckfuck. Ёстой заяагүй юм аа” гэж Электрон бичив.

Пад: “Sigh sigh sigh” гэхээс өөр зүйл хэлсэнгүй. (sigh-санаа алдах гэсэн утгатай)

Феониксийн ямар команд хэрэглэсэн болохыг Гандалф, Электрон хоёр нэг бүрчлэн лавлан нягтлаад ганц найдвар үлдсэн гэж үзжээ. Англид байгаа ЖАНЕТ компьютер руу энкриптийг тайлах түлхүүр програмын хуулбарыг шилжүүлж, тэнд нь Deszip програмыг уншуулах ажил хийхийг оролдох л үлдэв. Феоникс Crupt програмын хуулбарыг Гандалфад өгч, Британий хакер ЖАНЕТ компьютер дээрээ ажиллаж эхэллээ. Хэсэг хугацааны дараа тэрээр Алтосын болзоондоо иржээ.

Феоникс: “Гандалф? Болсон уу?”

Гандалф: “Чиний өгсөн програмаар энкриптийг тайлж үзлээ...”

Электрон: “Тэгээд? Тэгээд?” хэмээн бараг л сандал дээрээ гарах шахан асуув.

Гандалф: “Компресс хийсэн файлыг задлахыг хичээлээ. Хугацаа их орж байна. Бараг 8 мегабайт болох байх”.

Феоникс: “Өө балараа. Муу шүү. 3 мега байх л учиртай юм даа. Ингээд сая сая файл үүсгээд байвал хохино болно байх даа”.

Пад: “Бурхан минь! Маш их харамсалтай байна” гэж шивжээ.

Гандалф: “Deszip файл алдаа заагаад байна. Би уул нь файл янзлах лицензтэй програмтай юм л даа. Ер болж өгөхгүй байна.”

Феоникс: “Юундаа байгааг би огт ойлгохгүй боллоо.”

Электрон: “ЗовлонЗовлонЗовлон. Энэ хэзээ ч бүтэхгүй юм байна л даа.” гэж архирна.

Гандалф: “Бид хаа нэгтээгээс хуулбар авч болох уу?” гэж асуухад

Пад: “FTP-ын цохыг Пурдуед янзалсан ш дээ. Дахиад орж хэрэглэж чадахгүй байна л даа” гэлээ.

Бүгд сэтгэлээр унаж, анир чимээгүй байдал Алтосыг нөмрөв.

Мэдээж Deszip програмын бусад нөөц орд байсан. Феоникс, Электрон хоёр Калифорни мужийн Лауренсе Ливерморийн Үндэсний Лабораторид аль хэдийнээ нэвтэрч амжсан байлаа. Тэд gatt5 компьютер дээр руут олж чадсан агаад тус лабораторийн аюулгүй байдлын мэргэжилтэн Рассель Брендын Вутхел нэртэй компьютер руу дайрахад хэрэглэхээр хадгалсан ажээ. Рассель Брендийн компьютер дээр Deszip програм байгаа гэдэгт хоёр хакер итгэлтэй байв.

Магадгүй түүний компьютерээс том амжилт, эсвэл гутрал гунигийн алиныг ч болов хүртэх бизээ.

Пад: “За за би гарлаа. Дараа уулзъяа”

Электрон: “Би ч гэсэн гарлаа”

Гандалф: “Ок баяртай!” гэсэн мессэж үлдээжээ. Удалгүй “Шоронд уулзацгаая!” гэж Гандалф хошигнон бичив.

Зургаадугаар бүлэг

Нью-Йорк таймсийн эхний нүүр

“Маш гайхамшигтай нэгэн зүйлийн тухай уншаарай. Үүнд эргэлзэх зүйл алгаа.”

10,09,8,7,6,5,4,3,2,1 – “Үүнийг унш” Midnight Oil хамтлагийн дуу

Компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд тэднийг барихад ойрхон байгаа гэсэн Австралийн хакеруудын анхааруулгыг Пад хүлээн авчээ. Феоникс, Электрон хоёр Zardoz-ыг олзолж, Deszip-ийг алдсанаас төд удалгүй 1990 оны 2-р сард энэ явдал болсон юм. Пад анхааруулгыг бусдад мэдэгдсэнгүй. Энэ бол түүний зан биш билээ. Харин Электрон уг анхааруулгыг нилээд ноцтойгоор хүлээж авав.

Пад: “Спафын компьютерт юу хийснийг тэд мэдэж байна Фийн. Бусад системүүдэд ч чамайг орсныг мэджээ. Тэд чиний нэрийг мэддэг болсон” гэж Феоникст хэллээ.

Компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтэн Евгене Спаффорд хакеруудын довтолгоонд өртөж, ихээхэн гутарсан аймшигт дайсан болж хувирсан байв. Феониксийн арга барил маш өвөрмөц, илэрхий байсан учраас түүний олон нэвтрэлтийн холбоосыг аюулгүй байдлын мэргэжилтнүүд гаргаж авчээ. Жишээлбэл тэр өөртөө зориулан руут shell эсвэл руут access үүсгэхдээ компьютерийн ижил хэсэгт, ижил нэр дээр хадгалдаг байна. Зарим үед “Феоникс” нэртэй экаунтыг өөртөө зориулан үүсгэдэг байж. Түүний хөдөлгөөн, ул мөрийг мөшгихөд админууд эдгээр онцлогийг нь ашиглажээ.

Түүний болхи гэмээр арга барилаа өөрчлөх хэрэгтэйг Пад сануулсан байна. Австраличууд үйл ажиллагаагаа нэг хэсэгтээ намжаавал зүгээр гэж Пад үзсэн нь бас нэгч их муу санаа биш байлаа. Ирээдүйг зөгнөсөн мессэж нилээд ноцтой байсан учраас тэр биз.

“Хэргийн хойноос хөөцөлдөх учиртай Австралийн хуулийн байгуулагатай аюулгүй байдлын мэргэжилтнүүд холбоо тогтоосон гэж яригдаж байна” хэмээн Пад хэлсэн гэнэ.

Санаа нь тавгүйтсэн Феоникс: “Тэд миний жинхэнэ нэрийг мэдэж байгаа болов уу” гэж асуухыг Электрон сэтгэл зовнин харж суув.

Пад: “Мэдэхгүй л юм. Би Шаттераас сонссон. Тэр найдваргүй л дээ.. гэхдээ л...”

Мэдээлэл авсан эх сурвалж Шаттерын ач холбогдлыг бууруулж, Феониксын түгшилтыг намжаахыг Пад оролдож байв. Тэр Британий анд нөхдүүдэд итгэхгүй боловч Шаттер нууцлаг холбоотой гэж тооцож болохоор хүн юм. Шаттер бол мэдээллийн аюулгүй байдлын салбарын чиглэлд ажиллахаас гадна нууцлаг ертөнцөд нөлөө бүхий хүн байв. Тэр Пад, Гандалф хоёрт зарим мэдээллийг задалдаг. Хааяа Австрали хакеруудад ч гэсэн мэдээлэл дамжуулна.

Британий хоёр хакер Шаттерын зөвөлгөөг авах зуураа түүнтэй ярилцах боломж гардаг байв. Германы хакерыг баривчилсны дараа Пенго өөрийн талаар зөвөлгөө авахаар Шаттерт илгээсэн цахим шууданг Электрон замаас нь нууцаар уншиж амжжээ. 1989 оны зуны

амралтаараа Пенго АНУ руу аялвал аюултай эсэхийг мэдэхээр Шаттерт ханджээ. Шаттер түүний төрсөн өдөр болон бусад хувийн мэдээллийг тодруулав. Дараа нь ямар ч тохиолдолд АНУ руу зүглэж болохгүй гэсэн зөвөлгөөг тэр өгсөн байна.

Америкийн хөрсөн дээр Пенгог гишгэнгүүт баривчлах арга зам байгаа эсэхийг АНУ-ын Хуулийн департамент судлаж байсныг албаныхан хожим мэдээлсэн байдаг. Дараа нь тэд өөрсдийн шүүхээр түүний асуудлыг хэлэлцэхийг санаархаж байв.

Шаттер үүнийг мэдэж байсан болов уу? Эсвэл нийтлэг мэдрэмжээрээ л АНУ руу бүү яв гэж Пенгод хэлэв үү? Үүнд хэн ч итгэлтэй байгаагүй боловч Шаттерын түүнд хэлсэн үгс үнэний хувьтай гэж бусад хүмүүс үзсэн юм.

Пад: “Спафийн компьютерийн талаар Шаттер зөв мэдээлэлтэй байх нь гарцаагүй. 100 хувь үнэн байх магадлалтай. Чи яаж хакердсаныг тэр нэг бүрчлэн мэдэж байна лээ. Би үүнд итгэнэ. Чи одоо м8-ийг хакердаж байгаа бол болгоомжтой байхад илүүдэхгүй. Ялангуяа Inet дээр” гэжээ. (Inet гэдэг нь интернет гэсэн үгийн хураангуйлал-орч)

Алтосын хакерууд нэг хэсэг чимээгүй болов.

Пад үргэлжлүүлэн: “Чи ч бас ганцаараа биш. АНУ-аас аюулгүй байдлын хоёр мэргэжилтэн Англид ирж, Гандалф нэртэй хэн нэгний талаар олж мэдэхийг хичээж байна. Бас Гандын найз, Патрик гэсэн байхаа түүнийг ч бас сонирхож байгаа” гэж бичжээ.

Патрик үнэхээр өөрийн сүлжээний нэрийг жинхэнэ нэрнээс санаа авч хэрэглэсэн юм. Ухаалаг ямар ч хакер өөрийн жинхэнэ нэрнээс сүлжээний нэрийг санааг авахгүй. Гэхдээ уг Патрик эхнээсээ л Их сургуульд нь лекц уншдаг байсан, Ирланд гаралтай багшийнхаа нэрнээс сүлжээний нэрнийхээ санааг авсан гэдэг. Британий хакерууд Х.25 сүлжээг нээн илрүүлсний дараа Партай адилхан Падын нэр олны анхаарлыг татсан юм. Түүнийг нэр хоёр дахь утгаа олжээ. Х.25 PAD бол терминалын сервер эсвэл модем ба Х.25 сүлжээ хоёрын хоорондох интерфес буюу пакет ассемблерыг задлагч юм. (assembler-ассемблер-доод түвшний програмчлалын хэлийг компьютерийн хэлэнд хувиргагч юм-орч) Үүний адил “Бөгжний эзэд” киноны шидтэний нэр Гандалфийг терминалын бренд нэр болгон хэрэглэжээ. (Terminal-компьютер руу нэвтрэх электроникийн хэрэгслийг агуулсан тоног төхөөрөмжийг хэлнэ. Компьютерийн гар, дэлгэц гэх мэтийг агуулсан гэсэн үг-орч)

Пад: “Чи мэдэх үү? Түүний компьютерийг хакердаж байхад Спаф өөр оронд байсан гэсэн”

Гандалф: “Тийм үү, Хаана?” хэмээн ярианд оролцов.

Пад: “Европд”

Гандалф: “Ха ха” гэж инээснээ “Өө Хэлло эрхэм Стаффорд. Би бол авьяастай, би чадварлаг!” хэмээн тоглох аястай өгүүлэв.

Дэлхийн өөр өнцөгт ганцаар байгаа дөрвөн хакерууд дотроо инээж байлаа.

Пад: “Хэлло, тэр залууг тэгээд Патрик гэдэг юм үү?” гэхэд

Гандалф: “тэгэхлээр эрхэм Спаффорд, та өөрийнхөө FTP-г бөглөөгүй жинхэнэ тэнэг амьтан болж байна даа” хэмээн дүгнэв.

“Sequent компьютер дээр хадгалагдсан CHFN цохыг дурдахгүй өнгөрвөл шүү дээ! Эсвэл чи маш их бажгадсан байх даа” хэмээн Феоникс нэмж хэлнэ.

Феоникс Падын сэрэмжлүүлгээс болж бага зэрэг таагүй байсан хэдий ч дотроо инээд нь хүрч байв. Ингээд тэр яриа руу эргэн орж: “Пад аа Шаттер өөр юу ярьсан бэ?” гэж асуув.

Пад: “нэг их юм яриагүй ээ. UCSB-ээс болоод аюулгүй байдлын зарим шалгалтууд тусдаа хийгдэж байгаа гэсэн” гэлээ.

UCSB бол Берклей дэхь Калифорниагийн Их сургуулийг ингэж хураангуйлдаг. Калифорниа мужийн Лауренсе Ливерморийн Үндэсний Лаборатори болон Берклейн компьютерүүд руу Феоникс зочилдог байсан учраас маш олон админууд түүнийг ажиглаж, нэрийг нь тогтоожээ. Нэг өдөр Dewey-ийн компьютер гэж нэрлэгдэх dewey.soe.berkeley.edu гэсэн сайт руу ороход дараах мессэж байсанд мэл гайхжээ.

Феоникс ээ

Чи Dewey-ийн сүлжээнээс даруй гар!

Түүнчлэн ‘soe’-ийн ямар ч компьютерийг бүү хэрэглэ.

Баярлалаа,

Даниель Бергер гэжээ. Үүнийг харсан Феониксын зүрх амаараа гарах шахав. Тэр системээс олон удаа орж гарч байхдаа log in screen дээр байгаа үгнүүдийг харалгүй өнгөрдөг байжээ. Тэгтэл мань эрд хаягласан мессэж тэнд байгааг Феоникс олж үзэв.

Анхааруулгыг үл тоон Берклейгийн компьютер дээрх руутыг авах ажиллагааг хийж, Бергерийн файлуудыг харав. Дараа нь сандлаа налан сууж асуудлыг хэрхэн шийдэх талаар бодлоо. Эцэстээ сайныг бодож, сайтыг орхин гарж байгаагаа админд бичиж үлдээхээр шийджээ. Хэдэн өдрийн дараа Dewey-ийн компьютерт буцаж орж ирээд юу ч болоогүй юм шиг сүлжээгээр хэсэж гарлаа. Дараа нь тэр системд нэвтэрч өөрийн ур чадвараар руутыг олж чадав. Тэр компьютерийг эзэмдэх эрхээ олж хүртжээ. Түүнийг тайван орхи гэсэн утгатай мессэжийг админд үлдээж болох авч Даниель Бергерийг цухалдуулсны төлөө Берклейн компьютерүүд орохгүй байна гэдэг утгагүй асуудал гэж Феоникс үзэв.

“UCSB-ийн хүмүүс систем дээрээ нууцад хамаарах материал хадгалдаг гэж би бодож байна” хэмээн Пад өгүүлжээ.

Нууцын ангилал байхгүй сүлжээний компьютер дээр цэргийн маш нууц материалыг хадгалах учир байхгүй. Гэвч, заримдаа эрдэмтэд судалгаа шинжилгээний асуудалд илүү анхаарч аюулгүй байдлыг орхигдуулснаар тогтсон дүрмийг зөрчиж, ажлаа хийх тохиолдол байдаг гэж

Пад тааварлаж байв.

“Зарим зүйл хууль бус байж болох л доо. Дараа нь тэд хэн нэгэн хакер тэнд байгааг олж мэдсэн” хэмээн түгшсэн олонд Пад хэлэв.

Феоникс: “Балай юм”

Пад: “Тэгээд хэн нэгэн тэдний компьютерт нэвтрээд нууц мэдээллийг нь авах гээд байгаа бол ... юу болохыг тайлбарлах хэрэггүй биз. Тэдний компьютерт нэвгэрсэн хэнийг ч болов барихыг маш их хүсэх болно.” гэв.

Падын хэлсэн бүгдийг хакер бүр дотроо тунгаан хэсэг чимээгүй байв. Бусад хакеруудаас харьцангуй бие даасан зан чанартай Пад тухайн үед Алтосын хамгийн эрүүл ухаантай, итгэж болох хакерт тооцогдож байлаа.

Эцэст нь Падын хэлсэн сануулгын хариу болгон Феоникс руу Электрон: “Аюулгүй байдлын залуустай харьцана гэдэг зовлонгоос өөр зүйл дагуулахгүй” гэж би чамд хэлсэн шүү дээ гэв. Аюулгүй байдлын салбарт ажиллаж байгаа мэргэжилтэн буюу цагаан малгайтнуудтай ярих нь дажгүй санаа гэж боддог Феониксийг Электрон ихэд шүүмжилж байсан билээ. Өөрийн тэнэг бодлоо хөхүүлэн саймширч байгаа Феониксэд нилээд цухалдангуй хандахаас гадна өөртөө анхаарлыг татна гэдэг олигтой зүйл биш гэж Электрон үзэж байв. “Аюулгүйн чиглэлээр ажиллаж байгаа мэргэжилтэнтэй бусад хүмүүс ярихгүй байх” би бодож байна хэмээн Алтос дээр бардамнаж байсныг тэр санаж байлаа.

Онлайн дээр Электроны бичсэн зүйлийг уншсан Феоникс дуулгавартай нь аргагүй “Би хэзээ ч тэдэнтэй дахиж ярихгүй” хэмээн хариулав.

Энэ үгсийг Электрон урд өмнө сонсож л байсан аж. Түүний хэлсэн үгс архичин хүн дахиж хэзээ ч архи уухгүй гэж байгаа мэт санагдаж байв. Электрон бусадтай баяртай гэж бичээд гарч одов. Тэр одоо Феониксийг дахиж сонсох хүсэлгүй болжээ.

Харин өөр хүмүүс Феониксийг анхааралтай сонсож байлаа. Хэдэн зуугаад километрийн зайтай газар буюу Канберра дахь бусдын анхаарлыг үл татах нууц байранд түрүүч Майкл Костелло, байцаагч Виллям Апро нар Феониксийн утасны шугамаас гадагш урсаж байгаа дамжуулалт бүрийг хуулан авч байв. Түүний компьютерээс гарч, орж байгаа мэдээллийн урсгалыг хоёр ажилтан хуулбарлан авч байлаа. Дараа нь тэд өөрсдийн модем, компьютерт бичлэгийг уншуулан шүүхэд нотлох баримт болгохоор хадгална.

Цагдаагийн хоёр ажилтан Австралийн Холбооны цагдаагийн газрын Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжээс буюу Мелбурнийн хойд хэсгээс иржээ. Өөрсдийн түр зуурын ажлын шүрээн дээр PC, лаптоп байрлуулан тухласан ажилтнууд нууцаар хянах ажлаа 1990 оны 2-р сарын 1-нд эхэлсэн юм.

Австралийн Холбооны цагдаагийн газрынхан дата баримтжуулалт хийсэн анхны тохиолдол энэ байлаа. Тэд дэлхийн өнцөг булан бүрд байгаа олон арван компьютерүүд болон NASA, Техас, Берклей рүү хакердаж байгаа Феониксийн үйлдлийг баримтжуулахад ихээхэн цагийг

үрсэн ч туйлын сэтгэл хангалуун байв. Телефон утсыг нууцаар хянах ажилд 60 хоногийн зөвшөөрөл өгсөн нь бардам хакерын эсрэг нотлох баримт цуглуулахад хангалттай хугацаа байлаа. Цаг хугацаа одоо тэдний талд шилжжээ.

Нууцаар хяналт хийж байгаа ажилтнууд ээлжээр ажиллана. Үдээс хойш 8 цагийн үед Австралийн Холбооны цагдаагийн газрын Теле харилцаа холбооны тагнуулын салбарын ажилтан, байцаагч Апро ирнэ. Яг арван цагийн дараа маргааш өглөөний зургаан цагт түрүүч Костелло халааг нь авч, Апро унтах ажилд ордог. Апро дахиад оройны 8 цагт ирж шөнийн ээлжиндээ сууна.

Тэд байнга л Феониксийг ажиглаж байв. Хорин дөрвөн цагийн турш хүлээж, тагнасаар байлаа.

Энэ явдал маш их хөгжилтэй үргэлжилнэ. Техасын Аустин хотод Эрик Блудакс инээдээ барьж ядна, харин Мелбурнд их инээснээс болж гэдэс нь хөндүүрлэх Феоникс сууна. Хөгжилтэй байгаа биз!

Феоникс утсаар ярих дуртай байв. Тэр байнга Эрик рүү утас цохино. Заримдаа бүр өдөр болгон шүү. Утасны төлбөр төлөхгүй учраас Феоникс чөлөөтэй ярина. Утасны төлбөр хэн нэгэн азгүй хэрэглэгчийн нэр дээр гарах агаад утасны компанитай хамтран ажиллах мэт санагдана. Заримдаа Феоникс олон улсын дуудлага хийж байхдаа толгой нь эргэх вий гэж Эрик санаа зовох ажээ. Утсаар их ярьвал бусдын анхааралд өртөх байх гэж Эрик түгшинэ. Энэ тухай тэрээр хэдэн удаа Феониксээс асуужээ.

Харин Феоникс: “AT&T бол Австралийн компани биш. Америкчууд намайг яаж ч чадахгүй” гэж хариулна. Яваандаа Эрик үүнд сэтгэл түгшихээ болив. АНУ-ын Нууц Албаныхан түүний гэрт зочилсноос хойш Эрик Феоникс руу утасдаж зүрхлэхээ байжээ. 1990 оны 3-р сарын 1-нд өглөө эрт буу зэвсэг агссан хүмүүс түүний гэр рүү дайран орж ирэв. Мөрдөгчид оюутны байшинг салж унатал нь нэгжсэн боловч гэмт хэрэгт холбогдуулах нотлох баримт олж чадаагүй аж. Эрик тэднийг ирнэ гэдгийг мэдэж байсан учраас мөрдөгчид түүний компьютерийг хурааж чадаагүй байна. Харин Эрикийн 59 долларын үнэтэй компьютерийн гар, 300 баудын хүчин чадалтай болхи модемыг Нууц Алба хураан авчээ.

Эрикийн эзэмшсэн боловсролын баримт бичгийг Нууц Алба авч үзсэнийг сонссон учраас дайралт хийж болохыг тэр гадарласан байна. Тиймээс Нууц Албаныхан түүний гэрт ирэхэд Эрикийн үнэт хөрөнгө өөр газар очсон байв. Тэр компьютерээ гэртээ авчралгүй хэдэн долоо хоног өнгөрөөсөн нь түүний амьдралын хамгийн хэцүү үед тооцогдоно. Тэр сэтгэл мэдрэлийн өвчтэй болох шахсан учраас өөрийгөө сатааруулахын тулд хямдхан компьютер, модем худалдан авчээ. Нууц Албаныхан зөвхөн компьютерийн гар, модем хураан авсан тул гэмт хэрэгт буруутгах нотлох баримт хангалттай бус байв. Түүнд ял оноох боломж байсангүй.

Өөрийг нь хяналтанд авсан гэдгийг Эрик мэдэж байлаа. Түүний гэрийн утасны билл дээр Феониксын утасны дугаар гарч ирэхийг л тэр хүсэж байв. Тиймээс тэр Феониксийг утасдахыг хүлээнэ. Австралийн хакер ч байнга утасдаж байсан юм. Эрик шөнө ажиллаж байхад Феоникс байнга ярина. Энэ бол тийм ч хэцүү ажил биш байлаа. Зөвхөн компьютерийн хамгаалалтын хальсыг солиод л болно. Оюутны хувьд гайхамшигтай боломж.

Үүний ачаар Эрикт чөлөөт цаг их гарна.

Эрикийн утсыг чагнаж байгаа гэдгийг Феониксэд олон удаа хэлсэн боловч тэр үл тоомсорложээ. “Аан за, найзаа санаа зовох хэрэггүй ээ. Тэд юу хийж чадах билээ? Хүрч ирээд намайг барих уу?”

Эрик хакердах арга барил сонирхож эхэлснээс хойш Феониксийн туршлагыг амтархан сонссдог байв. Сонирхолтой систем, техникийн асуудлын тухай Австралийн хакер ярьж, дараа нь тэд компьютер руу нэвтрэх төрөл бүрийн стратегийн тухай хэлэлцэнэ. Гэсэн хэдий ч Феоникс Электронтой зөвхөн хакерын тухай сэдвээр ярьдгаас арай илүү өргөн хүрээг Эриктэй хийх яриа хамардаг байлаа. Тэд амьдралын тухай, Австралийн тухай, охидын тухай, тэр өдрийн сонинд юу гарсан тухай хүртэл хүүрнэнэ. Эриктэй юм ярихад таатай байдаг байв.

Тэр бусад хакеруудын адил агуу хүсэл мөрөөдөлтэй боловч хорхойд хоргүй, зөвхөн өөрийн далдхан хошин занд дулдуйдан харьцдаг нэгэн ажээ.

Феоникс байнга л Эрикийг инээлгэнэ. “Хөхөөний өндөг” номыг бичсэн, астрономич Клиффорд Столлын тухай тэр ярина. Сан Францискогийн ойролцоо орших Лауренс Берклейн Лаборатори дахь Столлийн компьютерийн систем рүү Германы хакер нэвтрэн орсон тухай уг номонд өгүүлдэг. Тэр хакер Пенгогийн бүлэглэлийн нэг гишүүн байв. Столл чадвар муутай хакер муутай байсан тул нэр хүнд маруухан байлаа. Столлын номыг уншсан Феоникс, Эрик хоёр уг номны тухай ярилцахаар чат дээр суужээ.

Феоникс: “Өөрийнхөө номонд цахим шуудангийн хаягаа оруулсан нь Клиффийг үнэн тэнэг гэдгийг харуулж байна. Хмм Ер нь түүний шууданг нэг сөхөөд үзвэл яадаг бол?” гэжээ.

Нэг өдрийн дараа Феоникс Эрик руу утасдав. “За би Клиффийн компьютерийн руутыг олчихлоо” гээд гэнэт тас хийтэл инээснээ “Тэгээд бас тэр өдрийн мессэжийг нь өөрчилсөн. Түүний нүүрэн дээр Хөхөөний өндөг унасан!” гэж өөрчилсөн гэв.

Энэ бол үнэхээр хөгжилтэй үе байв. Дэлхийн хамгийн алдартай хакер баригч эрхэм Столл хүүхдэд шоглууллаа! Хэдэн долоо хоногийн турш Эрик ийм хөгжилтэй түүх сонсоогүй билээ. Гэхдээ Нью Йорк таймсийн тухай Феоникст Эрик ярихад бүх зүйл үүнээс ч хөгжилтэй байх ажээ. Нилээд хэдэн компьютерт нэвтэрсэн зарим нэг төрлийн вирус эсвэл өтний програмыг нэгэн хакер бичсэн тухай гуравдугаар сарын 19-ны өдрийн сонины нийтлэл дээр дурьджээ.

“Үүнийг сонсож бай” гэж Эрик хэлээд гол хэсгийг нь Феониксэд уншиж өгөв. “Сүүлийн хэдэн долоо хоногийн туршид үндэсний хэмжээний сүлжээний хэдэн арван компьютерт нэвтэрдэг програмыг хакерууд бичжээ. Энэ програм өөрийгөө нууцлахын тулд файлуудыг арчиж, хэрэглэгчийн пассвордыг агуулж байгаа электрон хэлбэртэй бичиг баримтыг автоматаар хулгайлдаг” гэж уншив. Феоникс маш хүчтэй инээсэн учир бараг сандлаасаа унах шахжээ. Програм гэнээ? Автоматаар хийдэг гэнэ үү? Үгүй ээ. Энэ бол автоматчилагдсан програм биш, харин Австраличууд байсан юм! Энэ бол Realm-ийн хакерууд байлаа. Бурхан минь гэж маш инээдтэй байна.

Хүлээж байгаарай бас ингэж бичсэн байна. “Бас нэгэн хөнөөлт програм өргөн тархах хандлагатай байгаа” гэжээ. Эрик үгээ зөөж ядан инээнэ.

“Хор хөнөөлтэй програм! Хэн энэ нийтлэлийг бичсэн юм бэ?”

Эрик: “Жон Маркофф. Би түүн рүү утасдсан”.

“Чи юу? Чи тэгээд юу гэв?” гэж асуух зуураа Феоникс биеэ тайвшруулахыг хичээн амьсгаагаа дарна.

“Жон, Таймсийн 12-р тал дээр бичсэн нийтлэлийг санаж байна уу? Таны бичсэн зүйлс буруу байна! Хор хөнөөлтэй програм интернет рүү довтлоогүй юм” гэж би хэлсэн. Гэтэл тэр “Тэгээд юу байсан юм бэ?” гэсэн. “Энэ бол вирус эсвэл өт бишээ, Хүмүүс байсан юм” гэж би хариулсан гэв.

Эрик дахиад л тачигнатал инээж гарав.

Эрик: “Дараа нь Марк маш их сандарч ‘хүмүүс гэнээ?’ гэж асуусан. Би тийм гэсэн. “Чи яаж мэдэж байгаа юм?” гэж асуухад нь “Яагаад гэвэл би МЭДНЭ” гэж хариуллаа” гэв.

Феоникс чанга дугаар инээнэ. АНУ-ыг агуу интернет өт зохиогч Роберт Т. Моррис бишрүүлсэн учир Таймс сонины сурвалжлагч өт хэмээн боджээ. Түүнийг тавдугаар сард яллах гэж байсан билээ.

Өтөнд хамаатай гэж тэдний үзсэн нэг сайтаас нөгөө рүү шилжих хакеруудын холбоосыг АНУ-ын мөрдөгчид мөшгиж байв. Богино хугацаанд ийм олон сайтаар нэвтрэх санааг мөрдөгчид сайн ухаж ойлгохгүй байлаа. Үүнийг хүний гаралтай гэхээс илүү програмтай холбоотой довтолгоо гэж дүгнэсэн юм.

Эрик: “Тэгээд Марк надаас ‘Тэдэнтэй намайг уулзуулж чадах уу?’ гэж асуухад нь ‘Би чадах бүхнээ хийе’ гэлээ”.

Нью Йорк таймсийн нэгдүгээр нүүр, 1990 оны 3-р сарын 21: “Мэргэжилтнүүдээр доог тохуу хийхийн тулд компьютер руу нэвгэрч орсон гэж утсаар ярьсан хүн хэллээ” гэж Жон Маркофф бичжээ.

Тэр Нью Йорк таймсын эхний нүүрэн дээр гарч чадсан хэмээн Феоникс дуу алдав. Нийтлэлд өгүүлснээр “Утсаар ярьсан хүн өөрийгөө Австралийн Дейв нэртэй хүн ажээ” гэхэд Феоникс чимээгүйхэн дотроо инээлээ. Дейв Лиссек бол түүний хэрэглэдэг хуурамч нэр байв. Мэдээж тэр Дейв нэрийг хэрэглэдэг цорын ганц хүн биш юм. Алтос дээр анх удаа Австраличуудтай уулзаж байхад бүгд л өөрсдийгөө Дейв гэж нэрлэснийг хараад Эрик гайхаж байлаа. Би Дейв, тэр Дейв, бид бүгд Дейв гэж тэд хэлнэ. Ингэх нь бараг амар ч юм уу. Спаф болон Столлын компьютер руу Дейв довтолсон бөгөөд нууцаар нэвтрэлт хийснээс хойш Столлын ажиллаж байгаа Харвардын Их сургуулийн Смитсонианы Одон орон судлал, ажиглалтын хүрээлэнгийн бүх компьютерийг интернетээс салгасан гэж уг нийтлэлд бичжээ. Түүнчлэн ‘нүүрэн дээр нь өндөг’ гэсэн утгатай Феониксын түүнд ярьж өгсөн түүхийг сурвалжлагч

Маркофф нийтэлсэн байна.

Клиффи Столлыг хэрхэн хавчиснаа Феоникс бодоод инээд нь хүрнэ. Энэ нийтлэл түүний нэрийг өргөх л болно доо. Өөрийгөө ингэж үнэлүүлсэн нь сэтгэл хангалуун байлгахад хангалттай байв. Түүнийг бүх дэлхий харахаар хар цагаанаар бичсэн нь энэ байлаа. Дэлхийн хамгийн алдартай хакерын ангуучыг дөнгөж, Америкийн хамгийн нэр хүндтэй сонины тэргүүн нүүрэн дээр жаалсныг юу гэж ойлгох вэ.

Үүнээс гадна Спафын системд түүнийг бас нэвтэрсэн гэж мэдээлжээ. Феониксийн царайд баярын инээмсэглэл тодорно. “Аюулгүй байдлыг хангах мэргэжилтнүүд хакеруудыг агнадаг байтал хакерууд тэднийг хөөж явна гэж утсаар ярьсан Дейв хэлсэн” хэмээн Маркофф иш татжээ.

Нийтлэлд цааш үргэлжлүүлэн: “Дайсагнагч этгээдийн довтолсон газрын тоонд Лос Аламосын Үндэсний лаборатори, Харвард, Дижитал Экюипмент Корпорэйшн, Бостоны Их сургууль, Техасын Их сургууль зэрэг газрууд орж байгаа юм” гэж бичжээ. Тиймээ жагсаалт давгүй сонсогдож байна шүү. Мэдээж Австраличуудын хувьд багаараа ажилласан. Австралийн хакерын багийг удирдаагүй эсвэл зарим газруудын компьютерийг хакердахад оролцоогүй боловч Таймсийн нүүрэн дээр гарсан мэдээлэлд Феоникс сэтгэл хангалуун байв.

Өнөөдөр бол Феониксийн хувьд тугаа мандуулсан өдөр байлаа. Гэвч Электрон маш их уурлажээ. Феоникс яасан тэнэг үйлдэл хийгээ вэ? Австралийн хакеруудын өсөн дэвжих амжилтанд Феоникс ганцаар хөөрч байгааг тэр сайн мэднэ. Циркийн одой морь шиг ийм гэнэхэн, бүхний нүдэн дээр ил тоглолт хийж байгаад Электрон итгэж ядаж байлаа.

Феоникстэй хамтарч хакердах ажиллагаа хийж байсандаа Электроны ой нь гутаж байв. Тэр хэзээ ч Феониксэд бүрэн итгэж байгаагүй нь сайн юм болжээ. Түүнтэй утсаар ярьж байхад өнгөрөөсөн хэдэн цагийн туршид мэдээлэл нэг тийшээ л урсаж байсан юм. Феоникс өөрийн хийсэн ажилдаа төдийгүй Электроны гаргасан амжилтыг хүртэл өөрийн болгож бахархан ярьдаг байжээ.

Электрон Феониксийг засах гэж их оролдсон билээ. Наанадаж аюулгүй байдлын залуустай ярихаа зогсоо гэж Электрон түүнд сануулж байв. Тэр хашир, болгоомжтой байхыг байнга сануулна. Аюулгүй байдлын томоохон мэргэжилтэнд нээсэн ололтоо үзүүлэхийг Феоникс санал болгох удаа бүрд тэрээр аятайхан татгалзаж байв. Феоникс өөрөө ухаарч нөхцөл байдлаа ойлгох биз хэмээн Электрон тааваар орхиж байсан нь энэ ажээ. Магадгүй Феоникс руу орилж байгаа хүний зөвөлгөөг сонсож чадахгүй байгаа бол шивнэж байгаа хүнийг сонсож болохсон доо. Гэвч байдал хэвээр байлаа. Феоникс энэ талаар үнэхээр хөлдүү сэтгэлгээтэй аж.

Бүх л хакердах ажиллагаа хэдэн сар биш гэхэд хэдэн долоо хоног үргэлжилдэг. Таймс сонины тэргүүн нүүрэнд гарсан мэдээллийг Австралийн эрх баригчид огт ажиглахгүй өнгөрөөх боломж байсангүй. Америкчууд тэдний хойноос хөөцөлдөх нь лавтай. Ганцхан хүний бардамнал хүн бүрт зориулсан гайхамшигт үдшийг нураах нь энэ.

Электрон модемоо залгуураас нь сугалж, аавдаа аваачиж өгөв. Шалгалтын үеэр модемоо

нууж байхыг тэр ааваасаа гуйдаг байлаа. Тэрээр модемоо залгахаас өөрийгөө холдуулах арга зам байхгүй байсан учраас үүнийг хийнэ. Тэгээд ч өөрийн биеийг барихад шаардагдах сахилга бат түүнд байхгүй гэж үздэг байжээ. Түүний аав нь модем нуухдаа мэргэжилтэн болсон хэдий ч хэдэн өдрийн дараа Электрон олоод л авчихдаг байв. Гэрийнхээ нууж болох газар бүрийг сандчиж, ухаад модемоо олоод гарч иртэл бусниулах ажиллагааг Электрон хийнэ. Модемыг гэрийн гадна аваачиж нуусан ч түүний хайх хүсэл зоригийг мохоож чадаагүй юм.

Энэ удаад хуралдсан хар үүл нүүж цэлмэг болтол хакердах ажиллагаа хийхгүй гэж Электрон өөртөө тангараглажээ. Тиймээс тэр модемоо аавдаа өгч, хатуу зааварчилгаа хэлээд өөрийн хард драйв, дискүүдийг цэвэрлэж анхаарлаа холдуулахыг хичээв. Түүний хакердахдаа хэрэглэдэг файлуудыг алга хийх ёстой байлаа. Түүний үйл ажиллагааг нотлох хангалттай нотлох баримт бол файлууд юм. Тэр зарим файлуудыг delete хийж, зарим нэгийг нь дискэн дээр хуулж, найзынхаа гэрт хадгалуулжээ. Файлуудыг утсгах нь түүнд маш харамсалтай санагдаж байсан хэдий ч өөр арга зам үгүй ажээ. Феоникс өөрийгөө мөн адил буланд шахав.

“Ёох” гэж Электрон бичив.

Феоникс: “Энэ бол тоглоом биш шүү! Бид мэдээ бүхэл өдрийн турш уншлаа. Эрик рүү би утасдсан. Тэр надад тэгж хэлсэн юм”.

“Ммм..” гэж Электроныг хэлэхэд “Чи мэдэж байна уу, бид олон зүйлийг зөв хийсэн шүү дээ. Жишээлбэл Харвард байна. Бид Харвардын бүх систем рүү орсон. Шатраар бол сайн ч нүүдэл хийсэн. Бидэнд шаардлагатай нэр төрийг Харвард өгсөн” гэлээ.

Сонссон зүйлдээ Электрон итгэж ядна. Түүнд ямар ч нэр төр байтугай, мөрдөгчдийн анхаарлыг татах шаардлага байгаагүй билээ. Феониксийн өөрийн тухай ярих хэдэн үгс түүнийг үнэхээр цухалдуулж байв.

“Хөөе тэгээд ч чиний нэрийг тэд мэдэж байгаа” хэмээн Феоникс өдсөн янзтэй хэллээ.

Энэ үг түүний эгдүүг хүргэжээ. Электрон уураа барьж ядна.

Феоникс: “Хаха! Тоглосон юм. Санаа зоволтгүй. Тэд хэн нэгний нэрийг огт дурьдаагүй гэсэн” гэв.

“Сайн байна” гэж Электрон хэлээд дотор нь бага ч болов уужирлаа.

“Тэгэхлээр Тайм эсвэл Ньюсуикийн хавтсан дээр бид гарна гэж тооцоолж байна уу?”

Бурхан минь! Феоникс тэнэг бодлоосоо залхдаггүй юм байх даа? Хууль хамгаалах агентлагуудын мөрдөгчид шивээлсэн улсад үндэсний зургаан цагийн мэдээгээргарчихаад сэтгэл нь ханахгүй байна гэж үү. Одоо Нью Йорк Таймсийн хавтас дээр гарах санаатай. Түүнд одоо долоо хоног тутмын сонин хэрэг болж дээ.

Феоникс өөрийн нийтлэлдээ сэтгэл хангалуун байв. Тэр бараг дэлхийн дээвэр дээр гарсан

мэт сэтгэж, дотроо байгаа бүхнээр орилохыг хүснэ. Электрон өндөр зэрэглэлийн мэргэжилтнүүдийн компьютерийг хакердаж, амжилт гаргаж байсан хэдий ч биеэ барин, чимээгүйхэн баярлаж суудаг байлаа. Заримдаа Пад, Гандалф зэргийн хакеруудтай энэ зэрэгцэн байгаагаа дотроо эргэцүүлдэг байв. Түүнд өөрийн амжилтын талаар сонины сурвалжлагчид ярих шаардлагагүй эсвэл Клиффорд Столлын нүүрэн дээр чалчих зүрх байхгүй билээ.

“За тэгээд би юу бодож сууна даа?” хэмээн Феоникс байж ядан асуув.

“Юу ч бодсонгүй” гэж Электроныг хариулахад “Үгүй гэж үү? Биднийг гаргахгүй гэж бодож байна уу?” хэмээн Феоникс урам хугарсан янзтай дуугарав.

“Үгүй”.

“За за, Би шаардах болно. Хог гэж, бид Ньюсуикийн хавтас дээх гарахыг л хүссэн шүү дээ” гээд дараа нь бүр ширүүнээр “би хүссэнээ хийхийг оролдоно оо гэж” хэлээд инээв.

“Аанха. Ок юу хүссэнээ л хий” гэж Электрон хариулаад, түүнээс зайгаа авчээ.

Феоникс чи тэнэг юм даа хэмэн Электрон дотроо бодно. Анхааруулаад байгааг анзаарахгүй байна гэж үү? АНУ-д хийж байгаа баривчилгаа, Падын сэрэмжлүүлэг, Британичуудыг ангуучилж байгаа Америкийн мөрдөгчдийн тухай мэдээлэл гээд олон далд санаа байгаа шүү дээ. Дээрх мэдээллийг Феоникс сонсоод бардам сэтгэлдээ бялуурч байхад дэлхийн томоохон компаний боссууд компьютер сүлжээний менежерээ дуудаж, компьютерийн аюулгүй байдал ямар түвшинд байгааг лавлаж байгаадаа.

Хэнэггүй зантай хакерууд компьютерийн аюулгүй байдлын салбарыг хөнгөхөн доромжилсны үр дүнд өөрсдийн эсрэг дайн зарлахад хүргэж байгаагаа ухамсарлахгүй сууна. Мэргэжилтнүүд хууль хяналтын байгууллагуудтай ярилцан тохиролцож, улс орноор хэрэн тэнүүчилсэн мэдээллийг солилцож байгаа нь илэрхий юм. Дэлхийн электроникийн бүсийн хуйвалдагчид ухаан санаагаа дээд зэргээр хурцлах хэмжээнд очжээ.

“Бид Спаффыг дахин хакердаж болно шүү дээ” гэж Феоникс санаачлага гаргав.

“Евгене Спафыг олон нийт тоож харахгүй биз дээ” хэмээн Электрон хэлээд Феониксийн санааг унтраахыг хичээнэ. Тэр эрх мэдэлтнүүдээр тоглохыг байнга хүсэх агаад буруу арга зам гэдгээ ойлгоогүй байв.

Феоникс: “Би шүүх хуралд орвол их хөгжилтэй юм болно. Өмгөөлөгч Спафыг дуудаад “За эрхэм Спаффорд та дэлхийд алдаршсан компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтэн үү?” гэж асууна. Түүнийг “Тиймээ” гэж хариулахад би суудлаасаа үсрэн босоод ‘би эсэргүүцэж байна шүүгчээ, энэ залуу юу мэддэггүй шүү дээ. Түүний компьютерийг хакердахад ямар асуудал тулгарч байгаагүй! гэж би хэлнэ’ ” гэх ажээ.

“Ммм”

“Хөөе, хэрэв биднийг дараагийн хоёр долоо хоногт барьж чадахгүй бол гайхамшиг гэдэг тэр л болно доо” хэмээн Феоникс хөгжилтэй нь аргаггүй үргэлжлүүлэв.

“Би итгэхгүй байна.”

“Тэр чинь маш их хөгжилтэй байх болно. Бид баригдана! Бид баригдана!” гэж Феоникс егөөтэйгээр ориллоо.

Электроны эрүү газар хүртэл унжсан мэт санагдав. Феоникс галзуурчээ. Мэдрэлийн өвчтэй хүн л ингэж аашлах биз. Бага зэрэг ядарсан мэтээр шалтаглан Электрон баяртай гээд утсаа тавилаа.

1990 оны 4-р сарын 2-ны үүрийн 5 цаг 50 минутанд Электрон орноосоо чүү чай ховхорч, ванны өрөө рүү явжээ. Түүнийг замынхаа талд орж байхад цахилгаан тасрав. Ямар сонин юм бэ? Үүрийн бүдэг гэгээнд Электрон нүдээ нээлээ. Тэр унтлагын өрөөнд орж юу болсныг тодруулахаар жинсэн өмдөө өмсөж гарав. Гэнэт гудамжны хувцастай хоёр эр цонхыг нь цөм цохин өрөөнд орж ирээд “Шалан дээр хэвт” гэж ориллоо .

Ямар хүмүүс ороод ирэв? Хагас нүцгэн Электрон өрөөнийхөө голд хөдөлгөөнгүй зогсоно. Цагдаа нар түүний гэрт зочилно гэдгийг битүүхэн хүлээж байсан боловч дүрэмт хувцасгүй байгаад нь ихэд гайхаж байлаа. Тэд өөрсдийгөө танилцуулдаггүй юм байх даа?

Хоёр хүн Электроныг барьж аваад нүүрийг нь шалан дээр дарж, гарыг нь ард нь гавалжээ. Түүний арьсыг холгохоор гавыг чанга зүүлээ. Дараа нь хэн нэгэн этгээд гэдэс рүү нь хүчтэй цохив. “Гэрт нь ямар нэгэн галт зэвсэг байна уу?” гэж хүмүүсийн нэг нь асуув.

Электрон амьсгалж чадахгүй байсан учраас хариулт хэлсэнгүй. Түүнийг хүчтэй дэлсчээ. Түүнийг хэн нэгэн чирч босгоод сандал дээр суулгав. Гэрт нь хаа сайгүй гэрэл гялалзаж, зургаа эсвэл долоон хүн хөдөлж харагдана. Тэд гэрт өөр аргаар орж ирсэн бололтой. Тэнд байсан хүмүүсийн хувцсан дээр “AFP” гэсэн гурван үсэг байлаа. (AFP-Австралийн Холбооны Цагдаагийн газар-орч)

Цагдаа нар галт зэвсэг байгаа эсэхийг яагаад асуусныг Электрон удалгүй ойлгов. Холбооны мөрдөгчид ирэнгүүт аавынхаа 22 калибрийн бууг хэрхэн ашиглах талаар Феоникстэй утсаар ярьж байхдаа тоглон өгүүлж байснаа тэр саналаа. Мөрдөгчид түүний гэрийн утсыг чагнасан юм байна.

Өөр өрөөнд цагдаагийн нэг ажилтан аавтай нь ярилцан, нэгжлэг хийх зөвшөөрөл чангаар уншиж байх зуур түүний 3000 долларын компьютер хэрэгслийг гадагш зөөж байлаа. Тэд зөвхөн модемийг л олж чадаагүй юм. Австралийн Холбооны Цагдаагийн ажилтнууд хүртэл олж чадахааргүй газар аав нь нуух туршлагатай болжээ.

Хэдэн ажилтнууд Электроны өрөөг нэгжиж эхлэв. Өрөөний шал хог новшоор битүү хучигджээ. Хэрэглэсэн ганц удаагийн аяга, өмд, хувцас, үзэг, подволка, пассворд, хаяг сараачсан цаас, хуурцаг, сэтгүүл, ном зэрэг зүйлс шалаар хөглөрнө. Цагдаа нар өрөөг нэгжсэний дараа анх эхэлснээ бодвол арай цэвэрхэн болсон харагдана.

Тэд өөр өрөө рүү орох үед Электрон шалан дээр унасан нэг цаасыг шүүрэн авав. Энэ бол Цагдаагийн мансууруулах бодис ялган таних аргачлалыг харуулсан хананд наадаг ухуулга маягийн цаас байсан аж. Үүнийг түүний аавын найз нь бэлэг болгон өгсөн юм. Харин энэ хуудас дээр одоо Австралийн Холбооны цагдаагийн ажилтны хөлийн мөр гарчээ. Одоо энэ хуудас жинхэнэ цуглуулганд орох эд болсон санагдана. Электрон дотроо инээгээд цаасыг далд хийв. Түүнийг зочны өрөөнд ороход цагдаагийн ажилтан хоёр хүрз барьсан байхыг хараад мөн инээд нь хүрэв. Электрон өөрийнхөө хамгийн хэрэгтэй хакерын дискүүдээ гэрийнхээ арын цэцэрлэгт булсан гэж Феониксэд хэлж байснаа саналаа. Одоо цагдаа нар хэдэн өдрийн өмнө устгасан зүйлийг эрж олохоор энд тэндгүй ухаж байгаа нь хөгжилтэй санагдана.

Электроны гэрээс хакердах ажиллагаатай холбоотой нотлох баримт бага олсон ч тэд шаардлагатай зүйлээ аль хэдийнээ олсон гэж үзэж байв. Бага үдийн алдад хорин настай Электроныг дугааргүй машинд суулган, сүртэй харагдах Австралийн Холбооны цагдаагийн байранд аваачив. Цагдаа нарын албан байр Латроуб гудамжны 383-д орших ажээ.

Үдээс хойш асуултаар тасралтгүй бөмбөгдсэн байцаалт түр завсарлаж, Электрон хонгилд гарч ирлээ. Хонгилын нөгөө үзүүрт балчир царайтай Феоникс (18 настай), Realm-ийн гишүүн Ноум (21 настай) нарыг байцаахаар авч явж байв. Хоорондоо ярилцах боломжгүй хол байсан тул Электрон инээмсэглэн зогсоно. Ноум сандарсан шинжтэй харагдлаа. Феоникс цухалдсан янзтай алхаж байв.

Электрон өмгөөлөгч авахыг хүсэхгүй байлаа. Өмгөөлөгч авах ямар ч шаардлага байна? Түүний утсыг нууцаар чагнасан цагдаа нар хангалттай мэдээлэл олж авсантай маргах зүйл алга. Түүнчлэн Мелбурнийн Их сургуулиас авсан log хийсэн жагсаалтыг түүнд үзүүлсэн. Бүгд л түүний гэрийн утас руу чиглүүлсэн мэдээллийг агуулсан байлаа. Электрон бүх зүйл дууссан гэж бодож байв.

Хоёр ажилтан байцаалт хийлээ. Эрүүгийн төлөөлөгч Гленн Проебстл мөрдөн байцаалтыг удирдлаа. Түүнтэй хамт байцаагч Наташа Эллиот байсан бөгөөд хааяа нэг асуулт асууж, ихэнх хугацаанд ажиглах маягтай сууж байв. Электрон асуултанд чин сэтгэлээсээ хариулах тухай бодох авч тэдний аль нь ч компьютерийн талаар ойлголт багатай гэж тэр үзжээ. Тэд түүний ярьсан зүйлийг ойлгохыг хичээх шиг санагдана.

Электрон бүх зүйлийг суурь ойлголтоос эхлэн тайлбарлах хэрэгтэй байлаа. Тэр FINGER команд юу гэсэн утгатайг тайлбарлав. “Finger” гэсэн үгийг шивсний дараа username-ийг бичихэд компьютер хэрэглэгчийн нэр болон бусад зүйлийн тухай үндсэн мэдээллийг өгдөг.

“Тэгэхлээр энэ аргын цаана ямар зорилго оршиж байгаа юм бэ... finger.. тэгээд...пассвордыг олж авахыг оролдсоны дараа жирийн команд өгсний дараа яах вэ?” гэж асуултаа байцаагч Эллиот чүү чай асууж төгсгөв.

Түүний юу асууж байгааг Электрон ойлгож чадаагүй нь хамгийн хүндрэлтэй байлаа.

“Тэгэхлээр, за, тэнд өөр ямар нэгэн... finger-ийг ашиглаагүй тохиолдолд...”

Байцаагч Эллиот: “За за гэж тээнэгэлзсэнээ, тэр системийг урьд өмнө ашиглаж байсан уу?”

Электрон: “Ямар систем?” гэж Электрон асуух зуураа Лауренсе Ливерморийн компьютерийг хэрхэн хакердсан талаар уу эсвэл зарим өөр сайтын тухай ярьсан уу гэдгийг ойлгож ядан асуув.

“Finger... finger системийн тухай?”

Аан? Энэ асуултанд Электрон яг яаж хариулахаа мэдэхгүй байв. Тийм зүйл байдаггүй юм. Finger бол команд болохоос биш компьютер биш юм гэхэд “Аан тийм л дээ” гэж тэр сандарлаа. Хоёр ажилтнаас хамаагүй илүү мэдлэгтэй Электрон компьютерийн технологийн тухай иймэрхүү байдалтай байцаалт өгч байв. Бүтэн өдөр байцаасны эцэст эрүүгийн төлөөлөгч Проестл: “Хилийн чанад дахь компьютерүүдэд нэвтэрснээр ямар мэдрэмж чамд төрдөг тухайгаа өөрийн үгээр хэлнэ үү” гэж Электроноос асуулаа.

Электрон: “Үндсэндээ хувь хүнд ямар нэгэн ашиг хонжоо гэхээр зүйл байхгүй ээ” гэж хэлэв. Энэ бол хариулахад хүндхэн асуулт байсан юм. Тэр хариултыг мэдэхгүйдээ бус харин компьютер хакердаж байгаагүй хүнд тайлбарлахад хэцүүд л хамаг учир оршиж байлаа. “Яг л компьютер руу нэвтрэх цохилт хийж байгаа мэт санагддаг. Чи нэгэнт дотор нь орсон бол эсвэл түүнд нэвтрэх access байлаа ч гэсэн уйтгартай санагдаж дахин зочлохгүй байж мэднэ гэх юм уу даа. Шинийг байнга хайж явах сайхан ч гэх юм уу.. Энэ бол үнэхээр уриалан дуудсан гэмээр үйлдэл. Бусад хүмүүсийн хийхийг хүссэн ч чадахгүй зүйлийг хийхийг оролдоно гэдэг.. Өөртөө итгэлтэй бардам байдлыг төрүүлдэг гэх юм уу даа. Бусдаас илүү ур чадвараа мэдрэх орчин гэж ч болно” гэв.

Үүний дараах хэдэн асуултаар бүтэн өдөр үргэлжилсэн байцаалт дууслаа. Дараа нь Электроныг Фитцройгийн цагдаагийн хэсэг дээр аваачив. Барьцаагаар суллах хүсэлт гаргах процессыг хийхэд хамгийн ойр газар ирсэн байх гэж тэр таамаглаж байлаа. Хуучин тоосгон байшингийн өмнө, явган хүний зам дагуу хэдэн хүмүүсцугларсан байхыг Электрон оройн бүрэнхий гэрэлд харав. Цагдаагийн машин ирж зогсонгуут цугларсан хүмүүс гэнэт идэвхжин, тэмдэглэлийн дэвтэр, үзэг харандаа гаргаж, телевизийн камерын гэрлээ асаалаа.

Үгүй ээ! Электрон үүнд бэлэн биш байлаа.

Цагдаагаар хүрээлүүлсэн Электрон гэрэл зургийн гэрэлд нүдээ анивчуулан алхав. Хакер тэднийг үл тоохыг хичээж байв. Телевизийн камер, гэрэл зургийн аппарат түүний өмнө эрээлжилж, сурвалжлагчид зууралдан чиргүүлдэнэ. Эцэстээ арай гэж нэг юм байшингийн дотор талд орлоо. Уулзалтын ундуй сундуй өрөөнд яах гэж байлгаж байгааг Электрон сайн ухаарсангүй. Удалгүй мөрдөгчийн асуулт бүх зүйлийг тодруулж өгөв. “Энэ удаад цагдаа нар тантай бүдүүлэг харьцсан гэж үзэх ямар нэгэн тайлбар байна уу?” гэж түүнээс асуухад унтлагын өрөөний шалан дээр хэвтэж байхад хэвлий рүү нь хүчтэй цохисныг Электрон санаад мөрдөгч Проестлийн нүд рүү ширтэв. Мөрдөгчийн царайд үл ялиг инээмсэглэл тодорчээ.

“Үгүй ээ” гэж Электрон хариулав.

Тэр өрөөнд байгаа прокурорын ярьсан зүйлийг Электрон сонсоод бүр алмайрав. Тухайн үед бас нэгэн гэмт хэрэгтэн тэнд байсан бөгөөд онц аюултайгаас гадна, өвчтэй нэгэн гэж

прокурор хэлжээ. Прокурор түүнийг барьцаагаар суллахын оронд тэр этгээдтэй хамт саатуулахаар шийдсэнээ мэдэгдсэн аж.

Үүнийг Электронд тустай сануулга гэх үү эсвэл садист хандлагыг илэрхийлж, ямар нэгэн таашаал авахын тулд хэлсэн үгс гэж ойлгох уу? Электрон айсан боловч удаан эргэцүүлэх хугацаа байсангүй. Прокурор түүнд барьцаагаар суллагдах зөвшөөрөл олгожээ. Электроны аав түр хорих байранд ирж хүүгээ авахдаа нэгэн бичиг баримтанд гарын үсэг зуржээ. Хэрэв Электрон хотоос гадагш гарвал 1000 доллар төлөх болсон аж. Оройны мэдээгээр түүний нэр гарахыг Электрон харж суулаа.

Дараагийн хэдэн долоо хоногийг гэртээ өнгөрөөхдөө хакердах сонирхлоо үүрд хаях эсэхээ бодож шаналсаар байв. Түүнд компьютер байхгүй боловч модем нь бий. Компьютер байсан ч хакердах тухай бодох нь аюултай гэдгийг тэр ойлгожээ.

Ингээд тэр мансууруулах бодисыг сонгов.

Электроны аав 1991 оны 3-р сард эмнэлэгт хэвтэхээс өмнө өвчнөө хүндэртэл гэртээ хэвтжээ. Эмнэлэгт хэвтвэл дахин хэзээ ч гэртээ буцаж ирэхгүй гэдгээ тэр мэдэж байлаа.

Тиймээс эмнэлэгт хэвтэхээс өмнө хийж амжуулах, зохион байгуулах зүйл их байв. Орон байр, амь даатгалын бичиг баримтын асуудал, гэрээслэл, оршуулга, хоёр хүүхдийг нь харж хандах найз нөхөддөө зааварчилга өгөх зэрэг олон ажил хүлээнэ. Мөн хүүхдүүддээ захиж хэлэх зүйл их байна.

Тэр хоёр хүүхэд рүүгээ сэтгэл зовнин харна. Тэд 19,21 нас хүрсэн ч халамж, туслалцаа шаардлагатай ажээ. Түүний үхэл хаалга тогшиж байгаа энэ үед Электроны үзэл бодол, түүний дүү охины тусгаарлагдмал араншин зэрэг бэрхшээлүүд шийдэгдэхгүй үлдэнэ гэдгийг аав нь ойлгожээ. Хорт хавдар улам хүндрэх тусам хүүхдүүддээ хир их хайртай болохоо илэрхийлэхийг аав нь оролдоно. Өнгөрсөн хугацаанд зарим нэг талаараа хөндий байсан ч үлдсэн цаг хугацааг бодохоор хүүхдүүддээ өрөвдөн шанална.

Харин Электрон хэрэгт орооцолдсон асуудлыг аав нь үл тоох хандлагатай байв. тэрээр нилээд амжилт гаргасан хакердах ажиллагааны тухай л аавдаа хааяа нэг хэлдэг байжээ. Хакердах ажиллагаа бол хууль бус гэж түүний аав үздэг байв. Цагдаа нарт баригдах цаг ирнэ гэж ч тэр хүүдээ хэлж байсан гэдэг. Тэр цагт чи өөрөө л асуудлыг шийдэх хэрэгтэй болно шүү хэмээн захисан нь санагдана. Гэвч тэр хүүгээ дуртай юмнаас нь холдуулахыг хүсээгүй юм. Нөгөө талаар хүүгээ бие даан амьдарч, хийсэн үйлдлийнхээ үр дагаварыг эргэцүүлэх насанд хүрсэн гэж тэр үзжээ. Цагдаагийнхан түүний гэрт нэгжлэг хийж байхад Электроны аав нь үл тоосон янзтай байсан билээ. Тэрээр: “Би хэзээ нэгэн цагт ийм зүйл болно гэж хэлдэг байсан, одоо чи өөрийнхөө хариуцлагыг үүрэх болсон” хэмээн төвийг сахисан байр сууринаас хэлж байв. Электрон Их сургуулийн нягтлан бодохын ангид сурч байхдаа хакердах ажиллагааг сонирхож эхэлжээ. 1991 оны 3-р сард түүнд ял тулгасан юм. Тэр ялыг давж заалдахаа шийдэх эсэх л үлджээ.

АНУ болон Австралийн компьютерүүд рүү хууль бусаар нэвтэрсэн үйлдэлд нь түүнд 15 зүйл ангиар ял тулгав. Худалдаа бизнесийн салбарын мэдээллийн санд нэвтэрснийг нилээд

ноцтой гэмт үйлдэл гэж үзжээ. Төрийн прокурорын газраас мэдэгдсэнээр Электрон мэдээллийн санг санаатай өөрчилж, арчсан гэж мэдэгджээ. Электрон өөрийн нууц ажиллагааг хийхэд зориулан системд гарц бий болгох явцад дээрх үйлдлүүд гарсан болохоос бус ямар ч файлыг санаатайгаар гэмтээж байгаагүй ажээ. Түүний эсрэг гаргаж үзүүлсэн нотлох баримт маш хүчтэй байлаа. Хакердах тухай Феониксийн утаснаас Электрон руу ярьсан ярианы бичлэг, цуглуулсан мэдээллийн хуулбар, Мелбурнийн Их сургуулийн системээс гарсан холболт түүний гэрийн утастай шууд холбогдсон логоуд, эцэст нь Электроны цагдаад үнэнээ мэдүүлсэн байцаалт зэрэг хөдөлшгүй нотлох баримтууд шүүхийн гарт байв. Хакерын тухай шинэ хууль гарснаас хойш Австрали улсад гарсан анхны томоохон хэрэг энэ байлаа. Энэ бол Австрали улсад гарсан компьютер хакердах гэмт хэргийг шийдвэрлэх анхны тохиолдол учраас Төрийн прокурорын газраас хатуу бодлого барьжээ. Хавтас хэрэгт нийт 17 боть нотлох баримт буюу ойролцоогоор 25000 хуудас материал цугларч, Ерөнхий прокурор Лиза Вест АНУ, Европ, Австралиас хорь орчим тооны гэрч, шинжээчийг дуудахаар төлөвлөсөн байна. Дэлхийн эргэн тойронд байгаа компьютер сүлжээнд маш их будлиан тарьсан Австралийн хакеруудын тухай ярих үлгэр тэдгээр гэрчүүдэд их байв. “Execucom Systems” корпорацийн мэдүүлж байгаагаар тэдний систем дээр хадгалагдаж байсан Техаст байдаг компаний худалдан авсан эд хөрөнгийн жагсаалтын цорын ганц мэдээллийн баазыг Феоникс санамсаргүй устгасан ажээ. Мөн хакерууд АНУ-ын Тэнгисийн цэргийн судалгааны лабораторийн аюулгүй байдлын ажилтнуудыг сандаргаж дөнгөжээ. Тэд Нью-Йорк Таймс сонинд бардамнаж, NASA-ийн компьютерийн сүлжээг 24 цаг таслахад хүргэж байв.

Австралийн Холбооны цагдаагийн газрын түрүүч Кен Дей NASA-ийн Ланглей дахь компьютерийн менежер Шарон Бескинисээс гэрчийн мэдүүлэг авах гэж дэлхийн хагасыг туулсан юм. Шарон бол Deszip програмыг олзолж авахыг Феоникс оролдох үед сүлжээнээс нь санамсаргүй гаргачихсан админ байсан билээ. Бескинис хатагтай 1990 оны 7-р сарын 24-ний өдөр Виржиниад гэрчийн мэдүүлэг өгчээ. Түүний өгсөн мэдүүлэгт дурьдсанаар 1990 оны 2-р сарын 22-нд бүхэл бүтэн 24 цагийн турш дэлхийн бусад хэсгээс NASA-ийн компьютерийн систем салгагдаж, гадаад харилцаа холбоо тасарсан гэж бичжээ. Товчхондоо гэмт хэрэгт буруутгаж байгаа шүүх хурлаас зүгээр нэг мултрах боломж байхгүй гэж Электрон дүгнэв. Ноум ч ингэж бодож байв. Феоникс зөвшөөрөлгүй бусдын компьютерт нэвтэрч байсныг тэр сайн мэдэж байсан билээ. Түүний хоёр гэмт үйлдэлд ял төлөвлөжээ. Нэг нь Ланглей дахь NASA нөгөө нь CSIRO буюу zardoz-ийн файлтай холбоотой үйлдэл байв. Ноум ч түүнд тулгасан ялыг эсэргүүцсэнгүй. Гэвч хуульчийг санхүүжүүлж шүүх хурлын ажиллагаанд хуулийн туслалцаа авах явдлыг эсэргүүцсэн нь түүний шийдвэрт нөлөөлсөн нь эргэлзээгүй юм.

1991 оны 3-р сарын 6-ны өдөр Викторианы шүүхэд Электрон, Ноум хоёрын хэргийг шүүгч Роберт Лангтон авч хэлэлцэв. Анд хакеруудын үзэд бодлыг Феоникс зөвшөөрөөгүй юм. Гэр бүлээсээ санхүүгийн туслалцаа авсан Феоникс түүнд тулгасан ялыг эсэргүүцэхээр шийджээ. Гэмт хэрэг үйлдэгдсэн газраас шалтгаалан өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг төлөвлөсөн 48 үйлдэлд оноосон ялаас 47 үйлдлийг хасахыг Феониксийн өмгөөлөгч хатагтай Фелисити Хампел хүсэв. Нэг үйлдэл нь Австрали улсаас гадна хакердах ажиллагаа хийсэн буюу Zardoz-ыг хулгайлахаар CSIRO-ийн компьютер руу нэвтэрсэн үйлдэл болж таарчээ. АНУ-ын Техас мужийн компьютерийг хакердсан үйлдэлд Австралийн шүүх ял оноож болно гэж үү?

Олон нийтийн нүдэнд Феоникс ялыг эсэргүүцэж байгаа мэт байсан ч Австралийн шүүх АНУ-тай тохирон түүнийг шилжүүлж магадгүй хэмээн эмээж байлаа. Аль ч талаас үзсэн энэ бол туршилтын туулай болсон хэрэг байв. Австралийн хакертай холбоотой анхны хэрэг төдийгүй компьютерийн гэмт хэргийг таслан шийдвэрлэх ажиллагааны явцад тулгасан ялыг эсэргүүцсэн анхны тохиолдол байлаа. Түүний 48 үйлдлийн нэгийг нь хасахыг прокурор хүлээн зөвшөөрсөн хэдий ч Феоникс хүндхэн цохилтонд орох бяцхан л ялалт хийсэн гэлтэй. Хэргийн сонголыг хоёр хоног хянасан шүүгч Жон Вилкинсон Хампел өмгөөлөгчийн гэмт хэрэг үйлдэгдсэн газар нутгийн тухай заргыг үндэслэл байхгүй гэж үзсэн учраас Феониксийн хэргийг 1991 оны 8-р сарын 14-ны өдрийн мужийн шүүх хурлаар авч хэлэлцэхээр шийдвэрлэжээ.

Электроны хэргийг гуравдугаар сард авч хэлэлцэх үеэр түүний аавын бие эрс муудаж эхлэв. Түүний ходоодны хорт хавдар улам хүндэрчээ. Гуравдугаар сарын сүүлчийн өдөр эмнэлэг бараадах цаг нь болсон гэж түүний эмч зөвлөсөн аж. Гэвч аав нь эмчийн зөвөлгөөг эсэргүүцэн зөрүүдэлсэн байна. Тэд дахин ятгасан боловч эсэргүүцсээр бүр сүүлдээ гуйж үзсэн гэдэг.

Тэр өдөр болон маргааш нь Электрон ба түүний охин дүү аавынхаа хамт олон цагийг өнгөрөөжээ. Түүний сэтгэлийн дэм өгөхийн тулд аавынх нь дүү, бусад олонхүмүүс иржээ. Электроны авга ах Иус Христ итгэхийг сүсэглэн гуйх агаад тамд очихгүй гэж тайлбарлана. Электрон авга ахыгаа итгэж ядан харна. Тэгээд ч биеэ барихыг илүүд үзсэн Электрон аавынхаа орны хажууд тайван сууж, нүдэнд цийлэгнэх нулимсаа барьж ядан хүчлэнэ.

Аав нь өөрийн үхлийг хүлээн зөвшөөрсөн мэт оршуулгын тухай ярьж эхэллээ. Тэр оршуулга гэдгийг хурим хэмээн хальтарч хэлээд хэсэг түдгэлзсэнээ алдаагаа ойлгов. Хуруундаа зүүсэн хурмын мөнгөн бөгж рүү нүдээ аажуухан шилжүүлэн гөлөрснөө, сулхан инээмсэглэж: “Бараг л хурим шиг болох биз дээ” хэмээн хэллээ.

Электрон охин дүүгийн хамт эмнэлэг рүү очиж, аавынхаа орны хажууд сууж дөрвөн өдрийг өнгөрөөжээ. Тав дахь өдрийн өглөөний зургаан цагт тэдний гэрийн утас дуугарав. Хүүхдүүдийг харж байхыг захисан аавынх нь найз утсаар ярьжээ. Түүний аавын бие улам муудаж, амьсгаа хурааж магадгүй тухай мэдэгдэв.

Электрон дүүгийн хамт эмнэлэг дээр ирэхэд сувилагчийн царай бүхнийг илэрхийлж байлаа. Тэд оройтжээ. Аав нь арван минутын өмнө амьсгал хураасан байв. Электрон шалан дээр сөхрөн суугаад уйлж гарлаа. Эмнэлгээс буцах замд гэр бүлийнх нь найз эмэгтэй утасны автомат хариулах машин аваад: “Хүн бүр утасдаад эхлэхээр та хоёрт хэрэг болно. Нэг хэсэгтээ утсаар ярихыг хүсэхгүй байх” гэж хэлжээ.

1990 онд цагдаа нарт баригдсаны дараа Электрон марихуана татаж эхлэв. Эхлээд их сургуулийн бусад оюутны хамт татдаг нийтлэг сонирхол байлаа. Зарим нэг найзууд нь гэрт нь ирээд хэдэн холимог татсаны дараа хотын төвөөр явж шөнийг өнгөрөөнө. Тэр хакердах ажиллагаа хийж байхдаа хэзээ ч мансууруулах бодис татаж байгаагүй аж. Толгой эрүүл саруул байх туйлын их ач холбогдолтой байв. Түүнээс гадна марихуана татсанаас хакердах нь хэдэн зуу дахин их таашаалыг түүнд өгдөг байлаа.

Нью Йорк Таймс сонины тэргүүн нүүрэнд Феониксийн тухай гарч эхлэнгүүт Электрон хакердах явдлаа зогсоожээ. Тэгээд ч цагдаагийнхан компьютерийг хурааж авсан тул хакердахыг хүслээ ч хийх боломжгүй байсан юм. Аавынхаа биеийг муудах тутам өөрийгөө сатааруулах ямар нэг зүйл хийхийг хичээсэн боловч гарт баригдах зүйл олж чадсангүй. Нягтлан бодох мэргэжлээр суралцахдаа тэр нэг их амжилт олж чадаагүй нь сэтгэл дутсаных бизээ.

Оргүй хоосон санагдах орчинг мансууруулах дон дүүргэж, түүндээ улам гүн орж байв. Өөрийн гэртээ хакердаж байгаад баригдах нь найзынхаа гэрт марихуана татаж байгаад баригдахаас хэцүү гэж тэр өөртөө хэлэх болжээ. Муу зуршил түүнийг улам идэж байлаа. Удалгүй тэр гэртээ татдаг болов. Шинэ найзууд гэрээр нь зочлох болж, мансуурах дон наргих бус амьдрахын тулд хийж байгаа зүйл болон хувирчээ. Электрон шинэ хоббидоо мөнгө ихээр үрэх болов. Тэдний гэрт Электроны хоёр шинэ найз хэдэн сар амьдрахаар иржээ. Дүү охин нь гэртээ мансууруулах бодис худалдаж байгаад дургүй байсан ч Электрон түүний эргэн тойронд юу болж байгааг мэдрэх сөхөөгүй байлаа. Тэрээр зөвхөн өрөөндөө суугаад хөгжим сонсож, марихуана татан өдрийг өнгөрөөдөг болов.

Хөгжимний чихэвч гэрт нь байгаа бусад хүмүүсээс тусгаарлах хэрэгсэл болж Электрон хачин чиг аястай хөгжимд толгойгоо мэдүүлжээ. Түүний оюун санаанд ер бусын хачин бодлууд эргэлдэж, хөгжмийн ертөнцөөр жингүйдэх болов. Аав нь амьд байгаа мэт санагдана. Маргааш өглөө нар мандана гэдэгтэй адилхан Электрон үүнийг баттай мэдэж байгаа гэдэгтээ итгэж байлаа. Тэр өөрийн аавыг эмнэлгийн орон дээр нас барсныг харсан боловч өөрийн бодолдоо итгэх болжээ.

Удалгүй хүмүүс этгээд аашлах болов. Хүмүүс Электронд юм хэлэхэд тэднийг ойлгож чадахгүй удаан зогсоно. Хөргөгчнөөс савтай сүү гаргаад үнэрлэх үед “Сүү дуусчихсан” гэж түүний дүү охин хэлнэ. Харин Электрон юу хэлээд байгааг нь бүрэн ухаарахгүй, түүн рүү гайхан хардаг болжээ. Магадгүй дүү нь аалз ч юм уу ямар нэгэн өөр зүйлийн тухай хэлэхийг оролдсон байх гэж бодно. Жишээлбэл: аалзыг сааж хор авах тухай ч юм уу...

Хачин бодол Электронд төрөнгүүт гайхан санааширж, сатаарна. Иймээс тэр өрөөндөө л олж мэдрэх аюулгүй орчин руу буцаж, хөгжмөө сонсох ажээ. Мартагдсан ертөнцөд хэдэн сарыг өнгөрөөсний дараа өөрийн унтлагын өрөөнд сэтгэл мэдрэлийн эмч нар ирсэн байхад Электрон ухаан орлоо. Тэд түүнээс асуулт асууж байгаад хөх өнгөтэй эм уулгахыг оролджээ. Электрон эмнүүдийг уухыг хүссэнгүй. Жижигхэн хөх эмнүүд тайвршуулах үйлчилгээтэй юм болов уу? Тэр үүнд эргэлзэхгүй байв. Эсвэл түүнээс ч илүү хөнөөлтэй байх гэж бодно. Эцэстээ сэтгэл мэдрэлийн эмч нар Электроныг стелазине гэдэг эмийг уулгаж дөнгөжээ. Гэвч тэднийг явсны дараа аймшигт зүйлс эргэн ирнэ. Түүний нүд хяналтгүйгээр эргэлдэж, толгой нь зүүн тийш татах ажээ. Тэр амаа том ангайгаад хааж чадахаа болив. Хаахыг хичнээн оролдовч чадахгүй байлаа. Тэр толгойгоо эгцэлж харахаас өөр биеэ удирдах, хөдөлгөөн хийж чадахаа больжээ. Электрон өөрийгөө толинд хараад цочиж байв. Түүний царай аймшгийн киноны баатар мэт харагдана.

Тэр удалгүй өөрийгөө алмаар санагдаж байна хэмээн ярих болжээ. Сэтгэл мэдрэлийн эмч нарыг дахин дуудаж үзүүлэхэд амиа хорлох оролдлого хийхгүй гэж амласан цагт л явна гэж хэлж байв.

Электрон тэдний хүсэлтийг эсэргүүцсэн тул сэтгэл мэдрэлийн эмнэлгийн барааг харахаас өөр аргагүй болсон юм. Тэр галзуурсан ч гэсэн эмнэлэгт хэвтсэн гэдгээ мэдрэх сөхөөгүй байлаа. Тэр хаана ч явсан нэг газар байгаа мэт аашлах ажээ. Түүний аав бүгдийг зохион байгуулсан гэж тэр үзэж байв.

Түүнд юм ярьсан хэнд ч болов тэр итгэхээ больжээ. Бүгд худал гэж үзнэ. Тэд нэг юм ярина, гэтэл нөгөө ярьсан зүйл үргэлж өөрийг өгүүлнэ. Тэр ч үүнийг нотолжээ. Ханан дээр бичиж наасан өвчтөний нэрсийг Электрон уншиж байгаад Tanas нэрийг олов. Энэ нэр тусгай утгатай байлаа. “Santa” гэсэн үгний үсэгнээс тэр нэр бүтсэн. Гэвч Санта Клаус бол үлгэр домог байсан учраас эмнэлгийн ханан дээр байгаа жагсаалтын Tanas нэр бусдад итгээд хэрэггүй гэдгийг нотолно гэж тэр үзжээ.

Электрон хоолоо чимээгүйхэн идэж, хоолны газар байгаа бусад өвчтнүүдийг үл ойшоохыг хичээнэ. Нэгэн удаа үдийн хоолны үеэр Электроны ширээн дээр гадны хүн ирж суув. Өөр хүнтэй юм ярих нь туйлын ядаргаатай санагдах тул үл таних хүнийг хурдан явахыг тэр хүсэж байлаа. Үл таних эр эмнэлэгт сайн мансууруулах эм өгч байгаа тухай ярьжээ.

“Мм .. Би маш их мансууруулах зүйл хэрэглэж үзсэн” гэж Электрон ярив.

“Их гэж аль хир вэ?”

“Би дөрвөн сарын хугацаанд 28000 долларыг марихуанад зарцуулсан” гэхэд “Хөөх” гэж үл таних эр шогшроод “Мэдээж чи энд мансууруулах эмнүүдийг худалдаж авах шаардлагагүй. Үнэгүй авна шүү. Би ч үнэгүй авдаг” гэв.

“Тийм гэж үү?” хэмээн Электрон гайхан асуув.

“Тиймээ, байнга л авдаг. Асуудал огт байхгүй ээ. Харж бай” гэж үл таних эр бардам хэллээ.

Тэр хоол идэж байгаа сэрээгээ ширээн дээр аажуухан тавиад, болгоомжтой нь аргагүй боссоноо тэнхээ мэдэн хашгирав. Мань эр гараа савчин, бусад өвчтнүүдийг хэл амаар доромжилж гарлаа. Хяналтын өрөөнөөс хоёр сувилагч гүйн ирэв. Тэдний нэг нь орилж байгаа эрийг тайвшруулахыг оролдох зуур нөгөө нь төрөл бүрийн эмнээс сонголт хийж, аяга устай хамт барилаа. Үл таних эр эмийг залгилж, уснаас томоохон балган чимээгүй болов. Сувилагчид мөрөн дээгүүр эргэж харсаар алхан холдлоо.

“Харав уу?” гэж мань эр хэлээд “За за эм үйлчилж эхлэхээс өмнө би явлаа. Дараа уулзая” гэж хэлэв.

Үл таних эр цүнхээ үүрээд хоолны газрын хаалгаар гарч одохыг Электрон харна.

Нэг сарын дараа Электрон эмнэлгээс гарч Куинсланд дахь эмэг эхийн гэрт очжээ. Тэр сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтанд байх болов. Өөрийгөө Иусус Христ гэдэгт итгэх Электрон Куинсландад эхний хэдэн өдрийг өнгөрөөжээ. Тэр тэнд удаан амьдарч чадаагүй юм. Хоёр долоо хоногийн дараа тэрээр Буддагийн хойд дүр гэдэгт бүрэн итгэж болсон байна.

1992 оны 2-р сарын сүүлээр сэтгэл мэдрэлийн эмчилгээнд гурван сар хамрагдсан Электрон Мелбурнд цүнх дүүрэн эмтэй буцан ирж, их сургуульдаа суралцлаа. Тайвшруулагч эм прозакийг тэр ууж эхэлжээ. Өдөр бүрийн амьдрал жирийн өнгөрч байв. Өглөө хоёр, өдөр хоёр, шөнө хоёр гэхчлэн зургаан прозакийг ууна. Өөрийн мэдэлгүй нүд эргэлдэх, эрүү сулран унжих, хүзүү хөшихөөс урьдчилан сэргийлэх эмийг мөн шөнийн цагаар ууж байлаа. Эдгээр эмнүүд нь Каннабисын эмгэг, шизофрения, сэтгэцийн өөрчлөлт, шизофренаформ, анфетамины сэтгэцийн гажиг зэрэг оноштой өвчтөнд өгдөг эм аж. Гэвч эм түүнд онц нөлөө үзүүлж чадаагүй юм. Электрон бие сайжирч амжаагүй мөртлөө Мелбурнийн олон бэрхшээл дунд эргэж орсон нь байдлыг нөхцөл байдлыг улам хүндрүүлжээ.

Түүний өвчин хүндэрсэн учраас хуулийн савраас хол байх болов. Нарлаг Куинсланд түүнийг аятайхан мултрах боломжоор хангажээ. Одоо тэрээр Викториад эргэн ирж их сургуулийн нягтлан бодохын ангид суралцахын зэрэгцээ сэтгэцийн өвчинтэйгээ тэмцэлдэж байв. Үүнээс гадна Австралийн хакерын хамгийн томоохон, анхны гэмт хэрэгт тооцогдох үйлдэлд нь арван жилийн ял тулгажээ. Хүндхэн өвөл болж магадгүй байлаа.

Электрон ууж байсан эм нь түүний сурлагт ноцтойгоор нөлөөлсөн юм. Хүчтэй эмний муу нөлөөг сааруулах бэлдмэл түүний нүдний булчинг амрааж, тод харах чадварыг нь бууруулна. Самбар дээр байгаа бичиг эрээлжилж, бүрэлзсэн хавтан болж харагдана. Тэмдэглэл хийж авахад хүртэл хүндрэлтэй. Түүний ууж байгаа эм гарыг нь чичрүүлэх тул зүгээр гаргацтай бичиж чадахгүй байв. Лекцийн тэмдэглэл нь хүн гаргахын аргагүй байдаг байлаа. Электрон эмээ ухаа зогсоож марихуана татдаг боллоо. Удалгүй түүнд арай л хялбар мэт санагдах болов. Марихуна олдохгүй тохиолдолд шидэт мөөг, хий юм харагдуулж дэмийрүүлдэг кактусыг хэрэглэнэ.

Хакердах гэмт хэргийг шийдвэрлэх хугацаа ойртсоор байв. 1991 оны 12-р сарын 6-нд түүнийг Куинсланд руу нисэхээс өмнө, сэтгэл мэдрэлийн эмнэлгээс гарсны дараахан Төрийн прокурорын газраас Электронд 15, Ноумд 3 ял тулгаж албан ёсоор Викториа мужийн Шүүх хурлаар авч хэлэлцэхээр шийдвэрлэжээ.

Электрон Феоникстэй ярилцахаа больсон боловч Төрийн прокурорын газрын хуульчид түүнийг мартаагүй байсан юм. Феоникс хуулийн байгууллагатай тэмцэлдэж байсан учраас түүнд зориулан арай томоохон төлөвлөгөө зохиожээ. Феоникс баривчлагдсан өдрөө цагдаагийн ажилтны асуултанд хариулахаас татгалзаж байв. Түүний гарын хурууны хээг авах гэхэд эсэргүүцэж маргасан аж. Түүний ааш цагдаа болон прокурорын газрын ажилтнуудын дургүйцлийг хүргэсэн нь дамжиггүй.

1992 оны 5-р сарын 5-нд мужийн шүүхээр Феониксэд тулгаж байгаа 40 ялыг авч хэлэлцэх болов. Электрон, Ноум хоёрт тулгаж байгаа ялтай нийлээд нийт 58 ялыг төлөвлөжээ.

Электрон шоронд орохоос айж байв. Дэлхийн эргэн тойронд байгаа Пар, Пенго, LOD, Эрик Блудакс, MOD, Realm-ийн хакерууд, Пад, Гандалф болон Олон улсын босогчид нэртэй бүлгийн хакерууд бүслэлтэнд байлаа. Электронд 1990 оны 4-р сард анх удаагаа тулгасан ял нилээд өөрчлөгджээ. Анх удаа цагдаа нарт баривчлагдсан тэр өдөр, түүнийг буруутгаж танилцуулсан ял прокурорын газрын сүүлд танилцуулсан ялаас огт өөр болжээ. Хамгийн сүүлд тулгаж байгаа ял нь дэлхийн томоохон байгууллагуудын хэн нь хэн бэ гэснийг харуулах

мэт санагдаж байв. Калифорниагийн Лауренсе Ливерморийн лаборатори, Вашингтоны АНУ-ын Тэнгисийн цэргийн судалгааны лабораторийн хоёр өөр компьютерүүд, Нью Жерсей мужийн Рутгерсийн Их сургууль, Финландын Тамперын нэрэмжит Технологийн Их сургууль, Мелбурнийн Их сургуулийн гурван компьютер, Финландын Хелсинк хотын Технологийн Их сургууль, Нью Йоркийн Их сургууль, Виржиниа мужийн Хамптон дахь NASA-ийн судалгааны төв, Викториагийн Карлтон дахь CSIRO зэрэг байгууллагыг дурьджээ.

АНУ-ын Тэнгисийн цэргийн судалгааны лаборатори, CSIRO, Лауренсе Ливерморийн лаборатори, NASA-ийн компьютертэй холбоотой үйлдлүүд Электроны санааг ихэд зовоож байв. Хамгийн сүүлийн гурав дээр хакердах гэмт хэргийг ганцаар үйлдээгүй билээ. Феоникс тэдгээр сайтууд нэвтэрч байхад Электрон санаатайгаар тусалсан гэж прокурорын газар буруутгаж байгаа юм.

Арван гурван хуудас ялын дүгнэлтийг Электрон хараад уйлах, инээхийн хооронд алмайран зогсоно. Тэдгээр сайтуудад нууцаар нэвтрэхэд санаатайгаар тусалснаас илүү ихийг тэр хийсэн билээ. Ихэнх тохиолдолд компьютерүүд рүү Феоникс нууцаар нэвтрэх боломжийг Электрон өгсөн. Электрон бусдын сүлжээнд даруухан, чимээгүй нэвтэрдэг байсан бол Феоникс үхэр сүрэг дайраад гарсан мэт их хэмжээний ул мөрийг үлдээж байв. Тэдгээр сайтууд руу нэвтэрсэн бүх ялыг Электрон ганцаар үүрээд гарахыг хүсэхгүй байв. Тэрээр Х.25 сүлжээн дээр хэдэн мянгаад сайт руу нэвтэрсэн боловч тэдгээрийн алинд ч шийтгүүлээгүй юм. Татвараас зайлсхийхийн тулд Ал Капоне юу хийсэнтэй адилхан үйл явдал болж байгаа мэт түүнд санагдаж байв.

Хэргийг шийдвэрлэх явц хэвлэл мэдээлийн анхаарлыг зүй ёсоор татаж байлаа. Австралийн Холбооны цагдаагийн газар болон прокурорын газрынхан “Ямар нэг зүйл хийснээ” Америкчуудад харуулах үүднээс удахгүй болох шүүх хурлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санаатайгаар сануулга хийсэн гэж Электрон сэжиглэж байлаа. Америкчуудаас ирж байгаа дарамт энэ хэрэг дээр илт мэдрэгдэж байлаа. Шүүх хуралд АНУ-ын гэрчүүдийг оролцуулахын тулд Америкийн компаниуд, засгийн газрын агентлагууд мөнгөн шагнал амласан хэмээн сэжиглэж байгаагаа Электроны өмгөөлөгч Борис Кейсер хэлжээ. Австралийн хакерууд хамгийн дээд ялыг авахыг Америкчууд хүсэж, чадах бүхнээ хийж байв. 1988 онд АНУ-ын Нууц Алба, Австралийн Холбооны цагдаагийн газартай холбогдож, мөрдөн байцаалт хийлгэх хүсэлт тавьснаар The Realm-ийн хакеруудыг тагнаж, одоогийн хуулийн асуудал үүссэн гэж Электронд танилцуулсан байна. Тухайн үед Citibank-ны компьютер руу нэвтэрсэн хакеруудын араас Нууц Албаны мөрдөгчид ажиллаж байсан юм. Харин Электрон Citibank-ны хэрэгт огт оролцож байгаагүй аж. Түүнийг сонирхлыг кредит карт татдаггүй байлаа. Банкны компьютертэй зууралдах нь уйтгартай, тэгээд ч нягтлан бодохын ертөнцэд хамааралтай тоонуудаар дүүрсэн байдаг гэж тэр үзнэ. Тэр Их сургуулийн нягтлан бодохын ангид тэдгээр төрлийн тоог хангалттай үзэж, шаналсан юм. Яагаад ч юм банкнаас хулгай хийнэ гэсэн бодол түүнд төрдөггүй байжээ.

Харин АНУ-ын Нууц Алба Феоникс болон банкнуудыг маш их сонирхож байв. Феоникс Citibank-ны компьютерт нэвтрээд зогсохгүй Citibank руу хийсэн довтолгоог удирдан зохион байгуулсан гэж үзэж байлаа. АНУ-ын Нууц Алба яагаад ингэж бодох болов? Яагаад гэвэл Феоникс хакерын ертөнцөд энэ тухай сайрхан, бардамнаж байсан юм. Энэ тухай ч Электрон

хэлж байв. Тэр Citibank-ны компьютерийг хакердаад зогсохгүй 50,000 долларыг хулгайлсан гэж онгирчээ.

Түүнд танилцуулсан зүйл үнэн гэдгийг нотлох зүйлийг Электрон олж мэдэв. Феониксийн гэрийн утсыг чагнах зөвшөөрлийг авахад Citibank-нд учруулсан хохирол гол үндэслэл болсон ажээ. АНУ-ын Нууц Алба хэргийг мөрдөж байсанд эргэлзээ алга гэж Электрон боджээ. Нэр нь үл мэдэгдэх гадны этгээдүүд тэднийг хоослох арга зам олсныг банкууд мэдээд сэтгэлээр унасан нь мэдээж.

Феоникс Citibank-наас ямарч мөнгө хулгайлаагүй гэдгийг Электрон мэдэж байлаа. Хакеруудын дунд нэр төрөө өсгөхийн тулд зөгнөлт зохиол гэмээр түүхийг тэр тарааж байсан бөгөөд ингэх явцдаа бүгдийг баригдах суурийг тавьжээ.

1992 оны 9-р сард Феоникс Электрон руу утасдаж хэргийн талаар ярилцъяа гэв. Электрон маш ихээр гайхав. Магадгүй тэр тэдний хоорондох холбоо улам суларч байгааг мэдэрсэн байх. Электроны өвчин ертөнцийг үзэх үзлийг нь өөрчилжээ. Феоникстэй хол хөндий харьцаж байгаа явдал нь түүний байнга сагсуурч, бардамнаж байсанд эндүүцсэний илэрхийлэл байлаа. Электрон түүнд дургүй учраас уулзахыг хүсэхгүй байв. Үүнээс гадна Австралийн хакеруудад тулгаж байгаа одоогийн ял бол Феониксээс шууд хамааралтай гэж тэр боджээ.

Хэдэн сарын дараа Феониксийн өмгөөлөгч Жон Маклоуфлин Электронд нэгэн санаа хэлэв. Хуулийн хүрээнд авч үзвэл энэ бол шинэ зүйл биш ажээ. Харин Электронд түүний хэлсэн зүйл цоо шинэ мэт байлаа. Тэр Маклоуфины зөвөлгөөг дагахаар шийджээ.

Электрон Феониксийн эсрэг гол гэрч болж мэдүүлэг өгөхөөр шийдэв.

Шүүх хурал

“Таны мөрөөдлийн ертөнц төгсөх болжээ”

“Dream world” Midnight Oil хамтлагийн дуу

Realm-ийн хакеруудыг Австралийн хуулийнхан илрүүлсэн гэсэн аймшигт мэдээг Британий хакер Пад, Гандалф нар дэлхийн нөгөө өнцөгт сэтгэл түгшин сонсжээ. Нэг л өдөр Электрон сураггүй алга болов. Богино хугацааны дараа Феоникс мөн алга болсон. Удалгүй сонин болон Алтостой адилхан Германы боард Лутцифер дээр Австралийн хакеруудын тухай мэдээлэл цацагдаж эхэллээ. Пад мөн адил сэтгэлийн дарамттай байв. Британий хакерууд RTM өтний програм дээр үндэслэн шинэ програм зохиож интернет рүү тавина гэж Евгене Спаффордын бичсэн файлыг хакердах явцдаа олж уншжээ. Түүний бичсэнээр Британий нэр нь үл мэдэгдэх хакерууд хэдэн мянган интернет сайтууд дээр дээд зэргийн гамшиг учруулах аж.

Пад, Гандалф хоёр төрөл бүрийн өтний source кодийг олзолж авсан нь үнэн байсан юм. Тэд SPAN-ы сүлжээгээр хэсүүчилж байхдаа Father Christmas өтний хуулбарыг олж авчээ.

Лауренсе Ливерморийн Үндэсний лабораторийн Рассель Брендийн компьютерийг амжилттай хакердсаны дараа WANK өтний иж бүрэн хуулбарыг чадварлагаар хулгайлсан байна. Түүнчлэн SPAN-ы сүлжээ рүү нэг этгээд нэвтгэрч WANK өтний кодыг хайсан тухай тодорхойлсныг Брендийн компьютерээс уншжээ. Гэхдээ хэн уг өтний кодыг хайсан гэдгийг олж тогтоогоогүй ажээ. “Тэр хүн чинь би байсан юм гэж” Гандалф Падад хэлж байлаа.

Өтний кодны арвин цуглуулгатай болсон хэдий ч Пад тиймэрхүү өтний програмыг бичих санаа байгаагүй юм. Тэд өтний нэвтгэрч байгаа аргыг судлахаар кодыг цуглуулсан бөгөөд өөр шинэ арга замыг эрэлхийлж байлаа. Хакердсан системдээ ямар ч хохирол учруулж байгаагүй гэдгээрээ Британий хакерууд бахархана. Баат, Эдинбург, Оксфорд, Стратклайдын Их сургуулийн компьютер руу нууцаар нэвтрээд тэд админд зориулж 8lgm гэсэн тэмдэглэлийг үлдээж байв. Энэ бол өөрсдийгөө мэдрүүлэхийн сацуу уг системд ямар нэгэн буруу зүйл хийгээгүй гэдгийг админд хэлж байгаа хэрэг байлаа. Нэгэн их сургуулийн админ үүнийг Белгийн үгний хувилбар гэж үзээд, үүнийг Белгийн хакерууд бичсэн байх гэж дүгнэжээ. Мөн өөр нэгэн Их сургуулийн админ үгний утгыг янз бүрээр тааварлав. Бүхэл шөнийн турш хакеруудын хөлд гишгүүлсэн системээ харсан админ: “Манай найман жижигхэн ногоон хөвгүүд бидэн дээр иржээ” хэмээн хэлж байсан гэдэг.

Ланкастерийн Их сургуулийн компьютерийг хакердсан хүүхдүүд: “Ямар нэгэн утгагүй зүйл бүү хийгээрэй. Бид дэлхийн хэмжээнд дажгүй нэр хүндтэй шүү. Тиймээс системийг оролдсон тухай утгагүй яриа бүү зохио. Биднийг бүү үзэн ядаарай. Зүгээр л бидний тухай байнга бодоорой хө” гэсэн мессэжийг админд бичиж үлдээжээ. Тэд хаана ч явсан адилхан мессэж үлдээнэ. Спаф компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд, хуулийн ажилтнуудыг сандралд оруулж, Британий хакеруудын хийгээгүй үйлдэлд бүх бурууг тохохыг санаархаж байна хэмээн Пад үзэв. RTM өтний тухай яриагаар хакеруудыг Спаф өдөж байгаа гэж нууц бүлгийн гишүүд үзэж байлаа. Тиймээс Гандалф Спафын компьютерийг хакерджээ.

Спафын файлыг нээж байхад Австралийн хакерууд баригдсан явдал Падыг сүрхий айлгасан байна. Байнгын болгоомжтой ажилладаг Пад хакердахаа зогсоохоор шийджээ. Шөнө бүр хийдэг ажлаасаа хагацна гэдэг хэцүүхэн даваа байлаа. Гэвч Электрон, Феоникс хоёрт тохиолдсон явдал түүнд нэгийг бодоход хүргэв.

Пад хакердахаа больсны дараа Алтос руу хууль ёсны дагуу холбогдох замыг сонгожээ. Тэр интернетэд орохын тулд цагийн арван паунд төлөх болсон тул компьютер дээр удаан суух боломжгүй болов. Алтос дээр тааваараа чатлаж байсан цаг өнгөрч, Теорем, Гандалф зэрэг найзууд руугаа цахим шуудан л илгээх ажээ. Нэг цаг машинаар давхих газар буюу Ливерпуулд амьдардаг Гандалф найз нөхөрлөлийн холбоогоо хадгалах илүү хялбар арга зам түүнд байв. Пад, Гандалф хоёр хэзээ ч уулзаж, утсаар ярьж байгаагүй юм. Тэд онлайнаар чатлаж, цахим шуудангаар харьцаж байлаа. Тэд ийм аргаар л холбогдож байв.

Хакердахаа болих өөр шалтгаан Падад байжээ. Британий Telecom компани интернет хэрэглэсэн төлбөрийг орон нутгийн утасны дуудлага хийсэн тарифаар авдаг байсан учир түүний хобби үнэтэйд тооцогдож байсан юм. Харин Австралид хакерууд олон цагийн турш онлайн дээр байх боломжтой. Тэд орон нутагт нэг дуудлага хийх үнээр дата сүлжээний нэг компьютерээс нөгөө рүү хэсүүчилнэ. Пад Австраличуудын адил X.25 dial up-аар хакердах ажиллагааг хийнэ. Нэг утасны дуудлага дээр үндэслэн бүхэл шөнийн турш хакердахад 5 паундын зардал гардаг нь ажилгүй хүний хувьд их мөнгөнд тооцогдоно. Тиймээс мөнгөгүй болсон үедээ Пад хакердаж чадахгүй болдог байлаа.

1990 оны эхээр Британий хуулийн дагуу шийтгэгдэнэ гэж Пад бодож байгаагүй боловч 1990 оны 8-р сард компьютертэй холбоотой гэмт хэргийг хуульчилсан Компьютерийг зохисгүй хэрэглэх хуулийг Англи улс батлана гэдгийг мэдэж байв. Хорин хоёр настай хакер алдаагүй байгаа дээрээ хакердах сонирхлоо орхисон нь дээр гэж шийджээ.

Гэвч тэр сонирхлоо түр зуур л орхиж чадсан аж. 1990 оны 7-р сард өөрөөсөө хоёр дүү Гандалфтай хамт шинэ хууль гарахаас өмнө сүүлчийн удаа хакердах ажиллагаа хийв. Сүүлчийн удаа гэж Гандалф түүнээс шалж байжээ. Долоодугаар сард хийсэн сүүлчийн хакердалтын дараа Пад дахин хакердахаа зогсоов. Хуулийн хоёр комиссын гараар дамжсан Компьютерийг зохисгүй хэрэглэх тухай хууль 1990 оны 8-р сард батлагдлаа. Хакер бусад хүнд хохирол учруулж, мэдээллийн санд хууль бусаар нэвтэрвэл хууль бус үйлдэлд тооцох тухай саналаа Шотландын хуулийн комисс 1987 оны илтгэлдээ дурьджээ. Уг илтгэлд дурьдсанаар зүгээр харах зорилгоор хакердах үйлдлийг хийсэн бол гэмт хэрэгт тооцоохгүй ажээ. Гэвч Англи, Уэйлсийн хуулийн комисс тодорхой зорилго, сэдэлт байхгүй ч зөвшөөрөлгүй нэвтэрсэн л бол гэмт хэрэг үйлдсэнд тооцно гэсэн саналаа 1989 оны илтгэлдээ дурьдав. Энэ санал хуулийн нэг зүйл анги болж орсон юм. Британий парламентад консерватив үзэлтэй гишүүн Майкл Колвин нэгэн шинэ хуулийг 1989 оны сүүлээр танилцуулжээ. Энэ хуулийг консерватив үзэлтэй бөгөөд хакердах үйлдлийн эсрэг тэмцэгч Эмма Николсон гишүүн шууд дэмжиж, олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион явуулснаар хуулийг парламент амжилттай баталсан байна. 1990 оны 11-р сард Пад онлайнаар Гандалфтай чатлах үед хуучин цагаа дурсан ганцхан удаа хакердах саналыг Гандалф гаргажээ. Пад ч сүүлийн удаа хакердах саналыг хүлээн авав.

Хэсэг хугацааны дараа Пад дахин хакердаж эхлэхээс өмнө Гандалф муу зуршлаа орхихыг

хичээжээ. Пад түүнийг муу замд буцаан татаж амжив. Тэд бие биенээ уруу татах сургуулийн хүүхэд шиг л байсан гэхэд болох юм. Хэрэв Пад, Гандалф хоёр бие биенээ таньдаггүй байсан бол 1990 онд хакердахаа үүрд болих байлаа. Нэгэн удаа Гандалф: “Бид нүүр нүүрээрээ уулзах газар бол цагдаагийн хэсэг л байх болов уу” хэмээн хошигнож байв. Алиа хошин зантай, өөдрөг үзэлтэй Гандалф жинхэнэ найз болохоо батлан харуулж чадсан юм. Бодит амьдрал дээр ийм хүнтэй Пад ховор тааралдаж байлаа. Падын хувьд Гандалф урьд өмнө таарч байгаагүй сайн анд байв.

Пад хакердахаа больсон үед Гандалф Английн хойд хэсэг амьдардаг хакер Вандийтай найзалжээ. Олон улын хакерын тавцан дээр Вандий тоглолт бага хийсэн боловч Европын компьютерийг хакердаж байсан нэгэн. Тэр хоёр дажгүй харьцаатай байсан хэдий ч тийм дотно биш байлаа. Тэд зүгээр л танилын хэмжээнд харьцана.

1990 оны 6-р сарын дундуур Пад, Гандалф, Вандий гурав идэвхитэй хакерджээ. Тэд Европын Люксембург дэхь The Financial Times (FTSE 100 хувьцааны индексийг эзэмшигч) Британий Батлан хамгаалах яам, Гадаад хэргийн газар, NASA, Лондонгийн SG Варбургийн хөрөнгө оруулалтын банк, Америкийн компьютерийн дата баазын програм хангамж нийлүүлэгч Oracle, Жанет сүлжээний олон компьютерийг хакердсан юм. Пад Натогийн системийг багтаасан цэргийн нууц сүлжээнд хүртэл нэвгэрч байв. Түүнчлэн тэд Tymnet X.25 сүлжээтэй ойролцоо, Британий Telecom компаний Packet Switched Stream сүлжээ (PSS) рүү маш амархан нэвгэрчээ.

Гандалф “Хэрэв компьютер ажиллаж л байвал хакерд” гэсэн уриатай байлаа. 1991 оны 6-р сарын 27-ны өдөр Пад Манчестер дахь гэртээ жилийн хамгийн урт өдрийн нарыг шингэж байхыг хараад сууж байв. Оройн 11 цагийн орчим тэр модемоо залгаж, Atari 520 ST компьютерээ асаалаа. Түүний эцэг эх нь компьютер хэрэглэдэггүй боловч хоёр ширхэг Atari-тай байгаа нь түүнийг компьютерт хир зэрэг дуртай болохыг харуулна. Гэвч тэр хуучин Atari-гаа хэрэглэдэггүй байв. Химич мэргэжилтэй том ах нь докторын диссертация бичихэд тэр компьютерийг ашигладаг байжээ.

Пад dial up хийхийн өмнө гэрийн утасны шугамыг хэн нэгэн хэрэглээгүй эсэхийг шалгаад сүлжээнд оров. Дараа нь тэрээр Лутцифер дээрх цахим шуудангаа шалгажээ. Германы сайт руу түүний компьютер холбогдохыг хүлээн хэдэн минут сууж байхдаа пид гэсэн дууны дараа чихарсан чимээг сонсов. Тэрхүү дуу чимээ үүднээс гарчээ. Хэдхэн секундын дотор үүдний хаалганы хүрээ чихран, хаалга онгойлоо. Гэнэт бөөн хүмүүс орж ирээд түүний унтлагын өрөө рүү гүйлдэв. Компьютерын өмнө суугаа чигээрээ байсан Пад модемоо салгаж, компьютерээ шууд унтраалаа. Тэд унтлагын өрөөнд өрөөнд нэгэн залуу компьютертэй сууж байхыг олов. Гэхдээ тэд буруу хүнийг чиглэн очсон байлаа. Падын ахыг андууран барьснаа олж мэдэх хүртэл цагдаа нар арван минут алджээ.

Шуугиан гарах чимээнээр эцэг эх нь үүдний өрөөнд орж ирэхэд цагдаа нар хүн бүрийг хориглон зогсоогоод Падаас асуулт асуув. “Чи компьютер хэрэглэдэг үү? Чи компьютер дээр Пад гэсэн нэрийг ашигладаг уу?” гэж тэд асуулаа.

Түүний тоглоом дууссаныг Пад ойлгов. Нэг их ноцтой гэмт хэрэг үйлдээгүй гэж бодсон тэрээр асуултанд үнэнээр хариуллаа. Тэр их тайван байв. Цагдаа нар өрөөг нь нэгжиж байх

зуур Падыг унтлагын өрөө рүү аваачлаа. Түүний компьютерийн дээр байгаа тавиур дээрх номнуудыг цагдаа нар нэг бүрчлэн үзэв. Цагдаа нар тавиур дээр компьютерийн тухай номноос бусдыг эргүүлэн тавьж, нотлох баримтуудыг хураан авжээ. Дараа нь тэд Падын хөгжмийн хуурцагнуудыг нэг бүрчлэн үзээд олигтой нотлох баримт олсонгүй. Түүний хувцасны шүүгээг нэг цагдаа онгойлгож, “Сонирхол татах зүйл байна уу энд?” хэмээн асуув. Пад үгүй гэж хэлээд та нарт хэрэгтэй зүйл тэнд бий хэмээн компьютерийн дисктэй хайрцаг руу заав. Цагдаа нар нэгжиж олохоос хойш нуугаад байх зүйл түүнд байхгүй ажээ. Тэр Австралийн хакеруудтай адилхан цагдаа нар орж ирнэ гэдгийг мэдэхгүй байсан юм. Түүний хард драйв дээрх файлууд энкриптэлсэн боловч гэмт хэрэгт буруутгах бусад олон файлуудыг цагдаа нар олжээ. Эцэг эхтэй нь нөгөө өрөөнд юу ярьж байгааг сонсож чадаагүй Пад тэднийг тайван байгаа гэдэгт итгэлтэй байв.

Тэдний хүү нь ноцтой хэрэг хийгээгүй мэт тэд тайван байлаа. Тэр шар айрагны мухлагт хэн нэгнийг зодож, бусдыг дээрэмдээгүй. Согтуугаар машин барьж яваад хэн нэгнийг мөргөчихөөгүй билээ. Магадгүй тэр интернетээр орох ёсгүй сайт руу орсон байх, гэхдээ тэр үйлдэл нь ноцтой гэмт хэрэгт тооцогдох уу? хэмээн эцэг эх нь боджээ. Тэдэнд санаа зовох хэрэг байхгүй ажээ. Падын ээж нь цагдаа нарыг цай уух ыг урив. Цагдаа нарын нэг нь цай уухаар суухдаа “Хэрэв чамд ажил хэрэгтэй байсан юм бол цагдаад орж ажиллахыг хүсээгүй юм уу?” гэж асуужээ. Пад хэсэг хугацаанд чимээгүй сууна. Түүний гэрт ВТ компаний мөрдөгчид болон Скотланд яардын компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн цагдаа нар хүч түрэн орж ирээд хэдэн зуун компьютерыг хакердсан залуугаас яагаад цагдаа болоогүй юм бэ гэж асуугаад сууж байдаг? Тэр инээдээ барьж ядав. Пад баригдаагүй байсан ч цагдаад орох тухай бодохгүй байсан юм. Хэдэн сая жил болсон ч тэгж бодохгүй. Хэ хэ хэ. Түүний гэр бүлийнхэн болон найз нөхөд нь Падыг хакерддаг, аль сайт руу нэвтэрсэн гэдгийг ч мэднэ. Компьютерийн дэлгэцийн өмнө маш удаан сууж байгаа хүүдээ эцэг эх сэтгэл зовниж байсан боловч компьютерт дурласан сэтгэлийг нь дэмжихийг хичээж байв.

Түүний 1200 баудын модемыг салгаж аваад уутанд хийхийг Пад харж зогсоно. Тэр 18 настай байхдаа тэр модемыг авсан юм. Цагдаа нар кабель утсыг нь эвхэж, базаад 20 мега байтын хард драйв, дэлгэцийн хамт гялгар уутанд хийж, шошго наалаа.

Нэг цагдаа Падыг үүд рүү дуудан, өөрийгөө дагахыг хүсэв. Эвдэрсэн хаалганы гинж холбоотой хэвээр харагдана. Хакерыг онлайн дээр байхад нь барихын тулд цагдаа нар хаалга эвдсэн ажээ.

Салфорд Кресентын цагдаагийн хэсэг дээр Пад шөнийг өнгөрөөв. Тэр саатуулах өрөөний орон дээр хэвтсэн боловч унтаж чадахгүй байлаа. Гандалф яасан бол ? гэдэгт Пад санаа зовж байв.

Пад санамсаргүй тохиолдлоор хакердах хоббитой болжээ. Бусад хакертай харьцуулбал тэрээр харьцангуй орой буюу 19 настай байхдаа хакердаж эхэлсэн байна. Түүнийг ийм сонирхолтой болоход Алтос нөлөөлжээ. Тэр BBS-ээс Алтос юу болохыг тодорхойлоод зогсохгүй компьютерийг хэрхэн хакердах тухай тайлбарласан файл олж уншив. Хэн нэгэн хакер Английн BBS дээр харилцаа холбооны компани ВТ-ийг хэрхэн хакердах тухай мэдээллийг тавьжээ. Пад BBS дээр байсан файл доторхи зааварчилгааг даган хичээллэсээр Германы чатын сувгийг олжээ. Тэр Теоремтай адилхан амьдралын шинэ орчинд хөл тавилаа. Энэ бол

маш гайхамшигтай олон улсын хакеруудын цуглаан байв. Австрали, Америк, Швейцарь, Герман, Итали хүмүүстэй өдөр бүр ярилцаад байх боломж түүнд олдохгүй. Ингээд удалгүй Алтос дээр байнга зочлох бусад хүмүүсийн адил тэр хакер болсон юм.

Хэдэн жилийн өмнө үзсэн Дайны тоглоом нэртэй кино түүнд их таалагджээ. Арван зургаан настай хөвгүүн телефон утасны шугамыг ашиглан компьютерээр бие биетэйгээ харьцаж болохыг тэр киноноос мэдсэн гэдэг. Сансрын хиймэл дагуулыг хакердах ур чадвараа ашиглан хөдөлгөсөн хакерын бүлгийн тухай мэдээ телевизороор гарахыг үзээд Электроны адил анхаарал нь маш их татагджээ.

Пад Их Манчестерт өсөж хүмүүжсэн байна. Нэг зуун жилийн өмнө тус хот бөс даавуун эдлэлийн өлгий нутаг байлаа. Энд 1840 оны эхээр аавынхаа хөвөн боловсруулах үйлдвэрт Фриедрих Энгельс ажиллаж байсан аж. Тэр Коммунист хөдөлгөөний түүх бүтээлээ 1848 онд туурвисан билээ.

Ажилчин ангийн хот байсан Манчестер баячуудыг үзэн яддаг газар байсан юм. 1970, 1980-аад оны үед ажилгүйдэл газар авч, нэгэн цагт бахархал болж байсан бөс даавууны үйлдвэрлэлийг зогсоход хүргэсэн гэдэг. Пад тэр үеийн дунд түвшний давхарга амьдардаг хотын захын хороололд өсөж, торнижээ.

Сансар огторгуйн хиймэл дагуулыг байрнаас нь хөдөлгөсөн хакеруудын тухай мэдээг уншаад үл итгэх сэтгэл төрж байсан хэдий ч Электронтой адилхан татагдсаар байв. Үнэн эсэхийг өөрийн биеэр үзэхийг хүссэн Пад хакердах сонирхолд автжээ. Эхлээд компьютерийн сонирхол татсан хэсгийг судалж байснаа удалгүй томоохон институтуудын компьютерийг оролдож эхлэв. Цаашлаад Австраличуудтай хамтарч ажиллан, компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтнүүдийг онилох аргад суралцжээ. Учир нь тэдгээр мэргэжилтнүүдэд л үнэт эрдэнэс хадгалагдаж байдаг байв.

Цагдаагийн хэсэг дээр харгалзагч цагдаа түүнд идэх юм өгөв. Дараа нь ВТ компанийн төлөөлөгч болон энгийн хувцастай хоёр ажилтан хүлээж байгаа байцаалтын өрөөнд түүнийг хүргэжээ.

Түүнд өмгөөлөгч хэрэгтэй юу? Үгүй ээ. Падад нууц зүйл алга. Тэгээд ч гэрээс нь хакердаж байсан энкриптлээгүй дата логууд зэрэг хангалттай нотлох баримтыг цагдаа нар хурааж авсан. Ийм нотлох баримтын эсрэг тэр юу хийж чадах билээ? Тиймээс Пад асуултанд нуулгүй хариулж байлаа.

Гэтэл тэд Лондонгийн Политехникийн компьютерүүдэд гэмтэл учруулсан тухай асууж эхлэхэд байдал биш болж ирэв. Хохирол, гэмтэл гэнээ? Ямар гэмтэл? Пад ямар ч компьютерт хор хохирол учруулж байгаагүй юм.

Тиймээ, 250,000 орчим фунт стерлингийн хохирол гэж цагдаа хэлэв. Пад сонссон зүйлдээ үл итгэн сууна. 250,000 фунт стерлинг гэнээ? Бусдын систем рүү довтолж байсан үеэ тэр дахин бодохыг хичээнэ. Тэр ноцтой өөрчлөлт хийлгүйгээр-компьютер асахад гардаг мессэжийг “Hi” гэж өөрчлөөд, 8glm гэсэн гарын үсэг үлдээж байсан. Мөн хожмын өдөр дахин лог хийх боломж гаргахын тулд хэдэн эккаунт нээжээ. Энэ бол түүний хийдэг жирийн л үйлдэл. Ер нь

Жанет систем дээр Гандалф тэр хоёр 8glm нэртэй экакаунт үүсгэдэг зуршилтай байсан юм. Түүнчлэн тэр өөрийн мөрийг баллахын тулд бүх үйл ажиллагааны логиудыг арчсан боловч компьютерийн эзний мэдлийн ямар нэгэн файлыг хэзээ ч устгаж байгаагүй билээ. Бүх л зүйл админтай муур хулгана болж тоглохтой адил өнгөрдөг байлаа. Тиймээс тийм их хэмжээний хохирол учруулахаар ямар нэг үйлдэл хийснээ тэр огт санахгүй байв. Тэд өөр хакертай андуураад байна уу?

Үгүй л баймаар. ВТ компани, Скотланд Ярд болон бусад газрын ная орчим мөрдөгчид 8glm-ийн хакеруудыг хоёр жил мөрдөж байгаа юм. Тэд телефон утасны холболтууд, түүний компьютерээс хуулж авсан логиуд, хакердсан сайтуудын логиудыг олж авсан. Тэд Падыг сайн мэдэж байв.

Ингээд Пад анх удаагаа хүндхэн цохилтонд өртлөө. Мөрдөгчид Падыг ноцтой гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байлаа.

Түүнийг хоёр цаг байцаасны эцэст Падыг хорих өрөөнд буцаан хийв. Маргааш нилээд асуултаар булна гэж тэд хэлсэн ажээ.

Аав ээж нь цагдаагийн байранд ирсэн гэж хэлэхээр нэгэн цагдаагийн ажилтан үдээс хойш Пад дээр ирлээ. Тэдэнтэй уулзалтын өрөөнд уулзаж болох аж. Шилээр заагласан цонхоор эцэг эхтэйгээ ярьж байхдаа тэднийг тайвшруулахыг Пад оролдоно. Таван минутын дараа уулзах цаг дууссан гэж түүнд хэллээ. Хамгаалагчийн тэвчээргүй харцан дор хурдхан баяртай гэж хэлэх зуураа аав нь унших ном авчирсан гэж хэлжээ. Энэ бол далай судлалын тухай сурах бичиг байв.

Хорих өрөөнд ном уншихыг оролдож байсан ч анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байлаа. Лондонгийн Политехникийн сургуулийн сүлжээнд нэвтэрч байх үеийг дахин санахыг хичээж, санамсаргүй 250,000 фунт стерлингийн хохирол учруулсан байж болох үйлдлийг төсөөлнө. Пад ур чадвартай хакер байсан учраас арван дөрвөн настай хүүхэд системээр хэсүүчилж байгаатай адилгүй юм. Системийг гэмтээхгүйгээр орж гарах аргаа тэр сайн мэдэж байв.

Оройн найман цагаас хойш түр саатуулах өрөөний орон дээр суух Пад хохирол учруулсан тухай эргэцүүлж байхдаа уйтгартай хөгжим сонсжээ. Уг хөгжим Уэльсийн хоорын аяс мэт санагдах агаад түүний дээд давхраас сонстоно. Пад тааз руу ширтэв. Эрэгтэй хүмүүсийн дуу хоолой гэнэт зогсоод дахин эхэлнэ. Хакерын инээд нь хүрж байлаа. Орон нутгийн цагдаагийн хоорын хамтлаг түүний хорих өрөөний дээр хичээллэж байв.

Маргааш өдөр нь Пад дахин байцаагдлаа. Цагдаа нар асуулт ихээр тавих боловч компьютерийн талаар нэг их зүйлийг мэдэхгүй юм шиг санагдана. Тэдний асуултаас үзвэл Алтосын сайн хакерын хаана ч хүрэхээргүй мэдлэгтэй бололтой. Цагдаа нар асуулт асуугаад ширээний нөгөө өнцөгт сууж байгаа ВТ компаний ажилтан руу харж, “Энэ асуулт ойлгогдохоор байна уу?” гэж лавлана. ВТ компаний ажилтан үл ялиг толгойгоо дохингуут цагдаа нар Парын хариултыг авахаар гөлөрнө. Пад тэдний юуг асууж мэдэх гээд байгааг төвөггүй сэтгэж байсан тул зохих ёсоор хариулт өгч байлаа.

Цагдаа нар түүний яллах төлөвлөгөөг боловсруулж байхад Пад хорих өрөөндөө сууж байв. Дахиад л ганцаар... Тэр Гандалфыг барьсан эсэхийг одоо хүртэл гайхшран бодсоор. Хананы цаана телефон утсаар ярих чимээг Пад сонсоно. Чухам яг тэр үед цагдаагийнхан Гандалфыг баривчилжээ.

Гандалфын тоглож хэлснээр тэд хоёр жилийн дараа уулзах болно. Тэр ямаршуу залуу бол? Байцаалттай холбоотой бичиг цаасыг янзалж дууссаны дараа нэгэн ажилтан Падыг хүлээлгийн өрөөнд аваачив. Гандалф, Вандий хоёртой уулзуулна гэж тэр цагдаа хэллээ. Нилээд хэдэн цагдаа тэр хоёрыг хагас дугуй тойрог болон хүрээлж зогсох агаад хакеруудыг сонирхсон янзтай харна. Скотланд Ярдын компьютерын гэмт хэрэгтэй тэмцэх нэгж, BT компаний ажилтнуудаас гадна Грийтер Манчестер, Мерсейсайд, Вест Йорзшайрегийн баривчлагаанд долоон цагдаагийн ажилтнууд гэмт хэргийг мөрдөх ажиллагаанд оролцжээ. Тэд бүтэн хоёр жил хакеруудыг мөрдсөн боловч жинхэнэ нэрийг нь олж мэдээгүй ажээ. Удаан хугацааны туршид мөшгисөн цагдаа нар хакеруудыг онлайн дээр байхад нь баривчлахыг хүснэ. Өөрөөр хэлбэл хаа нэгтгээгээс хакеруудыг log in хийхэд гадаа нь хүлээж байх шаардлагатай гэсэн үг юм. Хакерууд бие биендээ анхааруулах боломж өгөхгүйн тулд тэднийг хэдхэн цагийн зөрүүтэй баривчилжээ. Тиймээс удаан хугацаанд нилээд хүч хөдөлмөр зарцуулсан ажиллагааны дараа цагдаа нар хакеруудыг ойроос харахыг хүсэх нь зүйн хэрэг.

Падыг дагуулах ажилтан тойрон зогссон хүмүүсийн дэргэд очоод Гандалфтай танилцуулав. Тэр туранхай өндөр биетэй, хүрэн үстэй, цонхигор царайтай бөгөөд Падтай төстэй харагдана. Нэг цагдаагийн ажилтан Вандий руу заахаас өмнө хоёр хакерууд бие бие рүүгээ ичингүйрэн инээмсэглэж зогсов. Вандий 17 настай сургуулийн хүүхэд байлаа. Хакеруудыг нэг эгнээнд зогсохыг цагдаа нар шаардсан учир Пад Вандийг сайн харж чадсангүй. Тэдэнд хэргийн тухай танилцуулах үед Гандалф хоёр хакерын голд зогсож байсан юм. 1990 онд баглагдсан Компьютерийг зүй бусаар хэрэглэх хуулийн дагуу тэдэнд ял тулгажээ. Шүүх хурал хуралдах өдрийг товлож тэдэнд мэдэгдэнэ хэмээн тайлбарлав.

Хакеруудыг өөр тийш авч явах үед Вандий аль хэдийнээ явчихсан байлаа. Пад, Гандалф хоёр гадагш гарч, нарлаж суух зуураа ярилцаж гарав.

Гандалф онлайн дээр байдаг шигээ харилцан ярилцахад төвөггүй залуу байлаа. Тэд утасны дугаараа солилцож, цагдаагийн баривчилгааны тухай ярилцав. Гандалфаас байцаалт авахаас өмнө өмгөөлөгч авахыг хүсэхэд компьютерийн гэмт хэргийн талаар огт мэдлэггүй хуульч иржээ. Түүний зөвөлснөөр Гандалф мэдэж байгаа бүхнээ цагдаа нарт хэлсэн гэнэ.

Шүүх хурал Лондонд болно. Бүх хакерууд Английн хойд хэсэгт амьдардаг байхад өмнөд хэсэгт хэргийг шийдэх гэж байгаад Пад ихэд гайхжээ. Эцэст нь тэдний үйлдсэн гэмт хэргийг Манчестерийн шүүхээр хэлэлцсэн юм.

Магадгүй Лондонд Скотланд Ярд байрладаг учраас тэгсэн байж болно. Бичиг цаастай холбоотой бүх ажил тэнд хийгдсэн ч байж магадгүй. Түүнчлэн тэдний үйлдсэн гэмт хэрэг харъяаллын дагуу Гэмт хэргийн төв шүүхээр орох ёстой ч байж болох юм. 1992 онд нилээд хэдэн процессын ажиллагаа болсны дараа Падын олон таамагнал зөв болохыг мэджээ. 1992 оны 4-р сард Боу Гудамжинд байрлах Шүүхээр түүний хэргийг авч хэлэлцэх үед таамаглаж

байсанчлан хэвлэл мэдээллийнхэн дүүрсэн байв.

Хэдэн хакерууд нууц ертөнцийнхний тугийг өргөсөн харагдана. Шүүх хурлын дараа Пад руу үл таних хүн гүйж ирээд “Сайн байна, Падди” хэмээн нуруун дээр нь алгадав. Пад түүн рүү хараад инээмсэглэх агаад үл таних хүнд юу хэлэхээ мэдэхгүй байв.

Австралийн гурван хакерын адил Пад, Гандалф, Вандий нарыг тус улсын хакерын шинэ хуулийн дагуу тэнсэн харгалзах ял оноожээ. 8glm бүлгийн хэргийг шүүхээр авч хэлэлцэх үеэр сонин хэвлэл дээр гарсан мэдээллээс үзвэл хэргийг мөрдөх ажиллагаанд Британий хууль хамгаалах агентлагууд 500,000 гаруй фунт стерлингийг зарцуулсан ажээ. Энэ хэрэг нилээд анхаарал татсан чухал ач холбогдлыг агуулсан учир татвар төлөгчдийн мөнгийг зүгээр ч нэг үрчихээгүй гэдгээ засгийн газрын агентлагууд олон түмэнд мэдэгдэхийг хүсэж байв.

Бусдын компьютер руу хууль бусаар нэвтэрсэн үйлдэлдээ хакерууд ял аваагүй юм. Тэд ноцтой гэмт хэрэгт тооцогдох үгсэн хуйвалдах гэсэн зүйл ангиар ял сонсов. Хакердах ажиллагааг ашиг орлого олох зорилгоор хийгээгүй гэдгээ мань гурав хүлээн зөвшөөрөх үед бусдын компьютерийн системд нэвтэрч өөрчлөх гэж хуйвалдсан гэж прокурорууд буруутгаж байлаа. Баривчлагдахаас өмнө гурван хакер хэзээ ч биечлэн уулзаж, утсаар ярьж байгаагүй нь тэдэнд үнэхээр хачин санагдах ажээ. Санаатай хор хохирол учруулахгүйгээр бусдын компьютер руу нэвтэрсний төлөө хакерууд дээд тал нь зургаан сар шоронд хоригдох болон 5000 хүртэл фунт стерлингээр торгуулах шийтгэл амсах байв. Харин хуулийн өөр хэсэгт заасан хуйвалдааныг хийсэн гэж үзвэл таван жил шоронд хорих, хязгааргүй хэмжээний торгуулийг төлөх шийтгэл авах юм.

Мөрдөн байцаалт томоохон сугалаа мэт байв. Хуйвалдсан үйлдлийг нотлоход төвөгтэй. Учир нь гэмт хэргийн санаа сэдлийг сайн тодруулах шаардлага зүй ёсоор гарна. Хэрэв прокурорууд үүнийг нотлож чадвал Британий түүхэнд гарсан хамгийн чухал хакердах гэмт хэргийн эзэд шоронд явах байлаа.

Пад, Гандалф хоёр буруугаа хүлээх сонголтыг хийсэн бол Вандий бүх арга замаар ялыг эсэргүүцэх чиглэлийг барьжээ. Хакерууд ажилгүй, орлого багатай байсан учраас Хуулийн туслалцаа үзүүлэх байгууллага өмгөөлөгчдийн хөлсийг олгов.

Жирийн шүүх хурлаас арай өөр статустай болж байгааг Вандийгийн өмгөөлөгч хэвлэлээр мэдэгдсэн байна. Эх орноосоо урвах гэмт хэргийг ихэвчлэн авч хэлэлцдэгшүүх хуралтай ойролцоо статустай шүүх хурлаар хакеруудын хэргийг шийдвэрлэж байна гэж тэр үзжээ.

1993 оны 2-р сарын 22-ны өдөр Феоникс, Ноум хоёрын эсрэг гэрч болохоор Электрон шийдвэрлэснээс хойш хоёр сарын дотор 8glm бүлгийн гурван хакер Лондонгийн өмнөд хэсгийн Соутварк Кроун шүүхээр оржээ.

Боу Стрийт гудамжинд болсон шүүх хуралтай адилхан хурлын танхимд хүн пиг дүүрчээ. Скотланд Ярдын мөрдөгчид хамгаалалтанд гарч, цугларсан олон 12-р өрөө рүү цуврана.

Мөрдөгчид компьютерийн 800 орчим дискийг нотлох баримт болгон хурааж авсан гэж хэвлэлийнхэнд мэдэгджээ. Хэрэв бүх мэдээллийг А4 цаасан дээр буулгавал овоолсон цаасны

хэмжээ 40 метр өндөр болох байсан гэж тэд хэлэв. Вандий, Пад, Гандалф нарыг компьютерийн хоёр хуйвалдаан хийсэн гэж буруутгажээ. Нэгдүгээрт теле харилцаа холбооны үйлчилгээг шударга бусаар хуйвалдан олж авсан, хоёрдугаарт компьютерийн материалыг зохих зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн хэмээн буруутгав. Түүнчлэн компьютерт хор хохирол учруулсан гэж Падыг буруутгалаа. Лондонгийн төв дэхь Политехникийн сургуулийн системд 250,000 фцнт стерлингийн хохирол учруулсан хэрэг нь Падын гуравдахь үйлдэлд хамаарч байв. Австралийн хакеруудтай адилгүй NASA мэтийн тусгай сайтууд руу довтолсон хэрэгт Британий хакеруудад ял тулгаагүй юм.

Тэдэнд сонголт байхгүй гэж үзсэн учраас Пад, Гандалф хоёр гэмт хэргээ хүлээсэн билээ. Байгаа нотлох баримтаас үзвэл гэм буруугүй гэж зүтгэх нь тийм ч бодит сонголт биш гэж тэдний өмгөөлөгчид нь хэлсэн аж. Шүүхийн гарт өөрсдийн хувь тавиланг даатгах нь хамаагүй дээр гэж тэд зөвлөжээ. 1992 оны төгсгөлд хийсэн уулзалтан дээр Гандалфийн өмгөөлөгч: “Би чамд Зул сарын баярын мэнд хүргэхийг хүсэж байна. Гэхдээ энэ бол миний баяр хүргэж байгаа анхны бөгөөд сүүлийнх гэж би бодохгүй байна” гэжээ.

Вандийгийн өмгөөлөгчид тулгасан ялыг эсэргүүцэж байв. Хуйвалдааны гурван үйлдэлд ял тулгасныг Вандий хүлээн зөвшөөрсөнгүй. Вандий компьютерийн хакердах ажиллагаанд донтсон бөгөөд үүний улмаас гэмт хэргийн санаа зорилго байхгүйгээр хакердаж байсан тул буруутгагдах үндэслэл болохгүй хэмээн өмгөөлөх багшүүгчтэй маргаж байв.

Вандийгийн хэрэг барьцгүй гэж Пад үзжээ. Донтоно гэдэг бол түүнийг зөвтгөх бодит шалтгаан биш ажээ. Тэгээд ч Вандий маш их сандарч байгааг тэр ажиглаж суув.

Шүүх хурлаар орсны дараа Пад, Гандалф хоёр хойд зүг руу буцаж, Вандийгийн хэрэг хэрхэн шийдэгдэж байгааг хэвлэлийн шуугианаар ажиглана.

Тэд сэтгэлээр нэг их унасангүй. Жеймс Ричардсоноор удирдуулсан мөрдөн байцаах баг хэвлэлийг мэдээллээр хэрхэн хангахаа мэдэж байв. Тэр Вандий дээр хамаг анхаарлаа төвлөрүүлж, сургуулийн насны хүү Люксембургийн албан газрын сүлжээнд хэрхэн нэвтэрч байсныг шүүхэд ярьж өглөө. Тэр дэлхийн олон Их сургуулиудад үймээн тарьж байсан. Вандий хакердахдаа Зул сарын бэлэг болгон өгсөн, 200 паундын үнэтэй ВВС-ийн микро компьютерийг ашиглаж байв. Европын компьютерийг хакердах ажиллагаа үүгээр хязгаарлагдаагүй юм гэж Ричардсон сэтгүүлчдэд ярина. Вандий Лийдсийн Их сургууль, The Financial Times, Lloyd банкиг хакердсан аж. “The Financial Times” компаний сүлжээнд Вандий “Лондонгийн хувьцааны арилжааны индекс” буюу FTSE 100 хувьцааны индексийн хэвийн ажиллагааг алдагдуулсан байна. FT компаний сүлжээнд скан хийдэг програмыг хакер суурилуулж, секунд бүр гадагш нэг дуудлага хийдэг болгожээ. Вандийгийн хамгийн томоохон хорлон сүйтгэх ажиллагаа бол “a700 билл” буюу гол системийг унтраах шийдвэрийг менежментээс гаргахад хүргэсэн чухал файлыг устгасан явдал байв. FT компаний компьютерийн босс Тони Жонсоны хийсэн тооцоогоор Вандийгийн үйлдэл түүний байгууллагад 24871 фунт стерлингийн хохирол учруулжээ. Харин FT компаний дараа яригдсан зүйлс хүмүүсийг улам алмайрууллаа. Брюссельд байрлах Хорт хавдрын эмчилгээ, судалгаа шинжилгээний хүрээлэнг тэр хакерджээ. Тэнд үлдээсэн сканнер програмын уршгаар 10,000 долларын утасны билл тус байгууллагын нэр дээр гарсан тухай шүүхэд мэдэгдэв. Тэрхүү сканнер програм 50,000 утасны дуудлага хийсэн мөр үлдээж, 980 хуудас

утасны билл гаргахад хүргэсэн хортой үйлдэл хийжээ. Сканнерын улмаас судалгааны хүрээлэнгийн систем нэг өдөр хаагдсан гэж Хорт хавдрын эмчилгээ, судалгаа шинжилгээний хүрээлэнгийн мэдээллийн системүүд төслийн менежер Винсент Пиедбоеуф шүүгчид хэлэв. Тус хүрээлэнгийн мэс заслын эмч нар өвчтнүүдийг бүртгэхийн тулд компьютерийн сүлжээний системийг хорин дөрвөн цагийн туршид тасралтгүй ажиллуулж байх шаардлагатай байдаг гэж тэр тайлбарлажээ. Хүрээлэнгийн мэдээллийн сан Хорт хавдартай тэмцдэг судалгааны төвүүд, эмч нар, эм үйлдвэрлэгч компаниудын хооронд холбоо барих гол суваг болдог байна.

Сонин хэвлэлийн хувьд энэ хэрэг маш их дуулианыг тарьжээ. “Daily Telegraph” сонины тэргүүн нүүрэнд “Өсвөр насны хакер дэлхийн хэмжээний гамшиг тарилаа” гэсэн гарчигтай нийтлэл гарав. Харин Daily mail сонины гуравдугаар нүүрэн дээр “өсвөр насны хакер шуугиан тарив”, Гласгоу хотын The Herald дээр “Хөвгүүн 10,000-ын утасны төлбөр гарахад нөлөөлжээ”, Irish Times сонинд “Залуухан хакер Европын холбооны компьютерийн аюулгүй байдалд халдав” гарчигтай нийтлэл гаргаж байлаа.

Түүнчлэн хэрэг илрээд нэг долоо хоног өнгөрч байхад хорт хавдрын төвийн мэдээллийн баазыг Вандий сүйрүүлсэн гэж “The Guardian” сонин зарлав. Мөн “Өсвөр насны хүү хорт хавдраар өвчилсөн хүмүүсийн материалыг уншжээ” гэж “The Independent” сонинд бичжээ. Шүүх хурал эхлээд дөрөв хонож байхад “Daily Mail” сонинд Вандийг “компьютерийн гоц авьяастан” хэмээн өргөмжилсөн төдийгүй тав дахь өдөр нь түүнийг FT компанид 25000–ийн хохирол учруулсан “компьютерийн байлдан дагуулагч” гэж нэрлэжээ.

Тэдний хакердсан байгууллагын жагсаалт үргэлжилсээр байлаа. Токиогийн амьтны хүрээлэн, Цагаан Ордонг Вандий хакердсан тухай мэдээлэл хэвлэл дээр гарсан хэдий ч аль нь илүү ноцтой хохирол амссаныг хэлэхэд хэцүү ажээ.

Вандийгийн өмгөөлөх баг үйлчлүүлэгчээ хамгаалах чамгүй бэлтгэлийг базаажээ. Иан Макдоналд, хүүхдийн зөвлөх Алистаир Келман, өмгөөлөгч Дебора Триплей нар Лондонгийн Их сургуулийн профессор Жеймс Гриффит Эдвардсийг шүүх хуралд шинжээч гэрчээр оролцуулах болов. Тэр профессор донтох зан аашаар мэргэшсэн нэгэн байв. Тэрээр Үндэсний донтолтын төвийн дарга байхдаа Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын донтох зуршлын тодорхойлолтыг бичсэн бөгөөд тус багийн бүрэлдэхүүнд орж ажилласан юм. Түүний мэдлэг мэргэжлийн талаар хэн ч эргэлзэхээргүй нэр хүндтэй хүн байлаа.

“Вандий компьютерээс салж чадахаа болж, хязгааргүй хэрэглэх хүсэлдээ баригдсан учраас чөлөөтэй сонголт хийх чадвараа алдсан” гэж Вандийгийн талаар хийсэн дүгнэлтээ шүүхэд танилцуулжээ. Тэр цагдаа нарт байцаалт өгч байхдаа “Би донтсон, би хүсэж хийдэггүй” гэж 12 удаа давтсан тухай Гриффит Эдвардс шүүхэд хэлжээ. Вандий өндөр мэдлэгтэй ухаалаг. Гэхдээ компьютерийн аюулгүй байдлын системийг давж гарах хүслээ дарж чадахгүй болсон тул хакерын оюун санаанд өөрчлөлт орсон. “Энэ бол мөрийтэй тоглох донтой хүмүүсийн сэтгэцийн өөрчлөлттэй адилхан үндсэн шинжийн нэг” гэж есөн эрэгтэй, гурван эмэгтэй шүүгч нарт профессор тайлбарлав.

Гриффит Эдвардс цааш үргэлжлүүлэн: “Түүнчлэн чадварлаг, ухаалаг Вандий хэзээ ч найз охинтой байгаагүй нь анхааралдаа авах бас нэгэн шинж. Эмэгтэй хүнтэй болзох талаар асууж

ч үзээгүй, энэ талаар юу бодож явдгийг нь асуухад маш их ичиж байсан. Түүнийг ямар хүн бэ гэж асуухад хариулт өгч чадахгүй” хэмээн хэлжээ.

Сандал дээр сууж байгаа шүүгч нар профессорын ярьж байгаа зүйлийг анхааралтай сонсож, урагш тэмүүлсэн янзтай харагдана. Тэд ч сонирхох нь гарцаагүй байлаа. Профессор залуу хакерийн оюун санааны ер бусын өөрчлөлтийг гарган харуулжээ. Британий төдийгүй Европын хамгийн нэр хүндтэй институтүүдийн компьютер руу ядах юмгүй нэвтэрдэг хакер маань эмэгтэй хүнийг болзоонд урих талаар ямар ч алхам хийж чадахгүй нь тэдний анхаарлыг татсан аж. Дундаж хүмүүст нийтлэг илрэх согтуурал, хурд хэтрүүлэх, эвдэж хэмхлэх зэрэг донтолт байхаас бус хүүхдийн тоглоом, үг боловсруулах програмуудыг ашиглах компьютерт донтох явдал байдаг эсэхийг анх удаа сонсож байв.

Вандийгийн донтолтын тод жишээнүүдийг үзүүлсэн өмгөөлөх ажиллагаа үргэлжлэв. Англи хэлний лекц уншдаг Вандийгийн ээж өөрийн хүүгээ компьютер, модемноосхол байлгах гэж үйлээ үзжээ. Ээж нь модемийг нуухыг хүртэл оролдож байв. Тэр хайж байгаад олонгуут нь тусдаа амьдардаг эмээгийнх нь гэрт аваачиж нуужээ. Тэр эмээгийнхээ гэрт нууцаар орж модемоо дахин авчирчээ. Түүний компьютерийг хурааж авах гэсэн боловч Вандий ээжийгээ өөрийн өрөөнөөс түлхэн гаргасан байна.

Түүний хакердах ажиллагааны улмаас 700 долларын утасны мөнгө гарчээ. Ээж нь цахилгаанаа таслангуут хүү нь дахин холбоно. Утсан дээр нууц код оруулах үйлчилгээ авангуут хүү нь эвдэж орхино. Бусдын хүүхдийн адил гадаа гарч тоглохгүй байгаад ээж нь ихэд санаа зовж эхэлжээ. Тэр бүтэн шөнө байтугай бүтэн өдрийн турш суудлаасаа босохгүй хакердаж байлаа. Ээж нь ажлаасаа ирэнгүүт хүүгээ зочны өрөөний шалан дээр үхсэн мэт хэвтэж байдаг байв. Тэр үхээгүй харин хэт ядарч туйлдсандаа хаа явсан газраа унтаж орхино. Тэр ухаан алдаж унатлаа хакердана. Хэсэг унтаж байгаад дахин босож үргэлжлүүлнэ. Вандийгийн компьютерт донтсон тухай яриа шүүхийн танхимд суух хүмүүсийг гайхшруулж, эцэстээ түүнийг өрөвдөх хандлага газар авчээ. Хэвлэлийнхэн түүнийг “Ганцаардсан хакер” хэмээн нэрлэв.

Мөрдөн байцаалтын явцад цуглуулсан нотлох баримтыг Вандийгийн өмгөөлөх баг бүрэн няцааж чадахгүй байлаа. Тэд бүр эсрэгээр нотлох тактикийг хэрэглэж, мөрдөх явцад хохирогчоор нэрлэсэн байгууллагуудаас илүү олон сайтыг Вандий хакердсан гэж өмгөөлөгч нотлов. Тэр зүгээр ч нэг олон сайт бус бүр маш олныг хакердсан гэжээ. Ингэсний хүчинд шүүгчийн өмнө гэмгүй царайлан суух залууг ялаас хэлтрүүлэх шалтгаан байгаа гэдэгт өмгөөлөгчид итгүүлж чадлаа. Шүүх хурлын явцад хэвлэлийнхэн Вандий дээр хамаг анхаарлаа төвлөрүүлсэн боловч нөгөө хоёр хакерыг ор тас мартчихаагүй ажээ. Компьютерийн долоо хоног тутмын нэгэн сэтгүүл Гандалфын ажиллаж байх үеийн зургийг авч хамгийн эхний нүүрэндээ нийтлэв. Барклейн банкны системийг хакердахад хэрэглэх програм дээр Английн хамгийн алдартай хакерын бүлгийн гишүүн ажиллаж байна гэж сэтгүүлд дурьджээ. Түүнийг ингэж бичих шалтгаан ч бас байсан юм. Гандалф аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж болох учраас санхүүгийн чиглэлийн ямар нэгэн байгууллагуудад ажиллуулж болохгүй байлаа. Хакерууд сэтгүүлд гарсан сурвалжлагад ихэд уурлаж байсан авч ял сонсгох өдөр хүртэл хэлээ хазаад хүлээх явдал чухал байв.

Хэргийг шүүхэд авч хэлэлцэхээс эхлээд л хакеруудад тодорхой нотлох баримт олж авахад

хүндрэлтэй байлаа. Цагдаа нар гэрт нь нэгжлэг хийх үед хурааж авсан зарим материал шүүх хуралд хэрэг болно гэж Гандалф үзнэ. Хакердсан системд байгаа аюулгүй байдлын цоорхойг олж өгсөнд зарим админууд талархсан мессэж илгээж байсан аж. Тийм материалуудыг хавтаст хэрэгт оруулаагүй байв. Яллагдагч нар тэрхүү мэдээллийг авч үзэхийг хүсэхэд нууцад хамаарах дискэн дээр байгаа тул өгөх боломжгүй гэж татгалзжээ. Мэдээллийг ил болгох тухай Ерөнхий Прокурорын зааварчлагыг уншиж үзэхийг хакеруудад зөвлөв. Засгийн газрын болон цэргийн систем рүү довтолсон ажиллагааны тухай нотлох баримтууд ЖАНЕТ мэтийн нөхөрсөг системийн компьютер руу нэвтэрсэн үйлдэлтэй холилдсон байна гэж өмгөөлөх багийнхан тэдэнд хэлжээ. Тэдгээр хоёр өөр чиглэлийн системийн мэдээллийг тусгаарлахад цаг их орох юм.

Эцэст нь цагдаагийн хяналтан дор шаардлагатай материал, хуулбарыг авахыг тэдэнд зөвшөөрөв. Хакерууд хэрэгт шаардлагатай өмгөөлөх нотлох баримтыг цуглуулахаар Лондоны Холборний цагдаагийн хэсэг дээр иржээ. Гэсэн хэдий ч цаг их шаардах иймэрхүү ажлыг байнга хийх боломжгүй нь тодорхой боллоо. Удалгүй Прокурорын газрын хандлага зөөлөрч ямар ч хуулбар хийхгүй гэсэн болзолтойгоор дискэн дээрх материалыг Падын өмгөөлөгчид өгсөн байна. Гэхдээ тэд дискийг хуулийн байгууллага дотор хэрэглээд, ажлын өдрийн төгсгөлд буцааж өгөх ёстой байлаа.

Вандийгийн хэрэг шүүхийн олон шатыг даган өнхөрч байх зуур Пад, Гандалф хоёр ял сонсох өдөртөө бэлдсээр байв. Гандалф өдөр бүр өөрийн найз руугаа Ливерпуулээс Манчестер руу аялна. Тэд орон нутгийн сонины цэгээс нилээд сонин худалдаж аваад Падын өмгөөлөгч суудаг байр руу зүглэнэ. Хакерын үйлдсэн гэмт хэргийн тухай нийтлэлүүдийг хурдхан гүйлгэж хараад, дурамжхан олгосон дискнүүдийг хоёр хакер шүүж суудаг байв. Тэд компьютерийн нилээд зэгсэн мэдлэгтэйд тооцогдох хуулийн газрын кассчны хяналтан дор компьютер дээрх материалыг унших ажээ.

Соутваркийн шүүхийн танхимд арван таван өдөр үргэжилсэн хурлын сонсголын дараа Вандийгийн шүүгч нотлох баримтыг эргэцүүлэхээр түр завсарлав. Тэднийг хэлэлцэх өрөөнд орохын өмнө Вандийгийн донтсон үйлдэл ялаас мултрах шалтгаан бус шүү гэдгийг шүүгч Харрис хатуу анхаарууллаа.

Түүнд өгөх ялыг хэлэлцэхэд 90 минутын хугацаа л зарцуулсан агаад шүүх хурал дээр ялын тогтоолыг уншиж танилцуулахад цугларсан олон дуу алдан хүлээж авав.

Бүх талаараа гэм буруугүй гэсэн шийдвэр гарчээ.

Вандийгийн ээж баярласандаа инээдээ барьж ядна. Өмгөөлөгчид баярлахгүй байхын арга алга. Харин хуулийн байгууллагынхан гайхсандаа юу ч хэлж чадахгүй сууна. Эрүүгийн ажилтан түрүүч Барри Донован шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг хүлээн зөвшөөрөхгүй байв. Хуулийн байгууллагад 21 жил ажиллахдаа үүн шиг тохиолдолтой таарч байсангүй. Шүүгчдийн шийдвэрийг өлгөн авч Британий хэвлэл мэдээллийн хэрэгсэл баруун зүүнгүй мэдээ цацаж эхлэв. “Guardian” сонин шүүхийн шийдвэрт зэвүүцэн: “Бусдын компьютерийн системийг сүйтгэсэн хакер чөлөөтэй явж байна” гэсэн мэдээлэл гаргажээ. “Evening Standart” сонинд: “Компьютерийн гоц авьяастан хакердах хуйвалдаанаас хөнгөхөн мултарлаа” гэсэн бол “Times” сонинд: “Хакердах донтон ялгүй мултарлаа” гэжээ. Тэдний дундаас “Daily

Telegraph” сонинд гарсан “Цагаан ордны сүлжээнд нэвтэрсэн өсвөр насны хакерын донтон ялгүй үлдэв” гэсэн сурвалжлага хамгийн сүржин нь байлаа.

Удалгүй хэвлэл мэдээллийн зүгээс хүнд цохилт үзүүлэв. Хэн нэгэн этгээд муу үр дагавартай түүхийг дэлгэжээ. “Ma1”1 сонины Ням гаргийн дугаарт Бракнель дэхь Дунд түвшний цаг агаарын мэдээний Европыг хариуцсан төвийн ажилтан Крейгийн компьютерт гурван хакер нэвтэрсэн тухай мэдээлэв. Энэ компьютер бол өнөөх бусад халдлагад өртсөн компьютерүүдийн жагсаалтнаас нэг шалтгаанаар хасагдах ёстой байжээ. АНУ-ын цэргийнхэн Персийн буланд Иракийн эсрэг довтлох төлөвлөгөөг энэ төвөөс гаргасан цаг агаарын мэдээн дээр үндэслэсэн байна. Хэвлэлд гарсан нийтлэлээс үзвэл хакерууд Крейгийн компьютерийн тооцоо гаргах хурдыг бууруулснаар “Цөлийн шуурга ажиллагаа”-нд бүхэлдээ аюул учруулжээ. Хакерууд мянга мянган цэргийн алба хаагчийн амьдралыг эрсдэлд оруулж, Саддам Хуссейны эсрэг хэрэгжүүлэх олон улсын бодлогод ноцтой заналхийллийг шууд бусаар үзүүлсэн гэж сонинд өгүүлэв.

Түүнчлэн Пентагоны батлан хамгаалах төлөвлөлтийг саатуулсны улмаас Ерөнхий сайд Жон Мэжорт танилцуулахад хүргэсэн Британий хакеруудын олон удаагийн довтолгоог АНУ-ын Төрийн департамент ихэд жигшин зэвүүцсэн гэж сонинд дурьджээ. Төрийн департаментыг бодвол Цагаан ордон асуудлыг илүү ноцтой хүлээн авж, Хакеруудаа зогсоохгүй бол Транс Атлангийн дата болон дуут теле харилцаа холбоог хангадаг хиймэл дагуулд холбогдох Европын эрхийг хасна гэж мэдэгдэв. Мэдээж Британи улс тэдний дарамтыг хүлээн авч, арван хоёр сараас бага хугацаанд гурван хакерыг баривчилсан билээ.

Тэднийг буруутгаж байгаа зүйл бол үндэслэл байхгүй гэж Пад бодов. Тэрээр цаг агаарын мэдээний төвийн VAX компьютерт нэгэн шөнө хоёр орчим цаг л зочилсон, тэгээд ч Крейгийн компьютерийг огт оролдоогүй байна. Мэдээж тэр компьютерийн хурдыг удаашруулах юу ч хийгээгүй юм. Тэнд хэрэглэгчийн пассвордыг олох програмууд, скан хийдэг програмуудын алиныг ч хэрэглээгүй аж. Хэдийгээр Пад энэ хэрэгт холбоотой байсан ч гэсэн Беркшайре дахь нэг компьютер Персийн буланд Барууны холбоотнууд ялалт байгуулахад нөлөөлнө гэдэгт огт итгэхгүй байлаа.

Вандийг эрүүгийн ялаас мултарсны дараа, Пад, Гандалф хоёрт ял өгөх шүүх хурлаас өмнө хэвлэл дээр ийм мэдээллийг цацаж байгаад тэр маш их гайхаж байв. Магадгүй тэднийг доош хийх оролдлого байж болох уу?

Хэвлэл мэдээллээр Вандийд зориулан гаргасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол болон хакердах донг өмгөөлөл болгон ашигласан тухай дөрөв хоногийн туршшуугилаа. Компьютер эзэмшигчийг өөрийнхөө системийг хамгаалах хариуцлагыг үүрэх ёстой гэж зарим шүүмжлэгчид сануулна. Бусад нь хакерийн хатуухан хуультай болохыг шаардаж байв. “Тэдгээр хакерийн насан дээр байгаа машины хулгайч хорих ял заавал авна шүү дээ. Энэ хоёр гэмт хэрэг хоёулаа л бусдын өмчийн эсрэг гэмт хэрэг... Хэргийн улмаас учирсан хохирлыг шүүгчид тунгааж үзэхгүйгээр шийдвэр гаргасан байх” гэж “The Times” сонин дээр бичсэнийг зарим хүмүүс дэмжиж байлаа.

Иймэрхүү хэлэлцүүлэг хүчээ нэмэн түрсээр Британий хилийг аль хэдийнээ давжээ. Хонг Конгод “Персонал компьютеруудыг удаан хугацаагаар хэрэглэсэн, өсөж бойжоогүй, дэвэргэн

оюун санаанууд гэмтэж болохыг харуулсан нийгмийн шинэ үзэгдлийн нотлох баримт энэ мөн үү?” гэж Өмнөд Хятадын “Morning Post” сонинд асуусан байна. Компьютерийн хэнээтэн болсон өсвөрийн арми дэлхийн мэдээллийн баазыг хүссэнээрээ сүйтгээд, баригдангуутаа сэтгэцийн эмгэгтэй гээд ногоон гэрлээр мултарчихыг Вандийгийн хэрэг нотлож байгаад эмзэглэсэн олон нийтийн бодлыг сонин тодорхойлжээ.

1991 оны инээдмийн баярын өдөр, шүүх хурлын төгсгөлөөс хойш хоёр долоо хоногоос илүү хугацааны дараа “The Guardian” сонины өргөмжилсөн нэрийг Вандий өөрийнх болголоо. Вандий ээж болон өмгөөлөгч нарынхаа хамт ялалтаа чимээгүйхэн тэмдэглэж байх зуур Скотланд Ярдын мөрдөгчид Вандийгийн хэргээс илүү ноцтой үйл явдлын гэрч болж байсан хэмээн хэвлэлд бичжээ. Компьютерийн гэмт хэргийн нэгжийг дахин зохион байгуулж байв. Таван ажилтантай нэгжээс туршлагатай хоёр ажилтан нь гарчээ. Албан ёсны мэдээллээс үзвэл энэ бол албан хаагчдын сэлгээ хийгдэх Скотланд Ярдын жирийн нэг үйл явдал аж. Гэхдээ Вандийгийн хэрэг бол цаг, мөнгө үрсэн, дахин давтаж болохгүй алдаа учраас ийм зохион байгуулалт хийсэн гэж албан бусаар тайлбарлаж болох байлаа.

Шүүх хурал ойртох тутам Пад, Гандалфийн дээр аадрын хар үүл хуралдана. Вандийгийн ялалт хакерын бусад хүрээнийхний дунд баяр баясгалан авчирсан байж болох хэдий ч 8glm-ийн хакеруудын дунд бол хэцүүхэн сэтгэгдэл тээхэд хүргэж байв. Аль хэдийнээ буруугаа хүлээсэн Пад, Гандалф хоёрын хувьд Вандийгийн ялалт гамшиг авчрах мэт санагдана.

1993 оны 5-р сарын 12-нд Вандий хэргээс мултарснаас хойш хоёр сарын дараа Борис Кейзер Электроны хэргийг өмгөөлж байв. Викторин мужийн шүүх хурлын танхимд чив чимээгүй байлаа.

Шүүх хуралд оролцож байгаа хүмүүсийн өмнө хүнгэнэсэн дуугаар ярих өндөр биетэй, буржгар үстэй хүний хар нөмрөг сэтгэл хөдлөм үйл хөдлөлийн аясаар намирч харагдана. Энэ бол өмгөөлөгч Кейзар байлаа. Тэрээр өөрийн ард суух сурвалжлагч, сэтгүүлчид, урдаа суух шүүгчидтэй хэрхэн харьцахаа маш сайн мэддэг нэгэн юм.

Электрон босож зогсоод Прокурорын газартай тохиролцсон ёсоор арван дөрвөн үйлдэлд буруутай гэдгээ хүлээв. Өөрөөр хэлбэл шүүхийн ажилтан Электроны үйлдсэн хэрэг бүрийг уншаад буруутай эсэхийг асуудаг шүүх процессыг товчилсон хэрэг байв. Гараа хүний анхаарлыг татахаар хөдөлгөх Кейзер бүх буруугаа хүлээж байгаа үйлчлүүлэгчийн өмнөөс зарим процессыг алгасахыг хүсчээ. Хэвийн процессыг тасалдуулсан хүсэлт нь асуулт гэхээс илүү зарлалтай төстэй байв.

Хүсэлтийг хүлээж авахын хажуугаар ял оноох ажилдаа орлоо. Шоронд суух эсэхээ Электрон санаашран бодно. Электроны өмгөөлөгчийн хөөцөлдлөгийг прокурорууд үл хэрэгсэн хорихоос өөр ял санал болгохоос татгалзжээ. Түүнийг гол гэрч болгосны хариуд шоронгийн тухай асуудал хөндөгдөхөд прокурорын газрынхан чимээгүй байхаар Электроны өмгөөлөгч тохиролцов. Тиймээс Прокурорын газрын оролцоогүйгээр шүүгч шийдвэр гаргах ёстой байлаа.

Баруун гартаа зүүсэн аавынхаа хурмын бөгжийг Электрон сандрангуй эргүүлнэ. Аавыгаа нас барснаас хойш Электроны дүү нь гэрийнхээ эд зүйлийг гадагш зөөх болжээ. Харин Электрон

аавынхаа зурагнууд болон бөгжнөөс өөр зүйлээс бусдыг хүсэхгүй байв.

Электронд оноох ялыг хөнгөрүүлэхийн тулд Кейзер маш олон гэрчийг дуудан асууна. Электроны Куинсландаас ирсэн эмээ, аавыг нь эмнэлэгт нас барсан өдөр хүргэж өгсөн гэр бүлийнх нь найз, Электроны сэтгэл зүйч эмч болон бусдаас илүү ач холбогдолтой Лестер Валтон байв. Электроныг жирийн амьдралд хөтлөх сайхан боломж эсвэл сэтгэл зүйн хувьд аль хэдийнээ доройтсон залууг улам шархлуулах шорон руу хөтлөх хоёр замын зааг дээр Валтон зогсож байлаа. Хорихоос өөр ял оноохыг Кейзер дүгнэн хэлэх үед түүний хоёр талаар зогсох сурвалжлагчид тэмдэглэлийг галзуу мэт хөтлөж байхыг Электрон ажиглана. Тэр сурвалжлагчид руу харахыг хүсэх боловч цэвэрхэн индүүдсэн цагаан цамцны захан доогуур шургуулсан, давжаа морины сүүл шиг үсийг нь шүүгч харчихаас эмээжээ. Сурвалжлагчид эгнэн суусан хойд тал руу хяламхийн харангуугаа, Кейзер: “Эрхэм шүүгчээ, миний үйлчлүүлэгч Электроникийн зүрх цохилсон хуурамч ертөнцөд амьдарч байна” гэж хэлэв.

Сараачин бичих чимээ сонсогдсоор... Сэтгүүлчдийн харандаа үзэг хэзээ дээд хурдаа авахыг Электрон бараг л урьдчилан таах боломжтой байв. Архичин хүний санаанаас шил гардаггүйтэй адилхан түүний үйлчлүүлэгч компьютерийн донтон болсон гэж Кейзер хэллээ. Миний үйлчлүүлэгч хэзээ ч бусдын системийг гэмтээж, мөнгө хулгайлан ашиг олохыг эрэлхийлж байсангүй. Тэр зүгээр л нэг хортой хөнөөлтэй байгаагүй юм. Тэр өөрийн сонирхлын дагуу бас тоглоом тоглож байлаа.

“Би бодохдоо” хэмээн Электроны өмгөөлөгч сэтгэл хөдөлмөөр хэлээд сэтгүүлчид бичиж авахаар удаашруулан “түүнийг жижигхэн Жак Хорнер гэж нэрлэвэл таарна. “Би ямар сайн хүн бэ?” гэж бодох учиртай!” гэлээ.

Одоо хүлээх л үлджээ. Ял тулгахаас өмнөх цуглуулсан бичиг баримт, Электроны гэр бүлийн байдал, гол гэрч болсон тухай баталгаа зэргийг үзэхээр шүүгчид танхимыг орхин гарав. Тэнд Феониксийн эсрэг мэдүүлэг өгсөн есөн хуудас бичмэл мэдүүлэг бас бий. Хэрэв Феониксийн хэргийг шүүх авч хэлэлцвэл Электрон өөрийн өгсөн мэдүүлгийг батлаж, асуултанд хариулах ёстой болно.

Электрон шүүх хурлаар орж ял авахын өмнөх нэг сарын хугацаанд шүүгч нар хэрхэх бол гэж бодсоор байлаа. Түүний зарим ял нилээд эргэлзээтэй байв.

Нэг хэрэг дээр олон нийтийн эккаунтыг ашиглан олон нийтийн мэдээлэл рүү хууль бусаар нэвгэрсэн гэж түүнийг яллажээ. Тэрээр Хельсинкийн Их сургуулийн нэргүй FTP сервер руу орж, DES-ийн тухай мэдээллийг хуулбарлах гэж оролдсон. Мелбурнийн Их сургуулийн эккаунтаар дамжин орсон нь түүний нэвтрэлтийн хамгийн анхны цэг нь байв. Гэвч түүний эсрэг гарган тавьсан нотлох баримтыг сайн нягталж үзэх шаардлагатай гэх шалтгааныг Электрон гаргаж тавина.

Австрали болон хилийн чанадаас ирсэн сурвалжлагчид сүлжээгээ хакеруудаас болж хаасан талаар NASA-гийн төв штабын өгөх тайлбарийг асуухад тус агентлаг булзааруулсан хариулт өгөхөөс өөрийг хэлж эс чадна. Тэд NASA-ийн сүлжээ хэзээ ч хаагдаж байгаагүй, энэ бол андуу ташаа ойлголт гэж NASA-ийн хэвлэлийн төлөөлөгч мэдэгджээ. Хэвлэлийн төлөөлөгч Шарон Бескинисын хийсэн мэдэгдэл хөдөлшгүй үнэн байж чадсангүй. Тэр NASA-ийн

ажилтан биш төдийгүй Локхийдээсгэрээгээр ажилладаг хүн байжээ.

Шүүх хурлыг хүлээх нэг сарын туршид бусдын хэлсэн үгийг тэвчихэд Электронд хэцүүхэн байлаа. Түүнийг найзууд руугаа утасдангуут тэд “Аан Бяцхан Жак Хорнер уу?” хэмээн яриагаа эхэлнэ. Тэд Кейзер болон түүний үйлчлүүлэгчийн яриаг харуулсан мэдээг шөнийн турш үзчихжээ. Кейзер шүүхийн танхимыг орхин гарахдаа баргар царайлсан бол Электрон Жон Ленноны нүдний шилний загвартай хар шил зүүж, мөрөө хүрэх үсээ шидлэн, камерын зүг инээхийг хичээх ажээ.

Австралид Электроныг яллахыг үзсэнээс хойш Пад, Гандалф хоёр Лондонгийн Соутваркийн шүүх хурлаар цуг оров. 1993 оны 5-р сарын 20-нд эхэлсэн шүүх хурал нэг өдөр хагас үргэлжилж, өмгөөлөгчид чадах бүхнээ хийсэн байна. Манай үйлчлүүлэгчид компьютерийг хакердсан нь үнэн гэхдээ одоо тулгаж байгаа ялтай эн дүйцэх хэмжээнд гэмт үйлдэл хийгээгүй гэж тэд шүүгчид тайлбарлана. Пад, Гандалф хоёрт хорих ял оноолгохгүй байхын тулд өмгөөлөгчид ажиллаж байлаа.

Тэдэнд тулгах ялыг сонгож байсан яг тэр үед Гандалф Падыг инээлгэж орхив. 81gm бүлгийн хакерууд олон жилийн турш хуримтлуулсан техникийн мэдлэгийн тухай өмгөөлөгчид нь ээлжлэн ярьж байхад Пад түүний инээдийг хүргэжээ. Пад Гандалф руу хяламхийн харж байснаа хоолойгоо засах аядаад, инээдээ барьж чадалгүй нирхийтэл инээсэн байна. Гандалфийн царайд түүнийг турхирсан мэт байдал илт ажиглагдаж байв. Ширүүн дүр төрхтэй шүүгч Харрис тэднийг шоронд илгээхэд ядах зүйл байсангүй. Гэхдээ л тэр юу болоод байгааг ойлгохгүй байлаа. Хоёр хакерын толгойд ямар бодол төрснийг тэдний хэн ч таамаглаж чадахгүй ажээ. Тэдэнд хакердана гэж юуг хэлээд байгааг сайн ойлгож чадахгүй байв. Жишээлбэл мэргэжилтэн гэх хүмүүсийг хэрхэн хууран мэхлэж довтолгоо хийх, сонгосон компьютертээ нэвтэрсний дараах сэтгэлийн тааламж, тэрхүү системийг өөрийн эрхшээлдээ оруулах үед төрөх сэтгэгдэл, гадаад ертөнцөөс ирж байгаа хүчтэй шуургын эсрэг гол тулах цэг болж цохилт өгөх чадвар, Алтосын хүрээний олон улсын хакеруудын багийн тухай яриаг мэдлэггүй хүмүүс шууд ухан ойлгохгүй байсан юм.

Өмгөөлөгчид мэргэжилтнүүдийг дуудан асуулт асууж, шүүгчдэд сэтгэл зүйн шинжилгээний илтгэлүүдийг тайлбарлан ярьж чадах боловч хэзээ ч биечлэн хакердаж байгаагүй учир бодитоор ойлгож, мэдрэхгүй билээ. Нууцхан өрөөнд байрлуулсан нэвт хардаг толиор шүүх танхим руу харж байгаа мэт Пад, Гандалф хоёр гөлрөн сууна.

Зөвхөн түүнд тулгаж байгаа гурав дахь ял Падын сэтгэлийг зовоож байлаа. Лондонгийн Төв Политехникийн сургуулийн сүлжээнд 1990 онд нэвтэрч хохирол учруулсан үйлдлээ тэр хүлээн зөвшөөрсөн юм. Файлуудыг арчиж компьютерийг эвдэлсэн гэх үйлдлийг Пад огт хийгээгүй боловч эсрэг талынхан түүнийг 250,000 фунт стерлингийн хохирол учруулсан гэж нэхэмжилсэн ажээ. Тэр хэмжээний мөнгийг компьютер сүлжээнд зарцуулсан гэдэгт хакер итгэхгүй байлаа. Түүний хийсэн дайралтын ул мөрийг янзлахад хэдий хирийн хугацаа зарцуулахыг тэр мэдсэн юм. Гэвч мөрдөгчид учруулсан хохирлын хэмжээг шүүгчид итгүүлж дөнгөх аваас хакер урт хугацааны хорих ял авах магадлал их байв.

Тэрээр шоронд орох боломж хамгийн их байгааг Пад бараг хүлээн зөвшөөрсөн мэт байлаа. Шүүх хурлаар оруулж ял оноохоос өмнө 81gm-ийн хоёр хакерийг саатуулж болохыг түүний

өмгөөлөгч сануулжээ. Вандийгийн хэргийг шийдвэрлэсний дараа шүүгчийн буруу таслан шийдвэрлэх тогтоолыг дахин өөрчлүүлэхийг хүссэн олон нийтийн дарамт их байсан юм. “The Times” сонинд бичсэнээр Вандийгийн шийдвэрийг цагдаа нар “Хакердах зөвшөөрлийн лиценз” олгосон асуудал гэж үзжээ. Вандийгийн шүүх хурлыг даргалсан шүүгч хакерын ертөнцийн гишүүдэд ойлгомжтой мессэж илгээхийг хүссэн мэт санагдана. Магадгүй Вандийгийн хамт гэм буруугүй гэж мэтгэлцсэн бол ял авалгүй өнгөрөх байсан биз гэж Пад бодож байлаа. Гэхдээ Вандий компьютерт донтсон тухай нотлох баримтыг хэлэлцэж байхад ард олон түүнийг доромжилсон шиг дарамтыг Пад тэсвэрлэж чадахгүй байх гэж үзсэн юм. Гурван хакер сэтгэцийн гажигтай, хэвийн бус, нийгмийн дотор амьдрах чадваргүй болхи, гоц авьяастай хэмээн хэвлэл мэдээлэлд цацаж байсан. Үүнийг ч Вандийгийн өмгөөлөгчид ихэд хүсэж байсан билээ. Нилээд ухаалаг, боловсролтой гэж хэлүүлэхэд Пад татгалзах зүйл үгүй боловч компьютерын донтон болж харагдахыг хүсэхгүй. Тэр найз охинтой. Найз нөхөдтэйгээ бүжиглэж, хөгжих дуртай байсан нэгэн. Тэр гэртээ бие бялдраа хөгжүүлдэг. Ичимтгий гэвэл үнэн. Харин компьютерийн донтон л лав биш.

Компьютерт донтсон учраас хакердах ажиллагааг Пад хийсэн байж болох уу? Хэдийгээр тэр донтсон гэдэгтээ итгэхгүй байгаа ч тийм байж болно. Бүрэн татагдсан эсвэл хийх дуртай ажил нь болсон гэж үү? Магадгүй. Донтсон гэж үү? Үгүй ээ. Тэр ингэж бодохгүй байлаа. Тэгээд ч донтсон гэдгээр өмгөөлөх оролдлого хийвэл түүнийг бүрэн хамгаалж чадах байсан эсэхийг хэн мэдэх билээ?

250,000 фунт стерлингийн хохирол учирсан гэх нэхэмжлэлийг хаанаас гаргасан болох нь Падын хувьд нууцлаг хэвээр байлаа. Цагдаа нар байцааж байхдаа л үүнийг хэлсэн шүү дээ. Пад хохирол учруулсан гэх нотолгоог хэзээ ч харж байгаагүй бөгөөд шүүгч энэ асуудалд хэрхэн хандах бол гэдэгт санаа их зовж байсан юм.

Хэн нэгэн хамааралгүй мэргэжилтнээс техникийн зөвөлгөө авахыг хамгийн зөв хариулт гэж үзэв. Пад, Гандалф хоёрын өмгөөлөгчдийн хүсэлтээр Манчестерийн Их сургуулийн доктор Петер Миллс, Лондонгийн Бизнесийн сургуулийн доктор Расселл Ллойд мөрдөгчдийн хавгаст хэрэгт оруулсан техникийн холбоотой их хэмжээний нотлох баримтыг шинжилжээ. Мөрдөн байцаалтын явцад хакеруудад тулгасан хохирлоос бага хохирол учруулсан байна гэж мэргэжилтнүүд хорин гурван хуудас гаруй бие даасан дүн шинжилгээндээ бичив. Үүнээс гадна томоохон хохирол нэхэмжилж байгаа үйлдлийн нотолгоог тусад нь нарийвчлан хянахыг доктор Миллээс Пад хүслээ.

Системийг нилээд өндөр үнээр дахин шинэчлэх шаардлагатай гэж Британий Telecom компаний ажилтан хэлсэн тухай цагдаагийн шинжээч гэрчилсэн тухай доктор Миллс өгүүлжээ. Хэдийгээ Английн ВТ-ийн мэргэжилтэн 250,000 фунт стерлингийн төсөвтэй шинэчлэл хийгдэх учиртай гэж дурьдаагүй аж. Тэр ч бүү хэл төдий тооны мөнгө шаардлагатай гэх мэдлэг түүнд байхгүй гэжээ.

Үнэндээ түүний хавгаст хэрэгт 250,000 фунтын хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай гэсэн нотолгоо байхгүй хэмээн доктор Миллс дүгнэсэн юм. Тусад нь гаргасан дүгнэлтэндээ доктор Миллс:

“1/ Хэрэгт холбоотой компьютер бол Vax 6320. Энэ бол нилээд хүчирхэг систем бөгөөд хэдэн

зуугаад хэрэглэгчийг дэмжих хүчин чадалтай.

2/ Файлуудыг зургаан хуурцагт хураасан байгаа боловч файлын системийн хэмжээг шууд тодорхойлох боломжгүй гэж үзэж байна. Хуурцаг 0,2 Гигабайтаас 2,5 гигабайт хүртэл ялгаатай байдаг.

3/ Компьютер гурван өдөр унтраастай байжээ. Энэхүү товч мэдээллээр компьютерийг дахин ажиллуулахад гарах зардлыг тодорхойлоход хэцүү. Гэвч дараах тооцоог хийж болно. Үүнд:

1/ Системийг дахин сэргээхэд зарцуулсан хугацаа. Өдөрт 10 хүнийг тус бүр 300 фунт стерлингээр бодоход 3000

2/ Хэрэглэгчийн хохирсон цаг. Өдөрт 30 хүнийг 300 фунт стерлингээр бодоход 9000 болж байна. Миний бодож байгаагаар нийт хохирол 12,000 гаруй фунт стерлинг болж байна. Гэхдээ үүнийг хамгийн дээд хэмжээгээр тооцоолсон гэж үзнэ. Иймээс би 250,000 фунт стерлингийн хохирлыг зөвтгөх шалтгаан байхгүй гэж үзэж байгаа билээ” гэжээ.

Мөрдөгчид зөвхөн хохирлыг нөхөн төлүүлэхийн төлөө яваагүй нь Падад тодорхой болжээ. Энэ бол системийг аюулгүй болгох буюу, системийг бүхэлд дахин шинээр хийхийн тулд ийм хохирлыг нэхэмжилж байгаа ажээ. Цагдаа нар политехникийн нэг сургуулийн бүхэл компьютерийн системийг аюулгүй болгох хөрөнгийг ганц хакерын нуруун дээр тохохыг оролдож байгаа мэт түүнд санагдаж байв. Политехникийн сургууль өөрийн сүлжээндээ 250,000 фунт стерлинг хэзээ ч зарцуулж байгаагүйг Пад олж мэдсэн юм.

Пад хөнгөн ял авна гэдэгт итгэхийн хажуугаар уурандаа дэлбэрэх шахаж байв. Цагдаагийнхан түүнийг асар их мөнгөөр дарамталж, заналхийлж байгаа нь байдлыг улам хэцүү болгоно. Эцэст нь дүгнэхэд асар их хэмжээний мөнгийг өчүүхэн ч нотлох баримтгүйгээр нэхэмжилж байгаа нь тодорхой боллоо.

Доктор Миллсийн дүгнэлтийг ашиглан Падын өмгөөлөгч Мухтар Хуссейн прокурортой уулзаж, хохирлын хэмжээг 15,000 фунт стерлинг болгож чадав. Энэ тоо Падын хувьд их хэмжээнд тооцогдох боловч 250,000-тай харьцуулбал дажгүй сонсогдоно. Гэвч тэр бэлгийн морины шүдийг үзэх хүсэлгүй байлаа.

Шүүгч Харрис ч хохирлын шинэчилсэн үнэлгээг зөвшөөрчээ.

Мөрдөгчид хохирлын үнэлгээнд хожигдол хүлээсэн авч тулаанд бууж өгөх бодолгүй байв. Энэ хоёр хакер дэлхийн эргэн тойронд байсан 10000 компьютерийг хакердсан юм гэж ял оноох шүүх хурал үргэлжлэх үед Жеймс Ричардсан хэвлэлийнхэнд ярьжээ. Тэд хамгийн багадаа арван таван орны компьютер сүлжээгээр хэсүүчилсэн. Жишээлбэл: Орос, Энэтхэг, Франц, Норвеги, Герман, АНУ, Канад, Бельги, Швед, Итали, Тайван, Сингапур, Исланд, Австрали гэх мэт. Хакеруудын байнд онилогдсон газруудын жагсаалтыг гаргавал бараг толь бичиг шиг хэмжээтэй болох байх гэж Ричардсон шүүх хурал дээр хэлэв.

Пад жагсаалтыг уншиж байхад анхааралтай сонсоно. Зөв байх шиг санагдах ажээ. Харин Х.25 сканнер програмыг пакет сүлжээн дээр ажиллуулж, Шведын телефон утасны сүлжээг

ажиллагаагүй болгосон гэж Пад, Гандалф хоёрыг буруутгаж байгаа нь андуурал байсан юм. Уг сүлжээ ажиллахгүй болсны улмаас Шведийн засгийн газрын сайд телевизээр ард түмнээсээ уучлалт гуйж байлаа. Сайд уучлал гуйж байхдаа асуудлын гол шалтгааныг тодорхой хэлээгүй гэж цагдаагийнхан хэлжээ.

Пад тэдний юу яриад байгааг ойлгохгүй байв. Гандалф, Пад хоёр Шведийн утасны системд ямар ч халдлага хийж байгаагүй ажээ. Тэднийг хийгээгүй үйлдэлд нь буруутгах оролдлого эхэллээ. Хоёр хакер хууль ёсны хэрэглэгчдийн утасны биллээс 25,000 фунт стерлинг зувчуулж, утасны системийг гэмтээснээр нийтдээ 123,000 фунт стерлингийн хохирол учруулсан гэж Ричардсон шүүх хурал дээр хэлэв.

Эдгээр тоог хаанаас аваад байгаа юм бэ? Тэд нотлох баримтыг маш сайн шүүж үзсэн учраас хакеруудын учруулсан хохирлыг нотлох нэг ч биллийг харж байгаагүй юм. Цагдаа, прокурорын яриад байгаа тоонууд бол жинхэнэ билл биш байлаа.

Эцэстээ 5-р сарын 21-ны Баасан гаригт нотлох баримтыг дэлгэн танилцуулсны дараа шүүгч оноох ялыг эргэцүүлэхын тулд түр завсарлаж байгааг зарлав. Шүүгч арван таван минутын дараа буцаж ирэх үед түүний нүүрнээс юу тохиолдохыг Пад шууд мэдэрлээ. Хакерын таамагласнаар: “Чамд Вандийгийн хүртэх ёстой байсан бүхнийг өгөх болно” гэж хэлэх шиг санагдав.

“Хэрэв та хоёрын хүсэл сонирхол компьютер бус машин байсан бол та нарын үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх байлаа. Иймээс оюун ухааны хөөрөл гэж тодорхойлж байгаа ойлголтыг би эсэргүүцмээргүй байна. Хакердах үйлдэл бол гэм хоргүй зүйл биш билээ. Зарим байгууллагын яаралтай тусламжийн үйлчилгээ компьютерээс хамааралтай байна. Компьютерийн гэмт хэргийг уучилж өршөөх үндэслэл байхгүй гэж хакеруудад илэрхий сануулах, ойлгуулах шаардлагатай бөгөөд ял оноохдоо би маш удаан эргэцүүллээ ” гэж шүүгч Харрис хэлэв. Хакеруудад хор хохирол учруулах санаа зорилго байгаагүй гэдгийг тэр хүлээн зөвшөөрсөн боловч нийгмийн компьютер системийг бусдын халдлагаас хамгаалах шаардлага зайлшгүй гарна. Хэрэв шүүгч хоёр хакерыг зургаан сарын хугацаатай шоронд илгээхгүй болнийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй мэт харагдана.

“Та нарын хийсэн үйлдлийн улмаас учирсан хохирол болон хакердах санаа зорилго агуулж байгаа бусад хүмүүст анхааруулга болгох үүднээс хорих ялыг сонгосон” хэмээн шүүгч Харрис хэлэв.

Пад, Гандалф хоёрыг шүүх хурлын танхимаас гаргаж байхад “Энэ бол Вандийгийн шүүх хурлаа тэс өөр шоу болгох шүүх хурал байлаа” гэж Пад боджээ.

Пад, Гандалф хоёр ял авснаас хойш хоёр долоо хүрэхгүй хугацаа өнгөрч байхад өөрийн хувь тавилангаа шийдүүлэхээр Викториа мужийн шүүх хуралд Электрон ирж байв. 1993 оны 6-р сарын 3-ны өдөр шүүх хурлын танхимд оноосон ялаа сонсож байхдаа Электрон хий юм хардаг болсноо мэджээ. Тэр танхим дотор Феоникс, Ноум хоёрыг хайсан боловч олж харж чадсангүй. “Тэдний хийсэн үйлдэл нь нилээд ноцтой тул хорих ял өгөх ёстой гэж би үзсэн. Тэгээд ч олон нийт ийм төрлийн гэмт хэргийг тэвчихгүй гэдгийг харуулах шаардлага байлаа” хэмээн шүүгч Смит хэлэв.

“Манай нийгэм өнөөдрийн байдлаар компьютер технологийн хэрэглээнээс их хамааралтай болсон. Харин та нарын үйлдэл энэ технологийн хэрэглээнд заналхийлэл болж харагдана... Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх явдалд хувь нэмэр оруулах үүднээс ял оноох нь шүүхийн үүрэг хариуцлага гэж бид үзнэ.”

“Таныг зургаан сарын хугацаатай шоронд хорих ялаар шийтгэж байна” хэмээн шүүгч хэлээд хэсэг амсхийснээ “Ингэхдээ та 500 долларын барьцааг төлөхийг тушааж байна... Танд оноосон ялын хугацаанд биеэ зөв авч явбал шоронд ял эдлэх шаардлагагүй” гэж хэллээ. Дараа нь 300 цагийн албадан хөдөлмөр хийж, сэтгэцийн үнэлгээ хийлгэн, эмчлүүлэх шийдвэрийг шүүгч гаргав.

Электрон санаа амарч гүн амьсгаа авлаа.

Шоронд хорих ялыг хойшлуулах хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тайлбарлаж байхдаа шүүгч Смит: “архичин лонхонд дурладагтай адилхан Электрон компьютерт донтсон ” гэж тодорхойлжээ. Хэвлэлийн анхааралд хүргэх үүднээс Борис Кейзерийн хэрэглэсэн үгс, шүүгчийн үзэл бодолд нөлөөлсөн нь илэрхий байлаа. Шүүх хурал дуусангуут Электрон өмгөөлөгчтэйгээ гар барьж, яллагдагчийн тавцанг орхив. Шүүхэд буцаж ирэх шаардлага түүнд дахин нэг удаа гарах ёстой байв.

Хэрэв эрүүгийн гэмт хэргийн шүүх хурал дээр Феоникс өөрийн үйлдлийг бүрэн зөвтгөвөл прокурорын газрынхан Электроныг түүний эсрэг гэрчийн мэдүүлэг өгүүлэхээр дуудах юм. Энэ бол тун хэцүү өдөр байх болно.

Английн баруун хойд эрэг дээр байрлах Престоны ойролцоох Киркхамын шоронгийн хоригдлууд Пад, Гандалф хоёрыг ирнэ гэдгийг аль хэдийнээ сонссон байлаа. Тэд хакеруудыг нэрээр нь шууд дуудна. Тэд телевизороор гарч байгаа мэдээг үзсээр хакеруудыг таньдаг болжээ. Ялангуяа Шаттл сансрын хөлөг хөөрч байгаа бичлэгийг NASA-г Гандалф хэрхэн хакердсан тухай мэдээтэй хамт үзжээ. Хоёр хакер доошоо орж байхад харин сансрын хөлөг дээш хөөрч байна гэж зарим сэтгүүлчид даажигнаж байв.

Киркхам бол шорон руу ачигдахын өмнөх хэдэн хоногийг өнгөрөөсөн Брикстоныг бодвол илүү тухтай санагдана. Шоронгийн тухай Падын төсөөлж байсантай Брикстоны шорон маш адилхан санагджээ. Аз болоход тэднийг өөр шорон руу хувиарлахын өмнө нэг өрөөнд хорьсон нь ихэд тааламжтай байлаа. Пад, Гандалф хоёрыг Брикстонд арав гаруй хоног хорьсны эцэст холбож гавлан, байнга салхилах баруун эрэг рүү зөөвөрлөжээ. Тэднийг зөөвөрлөж байхад Пад гялалзах гав болон инээмсэглэн суух Гандалфын зүг ээлжлэн харсаар гэнэт инээд алдав. Тэд инээдээ барьж чадахгүй хөхрөх ажээ.

Дэглэм доогуур Киркхамын шоронд 632 хоригдол байх агаад дэлхийн хоёрдугаар дайны эзэн хааны агаарын хүчний бааз шиг сэтгэгдэл төрүүлнэ. Тэнд ханан хашаа байхгүй оронд нь төмөр сараалжин хашаа хэрэглэдэг. Шоронгийн хоригдлууд уйдаад ирэнгүүтээ амархан давдаг тухай Пад удалгүй сонсжээ. Киркхамын шоронг хорих газар гэж хэлэхэд хэцүү байлаа. Тэнд шувуутай хиймэл нуур, орой эртхэн үйлчлэх жижиг кинотеатр, найман төлбөртэй утас, хөлбөмбөгийн талбай, крикетийн асар зэрэг олон том талбайг харж болно. Долоо хоногийн ажлын өдрүүдэд үдээс хойш болон амралтын өдрүүдэд 1:10-3:30 хооронд

хоригдлууд дээр эргэлт ирнэ.

Хоёр хакер руу Лак инээмсэглэнэ. Тэд нэг нааран дээр хувиарлагдсан учраас өрөө хамууд болжээ. Таван сараас хойш шоронд хоригдож байгаа тэд зуны гурван сар “хүмүүжилтэй байж, бусад хоригдолтой муудалцахгүй бол” эрх чөлөөндөө гарах байлаа. Бусад шоронгуудын адил Киркхамд хоригдлууд бие биетэйгээ таардаггүй шалтгаан байна. Ихэнхдээ тэд яагаад шоронд орох болсныг асууна, ялангуяа бэлгийн гэмт хэрэгт буруутгагдсан эсэхийг асууна. Тэд бэлгэсийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудад дургүй байлаа. Нэгэн удаа хүчингийн гэмт хэрэг үйлдсэн байж болох этгээдийг дүүжлэхээр мод руу чирж байхыг Пад харсан юм. Үнэндээ бол хоригдол ямар нэгэн бэлгийн гэмт хэрэгт ял аваагүй байсан аж. Тэр татвараа төлөхөөс зайлсхийсэн этгээд л байжээ.

Аз болоход хүн бүр Пад, Гандалф хоёрын тэнд байгаа шалтгааныг мэдэж байлаа. Тэд шоронд ороод долоо хонож байхдаа өөрсдийн өрөөнд орж ирэхэд ханан дээр нь “NASA-ийн төв штаб” гэсэн бичиг сараачсаныг олжээ.

Жирийн дэглэмтэй хорих ангид байгаа зарим хоригдлууд хакердах гэмт хэргийг сайн ойлгож байсан учраас хэрхэн мөнгө хийх тухай олон санаа бодол хэлж байв. Энд хоригдож байгаа ихэнх гэмт хэрэгтнүүд хулгай, кредит картны залилан, бусад хөнгөн гэмт хэрэг үйлдсэн байдаг. Тэнд мөн Пад, Гандалф хоёртой хамт нэг өдөр ирсэн фреакер хүртэл байлаа. Тэр хоригдол 8glm-ийн хакеруудыг бодвол хоёр дахин буюу найман сар шоронд хоригдох ял авчээ. Үүнийг Пад бусад хакерууд руу илгээж байгаа мессэж гэж үзсэн юм.

8glm-ийн хакерууд хичнээн хичээсэн ч шоронгийн амьдралд дасахгүй байв. Оройн цагаар бусад хоригдлууд хар тамхи татаж, билльярд тоглоно. Харин Гандалф өөрийн өрөөний орон дээр тухлах зуураа VMS компьютерийн тухай номыг судална. Пад компьютерийн сэтгүүл уншиж, энэтхэг стилийн хөгжим сонсоно. Шоронгийн тухай кинон дээр гардаг шиг мань хоёр ханан дээр дөрвөн зураас зураад хөндлөн нэгийг татна. Мөн тэд өөр зүйлс ханан дээр зурдаг байв.

Өдөр хоног ээлжлэн өнгөрөх зуур Пад, Гандалф хоёр шоронгийн амьдралд хөл нийлүүлэн алхах болов. Өглөөний 8:30-д хоригдлууд оргосон эсэхийг шалгах тооллого явуулна. Дараа нь тоглоомын талбайг туулан шош, гахайн бейкон, шарсан өндөг, хайрсан талх, зайдас идэхээр явна. Тэднийг ногоо тарих байранд ажиллах ажилд хувиарлажээ.

Ажил хүнд биш байлаа. Шороотой саванд суулгацны нүх гаргана. Салатны навчны үрслэгийг суулгаж, ногоон чинжүү услана. Улаан лоолын үрслэгийг зөөвөрлөнө. Бага үдийн хавьд ногооны хүлэмж халах үеэр Пад, Гандалф хоёр сэрүүцэхээр гадагш гарна. Найз охидууд, хүүхнүүдийн тухай эрчүүдийн хошин яриа тэдний үндсэн сэдэв болно. Үдийн хоолны дараа ногооны хүлэмжинд хэсэг хугацаа өнгөрөөж байгаад шоронг хүрээлэх ногоон нуга руу алхана. Эхлээд хөл бөмбөгийн талбай, дараа нь хэдэн үнээ харагдах нугын наахна очиж тухлана. Хошин шогийн мэдрэмжтэй, хүнтэй эв түнжин сайтай Пад бусдын хүндэтгэлийг хүлээдэг байлаа. Гэхдээ түүнийг таална гэдэг түүнийг мэдэхтэй адилгүй юм. Хувь хүний шинж чанар нь хошин зантай ямар ч холбоогүй байв. Гандалф үүнийг сайн мэднэ. Гандалф бол хүнтэй нийтэч хүн. Тэд удаан хугацаагаар зугаалах үедээ зогсоо зайгүй санал бодлоо хуваалцсан билээ. Тэд ногоон талбайгаар алхаж байхад Пад деним яак байнга өмсөнө.

Шоронгоос өгч байгаа хувцас хөх өнгөтэй боловч Пад деним яакнаас сална гэж үгүй. Шоронгийн эргэн тойрон алхаж ихэнх цагийг өнгөрөөх Пад эндээс оргох яасан амархан бэ хэмээн бодох үе байлаа. Гэвч энэ бол хүсээд байх зүйл биш гэдгийг тэр мэднэ. Цагдаа нарт баригдана, дахин буцаж ирээд хоригдох хугацаагаа нэмүүлэхийг хэн ч хүсэхгүй. Падын эцэг эх нь долоо хоногт нэг удаа эргэж ирнэ. Нэгэн удаа хурааж авсан компьютерийг нь буцаан өгсөн тухай мэдээг эргэлтээр ирсэн ээж аав нь хэлэхэд тэр маш их баярласан гэдэг. Падыг шоронд зовж байгаа гэж хариулна хэмээн бодсон цагдаагийн ажилтан түүний ээжээс Падын тухай асуухад “Тэр маш сайн байгаа. Шорон түүний бодсон шиг муу биш юм билээ” хэмээн хариулжээ. Ингээд гурван сар ногоон нугаар алхсан Пад, Гандалф хоёрын царай ч борлож, шоронгоос ч гарах дөхлөө.

Шүүх хурлын танхимд суугаа жирийн хүмүүст ч Феониксийн ээж аав хоёрын хөндий харьцаа мэдэгдэнэ. Тэр хоёр бие биетэйгээ ойр суугаагүй боловч далдхан буцлах дайсагналаа дарж чадахгүй байгаа нь илт байлаа. Ноумын өргөж авсан эцэг эхийн хажууд Феониксийн төрүүлсэн эцэг эхийн байдал эрс ялгаатай байв. 1993 оны 8-р сарын 25-ны Лхагва гаригт Феоникс, Ноум хоёр 15 үйлдэлд буруугаа хүлээн тус бүр ял авчээ. Мөрдөн байцаалтын явцад цуглуулсан нотлох баримт тэднийг ялаас мултрах бүх замыг хаажээ. Электрон ч гэрчийн мэдүүлэг өгөхөөр шүүхэд ирэх шаардлага гарсангүй. Маргаашийн давж заалдах уулзалт дээр Феониксийн өмгөөлөгч Дайсон Хоре Лэси түүний салсан эцэг эхийн тухай шүүгчид тайлбарлахад нилээд цаг зарцуулав. Эцэг эхийн салалт, гэр бүлийн гишүүдийн тусдаа амьдралын гайгаар хүү компьютертэйгээ л нөхөрлөхөөс өөр зам байгаагүй гэж ойлгуулах явдал Феониксийг хорих ялаас аврах ганц боломж гэлтэй. Эцэг эхийн буруу хандлагын улмаас амьдралын зөв замаас хазайж, одоо л ажил амьдралынхаа зөв чиглэл рүү тэмүүлж байгаа залуу хүнийг дэмжих ёстой гэсэн ойлголтыг түүний өмгөөлөгч гаргаж тавив.

Прокурорын газар Феониксийн эсрэг хатуу бодлогыг баримталж байв. Түүнийг бардам этгээд гэж үзэх прокурорынхон шоронд ял эдлүүлэх сонирхол их байгаа мэт сэтгэгдэл төрүүлнэ. Аюулгүй байдлын цоорхойг нь илрүүлсэн тухайгаа Карнеги Меллоны Их сургуулийн компьютерийн мэргэжилтэн Эдвард Дехарт руу утасдаж онгирч байгаа Феониксын дууны бичлэгийг шүүхэд сонсожээ. Дехартыг компьютер руугаа орж “passwd-f” аюулгүй байдлын цохны тухай алхам алхамаар судлахыг Феоникс зөвлөсөн гэнэ. Хамгийн инээдтэй нь энэ аюулгүй байдлын цоорхойг Электрон олж нээсэн бөгөөд түүний нэрийг Феоникс Дехартад дурьдаагүй юм.

Тэр өдөр шүүх хуралд Австралийн Холбооны цагдаагийн газрын Өмнөд бүсийн компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, мөрдөгч, түрүүч Кен Дей оролцжээ. Тэр энэ өдөр шүүх хуралд оролцохгүй өнгөрөөх эрхгүй байв. Феониксийн эцэг эхийн хоорондох хурцадмал байдлын тухай өөр нэгэн гэрч мэдүүлэг өгөх болжээ. Намхан биетэй Дей дарга Феониксийг тун таагүй хүлээж авдаг нэгэн гэдэг нь илт байлаа. Гэхдээ олон нийтийн өмнө Феониксэд дургүйгээр ил гаргах тэнэг хүн тэр биш ажээ. Түүний царай үзэн ядсан шинжийг үл гаргах бөгөөд нүүрний булчин үл ялаг чангарахыг ажиглах хүн үгүй байлаа. 1993 оны 10-р сарын 6-ны өдөр Феоникс, Ноум хоёрт ял оноолоо. Ширүүн гэмээр дүр төрхтэй шүүгч Смит хакеруудын Realm бүлгийн гарал үүсэл болон хоёр хакерын ялыг нэг бүрчлэн тодорхойлов.

“Чиний хийсэн ажиллагаа түүнийг буруутгаж байгаа явдалд гайхах зүйл байхгүй юм. Чи зарим системийн администратор руу хандан тайлбар хийжээ. Гэхдээ энэ бол бусдын сайн сайхны төлөө гэхээс илүүтэй чиний өөрийгөө бусдад гайхуулах гэсэн бүдүүлэг зантай тань холбоотой болов уу... Чи юу хийсэн болон цаашид юу хийх талаар онгирч сагсуурсан. .. Үйлдлийг чинь бүхэлд нь авч үзвэл бүдүүлэг, бардам байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл аливаа компьютерийн системийг дайсагнасан санаа зорилгоор, нээлттэй хакердсан нь илэрхий харагдана. Тэрхүү хакердах үйлдлийн үр дүнд хараандаа авсан олон төрлийн системүүдэд хэсэг хугацааны үймээн тарьжээ” гэж шүүгч хэлэв.

Ял оноосон тогтоолыг уншиж байхдаа шүүгч хэдийгээр тайван харагдах боловч дотроо өөрийн гаргасан шийдвэрийг эргэцүүлж, эргэлзсээр байсан юм. Австрали улсад хакердах гэмт хэрэгт оноох ялны талаар тодорхой жишиг тогтоох, иймэрхүү үйлдлийг таслан зогсоох хэрэгцээ шаардлагыг дэнслэхийг хичээхийн сацуу энэ хэрэгт холбогдсон хувь хүн бүрийн гүйцэтгэсэн үүргийг үнэн мөнөөр нь ялгах хэрэгтэй байлаа. Хэрэгт холбоотой маргааныг дахин дахин эргэцүүлсний эцэст тэр өөрийн шийдвэрээ гаргажээ.

“Манай нийгмийн зарим хэсгийнхэн хорих ял оноох нь хамгийн зүйд нийцсэн шийдвэр хэмээн үзэж байгаад эргэлзэхгүй байна. Би ч гэсэн тийм санааг дэмжинэ. Гэхдээ анхаарч үзэх шаардлагатай бусад асуудлыг хөндвөөс хорих ял оноох шаардлагагүй гэсэн дүгнэлтэнд хүрэв” гэж шүүгч хэлэв.

Хакеруудын хамаатан садан, найз нарын царайд баярын мишээл тодорлоо. Шүүгч Феониксэд хоёр жилийн хугацаанд 500 цагийн албадан хөдөлмөр хийлгэх ял оноож, 1000 доллараар торгожээ. Шүүгч Ноумд 200 цагийн албадан хөдөлмөр хийлгэх ял, 500 долларын торгууль оноов.

Феониксийг шүүхийн танхимаас гарч явахад туранхай өндөр хүн түүнийг чиглэн ирлээ. Үс нь мөрөө шүргэсэн, үл таних хүн “Баяр хүргэе” гэхэд Феоникс “Баярлалаа” гэв.

Феоникс: “Би таныг таних билүү?” гэж асуухад үл таних хүн “Магадгүй ээ. Намайг Мендакс гэдэг. Би чиний туулсан замаар явах болоод байна. Гэхдээ арай хүндхэн замаар” хэмээн хариулав.

Наймдугаар бүлэг

Олон улсын босогчид

“Нууцлаг дуу чимээний эргэн тойронд”

“Maralinga” Midnight Oil хамтлагийн дуу

Prime Suspect Мендакс руу утасдаж адал явдалт аялалд урив. (Prime Suspect-гол сэжигтэн гэсэн утгатай үг) Тэрээр NMELH1 нэртэй хачин системийг нээсэн бөгөөд одоо тэрхүү системээр аялахыг хүсчээ. Уг нэрийг дуудвал N-Melly-H-1 гэж сонстоно. Мендакс dial up дугаарыг уншиж байхдаа өөр нэгэн хакердсан систем дээр байсан модем утасны дугааруудын жагсаалт байхыг олов. Мендакс гартаа байгаа цааснуудыг уншиж байгаад компьютерийн системийн нэрийг олохыг хичээжээ.

“N” үсэг нь Northern Telecom буюу жилийн орлого нь 8 тэрбум доллараар хэмжигдэх Канадын компанийг илэрхийлнэ. Тус компани NorTel гэсэн нэрээр олны танил болсон бөгөөд хамгийн сүүлийн үеийн свитчүүд, телефон утасны тоног төхөөрөмжүүдийг дэлхийн томоохон утасны компаниудад хэдэн мянгаар нь худалдана. “Melly” гэдэг нь Мелбурнд байгаа систем болохыг төвөггүй тааж болох аж. Харин “H-1” гэсэн нь “Host-1” буюу нэгдүгээр компьютерийг илэрхийлж байна гэж Мендакс тааварлажээ.

Прайм Саспект Мендаксийн сонирхлыг улам өдөөж байлаа. Телефон үйлчилгээний байгууламжийг хянадаг компьютерийн доторх командыг судлахад Мендакс нилээд хэдэн цагийг зарцуулав. Эцэстээ тэдний анхны довтолгоо нь туршилт, алдаагаа олж мэдэх, эсвэл нээлт хийх эрсдэлтэй алхам буюу харанхуйд тэмтчихтэй адилхан ажил байжээ. Ганц компьютерт алдаа хийхтэй адилгүй телефон үйлчилгээний байгууламжийн доторхи командыг буруу тооцвол Сидней эсвэл Мелбурнийн 10,000 эсвэл түүнээс ч их телефон утасны шугамд эгшин зуур бужигнаан үүсгэх боломжтой байв.

Олон улсын босогч бүлгийнхэн ч ийм байдалд хүргэхийг хүсэхгүй байлаа. Олон улсын босогчид бүлгийн гурван хакер-Мендакс, Прайм Саспект, Тракс нар Англи, Австралийн хакеруудын танил болсон гишүүд ажээ. Олон улсын босогчид бүлгийн хакерууд өөрсдийн ажиллагааг нууц байлгах шалтгаан байлаа.

Феоникс, Ноум, Электрон нар гол шалтгаан аж.

Харин үйлдвэрлэгчийн техникийн бичиг баримтыг уншсанаар сая долларын телефон утасны сүлжээний байгууламжийг оролдож болох эсэхийг Мендакс бодож байв. Олон нийтэд бэлнээр олдохгүй NorTel компанийн компьютерийн сүлжээнд хадгалагдаж байдаг тэдгээр бичиг баримтыг олж судлах боломж хир байдаг бол?

Тодорхой телефон утасны свитчийг хянах ажиллагааг зохицуулдаг Nor Tel-ийн DMS-100 мэтийн програм хангамж түүний оригинал source кодийг олж мэдэх хэрэгтэй байв. Тэр код NorTel компанийн сүлжээтэй холбогдсон компьютер дээр суулгасан байж болно. Тус компани энэ програмыг үйлчлүүлэгч рүүгээ илгээхээс өмнө сүлжээнд нэвтрэх боломжтой хакер

аюулгүй байдлын нууц цоорхой буюу арын хаалгыг уг програм дээр бий болгож болно. NorTel компаний төхөөрөмжийн ажиллагааны талаар техникийн сайн мэдлэгийг компаниас гаргасан тодорхой бүтээгдэхүүний хамт гаргах програм бүрт хавсаргасан арын хаалгатай хослуулснаар Бостоноос Бахрайн хүртэлх бүхий л телефон утасны свитчэд суулгасан NorTel-ийн DMS програмыг хяналтандаа бүрэн оруулах юм. Их эрх мэдэл шүү! хэмээн Мендакс бодлоо. Рио де Жанейро хотын 10,000 утсыг ажиллахгүй болгож, Нью Йорк хотын оршин суугчид нэгэн өдрийн үдээс хойш 5000 үнэгүй дуудлага хийнэ, эсвэл Брисбаны хотын телефон утасны яриаг сонсоно гээд боддоо. Дэлхийн телефон холбооны сүлжээ таны гарт орно гэсэн үг юм.

Олон улсын босогчид хакерын бүлгийн гурван гишүүд бусад хүмүүсийн адил Мелбурнийн BBS дээрх холбооноос гараагаа эхэлсэн юм. 1988 оны хавьцаа “Цахим мөрөөдөл” нэртэй сайт дээр Мендакс Тракстай, Мегаворкс дээр Прайм Саспекттай учирсан билээ. Тухайн үед Мелбурн хотоос холгүй орших уулархаг газар Текома дахь өөрийн гэрээс BBS чатын сайт байгуулж, хоёр хакерийг зочлохыг урьжээ. Текома бол бараг ой дотор байдаг гэж болох мужийн зах хязгаар байлаа.

Бусад BBS чатын сайтыг бодвол нууцлал арай өндөр байсан учраас Мендаксийн BBS рүү хоёр хакер орж ирэх дуртай байв. Удалгүй тэд утасны дугаараа солилцож харьцахдаа зөвхөн модемноос модемд гэсэн аргаар ярилцана. Тэд олон сарын турш утсаар дуут яриа хийж, дэлгэц дээр бичих маягаар харилцсан бөгөөд өөр нэг ч хүнтэй харьцаагүй ажээ. Ингээд 1990 оны сүүлээр 19 настай Мендакс 24 настай Тракс руу утасны дуудлага хийв. Мөн 1991 оны эхээр арван долоон настай Прайм Саспекттай Мендакс утсаар ярьж эхэлсэн гэдэг. Тракс маш өвөрмөц зан араншинтай бөгөөд сэтгэцийн ямар нэгэн эмгэгтэй мэт санагдаж байв. Тэрээр хот руу явж эмчид үзүүлэхийг эсэргүүцэж байсан юм. Харин Мендаксын сонирхлыг татсан хүмүүс дандаа л ер бусын байдаг. Тракс ч тийм шинжийг агуулжээ.

Мендакс болон Траксын хооронд нийтлэг зүйл олон байлаа. Хоёулаа боловсролтой боловч ядуу гэр бүлээс гаралтай, хоёулаа хотын захад амьдарна. Харин тэдний бага нас өөр өөр орчинд өнгөрчээ. Траксийн эцэг эх нь Европоос Австрали руу цагаачлан ирсэн ба аав нь компьютерийн техникч хийж байгаад тэтгэвэрт суусан, ээж нь Герман аялгаар ярьдаг хүн байв. Тракс айлын ганц хүү байжээ.

Мендакс арван таван нас хүрэх үед түүний гэр бүл Перт, Магнетик айланд, Брисбане, Тоунсвилле, Сидней, Аделейдс хилс, Нью Соут Уейлсийн хойд хэсэг ба Баруун Австралийн жижигхэн хот зэрэг газруудаар явж амжсан байлаа. Арван таван жилийн дотор тэр маш олон сургууль сольжээ.

Түүний ээж нь зурсан зургаа зарж, мотоцикль, майхан, Австралийн газрын зураг авах мөнгөтэй болонгуут Куинсланд дахь гэрээ орхин гарчээ. Тэр үед Мендаксын ээж 17 настай байлаа. Хоёулаа их сургуулийн багш мэргэжилтэй эцэг эхээ гайхшруулан “баяртай” хэмээн гарсан охин 2000 километр аялсны дараа Сиднейд ирсэн түүхтэй. Тэнд зураачаар ажиллаж байхдаа Вьетнамын дайныг эсэргүүцсэн жагсаалд идэвхитэй оролцож байсан залуутай танилцаж, дурласан байна. Мендаксийг төрснөөс хойш нэг жилийн дотор хосуудын харьцаа хөрчээ. Түүний ээж нь Мендаксийг хоёр настай байхад хамт ажилладаг жүжигчинтэй гэрлэв. Мендаксийн хойд аав нь жүжиг найруулан тавьж, ээж нь жүжигчдийн нүүрний будалт,

хувцас, дизайныг хийнэ.

Цөмийн зэвсгийг эсэргүүцсэн уулзалт зохион байгуулсны дараа түүний ээж болон хэсэг нөхөд нь тэдний гэрт иржээ. Тэр үед Мендакс дөрвөн настай байв. Ирсэн хүмүүсийн нэг нь Өмнөд Австралийн баруун хойд хэсгийн элсэн цөл дэхь Маралингад Британчууд цөмийн туршилт хийсэн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримт байгаа гэж ярьж байв.

1953-1963 онуудад Британий Засгийн газар Маралингад цөмийн бөмбөг олноор туршиж, 5000 Аборигейнчуудыг төрөлх нутгаас нь хүч хэрэглэн хөөсныг 1984 онд Эзэн хааны Комисс олонд ил болгосон юм. 1993 оны 12-р сард олон жил булзайруулсны эцэст 200 хавтгай дөрвөлжин километр бохирдсон газрыг ариутгах зардалд 20 сая фунт стерлинг нөхөн олгохыг Британий Засгийн газар хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ бүр 1968 онд уг газрыг цэвэрлэх хариуцлагыг Британи улс хүлээх ёстой гэж Мензиесийн Засгийн газар зөвшөөрсөн байсан юм. 1970-аад оны үед Маралингад чухам юу болсныг Австралийн Засгийн газар нуусаар байлаа.

Мендаксын ээж өөрийн найзын хамтаар Маралингагийн эмгэнэлийг нотлох баримтыг авч Аделейдын замаар явжээ. Гэтэл тэднийг номер дугааргүй машин дагаж эхлэв. Тэд дагаж байгаа машинаас салах гэж оролдсон ч амжилт олсонгүй. Цагдаа нар тэднийг зогсоохоос өмнө нотлох баримтыг Аделейдын сэтгүүлчдэд хүргэх ёстой гэж ээжийнх нь найз сэтгэл зовон хэлэв. Мендаксийн ээж нь харанхуй зам руу хурдлан орж, найзыгаа машинаас буулгаад цагдаа нарын анхаарлыг татан өөр тийшээ давхилаа.

Удалгүй цагдаа нар эмэгтэйг баривчилж, уулзалтан дээр юу яригдсан, найз нь хаана байгааг асуугаад машиныг нь нэгжив. Түүнээс олигтой зүйл сонсож мэдэхгүйгээ ойлгосон нэг цагдаа: “Чи хүүхэдтэй шүү дээ. Чамайг улс төрөөс ангид байхыг зөвлөж байна залуу хатагтай. Тэгвэл таныг сайн ээж гэж хүмүүс хэлнэ шүү дээ” хэмээн хэлжээ.

Заналхийллээс хойш хэдэн өдрийн дараа нүүр нь үл ялиг хөхөрсөн ээжийнх нь найз Мендаксийн гэрт ирэв. Цагдаа нар түүнийг зодохоос гадна биедээ мансууруулах бодис авч явсан гэж зохиомол хэрэг тулгажээ. “Би улс төрөөс гарлаа” гэж тэр хэлсэн билээ.

Түүний ээж болон нөхөр нь театртэй холбоотой хэвээр байсан боловч циркэд ажиллахаар гэрээсээ хэзээ ч зугатах сэтгэхүй залуу Мендакст байгаагүй юм. Тэрээр байнгын аялан тоглолтоор хэсүүчлэх амьдралд хангалттай ихийг үзжээ. Түүний хойд эцэг сайн аав, сайн жүжигчин байсан хэдий ч архи уудаг муу зуршилтай байв. Мендакс есөн настай байхад түүний эцэг эх дахин салж, тусдаа амьдрах болжээ.

Ингээд Мендаксийн ээж уур уцаар нь багтаж ядсан хөгжимчинтэй холбоотой болов. Түүнийг сэтгэцийн өөрчлөлтэй, зальтай гэж боддог байсан учраас Мендакс ихэд эмээдэг байлаа. Тэрээр түрийвчиндээ таван өөр үнэмлэхтэй явдаг байжээ. Түүний боловсролоос эхлээд төрсөн газар нь хүртэл худал мэт санагдана. Энэ хүн болон ээжийнх нь харилцаа төгсгөл болонгуут улс орноороо хэрэн тэнүүчлэх аялал дахин эхэллээ. Тивийн хоёр талд олон газраар аялж, амьдарсаар Мелбурнийн захын хороололд Мендакс болон түүний гэр бүлийнхэн суурьшжээ.

Удахгүй түүнийг баривчилж магадгүй гэсэн мэдээлэл авсан Мендакс 17 настай байхдаа гэрээсээ явав. Тэр диск, хувилж авсан материалуудаа устгаад зугтжээ. Долоо хоногийн дараа түүний гэрт Викториа мужийн цагдаагийн товчооны мөрдөгчид ирж, өрөөг нь нэгжээд юу ч олсонгүй. Мендакс дотуур тамиртай гэмээр ухаалаг охинтой гэрлэж жилийн дараа гэхэд хүүхэдтэй болжээ. Түүний эхнэр нь тэр үед арван зургаан настай байсан юм.

Мендакс компьютерийн далд ертөнцөөс өөрийн олон найзыг олж авчээ. Тэр найз Тракстайгаа нэг удаа утсаар ярихдаа таван цагийн турш тасралтгүй хөөрөлдөнө. Тэдний яриа таардаг байв. Харин Прайм Саспект утсаар удаан ярих дургүй нэгэн байлаа.

Чимээгүй, барагтай л бол үг унагахгүй Прайм Саспект таван минут яриад л уйдаж янзандаа орно. Ерөнхийдөө Мендакс ичимтгий хүн тул удаан хугацааны туршид чимээгүй сонсох нь элбэг тохиолдоно. Мендакс Прайм Саспектийг ихэд хүндэлдэг байлаа. 1991 оны дундуур Траксийн гэрт гурван хакер уулзах үед харилцаа холбоо сайтай “Олон улсын босогчид” бүлгийн хакер Прайм Саспектийг сайн найзаас илүү хүн юм гэдэгт Мендакс итгэх болжээ.

Прайм Саспект бусдыг хамгаалах, туслах чин сэтгэлтэй хөвгүүн байлаа. Тэрээр бусдын нүдэнд 12-р ангиа амжилттай дүүргэсэн, ирээдүйтэй хүүхэд хэмээн тооцогдоно. Харин хүүгийн гэр бүлийн амьдрал гаргаж байгаа амжилттай нь харьцуулшгүй өөр ертөнц байсан юм. Эм зүйч мэргэжилтэй аав нь сувилагчаар ажилладаг түүний ээжтэй байнгын маргаанд манарч, салах дээрээ тулсан хэцүүхэн үед түүний аав нь хорт хавдраар өвчилсөнийг шинжилгээгээр нотолжээ. Хатуу ширүүн ийм нөхцөлд найман настай Прайм Саспект аавтайгаа салах ёс хийхээр эмнэлэг дээр очиж байсан гэдэг. Прайм Саспектийн хүүхэд ахуй нас санхүүгийн хүндрэлд орж, тавгүйцсэн ээжийн уур уцаар дунд өнгөрсөн ажээ. Түүнийг найман настай байхад арван зургаан настай эгч нь гэрээсээ зугатаж, Перт хот руу явснаас хойш ээжээсээ холбоо тасарчээ. Багаасаа хэрсүү амьдрал үзсэн Прайм Саспект зарим талаараа насанд хүрсэн мэт байсан юм. Ойр орчин нь уур уцаарт дарагдах цагт өөрийн өрөөнд хоргодож цагийг өнгөрөөх Прайм Саспект хүү арван гурван насандаа анхныхаа Apple II компьютерийг худалдан авчээ. Компьютер бол түүний хамгийн ойрын хамаатан садангаас илүү хань, нөхөр болно. Сургууль дээрх компьютерүүд гадаад ертөнцтэй модемоор холбогдоогүй учир түүний сонирхлыг бага татна. Apple компьютер хэрэглэгчдийн нийгэмлэгийн тараах материалыг олж уншсанаас хойш хүү модем авах мөнгө цуглуулж эхлэв. Удалгүй тэр санасандаа хүрч олон янзын BBS чат сайтуудаар зочлох боллоо.

Хэдийгээр томоотой харагдах, дуу шуу багатай хүү бусдад мэдэгдэлгүй үймүүлэх агаад баригдана гэж үгүй. Прайм Саспектэд гэм зэмгүй харагдах царайг байгаль эх заяажээ. Өндөр, гуалиг мөртлөө буржгар үстэй хүүгийн жинхэнэ нүүр царай түүний зальтай инээмсэглэлээр л тодрох ажээ. Түүний хийж байгаа үйлдлийг ухаан санааны түвшинтэй нь харьцуулшгүй гэж багш нар ээжид нь хэлснийг үзвэл хэдэн хүн гомдоллосон бололтой.

Арван нас хүрэнгүүтээ Прайм Саспект сайн хакер болж, ихэнх цагаа компьютерийн ард өнгөрөөх боллоо. Заримдаа тэр хичээлээ таслаж, даалгавараа нөхөх шаардлага гарна. Тэрээр нилээд бүтээлч маягаар уучлал гуйхаас залхаж, багшдаа үнэнээ хэлж байгаагаар төсөөлдөг байв. “2000 үгтэй даалгавараа бичиж амжаагүй боловч өнгөрсөн шөнө NASA-гийн сүлжээнд нэвтэрч чадлаа” хэмээн хэлж байгаагаар төсөөлсөн хакер инээд алдан сууна.

Охидыг хакердах ажиллагаанд саад хийдэг нэг шалтгаан гэж тэр үзнэ. Үдэшлэг дээр хэн нэгэн охинтой уулзаж ярилцсан мөртлөө түүнтэй уулзах санал хэзээ ч тавьж байсангүй. Тэр гэртээ харьж компьютер дээрээ суухыг илүүд үздэг учраас ямар нэгэн охинд сэтгэл алдарч байгаагүй юм. Прайм Саспект хакердаж байгаагаа сургуулийнхаа хэнд ч хэлээгүй бөгөөд Ментат хүртэл энэ тухай гадарлахгүй байжээ. Realm-ын зочин, Форсийн найз Ментат Прайм Саспектаас хоёр ангиар ах байлаа. Гэхдээ өөрөөсөө дүү Прайм Саспекттэй ярилцахдаа Ментат дурамжхан байв. Үүнд ч залуу хакер нэг их сэтгэлээр унахгүй. Бусад хакеруудын муу үлгэр жишээг олонтаа сонссон залуу хакер тэдний ажиллагааны нэг хэсэг мэт харагдахыг хүссэнгүй. Тэрээр хакердах амьдралаа ганцаар үргэлжлүүлэхдээ баяртай байжээ.

Realm нуран унахаас өмнө шөнийн хоёр цагт Феоникс түүн рүү утасдаж Ноумтай хамт хакердах тухай яриу. Утас дуугарангуут сэрсэн Прайм Саспектийн ээж ийм эрт утсаар ярихыг найз нартаа зөвшөөрсөнд уурлан хараана. Түүний нэг чихэнд Феоникс бардамнаж, нөгөө чихэнд ээж нь цамнан үглэх тэр мөчид Прайм Саспект хоёулангаас нь залхаж байгаагаа мэдэрчээ. Тэр Феониксэд үгүй ээ баярлалаа гэж хэлээд, ээждээ зориулан өрөөнийхөө хаалгаа хаалаа.

Гэсэн хэдий ч тэр Пауерспайктай утсаар нэг бус удаа ярьж байв. Хөгшин хакер хэт үл тоосон шинжтэй харьцана. Ерөнхийдөө Прайм Саспект эдгээр богино ярианаас бусад тохиолдолд өөр хакертай ярьсан удаа байхгүй бөгөөд Олон Улсын Босогчид бүлгийн гишүүд биш бол шууд зайлсхийнэ. Ялангуяа Мендакс хоёр цэргийн маш нууц зэрэглэлтэй компьютерийг хакердсанаас хойш тэр өөр хүнтэй харьцахаа больжээ.

Мендаксийн бичсэн Syscophant програмыг ашиглан Олон Улсын Босогчид бүлгийн хакерууд АНУ-ын Армийн компьютерийн сүлжээ рүү томоохон дайралт хийв. Тэд довтолгоонд хэрэглэдэг найман компьютер дээр Syscophant програмыг хуваан байршуулахдаа Австралийн Үндэсний Их сургууль, Техасын Их сургууль мэтийн газрын компьютерийн системийг сонгожээ. Тэд эдгээр найман компьютерийг бай руу чиглүүлэн галлана. Зургаан цагийн дотор найман компьютер мянга мянган компьютер руу довтоллоо. Заримдаа хакерууд нэг шөнийн дотор 100,000 эккаунтын мэдээллийг хурааж байв. Syscophant програмыг ашиглан компьютер сүлжээн дэхь Unix үйлдлийн системтэй компьютерүүдийг бүхэл бүтэн интернет систем рүү довтолгоо хийх горимд албадаж оруулна.

Энэ бол тэдний довтолгооны зөвхөн эхлэл байсан юм. Яг тодорхой нэгэн компьютерийг хакердсан ч гэсэн маш олон сайтаар хэсүүчилж байсан учраас хожим тэд ямар компьютерт зочилсноо огт санахгүй билээ. Тэдний санаж байгаа газруудыг дурьдвал Америкийн цэргийн аж үйлдвэрийн салбарын хэнсэн билээ дээ л гэж хэлэх бизээ. Пентагоны АНУ-ын Агаарын хүчний 7-р бүлгийн төв штаб, Калифорни дахь Станфордын Судалгааны Институт, Виржиниа дахь Тэнгисийн цэргийн далай дээрх тулааны төв, Техас дахь Локхийд Мартины Агаарын хүчний дайралтын зэвсэг техник үйлдвэрлэх газар, Пенсилвания дахь Блуе Беллийн “Unisys” корпораци, NASA-ийн Годдардын Сансрын нислэгийн төв, Иллиноис мужийн Моторолла корпораци, Калифорни мужийн Редонда Бийч дэхь “TRW” корпораци, Питтсбургийн Алкоа, Нью Жерсейн Панасоник корпораци, АНУ-ын Тэнгисийн цэргийн далай доорхи тулааны инженерчлэлын станц, Массачусеттс дахь “Siemens Nixdorf” мэдээллийн системийн корпораци, Нью Йоркийн Секьюритис Индастри Автомашн

корпораци, Калифорния дахь Лауренсе Ливерморийн Үндэсний Лаборатори, Нью Жерсейгийн Белл холбоо харилцааны судалгааны хүрээлэн, Калифорния дахь “Xero Palo Alto” судалгааны төв гэх мэт газрууд байна.

The Realm-ийн амжилтын түвшинд хүрэнгүүт Олон Улсын Босогчид бүлгийн хакерууд эрсдэл дагуулах магадлал байгааг ойлгож, Австралийн хакерийн хүрээнийхнээс зайгаа авч эхэлжээ. Удалгүй тэдний хүрээнд хэн ч орж чадахгүй болтол нягт хамгаалалтыг үүсгэв. Тэд зөвхөн өөр хоорондоо л ярина.

Realm-ийн хакерууд үгүй болсон явдал хакеруудын дараагийн шинэ үе гарч ирэхэд саад болж чадсангүй. Энэ бол хакерууд улам л далд байдалд орох шалтаг болж өгсөн гэдэг.

1991 оны хавар Прайм Саспект, Мендакс хоёр интернет дээрх хамгийн чухал компьютер байгаа АНУ-ын Батлан хамгаалах газрын Сүлжээ мэдээллийн төвийн (NIC буюу Network Information Center) руутыг авах гэж оролджээ.

Мелбурнийн Их сургуулийн компьютер дээр хоёр хакер нөхөрсөг чат хийж байх хооронд Прайм Саспект Сүлжээ Мэдээллийн Төвтэй ойр холбогдсон АНУ-ын Батлан хамгаалах департаментын систем ns.nic.ddn.mil рүү нэвтрэхээр өөр нэгэн дэлгэц дээр чимээгүйхэн ажиллана. Сүлжээ Мэдээллийн Төв NIC ба түүний охин системхоорондоо холбогдон ажиллаж магад гэж үзсэн тэрээр NIC рүү нэвтрэхэд охин системийг ашиглахыг оролдов. Тэгээд NIC бүх зүйлийг хийж байлаа.

Бүхэл интернэтийн хүрээнд зориулан цахим шуудангийн хаягны төгсгөлд “.com” ба “.net” гэсэн домайн нэрсийг NIC олгожээ. Түүнчлэн АНУ-ын армийн өөрийнх нь дотоод хамгаалалтын дата сүлжээ буюу “MILNET”-ийг NIC хянаж байв. Мөн бүх интернетэд зориулсан харилцаа холбооны протоколын стандартуудыг NIC гаргасан юм. RFC хэмээн нэрлэдэг (Request for Comments-сэтгэгдэл, тайлбар хүссэн хүсэлт гэсэн утгатай үгс –орч) эдгээр техникийн үзүүлэлтүүд нь интернет дээрх нэг компьютерийг нөгөөтэй нь ярих боломжийг олгоно. Батлан хамгаалах дата сүлжээний аюулгүй байдлын бюллетень, АНУ-ын Батлан хамгаалах департаменттай адилхан эрх хэмжээтэй CERT-ийн зөвлөмжүүд NIC-ийн компьютерээс ирдэг байлаа. Магадгүй интернет дээр урвугаар мэдээлэл хайх үйлчилгээг NIC хяналтандаа байлгадаг нь хамгийн чухал байсан бизээ. Хэн нэгэн хүн интернетээр дамжуулан өөр сайттай холбогдох бол сайтын нэрийг жишээлбэл: Мелбурнийн Их сургуулийн ariel.unimelb.edu.au гэсэн хаягийг шивнэ. Үсгээр бичсэн хаягийг компьютер хувиргах буюу хөрвүүлж тоон хаяг болгоно. Үүнийг IP address гээд байгаа. Дээрх жишээн дээр 128.250.20.3 гэсэн тоон хаяг болгож хөрвүүлнэ гэсэн үг. Интернетэд холбогдсон бүх компьютерүүд мэдээллийн багц буюу дата пакетыг нөгөө компьютер рүү дамжуулахад IP хаяг шаардлагатай. Харин интернет компьютерүүд үсгээр бичсэн хаягийг IP хаяг болгон урвугаар хөрвүүлэхийг NIC шийдэж байсан юм.

Хэрэв чи NIC-г удирдаж, хяналтандаа байлгавал интернет дээр ер бусын хүч чадлыг эзэмших болно. Өөрөөр хэлбэл чи Австрали тивийг зүгээр л алга болгочих жишээтэй. Эсвэл та Австралийг Бразиль болгон хувиргаж чадна. Австралийн бүх сайтуудад зориулан өгсөн “.au” төгсгөлтэй интернет хаягуудыг Бразиль руу шилжүүлнэ. Нэг үгээр хэлбэл дэлхийн интернетээс Австралийг хасаж хаяад Австралийн интернет урсгалыг Бразиль руу

шилжүүлэхэд л болчих юм. Үнэндээ бол бүх домайн нэрсийн төлөөллийг өөрчилснөөр интернет дээрх бүх улс орны хооронд урсаж байгаа мэдээллийг бараг зогсоож болох билээ.

Тэгэхлээр үсгээр бичдэг хаягийн оронд тоогоор илэрхийлэх IP хаягийг бүрэн шивж чадвал энэхүү хүч чадлыг давж гарах цорын ганц арга юм. Гэвч үсгэн хаягтай ижил утга илэрхийлэх арван хоёр хүртэлх оронтой IP хаягаа хэдхэн л хүн мэдэх байх.

NIC-ийг хяналтандаа авна гэдэг бас өөр ашиг тустай. Та интернетэд холбогдсон бусдад итгэдэг ямар нэгэн компьютер рүү нэвтрэх виртуал түлхүүрнээс атгаад авна гэсэн үг. Тэгээд ч ихэнх компьютерүүд хамгийн багадаа өөр нэг системд итгэсэн байдаг.

Сүлжээгээр өөр компьютертэй холбогдож байхдаа хоёр компьютер уулзаж, мэндчилэх гэмээр процессыг хийдэг юм. Хүлээн авч байгаа компьютер эхний компьютер руу хандан хэдэн асуулт асууна. Холбогдож байгаа машины нэр нь юу вэ? Түүний нэр надтай холбогдох зөвшөөрөлтэй юу? Тэр компьютерт “итгэх” ямар аргаар би програмчлагдсан вэ? Тэр системээс холболт хийж байгаа нь аюулгүй гэдгийг зөвшөөрөх ямар програмчлал байгаа вэ?

Хүлээн авч байгаа компьютер NIC-ээс хангасан олон мэдээлэл дээр үндэслэн тэдгээр асуултанд хариулна. Энэ бүхэн юуг илэрхийлж байгаа вэ гэвэл та NIC-ийг хяналтандаа авснаар интернет дээр байгаа ямар ч компьютерт “итгэж” болно хэмээн ятгах агаад хакердах компьютерээ эсэргүүцэх чадваргүй болгоно гэсэн үг юм. Компьютерийн хувийн нэр дээр аюулгүй байдал хамаарч байх тул NIC-ийнхэн тэрхүү нэрсийг хамгаалах шаардлагатай байлаа. NIC-ийн охин систем рүү Прайм Саспект нэвтэрч орсны дараа Мендаксэд компьютерт нэвтрэх эрхийг өгчээ. Хоёр хакер NIC рүү довтолгоогоо эхэллээ. Мендакс NIC-ийн руутыг авсны дараа маш их эрх мэдэлтэй болсон мэт санагджээ. Прайм Саспект руутыг өөр аргаар олж чадсан байна. Тэд одоо NIC рүү хаалтгүй нэвтрэх болов.

Хакерууд нэвтрэхдээ хэрэглэсэн аюулгүй байдлын цоорхойг админ зассан үед хожмын өдөр ашиглах арын хаалгыг Мендакс үүсгэжээ. Үүнээс хойш Дата хамгаалалтын сүлжээний мэдээллийн сервер систем рүү орохыг хүсвэл “login 0” гэж шивээд NIC рүү нэвтрэх үл харагдах руут оролттой болох юм.

Энэ алхмыг хийж дууссаны дараа тэрээр уншиж болох сонирхолтой зүйлийг хайлаа. Нэгэн файлд хиймэл дагуул болон богино долгионы тавган антенны уртраг өргөрөг, дамжуулах долгионы үелзлийн жагсаалтыг хадгалсан байв. Энэ бол дэлхийн эргэн тойронд байгаа Батлан хамгаалах газрын компьютерийн мэдээллийн санг ажиллуулахад хэрэглэдэг холбооны төхөөрөмжийн бүрэн зураглалыг харж болох жагсаалт байлаа. Түүнчлэн Мендакс MILNET-ийн компьютерүүдэд тохиолдсон аюулгүй байдалтай холбоотой алдаануудын илтгэлийг цуглуулдаг MILNET-ийн аюулгүй байдлыг зохицуулах төвийн системд нэвтэрчээ. Эдгээр компьютерүүд нь аюулгүй байдлын сайн автомат програмуудыг агуулсан бөгөөд дэлхийн топ 20-д багтах DEC-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн юм. Жирийн бус бүх тохиолдлууд аюулгүй байдлын автомат илтгэлийг хийх үндэс болно. Хэн нэг нь компьютер дээр login хийхээр удаан хугацаагаар оролджээ. Login хийх олон оролдлого хийснээс үзвэл пассвордыг таах гэж үзсэн бололтой. Хоёр хүн нэг эккаунт руу нэгэн зэрэг лог хийсэн аж. Хамгаалалтын дохиолол ажиллаж, MILNET-ийн аюулгүй байдлын төв рүү гадны халдлага үйлдэгдэж байгаа тухай илтгэлийг сүлжээний компьютерүүд шууд илгээнэ. Эдгээр мэдээлэл нь “халуун жагсаалт”

хэмээн нэрлэгдэх файлд хадгалагдана. Мендакс өөрийн дэлгэц дээр MILNET-ийн аюулгүй байдлыг илтгэлүүдийг нэг бүрчлэн уншжээ. Ихэнх мэдээлэл онц содон зүйл харуулахгүй байв. MILNET-ийн хэрэглэгчид санамсаргүй аюулгүй байдлын хүрээнээс гарсан болон Герман дахь АНУ-ын цэргийн баазаас нэг анхааруулга ирсэн мэдээлэл байлаа. Энэ мэдээлэл компьютерээр үүсгэгдээгүй ажээ. Уг мэдээллийг хүн үүсгэсэн нь илт байв. Системийн админы компьютерт гадны этгээд нэвтрэхийг оролдсон тухай олон дахин мэдэгджээ. Тэр этгээд яаж ийгээд компьютерт нэвтэрсэн аж. Харин админ тэр этгээдийн хаанаас холбогдоод байгааг олж тогтоохыг оролдсон боловч амжилтгүй болжээ. Гайхалтай нь MILNET-ийн өөр нэгэн системээс довтлогоог хийсэн байв. Мендакс MILNET-ийн сүлжээний дотроос нь халдлага хийгдсэн болохыг нотолсон цахим шууданг өөр нэгэн файлаас олжээ. Шууданг уншсан Мендакс маш их гайхав. АНУ-ын цэргийн хакерууд MILNET-ийн систем рүү нэвтрэх дадлагыг хийсэн гэдгийг системийн админд мэдээлсэн байна. Мендакс үүнд итгэсэнгүй. АНУ-ын цэргийнхэн өөрсдийн компьютерийг хакердаж л байдаг?!

Үүнийг уншсан Мендакс: “Хэрвээ АНУ-ын цэргийн хакерууд дадлага хийхдээ өөрсдийн компьютерийг хакердаж байгаа юм чинь бусад орны компьютерүүд рүү хакердаж болох уу?” гэж боджээ. Тэрээр системээс чимээгүйхэн ул мөрөө баллаж гарахдаа уншсан зүйл санаанаас гарч өгөхгүй байв. АНУ-ын цэргийнхний төлөө ямар ч хакер ажиллаж болно шүү дээ. Гэхдээ тэр хакер зоригт шонхор бус харин анархист байх ёстой гэж тэр боджээ.

1991 оны 10-р сарын эхээр NMELN1-ийн экаунтын мэдээлэл, dial up дугаарыг Мендакс Тракс өгөв. Тракс сайн хакер байгаагүй ч фрейкинг хийх чадварыг нь Мендакс үнэлдэг байсан юм. Тракс бол Австралийн фреакингийн загалмайлсан эцэг бөгөөд фреакинг хийх урлагийг хөгжүүлсэн домогт хүн гэж үздэг. NoreTel-ийн сүлжээн дотор телефон утасны свитчүүдийг хэрхэн хянах тухай дэлгэрэнгүй мэдээллийг Тракс олж магадгүй гэж Мендакс боджээ.

Олон давтамжтай кодыг фреакердэх аргыг Тракс зохиосон юм. Түүний компьютерийн програмаар үүсгэсэн тусгай дуут чимээг утасны шугмаар илгээснээр телефон утасны холболтын байгууламж дахь тодорхой үйл ажиллагааг удирдаж болдог байна. Утасны кард болон хэн нэгний утасны төлбөр рүү ярианыхаа төлбөрийг шингээж үнэгүй ярих аргыг олон хакерууд сурсан юм. Харин Тракс хэнд ч төлбөрийг шингээхгүйгээр утсаар ярих аргыг нээсэн гэдэг. Түүний хийсэн утасны дуудлага үнэгүйгээс гадна мөрдөн мөшгих аргагүй байв.

Тракс өөрийн нээлтийг 48 хуудас ном болгон Австралийн фреакеруудын гарын авлага, нэгдүгээр боть гэж нэрлэжээ. Гарын авлагад олон шинж, зүйлийг нэмсний дараа хакеруудын гарт энэ ном орвол юу болох бол гэхээс сэтгэл зовниж эхлэв. Тиймээс энэхүү номоо Олон улсын босогчид бүлгийн хоёр хакераас өөр хүнд өгөөгүй ажээ.

Мендаксийн эрхлэн гаргадаг хакеруудын сэтгүүл болох “Олон улсын босогчид” дээр Фреакеруудын гарын авлага-2 номонд дурьдсан мэдээллийг гаргаж эхлэв. Олон улсын босогчид цахим сэтгүүлийн жирийн бодлогыг баримтална. Өөрөөр хэлбэл хэрэв чи нийтлэл бичвэл сэтгүүлийн хувийг олж авч чадна гэсэн үг. Энэ бол санамсаргүй цагдаа нарын анхаарлыг татаж болох туршлагагүй, мэдлэг дутуу хакеруудын гарт энэ сэтгүүл орохгүй байлгах сайн бодлого байлаа. Телефон утасны компаниудын сүлжээн дэхь аюулгүй байдлын цоорхойг бөглөхөд хүргэх алдааг туршлагагүй хакерууд гаргаж болох юм. Үүний улмаас

сэтгүүл гуравхан хүний гараар дамждаг байв.

Хакерын тухай ойлголтгүй хүнд энэ сэтгүүл утасны лавлах шиг л харагдана. Харин хакеруудын ертөнцөд бол үнэт эрдэнэ мэт санагдаж байлаа. Сайн хакер хүн модемны утасны дугаарууд, пассвордуудын мөрийг дагаж болох бөгөөд компьютерийн хориотой сүлжээний түнээлд байгаа нууц хаалгаар орж алга болно. Сэтгүүлээр зэвсэглэсэн хүн бэрхшээлтэй орчинг амжилттай давж, системийн админыг хууран, компьютер бүрийн нууц эрдэнэсийг олно. Тэдний хакердах ажиллагааны суурь болгон хэрэглэдэг Их сургуулийн модемоос үлдэх ул мөрөнд Прайм Саспект болон Мендакс санаа зовох боловч Траксийн ур чадвар хамтран зүтгэгчдийн сэтгэлийг тайтгаруулах ажээ.

Тракс өөрийн агуу нээлтийг санамсаргүй хийсэн юм. Модемнуудыг хайж олон тооны утасны дугаарууд руу автоматаар залгадаг компьютерийн жирийн програм болох утасны спринтерийг тэр хэрэглэж байлаа. Түүний компьютер үхмэл эсвэл огт байхгүй дугаар руу залгах үед модемныхоо дууг чангалахад холбоог салгасан тухай мессэж ирсний дараа сулхан клик хийх чимээг зарим үед сонсдог байв. Тэр дуу чимээ зүрхний сулхан цохилтыг санагдуулна. Тэдгээр хачин дугаарууд дээр туршилт хийснээр салгасан шугамнуудын дуу болохыг удалгүй нээсэн юм. Хачин дугааруудыг хэрхэн хэрэглэх талаар тэр бодож байв. Британий Чөтгөрийн тоглоомын газар нэртэй BBS дээр upload хийсэн материалыг Мендакс олж түүнд өгчээ. Уг материалыг уншсан Тракт нэгэн санаа төрөв. Тэнд ССИТТ #5 сигналын дуу чимээний тухай мэдээлэл тавьсан байв. ССИТТ бол улс хоорондын телефон шугмын байгууламжын хэл буюу олон улсын стандарт юм. Та Австралиас АНУ руу олон улсын ярианы дуудлага хийхэд яриа орон нутгийн телефон сүлжээний байгууламжаас Австрали улсын доторх олон улсын гарцны телефон байгууламжид дамждаг. Тэндээсээ АНУ дахь байгууламж руу аялна. ССИТТ сигналийн дуу чимээ нь бие биетэйгээ холбогдоход хэрэглэдэг олон улсын хоёр гарцны тусгай дуу билээ.

Дотоодын телефон ярианы хэрэгцээнд R2 гэж нэрлэх, энэ стандартийн сүүлчийн хувилбарыг Австралийн Telecom компани хэрэглэдэг. Telecom компани энэхүү шинэ стандартыг MFC (multi frequency code) буюу олон давтамжит код гэдэг. Товчоор хэлбэл Тракс Мендакс руу утасдах үед түүний телефон холбооны байгууламж Мендаксийн утас руу тэдгээр дуу авиаг хэрэглэн ярьж болох уу хэмээн асууна. Мендаксийн телефон холбооны байгууламж хариуд нь Мендаксийн утас завгүй эсвэл салсан байна хэмээн хариулж магадгүй. Telecom-ийнхон жирийн телефон утасны дарах товчлуурт байдаггүй дууны давтамжуудын хослолуудыг хэрэглэнэ. Тиймээс тагэр ахуйд хэрэглэдэг телефон утасны товчлуур дээр зүгээр л нэг дарахад ийм дуу чимээ гарахгүй юм.

Тракс өөрийн “Amstrad” компьютерээр тийм тусгай дуу чимээ гаргах програмыг бичиж, утасны шугамаар илгээнэ. Тэрээр дуу чимээ бүр чухам юуг илэрхийлж байгааг багцаалах болжээ. Телефон холбооны хоёр байгууламжийн хоорондох “ярианы” түвшин бүрт нилээд хэдэн зүйлийг нэг дуу чимээгээр илэрхийлдэг тул энэ амархан даалгавар байгаагүй юм. Тракс Telecom-ын хогийн савыг ухаж хамгийн чухал эрдэнэс болох MFC бүртгэлийн жагсаалтыг олжээ. Хилийн чанад дахь фреакингийн файлуудын хажуугаар MFC бүртгэлийн жагсаалтыг ашиглан Австралийн телефон холбооны байгууламжийн хэлийг Тракс идэвхтэй судалж эхлэв. Дараа нь тэр сурсан хэлээ өөрийнхөө компьютерт заасан гэж болох юм.

Тракс “зүрхний цохилт” шиг дуу чимээ гаргах утасны дугаарууд руу дахин залгахыг оролдов. Тэр өөрийн компьютерээр үүсгэсэн дуу чимээг өсгөгчөөр дамжуулан чанга болгож, янз бүрээр тогложээ. Энгийнээр тайлбарлавал Тракс бусад телефон утасны байгууламжийг орон нутгийн Telcom компанийн телефон утасны зангилаа гэж андууртал хуурах боломжтой болов. Одоо өөрийн утас болон салгасан дугаарын хооронд Тракс хаашаа ч утасдах боломжтой боллоо. Жишээлбэл түүнийг Мелбурнийн Их сургуулийн модем руу утасдах үед шугамыг хянаж байвал түүний гэрийн утасны дугаар хяналтын бичлэг дээр гарахгүй болжээ. Утасны системд Траксын дуудлагууд сүнс мэт орших учраас энэ дуудлагад ямар нэгэн төлбөр гарахгүй.

Телефон утасны байгууламж болон телефоны хооронд зальдах аргыг Тракс улам боловсронгуй болгов. Тэр өөрийн телефон утасны аппаратыг тоолж баршгүй олон удаа хэсэг хэсгээр нь салгаж, хэрхэн ажиллахыг ойлгох хүртлээ оролджээ. Хэдэн сарын дотор тэрэр үнэгүй дуудлага хийхээс ч илүү зүйлийг хийх боломжтой боллоо. Жишээлбэл утасны шугамыг ялгаж, тодорхой нэгэн өөр утасны дугаараас уг дуудлага хийгдэж байна гэж ойлгуулах чадвартай болсон юм.

Утасны шугам танигчийг илгээх Траксын аргыг Мендакс тэр хоёр ашиглан гарсан төлбөрийг нэгэн онцгой дугаар дээр шингээж байв. Тэр бол Мелбурн хот дахь Австралийн Холбооны цагдаагийн газрын Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн утасны дугаар байлаа. Олон улсын босочид бүлгийн хакерууд Австралийн Холбооны цагдаагийн газар тэдний мөрөөр орсныг мэдэж байв. Австралийн интернетийг ажиллуулдаг Жеоф Хастоны эзэмшлийн Канберрад байрлалтай компьютерийн системээр хэсэж байхдаа цагдаа болон Австралийн Академийн судалгаа, шинжилгээний сүлжээний (AARNET) хамтын ажиллагааны үр дүнд хакеруудыг мөшгих ажилд нилээд ахиц гарсныг мэдэв.

Деакиний Их сургуулийн Крейг Варренаас AARNET-ийн техникийн менежер Хастонд илгээсэн цахим шууданд Их сургуулийн системд хакерууд довтолж байгаа тухай дурьджээ. Хастон цахим шууданг цааш AARNET-ийн хэвийн ажиллагааг хангахад Хастонд тусладаг Петер Элфорд руу илгээв. Хакерууд Хастоны компьютер руу нэвтэрч захиаг уншжээ. Үүнд:

Хэнээс G.Huston@aarnet.edu.au Даваа гариг, 9-р сарын 23 09:40:43 1991

Хүлээн авсан: from by jatz.aarnet.au with SMTP id

AA00265 (5.65+/IDA-1.3.5 for pte900); Даваа гариг 9-р сарын 23 91 он 09:40:39 +1000

Өдөр: Даваа гариг 1991 оны 9-р сарын 23 09:40:39 +1000

Message-ID: <9109222340. AA00265@jatz.aarnet.edu.au

To: pte900@aarnet.edu.au

Хэнээс: G.Huston@aarnet.edu.au

Сэдэв: Re: Пүрэв гаригийн шөнөөс Баасан гаргийн өглөө хүртэлх хугацаанд Зочилсон

хүмүүсийн лог

Статус: RO

Өдөр: Ням гариг. 1991 оны 9-р сарын 22 19:23:13 +1000

>Хэнээс: Craig Warren <C.Warren @deakin.OZ.AU>

>Хамгийн сүүлд бидний ярилцсанаас хойш юу болсон талаар товч мэдээлэхийг хүсэв...

>Өнгөрсөн долоо хоногт Холбооны цагдаагийн газрын түрүүч Кен Дейтэй бид уулзлаа. Варрнамбуулээс ирсэн манай түншийн хамт утасны шугамыг шалгаж үзэхэд Austrac-ийн capella.cc.deakin.OZ.AU терминал серверийн шугамууд болохыг тогтоов. Энэ бол нээлттэй үлдээсэн шугам юм.

>Баасан гаргийн үдээс хойш Варрнамбуул дэхь телефон утасны эзэн рүү буцааж дуудлага хийх боломж олдов. Цагдаагийнхан тэр хүний нэрийг мэдэж байгаа. Өөр хүмүүс энэ хэрэгт холбоотой гэдэгт би итгэлтэй байна. Гурван хүн тодорхой нэг цаг хугацаанд идэвхитэй байгааг бид мэдсэн. RMIT-ийн оюутнууд эсвэл Деакиний Их сургуулийн оюутнууд хэрэгт холбоотой гэж сэжиглэж байна.

> Баасан гаргийн шөнө хакеруудыг мөрдөх идэвхтэй ажиллагаа явуулж байсан. Одоо цагдаа болон Telecom-ын ажилтнууд бас нэгэн номерийн араас хайлт, мөшгилт хийж байна.

>Маргааш өглөө би мөрдөн байцаах ажиллагаанд оролцож байгаа бүх хүмүүстэй уулзаж ярилцана. Бидэнд одоогоор гэмт хэрэг үйлдсэн байж болох хамгийн багадаа 2-3 хүний нэрс байна. Бид одоохондоо тэдгээр хүмүүсийг мөрдөхөд нь цагдаа нарт туслахын тулд AARNET рүү “capella”-аас хийх оролтыг хааж чадна.

> Хакеруудын дайралтанд өртсөн цорын ганц хүн нь та биш гэдгийг мэдээд баярлах буй заа. () Виктория дахь хоёр өөр сайтыг хүмүүс довтолж байгаа гэдгийг би мэдэж байгаа билээ. Тэдний нэг нь Telecom өөрөө!

> Маргааш би танд юу болсныг дахин мэдээлнэ. Хүндэтгэсэн Крейг” гэжээ.

Хакерууд гээд байгаа хүмүүс нь мэдээж манай “Олон улсын босогч” бүлгийн хакерууд. Хэн нэгний цахим шуудангаас өөрсдийн хакердсан паянгаа уншаад сууж байх тохиолдол тэр бүр олдохгүй юм.

Аюулгүй байдалтай холбоотой цахим шууданг уншихаар Мендакс, Прайм Саспект нар ANU-ийн компьютерт тогтмол нэвтэрнэ. Их сургуулиудын системийг хакердахын өмнөх гараа болгож ашигладаг. Гэвч Олон улсын босогчид бүлгийн хакеруудад Австралийн Холбооны цагдаагийн газар нилээд ойртсоныг мэдэж болох мэдээллийн сайн эх сурвалж байсан юм.

Мендаксын сонирхлыг хамгийн ихээр татсан зүйл бол Telecom-ын телефон утасны байгууламж руу довтолсон анхны дайралт байв. Прайм Саспектын олсон модемны дугаараар Мелбурн хотын төвд байрлах Telecom компаний Лонсдейл дэхь телефон утасны байгууламж

руу залгажээ. Түүний модем бас нэгэн модемтой холбогдсоны дараа компьютерийн дэлгэц юу ч гараагүй байна. Тэрээр системийг ойлгоход туслаж болох хэдэн үндсэн командыг өгөх гэж оролдов.

Login, list, Attach.

Байгууламжийн компьютер чимээгүй л байсаар.

Компьютерийн гарны танигдсан бүх тэмдэглэгээ бүрийг устгах програмыг Мендакс нөгөө компьютер дээр ажиллуулав. Бас л өөрчлөлт ажиглагдсангүй. Дараа нь тэр Amiga товчлуурыг ба В үсгэн дээр нэг зэрэг дарж сигналыг эвдэхийг оролдлоо. Тэр нэг алхам урагшилжээ. Хариу өгөхгүй байсан дэлгэц амьсгалж эхэлжээ. Тэрээр 200 нийтлэг командыг өгдөг өөрийн бас нэгэн хакерын програмыг ажиллуулав. Бас л хариу алга. Эцэст нь “logout” гэж Мендакс шивлээ. Гэтэл: “error, not logged on” буюу алдаа, лог хийгдээгүй байна гэсэн бичиг гарч ирэв.

Аан, команд нь “login ” биш “logon” юм байна гэж Мендакс боджээ.

:logon

Telecom-ийн сүлжээний байгууламжаас “username” хэмээн асуулаа. Одоо хэрэглэгчийн нэр, паролыг л олох шаардлага Мендаксд тулгарчээ.

Telecom компани NorTel-ийн төхөөрөмжийг ашигладаг гэж тэр мэдэж байв. Мэдээж NorTel-ийн ажилтнууд Telecom компаний ажиллагсдад сургалт зохион явуулсан учраас шаардлага гарвал сүлжээнд өөрсдөө нэвтрэх access шаардлагатай болж таарна. Олон өөр утасны свитч дээр ажиллаж байгаа NorTel-ийн ажилтнуудад бүх цаг хугацааны туршид аюулгүй паролд хэрэглэхэд хэцүү юм. NorTel болон Telecom компаниудын ажилтнууд мэдээж амархан, нийтлэг хэрэглэх паролыг сонгох биз. Ийм тодорхойлолтонд таарах ямар парол байж болох вэ?

Username: nortel

Password: nortel

Таалт амжилттай боллоо!

Гэхдээ компьютер рүү нэвтрээд ямар командуудыг хэрэглэхээ Мендакс мэдэхгүй байлаа. Тэгээд ч онлайн туслалцаа үзүүлдэг гарын авлага, бичиг баримт гэхээр зүйл алга. Телефоны свитч түүний урьд өмнө мэдэж сонсоогүй өөрийн хэлтэй байлаа. Ингээд олон цаг судалсны эцэст телефон сүлжээний байгууламжийн компьютер дээр ажиллаж болох командуудын жагсаалтыг Мендакс гаргав. Тухайн байгууламж Онгоцны тийзийн захиалга, пицца хүргэлт зэрэг үйлчилгээнд ашигладаг 13-аар эхэлсэн зургаан оронтой утасны бүх дугаарыг хянадаг аж. Энэ бол Telecom-ын “Ухаалаг сүлжээ” буюу утасны дуудлага чиглэсэн байгууллагын хамгийн ойрын салбар руу холбох зэрэг олон тусгай даалгаврыг биелүүлдэг зангилаа байв. Мендакс командуудын жагсаалтыг харж байгаад “RANGE” гэсэн командыг оллоо. Энэ бол тодорхой хүрээний нутаг дэвсгэр дотор бүх утасны дугаарыг сонгох боломжийг хэн нэгэнд

олгодог команд байв. Тэрээр 634-өөр эхэлсэн мянган дугаарыг сонгожээ. 634-ээр эхэлсэн дугаарууд бол Telesom-ын Куийн гудамжны оффисууд гэж Мендакс мэдэх ажээ.

Одоо командыг шалгах цаг боллоо. Мендакс 1000 шугаманд ямар нэгэн гэмтэл учруулахгүй командыг туршихыг хүсэж байв. Энэ үед өглөөний 7 цаг болж, Telesom-ын ажилтнууд оффис дээрээ ирэх дөхжээ. Түүний сонгосон “RING” команд хор аюул багатай мэт санагдав. Энэ командын хэрэглэж тодорхой хүрээний дотор байгаа дугаарууд руу нэг нэгээр нь залгах бөгөөд уг процессыг удирдаж болох ажээ. Тэрээр командыг шивлээ. Юу ч болсонгүй. Хэсэг хугацаа өнгөрсний дараа түүний дэлгэц дээр аажуухан дараах зүйлс тодорч ирэв.

.....

RUNG (хонхыг дуугаргалаа)

Систем 1000 утасны дугаар руу зэрэг залгаж хонхыг дуугаргажээ. Мянган утас нэг зэрэг дуугарсан гээд боддоо!

Telesom компаний инженер өглөө эрт ирээд сууж байсан бол яах бол? Тэнгэр тулсан байшинд байгаа бүх утаснууд нэгэн зэрэг дуугарвал яах бол? Ямар сэжиг төрүүлэх вэ? Мендакс хакердах ажиллагаагаа даруй зогсоохоор шийдэв. Сүлжээнээс гарч байхдаа орж ирсэн модемны шугамны логуудыг алга хийлээ. Үнэндээ бол dial up шугамыг хэрэглэсэн гэж хэн ч мэдэхгүй байх гэдэгт тэр итгэж байсан юм.

NorTel-ийн компьютерийн системийг нээж байхдаа ямар нэгэн буруу зүйл хийсэн гэж Прайм Саспект огт бодоогүй байв. Систем рүү хууль бусаар нэвтэрч байна гэсэн үгс login хийсэн дэлгэц дээр гарах боловч 18 настай хүү өөрийгөө халдан довтлогч гэж төсөөлсөнгүй. “Халдан довтлогч” гэдэг бол системд хор хөнөөл учруулах үйлдэл хийж байгаа хүн гэж Прайм Саспект үзэж байв. Тэр ч ийм бодол санаа агуулаагүй байлаа. Өөрийгөө тэр зүгээр л нэг зочин гэж тооцно.

Прайм Саспектийн өгсөн эккаунтаар NMELH1 систем рүү Мендакс нэвтэрч онлайн дээр хэн байна гэдгийг юуны өмнө харлаа. Прайм Саспект ба бусад есөн хүн байсны зөвхөн гурав нь идэвхитэй ажиллаж байв.

Прайм Саспект, Мендакс хоёр системийн руутыг олж авахын төлөө шунган орлоо. Олон улсын босогчид бүлгийнхэн бол хакерын ертөнцөд өөрсдийн байгуулсан гавьяагаар бардамнах хүүхдүүд биш боловч системийг хэн эхэлж хяналтандаа авахын төлөө хааяа өрсөлдөж хүчээ сорих ажээ. Тэд зөвхөн нөхөрсөг өрсөлдөөнийг л илүүд үзнэ.

Пассвордын файлыг агуулдаг руут директорид Мендакс оров. Нилээд хамгаалалт сайтай систем дээр давуу эрх байхгүй хэрэглэгчид руут директор руу орох боломжгүй. Харин энэ системд тэр тал нь нээлттэй байв. Энэ сайтан дээр байгаа директор буюу файлуудыг хадгалж байгаа ой санамжнаас юуг ч хуулбарлан авах, дэд директоруудын нэрсийг өөрчлөх боломжтой байжээ. Эдгээр үйлдлийг хийх зөвшөөрөл хамгийн чухал бөгөөд троян вирусийг үүсгэх боломжийг Мендаксад өгнө. Трояны хаант улсыг унагахад гол үүрэг гүйцэтгэсэн

Троян мориор нэрлэгдсэн энэ арга бол ихэнх хакеруудын дуртай аргад тооцогдоно. Трояны директори нь хакерын хүсэж байсан аргаар компьютерийг хуурах мэдээллийг агуулдаг юм. Үүнээс гадна Троян вирус нь хэрэглэгчийн нэр болон пассворд мэтийн үнэт мэдээллийг хууль ёсны хэрэглэгчээс хууран авах боломжийг олгоно.

Пассвордын файлууд хадгалагдах оригиналь буюу хууль ёсны “ЕТС”-ийн директори дотор байгаа зүйлийг Мендакс шинэ директори үүсгэн хуулбарлав. Пассвордуудыг энкриптэлсэн учир унших боломжгүй байлаа. Пассвордуудыг харах гэж хий хоосон цаг гарздахын оронд Мендакс байнгын хэрэглэгч Жое гэдэг хүний пассвордыг устгажээ. Одоо пассворд байхгүй учраас Мендакс ямар асуудал байхгүйгээр Жое хэмээн login хийх боломжтой болно. Хэдийгээр Жое энгийн хэрэглэгч байсан тул Мендаксын хүсэж байгаа руут байхгүй юм. Гэхдээ системийн бусад хэрэглэгчийн адил Жое хэрэглэгчийн таних дугаартай байдаг. Мендакс Жоегийн хэрэглэгчийн таних дугаарыг шидэт тоо болох “0”-ээр солив. “0” хэрэглэгчийн таних дугаартай хэрэглэгч бол рууттай байдаг. Одоо Жое гэдэг хэрэглэгч ихэвчлэн системийн администраторуудад өгдөг хүч чадлыг олж авлаа. Мэдээж аль хэдийнээ рууттай хэрэглэгчийг Мендакс хайж болох хэдий ч dial up шугамаар login хийсэн руут аксестай бас нэгэн оператор онлайн дээр байвал системтэй холбоотой байгаа админ шууд илрүүлэх байв. Юуны өмнө систем дээр ямар нэгэн сэжигтэй үйлдэл хийж бусдын анхаарлыг татахгүй байх нь хамгийн сайн хамгаалатын арга юм.

Одоо хууль ёсны ЕТС директорийг Трояны директороор солих асуудал үлдлээ. Хууль ёсны ЕТС директорийг устгах эрх Мендаксд байхгүй. Гэвч тэр директорийн нэрийг өөрчилж болно. Тиймээс компьютерийн систем танихгүй ямар нэгэн нэрээр ЕТС директорийн нэрийг солих шаардлагатай. Хэрэглэгчийн жагсаалт руу орох боломжгүй болсон компьютер ихэнх үйлдлээ хийж чадахгүй, тасалдана. Хүмүүс login хийх боломжгүй, хэн систем дээр байгааг мэдэхгүй, цахим шуудан илгээж чадахгүй болно. Мендакс маш хурдан ажиллах хэрэгтэй байлаа. Систем маш хүнд асуудалтай тулгарсныг хэн нэгэн хүн хэдхэн минутын дотор л ажиглачихна.

Мендакс өөрийн үүсгэсэн Троян директорийг ЕТС гэж дахин нэрлэв. Систем хуурамч директорийг шууд л уншиж “Жое” гэсэн хэрэглэгчийн пассворд огт байгаагүй мэт боллоо. Түүний статус нь супер хэрэглэгчийн түвшинд хүрчээ. Энэ удаад Мендакс “Жое” гэсэн нэрээр дахин лог хийв.

Тав минутаас бага хугацааны дотор олигтой боловсрол эзэмшээгүй хорин настай залуу өөрийн хурд багатай модем, 700 долларын үнэтэй компьютерээ ашиглан дэлхийн томоохон харилцаа холбооны компаниудын Мелбурн дахь компьютерийн системийг булаан эзлэж чадав.

Тэнд баллах ёстой хэдэн ул мөр байлаа. Дараагийн удаа “Жое” компьютертээ login хийнгүүт пассворд асуухгүй байвал ихэд гайхах болно. Тэгээд ч түүний статус супер хэрэглэгч болон хувирсныг үзээд итгэж ядах биз. Тиймээс Мендакс супер статусаа ашиглан Троян ЕТС файлыг устгаж, бүх зүйлийг анхны байдалд нь буцаалаа. Түүнчлэн “Жое” гэсэн хэрэглэгчийн нэрээр login хийсэн ул мөрөө бүрэн арчив.

Тэрээр дахин супер хэрэглэгчийн эрхтэйгээр “login” хийхийн тулд түүнд автоматаар руут

аксес хийхэд туслах тусгай програмыг Мендакс суулгажээ. Системийн далдхэсэгт уг програмыг нууж, товчлуурын нууц хувилбараар идэвхждэг функцийг нэмж өөрийн аюулгүй байдлаа хангав.

Мендакс “NMELH1” системийн руут экаунтыг эхэлж нээх үед Прайм Саспект түүнээс нэг их хол хаягдаагүй ажээ. Удалгүй тэдний эгнээнд Тракс нэгдэв. Тэд системийг шинжиж байхдаа олсон зүйлд итгэж ядаж байв. Хэзээ ч тааралдаж байгаагүй сонин бүтэцтэй системтэй тэд учирчээ.

Ихэнх томоохон сүлжээнүүд шаталсан бүтэцтэй байдаг. Цаашлаад үзвэл сүлжээнд нь гадаад сүлжээнд ойр урсгалтай бусад системийн олон хаягуудыг багтаажээ.

Харин NorTel-ийн сүлжээ ийм бүтэцгүй байсан юм. Хакерууд шаталсан түвшний бүтэцгүй сүлжээг олжээ. Уг сүлжээ бусад талаараа ч бас онцлог аж. Сүлжээн дээр байгаа компьютер бүр бусад бүх компьютерийн хаягийг өөртөө агуулж байв. NorTel-ийн дэлхийг хамарсан сүлжээнд 11000-аас илүү тооны компьютерүүд байлаа. Хакерууд яг гамбир шиг хавтгай тархсан бүтэцтэй, агуу том дотоод интернетийн сүлжээтэй адилхан зүйлийг харжээ.

Хавтгай тархсан бүтэцтэй системийг Мендакс олон удаа харсан боловч ийм их хэмжээгээр хэзээ ч харж байгаагүй гэнэ. Маш сонирхолтой байлаа. Шаталсан бүтэцтэй компьютерийн систем дээр хамгийн чухал компьютер болон мэдээлэл нь хаана байгааг төвөггүй олж болно. Харин ийм систем дээр бүх компьютерүүд ижилсэж, адилхан үүрэг функцтэй мэт харагдах агаад сүлжээгээр хакерууд саадгүй аялахад маш хэцүү билээ. Уг системийн хаана нь “Зул сарын баярт урьсан” хүмүүсийн жагсаалт эсвэл NorTel-ийн шинжийг илэрхийлэх бүтээгдэхүүний нууц дизайн хадгалагдаж байгааг хэн хэлж чадах вэ?

NorTel компаний сүлжээ “firewall”-оор хамгаалагдсан учир гадаад ертөнцөөс бараг оролт байхгүй гэж хэлж болно. Энэ нь dial up-аар залгагдаж хакердаж байгаа хүмүүст бүр хүндрэлтэй болно гэж Мендакс үзжээ. Интернетээр дамжин довтолгоо хийх боломжгүй болгосон учраас NorTel-ийн сүлжээний аюулгүй байдал харьцангуй тайван болсон юм. Арын хаалгаар чимээгүйхэн гулсан орж ирсэн хакерууд NorTel-ийн бүх сайтууд руу довтлох боломжтойг олж мэдэв. Тэд Мелбурн хотын Килда роуд дахь гудамжнаас Торонто хот дахь корпорацийн төв байр хүртэлх газруудыг хакердаж болох ажээ.

Компьютерийн олон сайттай, найдвартай гэгдэх аварга сүлжээг хурууны үзүүрээр хакердсан залуучууд шинэ нээлт хийхийг эрэлхийлж, баяр хөөрөөр дүүрэн байв. Сэтгэл нь хөөрсөн тэр гурвын нэг нь: “Далайн шуурганд сөнөсөн усан онгоцноос амьд үлдсэн нэгэн эр 11000 онгон эмстэй Тахитийн арлын эрэг ухаан орсон” мэт байлаа гэж хэлжээ.

Тэд yellow pages (шар хуудас гэсэн утгатай) буюу 400 компьютер сайтуудтай холбогдсон дата баазыг (мэдээллийн сан) олов. Тэдгээр 400 сайтууд бол Шар Хуудас дата бааз дахь пассвордуудын файлуудаас хамааралтай байлаа. Шар Хуудас дата баазын руутыг Мендакс олж чадсанаар 400 компьютерийн системийн хяналтыг эгшин зуур гартаа орууллаа. Маш том амжилт!

NorTel-ийн компьютерийн аюулгүй байдал хариуцсан администраторын мэдэлд байгаа нэг

системийг Мендакс илрүүлэн, шууд л цахим шуудангийн хайрцгыг шалгав. Цахим шууданг шалгаад тэр маш их инээжээ.

Нэгэн захидалд NorTel-ийн өргөн зурвас газрын сүлжээ “CORWAN” руу Австралийн Telecom компани оролттой болохыг хүссэн тухай дурьджээ. Уг оролтыг хийхэд “CORWAN” руу Telecom-ийн жижигхэн сүлжээг холбох аж. NorTel болон Telecom компаниуд харилцан ажиллагаатай бизнес эрхэлж байсан тул биелэх боломжтой хүсэлт байлаа. Тэдний ажилтнууд бүхий л цаг хугацаанд холбоотой ажиллаж байснаас үүнийг мэдэрч болох юм. Гэвч Telecom-ийн сүлжээнд хакерууд маш ихээр ордог учир Канадын компаний аюулгүй байдлыг хариуцсан админ тэдний тавьсан хүсэлтийг нь татгалзсан байна.

Telecom-д олон хакерууд байдаг аа? Одоо харин хөгжилтэй санагдаж байх чинь... NorTel-ийн компьютерийн аюулгүй байдлын мэргэжилтэн Telecom-ийн сүлжээг олны хөлөнд талхилагдсан гэж үзсэн тухай нууц цахим шууданг нь хакер уншаад сууж байдаг. Үнэндээ бол Мендакс “Telecom”-ийн систем рүү “NorTel”-ийн “CORWAN”-аар дамжин нэвтэрсэн бөгөөд харин ч бүр эсрэгээр харагдаж байгаа юм.

Магадгүй үүнийг нотлох гэсэн мэт “NorTel” компаний системийн пассвордыг хакердахыг Мендакс шийдсэн байж болох. “NorTel”-ийн сайтуудаас тэрээр 1003 пассвордыг цуглуулж, өөрийн зохиосон “TNC” пассворд хакердах програмыг сугалан түүний төлөө ажил хийчих нөөц компьютер хайн сүлжээгээр ан хийв. Тэрээр Канадад байрлаж байгаа 40 Sun компьютерүүдийн багцыг олж тогтоон өөрийн програмыг тэдэнд суулгажээ. “Sun4” гэсэн тэдгээр компьютерүүд дээр “TNC” програм маш сайн ажиллаж байлаа. Криптограф болон пассворд хакердах талаар диссертац бичсэн гэх АНУ-ын нэгэн албан хаагчаас зээлж авсан 60,000 үгийн толийг энэхүү програм ашиглаж байв. Түүнчлэн энэ програмд Куинсландийн Их сургуулийн эрдэмтэн Эрик Яангийн боловсруулсан “хурдан криптийн алгоритм”-ыг хэрэглэжээ.

40-өөд компьютерүүдийг ашиглаж, пассвордын жагсаалтуудаар секундэд 40,000 харьцуулалтыг Мендакс хийж байв. Хоёрийн зэрэг компьютер ачааллаа дийлэхгүй гацсан ч ихэнх нь довтолгооны аясыг сөрөн зогсоор байлаа. Нууц пассвордууд яг л хордсон ялаанууд шиг унана. Хэдэн цагийн дотор Мендакс 5000 пассвордыг хакердсаны 100 орчим нь руут экаунтын пассвордууд байлаа. Одоо тэр дэлхийн бөмбөрцгийн эргэн тойронд байгаа “NorTel”-ийн хэдэн мянган компьютерүүд рүү нэвтрэх гарцтай боллоо.

Эдгээр системүүдээс тэр маш тансаг шагналыг олж үзэв. Том компаний компьютерийн системийг хяналтандаа аваад зогсохгүй компаний удирдлагыг ч гартаа авсан хэрэг билээ. Яг л хашааны хаалганаас эхлээд шалгалтгүй алхсаар аюулгүй байдлын бүх саадыг давсан мэт үйл явдал болжээ. Оффисийн хаалганы ажилтан бүрийн нууц кодыг хүсэж байна уу? Энд байна, онлайн дээр...

Компаний цалингийн мэдээлэл руу орохыг хүсэж байна уу? Хэн хир их цалин авсныг харж болно. Үүнээс гадна өөрийгөө тус компаний албан хаагч болгон нэрсийн жагсаалтанд оруулаад, мөнгө шилжүүлэх цахим аргаар өөртөө хөөрхөн нэмэгдэл илгээчихэж дөнгөнө. Мэдээж таатай байдлыг ашиглан мөнгө хийх өөр арга байсан л даа. Жишээлбэл: тагнуул хийх ч юм уу..

“NorTel”-ийн үйлдвэрлэж байгаа төлөвлөгөөт бүтээгдэхүүний тухай нууц мэдээллийг амархан олзолж бусдад худалдах боломж Мендаксад байлаа. Судалгаа, зохион бүтээх төсөлд жил бүр нэг тэрбум долларыг зарцуулдаг “NorTel” мэтийн компаниудын хувьд шинэ технологийн тухай мэдээлэл алдагдвал ямаршуу хохирол амсахыг төсөөлшгүй. Зөвхөн шинэ бүтээгдэхүүн дээр ч бус тус компаний бизнес стратегийн тухай мэдээллүүд тагнуулын мэдээний ач холбогдлыг агуулна. Удирдах албан тушаалын ажилтнуудын хооронд зөвлөлдсөн дотоод олон шийдвэрийг хакер ядарч зүдрэлгүй авч зах зээл дээр хямдхан үнээр зарчихаж болно. Өрсөлдөгч компани ч иймэрхүү мэдээллийг зэгсэн үнээр худалдаад авчих биз.

Энэ бол муу санаат, орлого хөөсөн хакеруудын хийж чадах наад захын үйлдэл байв. Ихэнх компаниудын бүрэн автоматчилсан ажиллагааг компьютерээр удирдаж, хянана. Програмд жаахан өөрчлөлт оруулахад л бүтээгдэхүүн гардан үйлдвэрлэж байгаа хэдэн сая долларын өртөгтэй робот машинуудыг ажиллахгүй болгож, алдагдалд хүргэх аюултай.

Гэвч Олон улсын босогч бүлгийн хакерууд мэдээлэл хулгайлах, тагнуулын ажиллагаа хийх санаа зорилго байхгүй байв. Санхүүгийн боломж тааруухан оюутны амьдралаар таваргаж яваа тэд хакердаж олсон мэдээллийг худалдах ямар ч сонирхол байгаагүй юм. Тэдний үзэл бодлоор ийм ажиллагаанд ёс зүйг баримталж, шинийг нээх хүсэл тэмүүлэлд голчлон хөтлөгдөх хэрэгтэй ажээ. Тэд хакерууд болохоос бизнесийн салбарын тагнуулчид бус бөгөөд өөрсдийгөө шинийг нээгчид хэмээн үзнэ.

“NorTel”-ийн сүлжээ “firewall”-той ч гэсэн интернеттэй холбоотой нэгэн шугам байв. Системээр дайран гарсан тэр шугамыг “BNRGATE” буюу интернет руу холбогдсон “Bell-Northern Research’s gateway” хэмээн нэрлэдэг. “Bell-Northern” бол “NorTel” компаний охин компани байсан юм. Электроникийн гадаад ертөнцтэй холбогдсон холболт нилээд хязгаарлагдмал боловч сонирхолтой санагдаж байв. Хамгийн гол нь тийшээ хэрхэн нэвтрэх вэ? гэдэг л байна.

Мендакс орох гарц хайж ажлаа эхэллээ. Түүний пассворд эвдэх програм нь энэ системд үр дүнтэй ажиллаж чадахгүй боловч хүчээр пассвордыг эвдэх програм хэрэглэх бүдүүлэг аргаас өөр энгийн арга зам байгаа мэт санагдана.

Заримдаа системийн администраторууд пассвордыг цахим шуудангаар илгээдэг. Ерөнхийдөө цахим шуудангаар пассворд илгээхийг аюулгүй байдалд ноцтой эрсдэл үүсгэнэ гэж үздэг ч “NorTel”-ийн систем интернетээс “firewall”-оор хамгаалагдсан учир админууд хакерын тухай нэг их сэтгэл зовнихгүй байж болох ажээ. Гэхдээ дэлхийн хэдэн тивээр хэрсэн томоохон компаний админ шинэ компаний менежертэй биечлэн уулзаж пассвордоо гардуулах бололцоо байнга тохиолдохгүй. Харин шинэ пассвордыг жирийн шуудангаар явуулбал хичнээн тэсвэртэй менежер ч гэсэн долоо хоног хүлээхгүй гэдэгт эргэлзэхгүй билээ.

“NorTel”-ийн сүлжээнд цахим шуудан хадгалдаг хэсгийг хорь хүртэлх компьютер хуваан эзэмшдэг юм. Ийм бүтэц Мендаксад нилээд их бололцоог олгоно. Тэр цахим шууданг хадгалах хэсэг рүү ороод түлхүүр үгийн хайлтыг бүхэлд нь хийхэд л асуудлыг шийдчихнэ. Компьютерт “BNRGATE” эсвэл “пассворд” гэсэн үгийн хослолоор хайлт хийх команд өгч, “BNRGATE”-ийн систем админий нэрийг хайвал хэрэгтэй мэдээллээ олж болно.

Энэ аргаар олсон пассвордоо ашиглан Мендакс “BNRGATE” руу орж ойр орчныг тандав. Уг эккаунт маш их хязгаарлагдмал эрхээр нэвтрэх зохион байгуулалттай байсан тул системийн руутыг авч чадсангүй. Жишээлбэл “NorTel”-ийн сүлжээний гаднаас жирийн аргаар “FTP” файлуудыг ажиллуулж болохгүй байлаа.

Интернет хэрэглэгчдийн дунд FTP (file transfer protocol-файл дамжуулах протокол) бол нэр үг ба үйл үг дамжуулдагтай адилхан зүйл бодох биз. Харин FTP програм бол нэг компьютерийн сайтаас таны өөрийн компьютер руу файлын хуулбарыг тэр чигээр нь татаад авчихдаг юм. Тиймээс “FTP”-г ашиглах үйлдэл хууль бус хэмээн тооцогдохгүй бөгөөд интернет ашиглаж байгаа хэдэн сая хүн энэ үйлдлийг хууль ёсоор хийсээр л байна.

Интернетээс зарим зүйлийг “FTP” дэх зөвшөөрлийг “NorTel”-ийн админ ихэнх хэрэглэгчдэд олгодог болохыг Мендакс ажиглажээ. Гэхдээ “NorTel”-ийн компьютерийн сайт руу хуулбарласан файлыг авахаас урьдчилан сэргийлж хаалт хийсэн аж. Тэр файлуудыг хөл хорих эрх бүхий этгээдийн адил “BNRGATE”-ийн тусгай малын хашаа гэмээр хэсэгт хадгална. Харин системийн админ тэрхүү хашаанд тогтмол ирж, интернетээс сүлжээ рүү нэвтрэхэд хакерууд ашиглаж болох “Троян” эсвэл нуугдмалд вирус байгаа эсэхийг шалгаж магадлана. Гэвч BNRGATE дээрх цөөхөн тооны эккаунтууд л хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байв. Мендакс тэдгээр эккаунтын нэг рүү орж интернетээр аялав.

Гадны хүмүүс интернетээс “BNRGATE”-ээр дамжин “NorTel”-ийн сүлжээнд орох бололцоо хязгаарлагдмал байлаа. Харин “NorTel”-ийн сүлжээнд байгаа хүмүүс телнетээр дамжин интернетэд орж болно.

Хакерууд “BNRGATE”-ээр дамжин “NorTel” руу нууцаар нэвтрэхийг оролдсон нь гарцаагүй юм. Магадгүй хэдэн арав, зуун хакерууд “BNRGATE”-ийн агуу цайз мэт хамгаалалтыг сэтэлж чадаагүй байх. Хакеруудын хувьд “NorTel”-ийн сүлжээ эртний цайз шиг, харин “BNRGATE firewall” дийлдэшгүй тулаан мэт санагдана. Энэхүү “firewall”-аас интернет рүү телнет хийж байгаа Мендаксийн хувьд баярт үйл явдал байв. Тэрээр цайзны хаалгаар чөлөөтэй гарч, хүчирхэг цэргийн хамгаалалтыг өнгөрөөд шуудууг гатлан хот руу орж байгаа мэт байсан юм.

Цайз ч өөрөө цаашдын хакердах ажиллагаанд маш сайн хамгаалалтыг санал болгож байлаа. Хэн түүнийг мөрдөж чадах юм бэ? Эрчилдсэн routing систем дэхь тав зургаан компьютерийг дайран гарч түүнийг дагасан ч гэсэн тулааны талбарыг гэтлэн гарах чадвар байхгүй ажээ. Мендакс “firewall”-ын ард нь алга болох байлаа. Тэрээр 11000 компьютерүүдийн аль нэг дээр байгаа “NorTel”-ийн 60000 ажилтны хэн ч байж болох юм.

Мендакс телнетийг ашиглан интернет рүү орж хэдэн сайтуудыг нээсний нэг нь томоохон компьютер үйлдвэрлэгч “Encore”-ийн систем дэхь төв компьютер байлаа. Мелбурнийн Их сургуульд “Encore”-ийн компьютерүүдийг тэр харж байжээ. Ингэж явахдаа тэрээр Теоремийн цахим шууданг уншсан гэж Пард хэлсэн Америкийн хакер Коррапттай тааралдав.

Коррапт төрөл бүрийн компьютерийн системийн талаарх Мендаксийн өргөн мэдлэгийг шагшин магтаж байсан юм. Австралийн хакер” NorTel”-ийн “firewall”-д дотроос гарч ирснийг мэдээд Коррапт маш их бахархжээ.

Мендакс “NorTel”-ийн сүлжээнээс гарч ирэнгүүт л хакерууд харилцан ярилцдаг байв. Бруклины хар арьст дайчин Мелбурнийн захын цагаан арьст хакертай кибер орон зайд дутагдаж байсан холбоог бий болгожээ. Мендаксийг сайн хакер гэж үнэлсэн учраас Коррапт “Крейг”-ийн эккаунтын пассвордуудыг өгсөн байж болох юм.

1980 оны сүүл 1990 оны эхэн үеийн компьютерийн хакеруудад Крейгийн компьютерийн эккаунт платинум төлбөрийн карт адил өндрөөр үнэлэгдэж байв. Ихэнх хакеруудын гэрт байгаа компьютер гольфийн автомат машины адил үнэтэй байсан бол Крейгийнх компьютерүүд дотроо “Ройлс Ройс” нь байсан билээ. Крейг тухайн үедээ дэлхийн хамгийн хурдан, том компьютертэй байлаа. Жирийн компьютер дээр тооцоолоход их хугацаа зарцуулдаг астрономи, физикийн математик шинжилгээг Крейгийн компьютер хормын төдий хугацаанд гаргах тул Их сургууль мэтийн томоохон институцууд сая сая долларыг түүнд төлнө. Крей шөнө өдөр, амралтын үеэрээ хэзээ ч зүгээр суудаггүй байлаа. Крейгийн ажлын цагийг минутаар үнэлж төлбөр хийнэ. Тэр элит мэргэжилтэн байлаа.

Юуны өмнө Крейг пассворд эвдэхдээ хамгийн гаргууд нэгэн ажээ. Мендаксийн зохиосон пассворд хакердах толь бичгийн програмыг түүний компьютерт хэрэглэхэд 10 секунд зарцуулна. Пассвордын энкриптэлсэн файл гал дээр хийсэн тос шиг шууд л хайлж байлаа. Хакер хүний хувьд энэ бол бахархмаар зүйл учир Коррапт найз нөхдийн нөхөрсөг харилцааг бодож Мендаксад “Крейгийн хэдэн эккаунтыг” өгчээ.

Мендакс хариуд нь “Encore” компаний хэдэн эккаунтыг Корраптад санал болгов. Хоёр хакер чатлаж, Корраптыг “NorTel”-ийн сүлжээ рүү оруулахыг оролдсон ч амжилтгүй болжээ. Дэлхийд чансаагаар дээгүүрт орох хоёр хакер 10,000 милийн зайтай газраас Корраптыг “firewall”-аар нэвтрүүлэх гээд чадсангүй. Хоёр хакер хоорондоо байнга зөвлөлдөж, тус тусын улсын мөрдөгчид юу хийж байгаа талаарх мэдээллийг солилцон, сонирхол татсан системүүд дээр зарим нэг эккаунтын талаархи сэтгэгдлээ хуваалцана.

“NorTel”-ийн хавтгай дэлгэмэл бүтэц нь тодорхой сайтуудад ямар зүйлийг олох боломж, түүний гүйцэтгэх үүрэг, тэрхүү сайт руу довтлох зэрэг олон зүйлээр хакеруудыг татаж байлаа. “Олон улсын босогчид” бүлгийнхэн агуу том системээр ихэнх шөнийг өнгөрөөдөг байв. Маргааш өдрийн өглөө нь тэдний хэн нэг нь нөгөө хакер руу утасдаж, уншиж, хулгайлсан мэдээлэл, цахим шуудангийн тухай хөөрөлдөнө. Тэд интернет аялал хийх дуртай байв.

Гэтэл хаврын нэгэн тогтуухан шөнө бүх зүйл орвонгоор өөрчлөгдөв.

Мендакс NMELH1 сүлжээ рүү үүрийн 2:30 үед “login” хийлээ. Системийн операторууд юу хийж байгааг илэрхийлэх логуудыг шалгаж эхэлдэг зуршлаар хайгуулаа эхлэв. “NorTel”-ийн эрх мэдэлтнүүд “Олон улсын босогчид” бүлгийн гишүүдийг илрүүлэх ажиллагаа хийж байгаа эсэхийг Мендакс мэдэхийг хүсэж байлаа. Тэд телефон утасны дуудлагыг мөшгиж байгааг ядаж мэдвэл ач холбогдол ихтэй билээ.

Байдал нэг л биш болжээ. Нэг цагийн өмнө “NorTel”-ийн системийн админ тэдний нууц директорууд дээр суулгасан файлуудын нэгийг олж мэдсэн тухай логууд харуулж байлаа. Тэд файлыг яаж илрүүлснийг Мендакс ухаж ойлгохгүй байв. Энэ удаад тэд том загас барьжээ. Хэрэв сүлжээнд хакер байгааг админ ойлгосон бол шууд л Австралийн Холбооны цагдаагийн

газар руу мэдэгдэнэ.

Мендакс “KSH” буюу “korn shell” хэмээн нэрлэдэг логуудыг ашиглаж, админ яг юу хийж байгааг нууцаар танджээ. “Korn shell” програм нь тодорхой хэрэглэгчийн үйл ажиллагааны дарааллыг бичиж авдаг юм. Админ компьютер руу команд шивэхэд “KSH” түүний шивсэн зүйлийг “history” гэсэн файлд хадгална. Мендакс ийм маягаар файлд нэвтэрч, админы шивсэн бүх зүйлийг бараг хагас секундын дараа өөрийн компьютер дээр харж байв.

Гадны этгээдийн ул мөрийг хайсан бололтой админ системийг дахин шалгаж эхэллээ. Мендакс гэмт хэрэг үйлдсэнд буруутгах файлуудаа чимээгүйхэн устгана. Өөр ямар нэгэн ажиг сураг байхгүйг магадласан админ нууцлаг директорийг илүү нарийвчлан судлахаар шийджээ. Харин директори сураггүй алга болсон байлаа. Админ өөрийн харсан зүйлдээ итгэсэнгүй. Бараг цаг ч хүрэхгүй хугацааны өмнө түүний системд байсан сэжигтэй директори илрүүлсэн боловч ямар ч ул мөр үлдээлгүй алга болжээ. Директори зүгээр ч нэг ингээд алга болчихдоггүй ажээ. Энэ бол 0 ба 1 дээр үндэслэсэн логикийн систем буюу компьютер байсан юм. Би директори устгах шийдвэрийг огт гаргахгүй гэж тэр бодно.

Хакер орж ирсэн байна гэж Админ гэнэт боджээ. “NorTel”-ийн системд хакер орж ирээд директори устгажээ. Тэр одоо манай системд байгаа болов уу? Админ системийн “route”-ийг шалгаж эхэллээ.

Админ өөрийнхөө гэрээс систем рүү холбогдсон боловч хакер шиг ижил “dial up” шугамыг хэрэглээгүй юм. Админ “Telecom”-ын худалдааны X.25 дата сүлжээ, “Austrac”-аар дамжин холбогджээ. Магадгүй хакер ч гэсэн X.25 холболтоор орж ирсэн байх гэж тэр бодов.

Админ X.25 сүлжээгээр дамжин орж ирсэн системийн бүх хэрэглэгчийг шалгаж байгааг Мендакс ажиглана. Хакерын ямар ч ул мөр илэрсэнгүй. Дараа нь админ өнгөрсөн хагас цаг болон түүнээс цаашхи хугацаанд “logon” хийсэн хүн байгаа эсэхийг мөн шалгалаа. Бас л онц содон зүйл алга.

Админ хэсэг хугацаанд идэвхгүй болов. Магадгүй тэр компьютерийнхээ дэлгэц рүү алмайран харсан байх. Сайн л биз гайхаад байна гэж Мендакс бодов. Дараа нь админ сэтгэсэн бололтой. Хэрэв тэр хакер онлайн дээр байгааг мэдрэхгүй байгаа бол онлайн дээр юу хийгээд байгааг мэдэх боломжтой байж болно. Хакер ямар програм хэрэглэж байна? гэж тэр бодож байгаа. Админ шууд компьютер дээр ажиллаж байгаа бүх програмуудыг үзүүлдэг жагсаалтаас лавлахаар шууд чиглэв.

Мендакс админ руу хуурамч алдааны сигнал илгээлээ. Ингэснээр түүний “korn shell” эвдэрсэн мэт ойлголтыг админд өгөх юм. Админ дахин “login” хийж ороод ажиллаж байгаа програмуудын жагсаалтыг үзэхээр шууд зүглэв.

Зарим хүмүүс хэзээ ч сурахгүй дээ гэж Мендакс бодох зуураа “Segmentation violation” гэсэн алдаа заасан мессэжийг илгээн админийг дахин гаргажээ.

Админ дахиад л орж ирэв. Ямар шургуу этгээд вэ гэж Мендакс бодоод, энэ удаад түүний компьютерийн дэлгэцийг гацаан админыг гаргав.

Муур хулгана болох иймэрхүү тоглоом хэсэг хугацаанд үргэлжлэв. Админ системийн жирийн ажлаа хийж байгаа гэж бүрэн итгэсэн үедээ л Мендакс түүнийг тайван орхиж байлаа. Админ dial up шугам эсвэл компьютер ажиллаж байгаа програмын жагсаалтыг шалгахаар оролдох тэр минутад админ өөрийнхөө системээс үл мэдэгдэх шалтгаанаар гарчихдаг болов.

Системийн администратор гэнэт бууж өгсөн бололтой. Түүний компьютер дээр ямар нэгэн үйлдэл хийгдсэнгүй.

Сайн байна гэж Мендакс бодоод цагаа харах үед үүрийн 3 цаг болсон байв. Одоо системийг эзэгнэх миний цаг хугацаа.. Чи өдөр л системдээ орж болно. Чи одоо унт би одоо ажиллана. Би унтахаар чи ажиллаарай..

Дараа 3:30 үед гэнэтийн нэгэн явдал болов. Админ дахин гарч иржээ. Энэ удаад тэрээр Х.25 сүлжээгээр гэрээсээ биш харин Мелбурн дэхь “NorTel”-ийн албан байранд байх мастер компьютер дээрээ суужээ. Мендакс мэл гайхаж цэл хөхрөв. Админ шөнө дундад гэрээсээ гарч нууцыг тайлахаар хотын төвд ирсэн байна.

Одоо байдал өөр тийш эргэхийг Мендакс ойлгожээ. Админ мастер компьютерээр “login” хийсэн тохиолдолд түүнийг системээс гаргах, холхон байлгах ямар ч боломж байхгүй юм. Одоо эрх мэдэл өөр хүний гарт шилжиж, хакер админий мэдэлд орлоо. Мастер компьютер сууж байгаа админ бүхэл бүтэн системийг ч унтраах эрх мэдлээ гартаа авчээ. Модем бүрийг салга. Сүлжээнд холбоотой бүх холболтыг салга. Компьютерийг унтраана. Үдэшлэг дууслаа.

Хакеруудад админ улам ойртох тусам түүний дэлгэц дээр мессэж гарна. Энэ бол нэг системээс нөгөө систем рүү илгээдэг жирийн хэмжээгээр бичигдсан мессэж биш байдаг байв. Яг илбэ үзүүлж байгаа мэт админий дэлгэцийн яг голд нь гарна.

“Би одоо л ухаан орлоо доо”

Кибер ертөнцийн тагнуултай анх удаагаа нүүр тулсан админ хакеруудыг хайж улайран хөөцөлдөхөө хэсэг хугацаанд завсарласнаа, таг чимээгүй болчихов. Дараа нь илгээгч хүн мэдэгдэхгүй нэгэн мессэж дахин ирж дэлгэц дээр тодорно.

“Би хяналтыг гартаа авсан. Олон жилийн туршид би хар бараантай тэмцэлдэж явлаа. Би одоо л гэрэл харж байна ”

Админ хариу өгсөнгүй. Түүний компьютер дээр үйлдэл хийгдэхгүй байлаа.

Өөрийнхөө компьютер дээр сууж байгаа Мендакс байдаг чадлаараа инээв. Тэр ур чадвараа үнэхээр харуулж чаджээ.

Эцэст нь админ нойрноосоо сэрсэн бололтой. Тэр модемны шугамыг нэг нэгээр нь шалгаж эхлэв. Хэрэв тэр хакер аль шугамыг ашиглаж байгааг мэдэх юм бол тэр модемыг зүгээр л унтраачих юм. Эсвэл шугамыг ашиглан ул мөрөөр хөөн мөшгих хүсэлт гаргана.

Админий компьютерийн дэлгэц рүү Мендакс бас нэгэн нэргүй мессэж илгээв.

“Танай системээр тоглох сайхан байлаа. Бид ямар нэгэн хор хохирол учруулаагүй ээ. Бид хэдэн зүйлийг л сайжруулсан. Австралийн Холбооны цагдаагийн газарт мэдэгдэхгүй байхыг хүсье” гэжээ.

Админ мессэжийг үл огоорч хакерыг үргэлжлүүлэн хайсаар байлаа. Аль dial up шугамнууд хэрэглэгдэж байгааг олж тогтоохын тулд системийн сериал портууд дээрх телефон утасны шугамуудыг шалгах програмыг тэр ажиллуулжээ. Хакерийн хэрэглэж байгаа шугамыг админ илрүүлмэгц Мендакс зугатаахаар шийдэв. Түүний хийсэн дуудлагыг мөшгих боломжийг хаах үүднээс өөрийн телефон утасны харилцуурыг өргөж, модемыг салгаад NorTel-ийн модем эхэлж салгалтаа хийхийг хүлээжээ.

Хэрэв хакер ямар утаснаас дуудлага хийснийг мэдэхийг хүссэн “NorTel”-ийн админ хамгийн сүүлийн дуудлагыг санах програм буюу “LPR”-ыг суулгасан гэдгийг Мендакс мэдэж байлаа. Хэрэв “LPR” дагагч програм суулгасан бол хакерийн телефон утасны харилцуур тавихыг хүлээж, телефон утасны холболтын нэг төгсгөл болох “NorTel” холболтыг эхэлж салгахгүйгээр хүлээж байдаг ажээ. 90 секундын дараа телефон утасны байгууламж дуудлага анх хийгдсэн газрын утасны дугаарыг гаргаж ирнэ.

Хэрэв шугам дагагчгүй бол компанийн модем нь холболтоо алдсан хакерийн модемыг хайх болно. Үргэлжилсэн электроникийн сигналгүйгээр “NorTel”-ийн модем хэдхэн секундын дараа өөрийгөө холболтоос тасална. “NorTel”-ийн шугамын төгсгөл дээр хэн нэгэн нь дахин идэвхижүүлэхгүй л бол холболтыг 90 секундын дараа телефон утасны байгууламж бүрэн тасална.

Телефон утасны шугам дээр чихэнд чийртэй дуу гарган түүний модемыг “NorTel”-ийн модем хайж байгааг Мендакс тэвчээртэй сонсож байлаа. Энд ямар ч модем алгаа. Утсаа тавиаж гэж Мендакс дотроо бодно.

Дуу гэнэт чимээгүй болов.

ОК, одоо 90 секунд хүлээх л үлдлээ. Нэг минут хагас хиртэй хүлээгээд ул мөрөө үлдээгээгүй гэдэгт залбирахаас...

Дараа нь “NorTel”-ийн төгсгөл дээр хэн нэгэн телефон утас авлаа. Мендакс ихэд айжээ. Тэрээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үглэх чимээ ард нь сонстож байв. Бурхан минь! “NorTel”-ийн хүмүүс юу яриад байгаа юм болоо? Мендакс чив чимээгүй болоход амьсгал нь бараг тасарчих шахна. Телефон шугамны хоёр төгсгөлийн харилцуурууд чимээгүй байлаа. Мендаксийн зүрх түргэн цохилж байгаа нь сонсогдоно.

Алдарт хакер хөл алдаж эхлэв. Тэр хэзээ ч барин тавин сандардаггүй нь түүний сайн тал байлаа. Тэр айдастай баригдах дургүй нэгэн аж.

Дараа нь “NorTel”-ийн албан байранд хэн нэгэн эмэгтэй хүний сандарч, эргэлзсэн дуу сонстож: “Тэнд юу ч алга. Тэнд юу ч алгаа” гэсээр харилцуураа тавьчихлаа.

Мендакс тэвчээртэй хүлээсээр. Тэнд ямар нэгэн ул мөр үлдээсэн эсэхийг магадлаж,

харилцуураа тавихыг хүсэхгүй байв. 90 секунд өнгөрлөө. Утасны дуудлага хийгээгүйн улмаас хурдан өгөх дуут сигнал чихэнд аятайхан сонсогдохгүй ажээ.

Хагас цагийн өмнө түүнд тулгарсан зүйлийн талаар Мендакс дахин дахин бодож, ширээн дээрээ хөшсөн мэт суув. Дахин хэзээ ч “NorTel” рүү орохгүй. Маш аюултай юм байна. Өөрийгөө мэдэгдэлгүй зугагаж чадсан нь түүний аз байлаа. “NorTel” компани “Telecom”-той маш сайн харилцаа холбоотой. Хэн нэгэн хүн хурдан мөшгиж чадаж байгаа юм бол “NorTel” чадаж л таарна. Прайм Саспект, Тракс нарт анхааруулах ёстой гэж Мендакс боджээ.

Өглөө Мендакс Тракс руу утасдаж “NorTel”-ээс хол байхыг юуны өмнө сануулав. Дараа нь Прайм Саспект руу утасдахад шугам завгүй яриад байлаа. Магадгүй Прайм Саспектийн ээж өөрийнхөө найзтайгаа ярьж байгаа биз.

Мендакс утасдах гэж дахин дахин оролдов. Тэр санаа зовж эхлэв. Яг одоо Прайм Саспект “NorTel”-ийн сүлжээнд байгаа бол яах вэ? Дагагч програм суурилуулсан бол яана аа? Цагдаа нарт тэд мэдэгдвэл яах бол?

Телефон утасны байгууламжаар дамжин дуудлага хийгдэж байхад саад хийх ямар нэгэн арга байгаа эсэхийг Траксаас Мендакс яаралтай асуув. Тийм арга байдаггүй...

“Тракс чи мастер фреакер шүү дээ. Утасны холболтыг салгах ямар нэгэн зүйл хийгээч. Түүнийг шугамаас салгаач” гэж Мендакс гуйлаа.

“Тэгж болохгүй шүү дээ. Тэр чинь шатлан холбогдох телефон утасны байгууламжийг ашиглаж байгаа. Бид юу ч хийж чадахгүй” гэлээ.

“Юу ч гэж үү? Австралийн хакер-фреакерийн хамгийн алдартай бүлэг нэг утасны дуудлагыг салгаж дөнгөхгүй байна гэж үү дээ. Тэд бүхэл бүтэн утасны сүлжээний зангилааг мэдэлдээ оруулж чадсан мөртлөө зүгээр л нэг утасны дуудлагыг тасалж чадахгүй байна!”. Бурхан минь.

Хэдэн цагийн дараа Мендакс “Олон улсын босогчид” бүлгийн хакертай холбогдлоо. Тэд маш хурдан мэндчилээд: “NorTel дээр өнөөдөр байгаагүй гэж надад хэл дээ” хэмээн асуулаа. Прайм Саспект хэсэг хугацаанд түдгэлзэв.

“Би өнөөдөр NorTel дээр байсан...”

Есдүгээр бүлэг

“Цаг агаар” ажиллагаа

“Дэлхий ертөнц өнөө шөнө сүйрэн мөхнө, Хана туурганууд над дээр бууж ирнэ”

“Нар ба дэлхий” Midnight Oil хамтлагийн дуу

Австралийн Холбооны цагдаагийн газрын мөрдөн байцаах ажил амжилт олсонгүй. Австралийн компаниуд, судалгааны хүрээлэн, хилийн чанад дэхь хэд хэдэн сайтууд руу Рояль Мелбурний Технологийн Институт (RMIT)-ийн компьютер сүлжээг бүлэг хакерууд хакердах бааз болгон ашиглаж байв.

Австралийн Холбооны цагдаагийн газрын Өмнөд бүсийн компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийн мөрдөгчид довтолгооны ард ямар хакерууд байгааг тогтоож чадахгүй байлаа. Тэд бол Мелбурнд байрлалтай, хамтран ажилладаг хакеруудын жижигхэн бүлэг гэж таамаглаж байв. “RMIT”-ийн сүлжээн дээр хакердах маш олон төрлийн үйлдэл гарч байгаа учраас яг баттай нотлож чадахгүй ажээ. Тэнд нэг зохион байгуулалттай хакерийн бүлэг эсвэл нилээд хэдэн бүлэг ажиллаж байх боломжтой байв. Эсвэл нэг жижигхэн бүлгийн хажуугаар нилээд хохирол учруулах чадвартай ганцаардмал хакерууд байж болох билээ.

Тэд маш сайн халхавчтай ажилласан хэвээр байгаа нь цагдаа нарын сэтгэлийг зовоож байлаа. Мөрдөгчид ийм нөхцөл байдалд гараа ардаа баглуулаад хакеруудыг хайж болно. “RMIT”-ийн модемууд руу орж ирж байгаа бүх шугамнуудын сүүлчийн бичлэгийг “Telecom”-оос авч үзэх ажлыг юуны өмнө зохион байгуулна. Хакерийг “logon” хийхийг хүлээж байгаад дараа нь түүний хэрэглэж байгаа модемийг тусгаарлан хянана. Тэр модемийн шугамыг хянаж, хаанаас холбогдож байгааг тогтоох ажиллагааг шугамаар нь мөшгихыг “Telecom”-оор хийлгэнэ.

Харамсалтай нь тийм аргаар “RMIT”-ийн сүлжээг хянаж болохгүй байлаа. Шугамын зурвас, холболтууд зүгээр ч нэг тасалдахгүй бүр байнга хэвээр байх болов.

“RMIT”-ийн ажилтнууд хакерийг онлайн дээр олонгуут л шугамыг тогтоож, “Telecom” ямар утасны дугаараас дуудлага хийгдсэнийг мөшгинө. Гэтэл ул мөрөөр нь оронгуут л гэнэт тасарна. Хакерууд өөрсдийгөө мөрдөж байгаа гэдгийг мэдэж байгаа мэт санагдаж байв. Тэд Австралийн Холбооны цагдаагийн газрын мөрдөгчдийг няцаах аргаа олж, телефон системийг зальжин ашиглаж байгаа юм шиг харагдах ажээ.

Шинэ үеийн хакерууд шинэ арга олж нээгээд Холбооны цагдаагийн мөрдөгчдийг самууруулж байв. Гэтэл 1990 оны 10-р сарын 13-ны өдөр Австралийн Холбооны цагдаагийн мөрдөгчдийн од нь гийв. Магадгүй тэр өдөр хакерууд залхуурсан байх. Эсвэл буцаан мөшгих боломжгүй фреакингийн аргад нь техникийн саатал гарсан байх. Прайм Саспект өөрийнхөө гэрээс Траксийн ул мөргүй фреакинг хийх аргыг ашиглаж чадахгүй юм. Учир нь тэр телефон сүлжээний хоцрогдсон сүлжээг ашигласан агаад Тракс энэ арга техникийг урьд өмнө огт хэрэглэдэггүй ажээ. Ингээд “RMIT”-ээс гарч байгаа утасны хоёр шугамыг Telecom амжилттай мөшгиж, Холбооны мөрдөгчид хоёр хүний нэр, гэрийн хаягтай болов. “Прайм Саспект, Тракс..”

“Сайн уу Прайм Саспект”

“Юу байна? Мендакс. Илбэ ямар байв даа?”

“Амжилттай. “RMIT”-ийн цахим шууданг харж амжсан уу? Жеоф Хастоны шуудангийн хайрцаг...?” гэж Мендакс хэлэх зуураа цонхоо нээхээр алхав. Энэ бол 1991 оны хавар байсан бөгөөд цаг агаар маш сайхан, дулаахан байв.

“Тиймээс би харсан. Маш сонирхолтой байлаа. “RMIT” тэдгээр шугамнаасаа удахгүй салах байхаа даа.”

Мендакс: “RMIT ч хүсэж байгаа нь тодорхой” гэхэд

“Аанха, Мистер Дей тэдний компьютерийн шугамыг нэг бүрчлэн нэгжиж байх зуур RMIT-ийн ажилтнууд ихэд цухалдаж байгаа бололтой дог”

“Тиймээ, “RMIT”-ийн админ маш сайн ажиллаж байгаа. “AARNET” болон Холбооны цагдаагийн газрын шүүмжлэлд их өртөж байгаа хүн. Жеоф Хастон түүнийг нилээд дарамтлаж байна.”

“Тэгж байгаа гэдэгт мөрий тавихад ч бэлэн байна” хэмээн Прайм Саспект хэлснээ
“Холбооны мөрдөгчид шугамны мөшгилтийг жинхэнээсээ больсон гэж чи бодож байна уу?”

“Тийм л юм шиг санагдаж байна. Хэрэв “RMIT” тэднийг холдуулж чадвал Холбооны мөрдөгчид тэдний хамтын ажиллагаагүйгээр юу ч хийж чадахгүй болно. Тэдний системийг хамгаалахыг хүсэж байгаа утгатай юмыг захианд дурьдсан байна лээ. Түр азнаж байгаарай. Би сайн үзээдэхье.”

Мендакс захиаг дэлгэцэн дээр гаргаж ирээд гүйлгэн харав.

Хэнээс: aarnet-contacts-request@jatz.aarnet.edu.au 1991 оны 5-р сарын 28-ны өдөр, Мягмар гариг,09:32:31

Хүлээн авсан: jatz.aarnet.edu.au хувийн дугаар AA07461

(5.65 +/IDA-1.3.5 for pte 900); 1991 оны 5-р сарын 28 Мягмар гариг 09:31:59 +1000

Хүлээн авсан: possum.ecg.rmit.OZ.AU jatz.aarnet.edu.au with SMTP хувийн дугаар AA07457

(5.65+/IDA-1.3.5 for /usr/lib/sendmail-oi-faarnet-contacts-request aarnet-contacts-recipients) 1991 оны 5-р сарын 28 Мягмар гараг 09:31:57 +1000

Хүлээн авсан: by possum.ecg.rmit.OZ.AU for aarnet-contacts@aarnet.edu.au)

Он сар өдөр: 1991 оны 5-р сарын 28, Мягмар гараг. 09:32:08 +1000

Хэнээс: rcoay@possum.ecg.rmit.OZ.AU (Alan Young)

Хэнд: aarnet-contacts@aarnet.edu.au

Сэдэв: Re: Хакерууд

Хакердах нь муу, зогсоох шаардлагатай гэдэгт хүн бүр санал нийлэх байх. Эсвэл тийм үйлдлийг багасгах шаардлагатай бизээ. Тэдгээр хүмүүсийн хойноос мөрдөж зургаагаас найман сарыг өнгөрөөхдөө би хэдэн ажиглалтыг хийсэн юм.

1. Шаардлагатай зардал маш чухал байна.
2. Би өөрийн ажилтнуудаа шүүмжлээгүй боловч хүмүүс бөмбөг хаашаа өнхөрч байгаа анзаарахгүй байна. Бүхэлдээ хөөцөлдөж тоглоод байгаа дүр зураг харагдана.
3. Хакеруудыг барих (тэднийг шийтгэх), баривчлах нь бараг л боломжгүй. Та хууль бусаар бусдын компьютер руу “Logon” хийсэн байхад л тэдний орон байр руу нэвтэрч орох шаардлагатай болно.
4. Хэрэв тэднийг барьж чадвал шийтгэхийн тулд зардал маш их гаргах бөгөөд мөрдөн байцаалтын үр дүн баталгаатай байхгүй. Тэднийг баривчилж, шийтгэхэд саад болж байгаа ямар нэгэн нөхцөл байдал байна уу?
5. Мөрдөн шалгах ажилтай холбоотой хүмүүс хаалгаа нээлттэй байлгах бодлого шаардагдана. Харамсалтай нь бусад хэсгийг хамт ил гаргаад тавьчихдаг учир зарим талаараа шүүмжлэлд өртөнө.

Ерөнхийдөө энэ сэдэв бол нилээд өргөн цар хүрээг хамарсан, үр дүнтэй байх магадлал бага байна. Эрх чөлөө болон бусдын халдагаас урьдчилан сэргийлэх ажлын хоорондох тэнцвэржилтийг сайн хадгална гэдэг нилээд их хүсэл зоригийг шаардана. Алан Яанг –“RMIT” гэжээ.

“Тиймээ, “RMIT”-ийн энэ залуу биднийг барих гээд байна гэж хэлээгүй юм шигээ. Бид яагаад цаг хугацаа, мөнгөө хий дэмий зарцуулаад байгаа юм бэ гэсэн утгатай зүйл бичжээ.”

“Тийм байна. Холбооны мөрдөгчид тэнд бараг гурван сар ажилласан байна шүү дээ. Гэхдээ есөн сараас илүү хугацаанд юм шиг л санагдаж байна” гэж Прайм Састект хэллээ.

“Хмм. Тэгэхлээр бид ямар нэгэн зүйл огт мэдэхгүй байгаа юм биш байна.”

“Тэдгээр эккаунтуудыг нээлттэй байлгаад байгаа нь илт байна шүү дээ. Бид цахим шууданг нь уншаагүй байхдаа хүртэл үнэхээр сэжигтэй санагдаж байна гэж бодож байлаа.”

“Мэдээж, “RMIT” дээр олон хакерууд байгаа. Тэд үүнийг төсөөлсөн байгаа эсэхэд би эргэлзэж байна” хэмээн Мендакс хариулав.

“Хмм. Тэд болгоомжтой байхгүй бол баригдана даа”

“Гэхдээ хэн нэгнийг Холбооны цагдаагийнхан барьчихсан гэж би л лав бодохгүй”

“Тийм гэж үү? ” хэмээн Прайм Саспект асуув.

“За за тэгэхлээр тэд экаунтуудыг нээлттэй орхих ямар шаардлага байсан юм бэ? Яагаад “RMIT” байнгын ажилтан авах болов? ”

“Ямар ч шаардлага байхгүй юм шиг санагдана.”

“Үгүй ээ. “RMIT”-ийнхэн тэднийг холдуулсан гэдэгт маш их итгэлтэй байна” гэж Мендакс хэлэв.

“За хөвгүүдээ та нарт боломж байсан. Хэнийг ч барьж чадсангүй. Одоо явахдаа бэлдэж цүнх саваа хураа даа гэж хэлсэн байх” гэж Прайм Саспект шоолно.

“Тиймээ, Гэхдээ “Nortel”-ийн хувьд бол ёстой мэдэхгүй байна” гэж Мендакс хэсэг хугацаанд түдгэлзэв.

“Тиймээ”

Анир чимээгүй байдал орчныг нөмөрлөө.

Хэн нэгэн сайн хүнтэй найзалж нөхөрлөөд, хамтарч ажилласан мөртлөө ярих юм олдохгүй байгаа нь Мендаксд их сонин санагдаж байв.

“За за, би гарлаа. Хийх зүйл байна” гэж Мендакс нөхөрсгөөр хэллээ.

“За баяртай Мендакс” гэж Прайм Саспект хөгжилтэй нь аргагүй хэлэв.

Мендакс утсаа тавьжээ.

Харин Холбооны мөрдөгчид онлайн дээр байсаар байв.

1990 оноос хойш анхны шугамын мөшгилтыг хийснээс хойш 12 сарын хугацаанд “RMIT”-ийн dial up шугамнуудыг Холбооны цагдаагийн мөрдөгчид үргэлжлүүлэн хянасаар байсан юм. Шугамын мөшгилт дахин дахин тасарсаар байлаа. Гэхдээ хакерууд довтолсоор байгаа гэсэн репортууд ирсээр байгаа нь ихэнх халдлагууд илэрхий байгааг сануулсаар байв. Мөрдөгчид хяналтанд оруулах ангийн олзоо баг багаар мэдэрч эхлэв.

1990 болон 1991 онд Их сургуулийн системийг довтолгооны үүр болгон ашиглаж байсан хакеруудын улмаас “RMIT”-ийн dial up болон компьютерүүд эвдэрч байсан юм. Тэд системд бараг нээлттэй тоглолт хийж, “RMIT”-ийг өөрсдийн онлайн чат хийдэг талбар болгожээ. Институцийн сүлжээ довтолгоо хийх төгс төгөлдөр тавцан болсон ажээ. Хамгаалалт муутай боловч маш хүчирхэг компьютерүүдтэй бодит интернет орчныг уг байгууллага хангаж өгч байв. Хакеруудын диваажин гэхэд бараг болно.

Цагдаа нар энэ нөхцөл байдлыг мэдэж байсан учраас хакеруудын үйл ажиллагааг хянахын

тулд аюулгүй байдлын цоорхойг хаахгүй, онгорхой байлгахыг хүсчээ. Арав гаруй өөр хакерууд “RMIT”-ээр хэсүүчилж байсан бөгөөд зохион байгуулалт сайтай 2-3 хакерын бүлгийг тусад нь хянах тийм ч амархан даалгавар байгаагүй юм.

1991 оны дунд үед “RMIT”-ийн ажилтнууд компьютерээ нээлттэй байлгахад дурамжхан хандах боллоо. Наймдугаар сарын 28-ны өдөр “RMIT”-ийн Электроник Харилцаа Холбооны Группын дарга Аллан Яанг аюулгүй байдлын цоорхойг бөглөхийг хүсэж байгаагаа Австралийн Холбооны цагдаагийн мөрдөгчдөд хэлжээ. Мөрдөгчид үүнийг таатай хүлээж аваагүй бөгөөд “RMIT”-ийн захирал болон “AARNET”-ийн Жеоф Хастон руу хандав.

Мөрдөн байцаалтанд маш урт хугацаа зарцуулсан учир Холбооны мөрдөгчид маш эрчимтэй хөөцөлдөж байв. “RMIT”-ийнхэн хэн нэгэнд Холбооны мөрдөгчдийн үйл ажиллагааг хэлж болохгүй байсан тул компьютерүүдээ хэрхэн хамгаалах талаах сэтгэл зовних болжээ. “RMIT” дээрх хакерийн асуудлыг “AARNET”-ийн төлөөлөгчдийн хурал дээр зүгээр л нэг хэлээд тавьчих эрх Аллан Яангад байхгүй байв. Энэ хооронд түүний компьютерийн чиглэлээр ажилладаг хүмүүс цагдаа хулгайчдын тоглоомын үеэр цаг их алдаж, жинхэнэ ажлаа үл тоох боллоо.

Ингээд “RMIT”-ийнхэн Холбооны мөрдөгчдын тавьсан урхийг хаах тэр үед цагдаа нарт “NorTel”-ийн бялуунаас хувь хүртэх аз тохиожээ. 9-р сарын 16-ны өдөр “NorTel”-ийн dial up шугамны мөшгилтөөс үүссэн гомдол цагдаа нарт ирснээр бас нэгэн амжилтын үүд нээгдсэн юм.

Аравдугаар сарын нэгнээс эхэлж Прайм Саспектын утсыг Холбооны мөрдөгчид хяналтандаа авав. Хакерууд цагдаа нар тэднийг ажиглаж байгааг мэдсэн байж болох талтай. Ямартай ч тэд олзондоо их ойртжээ. Нууцаар чагнах явцад Мендакс дараа нь Тракс руу хяналтыг чиглүүллээ.

Ингээд Холбооны цагдаагийн мөрдөгчид гурван хакерийн утсыг бүрэн хяналтандаа авчээ. Тэд ийм шийдвэр гаргахдаа сайн эргэцүүлэх шаардлагатай байлаа. Телефон утсыг нууцаар хянах ажиллагаа нь үнэтэй бөгөөд хяналтыг доод тал нь нэг сар үргэлжлүүлэх хэрэгтэй аж. Тэд хакерууд онлайн дээр юу хийж байгааг хөдөлшгүй баримтжуулж чадсан юм.

“Цаг агаар” нууц ажиллагаанд нэмэлт тагнах ажиллагаа хийлгэхээс өмнө “Олон улсын босогчид” хакерийн бүлгийн нэг этгээд цагдаа нарыг ихэд гайхшруулав. Тракс өөрийн санаачлагаар цагдаа нар дээр очжээ.

10-р сарын 29-нд Прайм Саспект баяр тэмдэглэж байв. Түүнийг 12-р ангиа төгссөн гэж ээж нь оройн зоог бэлтгэсний дараа тэрээр Вермонт руу үдэшлэгт явжээ. Гэртээ ээж нь ирээд Лиззи нохойгоо хооллосны дараа гэр орноо цэвэрлэв. Тун удалгүй нохой нь хуцлаа.

“Чи үдэшлэгээсээ ийм хурдан ирлээ гэж үү?. Тэнд гоё биш байна уу?” гэж Прайм Саспектын ээж нь асуув.

Хэн ч хариу өгсөнгүй.

Тэр орон дээр цомцойн суулаа. Хэн нэгэн хүн хариу хэлэхгүй байхыг сонсоод ойрын үед хөршүүд нь ярих болсон хулгайн тухай гэнэт санав. Бүр хэд хэдэн удаа айл ухсан сураг сонссон байлаа.

Удалгүй эрэгтэй хүний дуу үүдний хавьцаа гарч, “Эмэгтэй хаалгаа онгойлгоорой” гэв.

Хаалган дээр очоод дурангаар харангуут үүдэнд Цагдаа нар зогсож байлаа.

“Би та нарыг цагдаа гэж яаж мэдэх юм бэ?”

“Хэрэв та хаалгаа нэхэгүй бол бид эвдэж орох болно!” гэж хахир дуугаар хариулав.

Хаалганы хажуу талын цонхоор бичиг баримтаа үзүүлээд байх шиг санагдлаа. Прайм Саспектын ээж нь ойрын харааны шилээ зүүгээгүй боловч цагдаагийн бэлгэдэл байхыг олж харав. Ээж хаалгаа сандран нээлээ.

Үүдэн дээр найм, есөн хүмүүс зогсоно. Тэднийг яах ийхийг асуух гэтэл хүч түрэн байранд орж ирэв. Нэгэн эмэгтэй цагдаа цаас сарвайж, “Үүнийг унш! Энэ бол нэгжлэг хийх зөвшөөрөл. Уншиж чадах уу?” гэж ууртай асуулаа.

“Үгүй ээ, арай чадахгүй. Би шилээ зүүгээгүй байна” гэв.

Ээж нь утсаар гэр бүлийн хуульчийг дуудахыг хүсэж, залгасан боловч болсонгүй. Тэр оршуулганд оролцож байв. Прайм Саспектын ээж хоёрдахь удаагаа утас руу ойртоход олон удаа утсаар ярилаа гэж нэгэн цагдаа лекц уншиж гарлаа.

“Чи чимээгүй бай мэдэв үү” гэж хуруугаараа зааж, цагдаа руу хэлээд дахин нэг удаа залгав. Бас л амжилтгүй.

Тэр өөрийнхөө хүүгийн өрөөг зааж өгөөд ирсэн зорилгоо биелүүл гэж хэлэхийг хүсэж байв. Гэвч цагдаа нар бүх орон байрыг нь нэгжинэ.

“Таны хүү хаана байгаа юм бэ?” гэж цагдааг асуухад “Үдэшлэг дээр” гэж ээж хариулав.

“Хаягийг нь мэдэх үү?”

Тэрээр нүдээ онийлгон бодож байснаа хаягийг хэлж өгөв. Цагдаа нар Прайм Саспектын өрөөг бужигнуулж компьютер, цаас, модемыг хураан авах үеэр ээж нь бүгдийг харж зогсох ажээ.

Хэн нэгэн хаалга тогшив. Энэ бол мужийн цагдаагийнхан байлаа. Түүний хөрш нь чимээ гарахыг сонсоод цагдаа дуудсан хэрэг байв.

Холбооны цагдаагийн газрын мөрдөгчид Вермонт руу хөдөллөө. Наргиж байгаа найз нөхдийг нь айлгахгүйн тулд гаднаа гараад хүлээж байхыг ээж нь утсаар хэлжээ.

Прайм Саспект утсаа тавингуутаа ихэд согтсоноо мэдрэв. Цагдаа нар хаягаар ирж гадаа

зогсоход үдэшлэг ид дундаа бужигнаж байлаа. Мөрдөгчид өөрсдийгөө танилцуулаад согтуу Прайм Саспектыг машиндаа суулган авч одов.

Тэгэхлээр “Чиний ширээний шургуулганд чинь юу байсан юм бэ?” гэж цагдаа түүний гэр рүү явах замдаа асуулаа. Прайм Саспект хүчлэн бодно. Миний ширээний шүүгээнд гэнэ ээ? Өө баларсан юм. Марихуана! Тэр байнга татахгүй боловч найз нөхдийн хамт хааяа нэг хөгжилдөхдөө хэрэглэдэг аж.

Тэр хариулсангүй. Тэр сэтгэл түгшиж байгаагаа мэдэгдэхгүйг хичээн цонхоор харж явав.

Түүнийг гэрт ирсний дараа байцаалт авахыг зөвшөөрөх үү гэж асуулаа.

“Би тэгж бодохгүй байна. Би бага зэрэг...” гэж түүнийг түгдрэх зуураа согтуудаа байцаалт өгөх нь аюултай гэж боджээ.

Хакердахад хэрэглэдэг сүүлчийн төхөөрөмжийг өрөөнөөс нь гаргасны дараа албан ёсоор хурааж авах тухай бичиг баримтанд Прайм Саспект гарынхаа үсгийг зурав. Унтлагын өрөөнд орж ирээд сэтгэл нь уймарсан тэрээр бодлоо хураах гэж ядна. Түүнийг хэдэн жил торны цаана суулгачих хангалттай нотлох баримт хураан авсан, харин одоо 100 долларын торгууль хүлээлгэчих хэмжээний марихуана татаад өрөөндөө сууж байдаг ..?!

Хаврын сэрүүхэн орой уул талыг бүрхэн авах үед Холбооны мөрдөгчид Мендакс, Тракс хоёрыг яасан бол гэж Прайм Саспект бодов.

Үдэшлэг дээр байхдаа цагдаа нарыг ирэхээс өмнөхөн тэрээр Мендакс руу утасдахыг оролдсон боловч ээж нь утсаа авчээ. Түүний ээжийн хэлж байгаагаар Холбооны цагдаа нар Прайм Саспектын гэрийг орвонгоор нь эргүүлж байгаа гэсэн ойлголт авсан учир утасдахыг оролджээ. Гэвч тухайн үед юу болохыг Мендакс, Тракс хоёр төсөөлөөгүй байсан юм. Цагдаа нар түүнийг авахаар орж ирэхэд Мендакс руу утасдахаар оролдсон авч, утас завгүй байсаар байлаа. Тэр оролдсоор дахин оролдсоор. Түүнд сануулах бололцоо гарсангүй.

Мендаксийн гэрт цагдаа нар очсон эсэхэд Прайм Саспект санаа зовж байсан ч одоо түүний утасны дуудлага ямар өөрчлөлт хийж чадахгүй байлаа.

Мендаксийн эхнэр гэрээс нь явахдаа бүх зүйлийг орвонгоор нь эргүүлжээ. Хагас тавилга нь алга болж, хагас нь ундуй сундуй хэвтэнэ. Хувцасны шүүгээ онгорхой, доторхи зүйлийг хуу хамсан байв. Өрөөний энд тэндгүй хөглөрсөн хувцас, эд зүйл. Түүний эхнэр нь салж явахдаа хөлд орж байгаа хүүхдийг нь авч явжээ. Түүнчлэн Мендаксийн хувьд амин чухал хэрэгтэй хэдэн зүйлийг авч явсан аж. Гурван жил ханилсан эхнэр нь ингээд алга болно гэж тэр хэзээ ч бодож байсангүй.

Аравдугаар сарын сүүлчийн долоо хоног Мендаксийн хувьд жас өдрүүд нь гэлтэй өнгөрсөн юм. Хайр дурлалдаа азгүйтсэн Мендакс сэтгэлийн тамд унажээ. Тэр компьютер хэрэглэх хүсэл сонирхолгүй болж, хэдэн өдөр хоол идэлгүй өнгөрөөв. Түүнийг гэмт хэрэгт буруутгах гол нотлох баримт болох хакердахдаа ашигладаг дискууд, компьютерт нэвтрэх хулгайлсан кодууд ихэвчлэн далд нууц газарт хадгалагдаж байв. Харин 1991 оны 10-р сарын 29-ны

өдрийн орой түүний 700 долларын үнэтэй “Amiga 500” компьютерийн эргэн тойронд 13 диск тараан шидсэн байлаа. Арван дөрөв дэх нь компьютерийн диск драйв дотор байв.

АНУ-ын хамгийн хатуу шоронгуудын нэгд есөн жил хоригдсон Жеорж Жексоны шоронгоос бичсэн захидлуудын тухай “Soledad Brother” номыг Мендакс уншиж байлаа. Хөнгөн гэмт хэрэгт ял авсан Жексон шоронд богино хугацаанд буух ёстой байсан хэдий ч амбан захирагчийн хүсэлтээр шоронд хоригдсоор байжээ. Эрх мэдэлтнүүд түүний хөлнөөс зуурч, эрүүгийн шүүх систем итгэлээр нь тоглох тэр үед Жексоныг шоронгийн хуягууд буудаж алсан юм. Энэ номонд Мендакс яагаад ч юм их дуртай байлаа. Гэвч түүний азгүйтлээс сатааруулах өчүүхэн ч дэмийг Мендакс номноос авч чадсангүй.

Телефоны хуурамч сигнал гэрт нь чанга сонсогдоно. Мендакс өөрийн модем болон компьютертээ стерео спикерээ залгаж, телефон утасны үйлчилгээний зангилаа байгууламжаас хариу өгөх үед телефон шугамаар түүний компьютер рүү ирж байгаа дуу чимээг сонсож байв. Энэ бол Траксийн MFC фреакинг хийх аргуудад маш сайн тохирч байсан юм.

Төхөөрөмжийн тохируулгыг сайн хийснээр фреакерын хар хайрцгийг мөн адил бий болгож болно. Хайрцаг нь телефон утасны байгууламжийг төөрөгдүүлж, түүний утас хариу өгсөнгүй гэж бодуулах агаад Мендаксийн найзад 90 секунд үнэгүй дуудлага хийх холбогдох боломж олгоно.

Харин энэ шөнө Мендаксийн илгээж байгаа сигнал бол түүний тайван орхи гэсэн утгыг илэрхийлнэ. Тэр ямар нэгэн компьютерийн систем рүү дуудлага хийсэнгүй. Зайтай орших модемтой ямар ч холбоо байхгүй утасны залгалт хийх хугацаа дуусаж, сигналаа илгээнэ.

Телефон утасны шугам, компьютерүүд рүү холбогдох гэж бага балчир насаа өнгөрөөх нь хачин санагдах бөгөөд өдөржингөө утасны дуудлага хийж байгаа чимээг сонсоод өнгөрөөх Мендакст уйтгартай санагдахгүй байв. Бийп ... бийп..... Тасралтгүй үргэлжилсээр.

Утасны хачин дууг хаалга хүчтэй цохих чимээ гэнэт эвдэв.

Номноос сэхээрэн, цантсан цонхоор харангуут хүний хэлбэр сүүдэртэн харагдана. Мендаксийн эхнэрийнх нь багийн найз Ратфейстэй ихэд адилхан санагдав.

“Хэн бэ?” гэж Мендакс зөөлөн сандал дээрээс хөдлөлгүй асуухад “Цагдаа байна. Хаалгаа онгойлго” гэх нь сонстлоо.

Шөнийн 11:30-д цагдаа нар яах гэж байгаа юм бол? Хүмүүсийг дандаа унтаж, анхаарал нь сарнисан үед л айлд ирж баривчилгаа хийдэг гэдгийг хэн ч мэдэх билээ.

Цагдаа нар түүнийг баривчлаж байна гэж Мендакс байнга зүүдэлж байв. Түүний зүүд цагдаа нараар өвчлөхөд хүргэсэн ч гэж хэлэхээр олон удаа давтагдаж, хаа саагүй дагаад байгаа мэт байлаа. Ингээд үүр цайхаас өмнө хүн амьтан унтсан цагаар зүүд биелэхийг Мендакс үзэв.

“Яв цаашаа, Ратфейс би чамтай тоглох зав алга” Мендакс хэлээд номоо дахин харлаа.

Дуу чимээ энэ удаад улам чангарч, “Цагдаа байна, хаалгаа онгойлго, ОДОО” гэж хэлэв. Цонхны ойролцоо өөр дүрснүүд ч сүүтгэнэлээ. Цонхны цаанаас цагдаагийн тэмдэг үзүүлэхийг хараад түүний бодолд өнгөрчээ! гэсэн үг зурхийн орж ирэв.

Цагдаа нарыг нэгжлэг хийх зөвшөөрлөө харуулахыг тэр хүсэхэд цонхны шилэн дээр нааж харагдав. Түүнийг хаалгаа нээхэд энгийн хувцастай олон цагдаа нар зогсож байлаа.

“Би ийм юм болж байгаад итгэхгүй байна. Миний эхнэр намайг дөнгөж хаячихаад байгаа. Та нар дараа ирэхгүй юм уу?” гэж асуув.

Австралийн Холбооны цагдаагийн газрын Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн өмнөд бүсийн дарга, мөрдөгч түрүүч Кен Дей цагдаа нарын өмнө манлайлан зогсоно. Тэр хоёр бие биенээ сайн мэдэх боловч хэзээ ч биечлэн учирч байсангүй. Дей эхэлж ярив.

“Намайг хүлээж байсан гэдэгт би итгэлтэй байна. Миний нэр Кен Дей”.

Үнэндээ Мендакс болон түүний найзууд Холбооны мөрдөгч нарыг хүлээж байсан юм. Тэд хэдэн долоо хоногийн туршид цахим шууданг хөндлөнгөөс хянаж, цагдаа нар мөрөөр ойртож байгааг уншжээ. “Намайг хүлээж байсан гэдэгт би итгэлтэй байна” гэж Дей хэлсэн нь мэдээллийн урсгал бүтэн тойрч байсныг илэрхийлсэн хэрэг байлаа. Хакер цагдаа нарыг, цагдаа нар хакеруудийг хянаж байсан тойрог...

Айж балмагдсан мөртлөө Дей рүү харан зогсох Мендакс “Гэхдээ чи цагдаа гэхэд их намхан юм” гэж амандаа бувтнажээ.

“Үүнийг доромжлол гэж үзэх үү?” гэж ихэд гайхсан Дей асуув.

Гэвч энэ бол доромжлол биш байсан юм. Мендаксийн хажуугаар цагдаа нар түрэн орж ирэх хүртэл тэр маш ихээр цочирдсон байлаа. Мендаксийн оюун санаа дахин ажиллаж эхлэв.

Дискүүд, зөгийн үүр...

Зөгий сонирхдог тул Мендакс өөрийн зөгийн үүртэй байсан юм. Тэр зөгийнд их татагджээ. Тэдний гайхалтай нийгмийн тогтолцоог Мендакс харах дуртай байв. Хакердах үйл ажиллагаагаа нууцлахад тэдний туслалцааг тооцсон явдал таатай асуудал байлаа. Тэрээр хэдэн сарын туршид хакердах ажиллагаанд ашиглаж байсан дискүүдээ зөгийн үүрэнд хадгалжээ. 60,000 хатгууртай нисдэг хамгаалагч нар дискүүдийг хамгаалж байсан тул зөгийн үүр хамгийн таатай байрлал байв. АНУ-ын Агаарын Хүчний 7-р командын Пентагон дахь сүлжээний компьютерүүдийн эккаунт, пассвордыг хадгалах зорилгоор зөгийн үүр худалдан аваагүй боловч нилээд сайн нууцлах газар мэт санагдана. Ажиллаж байгаа зөгийнүүдийг гаднаас нь харах зорилгоор шилэн хаалт хийжээ. Зуны цагт цаг агаарын хамгаалагч материалыг шилэн дээр тавина. Цагаан өнгийн хуванцар тагийг шилэн хавтангийн ирмэг дагуу метал хавчуургаар тогтооно. Зөгийн үүрээ улам сайжруулах зуураа зөвхөн бал авах бус бас өөр хамгаалах орчин болгож ашиглах аргыг тэр сэджээ. Шил болон хуванцар хавтан хоёрын хооронд дискүүдийг эвтэйхэн шургуулав. Нимгэхэн завсарт дискүүд маш сайн таарч байлаа.

Тэрээр өдөр бүр дискүүдийг авч, буцааж хийх замаар зөгийнүүдийг Мендакс руу довтлохгүй байхад дасгажээ. Өөрийн гарын хөлсийг хусан цуглуулж, чихрийнуусмалтай холин чихэрлэг хөлсөнд зөгийг дасгаж байв. Байгалийн бусад дайсагнагч амьтны оронд өөртөө дасгахыг Мендакс хүсэж байлаа.

Гэтэл холбооны мөрдөгчид түүний гэрт ирсэн орой Мендаксийг гэмт хэрэгт холбогдуулах нотлох баримт болох дискүүд компьютерийн ширээн дээр задгай дэлгээстэй харагдана. Үүнээс илүү нотлох баримт гэж үгүй байх гэж Кен Дейд бодогдсон нь лавтай. Дискүүд дээр хэрэглэгчийн нэрс, энкриптэлсэн пассворд, эвдсэн пассворд, модем утасны дугаарууд, компьютерийн бусад системийн аюулгүй байдлын алдаанууд, Австралийн Холбооны цагдаагийн газрын мөрдөн байцаалтын дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг Мендаксийн хууль бусаар нэвтгэрч, олж авсан бүх зүйлс байлаа.

Зөгийн үүрэнд хадгалж байсан дискүүдээр Мендаксын асуудал хязгаарлагдсангүй. Түүний сүүлчийн өдөр хийсэн зүйлс дэлгэц дээр зурайн харагдана. Дэлгэц дээр 1500 орчим эккаунтууд, тэдний пассворд, он сар өдөр, бага зэрэг тэмдэглэл зэрэг байв.

Цагдаа болон “Telecom”-ийн хамгаалалтын албаны ажилтнууд гэр орныг нь нэгжиж байхад Мендакс ажиглаж зогсоно. Тэд компьютерийн зургийг нь дарж, дискүүдийг хураан, дараа нь хивсийг хуулж, модемтой холбоотой байсан телефон утасны зургийг видео камераар бичив. Мендакс ном их унших дуртай байсан учир түүний гэрийн номын санд байгаа бүх номнуудыг нэг бүрчлэн үзэж нотлох баримт хайжээ. Захиа, дэвтэр, гар бичмэл зэрэг нотлох баримт байж болох бүгдийг хураан авч байхад нэгэн цагдаа: “Энэ ажлыг хийхэд хэдэн цаг болсон ч хамаагүй ээ. Бид илүү цагаар ажилласны мөнгө авч байгаа. Тиймээс мөнгө их орж ирнэ гэсэн үг” хэмээн тоглоом хийж байв.

Мөрдөгчид түүний шинжлэх ухааны холбоотой сэтгүүлийг хүртэл хураан авч, нэг бүрчлэн шалгаж үзжээ. Магадгүй хаа нэгтээ үг тэмдэглэж, энкриптийн програмдаа хэрэглэхээр үлдээсэн байж болно хэмээн тэд үзсэн бизээ.

Мэдээж тэд “Олон улсын босогчид” нэртэй сэтгүүлийн ядаж нэг хувийг ч болов олохыг хүссэн байх. Цахим хэлбэрээр гарч байсан сэтгүүлийн хэвлэмэл ганц хуудсыг ч болов хайж бүх цаасыг онгичож байлаа. Түүний эд хөрөнгийг нягт шалгаж, компьютерийн өрөөг салгах нь холгүй байх зуур “Amigas”-ийн мэргэжилтэн ирлээ. Тэрээр Мендаксийг өрөөнөөсөө гарахыг хүсчээ.

Мендакс өрөөнөөс гарсангүй. Түүнийг баривчлаагүй болохоор цагдаа нар өрөөнд нь ямар нэгэн зүйл суулгахгүй байхад анхаарах хэрэгтэй байв. Тиймээс цагдаад хандан “Энэ бол миний орон гэр. Би энэ өрөөний хаа хүссэн газраа зогсох эрхтэй. Намайг баривчилсан үгүйг хэлээч” гэж тэр асуув.

“Чи баривчлуулахыг хүсээд байгаа юм уу?” гэж нэг цагдаа архиран асуулаа.

Мендакс ч чимээгүйхэн зөвшөөрөх үед Дей түүнээс байцаалт авахаар өөр өрөөнд дагуулан оров. Дей бага зэрэг жуумалзсанаа: “Тэгэхлээр баригдах ямар байна? Ноумын чамд хэлсэнтэй адилхан байна уу?” гэлээ.

Мендакс хөшсөн мэт сууна.

Түүнийг хэрхэн баривчилсан талаар Мендакт хэлсэн зүйлийг мэдэх хоёр арга зам Дейд байв. Ноум түүнд хэлсэн байж болно. Гэхдээ энэ бол боломжгүй зүйл. Учир нь Ноумын хакердсан хэрэг шүүх рүү шилжих арай болоогүй байсан, мөн Ноум цагдаа нартай найзлах үедээ ороогүй байсан юм. Эсвэл Холбооны мөрдөгч нар Мендаксийн хүрээний хакеруудын телефон утсыг нууцаар чагнаж байсан, тэндээс л “Олон улсын босогчид” бүлгийн гурвал цагдаа нарын хараанд өртсөн байх. Гурван хүн оролцсон утасны яриагаар Ноум Мендакс, Тракс нартай ярьж, өөрийн баривчлагдсан түүхээ хүргэсэн билээ. Дараа нь Прайм Саспектад Ноумын түүхийг Мендакс ярьж өгсөн юм. Нэг зүйлийг сэжиглэнэ гэдэг өөр асуудал. Харин Холбооны мөрдөгчдийн ахлагч ийм юм ярина гэдэг бүгдийг баталж байгаа хэрэг.

Дей халааснаасаа бичигч гаргаад ширээн дээр тавьж, асаагаад хэдэн асуулт асуулаа. Мендакс: “Бичигчгүйгээр яривал болох л юм” гэж хэлэхэд Дей бичигчээ шууд унтраав.

Мендакс маш чанга инээлээ. Цагдаа нар чинь сурвалжлагч биш шүү дээ. Цагдаагийн ажилтан болон сэжигтний хооронд бичлэг хийхгүй ийм яриа хэзээ ч болохгүй ёсгүй.

Мендакс хуульч руугаа ярихыг хүслээ. Тэрээр утсаар ажлын бус цагаар хуулийн зөвөлгөө өгдөг Алфалайн руу утасдахыг хүсэв. Дей ч зөвшөөрч, Мендакс руу телефон утас өгөхөөс өмнө шалгах гэтэл ямар нэг зүйл биш болохыг мэдэрчээ. Дей урд өмнө сонсож байгаагүй дунд зэргийн тасалдалтай дуу чимээг харилцуураас сонсов. Гэрт “Telecom”-ийн хоёр албан хаагчдаас гадна нилээд хэдэн цагдаагийн ажилтан байсныг эс тооцвол ийм хөгжилтэй утасны чимээг Дей сонсож байсангүй. Тэрээр Мендакс руу эгцлэн хараад: “Энэ барьцаалсан утасны шугам уу?” гэж асуув.

Барьцаалсан гэнээ? Дейн хэлсэн үг Мендаксийг бүрэн эзэмджээ. Шугамыг барьцаалсан гэж түүнийг сэжиглэж байгаа Дейгийн хэлсэн үгс бус харин шугамыг өөрчилсөн гэдгийг тэр мэдэхгүй байгаа шүү дээ гэж Мендакс бодно.

“Та мэдэхгүй байгаа юм уу?” гэж Дейг тэрээр шүүмжлэх аястай хэлэв.

Дараагийн гучин минутын туршид Мендаксийн телефон утсыг шүүрэн авч сонирхох Дей болон бусад ажилтнууд түүнийг ямар хорт явуулга хийх гэж байгааг лавлан тодруулахыг оролдлоо. Өөрийн утасны шугамыг мөшгих боломжгүй болгосон эсэх, эсвэл утасны шугамд ямар нэг аргаар дахин дамжуулах холболт хийсэн эсэхийг урт үстэй залуугаас тодруулахын тулд хэд хэдэн утасны дуудлага хийв.

Үнэндээ бол Мендаксийн утасны залгах дуудлагын чимээ бол ARE-11 телефон утасны залгах байгууламжийн жирийн л нэг дуу байсан юм. Бусад төрлийн утасны залгах байгууламжийн гаргадаг дуу чимээнээс ялгаатай юм. АХЕ мэтийн шатлан холбогдох утасны зангилаа байгууламж ялгаатай дуу чимээ гаргана.

Эцэстээ Мендаксыг хуульч руугаа утасдахыг зөвшөөрөв. Хакерийг нэг ч үг бүү ярь гэж хуульч сануулжээ. Цагдаа нар биедээ чагнах төхөөрөмж авч явж магадгүй мөн хакер юу ч яриагүй гэж цагдаа нар шүүхэд мэдүүлэх үүрэгтэй гэжээ.

Дараа нь хакераас мэдээлэл олж авах нөхөрсөг хандлагаар Дей: “Чи бид хоёрын хооронд л энэ яриа болж байна. Чамайг Мендакс гэдэг үү?” гэж асуув.

Чимээгүй байдал өрөөг нөмөрлөө.

Дей бас нэгэн тактикийг хэрэглэхийг оролдов. “Сүүлийн үед чиний нууц нэрийг хэрэглэдэг хүмүүс олширсон” гэж тэр хэллээ. Түүнийг хуурч байгааг Мендакс мэдэрсэн боловч ажиггүй зогсоно. Цагдаа нар түүний нууц нэртэй холбоотой нотлох баримт хангалттай цуглуулсан учир түүнд эсэргүүцэх шалтгаан байсангүй.

Дейгийн халаасанд сонирхол татсан өөр олон асуулт байв.

“За тэгэхлээр унтлагын өрөөнд чинь байгаа цагаан нунтагны талаар чи юу мэдэх вэ?”

Унтлагын өрөөнд байдаг ямар ч цагаан нунтагны тухай Мендакс санахгүй байлаа. Тэр мансууруулах бодис хэрэглэдэггүй юм. Улаан өнгийн хоёр багажны хайрцгийг цагдаагийн хоёр ажилтан авчирлаа. Мансууруулах бодисны тест хийдэг иж бүрдэл мэт харагдана. Бурхан минь. Намайг хэрэгт холбогдуулах ажиллагаа хийж байна гэж тэр бодлоо.

Цагдаа нар түүнийг унтлагын өрөөнд оруулан, вандан сандал дээр хоёр тууш шугам болгон татсан цагаан өнгийн нунтаг руу заав.

Мендакс тайван инээмсэглээд: “Энэ бол та нарын бодож байгаа зүйл бишээ” гэв. Цагаан нунтаг бол өөрийн хүүхдийн унтлагын өрөөний таазанд од зурахад хэрэглэж байсан хар цавууны бэлдмэл байв.

Хоёр цагдаа бие биерүүгээ хараад инээмсэглэж эхлэв. Тэд юу бодоод инээж байгааг Мендакс гадарлаж байлаа. Кокаин болон бусад мансууруулах бодис хэрэглэгч нар иймэрхүү түүхийг өдөр бүр хэлээд байдаггүй л байх.

Нэг цагдаа хөгжилтэйгээр инээснээ: “АМТАЛГАА!” хэмээн уулга алдав.

“Сайхан ч санаа биш байна даа” гэж Мендакс хэлсэн боловч түүний эсэргүүцэл нөхцөл байдлыг муутгахаас өөр нэмэр үзүүлэхгүй билээ. Цагдаа нар түүнийг өөр өрөөнд оруулаад цагаан нунтгыг өөрсдөө шалгахаар буцаж ирэв.

Мендакс Прайм Саспект руу яаж ийгээд мэдэгдэхийг хүснэ. Цагдаа нар “Олон улсын босогчид” бүлгийн гишүүдийг нэгэн зэрэг дайрсан байж болно, үгүй ч байж магад. Цавууг шалгаж байх зуур Мендакс харилцуур авч салж явсан эхнэртээ Прайм Саспект руу утасдан, анхааруулахыг гуйв. Тэр болон түүний эхнэрийн харилцаа хэцүүхэн байгаа хэдий ч эхнэр нь цааш утсаар ярих байх гэж тэр боджээ.

Мендаксийн эхнэр Прайм Саспект руу утасдах мөчид: “Тиймээ энд ч бас үдэшлэг болж байна хэмээн” хариу авсан ажээ.

Гал тогоондоо орж ирэхэд цагдаа нарын хураан авч байгаа зүйлс дээр шошго тавьж байгааг харангуутаа өөрийн мэдлээс гарах зүйлсийн тоо нэмэгдэж байгааг Мендакс мэдэв. Нэгэн

эмэгтэй цагдаа түүний принтерийг хөдөлгөх гэж оролдоно. Түүнийг туслахыг эелдэгээр гуйхад Мендакс хэлснээр нь хийлээ.

Үүрийн 3 цагт Мендаксийн гэрийг цагдаа нар орхив. Тэд гурван цаг гучин минут ноцолдсоны эцэст гэрээс нь 63 боодол зүйлийг хураан авсан боловч нэг ч гэмт хэрэгт буруутгасангүй.

Цагдаагийн энгийн машин сүүлийн эд зүйлийг ачаад хөдөлмөгц Мендакс гудамжинд гарч зогсов. Ойр орчинд нь хүн байгаа эсэхийг магадлаад ойр орших телефон утасны бүхээг рүү очиж Тракс руу утасдлаа. Тракс их сонин байдалтай яриад байлаа. “Аан, за, би мэдлээ”.

“Ямар нэг юм болоо юу? Чих их сонин яриад байна?” гэж Мендакс хэлэв.

“үгүй ээ. Юу ч болоогүй. Бага .. зэрэг ядраад... холбооны мөрдөгчид хэзээ ч.. ирж магадгүй байна...” гээд Траксын дуу тасрав.

Тэр асуудалд оржээ. Холбооны цагдаагийн мөрдөгчид Траксийн гэрт аль хэдийнээ ирээд 10 цагийн хугацаа өнгөрсөн байсан юм.

“Олон улсын босогчид” бүлгийн хакеруудад ял өгөх гэж гурван жилийг зарцуулсан билээ. 1991 оны 10-р сарын 29-ны өдөр Холбооны мөрдөгчид тэдний гэр оронд дайран орсноос хойш хакерууд ямар ч ажилд өргөдөл өгч болохгүй, найз нөхдөөс хол явах шаардлагатай болжээ.

1994 оны 7-р сард цахим шуудантай холбоотой үйлдэл дээрээ албан ёсоор ял авлаа. Олон жилийн туршид хүлээсэн хакеруудын амьдралд энэ хугацаанд нилээд өөрчлөлт оржээ.

Эхнэрээсээ салаад удаагүй байхдаа цагдаагийн довтолгоонд өртсөн тэрээр уур уцаар, дарамтанд орж, 1991 оны 11-р сарын дундуур эмнэлэгт хэвтэв.

Тэр эмнэлэгт хэвтэх дургүй тул эмч нараас гуйж, шаардсаар эмнэлгээс гарчээ. Тэр галзуурсан мэт байвч эмнэлэг түүнийг улам галзууруулж байсан юм. Тэр ээжийндээ амьдрахаар иржээ. Дараа жил бол түүний амьдралын хамгийн хэцүү үе байсан билээ. Нэгэнт орон гэрээ орхин явсан залуучууд гэртээ дахин очиход маш хэцүү байдаг ажээ. Богино хугацаанд бол тогтоно, удаан хугацаагаар бол хэзээ ч амжилт олж байгаагүй гэдэг. Мендакс гэртээ хэд хоног тогтсоны эцэст гадуур зугаалах болж, тэнгэрийн дор ил хэвгэж, нуга, голын эрэг, хотын захын хүнгүй газруудаар хоноглох болжээ. Заримдаа тэрээр хотод ойрхон ирж, Мерри Крикийн дархан цаазтай газраар шөнийг өнгөрөөнө.

Ихэнх цаг хугацаанд тэрээр Данденонгийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн Шербруукын ойд амьдарч байв. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн нилээд өндөрлөг газарт орших учир өвөлдөө Мелбурнийн бусад хэсгийг бодвол илүү хүйтэрнэ. Зун цагт шумуул тэвчихийн аргагүй байх тул Мендаксийн царай шумууланд хазуулснаас хавдаж улайсан явж байдаг байв.

Холбооны мөрдөгчид гэрт нь ирснээс хойш зургаан сарын турш Мендакс компьютерт хүрээгүй байна. Тэрээр өөрийн амьдралыг аажмаар, дахин босгож эхлэв. 1994 оны 7-р сард Австралийн Холбооны цагдаагийн газраас 29 гэмт хэрэгт буруутгасан цэнхэр хуудас ирэх үед

тэрээр хүүхдийнхээ хамт шинэ байранд орсон байв. Өөрчлөн шинэчлэлийн гэмээр хугацаандаа Мендакс хакерын хувиар бус харин найз нөхдийн хувиар Прайм Саспект болон Тракстай утсаар ярьж байлаа.

Прайм Саспект хакердаж байхдаа мансууруулах төрлийн бодис их хэмжээгээр хэрэглэж байгаагүй юм. Түүнд хар тамхи, охид, спорт хөөж байх цаг зав хомс байлаа. Цагдаа нар баригдсанаас хойш хакердахаа больж, хар тамхинд оржээ. 1992 оны 4-р сард анх удаагаа экстази хэрэглэж үзсэн Прайм Саспект есөн сарын турш хиймэл ертөнцөд өнгөрөөсөн ажээ. Тэр өөрийгөө мансуурах донтой болсон гэж үзэж байгаагүй ч хакердах авьяас сонирхлыг мансуурал орлох болов.

Хурд нэртэй нунтаг хамраар сорж, экстази үрэл амандаа шидчихээд Бямба гаргийн шөнийг дэмийрсэн мэт өнгөрөөнө. Бүхэл шөнийн турш, заримдаа бүр зургаан цаг зогсолтгүй бүжиглэнэ. Өглөө гэртээ харихад Ням гариг угтан авна. Долоо хоногт хэдэн удаа мансуурах зуршил тогтсон тэрээр илүү үнэтэй мансуурах бодист сатаарах болов. Сар, долоо хоног нисэх мэт өнгөрч байлаа.

Техно аянд бүжиглэх нь түүнийг солиоруулах дөхдөг байв. Мансуурсан үедээ бүжиглэхэд түүний оюун санаа бүрэн цэвэрлэгдэж, хөгжимд эзэмдүүлэх ажээ. Техно бол хөгжмийн ертөнцийг эвдэх хиймэл солиорол. Хурдан, давталт олонтой, компьютерээр үүсгэх цохилтууд хүмүүн төрөлхтний бусад аязыг хуу татан авах шиг болно. Тэр “Лоунж” нэртэй хотын клубт ирэх дуртай агаад хүмүүс дөрөв, таваараа л хүч муутай бүлэг болон наргина. Хүн бүр л видео дэлгэц дээрх хэзээ ч дуусашгүй гэмээр урсгал, олон өнгийн хэлбэр дүрсийг харж цагийг нөхцөөнө.

Прайм Саспект техно бүжгийн клуб руу явж байгаагаа ээждээ хэзээ ч хэлж байсангүй. Тэр найзындаа шөнийг өнгөрөөхөөр явж байна гэж хэлнэ. Мансуурч донтоогүй үедаа тэр “TAFE”-ийн компьютерийн шинжлэх ухааны курсэд явж, орон нутгийн супермаркетэд ажиллан долоо хоног бүр хэрэглэх экстазигийн 60 доллар, бүжгийн клубт орох 20 долларын төлбөрөө олж авна. Цаг хугацаа өнгөрөх тусам мансууруулах дон хөгжил цэнгэл авчирахаа болив. Нэгэн Ням гарагт тэрээр маш хатуу тамхи татсанаас хойш сэтгэлээр унаж, сэтгэцийн эмгэгтэй болжээ. Цагдаа нар түүнийг ажиглаж байгаа гэдгийг тэр мэдэж байлаа. Тэд түүнийг бүр эртнээс дагасан юм.

Байцаалтын үеэр түүний гэрт дайран орохоос хоёр долоо хоногийн өмнө AC/DC концертийг үзэхээр явснаас хойш цагдаа нар түүнийг хяналтандаа авсан гэдгийг тэр мэджээ. Прайм Саспект ямар хүмүүстэй үерхэж нөхөрлөдгийг Холбооны мөрдөгч нар мэдэхийг хүссэн гэж нэгэн ажилтан хэлжээ.

Одоо Холбооны мөрдөгчид түүнийг дахиад дагаж байгаа гэдэгт Прайм саспект итгэлтэй байв. Түүнийг хакердахаа больсон ч гэсэн нэг өдөр гэр рүү дайран орж ирнэ гэж тэр бодно. Гэхдээ энэ бол түүний эмээх шалтгаан биш байлаа. Муу зүйлийг зөгнөх нь логикгүй байсан хэдий ч өөрийн бодлоос хаях амаргүй байв.

Ямар нэгэн муу зүйл хэзээ нэгэн цагт болж л таарна. Айсуй байгаа ямар нэгэн том үйлдэл сэтгэлийг нь байнга шаналгаж, амьдрал нь утгагүй санагдаж эхлэв. Тэр сэтгэлийн дарамтанд

орсон учир нэг найз нь Аустин дахь эмнэлгийн сэтгэл зүйчид аваачиж уулзуулжээ. Цаашдаа сэтгэлийн дэмжлэг, зөвөлгөө авахыг зөв зам гэж тэр үзэв.

Сэтгэл зүйн зөвөлгөөгөөр түүний аавын үхэл, түүний ээжтэйгээ харьцах харьцаа, яагаад дотуур тамиртай болсон, хүмүүстэй тухтай ярилцаж чадахгүй байгаа шалтгаан, яагаад тэр хакердах болов, яагаад хакердах донтой болов, яагаад мансууруулах бодис хэрэглэх болов зэрэг олон асуудлыг нэг тийш болгоход тусалжээ.

Удалгүй хорин нэгэн настай Прайм Саспект мансууруулах донгоос хол боловч гар нь үл ялиг чичирдэг хүн болж хувирчээ. Тэр шинэ нээлт хийх замдаа оров. Холбооны цагдаагийн газраас тулгаж байгаа ял бол түүний хүлээж байгаа хамгийн хүнд зүйл байв.

Траксийн сэтгэл зүйн тогтворгүй байдал бүрэн эдгэрээгүй байжээ. 1985 оноос Тракс гэнэт айж цочирдох өвчнөөр шаналж байсан боловч мэргэжилтний туслалцааг авалгүй, асуудлаас зүгээр л зугатаасаар байлаа. Машины осолд орсны дараа түүний нөхцөл байдал улам хүндэрчээ. Тэр шөнийн цагт гэрээсээ гарахдаа ихэд айдаг болов. Машин жолоодох талаар бодоод ч хэрэггүй ажээ. Машинд сууж явахад нь хаалга онгойж, гадагш шидэгдэнэ гэсэн айдас түүнийг маш ихээр дарамтална. 1989 онд орон нутгийн сэтгэл зүйч тайвшруулах арга барилд суралцуулах болон ховсдолтоор фреакерийн сэтгэл санааг эмчлэхийг оролджээ.

Траксийн өвчин дахин шинэ сэтгэцийн фобиа руу хөтөлжээ. Тэр хөлгүй сансар огторгуйгаас айх боллоо. 1991 оны 10-р сарын сүүлээр цагдаа нар ирэхээс хэдэн өдрийн өмнө Тракс өөрөө утсаар ярих үед гэр орноосоо чөлөөтэй гарч чадахгүй болсон байлаа.

Өөр нэгэн фреакер түүний амь насанд заналхийлсний улмаас тэр цагдаа руу утасдаж дуудлага өгчээ. Ярих мэдүүлэг өгөх явцдаа өөрийн хакердах болон фреакинг хийх тухайгаа ярьж эхлэв. Тэр өөрийгөө илчлэхийг хүсээгүй боловч мэдүүлэг өгөх тусам илүү ихийг тайлбарлах хэрэгтэй болсон юм. Түүний санаа бодолд маш их зүйл эргэлдэнэ. Системд Мендаксын хийсэн аялалын улмаас “NorTel”-ийнхэн Прайм Саспектыг мөшгих болсныг тэр мэдэж байлаа. Прайм Саспект, Мендакс хоёр баригдахыг хүссэн мэт маш олон компьютерийн системийг хакердаж, идэвхитэй ажиллаж байсан юм.

Дараа нь аялах зам дагуу байгаа системүүдийг хуу хамах чадвартай хөнөөлт өтний програмыг бичих Прайм Саспектын төлөвлөгөө гарсан. Энэ үед уг санаа утсаар мөрөөдөн ярьсан санаа болохоос жинхэнэ төлөвлөгөө байгаагүй билээ. Хэдий тийм боловч Тракс түүний хэлсэн санаанаас ихэд эмээсэн гэдэг. “Олон улсын босогчид” бүлгийн гурван хакер асуудалд гүн гүнзгий орсон учир тэрээр бүлгээсээ гарах талаар бодох болжээ.

Тракс фреакинг хийхээ зогсоохыг оролдон, мөшгиж болдоггүй утасны дуудлага хийх боломжийг хаах зорилгоор шинэ телефон холболтын байгууламжийг ашигладаг утасны дугаараар солих хүсэлтийг “Telecom”-д тавьж байв. Түүнийг мөшгиж байгааг мэдэх юм бол хакердах болон фреакердах үйл ажиллагаагаа зогсооно гэж Тракс боджээ.

Тэр хэсэг хугацаанд хууль бус үйлдлээ зогсоосон байна. Гэхдээ компьютерт маш ихээр донтсон байсан учраас эрсдлийг үл тоон дахин ажилдаа оржээ. Хуучин холболтын байгууламжаас залгалт авдаг эгчийнхээ телефон утасны шугамнаас нууц кабель татав. Биеэ

барих чадваргүй түүний араншин өөрийг нь улам сул дорой, буруутан мэт болгожээ. Тэр одоо эрсдлийн талаар улам их бодож эхэлсэн үед алахаар заналхийлсэн явдал асуудлыг нэг тийш болгоход хүргэв. Тэр өөрийгөө яагаад цагдаад барьж өгснөө ч ойлгохгүй байлаа.

Викториа мужийн цагдаагийн газар Австралийн Холбооны цагдаа газарт мэдэгдэв. Яг тэр үед Австралийн Холбооны цагдаагийн газрын мөрдөгчид толгойгоо хайр найргүй балбаж байсан үе байлаа. “The Realm”-ийн бүлгийн хакеруудын дараа Австрали улсад гарсан компьютерийн гэмт хэргийг цэвэрхэн илрүүлэхийг тэд хүснэ. Тэдэнд нэрс, хаяг, утасны дугаарууд байна. Хакеруудын телефон утсыг тагнах зөвшөөрлийг авангуут бүх компьютерүүдийг хяналтандаа авч, хакеруудын бие биедээ хэлсэн бүгдийг баримтжуулж эхлэв. Дараа нь хяналтанд авагдсан этгээдүүдийн нэг нь цагдаа нарт өөрийгөө илчиллээ. Тэр залуу холбогдох цагдаагийн газар бус Викториагийн цагдаагийн байгууллага руу явсан байлаа. Гэнэтийн сэтгэлийн дарамт, заналхийллийн улмаас гүйгээд ирсэн нэгэн этгээд арван хоёр сар үргэлжилсэн “Цаг агаар” нууц ажиллагааг унагахад бэлэн болгов.

Австралийн Холбооны цагдаагийн газар хурдан хөдлөх хэрэгтэй болжээ. Хэрэв Тракс “Олон улсын босогчид” бүлгийн нөгөө хоёр хакертаа цагдаагийн газар дээр очсон тухайгаа мэдэгдэх аваас тэд өөрсдийн файлуудыг устгаж, ул мөрөө баллах аюултай байлаа.

Австралийн Холбооны цагдаагийн газрынхан Мендакс, Прайм Саспект хоёр дээр зочилсон шөнө тэд байцаалт өгөхөөс татгалзсан. Харин Тракс өөрийн гэртээ цагдаа нартай ярилцан хэдэн цагийг өнгөрөөсөн гэдэг.

Гэрээс нь авч Холбооны цагдаагийн төв байр руу явахаар заналхийлсний улмаас Тракс бүх үнэнээ ярьсан гэж “Олон улсын босогчид” бүлгийн бусад хакеруудад цагдаа нар хэлсэн ажээ. Айдасдаа дарагдсан сэтгэл хөдлөл нь түүнийг бүхнээ ярихад хүргэсэн байлаа.

Тракс хир зэрэг их зүйлийг цагдаа нарт ярьсныг Прайм Саспект, Мендакс хоёр мэдээгүй боловч бүгдийг нэгд нэгэнгүй хэлсэн гэдэгт итгэхгүй байв. Тэр хамтран зүтгэгчдийнхээ хакердах арга барилаас суралцахаас илүүтэй өөрийгөө даан ажиллах тал дээр анхаарлаа чиглүүлдэг байсан. Тэд Траксаас тусдаа байхыг хичээгээгүй боловч тэдний томоохон довтолгоонд гол байр суурь эзлэх хакер биш байлаа. Гэхдээ хакеруудыг баривчлахаас өмнөхөн бүлгийн хакеруудын ур чадвар маш их нэмэгдэж байгааг цагдаагийн мөрдөгчдөд Тракс хэлжээ. “Прайм Саспект, Мендакс хоёр бол хэн хэзээ ч хүрч байгаагүй томоохон зүйлийг хийсэн, өргөн хэмжээнд ажиллаж чаддаг хакерууд” гэж түүнийг хэлж байхад Холбооны мөрдөгчид тэмдэглэл хөтөлж байлаа.

Холбооны цагдаагийн мөрдөгчид дайралт хийснийхээ дараа мэдээлэгчээр элсүүлэхийг оролдсон гэж Тракс Мендакт хэлжээ. Тэд түүнд шинэ компьютерийн систем санал болгосон боловч татгалзсан гэж Тракс хэлсэн байна. Тиймээс “Олон улсын босогчид” бүлгийн хакеруудыг одоо хүртэл хянаж байна гэсэн сэжиглэл байгааг тэр мөн Мендакт хэлэв. Мендаксыг эмнэлэгт хэвтсэн гэж сонссон цагдаа нар ихэд санаа зовсон гэдэг. Чи нилээд их хууль бус үйлдлийг хийж байгаа учраас барихаас өөр аргагүй болсон, чи маш их систем дотор орж үймүүлсэн, одоо хяналтнаас гарсан учраас Холбооны мөрдөгчид гэрт тань очихоос өөр арга байгаагүй гэж Тракс тайлбарлажээ.

Хуульчийн өгсөн зөвөлгөөний дагуу 1991 оны 12-р сард байцаалт өгөхийг Мендакс зөвшөөрөв. Мендаксийг Кен Дей байцаах үед хакер илэн далангүй ярилцаж байлаа. Гэвч тэр Тракс, Прайм Саспект хоёрыг хэрэгт орооцолдуулахыг эсэргүүцэж байсан аж. 1992 оны 2-р сард Прайм Саспект байцаалгасан боловч найз хакеруудын тухай ярихдаа их болгоомжтой хандаж байв. 1992 оны 2-р сард Мендаксыг дахин байцаав. Харин Траксийг 8-р сард байцаажээ.

Түүний гэрт мөрдөгчид ирснээс хойш Траксийн сэтгэцийн хэвийн байдал ихээр алдагдсан байна. Сэтгэл мэдрэлийн олон эмчийн гараар дамжсан Тракс гэртээ сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийлгэх нь ихэсчээ. Удалгүй эмч түүнд эм бичиж өгдөг болов.

Гурван хакер утсаар ярьж, хааяа нэг уулздаг хэвээр байлаа. Хэн нэгэн нь ганц хоёр сараар алга болох авч удалгүй эгнээндээ нэгдэнэ. Тэд бие биендээ туслахын хажуугаар үзэл бодлоо хэвээр хадгалсаар байв.

Шуудангаар тэдэнд тулгасан ялын мэдэгдэл ирсний дараа бие биетэйгээ холбогдон харьцуулж үзжээ. “Надад хуульч хэрэгтэй болох нь” гэж Прайм Саспектад Мендакс утсаар ярина.

“Тиймээ, надад ч байгаа. Тэр бас хуульчдыг жагсааж байна.”

“Тэгээд сайн хуульч байна уу” гэж Мендакс асуув.

“Мэдэхгүй ээ. Байгаа гэж бодож байна. “Хуулийн туслалцаа” компанид ажилладаг нэгэн хуульч бий. Би түүнтэй хэдэн удаа уулзсан.”

“Хэн гэдэг юм бол?” гэж Мендакс асуув.

“Жон Маклоуфлин, Борис Кэйзер. Тэд Электроны хэрэг дээр ажиллаж байсан юм.”

Тракс, Прайм Саспект нар хэргээ хүлээхээр шийджээ. Тэд нэгэнтээ асар их нотлох баримт, телефон утасны бичлэг, мэдээллийн сан, хакердсан байгууллагын хэдэн арван гэрчийн мэдүүлэг, Telesom компаниас ирсэн гурван зуун хуудас материал байгаа учраас буруугаа шууд хүлээсэн нь дээр гэж үзжээ. Хууль ёсны бичиг баримт 7000 хуудсыг хол давжээ. Цагдаагийн байцаалтанд саад учруулахгүйгээр хамтран ажиллаж, буруугаа эртхэн хүлээвэл шүүгч харгалзан үзэх бөгөөд шүүх байгууллагын цаг мөнгийг хэмнэнэ гэж тэд үзэв.

Харин Мендакс тулгаж байгаа ялыг эсэргүүцэхээр шийджээ. Тэр Пад, Гандалф нарын хэргийн тухай сонссон аж. Тэдний илгээсэн мессэж нь маш тодорхой байлаа. Хэргээ хүлээ чиг шорон явна, эсэргүүцэн тэмц чиг эрх чөлөөтэй үлдэнэ.

1994 оны дунд үеэс 1995 оны хүртэл хугацаанд Прокурорын газраас тулгасан ял маш их өөрчлөгджээ. 1994 оны 7-р сарын 20-нд Траксын эсрэг тулгасан эхний ялнуудын тоо нь 1995 оны Валентиний өдрийн баярыг тохиолдуулсан мэт буурчээ. Тухайн үед Мендакс, Прайм Саспект нарын ял дээр “Телесом”-ын компьютерийг хакердсан үйлдэлд нь ял нэмж тулгав.

1995 оны 5-р сард гурван хакерт нийт 63 төрлийн ял тулгажээ. Мендаксд 31, Прайм Саспектад 26, Тракт 6-г оноов. “NorTel” компани хариуцагч талуудаас нөхөн төлбөр нэхэмжилж, хакеруудын учруулсан хохирол 160,000 долларт хүрсэн гэж мэдүүлжээ. Австралийн Үндэсний Их сургууль 4200 долларын хохирлыг нэхэмжлэв. Хууль бус аргаар байгууллагын худалдааны эсвэл бусад мэдээлэлд нэвтэрсэн, мэдээлэл оруулсан, нилээд хэдэн компьютерийн дата-г устгасан үйлдэлд ихэнх ялыг оноосон ажээ. Мэдээллийг устгасан үйлдэл нь хор хөнөөл багатай, хакердсан ажиллагааны зарим нотлох баримтыг цэвэрлэхтэй холбоотой үйлдлүүд байсан ажээ. Түүнчлэн гурван хакеруудыг “өдөөн хатгасан” хэлбэрээр бусдын компьютерт нэвтэрсэн үйлдэлд буруутгасан юм. “Олон улсын босогчид” сэтгүүлд бичсэн нийтлэлээрээ бусад хакер, фреакеруудыг хууль бус үйлдэл хийхэд өдөөн турхирч, мэдээллээр хангасан гэж мөрдөгчид үзжээ.

1995 оны 5-р сарын 4-ны өдөр Мендакс өөрийн өмгөөлөгч Паул Галбаллигийн хамт маргааш болох шүүх хуралд бэлдэж байв. Галбалли бол Мелбурнийн хамгийн нэр хүндтэй гэр бүлийн эзэмшлийн хуулийн фирмд ажилладаг, залуухан хуульч юм. Галбаллигийн ургийн бичгийг үзэж байхад хуулийг хэний хэн нь бичсэн вэ гэж хэлэхээр байлаа. Түүний аав Франк Галбалли алдартай хуульч хүн бөгөөд Викториа мужийн парламентын Сөрөг намын тэргүүлэгч, Жон Каиний засгийн газрын Хөдөлмөрийн яамны сайд байв. Ээжийнх нь талын өвөг эцэг Норман О Брайн Дээд шүүхийн шүүгч, түүний эхийн талын бас нэгэн авга мөн ижил албан тушаалд байжээ. Галбалли хүнийг шоронд хийхээс илүүтэй шоронгоос холдуулах санааг дэмждэг нэгэн ажээ.

Түүний гэр бүл ажилчин ангийн гаралтай, католик Ирландийн үр удам байлаа. Паул найман хүүхэдтэй айлын нэг агаад түүний аав нь мөн олон хүүхэдтэй айлаас гаралтай хүн байв.

Хуульчийн албан тасалгаанд Мендаксийг анх орж ирэхэд гучин дөрвөн настай эрүүгийн хуулиар мэргэжсэн өмгөөлөгч компьютерийн гэмт хэргийн тухай юу ч мэддэггүй байлаа. Викториагийн хуулийн туслалцаа үзүүлэх комиссоос өгсөн төлбөрөөс илүүг хялайгаж чадахгүй гэх ажилгүй Мендакс өөрт тохиолдсон бүхнийг Галбаллид тайлбарлажээ. Тэр хэрэг дээр ажиллахыг зөвшөөрөв.

Галбалли ба О’Брайн фирм эрүүгийн гэмт хэргээр мэргэжшсэн сайн фирмд тооцогддог байв. Худалдааны чиглэлийн фирмүүд заримдаа эрүүгийн хэрэг дээрх ажиллах боловч илүү ашиг орлоготой хуулийн ажлыг барьж авдаг. Гэмт хэрэгтнүүд их хэмжээний мөнгөтэй байх нь ховор. Барууны Уул уурхайн корпорациуд өөрсдийнхөө төлөө шилэн байшингийн тавьдугаар давхарт байрлах албан тасалгаанд бичиг баримтаа өгөөд сууж байдаг бол зэвсэглэсэн гэмт этгээд, хар тамхичинг дээрх орчин хүлээхгүй билээ.

Тавдугаар сарын 4-нд хийх Галбалли, Мендакс хоёрын уулзалт нэг цагийн дотор хийгдэхээр төлөвлөгджээ. Гэмт хэрэгт буруутгасан ялыг татгалзахаар Мендакс, Прайм Саспектын хамт шийдсэн. Харин Прайм Саспектын өмгөөлөгч Борис Кэйзер шүүх дээр тоглох шоууг удирдан болов. Галбалли, Мендакс хоёр Хуулийн туслалцааны комиссоос авч чадаагүй өмгөөллийн мөнгийг тэд хангалттай авч чадсан хэмээн Прайм Саспект хэлжээ. Тиймээс Мендакс шүүх хурал дээр өөрийн өмгөөлөгчтэй оролцох боломжгүй болов.

Мендакс үүнд татгалзсангүй. Хоёр хакерууд шүүх хуралд оролцох л болно. “NorTel” компаний

гаргасан нэхэмжлэлийг няцаах явдал тэдний хамгийн гол зорилго байлаа.

Мендакс, Галбалли нар албан тасалгаанд ярилцаж байхад бүх зүйл маш өөдрөг мэт санагдана. Мендакс шүүх хуралд амжилт гаргана гэдэгт итгэж байв. Дараа нь утас дуугарч Прокурорын газрыг төлөөлж байгаа хуульч Жеофф Четтль ярив. Четтльтэй ярилцаж байсан хуульчийн царай барайхыг Мендакс ажиглажээ. Тэр харилцуураа тавиад Мендакс руу түгшсэн байдалтай харав.

“Юу болов? Яав?” гэж Мендакс асуулаа.

Галбалли ярьж эхлэхээсээ өмнө санаа уртаар алдаад: “Прайм Саспект чиний эсрэг мэдүүлэг өгөх гол гэрч болжээ” гэв.

Та нар буруу ойлгосон байлгүй дээ. Мендакс өөртөө маш итгэлтэй байв. Магадгүй Прайм Саспектийн хэлсэн зүйлийг Прокурорын газар, Четтль нар буруу ойлгосон байх. Магадгүй Прайм Саспектын хуульчид асуудлыг өөр тийш эргүүлсэн биз. Ямартай ч эндүүрэл гарсан байлгүй дээ.

Прайм Саспект түүнээс нүүр буруулсан гэдэгт Мендакс итгэж чадалгүй Галбаллийн албан тасалгаанд суусаар байлаа. Тэр гарын үсэг зурсан батламжийг үзэх хүртэл хэнд ч итгэхгүй байсан юм. Тэр шөнөдөө Мендакс “За яахав, харж л байя. Магадгүй Четтль холион бантан хутгаж байгаа байх даа” гэж хэлжээ.

Харин Четтль тоглоогүй байлаа.

Түүний өмнө Прайм Саспектын гарын үсгээ зурсан гэрчийн батламж хэвтэнэ.

Бодит байдалтай эвлэрэхийн тулд Мендакс Мелбурнийн Шүүхийн танхимын гадна зогсож байлаа. Эхлээд тэнд хакердах нууцаа хуваалцсан Мендаксийн дөрөв, таван ойрын найзуудын нэг байсан. Тэр найз нь өнгөрсөн долоо хоногт алга боллоо.

Нөгөө талаар Прайм Саспект ба Кен Дей хоёр Австралийн Холбооны цагдаагийн төв байранд өдрийн 1:20-д, нэг өдрийн өмнө гарын үсэг зурсан, зургаан хуудас материал байна. Зургаан сарын турш Холбооны цагдаагийн газартай Прайм Саспект тохиролцож байсан гэж үү.

Дээрх хоёр асуудал түүний толгойд ээлжлэн бүжиглэнэ.

Шүүх хурал дээр Галбаллиг ирэхэд Мендакс байраа эзэллээ. Хор хохирол үзүүлсэн талаас авч үзвэл томоохон аюулд уначихгүй бололтой. Прайм Саспект ч хялбархан яваагүй байхаа. Тэр маш олон асуудлыг гаргаж ирэх боломжтой ч тэгсэнгүй. Цагдаагийн байцаалтанд өгч байхдаа хүлээн зөвшөөрсөн 31 үйлдлээ Мендакс аль хэдийнээ нотолжээ. Түүнчлэн тэрээр “Telecom” компаний телефон утасны холбох байгууламжийн дотор хийсэн аялалаа цагдаа нарт яриад амжсан байв.

Хэдийгээр Прайм Саспект Telecom-ын нэвтрэлтийг мэдүүлэгтээ нарийвчлан тусгасан ч засгийн газрын мэдэлд “Telecom” байсан учир телефон утасны байгууламжийг фреакердсан

ажиллагаа компанийг хуурсан бус харин нийгмийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж шүүгч үзэх болно. Прайм Саспект гол гэрчийн мэдүүлэг өгөх хүсэлтээ Холбооны цагдаагийн газарт өгсний улмаас 1995 оны 2-р сард “Telecom”-ын гэх шинэ ялыг нэмэхээр Прокурорын газраас шийдэв үү? Мендаксийнбодол ийм сэжиглэлд хүргэлээ. Өөр ч хувилбар алга даа.

Мелбурнийн Шүүх танхимд болох хурал сэтгэл зовоож эхлэв. Борис Кэйзер “NorTel”-ийн мэдээллийн системийн менежерийг няцаана гэдэг юу л бол. Галбалли богино хугацаанд өөрийн дүгнэлтээ танилцуулна гэдэг тийм ч амархан даалгавар биш билээ.

Мендакс танхимд байраа эзэлсний дараа Прайм Саспектыг харав. Тэр хуучны анд руугаа хурц, цоргим харцаар удаан ширтжээ. Прайм Саспект үл тоосон янзтай харц чулуудсанаа өөр тийш харцаа шилжүүлэв. Мендакс түүнд юм хэлэхийг хүссэн ч чадахгүй байсан юм. Прайм Саспект хэргийг шийдвэрлэж дуустал гар хүрэх газарт байхгүй байх журамтай ажээ.

Хуульчид шүүх танхимыг эзэгнэж гарлаа. Прокурорын газрын төлөөлөгч Андреа Павлека цонхгүй шүүх хурлын танхимд салхи татуулан орж ирээд нөхцөл байдлыг огцом өөрчлөв. Тэр эмэгтэй хүмүүст үнэхээр нөлөөлж чадаж байлаа. Өндөр, гуалиг, урт хөлтэй, алтан шаргал, буржгар эргүүлэгтэй үстэй тэр хүүхэн бага зэрэг шонтгор хамар дээрээ зузаан хүрээтэй нүдний шил тогтоожээ. Бусдын анхаарлыг татах цангинасан инээдтэй Андреа шүүхийн танхимд орж ирэхэд, баярын мишээл нүүрэнд нь тодорно. Тэр эмэгтэй түүний эсрэг талд байгаа нь даанч харамсалтай гэж Мендакс бодож байлаа.

Хурал эхэллээ. Прайм Саспект тавцан дээр зогсож, 26 компьютерийн гэмт хэргийн үйлдэлд буруутай гэдгээ хүлээв.

Хурлын явцад үйлчлүүлэгч нь “Telecom”-ын телефон утасны системийн зангилаа байгууламжинд нэвтэрсэн тухай Холбооны мөрдөгчдөд хэлсэн, цагдаа нартай хамтарч ажилласан гэж түүний өмгөөлөгч Борис Кэйзер тайлбарлав. Харин “Telecom” компанийхан тэдний утасны холболтын байгууламжинд хакер нэвтэрсэн гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа, зөвшөөрөхийг хүсэхгүй байсныг мөн адил уламжилжээ. Кэйзер өөрийн үйлчлүүлэгчийг үлгэр жишээч иргэн болгон магтах зууражиглагчдын суудалд суух Кен Дей нүдээ чимээгүйхэн эргэлдүүлэх ажээ.

Шүүгч Жон Тобин Прайм Саспектийн барьцааны хугацааг сунгаж, хамгийн сүүлд ял оноох шийдвэр гаргав.

Түүний асуудлыг авч хэлэлцсэний дараа танхимд байгаа хүмүүсийн анхаарал Мендакс руу шилжлээ. Жеофф Четтль прокурор босож, Сиднейгээс ирсэн “NorTel”-ийн менежерийг тавцан дээр гарч хэдэн асуултанд хариулахыг хүсжээ.

Четтль хүссэн үедээ хүнийг тайвшруулж, эсвэл сандрааж дөнгөдөг аж. Түүний хүнгэнэсэн дуу нь халзарч, шингэрсэн хэдэн үс, 40 орчим насны нар салхинд гандсан царайтай ихэд зохих мэт санагдана. Хурдан шилбэлзэх нүд, шулуухан дайрах арга барил нь олон өмгөөлөгчийн гаргадаг чухал царайг харуулж чадахгүй ажээ. Өмгөөлөгчийн хиймэл үс, болон нөмрөг түүнд зохихгүйгээс гадна сандлаас босох тоолонд хар малгай нь холбирон унана. Өмгөөлөгчийн хиймэл үс нь хайш яйш арзайн, хүүхэд шиг үсээ байнга янзлан татах Четтлийн

дүр зураг шар айрагны газар эсвэл хөл бөмбөгийн талбайд илүү тохирох юм шиг санагдана.

“NorTel”-ийн менежер тавцан дээр гарав. Гэрчийн үгэнд итгэж болно гэдгийг харуулах зорилготой хэдэн асуултыг Четтль асуугаад хакеруудаас нэхэмжилж байгаа 160,000 долларын хохирлыг тайлбарлажээ. Түүний даалгавар дуусаж, Четтль байрандаа суув.

Зургаан тохой өндөр Паул Галбалли эгцлэн босож, хүрмээ янзалж зогсохдоо бага зэрэг сэтгэл түгшсэн харагдана. 1960 оны загвартай зангиа зүүж, хар ногоон өнгийн хүрэм өмссөн хуульч маань шүүх танхимд сүр жавхлантай, даруухан сэтгэгдэл төрүүлж байв.

Эхлээд хэсэг түдгэлзсэн Галбалли өөртөө итгэл муутай харагдана. Магадгүй тэр WMTP файлууд, UTMР файлууд, PАССТ аудитс, Сүлжээний архитектор, IP хаягнууд зэрэг техникийн асуудлуудаас болж бага зэрэг сандарсан байх. Тэр нэг шөнийн дотор л энэ компьютертэй холбоотой мэдлэгийн үндсийг өөрийн болгох шаардлагатай байлаа. Сэтгэл зовнисон Мендакс түүнд тайлбар, асуух асуулт, тодорхойлолтуудыг сануулахыг оролдоно. Галбалли аажмаар өөрийн дүгнэлтийн хэмнэлийг олж, ажиллаж гарав. Шүүх танхимд байцаалт үргэлжилж байх зуур хамгийн эхний эгнээнд байгаа хүн Мендаксд арын эгнээнээс өгсөн хуйлсан цаасыг дамжууллаа. Мендакс цаасыг задалж, уншаад эргэн тойрноо харж инээв. Энэ бол Электрон байлаа.

Галбалли дүгнэлтээ дуусгаж байх үед “NorTel”-ийн менежерийн гаргаж тавьсан нотлох баримтуудын ихэнх нь няцаагдсан байв. Тэрээр гэрчийн дээр хар үүл хуруулж байх зуураа хакердах гэмт хэргийн талаар их зүйлийг мэдэхгүй гэдгийг “NorTel”-ийн менежерээр хэлүүлж дөнгөв. Тэр ч байтугай хэрэг гарах үед менежер тус компанид ажиллаж байгаагүй ажээ. Шууд эх сурвалжийн мэдээлэл дээр үндэслээгүй нотолгоог гаргаж, хакеруудаас 160,000 долларын хохирол нэхэмжилсэн явдал хууль ёсны бус мэт харагдаж эхлэв. 1991 онд тэр менежерээр ажиллаж байсан гэж үзсэн ч хакердсан хэргийн улмаас учруулсан хохирлыг нарийвчлан тодруулах техникийн мэдлэг чадвар байхгүй бөгөөд Unix-ийн аюулгүй байдлын багахан дадлага туршлагатайгаа “NorTel”-ийн менежер шүүх танхимд баталлаа. Өмгөөлөх ажиллагааны төгсгөлд Галбалли өмгөөлөгч “NorTel”-ийн менежерээс илүү мэдлэгтэй гэдгийг танхимд сууж байсан хэн ч гэсэн хэлж чадах байв.

Жеофф Четтль суудлаасаа босож, гэрчийг дахин асуух үед нөхцөл байдал аль хэдийнээ өөр тийшээ эргэсэн байлаа. “NorTel”-ийн менежерийн өгсөн мэдүүлэг бүрэн няцаагдсаныг Мендакс мэдэрчээ.

Шүүх хурал 5-р сарын 12-ны өдөр хүртэл завсарлав.

“Тэр залууг цаашид шүүх хурлын ажиллагаанд оруулах шаардлагагүй” гэж “NorTel”-ийн менежерийн тухай Четтль ярьж байхыг Мендакс шүүх хурлын дараа сонсжээ.

Энэ бол том ялалт байлаа. Түүний өмгөөлөгч “NorTel”-ийн гэрчийг няцаажээ. Гэхдээ олон даваа бий. Дараагийн шүүх хурал дээр прокурорууд “NorTel” компанийн аюулгүй байдлын багийн бусад гишүүд болон аюулгүй байдалд ноцтой хохирол учруулсан тухай 676 хуудас илтгэл бичсэн гэх Кларк Фергусоныг Канадаас авчирах болжээ. Тэдгээр гэрчүүд Unix систем хэрхэн ажилладаг, хакерын довтолгооны талаар анхан шатны мэдлэгтэй хүмүүс байх юм.

Тиймээс дараагийн удаад халуухан маргаан болно.

Нэг долоо хоногийн дараа хуваарь ёсоор Викториагийн шүүх танхимд Мендакс буцаж ирэх байв.

Хожим Галбалли ямар сонголт хийхийг хүсэж байгааг Мендаксаас асуужээ. Шүүх хурлыг дуустал явах, эсвэл “Олон улсын босогчид” бүлгийн бусад хакеруудын адил гэм буруугаа хүлээх үү? Тэр прокурорын газрын хандлага хэрхэн өөрчлөгдөхийг мэдрэхийг хүсэж байв. Хэрэв тэр гэм буруугаа хүлээвэл хатуурхах болов уу? “NorTel”-ийн менежерийн бүтэглэгүйтэл прокурорыг уур хилэнг бадраав уу?

Паул санаа алдаад, толгойгоо сэгсрэв. Прокурорын газрынхан үзэл бодол дээрээ хатуу зогсож байлаа. Тэд Мендаксыг шоронд илгээхийг хүсэж байв.

Прокурорын газрын баяр баясгалантай царайт Андреа Павлека цус харахыг улайрах мэт байжээ.

1995 оны 7-р сарын 21-ны өдөр буюу нэг сарын дараа Прайм Саспект ял авахаар Шүүх танхимд иржээ. Шүүх хуралд өмсөж очих хүрэм нь зүгээр эсэхийг магадлах Прайм Саспект маш их тавгүй байлаа. Түүний ээж нь өглөөний цайг нь бэлдэв. Шарсан гахайн мах, өндөг, талх өглөөний цайнд хэрэглэх дуртай гэж ээж нь бодох боловч бодит байдал дээр тэрээр Макдональдсын “Egg McMuffin”-д илүү дуртай ажээ. Тэр ээждээ хэзээ ч үүнийгээ дурсаж байсангүй.

Шүүх хурлын танхим хүнээр дүүрчээ. Сонин, телевизийн сурвалжлагч нар болон магадгүй өөр хэрэгт шийтгүүлэхээ хүлээж байгаа бусад хүмүүс байлаа.

Прокурорын суудал байх хэсэгт Кен Дей компьютерээ тогшин сууна. Харин түүний хажууд Жеофф Четтль, Прайм Саспектын өмгөөлөгч Борис Кэйзер нар цаас шагайн бэлдэнэ.

Мендакс танхимын арын хэсэгт байраа эзэлж, хуучны андаа харж суув. Нэг хэрэгт шалгагдаж байгаад хэргийг салгасан тул хамт гэмт хэрэг үйлдсэн хакер нь ямар ял авахыг Мендакс мэдэх шаардлагатай байв. Гэхдээ мөрдөн байцаалтанд туслалцаа үзүүлсэн гэдэг шалтгаанаар Прайм Саспект хөнгөн ял авч болох юм.

Прайм Саспектын ээж нь хүүгийнхээ найзуудтай сэтгэл түгшсэн байдалтай ярилцаж харагдана. Түүний найзуудын хэн ч хакерын хүрээнд хамааралгүй залуучууд байв.

Шүүх хурал эхэлж, хүн бүр байрандаа сууцгаалаа. Эхний ээлжинд Прайм Саспектын хэргийг авч хэлэлцсэнгүй. Өндөр биетэй, мөнгөлөг үстэй, тавь орчим насны хөх нүдтэй эрэгтэй хүн тавцан дээр гарч ирж байна. Сурвалжлагч нар тэмдэглэл бичиж эхлэнгүүт дажгүй хувцасласан энэ эрэгтэй хүн ямар гэмт хэрэг үйлдсэн болохыг Прайм Саспект тааж ядан сууна.

Хүүхдийг бэлгийн гэмт хэрэгт уруу татах.

Тэр хүүхдийг бэлгэсийн гэмт хэрэгт уруу татах гэмт хэрэгт өөрийн хүүгээ хохирогч болгожээ. Эцэг эхийн унтлагын өрөөнд, удаан хугацаанд давтан үйлдсэн гэж байна. Тухайн үед хүүхэд нь 10-аас бага настай байжээ. Түүний гэр бүл бүрэн сүйрчээ. Сэтгэл зүйн дарамтанд орсон хүү нь юм ярьж чадахгүй болтлоо айсан гэнэ.

Шүүгч Рассел Льюс тэр хүнд ямар ч уучлал үзүүлэлгүй таван жил, есөн сар шоронд хорих ял оноов.

Шүүхийн ажилтан Прайм Саспектыг дуудлаа.

Шүүхийн танхимийн хойно болж байгаа үйл явдлыг Мендакс сэтгэл догдлон харна. Эрүүгийн гэмт хэргийг шүүх ажиллагааны байгууллага хүүхдийг бэлгийн гэмт хэрэгт уруу татах гэмт хэрэгтэй хакерын гэмт хэргийг яагаад адилхан үзэж ангилдаг байна аа? Одоо хоёр өөр гэмт хэрэгт ял сонсох хүмүүс нэг шүүхээр орж байна шүү дээ.

Прайм Саспектын хэцүү амьдралын тухай нотлуулахаар олон гэрчийг Борис Кэйзер дууджээ. Тэдний нэг нь нэр хүндтэй сэтгэл зүйч Тим Ватсон-Мунро байв. Аустины эмнэлэгт эмчлүүлсэн Прайм Саспект шүүхэд хандан хүсэлт гаргасан тухай тэр ярилаа.

Хакердах ажиллагаа нь донтох үйлдэл гэсэн тайлбарыг шүүгч Льюс хурдан хүлээн авав. Прайм Саспектийн хакердсан зарим үйлдэл “героин цусанд шахсан”-тай адил байсан эсэхийг шүүхийн танхимд чанга асуусан юм.

Удаж төдөлгүй Кэйзер шүүх танхимыг эзэгнэгч дүр төрхөө бий болгон шүүмжилж гарав. Эхлээд тэр өөрийн үйлчлүүлэгчийг маш удаан хүлээлгэсэн Австралийн Холбооны цагдаагийн газрыг шүүмжиллээ. “Энэ залуугийн хэргийг зургаагаас арван хоёр сарын хооронд шийдвэрлэх ёстой байсан. Хорин настай байхдаа хүн амины хэрэг үйлдсэн хүний хэргийг Дээд шүүхээс 30 настай байхад нь хянаж үзээд 40 насанд нь хорин жилийн өмнө үйлдсэн хэрэгт ял оноож байгаатай зүйрлэж болно” гэж тэр хэлэв. Цагдаа нар түүний гэрт анх удаа очсоноос хойш Прайм Саспектын амьдралын 20 хувь нь үр бүтээлгүй өнгөрсөн байна гэж ам халсан Кэйзер дайрчээ. Дараа нь дуугаа улам өндөрсгөн: “Энэ залуу өсөж өндийх насандаа ямар тус дэм хүртээгүй, Тэр өсөж хүмүүжсэн бус зүгээр хөвж явжээ. Түүний ертөнц маш аймшигтай санагдаж байсан учир зөгнөлт ертөнц рүү татагдсан байна. Хүн амьтантай харьцах өөр арга замыг тэр огт мэдэхгүй билээ. Хакердах үйлдэл бол түүний сэтгэл хөөрлийн донтой яг ижилхэн. Хэрэв тэр кибернетик хурдны зам руу татагдаагүй бол одоо юу хийж явах байсан юм бэ? Гал тавих уу? Бусдын байрыг ухах уу? Түүний өөртөө өгсөн нэрийг хүртэл хар л даа. Прайм Саспект шүү. (Prime Suspect-гол сэжигтэн) Энэ нэр заналхийллийг өөртөө чиглүүлж байх шиг санагдана. Хүү компьютер дээр суухаас бусад цагт амьдралдаа ямар ч эрч хүчийг мэдэрч байгаагүй юм” гэв.

Түүнд шорон хорих ял эсвэл албадан хөдөлмөр хийлгэх ял оноох санааг шүүгч толгойноосоо авч хаяхыг Кэйзер хүсээд зогссонгүй, ямар ч буруу үйлдэл хийгээгүй гэж цагаатгахыг тулгаж байв.

Прокурорууд Кэйзерыг хөнгөхөн зугаа ярьж байгаа мэт үл ялиг инээмсэглэн харна. Тэдгээр хакеруудыг мөшгиж олоход Австралийн Холбооны цагдаагийн газрынхан олон сарыг

өнгөрөөж, түүнийг яллах дүгнэлт үйлдүүлэхэд бараг гурван жилийг авчээ. Харин одоо түүний өмгөөлөгч гол тоглогчийг ямар ч ялгүйгээр гарч явуулахыг хүсэж байдаг. Арай л хэтэрсэн дүгнэлт ажээ.

Ялыг эргэцүүлэн хянахаар шүүгч завсарлага авав. Тэр буцаж ирээд: “Хорих ял, Албадан хөдөлмөр хийлгэх ял үгүй. Гэхдээ 26 гэмт үйлдлийг нь цагаатгахгүй. Гурван жил үлгэр жишээч зан төлөвтэй байх барьцаанд 500 доллар, цагдаа нарын хураан авсан хуучны “Apple” компьютерийг торгуульд хураан авахыг тушаажээ. Түүнчлэн Австралийн Үндэсний Их сургуульд учруулсан хохирлын нэхэмжлэлд 2100 долларыг төлөх шийдвэр гаргасан” тухайгаа зарлав.

Түүний гэр бүлийнхэн, найз нөхөд нь инээд алдан, Прайм Саспект баярласандаа царай нь гэрэлтэнэ.

Хакер хэрэгт гол гэрч болсон учраас өгсөн ял хөнгөдсөн, тиймээс шүүх хамтран ажиллахыг Четтль сануулсан юм. Дараагийн бай болох Мендакс руу Прокурор хамаг анхаарлаа дамжуулах нь дамжиггүй. Энэ хэрэг дээр шүүхээс хамтран ажиллаа гээд ямар ч зүйлийг өөрчлөхгүй гэж шүүгч Льюс хэлэв. Шүүх танхимийн ард суух Мендакс гэнэт уйтгарт автлаа. Түүний хувьд сайн мэдээ боловч хоосон ялалт мэт санагдах ажээ.

Прайм Саспект бидний найз нөхөрлөлийг эвдсэн. Тэр өөрөө юу ч хийж чадаагүй гэж бодлоо.

Прайм Саспектийг ялласнаас хойш хоёр сарын дараа хакердах, фрекинг хийх зургаан үйлдэлдээ ял сонсохоор Тракс бас нэгэн шүүх дээр ирлээ. Хотод байхдаа уур уцаараа дарахын тулд эм ууж байгаа боловч тавцан дээр суухад түүний сэтгэл туйлын тавгүй байв. Хакерын бүлгийн бусад гишүүдийг бодвол хамаагүй цөөн тооны ял тулгуулсан Тракс бараг ялгүй өнгөрөх байх гэдэгт итгэлтэй байв. Гэвч түүний хуульч хэрэг дээр сайн ажиллахаас бас их зүйл шалтгаалах юм. Хэзээ ч эмхэлж амжихгүй гэмээр цаасан дунд суух Траксийн хуульч шүүх дээр ирж, нэг асуудлаар ахин дахин зүтгэнэ. Түүний дуу хоолой сонстох төдий гарч байсан учраас шүүгч чанга ярихыг зааварлажээ.

Шүүгч Мервин Киммийн гараас Тракс ял авахгүй өнгөрнө гэдэг худлаа хэмээн шүүх хурал болохоос өмнө прокурор Жеофф Четтль албан бусаар Мендакст хэлжээ. Шүүгч Кимм нилээд хахир шүүгчийн тоонд ордог байв. Хэрэв чи мөрий тавих дуртай бол ял тулгаж байгаа тал дээр мөнгөө тавьбал дээр гэж хүмүүс ярилцах ажээ.

Гэвч 1995 оны 9-р сарын 20-ны өдөр шүүгч юу бодож байгааг урьдчилан таамаглахад амаргүй байв. Прайм Саспектад оноосон ял, Траксын сэтгэл мэдрэлийн өвчний тухай зэргийг эргэцүүлж үзсэн шүүгч Траксыг ялаас чөлөөжээ. Түүнчлэн гурван жил зан араншингийн ямар нэгэн зөрчилгүй явах барьцаанд 500 долларыг авахыг тушаав.

Хакерын сэтгэл зүйн талаар сайн ойлголт багатай шүүгч Кимм бусад хүмүүсийг алмайруулахаар өгүүлбэр хэлсэн гэдэг. Тэр шүүх танхимд байгаа хүмүүст хандан: “хийсэн үйлдэлд хөнгөн ял оноохыг эхнээсээ зориогүй боловч ял оногдуулах асуудлыг шийдвэрлэхэд авч үзвэл зохих тусгай болон ерөнхий байдлаар асуудалд хандвал нөлөөлөх хүчин зүйл, шалтгаант ач холбогдол багатай байгаа юм” гэж тэр хэлжээ. Энэ бол сэтгэл мэдрэлийн өвчин

болон хакердах ажиллагааны хооронд зөрчилдөөн бага байгааг олж харсан Австралийн анхны шүүгчийн шийдвэр байх.

Мендаксийн хувьд Тракст оноосон ял чухал нөлөө үзүүлэв. 1995 оны 8-р сарын 29-ны өдөр компьютерийн гэмт хэргийн найман үйлдэлд гэм буруутайгаа хүлээсэн түүний үйлдлийг цагаатгажээ. Үүнээс бараг жилийн дараа 1996 оны 5-р сарын 9-ны өдөр нэмэлт арван нэгэн ялд гэм буруугаа хүлээж, зургаан үйлдлийг нь цагаатгасан байна. Прокурорынхон бусад ялыг хүчингүй болгожээ.

Хууль түүний талд зогсож байгаа гэж мэдэрсэн учраас Мендакс ANU, RMIT, NorTel, Telecom-той холбоотой зургаан гол ялыг няцаахыг хүсэж байв. Ял олгох дээр тулаад ирэхлээр хууль эрх зүйн орчин маш бүрхэг байсныг дурьдах нь зүйтэй. Дээд шүүхэд ирсэн хүсэлтээс үзвэл хууль эрх зүйн орчин болон шүүхийн талаас хоёуланг нь анхаарах шаардлагатай гэж дурьдсан байлаа.

Хоёр тал хоёулаа бодит факт баримт байгааг зөвшөөрсөн гэмт хэргийг шүүхэд хэлэлцэж байсан тохиолдол ховор боловч Викториа мужийн Дээд шүүхэд 1996 оны сүүлээр хүргүүлсэн асуудлууд ирээдүйн Австралийн хакердах гэмт хэргийн шийдвэрлэлтэнд шийдвэрлэх нөлөө үзүүлэх юм. “Компьютер рүү нэвтрэх оролт олж авна” гэж юу гэсэн үг вэ? Пассворд хэрэглэхгүйгээр хэн нэгэн этгээд бусдын компьютер рүү нэвгэрч чадах уу? Хэн нэгэн хүн хэрэглэгчийн нэрийг “guest” гээд пассвордыг нь “guest” гэж хэрэглэвэл юу болох бол?

Тэрхүү мэдээллийн санг үзэж харах ур чадвартай хүн, компьютерт хадгалагдаж байгаа мэдээлэлд хүрэх пассвордыг олж авсан үйлдлийг-тэрхүү мэдээллийн санд нэвтрэх оролдлого биш гэж үзэж болох уу гэсэн асуудал магадгүй хамгийн шийдвэрлэвэл зохих зүйл болоод байна. Хакердах ажиллагааны тухай бас нэгэн жишээн дээр авч үзье. Жишээлбэл Мендакс “NorTel”-ийн бизнесийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан компьютер рүү “log” хийж орсон хэдий ч тэдгээр файлуудыг огт уншаагүй бол “нууцаар нэвтэрсэн” эсвэл “бизнесийн нууц мэдээлэлд нэвтэрсэн” гэсэн гэмт хэрэгт яллаж болох уу?

Доод шатны шүүхийн ахлах шүүгч уг хэргийг Дээд Шүүхийн зөвлөлд хянуулж тайлбар хийлгэх нь зүйтэй гэж үзжээ. Франк Винсент, Кеннет Хэине, Жон Колдрей зэрэг Дээд Шүүхийн зөвлөлийн гишүүд хоёр талын хуульчдын хүсэлтийг нэн таатай хүлээж авсан юм.

1996 оны 9-р сарын 30-ны өдөр Дээд Шүүх дээр Мендаксийг ирэхэд түүний өмгөөлөгчөөс бусад хуульчид хуран цугларсан байлаа. Прокурорууд шүүх хуралд бэлдсэн хэдэн сарын ажлын үр дүн болох овоолоостой цааснуудыг гаргаж тавихыг харах Мендакс цагаа байн байн шагайна. Галбалли Дээд шүүхийн үүдний зузаан хивсэн дээгүүр нааш цааш алхална. Мендакс өмгөөлөгчөө хүлээсээр...

Мендаксын өмгөөлөгч хэдэн сая долларын маргаантай хэрэг дээр ажиллаж байгаа мэт амралтгүй ажиллажээ. Австрали, Англи, АНУ төдийгүй Барууны хэв загварын ардчилалтай дэлхийн улсуудад шүүхээр авч хэлэлцсэн адил төрлийн гэмт хэргүүдийг судлаж, компьютерийн гэмт хэрэгтэй холбоотой хууль эрхийн өргөн мэдлэгийг олж авчээ. Авьяас чадвар муутай хуульчид бүхий л амьдралаа зориулах шаардлагатай гэмээр хууль эрх зүй, философи, хэл шинжлэлийн хоорондын хамааралтай олон ойлголтууд байгааг тэр ойлгосон

байна.

Харин энэ хугацаанд тэр хаана байсан вэ? Галбалли гар утсаа халааснаасаа гаргаж албан тасалгаа руугаа тав дахь удаагаа залгалаа. Тэр муу мэдээ хүлээж авчээ. Өмгөөлөгч нь хэт их ядаргаанаас болж шүүх хуралд ирж чадахгүй боллоо гэсэн мэдээллийг дам эх сурвалжаас түүнд хэлэв.

Галбаллийн үс бараг саарал өнгөтэй болж байгаа мэт санагдана.

Шүүх хурал эхлэнгүүт Австралийн хамгийн нэр хүндтэй ахмад хуульчдын зөвлөлд хоёр өдрийн завсарлага авах шаардлагатай болсон шалтгаанаа Галбалли тайлбарлав. Прокурор Жеофф Четтль өмгөөлөгчийн гаргасан хүсэлтийг дэмжлээ. Гэвч үүнийг хамгийн хэцүү хүсэлт гэлтэй. Дээд шүүхэд цаг хугацаа бол ховор бөгөөд үнэт боломжид тооцогдоно. Аз болоход тэдэнд завсарлага авах зөвшөөрөл өглөө.

Техникийн мэдээллийг богино хугацаанд өөрийн болгох ухаалаг, сайн өмгөөлөгч олоход Галбаллид хоёр хоногийн хугацаа үлдлээ. Тэр Анджо Тиннейг сонгов.

Тинней өдөр шөнөгүй ажиллаж, Лхагва гариг буюу 10-р сарын 2-нд бэлэн болжээ. Хуульчид, хакер, сэтгүүлчид дахиад л шүүхийн танхимд цугларлаа.

Энэ удаад шүүгчид санаачлагыг гартаа авчээ. Тэд Дээд Шүүх хэргийг хянан авч үзэх шаардлагатай гэж яагаад үзсэнээ эхний нэг цагийн дотор тайлбарлахыг хоёр талаас хүслээ. Хуульчид бие биенээ гайхсан харцаар харна. Юу гэж хариулах вэ?

Хоёр талын товч маргааныг сонссоны дараа Дээд шүүхийн шүүгчид асуудлыг хэлэлцэхээр байрлалаа түр орхив. Тэднийг буцаж ирэхэд шүүгч Хэине зөвлөлийн шийдвэрийг уншиж танилцуулжээ. Шүүгчид хэргийг сонсохоос татгалзжээ. Дээд Шүүхийн шүүгчид зөвхөн энэ хэргээр зогсохгүй ирээдүйд ямар ч хэргийг ийм байдалтай оруулж ирэхийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг шүүгч тодорхой хэлэв. Компьютерийн гэмт хэрэг, аллага, залилан, ер нь ямар ч төрлийн хэргийг сонсохгүй гэж мэдэгджээ. Онцын шаардлагагүй бол бидэнд ийм төрлийн хэргийг бүү илгээгтүн гэж Доод шатны шүүхэд үүрэг болгосон байна.

Жеофф Четтль сандал дээрээ лагхийн сууж, гараараа нүүрээ таглав. Паул Галбалли гайхсан янзтай харагдана. “Би энэ хэргээс болоод сүүлийн хоёр өдөр өөрийгөө бараг алах шахсан юм. Та бүхэн сонсох ёстой!” гээд үсрэн харайхыг хүсэж байгаа мэт өмгөөлөгч Анджо Тинней зогсоно. Прокурорын газрын Андреа Павлекаг орлож шүүх хуралд ирсэн, чимээгүй даруухан Лесли Тейлор хүртэл гайхширсан байдалтай сууна.

Шийдвэр асар муу нөлөөг үзүүлэв. Доод шатны шүүгчид Дээд Шүүх рүү хууль эрх зүйн үүднээс тодруулга авах гэж ямар нэгэн хэрэг хэзээ ч илгээхгүй гэж эгдүүцнэ. Мендакс хууль эрх зүйн түүхэнд чухал хүнээр зүй ёсоор тооцогдох боллоо. Гэвч энэ бол түүний хүссэн зүйл биш билээ.

Мендаксын хэргийг Доод шатны шүүхэд дахин шилжүүлжээ.

Хуулийн туслалцаа үзүүлэх комиссын төсвийг хассан гэж зарласан учир өмгөөлөгч хөлслөх санхүүжилт олох найдваргүй болов. Төсвийг танасан явдал ядуу хүн гэм буруутан болгоход хүргэж, баячуудыг хуулийн хүссэн үйлчилгээ хүртэх боломжоор хангажээ. Өөрийн хэрэгт нь хандаж байгаа шударга бус байдлыг харгалзан үзэх үүднээс гэм буруутайгаа шууд хүлээн зөвшөөрч болохгүй байлаа. Түүнчлэн ирээдүйд хакердах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг ямаршуу хувь тавилан хүлээж байгаа нь сонин байв. Шүүгч нарын тайлбар өгөхөөс татгалзсан хуулийн утга санааг тодруулахгүй бол ирээдүйд шүүх, цагдаагийн байгууллагаас шударга хандлага хүлээх шаардлагагүй болжээ гэдэгт Мендакс итгэх болов.

Тэр 1996 оны 12-р сарын 5-ны өдөр үлдсэн зургаан үйлдэлд ял тулгажээ. Шүүх хурал дээр прокурор Жеофф Четтль оролцсонгүй, харин түүний оронд чимээгүй мөртлөө нөлөө ихтэй Лесли Тейлор ирэв. Мендаксийн өмгөөлөгчөөр Паул Галбалли өөрөө орж, үзэгчдийн суудлын хамгийн эхэнд царайнд нь ямар ч өөрчлөлт тодрохгүй Кен Дей сууж байв. Тэр бага зэрэг ядарсан харагдана. Түүнээс хэдэн эгнээний ард Мендаксийн ээж сэтгэл түгшсэн байртай сууна. Электрон арын суудал дээр аажуухан суух зуураа Мендакс руу үл ялиг инээмсэглэж байв.

Хижээлдүү насны, улаан царайтай, өтгөн саарал хөмсөгтэй шүүгч Росс өөрийнхөө сандал дээр суужээ. Эхлээд тэр хэргийг шүүхийг хүсээгүй учир тун дурамжхан байв. Хэрэгтэй анх танилцаж байсан шүүгч Кимм, Льюс нарт Мендаксийн хэргийг буцаах ёстой гэж тэр бодох ажээ. Шүүгч Росс шүүх хурлын танхимд өглөө ирэхдээбусад шүүгчид хакеруудад ямар ял оноосон талаар огт уншаагүй байлаа.

Лесли Тейлор нөгөө хоёр хакерт өгсөн шийтгэлийг товч танилцуулав. Шүүгч нэг их таагүй янзтай харагдаж байлаа. Эцэст нь энэ хэргийг би шийднэ гэж тэр зарлав. “Хоёр шүүгч энэ хэргийг шийдэхэд оролцсон байхад яагаад гурав дахь шүүгч нэмэгдэж болохгүй гэж? Тэр зохих түвшинд шүүх хурлыг хийх байлгүй” гэж боджээ.

Галбаллын сэтгэл зовниж байлаа. Бага үд дөхөж ирэнгүүт тэр нилээд сандарсан шинжтэй харагдана. Бүх зүйл түүний хүссэнээр явагдахгүй байв. Шүүгч Росс хорих ялыг илүүд үздэг болохоо аль хэдийнээ тодорхой илэрхийлсэн юм. Ял онооход ялгаварлан гадуурхахгүй байх зарчим Мендаксийн цорын ганц хамгаалалт мэт санагдаж байв. Прайм Саспект, Тракс хоёр Мендакстай адилхан гэмт хэрэг үйлдсэн учир ижил ял оноох ёстой.

Прайм Саспектыг шийтгэхдээ Шүүгч Льюс хэрхэн хандаж байсныг Росс гайхшран уншина. Бусад шүүгчдийн оноосон ялыг үзвэл ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хүрээнээс хэтэрсэн байна гэж тэр Лесли Тейлорд хэлэв. Бусдын оноосон ялаас яагаад өөр ял оноох хэрэгтэй байгаа шалтгааныг Тейлороос лавлана.

Телефон утасны яриаг нууцаар тагнасан тухай товч танилцуулгад огт дурьдаагүй байна гэж шүүгч хэллээ. Үнэндээ бол шүүгч зөвхөн хийсэн үйлдлийн товч жагсаалтыг уншсан байв. Тейлорыг “Олон улсын босогчид” гэж дурьдахад шүүгч “Тэр чинь юу билээ?” гэж асууна.

Дараа нь “фреак” гэдгийг яаж үсэглэх вэ гэж Тейлороос лавлаж байв.

Тэр өдрийн үдээс хойш шүүгч Росс бусад шүүгчдийн өгсөн ялыг бүрэн уншиж танилцсаны

дараа, Прайм Саспектэд өгсөнтэй адилхан ялыг Мендакт оноож, “АНУ” –ийн 2100 долларын хохирлыг барагдуулах, гурван жил ёс суртахууны доголдол гаргахгүй байх барьцаагаар шийтгэжээ.

Тэнд хоёр өөр хувилбар оршиж байлаа. Прайм Саспект ба Тракс хоёр ёс суртахууны доголдол гаргахгүй байхаар 500 долларын барьцаа өгөх шийтгэл оноосон бол Мендаксыг шүүгч Росс 5000 доллар барьцаанд өгөх шийдвэр гаргасан юм. Цаашлаад шүүгч Льюс 2100 долларын нөхөн төлбөрийг арван хоёр сарын дотор төлөх үүргийг Прайм Саспектэд даалгасан бол Мендаксыг гурван сарын дотор төлбөрийг барагдуулахыг шүүгч Росс даалгажээ.

Шүүгч Росс: “Би урд өмнө яригдсан зүйлийг давтах хэрэгтэй боллоо. Та бүхний хийсэн үйлдэл шоронд ял эдлэх ёстой гэмт хэрэг гэж би бодож байгаа хэдий ч анхаарч үзэх бусад нөхцөл байдлын улмаас ялыг өөрчлөхөд хүргэв. Чиний хамтрагч хакеруудад өгсөн ял шийтгэл тэрхүү үзэл баримтлалыг өөрчлөхөд хүргэсэн шүү” гэж Мендакт хэлжээ. “Боловсрол мэдлэг өндөр хүмүүс ийм ааш араншин гаргах учиргүй. Чиний хийсэн үйлдлийг зөвхөн ухаантай, агуу хүмүүс хийдэг гэдэгт би итгэж байгаа” гэж тэр эцэст нь дүгнэжээ.

Харин “донтох” гэсэн үг ялын тогтоолын хаана нь ч харагдаагүй гэдэг.

Аравдугаар бүлэг

“Антракс буюу Гадны этгээд”

“Тэд миний толгойд буу, нуруунд хутга тулгасан. Намайг битгий оролдооч дээ”

Midnight Oil хамтлагийн Blue Album-д орсон “Powderworks”-оос иш татав.

Антракс багаар ажиллах дургүй ажээ. Бусад хүмүүст хамгийн сул шинж байдаг гэж тэр үзнэ.

Хэдийгээр хүмүүст бүрэн итгэж болохгүй ч тэр олон хакер, фреакеруудтай нийгэмшиж, тодорхой төслүүд дээр хамтран ажилласаар ирсэн юм. Гэвч тэр хэн нэгэнтэй маш ойр дотно харьцаа хэзээ ч үүсгэж байсангүй. Түүний найз хакер цагдаад нууцаар мэдэгдлээ ч гэсэн түүний ямар үйл ажиллагаа явуулж байгааг бүрэн мэдэх боломжгүй. Түүнчлэн ганцаардал найз нөхдийн асуудлыг тодорхой нэгэн хэмжээгээр шийдчихдэг гэхэд болно. Антракс Викториагийн жижигхэн хотод амьдардаг байв.

“Realm” мэтийн хакеруудын түншлэлд хэзээ ч нэгдэж байгаагүй Антракс хүмүүстэй харьцах дуртай, тэр ч байтугай утсаар хэдэн цагийн турш ярина. Заримдаа хилийн чанад дахь мэргэжил нэгт фреакер найзуудаас олон улсын ярианы дуудлага өдөрт арав гаруй удаа хүлээн авах тохиолдол ч бий.

Антраксын ээж хаалганы завсраар шагайж, хөмсгөө өргөснөө Антракс руу толгой дохин: “Чамтай хүн ярина гэж байна. Дани улсаас ярьж байна лээ” гэж хэлнэ. Эсвэл Швед, Финланд, АНУ дэлхийн хаанаас ч хамаагүй дуудлага ирнэ. Олон орноос ярьж байгаа нь хачирхалтай санагдах боловч эцэг эх нь энэ тухай хэзээ ч сонирхожбайсангүй. Гэртээ олон улсын дуудлага хүлээн аваад байдаг хүүхэд хотоос зайдуу газар олон байхгүй бизээ. Гэхдээ л олон хүүхдүүд мастер фреакер болж чадсан байдаг.

Антракс гэрийн утасны системд дуртай тэгээд ч хүч чадлыг нь сайн мэднэ. Дэлхийн хаана ч байгаа найзууд руугаа утсаар үнэгүй ярих боломжтойг олон фреакерууд мэдэх билээ. Эсвэл гэрийнхээ утасны шугамыг мөшгилтөөс холдуулахын тулд утасны сүлжээнд хакердах ажиллагаа хийнэ. Харин Антраксын жинхэнэ хүч чадал дэлхийн эргэн тойронд хүмүүсийн яриаг дамжуулж байдаг дуут харилцаа холбооны системүүдийг удирдахад оршиж байсан юм. Тэрээр хүмүүсийн дуут шуудангийн хайрцаг дахь мессэжийг үзэж юу хийж байгааг нь судална. Мөн телефон утасны яриаг сонсохыг хүсэж байлаа. Түүнчлэн телефон утасны системийг дахинпрограмчилж, үйл ажиллагааг нь өөрчлөх, бүр ажиллахгүй болгож сурахыг хүснэ. Энэ бол бусад хүмүүсийн анхаарал нь гойд татагдах жинхэнэ эрх мэдэл байсан юм.

Антраксын эрх мэдлийн хойноос хөөцөлдөж эхэлсэн үе өсвөр насанд нь тохиолджээ. Тэр бүгдийг харж, мэдэхийн төлөө юуг ч хийхээс буцахгүй агаад гадаад орнуудын ер бусын системүүдээр тоглохыг тэсэн ядан хүлээнэ. Түүнд систем бүрийн зорилго, юунаас болж дуу чимээ үүсдэг болон тэд хэрхэн холбогдон ажилладаг болохыг мэдэх шаардлагатай байлаа. Утасны систем хэрхэн ажиллаж байгааг бүрэн ойлговол түүнд хүссэнээ хийх боломжийг олгоно.

Тэр хар багаасаа телефон болон хакердах ажиллагааг сонирхсон байна. Түүнийг арван нэгэн настай байхад аав нь “Дайны тоглоом” киног үзүүлэхээр авч явжээ. Кино театраас гарч ирэхэд түүний бодлыг зөвхөн хакердаж сурах хүсэл эзэмдэж байв. Эцэг эх нь төрсөн өдрийн бэлэг болгож “Sinclair ZX81” нэртэй нэг килобайтын санах ойтой хамгийн энгийн компьютер авч өгснөөр Антракс ер бусын хүслээ хөгжүүлэх боломжтой болов. Зах дээр байдаг хуучин номын дэлгүүрээс Антракс хакердах тухай хэдэн ном олж авав. Тэр Билл Ландретийн “Дотоод Тойрог”, Стевен Левигийн бичсэн “Хакерууд” номыг маш сайн судалжээ.

Арван дөрвөн настай байхдаа Форс гэж нэрлэдэг Мелбурн хотод байрлалтай хөвгүүдийн бүлэгт Антракс нийллээ. Уг бүлгийн гишүүд “Commodore 64” ба “Amiga” цахим тоглоомын програм солилцоно. Түүнчлэн гишүүд компьютерийн богино програмууд, өөрсдийн демо танилцуулгуудыг бичихийн хажуугаар цахим тоглоомын хуулбарлахыг хориглосон програмуудыг хакердаж, дэлхийн бусад програм эвдэгчдэд арилжиж байв. Тэд яг захидлаар харилцдаг олон улсын бүлэг адил ажиллаж байлаа. Хамгаалсан програмыг эвдсэн Антракс маш их сэтгэлийн таашаал авах болжээ. Түүний ер бусын хоббиг жижиг хотын хэдхэн хүүхэд л хуваалцаж байсан юм. “Форс” бүлэгт нэгдсэнээр тэр цоо шинэ ертөнцөд хөл тавьсан билээ.

Фреакинг хийх талаар анхны материалаа уншсаны дараагаар Антракс Америкт байдаг нэгэн найзаасаа шинэ ажиллагааг хэрхэн эхлэх талаар зөвлөлгөө асуужээ. Түүний найз нь Австралиас Америкийн операторуудтай холбосон “AT&T” утасны картны дугаарууд ба шууд залгах үнэгүй лавлагааны дугаарын жагсаалтыг илгээв. Хүчингүй болж, хугацаа нь дууссан картны дугаарууд Антракст хэрэгтэй байжээ. Хамгийн гол нь Номхон далайг гатлан Америк дахь оператор руу үнэгүй утасдах нь туйлын чухал байв. Антракс найзынхаа өгснөөс илүү тусгай дугааруудыг хайж олохыг хичээв.

Тэрээр өөрийн гэрийн ойролцоо байх төлбөрт утасны хажууд өдрийг өнгөрөөнө. Гэр орчмын газар нь тохижолт муутай боловч Антракс үнэгүй үйлчилгээтэй утасны дугаарууд руу залган гараар скан хийж, төлбөртэй утасны хажууд хэдэн цагийн турш зогсоно. Тэрээр олон улсын үнэгүй утасны дугаарын эхлэл 0014-ийг залгаад дараа нь хэдэн тоо цуглуулна. Удалгүй тэрээр илүү аргачилсан байдлаар ажлаа үргэлжлүүлэв. Антракс 300,400 мэтийн дугаарыг сүүлийн гурван дугаар болгон сонгожээ. Дараа нь дугаарыг нэг нэгээр нэмж залгана. 301,302,303,304. Ажиллаж байгаа утасны дугаарт холбогдонгуут нямбай тэмдэглэж авна. 0014-ээр эхэлсэн бүх утасны дугаар үнэгүй учир түүнд нэг цент ч үрэх шаардлага байсангүй.

Антракс хүчинтэй байгаа дугаарыг олсон боловч тэдгээр дугаарын ихэнх нь нөгөө үзүүртээ модемтой байлаа. Тиймээс илүү ихийг нээн судлахын тулд өөртөө модем авахаар шийджээ. Хууль ёсоор ажиллах насанд хүрээгүй байсан учраас худлаа ярьж, насаа нэмэн, компьютерт мэдээлэл оруулдаг ажилд сургууль тарснаас хойш ажиллах болов. Зав чөлөө гарах бүрийд л төлбөртэй утасны хажууд цагийг өнгөрөөх Антракс оператор хариулдаг дугаарууд болон үнэгүй модемны дугаарын жагсаалтаа баяжуулсаар байлаа.

Утасны дугаар руу залгаж скан хийх ажил нь түүний муу зуршил мэт болжээ. Тэр төлбөртэй утасны хажууд оройн 10 эсвэл 11 цаг хүртэл зогсох болов. Төлбөрт утасны дугаарыг эргүүлж залгадаг учир түүний ажилд хүндрэл учруулна. Заримдаа түүний хурууны өндөг цэврүү үсрэх нь жирийн үзэгдэл болжээ.

Нэг сар гаруйн дараа тэр үндсэн ажлаа эхэллээ. Тэр модем авахад хангалттай мөнгө хадгалжээ.

Антракс ээжийнхээ нөлөөгөөр улсын сургуульд 10-р анги хүртлээ явжээ. Ээж нь түүнийг боловсролтой хүн болгож, өөрийнхөө үзэж амжаагүй зүйлийг гарт нь атгуулахыг хүсэж байв. Антраксын ээж сэтгэл мэдрэлийн эмнэлгийн сувилагч ажилтай бөгөөд хүүгийнхээ “Commodore 64” компьютерийг 400 доллараар авч өгөхийн тулд олон сарын турш цалингаа хуримтлуулжээ. Анхны компьютерээс хойш хэдэн жилийн дараа 1989 онд илүү хүчирхэг “Amiga” компьютер авахын тулд зээл тавьсан хүн бол бас л ээж нь байлаа. Тэр өөрийнхөө хүүг маш сэргэлэн гэж үзнэ. Хүү нь анагаахын сурах бичиг уншиж ээждээ харагдах боловч компьютер түүний ирээдүй гэж ээж нь хэзээ ч бодохгүй байв.

Антракс 7-10-р ангидаа бусдаас илүү сайн суралцжээ. Гэхдээ түүний дуртай хичээл математик биш байв. Тэрээр зургаадугаар ангид байхдаа барилгын өндрийг хэмждэг дүүжлүүрт багаж зохиож шагнал авч байлаа. Гэвч Антракс 10-р ангиас хойш сургуульд яваагүй юм. Багш нар түүний мэддэг зүйлийг ярина, эсвэл ном уншаад хурдхан мэдчих зүйлийг давтан ярьдаг гэж үзнэ. Хэрэв судлах сэдэв түүнд таалагдвал номын сан руу яваад уншихна гэж Антракс боддог байлаа.

Тухайн үед ар гэрийн нөхцөл байдал нилээд хүндэрч ирэв. Англиас Австралид нүүж ирсэн цагаас хойш түүний гэр бүлийн амьдрал хүндхэн байлаа. Тэр үед Антракс 12 настай байсан бөгөөд гэр бүл нь санхүүгийн хувьд тогтвортой болох, орон нутгийн жижигхэн хотын хүнд хэцүү нөхцлийг даван гарах шаардлага тулгарав. Энэтхэг гаралтай Антракс, түүний дүү, ээж нар арьс өнгөөр ялгаварлахын эсрэг сөрөн зогсох ухаан юунаас ч илүү хэрэгтэй байлаа.

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, гарал үүслээр нь доромжлох хандлага жижигхэн хотод эрээ цээрээ алдсан байв. Үндэстний цөөнх болсон зарим нэг нь тэднийгүзэн ядах этгээдийн хувийн эзэмшил рүү санаандгүй цөмрөн орж, өөрийн орон байраа барьчихвал асуудал хүчирхийллээр дуусах нь энүүхэнд. Хөлбөмбөгийн тэмцээн зодооноор дуусдаг жижигхэн хот гэж тэдний амьдрах орчинг тодорхойлж болох байв. Энэтхэг, Британий цус холилдсон хөвгүүн хатуу эцгийн гараар өсөхөд амаргүй байжээ.

Английн цагаан арьст гэр бүлээс гаралтай Антраксийн аав нь таван хүүхэдтэй айлд өсөж хүмүүжсэн гэдэг. Тэрээр газар тариалангийн коллежэд байхдаа Энэтхэг оюутантай танилцан ханилсан бөгөөд орон нутгийн сонин дээр “Англи эр Энэтхэг хүүхэнтэй хуримлав” нийтлэл гарч, тэдний амьдрал нилээд ээдрээтэй эхэлсэн ажээ. Энэ бол аз жаргалгүй гэрлэлт гэж үзэх аав нь яагаад Энэтхэг хүүхэнтэй гэрлэсэн юм бэ? гэж Антракс гайхдаг байв. Магадгүй тухайн үед дурласан байх. Эсвэл зүгээр л дээрэлхэж, хянах боломжтой хүүхэн түүнд хэрэгтэй байж. Ямар учир шалтгаантайгаас үл хамааран цус холилдсон гэр бүл нь хамаатан садны цугларалтаас холхон байлаа. Антраксын өвөөгийн утгагүй шийдвэрийн ачаар энэ бүхэн тохиолдсон юм. Түүний гэр бүл Австралид шилжин ирэх үед мөнгөөр хомс байв. Төд удалгүй аав нь Мелбурнийн Пентридж шоронд ажилд оржээ. Амьдралын хэрэгцээг хангахуйц цалин авдаггүй боловч тэр ажилдаа дуртай мэт санагдана. Ээж нь сэтгэл мэдрэлийн эмнэлгийн сувилагчаар ажиллаж эхлэв. Санхүүгийн тогтвортой байдал бий болсон хэдий ч Антраксын гэр бүлийн дотоод харилцаа хүйтэн хөндий байлаа. Аав нь эхнэр, хөвгүүдээ үл хүндэлнэ, харин Антракс аавыгаа эс тооно.

Антракс өсвөр насны хөвгүүн болж эхлэх тэр үед аав нь нилээд дарамт үзүүлэх болов. Долоо хоногийн амралтын өдрүүдэд ажлаасаа ирсэн аав нь Антраксыг цохиж, хааяа шалан дээр унагаан зодох болжээ. Биеийн хүчирхийллээс зайлсхийхийг Антракс оролдох боловч шоронгийн ажилтны гараас мултарч эс чадна. Хэцүү аавын хажуугаар хотын хэцүүхэн амьдрал бодит эсэргүүцэл шаардах ажээ.

Антраксыг арван таван настай байхад нэгэн өдөр гэрт нь маргаан гарав. Гэртээ оронгуутаа Антракс эцэг эхийн унтлагын өрөөг чиглэжээ. Түүний ээж нь сэтгэлээр унаж, түгшсэн янзтай сууж байв. Харин ойр хавьд аав нь харагдсангүй. Аав нь зочны өрөөнд зөөлөн орон дээр хэвтгээд телевизор үзэж байлаа.

Тэрээр аавыгаа үзэн ядаж гал тогоо руу буцан орлоо. Удалгүй аав нь идэх зүйл авахаар гал тогоонд орж ирэхэд Антракс түүний араас зэвүүцэн харж байв. Шүүгээн дээр сийлбэрийн хутга байгааг Антракс ажиглажээ. Хутга руу дөхөх тэр мөчид эмнэлгийн түргэн тусламжийн ажилтнууд гэрийнх нь гадаа ирж, Антракс хутгыг буцааж тавиад холдов.

Тэр цагаас хойш түүний зан ааш илт өөрчлөгджээ. Тэр өөртэйгээ хий юм ярина. Сургууль, гэр хаа сайгүй өөртэйгээ ярьдаг болсноор томоохон асуудлын эхлэл тавигдсан юм.

Дунд сургууль, дээд сургуульд түүнийг хүүхдүүд зодож байсан цаг ард хоцорлоо. Антраксыг үе тэнгийн хүүхдүүд шоглож эхлэнгүүт тэр биеэ барих чадвараа алджээ. Хэсэг хугацааны дотор л түүнийг оролдсон хүүхдийн царай төрсөн аавынхаар нь солигдож Антракс тэр хүүхдийг харахын аргагүй болтол цохиж эхэлнэ.

Хүүгээ хэрхэн номхруулах аргаа Антраксын аав сайн сурсан аж. Аавынхаа ярьсан үг бүрийг эсэргүүцэх бүрийд эцгийн алганы амтыг үзнэ. Тэр хүүгийнхээ хүзүүг хугалах дөхсөн төдийгүй гарыг нь хүчтэй мушгиж гэмтээсэн явдал түүний сэтгэлд хэзээ ч мартахааргүй сэв болж үлдсэн гэдэг.

Аав нь хүүгийнхээ гарыг мушгиж, ард нь барьжээ. Яс нь бараг хугарсан гэмээр хачин санагдаж, тэвчихийн аргагүй өвдөв. Антракс аавынхаа согог үйлдлийг зогсоохыг хүсэж чанга орилоход тэр улам хүчтэй эргүүлэн, нөгөө гараараа хоолойг нь шахжээ. Хүүгийн эх нөхөр рүүгээ орилж, зогсоохыг шаардсан ч тэр огт ажирсангүй.

“Өөрийнхөө уйлж байгааг хар, үзэн ядмаар амьтан минь” хэмээн аав нь зэвүүнээр инээмсэглэнэ.

“Муу адгийн новш!” гэж Антракс мөчөөгөө өгөхгүй хариу барьж байлаа.

Антраксыг газар унагаан толгой, хавирга, бараг бүх газарт нь цохиж гарав. Тэр орон гэрээсээ дайжихаас өөр зам байсангүй. Мелбурнийн өмнөд хэсэг рүү долоо хоног аялахдаа унтаж болох газруудаар Антракс хоног төөрүүлжээ. Түүнчлэн түргэн тусламжийн төвийн өрөөнд хүртэл хонож үзэв. Сувилагч түүнээс яагаад тэнд байгааг асуухад, эелдэгээр “хүн надтай уулзана гэсэн юм аа” гэж хариулна. Харин сувилагч үгэнд нь итгэн толгойгоо дохиод яваад өгдөг байв.

Өөр явах газаргүй тул Антракс гэртээ буцаж ирээд бие хамгаалах урлагаар хичээллэх болов.

Нэгэн удаа Антракс “MILNET”-ийн сүлжээгээр хэсүүчилж яваад Систем “X” рүү нэвтрэх хаалга буюу гарц дээр тээглэв. Тэр энэ системийн тухай өгүүлсэн цахим шууданг олзолж уншсан учраас хэдэн сарын туршид ямар нууцыг агуулж байгааг мэдэхийг хичээжээ. Антракс тэр гарц руу телнетээр холбогдов. Телнет гэдэг нь интернетээр дамжин сүлжээний протоколыг ашиглан өөр компьютерт холбогдохыг хэлнэ. Энэ гарц хоёр өөр сүлжээг холбож байв. Жишээлбэл хоорондоо холбоо барихдаа өөр хэлийг хэрэглэдэг хоёр компьютер сүлжээг ажиллах боломжоор хангана гэсэн үг. Компьютер дээр DECNET програмыг ажиллуулж байгаа хэн нэгнийг TCP/IP дээр үндэслэсэн систем рүү “login” хийхэд (яг Unix шиг) уг гарц туслах ажээ. Систем “X”-ийн гарцыг давж нөгөө талд байгаа хостууд руу холбогдож чадахгүй байгаадаа Антракс бухимдана.

Олон сүлжээний жирийн хаягтай форматуудыг ашиглан гарц руу холболт хийх команд өгч үзэв. Жишээлбэл X.25. TCP/IP гэх мэт. Тэрхүү гарцны цаана байгаа програм хариу өгсөнгүй. Антракс туслах файл дотор жишээ болгох хаягийг олтлоо толгойгоо ихэд гашилгажээ. Тэдний аль нь ч ажилласангүй. Гэхдээ хаяг ямар форматыг авч болох вэ? гэсэн түүнд төрсөн гэдэг.

Хаяг бүр зургаан оронтой тооноос бүрдэнэ. Эхний гурван дугаар бол нийслэл Вашингтон хот дахь утасны “area” кодуудтай адилхан байв. Гараар утасны дугаар скан хийнэ гэдэг бол тэвчээр шаардсан ажил. Гэхдээ тэр бууж өгөлгүй ямар нэг зүйл болохыг хүлээн шургуу зүтгэв. 111.112.113.114.115. Үргэлжилсээр... Эцэст нь “login” мессэждээ IP хаягийг бүрэн агуулсан “Sinus Unix” системтэй холбогдлоо. Одоо асуудал арай хялбар болов. Бүрэн IP хаягтай болсноор “X” систем рүү интернетээр дамжин шууд холбогдож чадна. Хэрэвзээ тэр гарцаар дамжин холбогдохоос зайлсхийж байгаа бол бүх зүйл боломжтой гэсэн үг. Энэ нь руутинг хийх хэдэн сонголттой бөгөөд өөрийн ул мөрийг далдлахад байнга туслана. Хамгийн гол нь тэр Систем “X”-ийн зөвхөн гол хаалгаар орохоос ч илүү аргаар дөхөж очиж байгаа билээ.

Антракс өнөөх л байдаг хэрэглэгчийн нэр, паролдоор нэвтрэх гэж оролдов. Болсонгүй. Энэ систем рүү нилээд зэгсэн довтолгоо хийх шаардлагатай ажээ.

Тэр “login” хийсэн дэлгэцээс гарч, гарцнаас холдон Систем “X”-ийг нилээд холоос ажиглахын тулд өөр интернет сайт руу оров. Интернетээр Систем “X”-ийн тухай олдох бүх мэдээллийг хайж, нээх бололцоог судалжээ. Удалгүй тэр “Sendmail”-ийг олов.

Систем “X” дээр ажиллаж байгаа “Sendmail”-ийн хувилбар Антракст жижигхэн арын хаалганы програмыг илгээх боломжийг олгох аюулгүй байдлын цоорхойтой байлаа. Үүнийг хийхийн тулд тэр компьютерийн бага хэмжээтэй програмыг агуулах “захидал”-ыг Систем “X”-ийн мейл боловсруулах үйлчилгээг ашиглан илгээнэ. Бусад програмыг хэвийн ажиллах боломжийг Систем “X” хэзээ ч олгохгүй. Харин энэ програм яг л захидлаар илгээсэн бөмбөг шиг байлаа. Систем “X” захидлыг нээхэд програм ил гарч, далд ажиллагаандаа орно. Компьютер рүү паролд ашиглахгүйгээр 2001 портоор хэн ч холбогдож болно гэж “X” системд энэ програмыг оруула.

Порт бол гадаад ертөнцтэй холбогдох хаалга юм. TCP/IP компьютерүүд нь тодорхой

үйлчилгээнд зориулсан стандарт портуудын багцыг хэрэглэдэг. Порт 25-ыгмейлд, порт 79-ыг компьютерийн хайлтанд, порт 21-ыг FTP-д, порт 23-ыг телнетэд зориулж, порт 513-ыг Rlogin, порт 80-ыг World wide web-д зориулна. TCP/IP дээр үндэслэсэн компьютерийн систем 65535 портуудтай боловч ихэнхийг нь хэрэглэдэггүй. Харин дундаж Unix box зөвхөн 35 портыг ашиглаж, 65500 портуудааашиглахгүй орхино. Антракс тэдгээр унтаахай портуудын нэгийг сонгож, бяцхан захидлаас төрсөн програмын хүчээр бий болсон арын хаалгыг ашиглах юм.

Буцах товчлуур мэтийн тодорхой нэг товчлуурыг систем танихгүй болдог учраас портоор шууд холбогдох нь зарим хүндрэл үүсгэнэ. Энэ шалтгаанаар Антракс өөртөө зориулж эхкаунт үүсгэж, жирийн хэрэглэгчийн адил “login” хийж, сайт руу нэвтэрнэ. Эхкаунт бий болгохын тулд түүнд руут эрх хэрэгтэй, тэгсэн цагт системд нэвтрэх байнгын арын хаалгатай болно.

Тэрээр Систем “X”-ийн аюулгүй байдлын сул, эмзэг талыг судалж эхэллээ. Тэнд илэрхий тодорхой ямар нэгэн сул тал харагдахгүй байсан боловч байнга хэрэглэдэг цохоо туршаад үзэхээр шийдэв. Бусад хакерууд болон фреакеруудтай мэдээлэл солилцож байхдаа тэр энэ тухай сонсож байжээ. Аюулгүй байдлын цоорхойд системийн харьцангуй тодорхой бус ачаалах модультай програм холбоотой байлаа. (load module – ачаалах модуль) Компьютерийг ажиллуулахад програм тодорхой онцлогуудыг нэмэх бөгөөд хамгийн гол нь руут шиг харагддаг аж. Өөрөөр хэлбэл энэ програм компьютер дээр чөлөөтэй ажиллах боломжтой байв. Хэрэв өөрийн програмуудын нэг болох бяцхан Троянаар энэ програмыг ажиллуулж чадвал Систем “X”-ийн руутыг олж чадах ажээ.

Систем “X” дээр ачаалах модулийн цох ажиллана гэдэгт найдах арга байхгүй. Банк болон зээлийн үйлчилгээний компанийн компьютерүүд болон ихэнх худалдааны системүүд ачаалах модуль цохыг “Sunos” компьютерээс хэдэн сарын өмнө цэвэрлэж, хэрэгцээнээс гаргасан байлаа. Харин цэргийн сүлжээний компьютерүүд цохыгарчиж амжаагүй байв. Тэд гадна талдаа хатуу харагдах боловч дотор талдаа эмзэг, сулхан яг л яст мэлхий шиг байсан юм. Хакер системийн дотор орсон л бол цохыг илрүүлж чадахгүй учир цэргийн компьютерийн мэргэжилтнүүд үүнд нэг их анхаарал тавихаа больсон цаг. Систем “X”-ээс өмнө Антракс цэргийн олон системээр зочилж үзжээ. Тэдний “Sunos” компьютерүүдийн 90 гаруй хувь нь хэзээ ч цохыг янзалж чадахгүй гэдгийг тэр туршлагаасаа мэджээ.

Антракс жирийн руут эрхээр ачаалах модуль програмыг хүчилж, арын хаалганы Троян програмыг ажиллуулж чадахгүй байв. Гэхдээ тэр үүнийг хууран мэхлэх аргаар хийж болно. Үүний нууц нь жирийн товчлуурт тэмдэглэгээ /.-д оршиж байлаа.

Unix дээр үндэслэсэн компьютерийн систем нь дипломат корпусын протоколуудтай бага зэрэг төсөөтэй. Өчүүхэн засвар зарим нэг юмны утгыг бүхэлд нь өөрчилж чадна. Хакерууд ч гэсэн амархан ажиглагдахгүй өөрчлөлтийн ач холбогдлыг сайн ойлгоно.

Unix дээр үндэслэсэн систем нь /bin/program гэснийг bin program гэж өөрөөр уншдаг.

Зөвхөн нэг / гэсэн тэмдэглэгээ маш их өөрчлөлтийг хийнэ. Unix-ийн компьютер /. тэмдэглэгээг замын тэмдэг шиг уншдаг гэхэд болно. Хамгийн эхний хэсэг компьютерт: “ bin нэртэй хэрэглэгчийн гэр рүү хүргэх замыг дага” гэнэ. Дараа нь та тэнд хүрэнгүүтээ, дотор нь

орж “program” гэсэн нэртэй файлыг дуудаж, “ажиллуул” гэнэ. Харин “/” тэмдэглэгээ байхгүй бол шал өөр зүйлийг компьютерт хэлдэг гэсэн үг. Хоосон зайны дараа командыг үргэлжлүүлэн гүйцэтгэ гэж компьютерт үүрэг өгснөө Антракс мэдэж байлаа. Хоёр дахь хэсэг “bin нэртэй програмыг бүх газраар хайж олоод, ажиллуул” хэмээн компьютерт хэлнэ.

Антракс ачаалах модуль програм руу хийх довтолгоондоо бэлдэж, “bin” гэж нэрлэсэн өөрийн тусгай програмыг Систем “X”-ийн түр зуур хадгалах хэсэгт суулгажээ. Хэрэв руут эрхтэйгээр өөрийн програмыг ажиллуул гэж Систем “X”-ийг ятгаж чадвал систем рүү нэвтрэлт хийх руут түвшний оролтыг олж авна. Бүх зүйл бэлэн болмогц Антракс “/ ” тэмдэглэгээг хоосон зай гэж унш хэмээн системд албаджээ. Дараа нь ачаалах модуль програмыг ажиллуулаад ажиглав. Систем “X” “bin” нэртэй програмыг хайж эхлэнгүүтээ Антраксын Трояныг олж, ажиллуулав.

Хакер баярлаж суулаа. Хэдхэн товчлуур дарсны дараа пассвордын файлуудад нэвтрэх эрхтэй үндсэн эккаунтыг өөртөө зориулж нээв. Тэр холболтоос гарч 2001 порт руу холбогдлоо. 0014 гарцыг ашиглан Систем “X” рүү login хийж, шинээр нээсэн эккаунтаар нэвтрэв. Хакер баяр ёслолын байдалтай гол хаалгаар алхан орох сайхан байлаа.

Антракс дотогш нэвтрэнгүүтээ ойр орчноо хурдхан ажиглангуутаа олж харсан зүйлдээ ихэд гайхав. Систем гуравхан хэрэглэгчтэй ажээ. Маш хачин байлаа. Ихэнх системүүд доод тал нь хэдэн зуун хэрэглэгчтэй байдаг. 30 эсвэл 40 тооны хэрэглэгчтэй жижигхэн сүлжээг хүртэл бага гэж хэлэхгүй. Систем “X” бол цахим шуудан илгээх, хүлээн авахад зориулагдсан компьютер биш харин ямар нэгэн нууц зүйл хийдэг байх гэж Антракс дүгнэв.

Антракс өөрийн ул мөрийг хэрхэн цэвэрлэх, нууц сувгаа хэрхэн хамгаалах талаар бодож байлаа. Одоогоор өөрийгөө байгаа гэдгийг пассвордын файл дахь эккаунтуудын жагсаалт дээр ил харуулж байгаа учраас хэн нэгэн мэдчих боломжтой юм. Тэр өөрийн арын хаалга болсон эккаунтад бусдын анхаарал татахгүй нэр өгөв. Гурван хэрэглэгч системээ маш сайн мэддэг байх гэж тэр бодож байлаа. Зөвхөн гурван хэрэглэгч байгаа энэ систем байнгын хяналтанд байх магадлал өндөр юм. Тиймээс Антракс маш болгоомжтой ажиллах хэрэгтэй.

Тэр өөрийн ул мөрийг WMTP ба UMTP файлуудаас цэвэрлэв. Тэдгээр файлууд нь хэн онлайн дээр байсан, хэн “login” хийсээр байгаа жагсаалтыг харуулдаг юм. Админ системийн сүлжээний холболтууд ба програм боловсруулалтын жагсаалтыг сайн судалж хакеруудыг илрүүлэх боловч Антракс үл үзэгдэгч мэт байсангүй. Дараагийн зогсоол нь “login” програм юм.

Өөрийгөө илчлэх эрсдэл их байсан тул шинээр үүсгэсэн гол хаалганы эккаунтыг удаан хугацаагаар ашиглах боломжгүй юм. Хэрэв тэр компьютерт олон дахин ийм аргаар нэвгэрвэл админ түүнийг отоож байгаад илрүүлж, эккаунтыг устгачихна. Гуравхан хэрэглэгчтэй систем дээр тусгай эккаунт байвал шууд бууж өгснөөс ялгаагүй болно. Гэтэл сонирхол татаад удаагүй байгаа Систем “X” рүү нэвтрэх оролтоо алдмааргүй байдаг.

Антракс сандлын түшлэгээ налан сунналаа. Түүний хакердах ажиллагааны өрөө нь хуучин юм хадгалах өрөө байжээ. Өрөөний шалан дээр их хэмжээний цаас хөглөрөх бөгөөд ихэнх нь утасны дугааруудын жагсаалт ажээ. Зарим үед Антракс бүх цаасыг хурааж, хогийн уутанд

хийхэд гурван том хүүдий болдог байв. Гэхдээ тодорхой нэгэн дугаарыг хаана хийснээ тэр маш сайн мэддэг байжээ. Түүнд дугаар шаардлагатай болонгуут уул овоо шиг цаасаа ухаж, компьютер дээр эргэн очино.Цаас дахиад овоороод ирэнгүүт том уутанд буцаан хийнэ.

Хямдхан Panasonic телевизорыг монитор болгосон “Amiga 500box” компьютер түүний ээжийн оёдлын машины хажууд тавьсан ширээн байрлана. Ширээний дор хийсэн номын жижиг тавиур дээр Австралийн холбоо, компьютерийн тухай сэтгүүлүүд, Commodore, Amiga, Unix-ийн гарын авлагуудыг дүүрэн чихжээ. Түүнчлэн тэнд Антраксын хуучин стерео ба богино долгионы радио харагдана. Эквадор дахь радио станцаас цацах хакерын тухай нэвтрүүлгийг сонсоогүй үедээ Антракс Москвагийн радио, BBC-ийн дэлхийн мэдээг сонсоно.

Систем “X”-ийг яах тухайгаа Антракс бодож байлаа. Энэ систем түүний сонирхлыг маш ихээр татаж байгаа учир олон удаа зочлохоор төлөвлөжээ.

Одоо “login patch” програм дээр ажиллах цаг боллоо. “Patch” програм нь системийн жирийн “login” програмыг сольж, тусгай эрхээр буюу мастер пассвордоор ордог болгоно. Пассворд яг л дипломат паспорт шиг болно гэсэн үг. Үүнийг ашиглан хаашаа ч явж, юуг ч хийж болох боломжтой мэт санагдана. Тэр мастер пассвордыг ашиглан ямар ч хэрэглэгч болж “login” хийнэ. Цаашлаад мастер пассвордоор “login” хийсэн цагт “log” файлуудын алинд ч бүртгэгдэхгүй, мөн ул мөр үлдээхгүй.Жирийн “login” програмтай адилхан ажилладагт энэ програмын гайхамшиг оршино. Системийн байнгын хэрэглэгчид (гурвуулаа) пассвордоо хэрэглэн “login” хийж болох бөгөөд системд нь Антракс байсныг хэзээ ч мэдэхгүй.

Тэр өөрийн “login patch” (логин нөхөөс гэсэн утгатай үг) програмаа суулгах талаар бодно. Систем “X” дээр patch-ийг суулгана гэдэг жинсэн өмдийг янзлахтай адилгүй байв. Энэ бол үнэтэй ноолууран цамцыг засахтай төсөөтэй юм. Ноолууран утас нь яг таарсан өнгөтэй, адилхан эрчилсэн байх ёстой гэсэн үг. “Patch” програм нь өндөр чанарын, нүдэнд үл харагдах засварыг шаардахаас гадна хэмжээ нь яг зөв байх учиртай.

Компьютер дээр байгаа файл бүр гурван үндсэн он сар өдөртэй. Файл үүсгэсэн, файлыг хамгийн сүүлд шинэчилсэн, хамгийн сүүлд файлд орсон гэсэн он сар өдрүүдийг хадгална. Асуудлын гол нь “login patch” програмд оригиналь “login” програмтай яг адилхан бий болсон, шинэчилсэн он, сар, өдрүүд байх шаардлагатайд оршиж байгаа юм. Ингэвэл бусдын анхааралд өртөж, сэжиг төрүүлэхгүй. Он, сар, өдрийг олоход хэцүү биш хэдий ч нөхөөс болгон програм дээр суулгана гэдэг хэцүү байдаг. Програм ажиллах бүрд уг мэдээлэл өөрчлөгдөх тул хамгийн сүүлд файл руу оролт хийсэн он, сар, өдөр нэг их чухал биш ажээ. Өөрөөр хэлбэл Систем “X” рүү хэрэглэгч login хийх удаа бүрд мэдээлэл өөрчлөгдөнө гэсэн үг.

Хэрэв Антракс оригиналь “login” програмыг авч хаяад, өөрийн бэлдсэн нөхөөсийг оронд нь оёж чадвал шинэ он сар өдөртэй нөхөөс хадагдах юм. Системийн бүх цагийг өөрчилж болохгүй учраас он сар өдрийг шинээр солих ямар ч арга байхгүй гэдгийг тэр мэдэж байлаа. Системийн цагийг өөрчлөх гэж оролдвол систем “X”-ийн хаа нэгтээ томоохон асуудлыг үүсгэх магадлалтай.

Туршлагатай системийн админ хэн нэгнийг нууцаар нэвтэрсэн гэж сэжиглэвэл өмнөх хэдэн

өдөр нь шинээр үүсгэсэн, шинэчилсэн бүх файлуудыг хайж үздэг. Гадны этгээд байгаа гэж мэдэрсэн бол сайн админ таван минутын дотор л Антраксын “login patch” програмыг илрүүлэх байлаа.

Антракс цаасан дээр файлыг шинээр бий болгосон ба шинэчилсэн он сар өдрийг бичиж авав. Хэдэн хормын дотор энэ тэмдэглэл түүнд хэрэг болно. Түүнчлэн “login” файлын хэмжээг мөн адил тэмдэглэжээ.

Хуучин програмыг авч хаяад цоо шинэ програм оруулахын оронд Антракс хуучин програмын дээд хэсэгт өөрийн нөхөөсийг суулгахаар шийдэв. Тэр өөрийн мастер пассвордыг дотор нь шигтгэсэн “login patch”-ийг upload хийсэн боловч шууд суулгасангүй. Түүний нөхөөсийг Трояны богино нэр ‘troj’ хэмээн нэрлэсэн байв. Антракс: “cat/bin/login” гэж шивлээ. Cat гэсэн команд нь “troj гэсэн файл дотор байгаа датаг аваад ‘/bin/login’ файлд хий” гэж компьютерт хэлнэ. Тэр оригиналь файлуудын үүсгэсэн, шинэчилсэн он сар өдрийг бичсэн цаасаа авч үзээд програмд шинээр тавьсан нөхөөстэйгээ харьцууллаа. Файлын шинээр бий болгосон он сар өдөр бахэмжээ нь оригинальтайгаа яг таарч байв. Харин шинэчилсэн он сар өдөр нь буруу хэвээр байлаа. Гэвч түүнийг замынхаа гуравны хоёрыг туулсан гэж болох юм.

Антракс командын нилээд бага хэрэглэдэг функцийг ашиглаж нөхөөсны сүүлийн хэсгийг янзалж эхлэв.

```
/usr/5bin/date
```

Дараа нь оригиналь “login” файлын он сар өдөр дээр өөрийн “login patch” програмын шинэчилсэн он сар өдрийг өөрчлөв. Тэр өөрийн хийсэн ажлыг хараад бахарах сэтгэл төрнө. Шинээр суулгасан нөхөөс оригиналь файлтай төгс адилхан болжээ. Хэмжээ нь ижил, үүсгэсэн он сар өдөр нь ижил. Ингээд нөхөөсийг байранд нь оёсны дараа 2001 портоор зочлох үед суулгасан руут эккаунтыг устгав. Явахдаа хог бүү үлдээж бай гэж...

Одоо наргиан эхлэнэ дээ. Тэр орчноо шиншилж эхэллээ. Системийг чухам юунд ашиглаж байсныг мэдэх хамгийн сайн арга болох цахим шууданг шалгах ажилдаа Антракс оров. Тэнд гурван хэрэглэгчийн тоног төхөөрөмж авах, ажлын явц, хийгдэж байгаа ажлын тухай, тодорхой төслийн талаар маш их мэдээлэл байв. Ямар ажил, төсөл юм бол?

Дараа нь Антракс санах ойд хадгалагдаж байгаа олон файлуудын жагсаалт буюу директориг үзлээ. Тэр файл бүрийг нээж, ажиглах агаад бараг 100 гаруй дэд директори байгааг мэдэв. Тэдний нэгийг нээхэд олон зуун файлууд задран гарч ирлээ. Хамгийн жижиг дэд файл компьютерийн 60 дэлгэцийг дүүргэхээр материалыг агуулжээ. Материалыг шууд уншаад ойлгох боломжгүй байв. Дугаарууд, захидлууд, хяналтын кодууд... Антракс файлуудын хөл толгойг ялгаж чадахгүй байлаа. Бараг л компьютерийн бинари файлуудын цуглуулга мэт санагдав. Бүхэл дэд директори нь хэдэн мянгаад хуудас үл ойлгогдох зүйл буюу хөвдөөр дүүрчээ. Тэр ямар нэгэн мэдээллийн сангийн дата файлууд гэж бодож байв.

Үүнийг уншиж тайлах програм байхгүй учраас Антракс уншихад илүү ойлгомжтой файлыг хайлаа.

Нэгэн файлыг нээхэд жагсаалт гарч ирэв. Нилээд томоохон харилцаа холбооны компаний албан хаагчдын нэрс, утасны дугаарууд... ажлын ба гэрийн утасны дугаарууд байлаа. Эдгээр мэдээлэл ямар төслийн тухай яриад байгааг таамаглах боломжийг түүнд өгчээ. Ямартай ч харилцаа холбооны компаний тухай л байж таарлаа. Уг төсөлд холбогдсон ахлах албан тушаалын хүмүүсийн гэрийн утасны дугаар цэргийнхэнд хэрэгтэй болсныг үзвэл чухал төсөл бололтой. Дараагийн файл ч үүнийг батлав. Өөр нэгэн жагсаалт их онцгой санагджээ. Нилээд зүтгэсний эцэст далайгаас сувд, хакердахад зориулсан цаг хугацаа нь үр дүнгээ өгсөн мэт байлаа.

АНУ-ын засгийн газар тухайн үед юу болсныг мэдсэн бол нилээд сандрах байсан биз. Хэрэв гадаадын экстремист бүлгийн гишүүний гарт файлын мэдээлэл орсон бол Батлан хамгаалах агентлаг хууль хамгаалах байгууллагын мөрдөгч бүрийг дуудах байв.

Жон Макмахон л лав маш их орилж уурлах байсан биз.

Антраксын ээж орон гэрээ босгож, харин аав нь хүчирхийллээрээ бүгдийг нураана. Гэр бүлтэйгээ гэхээс илүүтэй найз нөхөдтэй байх нь илүү аз жаргалтай санагдана. Гэвч тэр хүнээр тоглоом хийхдээ гаргууд байсан аж. Жаахан хөвгүүн байхдаа л хүнийг хуурч тоглох, алиалах дуртай байсан учраас том болох түүний зуршил илүү хүчтэй хөгжжээ. Фреакинг хийх агуу сайхан санагдана. Түүнд дэлхийн хаа ч амьдрах хүнийг шоглох боломжийг фреакинг олгож байсан юм. Зүггүйтэх сайхан байлаа.

Найз нөхдүүдтэйгээ хамтран тоглох сайхан бөгөөд Антракс дуут конференсэд фреакер, хакеруудыг дууддаг байв. Гэхдээ ямар нэгэн нууц төсөл дээр хамтран ажиллах болонгуут тэр бусдад нэг их итгэдэггүй байжээ. Утсаар конференс хийхийн тулд фреакинг ашиглах арга түүний үндсэн ажил байв. Конференс хийж хэн нэгэнтэй уулзахдаа ярьж байгаа зүйлдээ хянамгай байхгүй бол эрсдэл их дагуулна гэж тэр үзнэ. Конференс дуудлагууд хийж нэгдэхдээ Антракс олон янзын арга хэрэглэнэ. Олон үндэстэн дамнасан корпорацийн “Dialcom” үйлчилгээ түүний дуртай аргын нэг байлаа. Компаний ажилчид дуудлага хийхдээ өөрсдийн хувийн дугаарыг оруулж, оператор хаа дуртай газар руу нь үнэгүй холбоно. Харин хүчинтэй хувийн дугаар л Антракст хэрэгтэй. Заримдаа үүнийг хийх хэцүү, заримдаа азтай тохиолдол бас байна. Dialcom-ын үйлчилгээг оролдож үзсэн өдөр Антраксийн азтай өдрүүдийн нэг байлаа. Тэр өөрийнхөө дуртай төлбөрт утаснаас залгажээ.

“Таны код хэд вэ? эрхэмээ?” гэж оператор асуув.

“Миний нэрийг Бейкер гэдэг. Надад олон дугаар бичсэн хуудас байна л даа. Би компанид шинээр орсон юм. Аль тоо нь зөв болохыг хэлэхэд хэцүү байна” гээд Антракс төлбөртэй утасны харилцуурт хэдэн цаас ойртуулан шаржигнуулав. “Хэдэн цифртэй дугаар байдаг юм бэ?”

“Долоо эрхэмээ”...

Түүнд бас хөөрхөн нэмэр болох мэдээлэл. Одоо долоон тоо олох хэрэгтэй. Антракс түргэн хоолны газар руу харав. Ямар нэгэн тоо харагдсангүй. Дараа нь машины бүртгэлийн дугаар түүний нүдэнд туслаа. Тэр эхний гурван дугаарыг уншаад, дараагийн дөрвөн тоог өөр

машины дугаараас хэлэв.

“Баярлалаа. Эрхэм Бейкер, таны дуудлагыг холболоо”.

Хүчинтэй дугаар байжээ! Ямар их аз вэ? Удалгүй өөрийн азтай дугаарыг Аделаид дахь найздаа өгч хилийн чанад руу утасдууллаа. Найз нь тэр кодыг уншиж байхад оператор гэнэт “Чи Бейкэр биш байна!” гэжээ.

“Яах вэ?... Би мөн. Миний код шүү дээ”.

“Үгүй гэдэгт итгэлтэй байна. Би түүний дууг таньдаг юм” гэж оператор хэлэв.

Найз нь Антракс руу утасдаж болсон явдлыг хэлэхэд татаж унаталаа хөхөрчээ. Тэр дахиад “Dialcom” руу утасдаж, өөрийн кодыг сольжээ! Энэ бол үнэхээр хөгжилтэй тохиолдол байлаа. Тиймээс ганцаар ажиллана гэдэг ямар ч аюулгүй гэдэгт тэр итгэлтэй байв.

Хакер хөдөө орон нутагт амьдарна гэдэг хэцүү. Антракс хүсэл сонирхлоороо бус харин хэрэгцээнээс болж фреакер болжээ. Түүнд холын дуудлагыг үнэгүй хийх шаардлага их байв. 008-аар эхэлсэн дугаар руу залгахад утасны дуудлага хэдэн удаа дуудаж байгаад клик гэсэн дуу гарч, хэсэг хугацаанд азнаснаа дахиад дуудахыг тэр ажиглажээ. Эцэстээ компаний төлөөлөгч эсвэл хариулт өгөх үйлчилгээ дуудлагыг авна. Утасны дуудлагыг автоматаар чиглүүлэх, өөрчлөгч тоног төхөөрөмжийн тухай харилцаа холбооны сэтгүүл, гарын авлагаас Антракс уншжээ. Клик гэж дуугарч байгаа нь өөрчлөн чиглүүлэгч төхөөрөмжөөр дуудлага дамжиж байгааг илэрхийлэх бөгөөд зөв цаг мөчид зөв дугаарыг оруулвал компаний үйлчлүүлэгчтэй харьцах ажилтантай холбогдохгүй дуудлага шууд хийж болно. Шугамыг мөшгисөн ч компани руу хөтлөөд цааш явахгүй зогсох юм.

Антракс 008-аар эхэлсэн хэдэн дугаар цуглуулж, тоглодог байв. Клик гэж дуугарсны яг дараахан өөр дугаар оруулбал дуудлагыг хүссэн газар руугаа дайверт хийх буюу чиглүүлж болно гэдгийг тэр нээжээ. Дэлхийн хаа нэгтээ байгаа фреакеруудтай утсаар конференс хийхдээ тэр 008 дугааруудыг ашиглана. Ялангуяа Торонтод байрлах Монтрейл, UPI, NPC бүлгийн Канад гишүүдтэй ярихад голдуу хэрэглэдэг. Тэд хэрхэн фреакердэх тухай гарын авлагыг Франц хэл дээр гаргаж байв. Фреакерууд утсаар конференс хийж байхдаа бусдаар тоглох тухай яриад зайлшгүй орно. Тэгээд ч Канад залуучууд хэрхэн тоглохоо сайн мэднэ!

Нэгэн удаа тэд Канадын томоохон хотын түргэн тусламжийн утас руу ярьжээ. Канад маягийн аялгаар Антракс цагдаагийн ажилтанд тусламж хэрэгтэй байна гэж хэлэв. Оператор хаана гэдгийг мэдэхийг хүсчээ. Фреакерууд “Хөх тууз” мөхөөлдөсний газарт гэж хэлэхээр шийдэв. Тэд ихэвчлэн аль нэг гишүүнийхээ нүдэнд харагдах газрыг сонгодог байна. Тэр найз фреакер нь тэнд юу болж байгааг ажиглах үүрэгтэй.

Оператор сандран асуулт асууж байхад бусад таван фреакерүүд чимээгүйхэн сонсож байлаа. “Буудуулсан цагдаа юм уу? Та буудуулсан юм уу? байна уу Жон?” гэж оператор хэлээд цааш хэн нэгэнтэй ярина. “Цагдаа буудуулчихлаа” гэж фреакер хариулав.

Инээдээ тэсч ядан барих үед гарах дуу хэн нэгэн буудуулсан хүн ярьж байгаа юм шиг

сонстоно. “Жон надтай ярьдаа, надтай ярь” хэмээн оператор утсаар гуйх шаардахын завсар ярилаа.

“Би буудуулчихлаа, би буудуулчихлаа” гэж Антракс сулхан хэлэв.

Антракс операторыг конференс ярианаас салгажээ. Дараа нь мөхөөлдөсний газрын ойролцоо амьдардаг фреакер гудамжийг цагдаагийн машинууд бүсэлсэн тухай мэдэгдэв. Тэд мөхөөлдөсний газрыг яаралтай шалгаж, шархадсан цагдааг хайжээ. Хэн нэгэн сахилгагүй этгээд тэднээр тоглосон байна гэдгийг мэдтэл хэдэн цаг болсон аж.

Маккенни гэдэг хүнээр тэр олон удаа тогложээ. Антракс утасны дугаарыг таамгаар сонгож утасдахад их таатай санагдсан тул дахин олон удаа ярьж тоглоом хийсэн байна. Тэр Маккенни руу олон жилийн турш ярьжээ. Ярианы сэдэв энэ олон жилийн турш ижилхэн байв.

“Эрхэм Маккенни? Би Петер Бейкэр байна. Та миний хүрзийг буцааж өгөөч”

“Надад чиний хүрз байхгүй”

“Би танд өгсөн шүү дээ. Хоёр жилийн өмнө хэрэглүүлэхээр өгсөн. Одоо буцааж авмаар байна”.

“Би хэзээ ч чиний хүрзийг авч байгаагүй. Зайл”

“Та авсан шүү дээ. Та миний хүрзийг авсан. Хэрэв та өгөхгүй гээд байгаа бол би өөрөө очоод авчихна шүү. Ингэвэл танд таагүй л байх болов уу. Одоо та миний хүрзийг буцааж өгөх үү?”

“Чөтгөр аваг! Би чиний хүрзийг аваагүй гээд байна шүү!”

“Миний хүрзийг өг л дөө!”

“Над руу битгий утасдаад бай! Чиний балай хүрзийг би огт аваагүй! Намайг тайван орхи!” гээд утас тасарна.

Өглөөний есөн цаг, оройны найман цаг, шөнийн хоёр цаг. Ингээд дэлхийн нөгөө талд байгаа нэг дахин дүү хүүгээс хүрзийг нь авснаа хүлээн зөвшөөртөл Маккеннигийн амар заяаг үзүүлэхгүй ажээ.

Заримдаа Антракс өөрийнхөө гэртэй ойролцоо байгаа хүнээр тоглоно. Хүмүүсээс юм худалдан авдаг эсвэл зардаг хүний дүрээр утасдаж өөрийгөө хөгжөөнө.

“Тиймээ эрхмээ, та угаалгын өрөөний онгоц худалдаж аван гэсэн зарлал тавьсныг би харлаа. Надад зарах угаалгын онгоц байна!” гэж Антракс дуугаа чухал болгож хэлэхэд “аан тийм үү? Ямар төрлийн онгоц вэ? Танд хэмжээ болон загварын дугаар нь байна уу?” гэнэ.

“Үгүй ээ загварын дугаар байхгүй. Гэхдээ нэг метр урт, хагас метрийн өргөнтэй гэдгийг мэдэж байна. Хуучны загвартай, цав цагаан. Харин нэг асуудал бий” гэж Антракс хэсэг азнав.

“Аан тэгээд тэр нь юу юм бэ?”

“Дотор нь нэг цогцос байгаа юм”.

Цөөрөмд үхэр чулуу хаях шиг зүйл болно доо.

Систем “Х” дээр байгаа жагсаалт дотор “dial up” модемны дугаарууд, хэрэглэгчийн нэр, паролууд байв. Тэдгээр хэрэглэгчийн нэрс “jsmith” эсвэл “jdoe” гэсэн үгтэй адилгүй товчлол, харин паролууд нь толь бичиг дээр гарахгүй үсэг тооны холимог байлаа. 12[AZ63. K5M82L. Компьютер л ийм паролдыг санах байх.

Энэ бол мэдээж компьютер эхнээс нь сонгосон парол болох нь илэрхий. Жагсаалтыг хараад шууд ойлгохооргүй байлаа. Тиймээ энэ бол хүн уншихад зориулагдаагүй жагсаалт байна. Зарим газар нь жагсаалтын тайлбарууд харагдана. Ихэнх програмчид кодын тайлбар хийдэг. Коммандуудыг хөрвүүлж байхад компьютер үгнүүдийг иймэрхүү байдлаар тодорхойлно. Эдгээр тайлбарууд нь кодыг судалж байгаа бусад програмчдад зориулсан юм. Жишээлбэл тайлбарууд нь газрын нэр байв. Fort Green, Fort Myers, Fort Ritchie гэх мэт. Арваад газрын нэрс. Тэдний бараг хагас нь АНУ-ын эх газраас хол оршдог газар юм. Филиппини, Турк, Герман, Гуам гэсэн газруудад байгаа оноосон нэрс. Тэр газарт АНУ-ын армийн олон баазууд оршино.

Олон Америкчууд болон орон нутгийн иргэдэд тэдгээр газрууд нууц биш билээ. Цэргийн баазууд хаана байдгийг хэн ч хууль ёсны дагуу мэдчихэж болно гэж Антракс бодно. Олон хүмүүс энэ тухай анзаарах ч үгүй. Гэхдээ иймэрхүү жагсаалтыг харвал цэргийн компьютерийн сүлжээний амин сүнс нь орших мэдээлэл байна гэдгийг сонирхох бизээ. Эндээс үзвэл АНУ-ын цэрэг дэлхийн хаа сайгүй тархсаныг харж болно.

Антракс Систем “Х”-ээс “logout” хийж гараад, бүх холболтуудаа устгаж, утсаа тавилаа. Одоо хөдлөх цаг боллоо. Тэр жагсаалтанд байсан нэг дугаар руу залгалаа. Хэрэглэгчийн нэр, паролын хослол ажиллаж байв. Түүний бодож байсанчлан энэ бол компьютер биш байлаа. Энэ бол телефон утасны холбох байгууламж “NorTel”-ийн DMS 100 байв.

Хакер, фреакерууд өөрийн мэргэшсэн чиглэлтэй байдаг. Антракс бол Х.25 сүлжээний мастер, дуут шуудангийн системийн хаан гэж Австрали хакерууд үздэг юм. Тэр “Trilgues”-ийг ихэнх компаний техникчээс илүү мэднэ. Мөн Meridian VMB системийг Австралид байгаа хэнээс ч илүү мэднэ. Түүнчлэн Aspen VMB системийн дэлхийн түвшний мэргэжилтэн гэдгийг фреакерийн хүрээнийхэн хүлээн зөвшөөрсөн хүн юм. Гэхдээ “DMS 100”-г тэр сайн мэдэхгүй ажээ.

BBS-ээс татаж авсан “DMS 100”-ийн тухай текст файлыг хакерын дискнүүдээс Антракс хурдан олов. Тэр яарах хэрэгтэй байв. Телефон утасны залгах байгууламж дотор 15-20 минутаас илүү хугацаагаар байж болохгүй. Уг төхөөрөмж хэрхэн ажилладаг талаар мэдлэг байхгүй үед баригдах аюултай. Текст файл байгаа дискиг олж, шүүн үзэх хоорондоо тэр телефоны залгах төхөөрөмжтэй онлайн хэвээр байв. Фреакерын файл системд нэг их саад хийхгүйгээр үндсэн мэдээллийг олгох зарим коммандуудыг түүнд өгчээ. Системийг санаандгүй гэмтээхийг тэр хүсээгүй учраас сайн ойлголттой болох шаардлагатай байлаа.

Хэдийгээр Антракс DMS 100 дээр ажиллах мэдлэг байхгүй боловч “NorTel”-ийн тоног төхөөрөмжөөр мэргэжсэн хакер найзтай байв. Тэр найз хакер нь түүнд жагсаалт өгчээ. АНУ-ын цэргийн бааз дахь DMS 100 төхөөрөмж байна гэж тэр хакер баталсан байна. Энэ төхөөрөмж жирийн телефон утасны систем бус харинцэргийн утасны систем ажээ.

Дайны нөхцөлд цэргийнхэн иргэний утасны системээс хамааралтай байхыг хүсэхгүй. Энхийн цагт ч гэсэн цэргийн албан хаагчид хоорондоо аюулгүй холбоо хэрэглэх шаардлагатай. Энэ мэтчилэн болон бусад шалтгаанаар цэргийнхэн бие даасан утасны системтэй байдаг. Мөн дата холбоонд зориулсан тусдаа сүлжээг хэрэглэнэ. Тэдгээр сүлжээнүүд нь жирийн сүлжээтэй адилхан ажиллах бөгөөд заримдаа гадаад ертөнцтэй өөрийн сүлжээгээр дамжуулан иргэний системтэй холбогдож харилцана.

Антракс мэргэжсэн хакераас зөвөлгөө авангуутаа хурдан сэтгэж эхлэв. Энэ үед sniffer буюу үнэртэгч гэсэн нэртэй програм түүний анхаарлыг татжээ. Сниффер бол Сиднейн Unix бүлгийн Рокстар нэртэй хакерын бичсэн програм юм. Энэ програм Систем “X” дээр хүн үл ажиглах нэрээр суугдаж, системд орж гарсан хүн бүрийг чимээгүй мөшгиж байдаг ажээ. Програм өөрөө Систем “X”-тэй этернет сүлжээний кабелиар дамжуулан интернет холболт хийсэн хүн бүрийн эхний 128 үсэг тоог бичиж авна. 128 тэмдэгт нь “login” хийсэн хэрэглэгчийн нэр, пассвордуудыг мэдэх боломжийг олгоно. Сниффер програм үр нөлөөтэй боловч хугацаа жаахан шаарддаг онцлогтой байлаа. Түүнийг эрүүл эхийн дотор өсөн торниж байгаа үр хөврөлтэй адил тогтвортой мөртлөө аажмаар өсдөг хэмээн зүйрлэж болох юм.

Антракс арван хоёр цагийн дараа эргэн ирж Систем “X”-ийг үзэхээр шийджээ.

Тэр “Commodore 64” компьютерт нуусан аавынхаа Англи дахь ар гэртээ бичсэн маш их цахим шууданг олов. Аав нь өөрийн эхнэрийн талаар хорон, үзэн ядах, ялгаварлах, муухай үгээр дүүрсэн захиа бичжээ. Түүнтэй суусандаа харамсаж байгаа тухайгаа ч дурьджээ. Антракс аавынхаа үгийг сөргөх нь олширч, нэг өдөр ээждээ уншсан зүйлийнхээ талаар ярьжээ. Гэр орны амгалан тайван байдал цаашид мартагдах болж, эцэг эх нь гэрлэлтийн хуульчтай уулзав.

Харин түүний аав захиа бичих зуршлаасаа амархан салаагүй юм. Тэр өөрийн бичсэн захидлуудаа хүүдээ үзүүлэхгүйн тулд пассворд хамгаалдаг програмыг ашиглах болов. Гэвч энэ бол бүтэлгүй оролдлого байлаа. Түүний аав нь өөрийн муу үйлдлийг нуух үр дүн муутай аргыг сонгосон ажээ.

Антракс шинэ захидлуудыг ээждээ үзүүлж, мөргөлдөөн дахин үргэлжилнэ. Гэр оронд нь хурцадмал байдал ихсэх тусам Антракс өөрийн найзууд руугаа тэмүүлнэ. Нэгэн удаа шөнийн клубт найзуудын хамт сууж байхад хэн нэгэн этгээд Антраксийг “карри завжлагч” гэж дууджээ. Энэ бол түүнийг тулаанд уриалан дуудсан мэт үг байв. Дэлбэрэхээ хүлээж удаан халсан давхарга гэнэт тэсэрч Антракс өөрийгөө доромжилсон этгээдийг цохиж, өшиглөж, бүх чадлаараа зодов. Тэр хичээллэж байсан таэквандогийн бүх хувилбарыг гарамгай ашиглажээ. Үгээр доромжилсон биш хүндхэн жавгий хүртсэн этгээдийн хамраас цус гарч, Антраксын шавай нь ханасан ажээ. Өс хонзон сайхан амттай байлаа.

Уурласан үедээ биеэ барих чадвараа алддаг Антракс заримдаа өөрөөсөө хүртэл айх болжээ.

Заримдаа өөртөө төвөг хайх мэт явдаг ч үе байв. Нэг удаа түүний найз охидуудын нэгийг хүчиндэхээр завдсан гэх ёс суртахуунгүй этгээдийг мөшгиж үзжээ. Антракс түүнд хутга гаргасан боловч түүний хийсэн үйлдэл хутга гаргахаар ноцтой биш байсан юм. Түүнийг уурлуулсан л бол үл хүндэтгэсэн гэж үзнэ. Антраксын найз охин гэж мэдсээр байж ийм үйлдэл хийсэн нь түүний уур хилэнг нь бадраахад хүргэсэн байна. Тэгээд ч найз охиныг оролдоно гэдэг нүүр рүү нь шүлсээ хаясантай адилхан билээ.

Магадгүй энэ хэргээс хойш хүндэтгэлийг чухалд үздэг Лалын шашинд ороход нөлөөлсөн байж болох юм. Тэр арван зургаан настай байхдаа Лалын шашинтан болж амьдралаа эрс өөрчилжээ. Антракс шашны талаар судалгаа хийж байхдаа сургуулийн номын сангаас Коран судар олов. Үүний хажуугаар тэр үед реп хөгжимсонирхох болжээ. Америкийн реперүүдийн хөгжмийн цуглуулгын тэн хагас нь Лалын шашинтай байсан агаад ихэнх нь Лалын шашинт үндэстний тухай дуулна. Тэдний нэг бол Министер Лоюис Фарракхан байв. Хар арьстнуудын амьдралд цагаан арьстнууд шударга бусаар нөлөөлсөн тухай утгыг тэдний дуу илэрхийлнэ. Хар арьст хүмүүс хүндлэл хүлээх ёстой гэж тэд уриалан дуулна.

Антракс Фарракханы тухай нийтлэл уншсанаас хойш Малкольм “Х”-ийн намтар мэтийн номыг унших болов. Дараа нь тэр Чикаго дахь Исламын үндэстний төв байр руу угасдаж, нэмэлт мэдээлэл илгээхийг хүсчээ. Final call (сүүлчийн дуудлага гэсэн утгатай) нэртэй сэтгүүлийн дараа бусад төрлийн уран зохиолын ном Антраксын гэрт үзэгдэх боллоо. Антракс сонирхолтой нийтлэлийг ээждээ чангаар дуудан уншиж өгдөг байв.

1990 оны дунд үед, Антраксыг арван нэгэн настай байхад аав нь Мелбурнийн Католик шашинтны сургуульд сурахыг зөвлөв. Сургууль үнэтэй бус, гэр бүл санхүүгийн зардлаа хэмнэх боломжтой байлаа. Антракс түүний саналыг эсэргүүцсэн боловч эцэг нь ятгасаар байв. Антракс ба түүний шинэ сургуулийн хооронд ямар зохидлогоо байсангүй. Католик сүмийн номлол Антраксын уур уцаарыг улам дэврээж, түүнийг Лалын шашны Исламын үндэстэн байгууллагын гарт чанга атгуулжээ. Хүмүүсийн амьдралыг өөрчлөх ёс суртахууны хүлээн зөвшөөрөгдсөн стандарт ба дэвшилтэт арга бол боолчлол гэж номлох институцыг тэр яаж хүндлэх юм бэ? Нэг семейстрын дотор л Антракс сургуулиа үзэн яддаг болж өөрчлөгджээ. Түүний сэтгэлд олон жилийн турш хадагдсан, ад үзэгдсэн мэт мэдрэмжийг Католик сургууль дэвэргэв. Тэр гадны хүнд тооцогдож байсан юм. Харин Исламын үндэстний Министер Фарракхан түүнийг ад үзэгдээгүй, ойр дотны хүн гэж хэлжээ. “Чи арьсны өнгөнөөс болж ялгаварлан гадуурхагдаж байгааг би мэдэж байна. Яагаад гэдгийг тайлбарлая. Цагаан арьстнуудын гарал үүсэл, тэднийг муу үйл хийлгэхээр ертөнц рүү хэрхэн илгээсэн тухай би ярьж өгье. Тэд өөрсдөө ямар ч үлгэр жишээ үзүүлж чадсангүй. Харин Дорны хүмүүсийн дайсан болохоос илүү зүйл хийсэнгүй. Цагаан арьстан хүмүүс бол дэлхий ертөнцийн хүмүүс биш билээ” гэж Фарракхан Антракст хэлжээ.

Исламын үндэстэн байгууллагын номлолд үнэний хувь оршиж байгааг Антракс олж харав. Өөр үндэстнүүд гэрлэх явдал хэзээ ч бүтэлтэй байхгүй. Цагаан арьстан хүн цагаан арьстан биш хүнийг дээрэлхэж, боолчлохын тулд гэрлэдэг. Тэр дурласан, эсвэл хүндэлсэн болоод гэрлэж байгаа юм биш. Барууны шашнуудыг бодвол Исламынхан эмэгтэйчүүдийг илүү утга учиртайгаар хүндэлдэг. Магадгүй энэ хүндлэл нь эмэгтэйчүүдэд үзүүлдэг Барууны эрчүүдийн хүндэтгэлээс өөр төрлийнх байж болох ч төрөлх орон гэртээ аав нь ямар төрлийн

хүндэтгэл, асрамж байгааг нүдээр үзсэн нэгэн юм.

Исламын үндэстэн байгууллагыг үндэслэгч эрхэм Элижах Мухаммедийн хэлсэн үгийг Антракс уншжээ. “Дайснууд заавал жинхэнэ чөтгөр мангас мэт байх албагүй. Тэр чиний аав, ээж, ах, эгч, нөхөр, эхнэр, хүүхэд алин ч байж болно. Ихэнх тохиолдолд тэд таны хажууд, гэрт чинь байдаг. Өнөөдөр ёс суртахуунт Мусульман шашинтан ба ёс суртахуунгүй цагаан арьстнуудын хооронд салан тусгаарлалт хийгдэх агуу цаг хугацаа болжээ” гэж тэр хэлсэн байна. Антракс өөрийн гэртээ чөтгөр шулам байж болох хүнийг харж байгаа. Цагаан чөтгөр...

Исламын үндэстэн байгууллага Антраксын оюун санааг угааж байлаа. Сүүлчийн дуудлага буюу Final call сэтгүүлийн дугаар бүрийг зарим уран зохиолын хамтаар тэр уншжээ. Мартин Бернелийн Хар Атхена, Ноам Чомскийгийн Ардчиллын няцаалт зэрэг бүтээлүүд хуйвалдааны нийтлэг асуудал, дарлал хавчлагийг харуулжээ.

Зургаан сар гаруйн дотор Антраксийн үзэл бодолд асар их өөрчлөлт гарав. Тэр эцэг эхтэйгээ өөрийн үзэл бодлоо огт хуваалцдаггүй байлаа. Энэ бол хувийн хэрэг гэж тэр үзнэ. Харин шашны хувьд хийсэн сонголтонд нэг их гайхаагүй гэдгээ ээж нь хожим хэлсэн гэдэг. Түүний өвөг нь Энэтхэгийн лалын шашинт эрдэмтэн байв. Үүнийг хувь тохиол гэлтэй. Түүний үзэл бодлын өөрчлөлт нилээд хаалттай байхад хүргэсэн юм.

Антракс үсээ хусдаг болжээ. Түүний ээж нь Лалын шашинд орсонд гайхаагүй боловч үсээ хуссаныг хараад толгой сэгсэрч байв.

Тэрээр хакердах урлагт хүчээ үзсэн шигээ Исламын үндэстэн байгууллагын номлолд гүнээ итгэгч болжээ. Фарракханы хэлсэн үгийг тэр цээжилж, түүнтэй адилхан ярих болсон бөгөөд Исламын үндэстэн байгууллагаас олж мэдсэн зарим хүмүүсийн үгийг иш татна. Тэдгээр хүмүүс АНУ-ын Холбооны Нөөцийн банкныг Еврейчүүдийн гарт орсон байна гэж тодорхойлж байлаа. 1941-1945 оны хооронд үй олноор нь хомроглон устгах ажиллагаа байсан эсэхэд Антракс эргэлзэж байв.

“Бяцхан Гитлер болж байгаа юм байна” гэж түүний аав нь хэлж байсан удаатай.

Исламын үндэстэн байгууллагын ном, сэтгүүл гэр орондоо харагдах болсонд аав нь дургүй байлаа. Тэр үүнээс бараг эмээж байсан гэхэд болно. Орон нутгийн жижиг хотын нэгэн байшинд засгийн газрыг эсрэг ажиллах зааварчилгаа хийсэн захидал хүлээн авч байгаа нь сонин санагдаж байв. “Болгоомжтой байх нь дээр шүү. Ийм зүйлийг шуудангаар аваад байвал аюултай. Магадгүй ямар нэгэн мөрдөлтөнд чи өртөхийг үгүйсгэхгүй” гэж аав нь хүүдээ сануулжээ.

Интернет хурдан хөгжиж байлаа. Систем “Х”-т холбогдсон этернет кабелууд тогтмол хурдтай ажээ. Хүмүүс бүлэг зөгий адил нууцлаг сайтнаас бужигнан орж, гарна. Арван хоёрхон цагийн дотор сниффер файлын хэмжээ 100 кило байт болжээ. Ихэнх холболтууд Систем “Х”-ээс харилцаа холбооны томоохон компани руу хийгдэж байв. Антракс ч тэр зүгт хөдлөв.

Тэр хэрхэн довтлохоо бодож суулаа. Тэр хэдэн дайвертер төхөөрөмж болон бусад үсэргэгч хэрэгслээр дайран гарч өөрийн ул мөрийг далдалж чадах бөгөөд уг компаний системд

бүхэлдээ бие даасан эх сурвалжаас цохилт өгөх юм. Энэ замын давуу тал нь нэр нь үл мэдэгдэх байдал байв. Хэрэв админ түүний оролтыг илрүүлж дөнгөвөл Антракс утасны компаний систем рүү орох сувгаа алдахаас бус Систем “X” хүү нэвтрэх боломжоо алдахгүй юм. Нөгөө талаар Антракс компаний сайт руу Систем “X” болон өөрийн гарцаар орох аваас гурван сайтуудад бүгдэд нь мэдэгдэх эрсдэл дагуулна. Гэхдээ түүний сниффер програм нь энэ зам дагуу маш их хөдөлгөөн байгааг харуулсан агаад тэр бужигнасан урсгал дунд уусаж алга болох бололцоотой байлаа. Систем “X”-ээр дамжсан гарцаар “login” хийж байгаа ганцхан хүн байгаа тохиолдолд компаний компьютерүүд сэжиглэнэ. Тэр Систем “X”-ээр нэвтрэх замыг сонголоо.

Антракс компаний компьютер руу сниффер програмыг ашиглаж авсан хэрэглэгчийн нэр, пассвордоор “login” хийв. Ачаалагч модуль цохыг дахин ажиллуулж, системийн руутыг авангуугаа өөрийн login patch програмыг систем дээр суулгалаа. Компаний ерөнхий сүлжээ нь Систем “X”-ийг бодвол хамаагүй энгийн бүтэцтэй харагдана. Хэдэн зуун хэрэглэгчид тэнд байв. Маш их цахим шуудан байгаа тул уншиж судлахад бэрхтэй санагдана. Бүх цахим шууданд хэдэн түлхүүр үгээр хайлт хийсний үндсэн дээр Систем “X” дээр хэрэгжүүлж байгаа төслийн ерөнхий зураглалыг олж мэдэхийг оролдов.

Уг компани ихэнхдээ харилцаа холбооны салбарт батлан хамгаалах чиглэлийн олон ажлыг хийдэг бололтой. Компаний төрөл бүрийн хэлтсүүд төслийн янз бүрийн ажлуудыг гүйцэтгэж байгаа нь харагдана. Антракс хүмүүсийн гэрийн директоригоор хайлт хийсэн боловч онц сонирхолтой зүйл олж чадсангүй. Учир нь бүхэл төслийн нэрийг тэр олж чадахгүй байлаа. Төвлөрсөн хяналтгүйгээр төслийн янз бүрийн хэсгийг хүмүүс тусдаа гүйцэтгэж байсан учраас олон жижиг ойлголтуудыг нэгтгэн дүгнэхэд хэцүү ажээ.

Тэр програмуудын төрлүүд гэж хэлж болохоор бинари файлуудын багцыг олсон боловч юунд зориулагдсан болохыг төсөөлж чадахгүй байв. Програмын зориулалтыг мэдэх цорын ганц арга бол туршилт хийж үзэх явдал юм. Тэр хэдэн бинари файлыг ажиллуулав. Тэд нэг их идэвхитэй ажиллагаатай мэт санагдсангүй. Дахиад хэдэн файлыг хөдөлгөөнд оруулав. Дахиад л юу ч байдаггүй. Тэр нэмж ажиллуулсаар байлаа. Бас л үр дүн алга. Дандаа алдаа гэсэн мессэжүүдийг хүлээн авчээ.

Дэлгэц дээр график үзүүлэх хяналт бинари файлуудад шаардлагатай мэт санагдав. Тэд Unix систем дээр нийтлэг байдаг графикайн үзүүлэн XII-ыг хэрэглэж байлаа. Антраксын хямдхан компьютерт график үзүүлэх ажиллагааны систем байхгүй аж. Тэр Систем “X”-д команд өгч өөрийн сүлжээн дээр байгаа нэг компьютерт бинари файлуудыг ажиллуулж чадах боловч өөрийн гэрийн компьютер дээр үр дүнг харах боломжгүй юм. Үүнээс гадна энэ бол нилээд эрсдэлтэй үйлдэлд тооцогдоно. Бинари файлыг ажиллуулахаар сонгосон тэр компьютер дээр хэн нэгэн хүн ажиллаж байвал яах вэ? Тоглолт дуусна гэсэн үг.

Тэр компьютерийнхээ гарнаас холдож, суниав. Тэр бараг 48 цаг унтаагүй учир ядарч байгаа бололтой. Заримдаа Антракс юм идэхээр явахдаа компьютерээ орхино. Гэхдээ буцаад идэх юмтайгаа компьютер дээр ирнэ.

Антракс мөргөл хийхээр өөрийн хакердах цагаа завсарлах шаардлага гарах болов. Лалын шашинтан хүн өдөрт таван удаа мөргөл үйлдэх заншлыг дагах нь туйлын чухал байлаа. Тэр

өглөө хоёр, үд дунд нэг, шөнөдөө хоёр удаа мөргөж шашныхаа үүрэг хариуцлагыг идэвхитэй биелүүлнэ.

Бүхэл шөнийн турш хакердахад цаг хугацаа нисэн өнгөрнө. Өглөөний нар тусах үед маш сонирхолтой аялалын ид дунд нисэж явдаг байлаа. Гэвч үүрэг бол үүрэг. Тиймээс хийх ёстой. Тэр контрол “S” товчлуурыг дарж дэлгэцээ амраагаад, мөргөлийн гудсаа дэлгэн Мекка руу хандаж, сөхрөн суулаа. Арван минутын дараа мөргөлийн гудсаа хурааж, компьютер дээр дахин сууж, контрол “Q” товчлуурыг даран ажилдаа оров.

Тус компаний компьютерийн систем түүнийг сэжиглэж эхэлсэн бололтой. Систем “X” төслийн эхний түвшин байсан бөгөөд бусад хэсэг нь дөнгөж эхэлж байжээ. Тэр Систем “X”-ийн файлуудын репортууд, олон хүснэгтийг олов. Репортонд “Сүлжээний урсгалын анализ”, “calls in”, “calls out”, “failure rate” гэсэн гарчигтай хэсэг байв. Үнэр авсны шинж гэж Антракс боджээ.

Систем “X” нь жагсаалтанд байгаа цэргийн телефон утасны холболтын байгууламж бүртэй холбогдож репорт авчээ. Систем “login” хийхдээ компьютер өөрөө үүсгэдэг хэрэглэгчийн нэр, пассвордыг хэрэглэсэн харагдана. Нэгэнтээ сүлжээнд орсны дараа Систем “X” дотор байгаа програм баазаас орж, гарсан дуудлагын дугаар зэрэг статистикийн чухал мэдээллийг авахаар ажиллажээ. Тэрхүү мэдээллийг Систем “X” дээр хадгална. Зарим нэг зүйлийн талаар репорт авахыг хүсвэл Систем “X”-ийг мэдээллийг багцал гэсэн команд өгөх болно.

Жишээлбэл: цэргийн баазаас сүүлийн 24 цагийн дотор гаднаас ирсэн дуудлагуудын жагсаалт ч юм уу. Энэ бүхнийг автоматаар хийх боломжтой.

Баазын телефон утасны шинэ шугам тавих, телефон зангилааны байгууламжинд өөрчлөлт хийхийг санал болгосон зарим цахим шууданг Антракс уншжээ. Урьд өмнө холболтыг гараар хийдэг байсан бол Систем “X” автоматаар хийх тухай тайлбарласан нь Антракст ихийг хэлж өглөө. Хүмүүсийн гараар хийдэг ажлыг уг систем маш хөнгөвчилөх ажээ. Үүнээс гадна 100 гаруй телефон утасны холболт байгууламжаар дайрч байгаа энкриптлээгүй утасны яриаг нууцаар чагнаж, сонсох боломжтой болно. Хэдэн командын тусламжтайгаар Филиппинд байгаа цэргийн баазын захирагчтай генерал ярьж байгаа зүйлийг сонсох болно. АНУ-ын хүчний эсрэг тагнуулын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага ийм мэдээллийг авахад нилээд мөнгө зарцуулна гэдэгт эргэлзэх зүйл алга.

Систем “X” болон 100 гаруй телефон холболтын байгууламжид хязгааргүй оролт хийх болсон хакерт сонголт олон байлаа. Тэр нэг шөнийн туршид АНУ-ын армийн дуут холбооны системийг хааж чадна. Тэнд үүсэх бужигнааныг төсөөлбөл үнэхээр аймшигтай санагдана. Систем “X”-ийн хэрэглэж байгаа автоматчиллын програмыг чадварлаг програмч хялбархан өөрчилнө. Нэг шөнийн туршид залгалтын бүх байгууламж руу залгалт хийлгэхэд арав түүнээс илүү тооны модемыг ашиглаж, статистикийн мэдээ шаардахын оронд Систем “X”-ийг бүхэл шөнийн турш холбогдож, байгууламжуудыг дахин програмчлахыг зааварчилна.

Генерал Колин Поувел харилцуураа авах тоолонд Оросын генералын албан өрөө рүү автоматаар холбогдчихвол яах бол? Тэр өрөөнийхөө утсаар ямар нэгэн өөр дугаар руу залгах боломжгүй болно. Тэр өөр дугаар руу залгасан ч утасны нөгөө үзүүрт Орос хүн дуугарна. Мөн генералын утасны дугаар руу залгах болгонд бичиг хэрэгслийн газар руу холбогдоод

байвал яах бол? Бүх утаснууд залгасан телефон утасны дугаартай холбогдохгүй байвал яах вэ? Хэн ч хүссэн хүн рүүгээ ярьж чадахгүй бол яахав? АНУ-ын цэргийн томоохон хэсэг зохион байгуулалтгүй болно. Дээр дурьдсан зүйлс дайны эхний хэдэн хоногт гарвал яах вэ? Систем “Х”-ийн дахин програмчилсан телефон утасны холболтын байгууламжийг чухал мэдээлэл дамжуулахад хэрэглэж чадахгүй.

Энэ бол үнэхээр эрх мэдлийг мэдрүүлж байв.

Түүний дуу хоолой аавынхаа эсрэг орилсноос хойш юу ч биш болж замхрахтай адилгүй ажээ. Тэр хүмүүсийг номхон зогсоож, босоогоороо анхааралтай сонсоход хүргэх эрх мэдлийг гартаа оруулжээ.

Системийг хакердсанаар бүхнийг хяналтандаа авсан мэдрэмжийг түүнд төрүүлэв. Системийн руутыг мэдэлдээ авсан тухай бодол орж ирэнгүүт л түүний цусаар адреналин шуугин урсах ажээ. Өөрөөр хэлбэл систем түүний мэдэлд бүрэн шилжсэн, тэр хүссэн бүхнээ хийнэ, хүссэн програмаа ажиллуулж, систем ашиглуулахыг хүсээгүй хэрэглэгчийг хасах боломжтой болжээ. Системийг би эзэмшдэг гэсэн бодол түүнийг эзэмдэв.

Түүний эзэмшилд орсон системийн жагсаалтыг тэр сонирхлоо. Системийн администратор тэдгээр системд “logon” хийсэн байхыг харна гэхээс Антраксийн уур хүрчбайв. Энэ бол булаан эзлэлт байсан юм. Хаалттай хаалганы цаана хэсэг хугацаанд ганцаар байсан эмэгтэйд Антракс өөрийн болгосонтой адилхан явдал болжээ. Тэр эмэгтэйд мэдэж эхэлж байтал өөр залуу хөндлөнгөөс орж ирээд түүнтэй юм яриад байгаатай адилхан санагдана.

Зайнаас системийг харах нь хэзээ ч хангалттай сэтгэгдэл төрүүлэхгүй бөгөөд хүсвэл хакердана гэдгээ мэднэ. Антракс системийг хакердах хэрэгтэй байлаа. Тэр үүнийг эзэмших ёстой. Системийн дотор юу байгааг тэр харах шаардлагатай, чухам юуг эзэмшээд байгаагаа мэдрэх хэрэгтэй. Админууд системийн аюулгүй байдлыг байнга оролдоод байдаг учир түүнд хамгийн их саад учруулна. Антракс үүнд их уурлаж байв. Антракс системтэй онлайн холбогдсон үедээ админуудын үйл ажиллагааг чимээгүйхэн ажиглаж, гэнэт тэднийг “log off” хийлгэх хүсэлд автана. Тэр админуудыг хашрааж, арга хэмжээ авахыг хүсэж байлаа. Хүний системд тэд орж ирсэн гэдгийг мэдрүүлэхийг хүснэ. Үүний хажуугаар тэдэнд өөрийгөө илчлэхийг хүсэхгүй байв. Тэднийг “log off” хийвэл аюулгүй байдлын ажилтнуудын анхааралд шууд өртөх бөгөөд хоорондоо сөргөлдөх хүсэл зориг хоёр тийш чангаана. Тэдний системийг хяналтандаа авсан гэдгийг мэдэгдэхийн сацуу одоо юм хийхээс өнгөрсөн гэж ойлгуулахыг Антракс хүсэж байлаа. Туслалцаа авах боломжгүй гэдгийг тэр илэрхийлэхийг хүснэ.

Гэвч Антракс нууц далд байхаар шийдэв. Тэр Систем “Х”-ийн телефон утасны холболтын байгууламжийн dial up, тэдний хэрэглэгчийн нэр, пассвордын жагсаалтыг олж авах зорилт тавьжээ. Ерөнхийдөө нэг хакер ганц модемоор АНУ-ын цэргийн холбооны сүлжээнд нөлөөлөл үзүүлнэ гэвэл нилээд хэдэн өдөр шаардагдана. Цэргийнхэн ухаан орж, сүлжээгээ хамгаалж эхэлтэл хэдэн утасны залгах төхөөрөмжийг жагсаалаас гаргачих л байх. Энэ бол цэргийн компьютерийг хакердсантай л адилхан юм. Чи компьютерийг энд, системийг тэнд авчихна гэсэн үг. Харин Систем “Х”-ийн хүч чадлын охь нь өөрийн эх сурвалжийг маш өргөн дэлгэр хүрээнд хурдан бөгөөд чимээгүйхэн ашиглах боломжтой оршино.

Дэлхийн хэмжээнд цохилт өгөх хүч чадалтай болсон гэж Антракс үзэж байв. Нээлт хийсны дараахан Систем “Х”-ийг хакердсан явдал жинхэнэ цохилт байлаа. Харилцаа холбооны компаний компьютерт сниффер програмыг хадгалвал таатай орчин мэт санагдав. Тиймээс нэг сниффер програмыг компьютерт суулгаж орхиод дараа буцаж ирэхээр шийджээ. Дараа нь “logout” хийж, орондоо оров.

Сниффер суулгасан компьютерт нэг өдрийн дараа буцаж ирсэн Антракс маш цочирдмоор мэдээлэл олж үзэв. Сниффер програмын бэлдсэн файлыг уншиж байхдаанэг оролтыг ажиглажээ. Хэн нэгэн этгээд компаний систем рүү түүний тусгай “login patch”-ийн паролдыг хэрэглэн “login” хийсэн байв.

Тэр тайван байхыг хичээнэ. Маш их бодлоо. Тэр хамгийн сүүлд хэзээ тэр тусгай паролдыг хэрэглэн систем рүү нэвтэрсэн бэ? Өмнөх хакердах ажиллагааны байдлыг түүний сниффер програм бичиж авсан байж болох уу? Хааяа нэг ийм тохиолдол байдаг. Хакерууд заримдаа өөрсдийгөө хөөрхөн бажгадуулдаг. Олон арван системийг хакердаж өдөр шөнөгүй суухдаа тодорхой ямах нэгэн систем рүү тусгай паролд хэрэглэж “login” хийснээ мартаж тохиолдол байна. Тэр бодох тусам өөртөө итгэлтэй болох ажээ. Тэр систем рүү дахин login хийгээгүй юм.

Тэгэхлээр ганц тодорхой асуулт үлдэнэ. Хэн бэ?

Заримдаа Антракс тоглоом хийнэ, хааяа хүндхэн шийтгэнэ. Шийтгэл хөнгөн, хүнд аль нь ч байж болно. Ихэнхдээ хатуу гэх үүдээ. Тэр олон янзын үйлдэл хийж байв. Жишээлбэл нэгэн номын санч байлаа. 1993 оны эхэн үед бүсийн ойролцоох хотын их сургуульд Антракс Ази Номхон далайн Бизнес сургалтын ангид элсжээ. Оюутны хотхонд ирэх тоолондоо их сургуулийн номын санд цагийн ажил хийдэг оюутанд чадуулна. Нэг бус нижгээд тохиолдолд хамгаалалтын албаны ажилтан түүний уншлагын ширээн дээр ирж цүнхийг нь нэгжсэн байна. Тэгээд ном олгох тавцан өөд харангуут өнөөх оюутан зогсож байдаг байв.

Антраксын найзууд хүртэл үүнийг ажиглах болжээ. Номын сангийн хаалгаар бусад оюутнууд чигээрээ гараад явна, харин түүнийг гарах тоолонд нэгжиж үзнэ. Номын сангийн номыг нэг хоног хэтрүүлж өгөнгүүт түүнээс бүх төрлийн торгуулийг номын санч шаардана. Их сургуулийн сургалтын хугацаа дуусч шалгалт ойртох үед Антракс номын санчийг гэсгээхээр шийджээ. Тэр номын сангийн бүхэл бүтэн системийг ажиллагаагүй болгоно.

Өөрийнхөө гэрээс модемоор холбогдон номын сангийн компьютерт “login” хийж, руут эрхийг Антракс хурдан олж авлаа. Худлаа ярьсан хүнд аюулгүй байдлын цоорхой нь бараг миль хүрэх хэмжээтэй байв. Дараа нь нэгэн жирийн командаар компьютер дээрх бүх файлуудыг устгалаа. Систем дээрх мэдээлэл хаа нэгтээ давхар хадгалагдаж байгаа гэдгийг тэр мэдэх бөгөөд системийг хэвийн ажиллуулахад дахиад нэг юм уу хоёр өдрийн хугацаа шаардагдах юм. Энэ хугацаанд ном хайх, түрээслэх ажлыг гараар хийх шаардлагатай болно.

Их сургуулийн эхний курст Антракс сурч байхад өчүүхэн зүйл л шийтгэл онооход хүргэж байлаа. Түүнийг машин бариад явж байхад хажуунаас нь шахсан нэгэн жолооч дээр төлбөр гаргуулахаа тангараглав. Танхай жолоочийн машины улсын дугаарыг тогтоож авсан Антракс түүний бусад мэдээллийг олж авчээ. Ихэнхдээ хулгайлсан машин гэж үзсэн мэдээллийг

цагдаагийн газар хүмүүс утасдаж хэлдэг байв. Тэр цагдаагийн мэдээлэлд шүүлт хийсний дараа жолоочийн нэр, хаягийг олж, цагдаагийн шалгах машин руу радио станцаар хэлүүлжээ. Антракс радио станцаар зарлуулах зүйлийг өөрөө бичсэн аж.

Дараа нь шийтгэх ажиллагаа эхлэнэ. Антракс жолоочийн гэр орны цахилгаан хариуцсан компани руу утасдаж эрчим хүчийг таслуулах захиалга өгнө. Маргааш өглөө жолоочийг гэртээ ирэхэд тог байхгүй, тасалсан байна. Магадгүй нэг өдрийн дараа түүний байгалийн хийн хоолойг хааж болно. Дараа нь усыг, дараа нь телефон утсыг нь хаалгана.

Хатуу шийтгэл оноосон хүний нэгт Билл орно. Англиар ярьдаг телефон утасны конференс харилцаа буюу Шведийн Үдэшлэг шугам дээр Биллийг Антракс анх ажиглажээ. Антракс уг шугам дээр байнга байх агаад хэдхэн сарын дотор фреакердэх аргаар 2000 гаруй удаа холбогдсон юм. Мэдээж оролдлого бүр амжилттай байгаагүй боловч холбогдсон хугацаа нь түүний хэрэгцээг хангалттай хангах ажээ. Уг конференс шугамд холбогдсоноос хойш арван минутын дараа автоматаар тасалдаг учир шугам дээр байнга байхын тулд нилээд хүч, тэвчээр шаардагдана. Антракс операторуудтай найз болсон учир түүнийг онлайн дээр арай илүү хугацаагаар байлгадаг болжээ.

Шведийн Үдэшлэг шугамын байнгын зочин, хар тамхичин Билл дөнгөж шоронгоос суллагдаад байв. Төмөр замын өртөөн дээр Вьетнам хүүг зодсон учраас шоронд орсон юмсанж. Тэр шугамд орж ирэнгүүтээ “Хэн нэгэн тэнэг энд байна уу?” гэж бүдүүлэг авирладаг байв. Эмэгтэй хүнд ч бас тийм ухаалаг хандахгүй ажээ. Тэр шугам дээр байнга орж ирдэг хүүхнүүдийг өдөж хоргооно. Нэгэн өдөр тэр алдаа хийжээ. Тэр сээтэгнэж байсан охинд өөрийн утасны дугаарыг өгөв. Оператор түүнийг хуулбарлаж аваад, тэр өдрийн үдээс хойш Антраксийн найз орж ирэнгүүт дугаарыг дамжуулжээ.

Антракс хэдэн долоо хоногийн турш Биллийн утасны экаунт дээр гарч ирэх телефон утасны дугаарыг нарийвчлан судалж, түүний амьдралын талаар төсөөлөлтэй болохыг хичээв. Билл урьд өмнө шоронд хоригдож байсан, хорт хавдраар өвчилж үхэх дөхсөн нэгэн байлаа. Антракс эмнэлэгт байгаа Билл рүү утасдаж, хүнийг сэтгэлээр унагах зорилгоор түүнтэй удаан ярьжээ. Удалгүй Билл нас барсан тухай Антракс сонсов. Харин хакер маань түүнийг арай л хэтрүүлчихлээ дээ гэсэн сэтгэгдэлтэй үлдсэн гэдэг.

Их сургуульд сурахаар явсны дараа Антракс гэр орны дарамтаас холджээ. Харин сургуулийн амралтаар гэртээ ирэхдээ аавыгаа араншинг тэвчиж чадахаа бүр больсон байв. Дараагийн удаа аавыгаа дахиад ингэх юм бол зодолдоно гэж тэр өөртөө тангаргалсан ажээ. Тэр ч бодсоноо хийв.

Антраксийн аав бага хүүгийнхээ ээрэхийг шоолон дуурайжээ. “Та ингэж болохгүй шүү дээ? Яаж байгаа чинь энэ вэ?” гэж Антракс орилов. Тэр аавынхаа тэнэгтэхийг таслан зогсоож чадлаа.

Тэр өөрийгөө ингэж хэлсэн гэдэгт итгэж ядаж байв. Антракс аав руугаа орилж, гараа зангидан хана цохижээ. Аав нь сандал барьж түүн рүү шидээд цагдаа дуудна гэж утас руу гүйв. Антракс хананд бэхэлсэн утсыг хуу татан хаялаа. Тэр аавыгаа хөөж, элдэх замдаа тааралдсан тавилга бүрийг шидлэн явжээ. Гэнэт Антракс ээжийнхээ дуртай цагийг эвдлэхээс

айж, замаас холдуулж тавив. Дараа нь стерео хөгжмөө өргөн, аав руугаа шидлээ. Хувцасны шүүгээ шалан дээр хөндлөн унажээ.

Түүний аав гэрээсээ гаран зугатсаны дараа Антракс ухаан орж, ойр орчноо харав. Газар хөдөлсөн мэт болжээ. Энэ бүх зүйлсийг ээж нь хайрлан цуглуулж, амьдралаа босгохын төлөө хуруу хумсаа хугалан байж хураасан билээ. Антракс хийсэн үйлдэлдээ ихэд гэмшив. Ээжийгээ сэтгэлээр унах зүйл хийсэн тэрээр юу хийхээ мэдэхгүй тээнэгэлзэнэ. Тэр цагаас хойш Антракс уураа барьж, биеэ хянахыг хичээхээр шийджээ. Энэ байдлаар яваад байвал маргаан үргэлжилсээр байх болно.

Антракс хэн түүний “login patch” пассвордыг хэрэглэсэн байж болох талаар бодно. Магадгүй Антраксийн login хийхээс өмнө өөр хакер сниффер програм суулгасан байж болно. Тэр хүн бол аюулгүй байдлын админ байх магадлалтай. Өөрөөр хэлбэл тэр Антраксийг мэдсэн гэсэн үг. Систем “X”-ээр харилцаа холбооны компаний компьютер руу үсэрч ороход хүртэл мөшгисөн байж болохыг илтгэнэ.

Антракс системийн админы шуудангийн хайрцаг руу чиглэв. Хэрэв тэр азаартсан бол шуудангийн хайрцагт ямар нэгэн мэдээлэл хадгалагдаж байх учиртай.

Тэнд нотлох баримт байна. Тэд түүнийг мөшгиж, цаг хугацаа огт алдаагүй ажээ. Админ CERT (Computer Emergency Response Team) буюу Меллоны Их сургуулийн Компьютерийн яаралтай тусламжийн багт захидал илгээжээ. Интернет хакеруудын хараалыг идсэн газар бол яах аргагүй CERT байлаа. Одоо хууль хамгаалах байгууллага руу утасдаж байгаа нь гарцаагүй.

Одоо системээс хурдан гарах учиртай. Гэхдээ сүүлээ хавчаад зугатахгүй хөөрхөн бэлэг үлдээнэ. Өөрөөр хэлбэл тоглоно.

CERT-ийнхэн админ руу болсон явдлыг бүртгэж авсан тухай захиа ирүүлэв. Админуудын нэг болж жүжиглэсэн Антракс CERT рүү захидал бичив. Албан ёсны болж харагдуулахын тулд хэргийн дугаарыг “лавлагаа” болгон нэмжээ. Уг захидалд:

“..... дугаарын хэрэгтэй холбогдуулж, бид нэмэлт олон шалгалтыг явуулж байна. Аюулгүй байдалд заналхийлсан энэ үйлдлийг архинд орсны улмаас ажлаас халагдсан этгээд компаниас хариугаа авахын тулд хийсэн болохыг олж тогтоолоо. Компаний ажиллах орчингоос үүдэлтэй сэтгэлийн дарамтнаас болж архи, мансууруулах бодист автах хүндрэлтэй бид тулгараад байна. Цаашид мөрдөн шалгалт явуулах шаардлагагүй” гэжээ.

Компьютер дээрээ сууж байгаа Антракс инээд алдана. Тэд үүнийг уншаад яах бол? ...

Компаний компьютер дээр үлдээсэн бүх ул мөрөө цэвэрлэж, сниффер програмаа устгаад тэр сүлжээнээс гарлаа.

Хожим сниффер програмын хийсэн бичлэгийг шалгахын тулд Систем “X” рүү ороход хэн нэгэн этгээд түүний “login patch” пассвордыг хэрэглэснийг олж мэдэв. Тэр маш их тавгүйтжээ. Худалдааны ямар нэгэн сайтаар хэсүүчлэх нь нэг хэрэг, цэргийн компьютерээр мөшгүүлэх нь өөр асуудал юм.

Систем “Х” дээр шинэ процесс нэмснийг Антракс ажиглав. Үүнийг –и гэж нэрлэнэ. Урьд өмнө цэргийн систем дээр харж байсан боловч яг ямар зорилгоор ашигладаг гэдгийг тэр мэдэхгүй байлаа. 24 цаг болсны дараа түүнийг системээс хүчээр гаргасныг тэр мэдэв. Тэр –и процессыг зогсоохыг оролдсон боловч секунд хүрэхгүй хугацааны дараа дахин гарч ирнэ. Тэр нэгэнт гарч ирсэн л бол устгах аргагүй ажээ.

Сэтгэл цочирдуулсан бусад цахим шууданг Антракс олж уншив. Систем “Х” болон компаний системийн админууд сэрэмжлүүлэх захидал илгээжээ. Үүнд: “Танай сайтанд аюулгүй байдалтай холбоотой зөрчил гарсан гэж бид бодож байна” гэжээ. Тойрог хумигдаж байгаа юм байна. Одоо л хурдан зайлах цаг боллоо. Тэр өөрийн юмсыг яаран хураан авч, снифферийн програмыг устгав. Файлуудаа зөөж, “login patch”-ыг авчээ.

Холболтоо салгасны дараа Антракс админуудын талаар бодож байв. Тэдний системд түүнийг орсныг мэдэж байгаа юм бол сниффер програмыг яагаад үлдээгээд, ажиллуулаад байна вэ? “Login patch” програмыг оролдохгүй орхисныг би ойлгож байна. Магадгүй тэд түүнийг мөшгих, болон нэгэнт л нэвгэрсэн учир холболтыг нь шалгахыг хүсэж байгаа биз. Харин “patch”-ийг устгана гэдэг нь админууд түүнийг ажиглах цорын ганц хаалгыг цоожилчихож байгаа гэсэн үг юм. Тэд систем рүү нэвтрэх өөр арын хаалга байгааг мэдэхгүй. Харин сниффер? Ямар нэгэн санаа огт төрөхгүй юм. Яах гэж үлдээсэн вэ?

Тэд сниффер програмыг хараагүй байж болно. Гэхдээ тэд ажиглахгүй өнгөрнө гэж баймааргүйсэн... Хэрэв тэд алдсан бол системийн гарч орох оролтуудыг админууд хянаж байсан биз. Холболтыг хяналтандаа авсан бол сниффер програмыг харах л байсан. Харин холболтыг хянаж байгаагүй бол “login patch”-ийн тусгай пассвордыг яаж олж чадах юм бэ? Систем дээрх бүх пассвордуудын адил түүнийг энкриптэлсэн байдаг. Тэр пассвордыг авах хоёр арга зам байна. Холболтыг хянаад снифферийг ажиллуулна. Эсвэл шууд хүч хэрэглэн энкриптийг тайлна.

Энкриптийг эвдэнэ гэдэг компьютерийн сая сая цагийг авах байсан биз. Тэр хэзээ ч ийм сонголтыг хийхгүй. Тэгэхлээр сниффер програмыг ажиллуулж үлдээсэн бол өөрийн сниффер програмд мэдээлэх болно. Сниффер програмыг санаатайгаар ажиллуулж үлдээх ёсгүй. Түүний снифферээр хакерыг ажиглаж байгааг хакер өөрөө мэдчихнэ гэдгийг тэд санаж л байх учиртай. Асуудал маш ер бусын дүгнэлт рүү хөтөлнө.

Түүнийг хөөж байгаа админуудын тухай Антракс боджээ. Тэдний тактик, стратегийг эргэцүүлнэ. Яагаад?.. хакердах үед тохиолдох хамгийн толгой эргүүлсэн асуудлуудын нэг байлаа. Зарим асуултуудын хариуг олж чадахгүй шаналах нь сониуч занг улам хөдөлгөх хөшүүрэг болно. Хашааг давж, нөгөө талд байгаа зүйлийг харах боломж байна уу?

“Хоригдлын сонголт”

“Харрисбург минь дээ. Ургамал ногоо хатаж Харрисбургийн хүмүүс хотоо орхин явж байна. Тэр зүйл чамд нөлөөлвөл чи гарч чадахгүй шүү” Харрисбург аас иш татав. Midnight Oil хамтлаг. Red sails in the Sunset цомог.

Антракс хэзээ ч баригдахгүй гэдэгт найдна. Гэхдээ тэр хачирхалтай гэмээр шалтгаанаар баригдахыг хүссэн гэдэг. Тэр өөрийгөө баригдах гэж байна гэж бодонгуут маш хачин сэтгэл хөдлөлд баригдсанаа мэдэрчээ. Магадгүй түүний өрсөлдөгчид тактик муутай, болхи байсанд цухалдсан сэтгэл байж болох юм. Тэд түүний мөрийг байнга алдаж, өөрсдийн чадваргүй байдалд тэвчээргүй хандаж байсан бизээ. Нилээд хүчтэй өрсөлдөгчийг давж гарна гэдэг амархан бус байх нь гарцаагүй юм.

Магадгүй мөшгүүлэхийг хүсээгүйтэй адилхан баригдахыг үнэхээр хүсээгүй байж болох билээ. Системийн администраторууд түүнийг отоож, цагдаагийнхан мөшгиж байгаа гэсэн санааг төсөөлөхөд Антракст сайхан байв. Түүний мөрдөн байцаалтын талаар хүмүүсийн цахим шуудангаас олж мэдэхэд түүнд таатай санагдана. Антраксыг хаанаас орж ирж байгааг мэдэхийг оролдож онлайн дээр байх түүнд сайхан байдаг байв. Тэднийг ажиглах боломжгүй аргаар компьютерүүдийг нь хяналтандаа авна. Тэрээр хүмүүсийн шивсэн тэмдэг бүрийг, бичгийн алдааг, буруу өгсөн командуудыг мөн түүнийг барихаар хийх хоосон оролдлого бүрийг харж сууна.

1991 оны эхэн хүртэл Антракс баригдаагүй байв. Хожмоо “Бурхны айдас” гэж нэрлэсэн ярианы дараа Антракс хакердах, фреакинг хийх ажиллагаагаа бараг больжээ.

Шөнө дундаас хойш Их сургуулийн компьютерийн системд ортол өөр нэгэн хакертай тааралдав. Энэ бол хамгийн нийтлэг тохиолдол биш юм. Мэдээж хакер өөрсдийн эгнээний нэгийг эргэлзэлгүй танина. Шөнө дундын үед сонирхолтой газарт үүссэн хачирхалтай холболтууд. Програмын болон процессын нэрс болон хэмжээ нь хувирамтгай, тохиромжгүй харагдана. Тэднийг хэрхэн олохыг мэдэж байгаа хүмүүст бол учир шалтгаан нь ил, шууд мэдрэгдэнэ.

Хоёр хакер бие биенээ тойрон бүжиглэж, хэн нь илүү их мэдээлэл үлдээхийг олж харахыг хичээнэ. Эцэстээ нууцлаг хакер Антраксаас: “Чи хонинд халдварладаг өвчин мөн үү?”

“Тиймээ” гэж Антракс маш энгийн хариулт хэлэв.

Нөгөө хакер өөрийгөө Прайм Саспект, “Олон улсын босогчид” бүлгийн гишүүн гэж танилцуулав. Антракс тэр нэрийг мэдэх ажээ. Прайм Саспектыг BBS-ийн сайтууд дээр харж, байрлуулсан мэдээллийг нь уншдаг байв. Антракс нөхөрсөг яриа үүсгэхээс өмнө Олон улсын босогчид бүлгийн гишүүн түүнд яаралтай сануулга илгээжээ.

Холбооны мөрдөгчид Антраксийн мөрөөр орсон тухай өгүүлсэн цахим шуудангуудыг тэр тайлбарлав. Miden Pacific дахь системийн админуудаас авсан шууданд Антраксийн зочилж

байгаа системүүдийг тодорхойлсон байв. Бусдын системд нэвтрэхдээ хэрэглэж байгаа түүний утасны холболтууд, “Telecom” түүний утаснышугмыг мөшгиж олсон талаар цахим шууданд бичжээ. Админуудын нэг нь: “Бид түүний мөрөөр орлоо. Би маш их цочирдлоо. Тэр арван долоон настай. Түүнийг илрүүлж, амьдралыг нь сүйтгэнэ” гэж бичсэн байв. Антраксын нуруу хүйт даан чийхрав.

Прайм Саспект мэдээллээ үргэлжлүүлэв... Эхлээд тэр цахим шууданд өөрийнх нь тухай өгүүлсэн байна гэж боджээ. Хоёр хакер нас чацуу байсан бөгөөд нэг ижил системд нууцаар нэвгэрч таарсан байв. Прайм Саспект шууданг галзуу мэт ухаж сэндийчжээ. Олсон захидлуудаа бүлгийнхээ хоёр хакерт үзүүлж, санал бодлоо солилцсон гэнэ. Захидалд дурьдсан олон зүйл таарч, хэдхэн мэдээлэл зөрж байв. Прайм Саспект хөдөөний телефон утасны холбох байгууламжаас дуудлага хийж үзээгүй ажээ. Тэд шууданд бичигдсэн мэдээллийг нэг бүрчлэн шалгах тусам хэн нэгэн өөр хүний тухай яриад байна гэдгийг мэджээ. Тэд бусад олон сонголтуудын жагсаалтыг шүүн үзээд Антракс байж болох юм гэж үзэв. Олон улсын босогчид бүлгийн хакерууд түүнийг нилээд хэдэн BBS болон системд түүнийг харжээ. Мөн өөр нэгэн фреакерын хамт конференс дуудлага хийж байхад Тракс түүнтэй ярилцаж байв. Хакерууд Антраксын тухай мэдэх бүхнээ ярилцаж, түүнийг гарцаагүй тогтоожээ. Австралийн Холбооны цагдаагийн газрын мөрдөгчид Антраксыг гадарлах болсон тул мэдээлэл хангалттай цуглуулав. Түүний гэр рүү орсон телефон утасны шугамыг дагаж, түүний нэрийг тогтоожээ. Тиймээс түүний нэрийг мөн адил мэдэж байгаа нь гарцаагүй болов. Утасны билл нь түүний эцэг эхийн нэр дээр гардаг учир Антраксыг нууцаар хянаж байж болзошгүй байв. Олон улсын хакер бүлгийн гишүүд түүнийг хамгаалж, анхааруулахыг хүссэн бөгөөд анх удаагаа холбоо тогтоож байгаа нь энэ байлаа.

Прайм Саспектэд Антракс талархсанаа илэхийлээд системээс гарч одов. Шөнийн чимээгүйд сандал дээр гөлрөн сууна. Нотлох баримтанд санаа зовохоос илүүтэй сэтгэлийн хөдлөлд баригдана гэсэн бодолд автжээ. Энэ бол түүний амьдралдаа үзэж байгаа анхны дотоод зөрчилдөөн байв. Өглөө нь тэр хакердахтай холбоотой цаас, тэмдэглэл, гарын авлага бүхнээ цуглуулахад гурван хайрцаг материал болжээ. Тэр гэрийн арын цэцэрлэгт гурван хайрцаг материалыг аваачиж, шатаав. Шатаж байгаа үнэт материалаа гөлрөн харах зуураа Антракс дахин хэзээ ч хакердахгүй гэж өөртөө амлав.

Гэвч тэр хэсэг хугацаанд л хэлсэн үгэндээ хүрчээ. Хэдэн сар өнгөрсөн боловч цагдаа нар үзэгдсэнгүй. Прайм Саспектын сэжиглэл худлаа байсан бололтой. Магадгүй Холбооны мөрдөгчид өөр хакерын хойноос явж байгаа байх.

1991 оны 10-р сард Австралийн Холбооны цагдаагийн газрын мөрдөгчид Прайм Саспект, Мендакс, Тракс нарыг илрүүлжээ. Харин Антракс бас дахин хоёр жилийн турш бие даан хакердсан байв. Олон улсын босогчид бүлгийн хакерууд баг болж ажилласан гэдгийг тэр байнга өөртөө сануулж байлаа. Бусад хакеруудыг илрүүлсэн мөртлөө намайг илрүүлээгүй юм чинь одоо түүнийг барьж чадахгүй гэж бодно. Цаг хугацаа өнгөрөх тусам тэр бусдын анхаарлыг татахгүйгээр, өөрийн ул мөрийн маш сайн далдалсан ур чадвартай хакер болжээ. Түүний амьдарч байгаа газар бол хүний хөлөөс зайтай, цагдаа нар ийм хол газар руу хэзээ ч зүглэхгүй. Хүний хөлөөс хол байгаа Антракс үүрд эрх чөлөөтэй байж, компьютерийн нууц ертөнцдөө ялагдашгүй Нед Келли байх болно. (Нед Келли бол олон жилийн турш

баригдалгүй явж чадсан алдарт гэмт хэрэгтэн байсан юм)

1994 оны 7-р сарын 14-ны өдрийн өглөө Антраксийн ой ухаанд маш олон бодол эргэлдэж байв. Нэг оюутантай хамт өрөө хөлсөлж байсан, хоосон шахуу байранд нь ачаа зөөх хүмүүс ирэх болжээ. Хамт өрөө хөлсөлж байсан оюутан аль хэдийнээ явсан агаад байранд нь хувцас, хуурцаг, ном хураасан хайрцагнууд үлджээ.

Байрны гадаа машин ирж зогсох үед Антракс орон дээр хэвтгээд “Today” шоууг унтах хэвтэхийн хооронд үзэж байв. Гэр нүүлгэдэг машин ирж байгаа гэж бодсон Антракс цонхоор харлаа. Энгийн хувцастай дөрвөн хүн түүний гэрийг чиглэн гүйж харагдана. Байрны хаалганд дөхөж ирэхээс өмнө тэд хоёр хэсэгт хуваагдлаа. Нэг нь машины зогсоол руу, нөгөө байрны нэг хэсэг рүү, гуравдахь нь үүдний хаалгыг тогших ажээ. Антракс толгойгоо сэгсрэн болж байгаа үйл явдлыг ойлгохыг хичээнэ.

Үүдний хаалган дээр зогсох намхан, бахим эр сэтгэл түгшээнэ. Тэр урт, сэвсгэр үстэй агаад хоолой барьсан цамц, халаасанд нь байгаа мөнгийг нь тоолж болохоор шахуу бариу өмд өмсчээ. Муу ёрын бодол Антраксын толгойд эргэлдэв. Түүний байр руу гадны этгээдүүд довтолж, үнэт зүйлийг нь дээрэмдэх гэж байгаа мэт санагдав. “Хаалгаа онгойлго, хаалгаа онгойлго” гэж намхан эр цагдаагийн үнэмлэх үзүүлэх зуураа ориллоо.

Айж балмагдсан Антракс хаалгаа нээв. “Биднийг хэн болохыг чи мэдэж байна уу?” гэж булчинлаг эр асуулаа.

“Үгүй” гэж сандарсан Антракс хариулав.

“Австралийн Холбооны цагдаа” гэж хэлээд нэгжлэг хийх зөвшөөрлийн бичиг харууллаа.

“Чиний компьютер хаана байна?” гэж булчинлаг эр Антракс руу архиран асуув.

“Ямар компьютер?” гэж цагдаа руу гайхан харлаа. Энэ гэртээ тэр ямар ч компьютер авчираагүй аж. Тэр найзынхаа болон их сургуулийн компьютерийг ашиглаж байжээ.

“Чиний компьютер. Хаана байна? Чиний найзын компьютер хаана байна?”

“Хэн ч компьютергүй шүү дээ. Надад бол байхгүй”.

“Тэгэхлээр хаана байгааг бидэнд хэлэхээр шийдсэн үедээ хэлнэ биз”.

Цагдаагийнхан түүний хувийн захидлуудыг үзэж асуулт асууна. Хэн энэ захиаг бичсэн юм? Компьютерийн хакер мөн үү? Түүний жинхэнэ хаяг нь юу вэ? гэх мэт асуултаар булж эхлэв.

Антракс асуултанд хариулахгүй гэж тоогоо мартгал олон хэлжээ. Унтлагын өрөө рүү орж байгаа цагдаа нарыг ажиглах хэрэгтэй гэж тэр бодоод хойноос нь дагав. Түүнийг өрөө рүү оронгуут нэг цагдаа зогсоолоо. Антракс хуульчтайгаа уулзахыг хүсэж байгаагаа илэрхийлэв. Цагдаа нарын нэг нь түүний саналыг эсэргүүцсэн байртай харжээ.

“Чи буруутай л болж таарлаа. Зөвхөн гэм буруутай хүмүүс л хуульч асуудаг юм. Би чиний

өмнөөс харамсаж байна” гэж тэр Антракст хэлэв.

Дараа нь мөрдөгчдийн нэг нь ярианд оролцож: “Чи мэдэх хэрэгтэй болов уу. Бид танай ээж аавын гэрийг чинь мөн адил нэгжиж байгаа” гэж өгүүллээ.

Антракс тэвджээ. Түүний ээж л лав ухаан санаагаа алдтал уурлах байх. Тэр гар утсаараа ээж рүүгээ утасдахыг хүсэв. Харин цагдаа нар түүнийг гар утсаар ярихыг нь хоригложээ. Дараа нь ээж рүүгээ төлбөртэй утаснаас ярихыг хүсэв. Цагдаа нар дахиад зөвөөрсөнгүй.

Өөр нэгэн өндөр, туранхайвтар цагдаа түүний сандарч байгааг ажиглах зуураа: “Ээж чинь бие муутай байна лээ. Өвчтэй ээждээ ийм зүйл хийж байх ч гэж дээ. Бид түүнийг Мелбурн руу байцаахаар авч явах гэж байгаа. Магадгүй түүнд ял оноож ч магадгүй. Баривчлаад шоронд хийж ч магад. Чи миний толгойны өвчин болсноо мэдэж байна уу. Түүнд бүх гай гамшгийг учруулж байгаа чам шиг хүүтэй эхийн өмнөөс харамсах сэтгэл төрж байна” гэв.

Тэр хормоос хойш өнөөх өндөр ажилтан Антраксын өвчтэй ээжийн талаар боломж олдох бүрийд ярьж байв. Антракс тоосон шинжгүй байхыг хичээнэ. Түүний ээжийг зовоож байгаа үхлийн өвчний талаар ч мань цагдаа мэдэхгүй биз. Биеийн гадна хэсгээс дотор эрхтэн рүү нөлөөлж байгаа ээжийнхээ өвчинг Антракс байнга бодож байлаа. Склеродерма хөл гарын арьсан дээр гарч хөрсжөөд, маш мэдрэмтгий болгоно. Ялангуяа цаг агаарын өөрчлөлт их байгаа үед. Халуун уур амьсгалтай газраас хүйтэн уур амьсгалтай газар амьдрахаар ирсэн эмэгтэйчүүдэд их тохиолддог өвчин юм.

Антраксийн гар утас дуугарав. Түүний ээж нь ярихыг оролдонгуут цагдаа нар хариу хэлэхийг зөвшөөрсөнгүй. Өндөр цагдаа утас авангуутаа булчинлаг мөрдөгч рүүэргэн, доогтойгоор: “Энэтхэг аялгатай нэгэн эмэгтэй ярьж байна” гэж Энэтхэг аялгаар хэлэв. Антракс уурандаа сандлаас үсрэн босож, гар утсаа шүүрэн авахыг хүсэж байлаа. Булчинлаг цагдаа өндөр рүү толгой дохиод тэр гар утсыг Антракс руу өгөв.

Эхлээд тэр ээжийнхээ юу ярьж байгааг ойлгохгүй байлаа. Тэр маш их сандарчээ. Антракс түүнийг тайвшруулахыг оролдоно. Дараа нь ээж хүүгээ тайвшруулахыг оролдов.

“Бүх зүйл зүгээр болно” гэж ээж нь байн байн хэлнэ. Антраксыг юу ч хэлсэн ээж нь дээрх үгийг маани аятай давтан үглэнэ. Антракс утасны цаана болж байгаа чимээг сонсохыг хичээх бөгөөд цагдаа нар гэр орныг нь нэгжиж байгаа бололтой. Ээж нь гэнэтхэн утсаа таслах болсноо хэлэв.

Антракс гар утсаа цагдаад буцааж өгөөд, толгойгоо хоёр гараараа даран суулаа. Ямар хүнд нөхцөл байдалд оров оо... Түүнд тохиолдож байгаа зүйлд тэр итгэхгүй байлаа. Цагдаа нар Мелбурн руу ээжийг нь аваачиж байцаах шаардлага байгаа юм болов уу? Ээжийнхээ гэрээс фреакердсэн гэдэг нь үнэн. Гэхдээ ээж ньхакердах, фреакердах талаар юу ч мэдэхгүй шүү дээ. Ээжийг нь шийтгэвэл, түүнийг аллаа л гэсэн үг. Бие болон сэтгэлийн ийм байдалд байгаа ээж нь шууд л хойд нас руугаа явна шүү дээ.

Түүнд олон сонголт байхгүй ажээ. Нэг цагдаа гар утсыг нь гялгар хүүдийд хийж, шошго тавьж байна. Цагдаа нар утсаар ярихыг хориглож байгаа учраас хуульч руу утасдах ямар ч

боломж байхгүй. Түүнийг Мелбурн руу авч явж, байцаана хэмээн цагдаа нар хэлж байна.

“Хамтран ажиллана гэдэг л чиний хамгийн сайн сонголт болов уу. Одоо бидэнтэй явж хамтран ажиллана гэдэгт итгэж байна” гэж цагдаа нарын нэг хэллээ.

Тэр цагдаа нарт байцаалт өгөхийг зөвшөөрчээ. Гэхдээ өөр өдөр байцааж болохгүй л юм байхдаа?

Цагдаа нар машиныг нь нэгжихийг хүсэв. Машинд гэмт хэрэгтэй холбоотой ямар ч нотлох баримт байхгүй учир Антракт таалагдахгүй байлаа. Лалын шашны дэг жаягийг дагаж гэртээ хөл нүцгэн явдаг байсан учраас Антракс гутлаа өмсөлгүй өвлийн өглөө хөл нүцгэн гадагш гарав. Цагдаа гайхан даарч байгаа эсэхийг асуулаа.

Харин нэг цагдаа Антраксийн өмнөөс “Үгүй дээ. Мөөгөнцөр тэдний хөлийг дулаан байлгадаг юм” гэж даажигнав.

Антракс шүдээ зуун, уураа барьж байлаа. Арьс өнгөөр ялгаварлах зовлонг хангалттай үзлээ. Цагдаа нараас шүү. Одоо тэр маш их уурлажээ.

Их сургуульд сурч байгаа хотод түүнийг нутгийн уугуул аборгени гаралтай гэж үздэг байв. Тэр улсад хоёр л арьстан байдаг. Цагаан ба Аборгени. Энэтхэг, Пакистан, Малайз, Бирм, Шриланк байх нь огт хамаагүй. Тэднийг Аборгеничүүд гэж үздэг байлаа.

Нэгэн удаа гэрийн гадна орших төлбөрт утаснаас ярьж байхад нь цагдаа нар ирж, юу хийж байгааг нь асуужээ. Утсаар ярьж байгаа нь илэрхий учраас юу хийж байгаагаа хариулав. Тэд түүний бичиг баримтыг шалгаж, халаасанд байгаа зүйлийг нь үзэв. Түүний халаасанд байгаа гар утсыг хулгайлсан биз хэмээн серийн дугаарыг шалгахаар авч явсан байна. Арван таван минутын турш хоргоосны эцэст уучлалт гуйсан болоод явуулжээ. “Чи ойлгож байгаа байх л даа. Чиний төрлийн хүмүүс ойр хавьд үзэгдээд байдаггүй юм” хоёр цагдаагийн нэг нь хэлжээ.

Тиймээ. Антракс ойлгожээ. Бараан арьстай хөвгүүн олон нийтийн утсаар яриад явах нь сэжигтэй харагдана.

Үнэндээ бол цагдаа нарыг ирэх үед Антракс Канад руу фреакердэх аргаар ярьж байсан тул утсаа тавихдаа нэг их түвэгшээсэнгүй. Бусад фреакеруудэд байж байгаарай гэж хэлжээ. Цагдаа нар явсны дараа утсаар үргэлжлүүлэн тоглов.

Тэр цагдаа нараар тоглох нь уурлахаас хамаагүй дээр гэдгийг эртнээс ойлгожээ. Тэднээр жаахан тоглоход яадаг юм. Чимээгүйхэн дотроо инээж, тэдэнд юу ч мэдэх боломж олгохгүй. Тиймээс тэр мөөгөнцрийн тухай яриаг үл тоомсорлож, машин руу дагуулан очив. Цагдаа нар юу ч олсонгүй.

Цагдаа нар явахдаа Антракт Австралийн Холбооны цагдаагийн газрын утастай нэрийн хуудас өгөөд “Байцаалт өгөх цагаа товлоод бидэн рүү утасдаарай” гэв.

Антракс цагдаа нар байцаалт авахаар утасдах бүрийд “би завгүй байна” гэж зугатаасаар байв. Харин цагдаа нар ээж рүү нь утасдаж эхлэнгүүт байдал хүндхэн болжээ. Түүний ээжтэй эелдгээр ярихын сацуу заналхийлэл хийж байгаа нь дарамттай байлаа.

“Үүнийг хэлэхэд хэцүү байгаа ч танд хэлэхгүй бол болохгүй байна. Антраксын хийсэн үйлдлийн төлөө таныг шийтгэх болоод байна. Жишээлбэл хакердах, фреакинг хийх гэх мэт. Хэрэв тэр бидэнтэй хамтарч ажиллахгүй бол... Инээдтэй санагдаж байж болох ч бидэнд байгаа эрх мэдлийн хүрээнд л хэлэхэд ийм байна. Үнэндээ бол хуулийн дагуу хийнэ гэвэл... утасны дугаар таны нэр дээр байгаа учраас...”

Түүний аавын нэр гэрийн утасны дугаар дээр байхад яагаад аавынх нь тухай ярихгүй байгаад Антракс гайхаж байв. Тэр шугам хүртэл хууль бус дуудлага хийхэд ашиглагдсан шүү дээ.

Түүний ээж нь сандарч эхлэв. Цагдаа нартай хамтран ажиллаач гэж ээж хүүгээсээ гуйжээ. Ээжийгээ хамгаалах үүрэгтэй тул их сургуулийн шалгалтын дараа байцаалт өгөхийг зөвшөөрчээ. Түүний ээжийг яллана гээд байгаа болохоор л тэр үүнийг хийж байгаа юм. Ээжийг нь шүүх ажиллагаанд оролцуулбал насыг нь богиносгож, эрүүл мэндийг нь муутгана гэдэгт тэр итгэлтэй байв. Арван нэгдүгээр сарын нэгэн сайхан өдөр аав нь түүнийг их сургуулиас авч, Мелбурнийн зүг давхилаа. Хууль болон цагдаагийн тухай бүхнийг мэдэх болсон ээж нь түүнийг байцаалтанд ор гэж шаарджээ. Антракс аавын хамт явахаас татгалзсангүй.

Хот руу явах замд Антракс байцаалтанд хэрхэн хариулах талаар ярилцав. Австралийн Холбооны цагдаагийн мөрдөгчид түүний хакерын тухай бус фреакерийн талаар асууна г гэж хэлсэн нь бас таатай санагдаж байлаа. Хамгийн сүүлийн үед хийсэн зүйлийн тухай ярих юм байна гэсэн ойлголттой Антракс байцаалтанд оров.Түүнд хоёр сонголт байна. Эхний хуульчийн сануулснаар бүхнийг хүлээн зөвшөөрөөд цэвэрхэн гарч ирэх. Эсвэл хамтран ажиллаж байгаа мэт дүр гаргаад өөрийн зөн совинг дагах.

Түүний аав нь хоёрдугаар сонголтыг илүүд үзжээ. “Чи тэдэнтэй хамтран ажиллах хэрэгтэй. Чамайг худлаа ярьж байгааг тэд мэдэх болно. Тэд худлаа ярих этгээдийг илрүүлэхийн тулд бэлтгэгдсэн байдаг. Тэдэнд бүгдийг яриад, сэтгэл амар яв. Хууль, дүрмийг дагах нь сэтгэлд амар” гэж аав нь хэлжээ.

“Ер нь тэд өөрсдийгөө хэн гэж бодоод байгаа юм бэ? Гахайнууд...” гэж Антракс хэлээд өөрийнх нь ээж мэтийн хүмүүсийг дарамталсан цагдаа нарыг үзэн ядаж байв.

“Тэднийг гахай гэж дуудаж болохгүй. Тэд бол цагдаагийн ажилтнууд. Чи хүнд байдалд орвол хамгийн эхэнд л тэднийг дуудна шүү дээ” гэж аав нь хэлэв.

“Өө тийм билүү. Би ямар төвөг бэрхшээлтэй учирч Холбооны цагдаа руу утасдах билээ?” гэж Антракс хариулав.

Байцаалтанд хариулахгүй удаан сууснаар өөрийн аавыг хэрэгт орооцолдуулах байдалд Антракс орж болно. Тэр мэдээж хувийн дэмжлэг өгөхөөр тэнд очоогүй.Тэдний хоорондох харилцаа маш хол байдаг. Түүний аав нь одоо амьдарч, ажиллаж байгаа хотод Антраксыг

ирэхэд ээж нь тэрхүү хол байгаа харилцааг ойртуулахыг хичээжээ. Асуудлыг халуун дулаан болгохын тулд Антраксыг хоолонд оруулахыг хүртэл аавд нь санал болгов. Тэд оройн хоолонд олон удаа хамт орж, Антракс аавынхаа лекцийг сонсоно. Буруугаа хүлээчихээ... Цагдаа нартай хамтарч ажилла. Амьдралаа бод. Хариуцлагатай бай. Огт хэрэггүй амьтан болохоос өмнө тэнэглэхээ зогсоо.

Антраксийн хакердах ур чадварын ачаар аав нь нилээд ашиг тусыг олсон гэж Анитракс бодож байв. Антракс маш их хэмжээний мэдээллийн сан руу орсныг тэр мэдмэгц “шорон” гэсэн үгийг агуулсан нийтлэлийг шүүж гаргахыг хүүгээсээ гуйж байжээ. Дараа нь тэр сахилга бат гэсэн үгтэй нийтлэлийг хайлгах болов. Хайлтууд нилээд хэдэн мянган долларын үнэтэй байж таарна. Харин аав нь Антракс хүүгийнхээ ачаар нэг цент ч гарзсангүй. Тэгээд дараа нь хакердах үйлдлийн муу нөлөөний талаар Антракст лекц уншихад их цаг зарцуулсан гэдэг.

Австралийн Холбооны цагдаагийн төв байранд ирэнгүүтээ хүлээн авах хэсэгт хөлөө сандал дээр тэгнэн суух Антракс замдаа авсан кока колаг онгойлгон тухлав. Түүний аав сэтгэлээр унасан харагдана.

“Чи сандал дээрээс хөлөө ав. Кока кола авчрах шаардлагагүй байсан юм. Соёлтой харагдахгүй байна”.

“ Хөөе, Би энд байцаалтыг өгөх шаардлагагүй” гэж Антракс хариулна.

Цагдаа Андрию Секстон ирж Антракс, түүний аав хоёрыг дээш гарган кофегоор дайлав. Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөгч, түрүүч Кен Дей уулзалтанд орсон тул байцаалтыг хэсэг хугацаанд хойшлуулах болсноо Секстон хэлжээ. Антраксын аав, Секстон хоёр хууль хамгаалах байгууллагын ажлын талаар ижил сонирхол, бодолтой байгааг олж мэджээ. Хоригдлын сахилга бат, нийгэмшүүлэхтэй холбоотой асуудлаар тэд санал солилцож, залуу Антраксын тухай хөөрөлдөв.

Залуу Антраксын дургүй нь хүрч эхэллээ. Түүнийг тэнд байхгүй байгаа мэт өөрийнх нь аав цагдаа нартай дотно харьцаж байгааг харж сууна.

Дей мөрдөгчийн уулзалт тарсан эсэхийг мэдэхээр Секстон явах үед Антраксын аав: “Чи ийм дүр төрхийг үзүүлээд байх шаардлага байхгүй. Залуу минь. Иймэрхүү аашлаад байх юм бол энэ ертөнцөд орох газар олдохгүй шүү. Хариу нь тонн тонн тоосго мэт унаж ирэх болно” гэж хэллээ.

Антракс юу гэж хариулахаа мэдэхгүй байлаа. Түүний ээжийг заналхийлсний дараа яаж тэдэнтэй сайхан харьцах билээ?

Байцаалтын өрөө жижигхэн бөгөөд эд зүйлээр дүүрэн ажээ. Хэвлэмэл цаасан дээр шошго нааж, хаягжуулсан арав гаруй хайрцаг сав харагдана.

Секстон байцаалтаа эхлэв. “Байцаалтын соронзон бичлэгийг 1994 оны 11-р сарын 29-ны өдөр Австралийн Холбооны цагдаагийн газрын төв байранд явуулав” гэж хэлээд байцаалтанд оролцсон хүмүүсийн нэрсийг уншлаа. Дараа хүн бүрийн дуу хоолойг тодруулж, таниулах

зорилгоор өөрсдийгөө танилцуулахыг хүсэв.

“Урьд өмнө тайлбарлаж байсанчлан миний нэрийг мөрдөгч, түрүүч Дей гэдэг. Таныг Telecom 008 гарцаар хувийн автоматчилсан телефон холболтын байгууламжийн салбарыг ашиглан улсын ба олон улсын хэмжээнд үнэгүй дуудлага хийсэн гэмт үйлдэлд буруутгаж байна. Танд тулгаж байгаа гэмт үйлдлийг хүлээн зөвшөөрөх үү?”

“Тиймээ”.

Секстон шаардлагатай, чухал, анхан шатны бүхий л асуултыг тодруулав. Бүх асуултанд хариулах үүрэг хүлээгээгүй гэдгээ Антракс ойлгож байгаа болов уу? Хуульчаа дуудах эрхээр хангагдсан гэдгээ тэр мэдэж байгаа юу? Байцаалтанд зөвхөн өөрийн хүсэлтээр орох ёстойг мэдэж байгаа болов уу? Дуртай цагтаа байцаалтыг орхин гарах эрхтэйгээ мэдэж байгаа юу?

Антракс: “Тиймээ” гэж асуулт болгонд хариулав.

Байцаалтын гол хэсэг утасны тухай ярианд орохоос өмнө Секстон стандарт процессыг дуусгах шаардлагатай байв. Тэр олон хайрцагнуудыг онгичож байгаад, нэгэн гар утас гаргаж ирлээ. Тэр өөрийн гар утас мөн болохыг нотлов.

“008 дугаарууд болон цааш үргэлжлүүлэн хийх дуудлагыг энэ утсаар хийсэн үү?” гэж Сектон асуулаа.

“Тиймээ”.

“Энэ утсанд урьдчилан сануулсан дугаарууд байгаа гэдгийг та зөвшөөрөх үү?”

“Тиймээ”.

“Гар утаснаас тэдгээр дугааруудыг гаргаж авахад төвөгтэй байлаа” хэмээн хэлэх Секстон Антраксийн гар утаснаас хурдан залгах дугаарыг хакердсан өөрийн үйлдлээр бахархах мэт харагдана. “Дугаар 22 миний анхаарлыг ихэд татсан юм. Энэ дуудлага Аароноос ирсэн байна. Урьд мэдүүлж байсанчлан тэр хүн Өмнөд Австралийн Аарон гэдэг хүн мөн үү?”

“Тиймээ. Гэхдээ тэр байнга нүүдэллэж байдаг. Түүнийг хаана байгаа гэдгийг хэлэхэд бэрх.”

Өөр хэдэн дугааруудыг Секстон тодруулж асуусан агаад ихэнх нь Антраксын хариулахаас түдгэлзэж байсан зүйлс байв. Утасны системийг хэрхэн залилдаг талаар тэр олон асуултыг Антраксаас асуулаа. Ялангуяа 008 дугаараар эхэлсэн Австралийн компаниудын хилийн чанад руу хийсэн үнэгүй дуудлагын талаар их асуув.

Антракс хэрхэн ажилладаг талаар тэвчээртэй нь аргагүй тайлбарлах үед Секстон хурдан залгадаг дугааруудын талаар нэмж тодруулна.

“Дугаар 43. Тэр дугаарыг таньж байна уу?”

“Тэр бол Шведийн үдэшлэг шугам”

“78 ба 30 дугааруудын тухай юу хэлэх вэ?”

“Би юу хэлэхээ мэдэхгүй байна. Урт хугацаа өнгөрчээ” гэж Антракс хариулаад ширээний нөгөө өнцөгт байгаа хүмүүсээс үзүүлэх дарамтыг мэдэрч суув. “Тэдгээр дугаар бол манай хотын дугаарууд байхаа. Гэхдээ хэнийх гэдгийг би мэдэхгүй байна. Би байнга үзэг, цаас авч явдаггүй учраас мэдэхгүй байна. Би зүгээр л утас руу дугаарыг оруулдаг.”

Секстон сэтгэл дундуур харагдана. Тэр арай өөр аргаар байцаалтыг үргэлжлүүлэхийг хүсчээ. “Би нилээд төөрөлдсөн бололтой. Чи ямартай ч 008-ыг хүлээн зөвшөөрсөн учир тийм төрлийн гэмт үйлдлийг хийх дээрээ тулбал өөрийн мэдлэг, туршлагаа ашиглаж чадна гэж бодож байна” гэснээ өөрийнхөө биеийг бага зэрэг барив. “Гэмт үйлдэл биш ээ. Чиний ийм төрлийн зүйлд оролцсон байдал... Чи бага зэрэг илүү... Би чамайг худлаа ярьсан гэж бодохгүй л байна. Буруугаар битгий ойлгоорой. Гэхдээ чи ийм зүйлийг маш сайн мэдэж байгаагаа л нуугаад байх шиг байна. Чамайг хир зэрэг ажигласныг ч мэдэхгүй л байх даа”.

Тэд сэтгэл зүйн дайралт хийжээ. Антракс ч түүнийг үмхэж авлаа.

“Намайг ажигласан гэнэ ээ? Тэр чинь зүгээр таамаглал байх. Үнэнээ хэлэхэд би тийм их зүйл мэдэхгүй ээ. Би телефон утасны холболтын байгууламж эсвэл түүнтэй адилхан зүйлийн тухай ярьж чадахгүй. Өнгөрсөн хугацаанд намайг ийм үйлдэл хийж байсан учраас л удирдагч гэсэн өнцгөөс харсан байх. Та нар ч гэсэн намайг тодорхой хэмжээгээр нэр төртэй болсныг мэдэж байгаа бизээ. Тэр цагаас хойш би ийм зүйл хийхээ болихыг шийдсэн юм.”

“Тэр цагаас хойш гэнээ?” гэж Секстон өлгөж асуутал “Үгүй дээ. Өмнө нь гэж хэллээ. Би ийм зүйл дахиж хийхийг хүсээгүй. Энэ бол тэнэг асуудал. Би найз охинтойгоо муудалцсаны дараа л Дахиад энэ рүү татагдсан. Эдгээр үйлдэлтэй би огт холбоогүй гэж хэлэхийг хүсээгүй. Гэхдээ л 008-ыг би зохиогоод хийчихсэн зүйл биш шүү. Бусад хүмүүс тийм дугааруудыг ашиглан скан хийдэг юм. Харин би дуудлага хийсэн, тэнэг гэмээр олон дуудлагыг хийсэн.”

Гэвч Секстон яс зуусан нохой шиг байв.

“Чамайг ингэнэ гэж... Чиний аав чинь энд байгаа учраас л... Би.. Антракс бол домог, тэр скан хийдэг байсан, мөн X.25-ыг ганц мэддэг хүн гэж бичсэн зүйлийг уншсан юм. Tymnet, Unix зэргийг хакердаад.”

Антракс дэгээг үмхсэнгүй. Цагдаа нар байцаалтын ийм тактикийг байнга ашигладаг юм. Хакеруудыг магтаж, өөрийг нь төвийлгэвэл бас үр дүнтэй байж болно. Гэхдээ тэдний үйлдэл хэт ил байв.

“Энэ бол худлаа. Би юу ч мэдэхгүй... Би програм бичиж ч чадахгүй. Би нэг мегабайтын санах ойтой “Amiga” гэдэг компьютертэй. Би компьютерийн талаар ямар ч мэдлэг, боловсрол байхгүй” гэж тэр хариуллаа.

Энэ хэсэг үнэний ортой байв. Бүх зүйлийг өөрөө сурна. Бараг бүгдийг гэж болно. Тэр их сургуульд байхдаа програмчлалын ангид сурсан боловч төгсөж чадаагүй юм. Тэр тусгай судалгаа хийхийн тулд номын сан руу очно. Түүний ангийн ихэнх хүүхдүүд хэдхэн функц

биелүүлэх 200 мөр програмуудыг бичдэг байсан бол тэр 500 мөртэй, олон тусгай функцтэй програм бичнэ. Гэвч тэр тестээр шалгалт өгөөд унажээ. Эмэгтэй багш нь : “Энэ програмд байгаа функцууд миний хичээл дээр заасан зүйл биш байна” гэж хэлсэн гэдэг.

Дараа нь Секстон скан хийх талаар нь асуув. Антракс хир зэрэг их хийдэг байв? Бусад хакеруудад скан хийж олсон дугаараа өгч байсан эсэх? Антракс хариултаас булзсан байдалтай ярьж эхэлсэн учраас мөрдөгчид тэвчээрээ алдаж эхэлжээ.

“Чи скан хийж олсон дугаараа бусад хүмүүст өгч хууль бус үйлдэл хийлгэсэн гэдэгт би итгэж байгаа юм” гэж Секстон өөрийн бодлыг ил дэлгэлээ.

“Телефон утасны лавлахаас өөр зүйл байхгүй ээ. Хүмүүст утасны лавлах байдаг л шүү дээ. Энэ бол зүгээр л жагсаалт. Би ер нь юуг ч эвдээгүй. Би жагсаалтыг л үзсэн юм”.

“Тэдгээр дуут шуудангийн систем бусад хүмүүст харьяалагдах нь илэрхий. Та VMB-г олвол юу хийх байсан бэ?”

“Түүгээр тоглоно. Хэн нэгэнд өгөөд: “Үүнийг үздээ. Маш сонирхолтой” гэж хэлнэ.”

“Үүгээр тогло гэж хэлэнгүүт VMB рүү нэвтэрч орохын тулд кодыг эвдэх үү?”.

“Үгүй ээ. Зүгээр л харна. Би VMB –г эвдэхдээ сайн биш.”

Секстон өөр тактик хэрэглэхийг оролдов. “1-900 дугаарууд юу юм бэ? Бичиг баримтын ард 1-900 дугаар байгааг харсан. Тэднийг юунд зориулсан юм бэ?”

Амархан асуултууд байна. “Америкт минут нь 10 доллар орчим байдаг юм. Тэдэн рүү утасдаж бүх төрлийн мэдээллийг авч болдог. Үдэшлэгийн шугамууд гэх мэт”

“Энэ чинь конференс төрлийн дуудлага уу?”

“Тиймээ”

“Энд бас нэг бичиг баримт байна. AS/AB/S/1 гэж хаягласан. Үүнийг скан гэж ойлгож болох уу? Чи өөрийнхөө гар бичмэлийг таньж байна уу?”

“Тиймээ. Энэ миний гар бичмэл байна. Дахиад хэлэхэд энэ бол ижил төрлийн скан юм. Энэ бол зарим нэг худалдааны дугаарууд руу залгаад тэмдэглэж авсан бичиг.”

“Чи тэгээд нэг зүйл оллоо гэж бодоход түүгээрээ юу хийдэг юм бэ?”

Антракс скан хийдэг бүлэглэлийн толгойлогч гэсэн ойлголт төрүүлэх ямар ч зорилго санаа байгаагүй бөгөөд аливаа нэг бүлгийн гишүүн бус, ганцаар ажилладаг хакер байлаа.

“Би зүгээр л ажигладаг. Жишээлбэл энд 630 гэсэн тоо байна. Хэдэн дугаарууд нэмж залгахад 113 хаа нэгтээ дайверт хийж байна гэж хэлдэг. 115 нь бүтэлгүй боллоо ч гэх юм уу. Би ингээд л орхидог. Дахиад ер нь оролдохгүй шүү.”

“Телефон утасны лавлах ном авангуут л эдгээр бүх мэдээллийг олоод авчихна гэж чи хэлэх гээд байгаа юм уу?”

“Үгүй ээ. Энэ бол телефон утасны ном шиг зүгээр л дугааруудын жагсаалт.”

“1-800 дугаарын хувьд юу хэлмээр байна?”

“Тэр чинь 0014-тэй адилхан.”

“Хэрэв чи 1-800 дугаар руу залгавал хаашаа холбогдох вэ?”

Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ажилтнууд хакеруудтай хийсэн ярилцлагаас ихэнх мэдлэгээ олж авдаг юм уу гэж Антракс боджээ.

“Та 0014 эсвэл 1-800 дугаарын алин руу нь ч хамаагүй залгаж болно. Адилхан гэж ойлгож болно.”

“0014 бол Канад уу?”

“Хаа сайгүй л холбогдоно.”

“Худлаа яриагүй биз? Үгүй байлгүй дээ?”

“Үгүй дээ би сайн мэдэхгүй байна.” (Гэхдээ Антракс яг ингэж бодож байсан юм).

“Тэр бичиг баримтын ард илүү олон төрлийн скан байна лээ...” хэмээн Секстон үргэлжлүүлэв.

“Энэ чинь бүгд ижилхэн шүү дээ. Тэнд байсан зүйлийг л тэмдэглэсэн бичиглэл. Жишээлбэл энэ тохиолдолд 544-р хайрцаг бол энэ эмэгтэйн мэдлийнх...”

“За дахиад асууя, энэ төрлийн мэдээллийг чи олны хүртээл болгодог уу?”

“Үгүй. Ихэнхдээ би өөртөө хадгалж байдаг. Дахиад бараг хардаггүй юм даа. Би ийм зүйл хийхээс уйдсан. Скан хийх нь хууль бус үйлдэлд тооцогдох уу?”

“Би хууль бус гэж хэлээгүй байна. Чи үүнийг үнэхээр санаатай хийж байсан эсэхийг л би тодруулахыг оролдсон. Надад ямар нэг дүгнэлт хийх ерөнхий дүр зураглал хэрэгтэй байна. Одоохондоо бүрэн ойлголттой болох...” Секстон гэнэт чимээгүй болсноо тактикаа шууд өөрчилж зөөлөн харьцах замыг сонгов. “Чамайг одоо ийм юм хийж байгаа гэж би хэлээгүй юм. Урьд бүх зүйл болж өнгөрөх үед чи телефон системд скан хийдэг байсан... за дуут шуудан ч бай... Чамайг 008-ыг олсон гэж би хэлээгүй ээ, гэхдээ “Telecom”-той холбоотой ямар нэг зүйл хийсэн байх. Чи бусад хүмүүст туслаж байсан, бас гардан хийсэн ч байж болно.”

Антракс түүний дайралтыг сөргөж эхлэв. “‘Телесом’-ыг оролдох зорилго агуулах ямар нэгэн учир шалтгаан байгаагүй.”

Секстон довтолгооноо сааруулан: “Магадгүй ... буруу үг сонгоод хэлчих шиг боллоо.”

Тэр дахиад хакердах сэдэв рүү орж эхлэв. Цагдаа нар энэ тухай ярилцана гэж хэлээгүй тул Антраксын уур хүрч эхэлжээ.

Завсарлага авах уу гэж Антраксаас Дей асуулаа.

“Үгүй ээ” гэж тэр хариулаад “Би үүнийг л хурдан дуусгахыг хүсэж байна. Хэрэв та бүхэн дургүйцэхгүй бол. Би худлаа ярихгүй. Би “тайлбар байхгүй” гэж хэлэх гээгүй байна. Надад хэлснээр би бүгдийг хүлээн зөвшөөрөх гэж байна. Энэ бол миний хийхийг хүсэж байгаа зүйл.”

Цагдаа нар хэсэг азнав. Тайлбарын сүүлийн хэсэг тэдэнд таалагдаагүй бололтой. Дей нөхцөл байдлыг лавшруулан тодруулах гэж оролдов.

“Цааш үргэлжлүүлэхийн өмнө танд хэн нэгэн хүний зөвлөсний дагуу бүх үнэнээ ярих сонирхолтой байна уу? Австралийн Холбооны цагдаагийн газрын хэн нэгэн ажилтан үүнийг хэлсэн үү?”

“Тиймээ”

“Хэн” гэж Дей асуултаа маш хурдан тавив.

Антракс тэдний нэрийг санахгүй байлаа. “Манай гэрт ирсэн нэг хүн. Миний бодлоор Андрию хэлсэн шиг санагдана гэж хэлэнгүүтээ улаан үстэй цагдаагийн зүг толгой дохив.”

Цагдаа нар яагаад гэнэт хувираад байдаг юм бол оо? Антракс болон түүний ээжид олон дахин хэлсэн нь нууц биш шүү дээ. Байцаалт өгөхийг зөвшөөрөх нь хамгийн зөв сонголт гээд байсан...

Дей урагш тонгойн Антракс руу ширтэж байснаа: “Таны хэлснийг юу гэж ойлгох вэ?” гэв.

“Хэрэв би үнэнээ хэлэхгүй бол., хэрэв “тайлбар байхгүй” гэвэл, мөн хамтран ажиллахгүй гэвэл асуудал... та намайг...” Антракс зөв үгээ хайн бачимдаж байх зуураа “илүү хүч хэрэглэнэ биз ...” гэж дотроо боджээ.

Цагдаагийн ажилтнууд сандарсан шинжтэй харагдана.

Дей дахин асуув. “Үүний улмаас таньд шударга бус дарамт учирсан гэж хэлэх гээд байна уу?”

“Ямар утгаараа?”. Тэр чин сэтгэлээсээ асуусан юм.

“Та тайлбар хийсэн. Түүнийг бичиж байгаа. Тиймээс би тодруулах шаардлагатай байна. Иймэрхүү наймаалцах саналыг танд аль нэг түвшинд тавьсан гэж та бодож байна уу?”

“Наймаалцах аа?” гэж Антракс бодлоо. “Бидэнтэй ярилц, тэгвэл чамайг шоронд явуулахгүйд анхаарал тавина” гэсэн наймаа шиг зүйл байгаагүй. Эсвэл “Одоо ярь, тэгвэл чамайг

зодохгүй” гэх маягийн зүйл яригдаагүй.

“Үгүй ээ” гэж тэр хариулав.

“Энд ирж үнэнийг хэлэх талаар ямар нэгэн дарамт мэдэрсэн гэж та бодож байна уу?”

Аан тийм маягийн зүйл бол болсоон.

“Тиймээ, намайг дарамталсан” гэж Антракс хэллээ. Хоёр мөрдөгч айсан шинжтэй харагдана. Өрөөнд түүний хэлснийг үл хүлээн зөвшөөрсөн байдал ажиглагдахыг мэдэрсэн Антракс хэсэг азнаснаа “Шууд бусаар” гэж хурдан бөгөөд өршөөнгүй маягаар хэлэв.

Антракс хэсэг хугацаанд аав болон цагдаа нарыг үл тоомсорлосон байдалтай байлаа. Тэр нөхцөл байдлын өөрийн мэдэрснээр тайлбарлахыг хүсчээ.

“Яагаад гэвэл тэд манай гэрт ирснээс хойш, хэрэв би байцаалтанд ирэхгүй бол миний ээжийг яллана гэсэн. Миний ээж өвчтэй хүн учир би тийм байдалд ээжийгээ оруулахыг хүсээгүй.”

Цагдаа нар бие бие рүүгээ харц чулуудсан байдалтай зогсоно. Чичиргээ бараг л өрөөнд байгаа хүн бүрт мэдрэгдэх ажээ. Австралийн Холбооны цагдаагийн газрынхан байцаалтын соронзон бичлэг дээр ийм зүйл бичигдэнэ гэж бодоогүй байх л даа. Гэхдээ түүний ээжийг заналхийлсэн нь үнэн байсан тул бичлэгт оруулах ёстой байв.

Кен Дей: “Тэгэхлээр чи одоо....” хэсэг түгдэрснээ “Чи сайн дураараа энд ирээгүй гэж хэлж байна уу?”

Антракс энэ тухай бодож байлаа. “Сайн дураараа” гэж юуг илэрхийлж байна? Цагдаа нар түүнийг сандалтай нь гавлаагүй. Ярихгүй бол эндээс явуулахгүй гэж хэлээгүй шүү дээ. Түүний толгой руу бороохойгоор цохиогүй. Тэд түүнд сонголт өгсөн. Ярь эсвэл өвчтэй ээжийгээ цагдаа нараар дарамтлуул гэж.. Нэг ч сайхан сонголт биш, шууд л ээжийнхээ төлөө ярь гэсэн тулгалт..

“Би энд сайн дураараа ирсэн” гэж тэр хариулав.

“Чи тэгж хэлээгүй шүү дээ. Чамайг энд ирж асуултанд хариултал дарамталсан гэж чи дөнгөж хэллээ. Тэгэхгүй бол тодорхой эсрэг арга хэмжээ авагдана гэж чи ойлгосноо хэллээ. Тэр чинь чамайг сайн дураараа энд ирснийг үгүйсгэж байна.”

Цөмрөх дөхсөн мөсөн дээр зогсож байгаагаа цагдаа нар ойлгосон бололтой. Өрөөнд таагүй нөхцөл байдал үүсч байгааг Антракс мэдэрч байв. Цагдаа нар уурлах маягтай. Түүний аав нь дурамжхан харагдана.

“Би тэртэй тэргүй ирэх байсан юм” гэж Антракс бараг л уучлал гуйх маягтай хэлэв. Нилээд чанга татсан утсан дээр явах нь зүйтэй гэж тэр боджээ. Тэднийг бүү уурлуул. Эс тэгвээс ээжийг маань яллана. “Нэгжих зөвшөөрлийн бичиг бариад явж байсан хүмүүсээс асууж болно шүү дээ. Би тэдэнд байцаалт өгнө гэж хэлсэн. Ямар ч шалтаг шалтгаан байлаа ч би та нарт үнэнээ хэлэх л байсан.”

“Харин одоо асуудал үүсчихээд байна. Яагаад гэвэл байцаалт эхлэхээс өмнө чамаас сайн дураараа ирсэн үү? гэж асуусан” хэмээн Дей ярив.

“Би тэгсэн. Хэн ч намайг албадаагүй ээ.”

Антракс цухалдаж эхлэв. Өрөө нэг л давчуухан санагдаад байх шиг. Тэр байцаалтыг хурдан дуусгаад тэндээс гарч явахыг хүснэ. Маш их дарамттай газар байна.

“Өнөөдөр энд ярьсан зүйлийг хэн нэгэн хүний дарамтаар хэлсэн үү?” гэж Дей дахин асуув.

“Ямар ч хувь хүн намайг албадаагүй. Үгүй”

“Хувь хүн биш харин ямар нэгэн нөхцөл байдлын улмаас танд дарамт учруулсан уу?”

“Үгүй ээ.” Мэдээж энэ бол нөхцөл байдал. Цагдаа тийм нөхцөл байдал бий болгосон гэж би хэлэхгүй.

Цагдаа нар түүнтэй тоглоом шиг хандаж байна хэмээн Антракс боджээ. Байцаалт тэдний таашаалд нийцэхгүй бол ээжийнх нь араас явах болно гэж цагдаа нар болон Антракс мэдэж байлаа. Ээжийг нь гэрээс нь авч цагдаа нар авч гарч байгаа бодол санаанд нь зурсхийн орж ирэв. Антракс халууцаж, хөлөрч эхэллээ. Тэднийг баярлуулах бүгдийг хийгээд хүн дүүрсэн энэ өрөөнөөс хурдан гарч явах минь...

“Тэгэхлээр цагдаа нар танай гэрт ирэхээс өмнө чиний хийж байсан үйлдэл чинь л чамайг албадсан гэж үзэж болох юм уу?”

“Энэ цагдаа юу яриад байна аа? Миний үйл ажиллагаа албадсан ч гэх шиг.” Антракс будилж эхлэв. Байцаалт хийгдээд бас нилээдгүй хугацаа өнгөрчээ. Цагдаа нар маш бүрхэг асуултаар булж байна. Өрөө ч маш жижигхэн юм.

“Чи хууль зөрчсөн гэдгээ мэдэж байгаа шүү дээ. Тэр чинь л энд ирж, үнэнээ хэлэхэд хүргэж байгаа, албадсан юм биш үү?” гэж асууж байна хэмээн Дей тулгана.

Тиймээ, хүссэнээр чинь л больёо. “Ок. Тэр бол шударга төсөө...” гэж Антракс хариулж эхлэнгүүт Дей түүний үгийг тасалж: “Австралийн Холбооны цагдаагийн газрын гишүүн таныг хууль бусаар, шударга бусаар албадан энд ирүүлсэн эсэхийг тодруулж мэдэхийг хүсээд байгаа юм. Тэгсэн үү?”

Шударга бус, хууль бус гэдгээ тайлбарлаач. Түүний эхийг яллаж магадгүй гэсэн цагдаа нар лав шударга бус гэж Антракс бодлоо. Харин тэд яг хуулийн дагуу тэгж болно гэж ээжид хэлсэн. Антракс бүр бодолдоо эргэж гүйцэв. Түүний толгойд олон янзын бодол эргэлдэнэ.

“Үгүй дээ. Энэ бол асуудлын гол нь биш.. намайг уучилна уу.” Даруухан бай. Өрөөнөөс хурдхан гар.

“Зүгээр, зүгээр Чи итгэж байгаа зүйлээ л хэл. Тэр бол бидний асуудал биш. Би зүгээр л тодруулах гээд байна. Бусад хүмүүс энэхүү соронзон бичлэгийг сонсож, дүгнэлт гаргаж, үзэл

бодлыг чинь судалж магадгүй. Би ямар ч тохиолдолд асуудлыг тодорхой болгох ёстой. Чи үүнийг ойлгож байгаа биз дээ?”

“Тиймээ, би ойлгож байна” гэж Дейгийн ярьсанд анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байгаа Антракс хэлэв. Тэр маш их туйлдаж, байцаалтыг хурдан дуусгахыг хүсэх болжээ.

Цагдаа нар цааш үргэлжлүүлэн, өөр сэдэвт оров. Түүнд улам хэцүү мэдрэмж төрүүлж эхэллээ. Дей асуух сонирхол байхгүй гэж амласан хэсэг рүү орж, Антраксын хакердах үйлдлүүдийн талаар асуужээ. Тэрээр хакердах тухай бус саяхны фреактинг хийсэн ажиллагааны тухай ярихаа зөвшөөрсөн аж. Үнэндээ бол түүний байцаалтын хүрээнд энэ талаар асулт байх ёсгүй гэж олон давтан хэлж байлаа.

Дей эелдгээр тайвшруулж байснаа дахин довтолно. “За за би чамд бас өөр нэгэн гэм бурууг тохож болох юм. Чи Австрали болон АНУ-ын компьютерийн системд хууль бусаар нэвтэрсэн. АНУ-д чи армийн компьютерийн системийг санаатайгаар онилсон. Тэр гэм бурууг тохож байгаа явдал болохыг чи мэдэж байна уу?”

“Би тэрнийг ойлгосон. Би энэ талаар ярихыг хүсэхгүй байна. Үгүй ээ эрхмээ, яасан ч ярихгүй.”

Дей дахин өөр тактик ашиглав. “Би чамайг Мендакс гэдэг хүнтэй хамтран ажиллаж байсанд чинь буруутгах болно.”

Энэ Дей гэдэг нөхөр юу яриад байгаа юм болоо? Антракс Мендаксийн тухай сонссон, гэхдээ тэд хэзээ ч хамтран ажиллаж байгаагүй шүү дээ. Цагдаа нарт нилээд сайн мэдээлэгч байгаа юм байна гэж тэр боджээ.

“Үгүй ээ тэр худлаа. Би тийм нэртэй нэг ч хүн мэдэхгүй.” Туйлын үнэн биш, гэхдээ хангалттай үнэн шүү.

“За тэгэхлээр бүх хакердах ажиллагааг намайг хийсэн гэж тэр хэлэх аваас худлаа ярьж байгаа нь тодорхой болно. Тэгэхгүй гэж үү?”

Гайхамшигтай. Зарим хакерууд Антракстай хамтран ажиллаж байсан тухай цагдаа нарт худлаа ярьж болно. Гэтэл Антракс хэзээ ч багаар ажиллаж байгаагүй юм. Түүнд няцаах хангалттай үндэслэл байна. Төсөөлөлдөө умбасан хэн нэгэн хакер түүнд хэрэггүй.

“Ер нь бол хэн ч хамтарсан гэж хэлж болно. Хэрэв хэн нэгэн өөр хүний нэрээр хэлсэн ч гэсэн тийм нэртэй хэнийг ч мэдэхгүй. Мендакс гэнэ үү?”

Үнэндээ бол Мендакс хэзээ ч Антраксийг ямар нэгэн үйлдэлд хутгаж байгаагүй юм. Энэ бол зөвхөн цагдаа нарын ашиглаж байсан байцаалтын тактик байлаа.

“Цэргийн компьютерийн болон бусад систем рүү хакердсан гэдэгт чи тайлбар өгөхийг хүсэхгүй байгаа юм уу?” Дей няцаашгүй зүтгэж байна гэж түүний өмнөөс Антракс хэлэхийг хүсэж байв.

“Үгүй ээ. Би ямар ч тайлбар хийхийг хүсэхгүй. Энэ сэдэвтэй холбоотой ямар ч зүйлд хариулт хэлж болохгүй гэсэн зөвөлгөөг надад өгсөн.”

“За за, ямар нэгэн компьютерийн систем рүү хууль бусаар нэвтэрсэн үү гэсэн асуултанд хариулах хүн үү үгүй юу?”

“Надад өгсөн хуулийн зөвөлгөөний дагуу би “үгүй” гэсэн сонголтыг хийж байна”.

Дей уруулаа хазлана. “Ойлголоо, хэрэв чи хариулахыг хүсэхгүй байгаа бол бид чамайг албадахгүй. Гэхдээ таны энэ үйлдлийн тухай бид мэдэгдэх болно. Тэр цагт та асуултанд хариулахаар дуудагдаж байгаа гэсэн зар хүлээн авна. Эсвэл тэдгээр тулгаж байгаа гэм буруугийн төлөө ял авна. Бидэн дээр эргэж ирэх нь таны хийх ганц сонголт байх болов уу.”

“Ёох”. Антракс гүнзгий амьсгал авлаа. Зарлан дуудах өгснөөр цагдаа нар намайг яриулж чадна гэж үү? Тэд тоглолтынхоо дүрмийг өөрчилж байна. Антраксын хөлийн дор байгаа хивсийг гуд татаад авчих шиг түүнд санагдав. Түүнд толгойгоо сэргээх хэдэн минут хэрэгтэй боллоо.

“Надад бодох хугацаа өгөөд дараа нь хэлэлцэх бололцоо байгаа юу?” гэж Антракс асуув.

“Тиймээ. Чи завсарлага авахыг хүсэж байна уу? Бид өрөөнөөс гарч болно, эсвэл чамд өөр өрөө олж өгч болно. Би ч үүнийг зөв санаа гэж бодож байна шүү. Та хоёрыг өөр өрөөнд оруулж, хоорондоо ярилцахад арван минут хангалттай гэж би бодож байна. Тэнд ямар нэгэн дарамт байхгүй.”

Дей, Секстон хоёр байцаалтаа зогсоож, эцэг хүү хоёрыг өөр өрөөнд оруулав. Тэд өрөөнд оронгуут Антракс аавынхаа зөвөлгөөг хүслээ. Түүний аав нь үнэхээр өөр хүн байсан тул Антракс руу хэт их довтолсон шинжтэй харагдана. Битгий нуугаад бай. Бүх зүйлээ ярих хэрэгтэй. Чамайг ийм тэнэг гэж бодсонгүй. Чи цагдааг хуурна гэж байхгүй. Тэд мэдэж байгаа. Оройтоогүй дээрээ бүх үнэнээ хэл. Арван минутын турш үгээр бөмбөгдүүлсний эцэст байцаалтаас гарч ирснээсээ илүү хүнд нөхцөлдорсон санагдав.

Байцаах өрөөнд буцаж ирсний дараа Антраксийн аав нь: “Тэр бүх үнэнээ ярихаар шийдсэн” гэж хэлжээ.

Үнэндээ бол аав нь түүний өмнөөс худлаа хэлсэн юм. Антракст тийм бодол огт төрөөгүй билээ. Түүний аав амаа ангайх болгонд гэнэтийн-хогийн гэмээр бэлэг унгах мэт түүнд санагдана. Кен Дей, Андрию Секстон хоёр нэгжлэгийн үед хурааж авсан Антраксийн гар бичмэл, телефон утас чагнасан бичлэг зэрэг олон бичиг баримтыг үзүүлж Антраксийг хэцүү байдалд оруулна. Яг тэр үед Дей түүний гараар бичсэн “KDAY” гэсэн бичгийг үзүүлэв. Тэр Антракс руу харна.

“Энэ юу вэ? миний нэр үү?”

Антракс гэнэт инээмсэглэв. Энэ бол баяр баясгалантай байх ямар нэгэн зүйлийг түүнд санагдуулжээ. Австралийн Холбооны цагдаагийн газрын Компьютерийн гэмт хэрэгтэй

тэмцэх хэлтсийн дарга түүний өмнөөс харж суугаад, ямар нэгэн том хэрэг илрүүлсэн гэдэгтээ итгэлтэй байх ажээ. Түүний нэр нартай өдөр мэт тод харагдахажээ. Дей ямар нэгэн сайхан зүйл хэлэхийг хүлээх мэт сууна.

“Хэрэв та наадах руу залгавал радио станц болохыг олж мэдэх болно. Америкийн радио станц” гэж Антракс хэлэв. Тэрхүү цаасны өөдөс дээр захиалга өгөхөөр сонгосон Америкийн хувцасны дэлгүүрийн нэрс, түүнчлэн АНУ-д байрлалтай радио станц байв.

“За за” гэж түргэн дүгнэлт хийсэндээ бантсан Дей инээж “Миний нэрээр нэрлэсэн радио станц байдаг юм байна” гэв.

Яагаад директоригийн паатууд, кодууд, алдаа илгээсэн мессэжийг бичиж авдаг байсныг Дей Антраксаас асуув.

“Зүгээр л тэмдэглэж авахад хэрэгтэй юм болов уу гэж бодоод. Анх удаа энэ “dial up” –ийг авсны дараа дээрх бүгдийг бичиж авсан гэж бодож байна. Би ер нь эргэн тойронд байгаа зүйлийг тэмдэглэж авдаг л даа.”

“Тэдгээр компьютерийн сүлжээгээр нэвтэрч байхдаа ямар санаа зорилготой байсан юм бэ?”

“Тухайн үед орж үзэхийг л хүссэн, сонирхолдоо хөтлөгдсөн.”

“Тэгэхлээр сонирхлыг татсан байж-“энэ зөвхөн сонирхолтой” байв уу эсвэл нэвтэрч үзэхийг хүссэн юм уу?”

“Тухайн үед би юу бодож байснаа хэлж чадна. Би анхныхаа системд оронгуутаа удалгүй дараагийнх, тэрний дараагийнх гээд... л Та энэ талаар маш их сонссон байх л даа. Ярьсан зүйлээ гүйцээх зөв үг сонгож хэлэхэд Антракст хэцүү байлаа.”

“Идэхийг хориглосон жимсийг амсангуут гэдэгтэй адилхан уу?”

“Яг тийм, зөв харьцуулалт байна.”

Дей Антраксийн хакердах ажиллагааны асуулт гаргаж тавьсаар байв. Тэр хакерыг хүлээн зөвшөөрөхөд хүргэх байдалд оруулсаар. Антракс цагдаагийн ажилтан урд өмнө авч байгаагүй их мэдээллийг Дейд өгсөн боловч түүний хүссэн бүгдийг яриагүй бизээ.

Гэхдээ түүний ярьсан бүхэн Антраксийн ээжийг цагдаа нараас холдуулахад хангалттай байлаа. Одоо түүнийг буруутгахад хангалттай их зүйлийг цагдаа нар мэднэ.

1995 оны 8-р сарын 28-ны өдөр шүүх дээр ирэх хүртлээ Антракс түүнд тулгаж байгаа ялын хамгийн сүүлийн жагсаалтыг огт хараагүй байжээ. Түүнийг хэргийг шийдвэрлэх ажиллагаа зохион байгуулалт муутай байсан юм. Түүний хуулийн туслалцаа үзүүлэх комиссоос өгсөн хуульч нь компьютерийн тухай ямар ч мэдлэггүй, компьютерийн гэмт хэрэг гэж юу болохыг л мэдэх хүн байв. Антракс өөрийн хэргийг хурдан шийдүүлэх хүсэл сонирхолтой учраас хуульч нь шүүх хурлыг хойшлуулах санал тавихад татгалзжээ. Антракс бүх гэм буруугаа хүлээж, сайн шүүгч таарах эсэхэд л найдахаас өөр аргагүй болсон юм.

Прокуророос бэлдэж өгдөг товч танилцуулгыг Антракс үзэхэд цагдаагийн авсан байцаалтыг маш сайн найруулж янзалсан байх бөгөөд дүгнэлт гэж хаягласан байлаа. Мэдээж тэрхүү байцаалтанд ярьсан зүйлээр бол ямар ч чухал дүгнэлтийг ярилцаагүй юм. Антраксыг байцаалтанд ирэхгүй бол ээжийг нь гэм буруутан болгоно хэмээн заналхийлсэн тухай хэсгийг прокурор болон цагдаа нарын аль нь ч тоолгүй хассан байв.

Антракс хэргийг сайн бодож цэгнэжээ. Түүний хэрэгт холбоотой болгон товч дүгнэлтээр дарагдах гэж үү? Дүгнэлтэнд дурьдаагүй үлдсэн бүхэн маш чухал ач холбогдолтой санагдана. Бичиг баримтанд огт дурсаагүй үлдсэн зүйл ч бас байна. Магадгүй шүүгч нар үүнийг мэдвэл тийм ч баяртай байхгүй л болов уу. Мэдээж цагдаа нар түүний ээжтэй хэрхэн харьцаж байсан талаар ямар нэг хариуцлага хүлээхийг хүсэхгүй байх.

Товч дүгнэлтийн бусад хэсэг ч тийм аятай байсангүй. Бичиг баримтанд дурьдсанаар Антраксын талаар нэг өрөөнд хамт амьдарч байсан оюутан хэргийн жинхэнэ гэрч болж мэдүүлэг өгсөн ажээ. “Антракс NASA-ын компьютер руу нэвтэрч хөлөг онгоцнуудын уртраг, өргөргийг харуулсан мэдээллийг үзэж байсан” гэж тэр мэдүүлжээ.

Сансрын хөлөг онгоцнуудад уртраг, өргөрөг гэж байх болов уу? Антракс мэдэхгүй байлаа. Тэгээд ч нэг өрөөний найзын хажууд NASA-ын компьютер рүү хэзээ ч нууцаар нэвтэрч байгаагүй юм. Энэ бол хуурмаг зүйл. Мань залуу худлаа ярьсан. Сайн хуульч тавхан минут л суугаад худал хуурмаг зүйл олныг илрүүлэх байлаа. Түүний өмгөөлөгчийн бичиг баримтаа хурдан эргүүлэх байдал, шүүх хурлын танхим дахь бужигнаан, гэр бүл зэрэг олон талаас түүнд дарамт ирж байсан тул ял оноож, шийтгэхдээ болхи хандах байх гэж Антраксын зөн совин хэлж байв.

Антракс өрөөг тойруулан харлаа. Сонирхогчдын вандан сандал дээр суугаа түүний аав дээр нүд нь тогтов. Шүүгч хэргийг хэлэлцэх үед нотлох баримтыг баталгаажуулахаар түүний аавыг хүрэлцэн ирэхийг хуульч хүсчээ. Шүүх хурал дээр гэр бүлийн гишүүд байх нь зүйтэй гэж тэр үзэв. Антракс түүний гаргасан саналыг халуун дотно хүлээж авсангүй. Шүүх хурлын процесс хэрхэн явагддагийг мэдэхгүй тул тэр хуульчийн зөвөлгөөг дагахаас өөр арга байсангүй.

Антраксийн ээж гэртээ үлдэж, мэдээ хүлээнэ. Тэр шөнийн ээлжинд ажилласан тул одоо унтаж байгаа биз хэмээн Антракс боджээ. Шүүх хуралд оролцож болохгүй шалтгаан түүнд байсан юм. Магадгүй Антракс ээжийнх нь сэтгэл хөөрөл шүүх хурлын үед эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөхөөс эмээсэн байж болно. Гэхдээ шалтгаан ямар ч байлаа гэсэн ээж нь бүтэн өдөр унтаагүй билээ. Тэр гэр орноо цэвэрлэж, аяга тавгаа угаан, өөрийгөө аль болох завгүй байлгаж байв.

Антраксын царайлаг Турк гаралтай найз охин нь шүүх хурал дээр иржээ. Тэр хэзээ ч хакер, түүний ажиллагаатай нь холбоотой байгаагүй юм. Түүний ард сургуулийн хэсэг хүүхдүүд, голцуу охидууд шивнэлдэж байв.

Прокуророос өгсөн дөрвөн хуудас дүгнэлтийг Антракс уншжээ. Түүнийг сүүлчийн хуудсанд хүрэх үед тэр ухаан алдах шахав. Хамгийн сүүлийн хэсэгт:

“31,. Ял s85ZF (a)—12 сар, 6000 доллар эсвэл хоёуланг онооно.

S76 E (a)--2 жил, 12000 доллар эсвэл хоёуланг онооно” гэжээ.

Сүүлчийн хэсгийг юу гэж ойлгох вэ хэмээн Антракс хуульчаас асуув. Шорон явж магадгүй гэхдээ нэг хоёр жилийн дараа гарчихна гэдэг муу сонсогдохгүй гэж хуульч нь хэлжээ.

Хүн хүчиндсэн хүн хүртэл үүнээс бага ялтай салдаг шүү дээ. Прокурорууд түүнийг шоронд оруулахыг хүсэж байгаад Антракс итгэж чадахгүй байлаа. Тэр цагдаа нартай хамтарч ажилласан, хүн зовоосон байцаалт өгсний дараа ингэж болно гэж үү. Тэр урьд өмнө шийтгэл хүлээж байгаагүй. Гэвч галт тэрэг нэгэнтээ хөдөлжээ. Шүүгч хурал нээснийг мэдэгдэв.

Одоо ухрах боломжгүйг ойлгосон Антракс 21 үйлдэлд гэм буруутайгаа хүлээжээ. Түүний хорин үйлдэл нь хууран мэхлэх, нэг үйлдэл нь хууль бусаар мэдээлэл оруулахтай холбоотой байв.

Түүний өмгөөлөгч хүүг урт хугацааны ял авахад хүргэжээ. Тэр аавыг нь шүүх хурлын тавцан дээр гарч ирэхийг урив. Аав нь сайн гэхээсээ саар зүйлийг хийсэн байж магадгүй. Түүний хүүг дахин гэмт хэрэг үйлдэх болов уу гэж асуухад аав нь “Би мэдэхгүй” гэж хариулжээ.

Антракс маш их уурлажээ. Цаашлаад тэр биеэ барьж чадахгүйгээ мэдэрч байсан аж. Шүүх хурал болохоос хоёр хоногийн өмнө аав нь Австралиас гарч явахаар төлөвлөж байсныг Антракс олж мэдсэн байна. Шүүх хурал болсны дараа хилийн чанад явна гэж аав нь эхнэртээ хэлж байжээ. Азаар ээж нь түүнийг нууцаар эрт гарч явахыг мэдсэн агаад хүүгийнх нь шүүх хурал доромжлол болно гэж тэр үзсэн байх. Антраксын ээж түүнийг гадагш явахаа хойшлуулахыг шаардсаны хүчинд дуртай дургүй зөвшөөрсөн нь энэ ажээ.

Антракс болон түүний хуульчаас аав нь нилээд зайтай суужээ. Өмгөөлөгч: “Энэ залуу маш олон янзын газраар зорчиж үзсэн. NASA, цэргийн сайтууд, мөн түүний байсан газрыг та итгэх ч үгүй байх” гэхэд нь шүүгч: “Түүний хаана байсныг би мэдэхийг хүснэ гэж бодохгүй байна” гэж дооглонгуй хэлэв.

Энэ тактик бол Антраксын гаргасан санаа байлаа. Тэр маш нууц олон системд орж үзсэн бөгөөд ямар ч хорлон сүйтгэх ажиллагаа хийж байгаагүй болохоо харуулахыг хүсчээ. Түүний гаргасан санаа үр дүнгээ өгч, шүүгч залуу хакерыг шоронд илгээх шаардлага байхгүйн зарлав.

Прокурорууд үүнд сэтгэл дундуур хандаж, 1500 цагийн албадан хөдөлмөр хийлгэх санал гаргаж байлаа. Антракс бие барьж ядна. Ёстой утгагүй асуудал. Бараг 9 сарын хугацаа болно шүү дээ. Байшин будаж, жорлон цэвэрлэнэ. Их сургуулиа мартаж хэрэгтэй болно. Шоронгоос дутуугүй шийтгэл болох байх.

Антраксийн хуульч гаргасан саналыг эсэргүүцэж: “Эрхэм шүүгчээ. Энэ торгууль бол кибер орчноос хэтэрсэн шийтгэл байна шүү дээ” гэв. Антракс ач холбогдолгүйгээр хүнийг өдсөн үг байна хэмээн айсан боловч өмгөөлөгч өөртөө итгэлтэй маадгар харагдана.

Шүүгч прокурорын гаргасан саналыг татгалзав. Антраксын найз охин шүүгчийн шударга, сайхан сэтгэлтэйг магтан бодож байтал: “Гэхдээ бид Антракст буруу үйлдлийг нь ойлгуулах ёстой. Хуулийн өмнө хакердах үйлдэл бол буруу гэсэн ойлголтыг олон нийт, сургуулийн

хүүхэд бүрт хүргэх шаардлагатай” гэж шүүгч хэлэв. Шүүгч түүний ялыг сонголоо. Түүнд хоёр зуун цаг албадан хөдөлмөр эрхлэх, 6116,90 долларыг “Telesom” ба Канад дахь “Teleglobe” компаниудад нөхөн төлөх ял оноожээ. Шоронд ороогүй ч ийм их хэмжээний мөнгө бол оюутан хүний хувьд санаанд оромгүй тоо байлаа. Хохирлыг нөхөн төлөхөд нэг жилийн хугацаа байна. Гэхдээ л тэр эрх чөлөөтэй үлдэж чаджээ.

“Төгсгөлийн үг”

Компьютерийн нууц ертөнцийн тухай мэдэхийг хүссэн, түүнтэй холбоотой хүмүүсийн томоохон цугларалт жилд нэг удаа болдог гэж би сонссон учраас оролцохыг хүслээ.

Техас мужийн Аустин хотын “ХоХоКон” бол миний хэзээ ч оролцож байгаагүй хачирхалтай хурал гэдэгт би эргэлзэхгүй. 1995 оны шинэ жил дөхөж байх үеийн долоо хоногийн Бямба, Ням гарагт Ramada Inn South зочид буудал хакерууд, фреакерууд, хакер байсан хүмүүс, компьютер сонирхогчид, сэтгүүлчид, компьютерийн компаний ажилтнууд, Америкийн хууль хамгаалах байгууллагын мөрдөгчдийн хөл дарагджээ. Зарим хүмүүс нь Герман, Канадаас ч ирсэн харагдана.

Хакер, фреакерууд 4-6 цаг л өрөөндөө унтсан байх. Өрөөндөө орсныг унтсан гэж үзвэл шүү дээ. Мөрдөгчид өрөөндөө хоёр цаг л унтсан байх. Би буруу ажигласан байж болох, магадгүй тэд мөрдөгчид биш. Гэхдээ тэд хамаагүй цэвэрхэн хувцасласан, бусдаас илт содон харагдаж байв. ХоХоКон дээр хэн ч индүүдсэн подволка өмсдөггүй юм.

Би хурлын гол танхимыг өнгөрч, 518 дахь өрөө буюу компьютерийн өрөө рүү оров. Би компьютерийн тоног төхөөрөмж байрлуулахаар булан руу шахсан зочид буудын хоёр орон дээр суугаад ажиглаж байлаа. Хурал зохион байгуулагчид бараг дэлгүүр нээчихмээр их тоног төхөөрөмж өрөөнд оруулж, интернеттэй холбожээ. Тэр өрөө гурван өдрийн турш хүнээр дүүрэн байв. Хорь орчим ба хориос доош насны залуучууд гар утсаар тоглож, зургаа долоон компьютер дээр ажиллаж сууна. Кока коланы хоосон лааз, чипсны уут, пиццаны хайрцаг өрөөнд дүүрэн. Хүмүүс компьютер рүү хамаг анхаарлаа чиглүүлж байгааг эс тооцвол томоохон коллежийн дотуур байр шиг санагдана.

Тэд бол хуралд оролцож байгаа цор ганц сонирхол татсан хүмүүс биш билээ. Би Аустин хотын сэхээтний давхаргынх гэмээр хөгшин нэгэн бүлэгтэй уулзлаа. Хөгшин гэдэг нь 26-аас дээш насны хүнийг хэлж байгаа юм. Тэд ирээдүйн дижитал дэлхий, энкрипт, нууцлал зэрэг залуу хакерын бүлгийн сонирхдог бүх асуудалд сонирхолтой байв. Мэдээж тэд бүгд техникийн мэргэжил, боловсролтой.

Доуг Барнес, Жереми Портер, Жим Маккой зэрэг хөх жинстэй сэтгэн бодогчдийн бүлэг их сургуулийн гэмээр хэв маягтай кафенд энчиладас ба маргарита зэрэг хоол идэнгээ уулзах дуртай. Тэд байнгын гурав эсвэл дөрвөн төсөл дээр өөрсдийгөө завгүй байлгана. Намайг тэдэнтэй уулзах үед дижитал мөнгө нь сарын онцлох зүйлээр тодорсон байсан цаг. Тэд бол бүтээлч санааг дэмжиж, өргөн тархсан дижитал мөнгийг бодит ажил хэрэг болгох хүмүүс билээ. 518 тоот өрөөнд байгаа хэдэн залуу хүн үүнтэй ижил замыг дагах бол гэдэгт би гайхах болсон. Тэгээд би өөрөөсөө: “Тэдгээр хүмүүс Австралид хаана байна вэ?” гэж асуулаа.

Бусдын нүдэнд ажиглагдахгүй эсвэл оршин байхгүй мэт санагдана. Харин компьютерийн нууц ертөнцөд бол байгаа биз. Галзуурал, бүтээлч амьдрал, донтолт, мөргөлдөөн, тэмцэл үргэлжлэх хэдхэн газар Австралид байдаг. Түүний нэг нь компьютерийн далд ертөнцийнх мэт санагдана. Гурван тив дээр хийсэн шүүх хурлын ажиллагаа, баривчилгаа, нэгжлэгийн дараа энэ номонд дурьдсан хакеруудад юу тохиолдсон бол?

Тэдний ихэнх нь бүтээлч, сонирхолтой зүйлсийг хийхээр сэтгэл шулуудсан юм. Энэ бүтээлд ярилцлага өгсөн хүмүүс сайныг бодож хакердах хүслээ орхисон гэхэд болно. Хакердсаны улмаас үзэж туулсан амьдралын дараа үргэлжлүүлэн хакердана гэвэл гайхалтай хэрэг болно.

Гэвч тэдний ихэнх нь хакердаж байсандаа харамсаж байгаагүй юм. Зарим нь мэдээж хүмүүсийг сэтгэл санаагаар унагаж байсан учраас уучлал эрсэн билээ. Бусдын системийг хакердсанаар системийн админуудад сэтгэл зүйн дарамт, уйтгар гуниг учруулж явснаа хэзээ ч сайнаар ярихгүй. Гэхдээ ихэнх нь хакердах ажиллагааг буруу зүйл гэж үзэхгүй, магадгүй цөөн хэд нь зөвхөн нэвтрээд харах гэсэн өнцгөөс хандаж байсантай холбоотой биз. Прокурорын хуульч Жеофф Четтлийн хэлснээр хор хөнөөл учруулаагүй хакердах ажиллагааг гэмт хэрэг гэж үзэх ч бас буруу биш юм.

Ерөнхийдөө тэдэнд оноосон шийтгэл уг сэдвийн талаарх үзэл бодлыг нь батжуулж өгсөн гэлтэй. Ихэнх тохиолдолд эрх баригчид тэднийг бусдад үзүүлэх жишээ болгохыг хичээсэн гэдгийг хакерууд мэдэж байсан. Өөрөөр хэлбэл илэрч баригдаагүй хакер ертөнцийн бусад гишүүдэд хандсан шинжтэй байлаа. Гэхдээ тэд зорилгодоо хүрч чадсан гэж хэлэхэд хэцүү юм. Компьютерийн далд ертөнцийн гишүүдийн хувьд тэдгээр баригдсан хакерууд бол баатрууд билээ.

Пар

Би Партай Аризоны Таксонд уулзсан юм. Тэр эцэг эхийн хамт амьдардаг Мид Вестерны цас бүрхсэн, жижигхэн хотоос ирсэн байв. Пар ажил хайсан хэдий ч түүндолдохгүй байжээ. Таксоны замаар хурдалж яваад Сонораны цөлийн шүүслэг какти ургамал дээр туссан өвлийн нарны туяа туссан үзэсгэлэнт байгалийг харахаар бимашинаа зогсоолоо. Урьд талын зорчигчийн суудал дээр суусан Пар: “Би замын эсрэг талаар машинтай явах ямар байдаг бол гэж байнга боддог” гэж тайвнаар хэлэв.

Би замын баруун тийш эргэж хурдлав.

Пар маш их баярласан харагдана. Тэр гараа дэлгэн амьдралын өгөх юм бүрийг хаман авах шиг явж байлаа. Тэр дахиад л амьдралын зам дээр гарчээ.

Тэр баруун эрэг рүү хэсэг хугацаанд буцаж очоод мөн л тогтвортой ажил олж чадаагүй юм. Түүнийг мэдээлэл компьютерт оруулдаг түр зуурын ажилд авсан гэдэг. Пар дөрвөн жилийн турш “Оргодлуудад зориулсан теле харилцаа холбооны курсийг амжилттай дүүргэсэн гэдгээ хаана ч тайлбарлаж чадахгүй байв. АНУ-ын Нууц Албаны зохион байгуулсан сургалт болж таарна.” Орон нутгийн коллежийн компьютерийн лабораторид оюутнуудад туслаж, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг тасалчихгүй байлгах ажил зүгээр гэж тэр бодож байв. Мэргэжлийн ямар нэгэн үнэмлэх байхгүй түүнд ийм ажил олоход хэцүү байлаа.

Тэр оргодлын амьдралаас ангижирсан ч гэсэн энгийн амьдралаа олигтой төвхнүүлж чадаагүй юм. Ээжтэйгээ хааяа нэг утсаар ярих хэдий ч сэтгэл санаагаа хуваалцаад байх шаардлага бараг үгүй болжээ. Оргодлын амьдралыг давж гарахыг оролдсон урт хугацаанд тогтсон амьдралын хэв маяг нь компьютерийн гэмт хэргийн ялаас мулттрахаас хамаагүй хэцүү байв. Түүний сэтгэцийн эмгэг байдал хааяа сэдэрнэ. Яг л далайн давалгаа орж ирж байгаа мэт.

АНУ-д эрүүл мэндийн даатгал байхгүй, ажилгүй залууд нийгмийн дэмжлэгийн олон үйлчилгээ байхгүй бололтой.

Прайм Саспект

Тэр хийсэн сонголтондоо хэзээ ч харамсаж байгаагүй юм. Мендакс болон Прайм Саспект хоёр амьдралын эсрэг чиглэлд явж байгаа мэт түүнд санагдана. Найз нөхөрлөл хэзээ ч өндөрлөж болох учраас Мендаксийн төлөө шоронд явахыг тэр хүсээгүй юм. Прайм Саспект компьютерийн програмчлалын TAFE курсыг төгсөж, цэцэглэн хөгжиж байгаа интернетийн салбарт ажилд оржээ. Тэр ажилдаа дуртай. Түүнийг хакердах гэмт хэрэгт буруутгагдсаныг мэдэх ажил олгогч нь саяхан цалинг нь нэмсэн сурагтай байсан. 1994 оны дундуур мансууруулах бодис хэрэглэх зуршлаа хаяжээ. 1995 онд зарим нөхдийн хамт байр хөлслөн амьдрах болсон ч 1996 оны 8-р сар гэхэд Прайм Саспект тамхинаас гарав.

Хакердаж цагаа үрэхгүй болсноос хойш түүний амьдралд хийх зүйл их гарч ирсэн юм. Тэр скай дайвингаар хичээллэж эхлэв. Ганц удаагийн үсрэлт түүнд хэдэн өдрийн заримдаа долоо хоногийн сайхан мэдрэмжийг хангалттай өгдөг байна. Түүний сонирхлыг охидууд татаж, таарсан хүнээ олвол гэрлэх тухай ч бодох болов.

Саяхнаас Прайм Саспект гардан тулааны урлагаар хичээллэж, долоо хоногт дөрвөн өдрийн сургалтанд хамрагдахыг эрмэлзсэн юм. Тэрээр гардан тулааны урлагийн сэтгэл зүйн болон философийн талд илүү татагдах болсноос гадна өглөө бүрийн 5 цагт босож гүйх эсвэл бясалгах болсон ажээ.

Мендакс

1992 онд Мендакс, Тракс хоёр Италийн үл хөдлөх хөрөнгийн наймаачинтай нэг баг болон Ла Тробе Их сургуулийн толгой компьютерийг худалдан авч, (тэд хакердаж байсан компьютерээ авсан нь инээдтэй байлаа) компьютерийн аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг компанийг байгуулжээ. Гол баатрууд дараах үйлдэл хийснээр хөрөнгө оруулагч зайгаа авч, компаний үйл ажиллагаа зогссон байна.

1993 онд Викторианы захирагч Жефф Кеннетт ба олон нийтийн хооронд үл ойлголцол бий болсны дараа Мендакс өөр хоёр нөхөртэй нийлж, Викторианы засгийн газарт нүүрлэсэн авлигатай тэмцэх, хариуцлагыг дээшлүүлэхийн төлөө иргэний эрхийн хөдөлгөөн байгуулжээ. Тэмцлийн ажилд туслалцаа болох үүднээс Мендакс бичиг баримт олох суваг болон хувирч, 1993-1994 оны хоорондох орон нутгийн захиргааны эсрэг шүүхийн олон маргаанд холбогдсон гэдэг. Эцэст нь асуудлыг хянаж байгаа улсын парламентын комисст камераар авсан нотлох баримтуудыг өгч, 40 гаруй гэрчийг олны өмнө гарах нөхцлийг бүрдүүлэхэд түүний хөдөлгөөн дэмжлэг үзүүлсэн байна.

Мендакс өөрийн компьютерийн ур чадвар, сайн дурын үйлсээ төрийн бус олон байгууллагын төлөө зориулсан юм. Ашгийн төлөө бус байгууллагын ач холбогдлыг тэр өндрөөр үнэлдэг бөгөөд олон нийтийн олон төсөл дээр ажиллаж чөлөөт цагаа өнгөрөөдөг идэвхтэн байлаа. Тэр Хууль хамгаалах байгууллагын ажилтнуудад мэдээлэл, туслалцаа үзүүлдэг байсан боловч хакеруудын эсрэг ажиллаж байгаагүй ажээ. “Би ёс зүйн талаас үүнийг зөвтгөж чадахгүй.

Гэхдээ бусад хүмүүсийн хувьд, хүүхэд эсвэл эдийн засгийн тагнуулыг агнаж байгаа хүмүүсийн эсрэг өөрийн ур чадвараа ашиглахад санаа зовохгүй байна” гэж Мендакс хэлж байв.

Кодчиллыг маш ихээр сонирхдог Мендакс өөрийн цаг хугацааг олон улсын програм зохион бүтээхэд зориулж, интернет дээр өөрийн програмуудыг үнэгүй тавьдаг байв. Шинэ технологийн шууд нөлөөллийн улмаас хүний түүхэнд нийгмийн асар их дэвшил гарлаа гэсэн үзэл бодол Мендаксийн философи байлаа. “NorTel” болон бусад олон байгууллагуудаас түүнийг хакердсан үйлдэлд буруутгасан боловч Мендаксийн зохиосон криптографийн програм хангамжийг хэрэглэсэн нь инээдтэй санагдаж магадгүй юм.

Антракс

Антракс Мелбурн руу нүүж, томоохон корпорациудын компьютер сүлжээний салбарт гэрээгээр ажиллах зуураа их сургуулийнхаа курсийг төгссөн юм. Түүний ээж, аав нь салсан өдрөөс хойш Антракс аавтайгаа яриагүй ажээ. Шүүх хурлаас хойш түүний ээжийн эрүүл мэнд арай тогтворжсон ч өвчнөөс болоод өвдөлт их мэдэрсээр байв. Арьсны өнгө нь бага зэрэг өөрчлөгдсөнийг эс тооцвол ээж нь дажгүй харагдана. Олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг салбарт ажиллаж байсны хувьд үнэнч дотно найз нөхдөөр түүний ээж хүрээлүүлж чаджээ. Тэд түүнд сэтгэлийн ихээхэн тэнхээг харамгүй өгдөг ар тал байв. Ээж нь хоёр хүүтэйгээ сайн харилцаа холбоотой байхын төлөө өөрийгөө маш ихээр дайчилж байлаа.

Антракс Исламын үндэстэн байгууллагатай одоо холбоогүй болсон хэдий ч Лалын шашинтан хэвээр үлдсэн юм. Орон нутгийн загас ба шарсан төмс хоолны газрыг ажиллуулдаг Албани гаралтай танил нь түүнийг олон Лалын шашинтан хүмүүстэй танилцуулжээ. Тун удалгүй Антракс Лалын шашны Сунни урсгалд оров. Баасан гаргийн оройн мөргөлд тогтмол оролцох Антракс согтууруулах ундаа хэрэглэхгүй, мөрийтэй тоглохгүй. Тэр Коран судрыг өдөр бүр уншиж, шашныхаа ариун номлолыг хэрэгжүүлэхийг хичээнэ.

Өөрийн компьютер ба бизнесийн ур чадварыг ашиглан Ази эсвэл Ойрхи Дорнодын лалын шашинт улс руу явах боломж байгааг тэр олж харав. Тэр өөрийн амьдралыг Исламын ертөнцөд өнгөрөөхийг хүсчээ.

Компьютерийн ертөнцийн сэтгүүлд гардаг бусад хүмүүсийн шоглох CD бичлэгээр тэр өөрийн хэрэгцээг хангах болов. Тэр одоо хүртэл Маккенни руу утасдаж алга болсон хүрээ хайдаг хэвээр байлаа.

Антракс Омбудсманы газарт цагдаа нарын талаар гомдол гаргасны дараа гарсан шийдвэрт сэтгэл хангалуун бус байсан юм. Тэр гомдолдоо түүний хэргийг шийдтэл цагдаа нар хэрхэн зүй бусаар хандаж байсныг гаргаж тавьсан ажээ. Ялангуяа Австралийн Холбооны цагдаагийн газар ээжийг нь заналхийлсэн, түүний зөвшөөрөлгүйгээр зураг авсан, сурч байсан их сургуульд нь хэргийг бүрэн шийдвэрлээгүй байхад мэдээлэл тараасан зэрэг баримтуудыг тэр дурьджээ. Австралийн Холбооны цагдаагийн газрын эсэрг 1995-1996 оны хооронд 1157 гомдол гаргасны 683-д нь Омбудсманы газраас мөрдөн шалгалт хийсэн байна. Гаргасан гомдлын мөрөөр хийсэн шалгалтын үр дүнд нийт гомдлыг зургаан хувь нь үндэслэлтэй нь нотлогдов. Өөр 9 хувь нь шийдвэрлэх боломжгүй, 34 хувь нь үндэслэлгүй, нийт гомдлын

дөрөвний нэгийг нь шалгах шаардлагагүй гэж үзжээ.

Омбудсманы газраас Антраксын хэргийг Холбооны цагдаагийн газрын дотоод хяналтын албаар шалгуулахыг зөвлөсөн аж. Антракс болон түүний ээж хоёроос авсан мэдүүлгээс үзвэл Антраксыг буруутгах нотолгоо байхгүй байжээ.

Антраксын гэрт нэгжлэг хийснээс хойш бараг хоёр жилийн хугацаа өнгөрсөн тул түүний гомдлыг үндэслэлгүй эсвэл шийдвэрлэх боломжгүй гэж дүгнэснээ Холбооны цагдаагийн газрын дотоод хяналтын алба гаргав. Ихэнх тохиолдолд Омбудсманы газрын түшмэлүүд цагдаагийн шийдвэрийг дэмжинэ. Ямар ч цагдаагийн ажилтан арга хэмжээ авахуулаагүй байна. Омбудсманы газраас түүний гомдлыг хүлээн авч, зөвөлгөө өгсөн явдал Антраксын цорын ганц тайвшрал байлаа. Үүнээс хойш цагдаа нартай холбогдсон түүхээ санан дурсах тусам Антраксын уур хилэн бадрах болсон гэдэг. Цагдаа нарын ажиллаж байгаа арга барилд өөрчлөн шинэчлэх зүйл их байна гэж тэр үзсээр байгаа юм.

Пад ба Гандалф

Пад, Гандалф хоёр шоронгоос гарсны дараа хамгаалалтын зөвөлгөө үнэгүй өгдөг интернет үйлчилгээг эхлүүлэв. “8Lgm”-ын зөвлөмжүүдийг гаргаж эхэлсэн шалтгаан бол админуудад системээ хамгаалахад нь туслахаар шийдсэнтэй холбоотой. Бас нэгэн шалтгаан бол аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдэд үлгэр жишээ үзүүлэх зорилго агуулж байв. “8glm”-ын зөвлөмж нь “CERT”-ын гаргадаг ямар ч хамгаалалтын зөвлөмжөөс давуу талтай гэж интернет хэрэглэгч олон хүн үздэг болов. Пад, Гандалф хоёр өөрсдийн мессэжийг зарим байгууллага руу илгээсээр байжээ. Тэд өөрсдийгөө шууд илэрхийлэхгүйгээр “Та нар биднийг илрүүлсэн. Та нар биднийг шорон руу илгээсэн. Гэхдээ тэр яахав. Ийм мэдээллийг та нар нууц хэвээр хадгалж чадахгүй. Цаашдаа та нараас илүү байх болно. Та нарын өөрсдийн тоглоомын дүрмээр чинь ялна” гэх мэтийн мессэжийг илгээнэ.

Системээс хакеруудыг хол байлгахын тулд юуны өмнө зөв хамгаалалт хийх ёстой гэдэгт итгэсэн Британий хоёр хакер аюулгүй байдлын шинэ цоорхойг дэлхий нийтээс нуугаад байгаа мэргэжилтнүүдийн эсрэг зогсож байв.

Аюулгүй байдлын талаарх уламжлалт мэдээллийг тэдний “8 glm” зөвлөмжүүд бут цохиж, илүү нээлттэй, хэрэгцээ хангасан хандлага руу түлхсэн юм. Пад, Гандалф хоёр гэрээгээр компьютерийн програм бичиж, заримдаа санхүүгийн байгууллагуудын захиалга авна. Тэдний үйлчлүүлэгчид нь ажлыг нь өндрөөр үнэлж байв. Хоёулаа найз охидуудтай болжээ.

Пад дахиад хакердахаа больсон. Баригдах эсвэл шоронд орохоос айж дуртай ажлаа хийхгүй байгаа юм биш, харин хакер довтолгооны дараа системийн администратор ул мөрийг нь цэвэрлэх гэж толгойны өвчинд баригддагт хамаг учир оршиж байв. Бусад хүмүүст хакерууд хир их зовлон учруулдаг болохыг Пад ойлгох болжээ. Түүнээс гадна Падад өөр шалтгаан бий болсон юм. Компьютер түүний цаг нөхцөөх хэрэгсэл биш харин мөнгө олж амьдралыг нь тэтгэх арга байх учиртай тэр үзжээ.

Тэр хилийн чанад руу аялснаас хойш жинхэнэ аялал бол хакердахаас илүү сонирхолтой юм байна гэдэгт итгэх болов. Түүнчлэн гитар тоглож сурсан тэрээр хакердах сонирхолд автаагүй

бол хэдэн жилийн өмнө хөгжимчин ч болох боломжтой байлаа.

Падын аялах сонирхлыг Гандалф хуваалцана. Гэрээгээр ажиллахын сайн тал нь тэднийг зургаан сарын турш эрчимтэй ажиллуулж, мөнгөө хураагаад, дараа нь хэдэн сар тааваар амардагт оршиж байв. Экс хакеруудын хувьд үүргэвчээ бэлдээд дэлхийг тойрох аялалд гарах нь хамгийн гол зорилго ажээ.

Британи улс хакердах үйл ажиллагааг таатай хүлээн авдаггүй тул Пад гадаад руу нүүж, амьдрах сонирхол их байжээ.

Сюарт Гилл

1993 онд Викториагийн Омбудсманы газар ба Викториагийн цагдаагийн газар хамтран цагдаагийн нууц мэдээллийг бусдад задалсан хэргийг илрүүлэхийн тулд Цагдаагийн газрын орлогч дарга Франк Грийний үйлдсэн авлигын гэмт хэргийг илрүүлэх цагдаагийн мөрдөн байцаалтын “Мөсөн уул” нууц ажиллагаатай хамтран ажиллажээ. Хоёр байгууллага хамтарч хийсэн мөрдөн байцаалтын илтгэлд Сюарт Гиллийн тухай тодорхой дурьдсан байлаа.

Викториагийн цагдаагийн газрын илтгэлд : “Гилл цагдаагийн орчинд чадварлагаар нэвтэрч мэдээлэл олзлох боломжтой байжээ” гэсэн бол Омбудсманы газрын дүгнэлтэнд: “Цагдаагийн газрын нууцад хамаарах, голдуу ISU [Internal Security Unit] буюу Дотоод аюулгүй байдлын хэлтсийн мэдээллийн санд хадгалагдаж байсан их хэмжээний мэдээг Косгрифф [Викториагийн цагдаагийн ажилтан] Гиллд өгчээ” гэж бичжээ.

Цагдаагийн байцаагч Хрис Косгрифф цагдаагийн нууцад хамаарах мэдээллийг Гиллд санаатайгаар дамжуулсныг цагдаагийн илтгэлд дурьджээ. Уг илтгэлд хэлтсийн дарга Тони Варрен, газрын орлогч дарга асан Жон Фрейм, Газрын даргын орлогч асан Бернис Мастерсттоныг мөн адил шүүмжилсэн байна.

Варрен ба Косгрифф хоёр Гиллтэй харьцаатай байсан явдал нууц мэдээлэл алдагдах суурь шалтгаан болсон нэж Омбудсманы газрынхан дүгнэжээ. Түүнчлэн “цагдаа нартай холбоотой байгаа таатай боломжийг Гилл ашигласан бол цагдаагийнхан ч гэсэн Гиллийг өөрсдийн ашиг сонирхолд буруугаар хэрэглэсэн” гэж Омбудсманы илтгэлд дурьдсан нь сонирхолтой санагдаж байгаа юм.

Үүнээс гадна Франк Грийний үйлдсэн гэмт хэрэгт ямар ч нотлох баримт байхгүй бөгөөд Эрхэм Грийний эсрэг олон жилийн турш тулгасан гэм бурууг зохих ёсоор залруулах шаардлагатай гэж Омбудсманы илтгэлд бичсэн байв.

Феоникс

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр түүний гэмт хэргийг шүүхээр хэлэлцэж байгаа тухай ам булаацалдан шуугиж байх зуур бороотой нэгэн шөнө Феоникс Мелбурнийн замаар мотоциклээр хурдалж яваад автомашин мөргөжээ. Машины жолооч урд талын суудлаас үсэрч унасан бол Феоникс зам дээр хол шидэгджээ. Тэрээр машины шатахууны савыг мөргөх үед хамгаалалтын дуулганы хажуу тал маш том хагарсан агаад жолоочийн дээр шатахуун их

хэмжээгээр асгарав. Феоникс ямар ч гэмтэл аваагүй нь ёстой ид шидийн гэмээр байлаа. Ослыг харсан хүмүүс түүнийг машины жолоочийн хамт ойролцоох байранд оруулжээ. Тэд түргэн тусламж дуудаж, хоёр залууд халуун цай өгөв. Феониксийн хүсэлтээр утасдсаны дагуу ээж нь хүрэлцэн ирлээ. Түргэн тусламжийн эмч нар Феониксийн ямар нэгэн яс хугараагүйг нотлоод толгой хөдөлсөн байж болох тул цаашдын шинжилгээ оношлогоонд орох хэрэгтэйг зөвлөжээ.

Феоникс, машины жолооч хоёр нэр болон утасны дугаараа солилцох үед 0055 утасны холболтын байгууламж дээр техникийн ажил хийж байгаа гэж Феониксжолоочид хэлэв. “Чи намайг таньж магадгүй. Би Феоникс байна. Шүүх дээр авч хэлэлцэж байгаа компьютерийн хакерын хэрэг бол миний үйлдсэн гэмт хэрэг” гэж тэр хэлжээ.

Жолооч түүн рүү гайхан ширтэнэ.

Феоникс: “Чи намайг телевизийн мэдээгээр харсан байж магадгүй.”

Жолооч “үгүй” гэж хэлэв. Аминд ойрхон ослоос золоор амьд үлдсэн залуу эрийн оюун санаанд гайхалтай зүйл бодогдоно.

Үхэлтэй нүүр тулах шахсан Феониксийн ослын дараахан урьд хакер байсан залуу маань Мелбурнийн томоохон корпорацийн мэдээлэл технологийн хэлтэст шилжин, шугамын техникчийн ажлаа сольжээ. Өндөр цалинтай шинэ ажилдаа Феоникс улаан хөлтнийг урдаа гишгүүлэхгүй авьяастай байлаа. Бүтээгдэхүүний шугамын нэг дээр хаягдал багасгах програм хангамж зохиоход тэр тусалж, мянга мянган долларын алдагдлаас компаниа аварч байв. Тэр одоо Япон болон бусад орон руу тогтмол аялах болсон юм.

Тэрээр нэгэн найз охинтой болсон боловч хэдхэн сарын дотор нөгөөдөх нь өөр хүн даган оджээ. Сэтгэлээр унасан Феоникс болзооноос олон сарын турш хол явж, хамаг хүч чадлаа ажилдаа зориулсан байна.

Түүний шинэ хобби нь хөгжим болов. Сонирхогчдын нэгэн хамтлагт цахилгаан гитар тоглох нь түүнд таалагдах ажээ.

Электрон

Шүүхээс ял авсны дараа хэдэн долоо хоногийн дотор түүний сэтгэл мэдрэлийн өвчин дахин хөдлөв. Түүнийг Ларундел дахь эмнэлэгт дахин хэвтүүлсэн бөгөөд богино хугацааны дараа дахин гарч, өөр эмчилгээ хийлгэх болжээ.

Хэдэн сарын дараа түүний сэтгэл мэдрэлийн өвчин дахин хөдөлж, эрүүл мэндийн хувьд доройтсон байна. Тэр өөрийн эрүүл мэндийн байдлын талаар интернетээс олон тайлбар олж уншсаар байсан агаад өөрийн өвчний талаар дэлгэрэнгүй судлах нь түүний эмчилгээ авах чадварыг үгүйсгэж магадгүй гэж эмч нар үзжээ.

Оюун санааны тогтворгүй байдлаас дөнгөж илааршиж байгаа хүмүүсийн тусгай байранд тэр шилжин оров. Тэр аажмаар өвчнөө давж гарахын төлөө тэмцэж эхэллээ. Эмчилгээ хийлгэх

хугацаандаа Электрон мансууруулах бодис, согтууруулах ундаа уух донгоосоо салж, байнга үзэн ядах нягтлан бодохын курсээ орхив. Хэсэг хугацааны дараа сэтгэл мэдрэлийн эм тангаас бүрэн салжээ. 1994 оны 12-р сараас хойш архи, мансууруулах бодис огт хэрэглээгүй байна. 1996 онд химийн хорыг орлох хамгийн энгийн муу зуршил нь тамхи л болсон ажээ.

1992 оноос хойш Феоникс болон Ноумтай Электрон огт яриагүй байна.

1996 оны эхээр Электрон бүжиглэх урлагаар хичээллэдэг өөрийн найз охины хамтаар шинэ орон сууцанд орж, сэтгэл мэдрэлийн өвчнөө урт хугацааны дараа дийлж чадсан юм. Электрон их сургуулийн өөр курсэд орж, философи судлах болов. Энэ удаад их сургуулийн амьдрал түүнд тохирч, эхний семейстрээр бүх хичээл дээрээ амжилттай дүн үзүүлэв. Тэр цаашдаа Сидней явж хичээл номоо үргэлжлүүлэх талаар бодох боллоо.

Орон нутгийн сургуулийн мужааны зарим ажил хийж, хана будсаар 300 цагийн албадан хөдөлмөр хийх шийтгэлээ Электрон эдэлжээ. Сургуулийн зүгээс нурж байгаа ханыг бэхлэх ажлыг түүнд бүрэн даалгажээ. Тэр дизайныг гарган, хэмжилтийг хийж, ханыг бэхлэв. Шүүхээс оногдуулсан албадан хөдөлмөр хийх сүүлчийн цагаа сургуулийн ханан дээр өнгөрөөсөн Электрон өөрийн бүтээлээр ихэд бахархасан гэдэг. Одоо ч гэсэн сургуулийн хажуугаар давхин өнгөрөх бүртээ өөрийн хана руу бардам харсаар өнгөрнө.

Австрали улсад хакердах гэмт хэрэг гарсаар байлаа. Мендаксийн хэргийг шүүхээр орж байх үед Брисбане хотын дүүргийн шүүхээр арван гурван хууль бус үйлдэлд Кроулер ял шийтгүүлжээ. 1996 оны 12-р сарын 20-ны өдөр 21 настай Куийнсландийн иргэн гурван жилийн тэнсэн харгалзах болон олон байгууллагын хохиролд 5000 долларын нөхөн төлөх ял оноожээ. Түүний модем, хоёр компьютерийг хураасан байна. Хакеруудын эхний давалгаанд гарч ирсэн хүмүүс ирж, буцсан боловч хакердах ажиллагаа үхлээ хүлээх цаг хол байна. Одоо бүр хүний нүдэнд үзэгдэхгүй далд хэлбэрт шилжив.

Хэд хэдэн орны хууль хяналтын болон шүүх байгууллага хакер болохыг хүсэгч шинэ үеийнхэнд анхааруулга илгээхийг оролдсон билээ. “Бүү хакерд!” гэсэн үг тэдний мессэж.

Хориглон тогтоох зарчим энэ түвшинд хакеруудад үйлчилсэнгүй. Би жирийн нэг мөрөөдөгч болон бага гарын хакеруудын тухай яриагүй байна. Би элит хакеруудын тухай ярьж байна шүү. Хууль хяналтын байгууллага хакеруудыг улам далд байдалд ороход нөлөөлсөн гэж үзэхээс гадна хакеруудыг илүү боловсронгуй болж, өөрсдийгөө хамгаалах илүү хүчтэй арга барилыг олж авахад зоригжуулсан байна. Сөрөг талыг шинэ нээлтийн эх гэж үзэх тал байдаг.

Цагдаагийн ажилтнууд өнөөдөр хакерын гэрт маршаар жагсан ирлээ ч хакер өмнөх өвөг дээдсээсээ илүү бэлтгэлтэй байх болно. Өнөөдөр топ хакерууд нууц гэсэн бүхнээ энкриптэлдэг болсон. Хард драйвууд дээрх мэдээлэл, тэдний бодит дата холболт, бүр дуут яриагаа хүртэл энкриптэлнэ.

Хакерууд ажиллагаагаа үргэлжлүүлээд байвал хэн тэдний бай болох вэ?

Сүлжээний бүх төрлийн үйлчилгээ үзүүлэгч, үүрэн гар утас, интернет үйлчилгээ үзүүлэгч мэтийн өргөн газар нутгийг хамарна. Цаашлаад компьютерийн програм үйлдвэрлэгч, тоног

төхөөрөмж үйлдвэрлэгч, руутерс, утасны свитч, гарц [gateway], галт хана [firewall] зэрэг орно. Мөн цэргийн институцууд, засгийн газрууд, банкнууд нилээд олон халдлагын хохирогч болсоор байна.

Аюулгүй байдлын мэргэжилтнүүд рүү довтлох ажиллагаа нийтлэг байх агаад бусад хакеруудын системд халдах явдал шинэ хандлагатай болжээ. “Бусад хакерууд юу хийх юм бэ? Холбооны мөрдөгч рүү утасдах уу? Холбооны цагдаагийн газарт хэлэх үү? Тийм ээ тэр зөв. Зарим компьютерийн гэмт хэрэгтнүүд миний компьютерт нэвтэрч, 20000 пассвордууд, “firewall”-ыг өнгөрөх нууц кодуудыг хулгайлчихлаа” гээд зогсох уу хэмээн Австралийн хакер хошигнож байв.

Баригдах аюулаас хол байхын тулд элит хакерууд ганцаар ажиллах явдал нийтлэг. Топ хакеруудын оролцоотой нууц хакерын бүлгүүд одоо хүртэл амь бөхтэй оршсоор байна. Канадад “UPT”, АНУ-д “10pht” гэсэн бүлгүүд байгаа боловч нийтдээ тархсан шинжтэй, урьд байснаас илүү задарсан байдалтай оршино.

Тэдгээр хакерууд техникийн орчинд хадлага хийх чадвараас гадна стратеги, зорилгын хувьд боловсронгуй байдлын шинэ төвшинд хүрчээ. Аж үйлдвэрийн мэргэжилтнүүдийн олж тогтоосон аюулгүй байдлын цоорхойг жагсаасан “Zardoz”-ын хуулбарыг Электрон, Феоникс мэтийн топ хакерууд авахдаа баяртай байсан цаг саяхан. Одоо хакерууд тэдгээр цоорхойг өөрсдөө олохын тулд Microsoft, Sun, CISCO, HP, DEC зэрэг газруудаас зохих source кодыг ашиглан алдааг мөр мөрөөр нь уншиж байна.

Ямартай ч миний сурвалжилсан хүмүүс аж үйлдвэрийн тагнуулын чиглэлээр ажиллаж байгаагүй юм. Би өрсөлдөгч компаний зохиогчийн эрхээр хамгаалагдсан source кодийг (ASCII текст файлаар бичигдсэн програмын зааварчилгаа, хөрвүүлэгчээр тодорхой үйлдэл хийхийн тулд багцлах ёстой байдаг. Ерөнхий хэллэгийг эвдэхгүйн үүднээс хэвээр бичив-орч) өөр нэгэн компанид өгсөн гэх хакертай уулзаж амжаагүй л явна. Гэхдээ өрсөлдөгч компаний компьютерт нэгэн компаний зохиогчийн эрхээр хамгаалагдсан source код байхыг олсон хакертай уулзаж явлаа. Тэрхүү source код хууль ёсны хуулбар байсан уу? Хэн үүнийг мэдэх вэ? Харин хакер тэгж бодоогүй бөгөөд тодорхой шалтгааны улмаас амаа хамхихаас өөр арга байгаагүй юм.

Аливаа програмын алдааны нөхөөсийг бүү гаргаасай гэж хүсэх шалтгаанаар хакерууд оригиналь цохнуудын талаар аль болох чимээгүй өнгөрөхийг хичээнэ.

Хоёр дахь түгээмэл бай бол source код боловсруулах машин юм. Топ хакерууд энэ чиглэлээр илэрхий зорилго агуулж ажилладаг. Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн (програм) гарахаас өмнө өөрийн арын хаалгыг суулгаж өгөх ажиллагаа орно. Тэд үүнийгээ үйлдлийн систем эсвэл програм дээр арын хаалгажуулах гэж нэрлэдэг. Компьютерийн нууц ертөнцөд “арын хаалга” гэсэн үгийг нэр үг ба үйл үг хоёулангаар нь хэрэглэнэ. Энэ сэдэвт хакерууд нилээд нухацтай хандах нь аргагүй. Зарим талаараа компьютерийн компаний ажилтнуудыг ажилгүй болгохыг тэд хүсдэггүй юм.

Арын хаалгажуулахын тулд хакерууд ямар төрлийн програм хангамж хүсдэг вэ? Хамгийн наад зах нь түгээмэл хэрэглэх интернет браузер, нийтлэг тоглоом, интернет пакет фильтр,

хууль хамгаалах агентлагуудын хэрэглэдэг мэдээллийн бааз боловсруулах бүтээгдэхүүн зэргийг тэдний онилсон бай болохыг хэлдэг.

Хамгийн хатуу даваа болох “firewall”-ыг нэвтрэн нууц суваг бий болгож аюулгүй гэх сүлжээний зүрх рүү хүрдэг сайн арын хаалга бол маш хүчирхэг хэрэгсэл билээ.

“Net browser”-ын (browser-интернет дээр веб хуудсыг үзэхэд хэрэглэдэг програмыг хэлж байгаа юм-орч) хувьд арын хаалганы онолыг тайлбарлавал – “World Wide Web”-ээр [www гэж тэмдэглэдэг. хэрвээ монгол хэлнээ хөрвүүлвэл Дэлхийг хэрсэн тор буюу сүлжээ гэж болно-орч] буюу интернетэд хэн нэгэн хүн гэрийнхээ компьютерээс холбогдонгуут хакер түүний компьютерт шууд холбогдох боломжтой гэсэн үг. Харин хакер одоохондоо танай компьютер рүү халдана гэж бодох хэрэггүй. Ихэнх элит хакерууд дундаж хүний гэрийн компьютерийг нэг их тоохгүй.

Магадгүй та ийм төрлийн довтолгоонд өртсөн гэж бодож болох юм. Ямар хүн ийм зүйлийг хийх вэ? Энэ асуултанд амархан хариулах арга байхгүй. Зарим хакерууд сайн хүмүүс байдаг, зарим нь муу. Яг л хэсэг бүлэг хүмүүсийн адил янз бүр байна. Дараагийн үеийн хакерууд бол арай онцлогтой. Тэгээд ч тэдний тухай өгүүлбэр гэвэл бас нэгэн ном болох байх. Гэвч би та бүхнийг ирээдүй рүү харах цонх нээж өгөх үүднээс нэг хүнтэй танилцуулахыг хүсч байна.

SKiMo-той танилцана уу.

Австралид амьдарч байгаа Европ гаралтай хакер SKiMo дөрвөн жилийн турш хакердаж байгаа юм. Тэр 1995 эсвэл 1996 оны үед дэлхийн түвшний хакерын хэмжээнд очсон гэдэг. Хэзээ ч баригдаж байгаагүй. Эрэгтэй, 18-25 настай. Хоёр дахь хэл болох Англи хэлийг сайн эзэмшсэн. Улс төрийн үзэл бодлын хувьд зүүнтнийг дагасан бөгөөд уламжлалт хөдөлмөрийн нам гэхээс илүү байгаль орчин, ногоон намын чиг хандлагыг илүүд үздэг. Мансууруулах өвс бага хэмжээгээр татдаг, согтууруулах ундаа хэрэглэдэг. Гэхдээ эрүүл мэндэд хортой хэмжээгээр хэзээ ч хэрэглэж байгаагүй.

Тэрээр Pink Floyd, Dog eat dog, Biohazard, old ice –T, Therapy, Alanis Morissette, Rage against the machine, Fear factory, Life of Agony, Napalm Death зэрэг хамтлаг, дуучдыг сонирхоно. Мөн Стефен Кинг, Стефен Хавкинг, Том Кланси, Алдоус Хакслей нарын зохиолоос гадна физик, хими, математикийн ном уншдаг.

Хувь хүний хувьд ичимтгий, багийн спортод дургүй, охидын хажууд өөртөө итгэлтэй биш. Тэр нэг найз охинтой дотносож байсан боловч үерхэл удаан үргэлжлээгүй ажээ. Одоо тэрээр өдөрт дунджаар 4-5 цаг хакердаж, код тайлж өнгөрөөдөг боловч заримдаа 36 цагийн турш ажлаа үргэлжлүүлэх тохиолдол бий.

“Үүний хажуугаар охидтой болзох дуртай. Магадгүй ижил сонирхолтой байвал... гэхдээ тийм охиныг олох хэцүү л дээ. Охид бол хакердахаас огт өөр зүйл. Хакердахтай адилхан бусад арга үр нөлөөгүй болвол тэдэнд хүч хэрэглэж болдоггүй юм” гэж тэр хэлж байв.

SKiMo хэзээ ч компьютерын системд эвдрэл гэмтэл учруулж байгаагүй юм. Үнэндээ түүнээс эвдрэл гэмтэл учруулж өгөхийг би хүсэхэд бараг уурлах шахаж байсныг хэлэх хэрэгтэй.

Гэхдээ тэр санамсаргүйгээр хэдэн системд гэмтэл учруулж байсан. Нэг тохиолдолд тэрээр систем рүү буцаж ирээд асуудлыг зохицуулж байсан удаатай.

Сургуульд сурахаас залхсан SKiMo хичээл дээрээ уран зохиолын ном уншиж, анги хамт олноо үймүүлэхгүйгээр багшдаа эсэргүүцлээ илгээж байсан юм. Автоматаар хариулдаг машин, VMB-г хакердсан хүмүүсийн тухай сэтгүүлээс уншаад хакердах сонирхолд тэр автжээ. Тухайн үед VMB гэж юу болох талаар огт төсөөлөлгүй байсан хэдий ч маш хурдан асуултынхаа хариултыг олсон гэдэг. Ням гаргийн нэгэн орой тэр өөрийн гэрийн утсаар скан хийж эхлэв. Удалгүй тэр фреакинг руу орж, Англиар ярьдаг үдэшлэгийн шугамд зочлох боллоо. Тэр өөрийн орчиндоо гадны хүн мэт сэтгэгдэл төрдөг байсан учраас Англиар яригчдын хүрээнд ороход нэн таатай байв.

“Би аль болох хурдан өөрийн орноосоо явахыг бодох болсон” гэж тэр хэлж байлаа.

Фреакинг хийгээд эхэлсэн бол хакердахад нэг хуруу дутуу байна гэсэн үг.

Түүнийг хакер, фреакингээр оролдоход юу нөлөөлөв? Магадгүй дэлхий даяар үзэн ядах телефон утасны компаниуд уу эсвэл эрх мэдлийг олох хурц хүсэл сонирхол уу, магадгүй “технологийн иж бүрэн нууцыг нээхийг хүссэн” эрмэлзэл ч байж болох юм. Тэр одоо болтол хакерадхаа үргэлжлүүлж байгаагаа тодорхой тайлбарлахгүй байгаа. “Миний хамгийн эхний болон нэн тэргүүний зорилго бол сурах” гэж тэр хариулна.

Их сургууль эсвэл номын санд зочилж хүсэл сонирхлоо биелүүлж болохгүй юм уу гэж асуухад SKiMo: “номноос чи зөвхөн онол сурна. Би онолд дургүй гэж байгаа юм биш харин компьютерийн аюулгүй байдал бол жинхэнэ амьдрал, онолоос тэс ондоо зүйл билээ” гэв. Түүнчлэн технологийн өөрчлөлт, хувьсалтай мөр зэрэгцэнэлхахад номын онол хангалтгүй гэж SKiMo хэлнэ.

Тэр компьютерт донтсон уу? “Үгүй” гэж SKiMo хариулна. Гэхдээ түүний өөрийн тооцоолсноор нийт 3000-10000 компьютерийг хакердсан байна. Өдөр, шөнөгүй компьютерээс салахгүй байгаа хүүгийнхээ зан авирын талаар эцэг эх нь сэтгэл зовниж байсан нь гарцаагүй юм. Тэд компьютерийг нь унтрааж байсан тохиолдол олон билээ. “Тэд намайг компьютерээс холдуудахын тулд бүх хүчээ дайчилсан” гэж SKiMo хэлж байв.

Тэд түүнийг холдуулж чадаагүй гэхэд гайхах зүйл алга. SKiMo өөрийн тоног төхөөрөмжийг нуухдаа гаргууд мастер болсон ажээ. Эцэстээ тэр аргаа барж, миний асуудалд бүү оролц хэмээн тэмцэлдэх болсон тэр үед эцэг эхийн гараас гарах цаг нь болсон байлаа. SKiMo сэтгэл мэдрэлийн болон сэтгэцийн ямар нэгэн өвчнөөр өвдөж байгаагүй гэж хэлдэг боловч хий юм харах, хоосон зүйлд итгэх шинж ажиглагдаж байв. 1996 онд хоёр удаа түүнийг дагаж байна гэдэгт тэр итгэжээ. Тэр хичнээн хичээвч дагаж байгаа хүмүүсээс хэсэг хугацаанд мултарч чадахгүй байв.

Одоо юу сонирхож байгааг харуулахын тулд нэг хакердах ажиллагааны тухай тэр ярьж өгөв. Германы гар утасны компаний (DeTeMobil-Deutsche Telekom) дотоод сүлжээнд SKiMo нэвгэрчээ. 1995 оны нэгдүгээр сард төрийн өмч байсан компанийг Европын томоохон теле харилцаа холбооны Deutsche Telekom компани болгон хувиргав. Уг компани сүлжээний

операторын хувьд дэлхийд гуравдугаарт жагсаж байлаа. 1995 онд нийт орлогоороо 37 тэрбум доллар болж, Герман улсдаа эхний таван компаний нэг болжээ. “Deutsche Telekom” компаний сайтыг нарийвчлан судалсны үндсэн дээр SKiMo DeTeMobil үүрэн гар утасны ярианд зориулан үүсгэдэг энкриптийн түлхүүрийг барих аргыг нээв.

“Түлхүүр нь тогтвортой биш. Тэднийг нэгэнт үүсгэсний дараа зарим мэдээллийн баазад хадгалдаг юм билээ. Компаний AUC [authentication centre-баталгаажуулах төв гэсэн утгатай-орч] нь гар утасны яриа бүрт зориулан түлхүүр бий болгодог. Тэр түлхүүрийг үүсгэхдээ “Ki”-г ашиглана. “Ki” бол гар утасны дотор байх смарт картанд нууцаар хадгалж байдаг нууц түлхүүр юм. Түүний хуулбар нь AUC дээр мөн адил хадгалагдана. AUC гар утсанд тодорхой ярианы түлхүүрийг “дамжуулангуут” мэдээлэл компаний MSC [mobile switching centre-гар утасны свитчинг төв] дамжин илгээгдэнэ” гэж тэр тайлбарлав.

“Хэрэв хэн нэгэн этгээд OMC-ээс [operations and maintenance centre-үйл ажиллагаа ба засварын төв] ирж байгаа холболт үүсгэх мессэж эсвэл смарт картан дахь Ki-г мэдэж байвал тодорхой гар утсыг чагнах боломжтой” гэсэн үг.

“ Хоёр сонголтыг бүхэлд нь хийх боломжтой. Хамгийн эхний сонголт нь A5 энкриптийн түлхүүрийг мэдэх шаардлагатайгаас гадна зөв тоног төхөөрөмж ашиглах хэрэгтэй болно. Хоёр дахь сонголт буюу Ki хэрэглэхэд A3/A8 алгоритмуудыг мэдэх шаардлагатай эсвэл Ki хэрэггүй болно. Тэдгээр алгоритмуудыг Siemens, Alcatel, Motorola свитч үйлдвэрлэгч компаниудыг хакердан олж авна.”

“Хяналтанд байгаа этгээдийн гар утаснаас дуудлага хийхэд A5 түлхүүрээр түүний гар утсыг тэжээнэ. Тэгснээр гар утасны хэрэглэж байгаа сувгийг нууцаар чагнах боломжийг олгоно. Ийм аргаар чагнахад яриа нь энкриптэлсэн учраас зөвхөн статик дуу чимээ гаргана. Түлхүүр, тоног төхөөрөмжтэй байхад ярианы кодыг тайлж болдог.”

Энэ бол гар утаснаас илгээсэн мессэжүүдийн нэг бөгөөд CCITT7 линкний монитор дээр лог хийгдсэн байгааг тэр харжээ.

13:54:46”3 4Rx< SCCP 12-2-09-1 12-2-04-0 13 CR

BSSM HOREQ

BSSMAP GSM 08.08 Rev 3.9.2 (BSSM) HaNDover REQuest (HOREQ)

-----0 Discrimination bit D BSSMAP

0000000-Filler

00101011 Message Length 43

00010000 Message Type 0x10

Channel Type

00001011 IE Name Channel type

00000011 IE Length 3

00000001 Speech/Data Indicator Speech

00001000 Channel Rate/Type Full rate TCH channel Bm

00000001 Speech Encoding Algorithm GSM speech algorithm Ver 1

Encryption Information

00001010 IE Name Encryption information

00001001 IE Length 9

00000010 Algorithm ID GSM user data encryption V. 1

***** Encryption Key C9 7F 45 7E 29 8E 08 00

Classmark Information Type 2

00010010 IE Name Classmark information type 2

00000010 IE Length 2

-----001 RF power capability Class 2, portable

---00---Encryption algorithm Algorithm A5

000-----Revision level

-----000 Frequency capability Band number 0

----1---SM capability present

-000-----Spare

0-----Extension

Cell Identifier

00000101 IE Name Cell identifier

00000101 IE Length 5

00000001 Cell ID discriminator LAC/CI used to ident cell

***** LAC 4611

***** CI 3000

PRiority

00000110 IE Name Priority

00000001 IE Length 1

-----0 Preemption allowed ind not allowed

-----0-Queueing allowed ind not allowed

--0011--Priority level 3

00-----Spare

Circuit Identity Code

00000001 IE Name Circuit identity code

00000000 PCM Multiplex a-h 0

---11110 Timeslot in use 30

101-----PCM Multiplex i-k 5

Downlink DTX flag

00011001 IE Name Downlink DTX flag

-----1 DTX in downlink direction disabled

00000000-Spare

Cell Identifier

00000101 IE Name Cell identifier

00000101 IE Length 5

00000001 Cell ID discriminator LAC/CI used to ident cell

***** LAC 4868

***** CI 3200

Урьдны аналог гар утаснуудыг бодвол дижитал гар утас хамгаалалт сайтай бөгөөд хөндлөнгөөс тагнаж, чагнахаас илүү хамгаалагдсан гэж үздэг. Хэрэв би тань руу дижитал гар утсаараа ярьвал бидний яриа А5 энкриптийн алгоритмаар хамгаалагдаж, гар утас ба утасны холбох байгууламжийн хооронд энкриптлэгдэнэ гэсэн үг. Мэдээллийг зөөвөрлөгч нь Ki-ийн хуулбарыг авдаг бөгөөд зарим орнуудын засгийн газрын эрх бүхий байгууллагууд тэдгээр хуулбарууд руу нэвтрэх эрх эдэлдэг. Гэхдээ үүнийг маш сайн хамгаалалтанд байлгадаг юм.

SKiMo энкриптэлсэн Ki-ийн мэдээллийн бааз руу оролттой болжээ. Тухайн үед мэдээллийн баазыг бүрэн хэмжээгээр декрипт хийхээр (тайлах гэсэн утгатай) А3 ба А8 алгоритмын тухай мэдээллийг хангалттай цуглуулахаар оролдож байгаагүй боловч хийхэд амарханд тооцогдож байв. Гэхдээ одоо тэрхүү мэдээллийг SKiMo олж авчээ.

SKiMo-ийн хувьд Германы гар утасны мянга мянган ярианаас бий болсон түлхүүрийн баазад нэвтрэх нь өөрийн сониуч зандаа хөтлөгдсөн хэрэг байв. Түүнд бусдын яриаг чагнах үнэтэй тоног төхөөрөмж байхгүй. Харин тагнуулын байгууллагын хувьд тиймэрхүү мэдээлэлд оролт байх нь маш үнэ цэнэтэйд тооцогдоно. Ялангуяа улс төрч мэтийн чухал хүмүүсийн гар утастай холбоотой мэдээлэл баазад байвал шүү дээ.

OMC [operations and maintenance centre] рүү оролттой бол үнэ цэнэтэйд тооцогдоно, MSC [mobile switching centre] рүү оролттой бол бүр сайн. Гэвч SKiMo энэ мэдээллийг ямар ч тагнуулын байгууллагатай хуваалцахгүй гэж хэлж байв.

Тэрээр “DeTeMobil”-ийн сүлжээнд нэвтэрч орсон үедээ зарим зураглал ба сигналын хүчний мэдээллийн санг хэрхэн ойлгохыг сурсан байна. Үр дүн нь? Хэрэв тус компаний хэрэглэгч гар утсаа асаалттай байлгаж байгаа тохиолдолд SKiMo нэг километрийн радиустай газарт газар зүйн байрлалыг зааж чадах ажээ. Хэрэглэгч утсаараа ярьж байх шаардлагагүй юм. Нэгэн өдрийн үдээс хойш SKiMo нэг хэрэглэгчийг хаагуур явж байгааг дагаж үзжээ. Тэр эрэгтэй Германыг хөндлөн туулж байлаа. SKiMo түүн рүү утасдлаа. Тэд Европын адилхан хэлээр ярьдаг хүмүүс болж таарав.

Та яагаад Хамбургээс Бремен хүртэл өөрийнхөө утсыг stand by mode дээр тавьж яваад байгаа юм бэ? гэж SKiMo асуужээ.

Үйлчлүүлэгч айх гайхахын хооронд чимээгүй сонсоно. Утасны нөгөө үзүүрт байгаа хүн түүнийг аялж байгаа гэдгийг мэдэж байгаа юм бол доо?

SKiMo өөрийгөө Greenpeace (байгалт орчноо хамгаалан тэмцэгчдийн байгууллага) –ээс ярьж байна гэж танилцуулжээ. “Машин бага жолоод. Их жолоодвол байгаль орчин бохирдуулна” гэж гайхсан гар утас хэрэглэгчид хэлэв. Дараа нь SKiMo эрчим хүч хэмнэх болон гар утсыг удаан хугацаагаар хэрэглэх нь хүний тархины тодорхой хэсэгт хэрхэн нөлөөлдөг талаар хэрэглэгчид ярьж өгөв.

Түүнийг мөшгихөд хэцүү, мөн хөдөлгөөнт холбоотой болно гэж найдсан учраас SKiMo анхнаасаа гар утасны мэдээлэл зөөвөрлөгч сүлжээнд нууцаар нэвтрсэн юм. Тэр үүрэн гар утасны сүлжээнд ажиллаж үзэхийг оролджээ. Бусад хүмүүс болон цагдаа нарын утасны яриаг чагнана гэдэг сугалаанд хожсон мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Хакер маань энэхүү төслөө хэрэгжүүлэх замдаа гар утас үйлдвэрлэгчээс гаргадаг кодыг нээжээ. Үүнээс үүдэн түүнд “олон хэлний төслийг” хэрэгжүүлэх шаардлага гарав. SKiMo :“Таныг олон хэл судлах зорилго тавьж байсан эсэхийг би мэдэхгүй юм. Ямар нэгэн функцийн нэр, тайлбартаа хэрэглэх ёстой бүх програмчдийннийтлэг хэлийг хэн нэгэн тодорхойлоогүй гэж үү? Ёстой утгагүй харагдаж байв. Уншихад хүртэл хөгжилтэй биш байлаа.” Түүний нэг хэсэг нь Финланд хэл дээр байлаа.

Тэр томоохон хэдэн компаниудыг хакердаж, нилээд олон тохиолдолд нь тэдний бүтээгдэхүүний source код руу нэвгэрчээ.

SKiMo томоохон нийлүүлэгчид зориулсан хамгийн гол source кодонд өөрийн арын хаалгыг суулгаж чадсан гэж үү? Тиймээ. Тэр өөрөө хийсэн гэж үү? SKiMo үгүй гэж хэлнэ. Нөгөө талаар үүнийг хийсэн гэж хэнд хэлэх вэ гэж түүнээс би асуув. “Хэн ч хийгээгүй. Яагаад гэвэл хоёр хүн хэн нэгнийгээ хийснийг мэдвэл эрсдэл дагуулна. Аюултай.”

SKiMo ихэвчлэн ганцаар ажиллана. Хакердах нууц арга барилаа бусад хүмүүст хязгаарлагдмал байдлаар хуваалцана. Гэхдээ тайлбарлах байдал нь илүү бүрхэг, үгээ болгоомжтой сонгосон шинжтэй байдаг. Тэр жинхэнэ үйлдвэрлэгчийн нэрийг өөр үйлдвэрлэгчийн нэрээр сольж хэлнэ, эсвэл компьютерийн аюулгүй байдлын техникийн асуудлыг хөндөж, онол голдуу ярина. Гэвч тэр хэзээ ч тодорхой ямар нэгэн системийн тухай нэрлэхгүй.

SKiMo утсаар ярьж байхдаа хакердах тухай нэг ч үг цухуйлгахгүй. Тэр ямар нэгэн амжилт гаргасан бол бусдад дэлгэхгүй дотроо л хөөрнө.

Гэхдээ байдал байнга ийм байгаагүй юм. “Би хакердаж, фреакинг хийж эхлэхдээ ‘техникийн зөвөлгөө’ авахын тулд хэн нэгэнтэй холбоо тогтоох хэрэгтэй байсан юм. Харин одоо хэн нэгнээс асууснаас өөрөө хийсэн нь хамаагүй амархан болсон. Би source кодыг хараад дараа нь шинэ цохнуудыг нээж, туршиж үздэг” гэж SKiMo ярьж байв.

Компьютер технологийн иж бүрэн хөгжилт хакеруудыг ганцаар бус багаараа ажиллахыг шаардаж байгаа юм биш үү? гэж асуувал тэр нэг талаараа тийм, нөгөө талаараа үгүй гэж хариулна. “Дахин юм сурахыг хүсэхгүй байгаа хүмүүсийн хувьд бол үнэн” гэж тэр хэлнэ.

SKiMo ирээдүйд хакердах сонирхлоо хаяхгүй гэж боддог.

Миний эсрэг талд хэн ажиллаж байгаа юм бэ?

Австралид бол Австралийн Холбооны цагдаагийн газар байна. Хэдийгээр компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байгуулагдсанас хойш чамгүй урт замыг туулжээ. Холбооны мөрдөгчид Феоникс, Ноум, Электрон нарыг илрүүлэх үед тэд том гавьяа байгуулсан хүн шиг байлаа. Харин байцаалт авсны дараа Австралийн хакеруудтай мэдлэгээрээ өрсөлдөхгүй гэдгээ ойлгосон. Тэдний техникийн мэдлэгийг хараад хакерууд чангаар инээх нь энүүхэнд. Гэвч Австралийн Холбооны цагдаагийн газар тэрхүү цоорхойг маш хурдан бөглөж чадсан юм. Кен Дей даргын удирдлаган дор хууль хамгаалах байгууллагын чадварлаг ажилтнууд ажиллаж байна. 1995-1996 оны хооронд Холбооны цагдаагийн газар 2800 албан хаагч байсны

800 нь АСТ ба Норфолк арлын орон нутгийн цагдаагийн байгууллагад олон нийтийн цагдаагийн чиглэлээр ажиллаж байв. Тус газрын жилийн зардал 1995-1996 онд 270 сая доллар хүрч байсан юм. Саяхнаас Австралийн Холбооны цагдаагийн газар бүтцийн томоохон өөрчлөлт хийж, илүү цэрэгжсэн гэхээсээ үйлчилгээнд чиглэсэн, бүтээлч хандлагаар ажиллах боллоо.

Тэдний хийсэн өөрчлөлт илт мэдрэгдэхүйц байв. Холбооны цагдаагийн газрын ажилтнуудыг одоо Холбооны мөрдөгчид гэх болжээ. Мелбурнийн компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр байнгын таван ажилтан одоо ажиллаж байгаа бөгөөд жилд хэдэн долларыг компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэхэд зарцуулдаг. Гэхдээ миний тооцоолсноор Мелбурн хотын хэмжээнд нийт 1 сая долларыг зөвхөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд зарцуулж байна. Сидней хотод мөн адил компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байдаг.

Хакер, фреакерыг илрүүлнэ гэдэг хэлтсийн үндсэн ажлын нэг хэсэг. Бусад мөрдөн байцаалтын ажиллагаанд компьютер техникийн шинжилгээ хийнэ гэдэг бас нэгэн чухал даалгавар тэдэнд бий.

Дей одоо хүртэл Мелбурнийн цагдаагийн газраа ажиллаж байгаа. Тэр гудамжны цагдаа шиг бодож, ажиллах үндэс байхгүй. Дей бол сэтгэл зүйгээр наадагч учир түүний өрсөлдөгч нарт маш тохирсон хүн гэлтэй. Компьютерийн далд ертөнц дэхь нэгэн найдвартай эх сурвалжийн мэдээлснээр тэр бол “сайн залуу”, “цэвэрхэн цагдаа” ажээ.

Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргаар олон жил ажилласан нь Дейг хакеруудын бай болгоход хүргэсэн юм. Ялангуяа хакерууд өөртөө болон түүний ажилд хэрхэн хандаж байгаагаар даажигнахыг оролдоно. Нэгэн удаа ABC телевизийн “Хандлага” шоунд оролцож байхдаа хакеруудад зориулан “Энэ бол тоглоом биш, Энэ бол гэмт хэрэг” гэж хэлж байв.

Харин шоуг үзэж байсан хакеруудын хувьд ямар сонголт хийж, тоглох вэ гэсэн бодлыг л өдөөнө. Түүний хэлсэн үг гарч дуусангуут Невро-кактус нэртэй Австралийн хакеруудын бүлгийн гишүүд Дейгээр тоглоом хийхээр шийдэв. Пик, Миннов нэртэй хоёр хакер Дейгийн хэлсэн үгэнд дуу оруулжээ. Нэг их удалгүй Дейгийн хэлсэн үгийг “The Bill”-ийн хөгжмийн аянд оруулж “Энэ бол гэмт хэрэг биш, Энэ бол тоглоом” болгон өөрчилсөн гэдэг. Невро-кактусын хакерууд хийсэн бүтээлээ хууль бус VMB-ээр дамжуулан үнэгүй дуудлага 008 дугаартай холбожээ.

“Хэн нэгэн хүн Дейгийн гэрийн утасны дугаарыг авахаар ажиллаж байгаа гэдгийг” би нэг бус удаа хакеруудаас сонсож байв. Зарим хүмүүс Дей рүү утасдаж тоглоом хийхийг хөгжилтэйд тооцсон байж магад. Шуудхан хэлэхэд түүний хийж байгаа ажлыг бодохоор би их өрөвддөг юм.

Нийгмээс хүнд ноцтой гэмт хэрэг гэж үзэж байгаа хэсэг рүү сэлгүүцэх хэн нэгнийг шийтгэх хүчин чадал хууль эрх зүйд байх учиртай. Гэхдээ хакеруудын үйлдсэн ноцтой бараг бүх гэмт хэргийг хакер бус хүн үйлдээд өөр хуулиар шийтгүүлж болно. Залилан, санаатайгаар хохирол учруулах, хулгайлагдсан эд зүйлийг наймаалах гэмт хэрэгт зохих ёсоор ял шийтгэл оноох шаардлагатай.

Харин сонирхолдоо хөтлөгдөж систем рүү нэвтрээд буцаад гараад явчихдаг хакеруудыг гэмт хэрэгтэн гэж үзэх үү? Би хорлон сүйтгэх ажиллагаа, болон залилан хийдэггүй хакеруудын тухай ярьж байна л даа. Магадгүй үгүй байх . Үүнийг гэмт хэрэг гэж үзэх боловч учруулсан хор хохирлыг тооцож үзэж байх шаардлагатай.

Ихэнх хакерууд зарим газрын ажилгүйдлийн түвшнээс болоод хэзээ ч ажил хийж үзээгүй байдаг. Тиймээс албадан ажил хийлгэх ял авсан хакер анх удаагаа ажил хийж байгаа гэсэн үг. Нийгэмд тэдний хувь нэмрийг эргүүлэн авах зорилгоор зөв чиглэлийн албадан хөдөлмөр хийлгэвэл зүгээр байх. Хакердах, фреакинг хийхийг донтох хэмжээнд хэтрүүлсэн хүмүүсийг гэмтэн болгох бус эмчлэн илааршуулах ёстой билээ. Хилийн чанад дахь шүүгчдийг бодвол Австралийн шүүгчид илүү шударга шийтгэл оноож байгаа нь практик дэрээс харагдсан юм. Энэ бүтээлд дурьдсан Австралийн хакеруудын хэн нь ч хорих ялаар шийтгүүлээгүй. Би Австралийн шүүгчдийн удирдаж байгаа шүүх хуралд сууж байхдаа тэднийг гэрийн даалгавраа сайн хийсэн гэж шууд дүгнэсэн юм.

Либерал Намын төв байрны компьютерт нэвтэрч, сонгуулын нууц стратегийг уншсан этгээд Хөдөлмөрийн намд мэдээллийг дамжуулсан хууль бус тагнах гэмт хэргийг авч үзье. Тэр тагнах явцдаа ямар ч дата устгаагүй, нэмж оруулаагүй эсвэл худалдааны мэдээлэл уншаагүй. Харин Австралийн Холбооны цагдаагийн газрын компьютерийн гэмт хэргийн хэлтсийн барьж ажиллах хуулинд зааснаар ямар ял оноох болов? Шоронд дээд тал нь зургаан сар хорих.

Үүнтэй ижил тагнах ажиллагаа хийсэн этгээд маш хурдан баяжихыг хүснэ. Орон нутгийн телефон утасны системийг ашиглан банкны компьютер рүү нэвтэрч, санхүүгийн байгууллагыг санаатайгаар залилна. Тэр худалдааны болон хувийн ямар ч мэдээллийг харахгүй, файлыг устгахгүй, мэдээлэл нэмж оруулахгүй. Харин түүний судлах мэдээлэл бол банкны байрны бүдүүвч зураг, галын дохиоллыг хэрхэн унтраах, ус шүрших системийг хэрхэн салгах нь банк залилах төлөвлөгөөнд гол ач холбогдолтой. Түүнд оноох ял хоёр жил шоронд хорих.

Манай тагнуулууд илүү том, ашигтай зүйлд анхаарлаа хандуулах болов. Тэр Батлан хамгаалах яамны компьютер руу Австралийн цэргийн стратегиудын талаарх мэдээллийг олж авах зорилгоор нэвтэрч Малайзчуудад дамжуулсан. Тэр дахиад л ямар нэгэн дата устгаагүй, нэмж оруулаагүй, гэхдээ тэр уншиж чадах бүх нууц бичиг баримтыг судалсан. Холбооны хакерын эсрэг хуулиар түүнд дээд тал нь хоёр жил шоронд хорих ял онооно.

Харин Их сургуулийн компьютерийн системд нэвтэрч ямар хор хохирол учруулаагүй хакер яах бол? Тэр ямар ч файлуудыг устгаагүй. Өөр системийн FTP файлыг оруулж, их сургуулийн ашиглагдаагүй буланд нууцална. Магадгүй тэр онлайн дээр хэн нэгэнд мессэж үлдээнэ. Хэрэв баригдвал Австралийн Холбооны цагдаагийн газар, Прокурорын газар нийлээд арван жилийн ял оноох гэж зүтгэнэ. Шалтгаан байна уу? Тэр дата оруулсан, устгасан.

Хуулиа өөрчилвөл тэд зан аашаа татаж болно байх. Зүгээр зүтгүүтэж байгаа хакерын үйлдлийг зөрчил болговол хууль хяналтынхан жинхэнэ гэмт хэрэгтнүүдийн хойноос хөөцөлдөхөд илүү их цаг зарцуулах болно.

Хакеруудын ихэнх нь тэр хайрцагнаас цааш яаж бодох вэ гэдэгт хамаг анхаарлаа тавина.

Хавсралт

AARNET Australian Academic Research Network

ACARB Australian Computer Abuse Research Bureau, once called CITCARB

AFP Australian Federal Police

Altos West German chat system and hacker hang-out, connected to X.25 network and run by Altos Computer Systems, Hamburg

ANU Australian National University

ASIO Australian Security Intelligence Organisation

Backdoor A program or modification providing secret access to a computer system, installed by a hacker to bypass normal security. Also used as a verb

BBS Bulletin Board System

BNL Brookhaven National Laboratory (US)

BRL Ballistics Research Laboratory (US)

BT British Telecom

CCITT Committee Consultatif Internationale Telegraph et Telephonie: Swiss telecommunications standards body (now defunct; see ITU)

CCS Computer Crime Squad

CCU Computer Crimes Unit (Australian Federal Police)

CERT Computer Emergency Response Team

CIAC Computer Incident Advisory Capability: DOE's computer security team

CITCARB Chisholm Institute of Technology Computer Abuse Research Bureau (now defunct. See ACARB)

COBE Cosmic Background Explorer project: a NASA research project

DARPA Defense Advanced Research Projects Agency (US)

DCL Digital Command Language, a computer programming language used on VMS computers

DDN Defense Data Network

DEC Digital Equipment Corporation

DECNET A network protocol used to convey information between (primarily) VAX/VMS machines

DEFCON (a) Defense Readiness Conditions, a system of progressive alert postures in the US; (b) the name of Force's computer program which automatically mapped out computer networks and scanned for accounts

DES Data Encryption Standard, an encryption algorithm developed by IBM, NSA and NIST

Deszip Fast DES Unix password-cracking system developed by Matthew Bishop

Dial-up Modem access point into a computer or computer network

DMS-100 Computerised telephone switch (exchange) made by NorTel

DOD Department of Defense (US)

DOE Department of Energy (US)

DPP Director of Public Prosecutions

DST Direction de la Surveillance du Territoire - French secret service agency

EASYNET Digital Equipment Corporation's internal communication network (DECNET)

GTN Global Telecommunications Network: Citibank's international data network

HEPNET High Energy Physics Network: DECNET-based network, primarily controlled by DOE, connected to NASA's SPAN

IID Internal Investigations Division. Both the Victoria Police and the AFP have an IID

IP Internet Protocol (RFC791): a data communications protocol, used to transmit packets of data between computers on the Internet

IS International Subversive (electronic magazine)

ISU Internal Security Unit: anti-corruption unit of the Victoria Police

ITU International Telecommunications Union, the international telecommunications standards body

JANET Joint Academic Network (UK), a network of computers

JPL Jet Propulsion Laboratory--a California-based NASA research centre affiliated with CalTech

LLNL Lawrence Livermore National Laboratory (US)

LOD Legion of Doom Lutzifer West German computer, connected to the X.25 network, which had a chat facility

MFC Multi Frequency Code (Group III): inter-exchange telecommunications system used by Telstra (Telecom)

MILNET Military Network: TCP/IP unclassified US DOD computer network

MOD Masters of Deception (or Destruction)

Modem Modulator De-modulator: a device used to transmit computer data over a regular telephone line

NCA National Crime Authority Netlink A Primos/Dialcom command used to initiate a connection over an X.25 network

NIST National Institute of Standards (US)

NIC Network Information Center (US), run by DOD: a computer which assigned domain names for the Internet.

NRL Naval Research Laboratory (US)

NSA National Security Agency (US)

NUA Network User Address: the 'telephone' number of a computer on an X.25 network

NUI Network User Identifier (or Identification): combined username/password used on X.25 networks for billing purposes

NorTel Northern Telecom, Canadian manufacturer of telecommunications equipment

PABX Private Automatic Branch Exchange

PAD Packet Assembler Disassembler--ASCII gateway to X.25 networks

PAR 'PAR?'--command on PAD to display PAD parameters

RMIT Royal Melbourne Institute of Technology

RTG Radioisotope Thermoelectric Generator, space probe Galileo's plutonium-based power system

RTM Robert Tappan Morris (Jr), the Cornell University student who wrote the Internet worm, also known as the RTM worm Scanner A program which scans and compiles information, such as a list of NUAs

SPAN Space Physics Analysis Network: global DECNET-based network, primarily controlled by

NASA Sprint US telecommunications company, an X.25 network provider

Sprinter Word used by some Australian and English hackers to denote scanner. Derived from scanning attacks on Sprint communications Sprintnet X.25 network controlled by Sprint communications

Sun Sun Microsystems--a major producer of Unix workstations

TCP Transmission Control Protocol (RFC793): a standard for data connection between two computers on the Internet

TELENET An X.25 network, DNIC 3110 Telnet A method of connection between two computers on the Internet or other TCP/IP networks

Trojan A program installed by hackers to secretly gather information, such as passwords. Can also be a backdoor

Tymnet An X.25 network controlled by MCI, DNIC 3106

Unix Multi-user computer operating system developed by AT&T and Berkeley CSRG

VAX Virtual Address Extension: series of mini/mainframe computer systems produced by DEC VMS

Virtual Memory System: computer operating system produced by DEC and used on its VAX machines

WANK Worms Against Nuclear Killers: the title of DECNET/VMS-based worm released into SPAN/DEC/HEPNET in 1989

X.25 International data communications network, using the X.25 communications protocol. Network is run primarily by major telecommunications companies. Based on CCITT standard # X.25

Zardoz A restricted computer security mailing list